

Юрий
Дольг - Михайлик

Ганц
дайчин
ганцдахгүй

icht
gefahr



ГЭНЭТ ИРСЭН ГИЙЧИН Утасны хонх удтал жингэнэв. Өөр үед бол 1—Ц хэлтсийн дарга хурандаа Бертольд буйдан дээрээс босон харайж, утас руу ухасхийх байсан бизээ. Энэ удаа хөдлөх ч үгүй нүдээ аниад хэвтсээр байгааг нь харвал унтаж байна уу гэмээр. Хурандаагийн туслах ахмад Коккенмюллер хэд хэд дахин хаалга тогшоод хариу дуугарахгүй болохоор хаалганы нь завсраар шагайж, даргыгаа буйдан дээр нүдээ анин хэвтэж байхыг хараад амрахад нь саад болохгүй гэж хаалгаа аяархан хаав. Дарга нь урьд шөнө нойргүй хоносныг ахмад мэднэ. Бүүр үүрээр, Гиммлерийг өөрөө утасдсаны дараа хурандаа бага зэрэг амарчээ. Туслагч нь Бертольдыг утсаар ярихад байлцаагүй боловч хурандааг утас авангуут биеэ эгцлэн зогсож, хүндэтгэлтэйеэ дуугарахыг сонсоод өлмийгөөрөө гэтэн тасалгаанаас гарахдаа бас хаалгыг сайн хаагаагүй билээ. Ахмадын ширээ байгаа зэргэлдээх өрөөнд дуулдсан ганц нэг үгнээс үзэхэд ч Гиммлертэй утсаар ярьсан явдал хурандаад санамсаргүй сайхан тохиол болсон нь тодорхой байлаа. Хурандаа Бертольд Гиммлерээс тийм сайхан үг сонссоны дараа элдвийг эргэцүүлэн санааширч хагас цаг хэвтэж болохтой байжээ. Ой мод ихтэй болохоор фюрерийн армид онцгой аюултай энэ Белорусс нутагт хурандаагийн гүйцэтгэсэн ажиллагааг дээд командлал маш өндөр үнэлж, Гиммлер өөрөө Бертольдод одооныхоос илүү өргөн хүрээтэй шинэ үйл ажиллагаа зэхэж байгаа гэдгийг бараг нуулгүй цухуйлгасан байна. Хурандаа цагийнхаа ердийн хуваарийг нилээд зөрчиж, жаахан санаашран мөрөөдөх учир шалтгаан байжээ. Вильгельм Бертольд уг нь хоосон санаашрагч хүн бишээ. Германы тагнуулын албанд хамаг насаа зориулсан ахмад офицер түүнд үргэлж албан тушаал ахиж, улмаар цөөн амтай гэр бүлийнхээ аж байдлыг өөд татах гэсэн ганц хүсэл бий. Өнөөдрийн яриа хурандаагийн сэтгэлийг баахан хөөргөжээ. Тэгэлгүй яах вэ дээ! Өмнө нь энэ ёозгүй нутгийг орхих аян шалтаг таарч байхад! Бертольд өөрийгөө өөр газар шилжүүлж өгөөч гэж хүссэн өргөдөл хэзээ ч хэрхэвч өгөхгүйсэн. Ингэвэл Дээд командлалын хаа тушаалыг яаж биелүүлэх вэ гэж бодохоос биш, өөрийнхөө төлөө огт санаа зовдоггүй офицер гэсэн нэр алдарт нь хор хүргэж, албан тушаал ахихад нь саад болох байсан билээ. Одоо бол Гиммлер өөрөө ... Утасны хонх дахин жингэнэж, сайхан бодлыг нь үргээв. «Ийм эрт хэн утасдаг билээ?» гэж Бертольд хальт бодтол тэрхэн агшинд хаалгыг нь аяархан боловч шаардангуй тогшихыг сонслоо. Хурандаа нүдээ ч нээлгүй: — Орогтун! гэсэнд — Арван хоёрдугаар дивизийн штабаас хоёр дахиад утасдаж байна гэж аяархан илтгэхэд нь — Юу болоо вэ? гэж Бертольд асуугаад урд нь цэх зогсож байгаа туслахаа дутуу аньсан зовхины завсраар харвал туслах нь нойргүй хоносон атал ядарсан шинж бараг байхгүй, шингэн үсээ урьдын адил толийтол самнаж, сахлаа мөлчийтөл хуссан байх агаад галгүй дүрлэгэр нүдэнд нь алжаасны шинж үл үзэгдэнэ. — Өчигдөр орой арван хоёрдугаар дивизийн хэсэг дээр оросын нэг офицер манай талд дагаар орж ирсэн байна. Тэр офицер дивизийн штаб дээр ямар нэг өчиг мэдүүлэг өгөхийг татгалзаад шууд эрхэм хурандаа тантай уулзуулахыг шаардсан байна! гэж Коккенмюллерийг илтгэхэд — Надтай юу? гэж лавлав. — Тийм ээ! Тэр офицер,

таны албан тушаал, нэр овгийг хүртэл хэлсэн байна! гэхэд нь — Юу-уу?! гэж Бертольд гайхан дал мөрөө хавчаад босов. — Нээрээ хачин юм. Таны нэр овгийг орос офицер хаанаас олж мэдээ юм бол? гэж Коккенмюллерийг хэлэхэд — Тэгэх тусмаа миний нэрийг шүү гэв — Ямар ч атугай эрхэм хурандаа таныг болгоомжтой байж үзээрэй гэж зориглон сануулья! Таныг хөнөөх зорилгоор зориуд тэр офицерыг илгээсэн байж болзошгүй юм шүү ... — Ахмад та өчүүхэн намайг хэтэрхий дээгүүр бодож байна. Жирийн нэг офицер миний аминд халдах гэж үү? ... — Гэсэн ч эрхэм хурандаа ... гэж туслах нь үг сөргөх гэсэн. Бертольд түүний үгийг эс сонсон: — Корпусын юм уу, армийн командлагчийн тухайд бол аминд халдах явдал байж болох юм биз гэсэнд Коккенмюллер ая тал засан: — Жирийн нэг офицер биш, Гиммлерийн дотнын нөхөр болсон офицерын тухай ярьж байгааг эрхэм хурандаа болгоох биз. Энэ чинь большевикуудад зэгсэн сайн шалтаг шүү гэв. — Та тэгж бодож байна уу? — Бат итгэж банна! — Тэгээд штабт юу гэж хэлэв? — Тэр зугтаж ирсэн хүний бичиг баримтыг нааш нь хүргүүлж, өөрийг нь жич тушаал өгтөл тэнд нь байлгахыг таны нэрийн өмнөөс тушаасан. — Тун зүйтэй. Бичиг баримт нь ирсэн үү? — Ирсэн. — Аваад ир. Коккенмюллер даруй тасалгаанаас гарч, төдөлгүй балцгар тарган бага даргыг дагуулан эргэж ирлээ. Бага дарга том дугуйтай бичиг өгч: — Эрхэм хурандаа танд биеэр гардуулж өгөхийг тушаасан юм гэж илтгэлээ. Хурандаа дугтуйд хавсаргасан гонзгой цаасан дээр гарын үсэг зурж өгсөнд бага дарга тасалгаанаас гарч одлоо. Бертольд дугтуйг нямбай хайчилж ирүүлсэн бичиг баримтыг гаргаж үзвэл: газар орны том байр зураг, офицерын үнэмлэх хоёр байлаа. Хурандаа тэр зургийг зэрвэсхэн нэг хараад туслахдаа дуугүй өгөв. Ахмад зургийг жижиг ширээн дээр даруулгаар хадаж тогтоогоод ширээнээс галт шил гаргаж, тэр зургаас ямар нэг нууц тэмдэг эрж байгаа бололтой тонгойв. Ахмад газрын зураг судлах ажилдаа улайгаад Бертольдыг дуугарахад цочжээ. — Энэ дагаар ирсэн хүний царай орос маягийнх биш шиг санагдмаар юм уу даа? гэж хурандааг асуухад Коккенмюллер дэргэд нь очоод даргынхаа араас гэрэл зургийг харж: — Ко-ма-роф ... гэж үеэр таслан уншаад зургийг дахин харж: Нээрээ тийм байна, эрхэм хурандаа. Европ хүний царай, тэр ч байтугай цэвэр герман хүний царай гэмээр байна. Та энэ өргөн магнай, жаахан хянгадуу шулуун хамрыг нь хараач гэсэнд — Штабт залгаад тэр хүнийг нааш хүргүүл гэж хэл гэв. Бертольд зөөлөн сандлын түшлэг налж, нүдээ дутуу аниад Гиммлертэй өглөө ярьснаа нэгэд нэгэнгүй дахин санах гэж оролдтол амттайхан сайхан бодол ахин эргэж ирсэнгүй. Хажуугийн өрөөнөөс Коккенмюллерийн чанга чанга дуугарах нь юм бодоход саад болсон ч байж мэднэ. Ахмад шуурхай хэлтэстэй ярьж чадахгүй их будилжээ. Бас тэр зугтаж ирсэн офицер гэж нэг юм байдаг! Тэр хүн заавал хурандаатай өөртэй нь уулзах гэж зүтгээд байдаг нь хачин юм даа. Удахгүй учир нь мэдэгдэнэ биз. Хурандаа бяцхан дэвтрийг дахин нээж, одоо өөр дээр нь авч хүний дүрс зургийг анхааралтай ажиглав. Сонин царай байна! Ийм жимгэр жижигхэн уруултай чинь хэн сэн билээ? Коккенмюллер босго алхангуут: — Эрхэм хурандаа таны тушаалыг биелүүллээ гэж илтгээд нэг сандал авч тасалгааны дунд тавив. Коккенмюллер нүдээ онийлгон тасалгааны дунд тавьсан сандал, өөр нэг зөөлөн сандал хоёрыг хэдэнтаа ээлжлэн хараад: — Та тэр хүнийг энэ сандалд суу гэж хэлээрэй. Ширээний дэргэдэх энэ сандал дээр би сууна. Ингэхлээр дагаар ирсэн хүн та хоёрын дунд таныг хамгаалахад хэзээд бэлэн нэг хүн байх болно гэв. Зөвлөлтийн Армийн дэслэгчийн дүрэмт

хувцастай, дунд зэргийн нуруутай, хорь-хорин хоёр насны залууг штабын хамгаалалтын офицер тасалгаанд оруулж ирэв. Бертольд орж ирсэн залуугийн царайг ширээн дээр байгаа дэвтрийн зурагтай хурдан зуур харьцуудан харвал зураг дээрх хүн биеэрээ байгаа нь гарцаагүй ажээ. Харин зураг дээр үсээ гэдрэг самнасан байхад одоо тэгшхэн хагалан самнасан байв. Үүний улмаас туранхай бор царайн нь төрх бүр тодхон харагдана. Ялангуяа хамар, нягт жимийсэн нимгэн уруултай ам нь гоц тодрон үзэгдэнэ. — Эрхэм хурандаа таны амрыг айлтгая! гэж ирсэн залуу германаар цэвэрхэн хэлээд өсгийгөө тов хийтэл товшин ёслов. Нэг хэсэг дуугүй байцгаалаа. Бертольд нүдээ онийлгон, орж ирсэн хүний төрх байдлыг нэгд нэгэнгүй шинжин ажигласанд дагаар ирсэн залуу тэр харцыг ажиггүй тайван даалаа. Харин түүний том тунгалаг хүрэн нүдэнд инээмсэглэл тодрох шиг Бертольдод санагджээ. — Сайн байна уу! Та энэ шөнө оросуудаас манай талд зугтаж ирсэн үү? гэж хурандаа эцэст нь дуугарсанд — Яг тиймээ. Би өнөөдөр үүр цайхаас өмнө фронтын шугам давж ирээд хурандаа Бертольдтой уулзуулахыг шаардсан юм гэж ирсэн залуу хариулав. — Та өөрөө түүнийг таних юм уу? гэж хурандаа асуугаад туслах өдөө ажиг бүү авахуул гэсэн янзтай харав. — Тиймээ, би таныг танина гэж тэр залууг хэлэхэд Бертольд гайхсанаа нуухыг ч хичээсэнгүй. — Яаж таних юм бэ? Бас заавал надтай уулзах гэсний учир юу билээ? гэж асуув. Ирсэн залуу урагшаа нэг алхсанд Коккенмюллер хамаг биеэ хөвчилж, гар бууныхаа бариулыг чанга атгав. — Би суух зөвшөөрөл гуйх гэсэн юм. Эрхэм ахмад санаа зовох явдалгүй. Надад буу зэвсэг байхгүйг та бэлхнээ мэдэж байгаа шүү дээ гэж залуу хэлээд инээмсэглэсэнд. — Суугтүн гэж Бертольд хэлээд тасалгааны дунд байгаа сандлыг заав.

Ирсэн залуу сууж, гутлынхаа өсгийг тайван эргэдэн авч эхэллээ. Коккенмюллер юмыг яаж мэдэх вэ гэж гар буугаа гэрнээс нь гарган өвдөг дээрээ тавив. Зугтаж ирсэн хүний гутлынхаа өсгий дороос гаргаж ирсэн бяцхан төмөр хайрцаг дотор юу байгааг хэн мэдэх билээ! Тэр завсар залуу нөгөө хайрцага онгойлгож алган дээрээ нэг цаасны өөдөс сэгсрэн унагаж байгааг ахмад хараад сая санаа амарчээ. Зугтаж ирсэн залуу, Коккенмюллерт хандан — Үүнийг хурандаад өгнө үү гэж хүслээ. Хурандаагийн туслах тэр цаасыг нь аваад гараа сарвайсаар даргынхаа ширээ тийш явах зуур тэр учир битүүлэг орос хүнийг нүд салгалгүй хардан ажиглана. Цаадахь нь тасалгааны доторхийг харж ажиггүй суухад Коккенмюллер бүрмөсөн тайвширчээ. Бас даргын нь царай гэнэт хачин хувьсхийхийг харж ахмадын анхаарал сарнисан байжээ.

— Энэ чинь юу вэ! гэж Бертольд дуу алдлаа. Ирсэн залуугийн царайд баярын инээмсэглэл үл мэдэг тодроод босон харайж ёслол: — Яг тиймээ! Би Генрих фон Гольдринг мөн гэдгээ танилцуулах завшаан тохиолдлоо гэсэнд хурандаа сандлаа огцомхон түлхэж бас босоод — Яагаад тэр билээ? Хаанаас гарч ирэв? гэж гайхан лавлав. — Би одоохон танд учрыг хэлье. Харин тантай хоёулахнаа яримаар байна ... гэсэнд — Боллолгүй яах вэ ... гэж хурандаа хэлснээ туслахынхаа сэжиглэсэн харцтай тулгараад түгдэрч дуугүй болсноо: — Ахмад Коккенмюллер бол миний туслах юм. Надад хэлэх гэсэн юм бүхнээ энэ хүний дэргэд ярьж болно ... Ингэхэд та тамхи татдаг уу? Тамхи тат гэж хурандаа хэлээд ороомол навчин янжууртай хайрцага ширээний зах руу ойртуулж өгөн. Ирсэн залуу дуугүй мэхийн ёсолж, навчин янжуурын үзүүрийг хазаж тастаад Коккенмюллерийн найр тавьж асаасан асаагуураас асааж, хэдэнтаа гүн сорлоо. —

Уучлаарай, тамхи татаагүй удлаа гэхэд нь — Та яарахын хэрэггүй гэж Бертольд бас найр тавин өгүүлэв. — Эрхэм хурандаа тантай уулзах цагийг би даанч удаан хүлээсэн болохоор энэ яриаг ганц мөч ч хойш тавих арга алга ... Бичиг баримт ёсоор бол би Зөвлөлтийн Армийн дэслэгч Антон Степанович Комаров гэдэг хүн ... Миний бичиг баримтыг хурандаа та үзэж танилцсан бизээ. Үгүй, үгүй, хуурамч баримт биш. Энэ дэвтрийг нэгтгэлийн штабаас надад гардуулж өгсөн юм. Үнэндээ бол би Генрих фон Гольдринг байгаа юм. Завшаанаар эрхэм хурандаа тантай урьд маш ойр дотно харилцаатай байсан таны танил барон Зигфрид фон Гольдрингийн хүү юмаа гэж ирсэн залуу яриад хурандаагийн өргөн нүүр өөд ширтэв. Бертольд сэтгэл хөдөлснөө нууж чадсангүй. Туслах нь хүртэл болгоомжлохыг умаргаж орхиод бууны бариулаас гараа өөрийн эрхгүй салгаж, энэ ер бишийн сонин ярианаас нэг ч үг гээлгүй сонсоё гэсэн шиг их биеэрээ урагш тонгойв. — Барон фон Гольдрингийн хүү яагаад улаан армид орсон байдаг билээ? Та яагаад Комаров нэртэй болов? Та суу л даа. Болвол ядраа биз, бас сэтгэл чинь хөдлөөд байгаа биз, аргагүй гэж хурандааг өгүүлэхэд — Нээрээ сэтгэл догдолж байгаа үнэнээ танд хэлье. Миний нас залуу боловч энэ завсар даанч их юм үзэж өнгөрүүлээ. Бас тантай ингэж уулзах цагийг даанч удаан хүлээлээ. Эрхэм хурандаа та үүнээс арай тодорхой ярихыг сонсох завтай байгаа бол ... Ай би, явж явж үнэн нэрээ хэлж чадах болсондоо туйлын их баяртай байгаад минь итгэж болно ... гэв, — Таны нэрийг сонсоход надад ч гэсэн тааламжтай байна. Энэ нэрийг дуулаад миний сэтгэл яаж хөдөлснийг та мэдэхгүй байна. Идэр залуудаа үерхэж явсан хамгийн дотно найзынхаа ганц хүүтэй уулзана гэдэг! Үнэнч сайн ажилтны хүүтэй уулзана гэдэг! Бас тэгээд ийм нөхцөл байдалд шүү! Генрих фон Гольдринг! гэж хурандаа ярив. — Би энэ нэрээ удтал мартаж хэрэгтэй болсон юм. Одоо таны амнаас энэ нэрээ дуулаад аавын минь эелдэг сайхан дуу санаанд орж байна. Харин би ... би ... гээд Генрихийн нүдэнд нулимс гүйлгэнэв. Үүнийг Коккенмюллер ажиглаад аягатай ус авч өгсөнд залуу ганц амьсгаагаар залгилж орхиод жаахан тайвширч, үргэлжлэн ярьсан нь: — Миний эцэг Зигфрид фон Гольдринг дэлхийн нэгдүгээр дайн дууссаны дараахан тэр үед тантай хамт нэг газар ажиллаж байсныг эрхэм Бертольд та бэлхнээ мэдэж байна. Таны мэдэх тэр газрын дарга хурандаа Александрын тушаалаар мянга есөн зуун хорин найман онд манай эцгийг Орос оронд томилон явуулсан юм. Бн тэгэхэд долоол настай байсан. Гэсэн ч зуны нэг орой нэг том өрөөнд таны дэргэд нэгэн гоо үзэсгэлэнт хатагтай сууж байсныг тодхон санаж байна. Тэр бол та манай эцгийг хүндэтгэн Вильгельмштрассын хорин наймдугаар байшинд байдаг байрандаа урьж, салах ёслолын үдэшлэг хийсэн нь тэр гэж манай эцэг хожим нь надад ярьж өгсөн юм. Эцэг маань Орос оронд очсон хойноо салах ёслолын үдэшлэгийн тухай ярихдаа энэ хаягийг хэлж өгсөн нь эндүүрээгүй биз? гэв, Бертольд түүний яриаг тасалж, — Та тун ой сайтай хүн юм байна. Танай эцэг тэр үед төргүй жаал байсан тантай хамт ирснийг саяхан өнгөрсөн явдал шиг тодхон санаж байна. Та одоо нэгэнт насанд хүрсэн ч гэсэн, тэр орой томчуул биднийг зугаацуулж баясгасан жаал хүүгийн төрх танд бас байна. Таны царай таньдаг хүнийх шиг санагдсан нь ийм учиртай байж л дээ. Таны уруул Зигфридийнхтэй яг адил юм. Том царайдаа хэтэрхий багадсан жимгэр уруултайсан. Таны царайн төрх илүү нарийн, нүдний чинь харц эцгийгээ бодвол эхтэйээ илүү адил юм байна. Тийм болохоор таныг харсан даруй таньж чадсангүй ... За уучлаарай, би урьдын явдлыг дурсан санаж

сэтгэл хөдлөөд таны яриаг тасалдуулчихлаа гэсэнд — Миний сэтгэл эрхэм хурандаа таныхаас илүү догдлоод байна. Тийм болохоор хүүхэд байх цагийнхаа явдлыг дахин бага зэрэг дурсан ярихыг зөвшөөрнө үү. Ингэвэл танд ч гэсэн биднийг явахаас өмнөхөн үеийн зарим байдлыг сэргээн санахад тус болно биз. Бидэий эх нутгаасаа явсан цагийг та санаж байна уу? Мянга есөн зуун хорин найман онд эцэг маань Зөвлөлт Орос улсад гадаадын мэргэжилтэн гэж очсон шүү дээ, тиймээ? гэсэнд хурандаа толгой дохиж — Тэр үед большевикууд гадаадын мэргэжилтнийг дуртай урьдаг байсан юм. Манай тагнуулын албанд алт шиг үе байж билээ! Даанч тэр үе хурдан өнгөрчихсөн юм гэв. — Гэхдээ бүүр тэр үед ч гэсэн болгоомлжлох арга хэмжээ авах хэрэгтэй байсан юм билээ. Тийм учраас манан эцгийн диплом Бауэрийн пүүсийн тодорхойлолтод Залесский гэдэг нэр тавьсан байна. Польш гаралтай Станислав Залесский гэдэг хүн гэж бичсэн байсан. Миний нэрийг бас өөрчилсөн. Явахаас бүүр өмнө эцэг маань миний жинхэнэ нэр Генрих биш, Юзеф гэдэг гэж өдөр болгон чи одоо герман биш, польш хүн болсон хэмээн ятган хэлж байсныг одоо болтол санаж байна гэж залуу ярилаа. — Тэр зэрлэг бүдүүлэг оронд таныг авч очсон нь тэнэг хэрэг болсон юм гэж Берггольд хэлэв. — Ээжийг нас барснаас хойш эцэг маань надаас салахаа больсныг та мартав уу. Ер нь манай эцэг Орос оронд тодорхой даалгавар авч очоогүй, тэнд аль болох удаан үлдэх үүрэгтэй очсон шүү дээ ... — Би таныг манайд орхиод яв гэж Зигфридэд хэлж байсан юм ... — Та болгоомж алдаж, энэ тухай миний дэргэд яриа үүсгэж билээ. Би дуу тавин уйлж, аавын ханцуйнаас зуурсныг та санаж байна уу? — Яасан сайхан ойтой хүн бэ! гэж Берггольд бахархан дуу алдав. — Таны гэргий Эльза авгай аав та хоёрыг загнаж билээ. Фрау1 Эльза энх мэнд үү? — Бидний уулзсаныг дуулаад баярлана даа. — Фрау Эльзад миний өмнөөс чин сэтгэлийн мэнд хүргээрэй. Бас охиндоо мэнд хүргээрэй. Би танай охиныг гэзгээс нь угзарч залхаадаг байж билээ ... Алтан үстэй Лора гэдэг жаалхан охин байсансан ... — Өө, одоо Лора маань эрд очих болсон том хүүхэн. Цаг гэдэг хичнээн хурдан өнгөрнө вэ! Хурандаа Берггольдын сэтгэл бүүр уярчээ. Хажууд нь Коккенмюллер байсан болохоор л Лора охиныхоо тухай дэлгэрэнгүй ярьж түвдсэнгүй, охиныхоо тухай ярих хорхойг сэтгэлийн их хүч гарган дарлаа. Тэгээд царай нь ердийнхөөрөө хэнэггүй тайван байдалтай болов. Хурандаа захирагдсан хүмүүсийнхээ дэргэд ийм төв царайтай байхыг мүндирийнхээ бүх товчийг товчилсон байх ёстойн адил албан ёсны үүрэг гэж үздэг билээ. Хурандаагийн санаа сэтгэл өөрчлөгдөхийг Генрих ажиглаж мэдээд цааш нь сэтгэл уярам элдвийн үг оруулалгүй товчхон ярьсан нь: — Би эрхэм хурандаа таны цагийг их авчихлаа. Тэгэхлээр одоо товчхон яриад танд өгөх илтгэх хуудсандаа юм бүхнийг тодорхой бичье, Манай эцэг эхлээд Донбасст цахилгааны мэргэжилтэн инженерээр ажиллаж байсан. Дараа нь түүнийг Уралд шилжүүлсэн юм. Тэгснээ мянга есөн зуун гучин онд том усан цахилгаан станцын барилга тийш оросуудын ярьдгаар «хаясан» юм. Чухам ямар газар гэдгийг ноён хурандаа та мэднэ. Яг тэр үеэс эхлэн манай эцэг тантай шууд радио холбоо барихын хамт манай тагнуулынхнаар дамжуулан шуудан харилцаатай байсан гэж эцэг маань хожим ярьж байсан юм гэжээ. — Яг үнэн. Бид маш нягт холбоотой ажиллаж, бие биеийнхээ ажилд сэтгэл хангалттай байсан юм гэж хурандаа өгүүлэв. — Мянга есөн зуун гучин дөрвөн онд эцэг маань дээд дарга нарынхаа тушаалын дагуу Алс Дорнодод шилжиж очихыг хичээх болсон юм. Тэр үед бүр Оросын харьяат болчихоод байсан юм. — Түүнийг би мэднэ. — Гэтэл Алс Дорнодод

очсоны дараа тантай шууд холбоо тасарсан. Бүх холбоог таны мэдэх тусгай хүмүүсээр дамжуулдаг байсан ... гэхэд Бертгольд дуугүй толгой дохив. — Мянга есөн зуун гучин долоон оноос бн эцэгтээ идэвхтэй тусалдаг болсон юм. Мэдээг нууц тулхүүрээр бичих, авсан зааврын нууц түлхүүр тайлахыг аав надад зааж өгсөн юм. — Энэ ч Зигфрид шиг туршлагатай хашир тагнуулчид байж болшгүй хөнгөмсөг хэрэг ээ гэж хурандааг хэлэхэд — Гэсэн ч манай эцэг дэндүү их ажилтай, даанч цөөн туслагчтай байсныг эрхэм хурандаа та зөвшөөрөх бизээ. Түүнээс гадна эцэг маань намайг Германы үнэнхүү эх оронч болгож хүмүүжүүлсэн болохоор ямар ч нөхцөл байдалд нууц задруулахгүй гэж итгэж байсан юм хэмээн Генрих эцгээ өмөөрөв. — Цааш нь ярь, ярь гэж хурандаа урамшуулан хэллээ. — Бүх ажил тун бүтэмжтэй явж байтал мянга есөн зуун гучин найман онд гай болж, чекистүүд манай нууц уулзалтын байранд хүрэх мөрийг илрүүлэн олж, тагнуулчдыг баривчилсны дотор аавыг илчилж магадгүй хүмүүс байсан. Инженер Залесскийн нэр зүүсэн манай эцэг зугтах аргагүй байсан боловч ямар ч атугай намайг аврахаар шийдээд өнчин хүүхэд асрах газар хүмүүжсэн Антон Степанович Комаров гэсэн нэртэй баримт бичиг, комсомолын гишүүний батлах олж өгөөд Одесс хотод явуулсан юм. Би тэнд очоод цэргийн сургуульд орж, дайны өмнөхөн төгссөн. Цэргийн сургуульд сурч байхдаа эцэгтэйгээ шуудангаар харилцах аргагүй байсан нь мэдээжийн хэрэг. Эцэг маань хааяа нэг агент тагнуулаар дамжуулан өөрийнхөө тухай товч мэдээ өгдөг байлаа. Хамгийн сүүлд эмгэнэлт мэдээ ирлээ. Аав надад энэ баримт бичгүүдийг явуулаад тусгай цаасан дээр хэдэн мөр юм бичиж явуулсан байв. Тэр зурвастаа нэгэнт илэрсэн учир баригдахаас өмнө хор идэж үхэхээс өөр аргагүй боллоо гэж бичээд большевикуудаас өшөөгөө аваарай гэж надад гэрээсэлсэн юм, Генрих ингэж яриад хоолой нь зангирсанд Коккенмюллер дахин савтай ус руу ухасхийлээ. Бертгольд босож, толгойгоо гудайлган, хэсэг зуур зогсов. Генрих уснаас нэг балгаж, аягыг цааш түлхээд уруулаа зоримог жимийж: — Эрхэм хурандаа танд маш их баярлалаа. Цааш нь ярихыг зөвшөөрнө үү ... Би хамаг амьдралаа Герман эх орныхоо төлөө зориулахаар тангарагласан боловч эцгийнхээ оронд ажиллах аргагүй байсныг та мэдэж байна. Аятай цагийг хүлээж суухаас өөр аргагүй байлаа. Гэтэл дайн эхэлж, аятай цаг ойртлоо. Намайг фронтод салаан даргаар томилсон. Би герман хэл мэддэгийгээ нуугаад байсан л даа ... Хэд хоногийн өмнө олзлогдсон герман офицерыг байцааж байх үед би санамсаргүй тааралдлаа. Тэгэхэд л би хүүхэд ахуй цагаас чихэнд дассан таны танил нэрийг сонссон юм. Бас таныг корпусын штабт ажиллаж байгааг олж мэдлээ. Тэгээд цааш юу болсныг та бэлхнээ мэдэж байна ... гэж ярив.

— Та энэ тухай мэдээгүй бол яах байсан бэ? гэж хурандаа! асуухад — Би герман цэрэгтээ ирж нийлэхээр аль эртний шийдсэн юм. Олзлогдсон герман бага даргыг байцааж байхад сонссон зүйл маань санасан хэргийг хурдатгасан даа. Бн ийм азтай сайхан завшааныг ашиглахгүй байж чадсангүй. Та бол манай эцгийн дотно найз, намайг хүүхэд байхын мэдэх болохоор намайг удаан хянаж шалгахын хэрэгцээ байхгүй болно шүү дээ! — Зүйтэй л байна, хүү минь. Гэхдээ ... баахан осолтой ажил хийжээ. Чамайг алчихаж болох байсан шүү. — Би тэгж бодоод их айж байсан. Тэгэхдээ би үхэхээс айгаагүй юм шүү, эрхэм хурандаа. Харин өөрийн цусан барилдалгаат герман цэргийн суманд үхэх болов уу, намайг дайсантай хамт булчих болов уу эцгийнхээ өшөөг

авч чадалгүй зээлдмэл нэртэй үхэх болов уу гэж айсан юм ... — Аа тэр аргагүй. Одоо чи өөрийнхнийхөө дунд ирсэн хойно ... — Төрсөн гэр орондоо буцаж ирсэн юм шиг санагдаж байна. — Тийм, тийм. Миний амь үрэгдсэн найзын хүү намайг хоёр дахь эцгээ гэж тооцож болно. — Би ингэнэ гэж итгээгүй байсан юм ... Ай эрхэм хурандаа! Миний дотор одоо юу болж байгааг та мэддэг ч болоосой. Таны өмнө дэлгээстэй байгаа эцсийн захидалдаа эцэг маань надад таныг олж уулзаарай, юм бүхэн дээр таны үгэнд орж яваарай гэж гэрээсэлсэн юм ... Эцэг хүний үгэнд орж яв гэсэн үг байна шүү гэж би одоо хэлж чадах боллоо. Генрих ингэж хэлээд босон харайж, урагшаа нэг алхсанаа тээнэгэлзэн зогссонд Бертольд өөрөө дэргэд нь хүрч ирээд залуугийн хоёр гарыг чанга атган. Бертольд суудалдаа буцан суугаад түрүүчийн бичгийг дахин үзсэнээ: — Энэ бичигт өв хөрөнгө гэж дурдсан нь юу юм бэ? гэж асуув. — Эцэг маань Орос руу явахдаа үл хөдлөх хөрөнгөө худалдсаныг та мэднэ. Тэгээд мөнгөнийхөө заримыг герман банкинд, гол хэсгийг нь Швейцарийн үндэсний банкинд хадгалуулсан юм. — Бүгд хэдий хэр юм бэ? — Хоёр сая жаахан гаруй марк гэсэнд — Оо-ёо! гэж Коккенмюллер өөрийн эрхгүй уулга алдав. — Аав чинь чамайг аз жаргалтай амьдралаар хангаж дээ, Генрих минь гэж Бертольд хөөрөн өгүүлэв. — Би амьдралаа Герман эх орондоо зориулах ёстой шүү дээ! — Аа тэр тэгэлгүй яах вэ. Энэ тухай бид чамайг амарч, сэтгэл тайвширсан хойно маргааш ярья ... гэж Бертольд хэлснээ Коккенмюллерт хандаж, Ахмад та бүх зүйлийг аялуул. Бароныг миний байрны дэргэд оруулаарай. Бас зохих хувцас хунар бэлтгэж өг. Ер нь ... гэсэнд — Эрхэм хурандаа та санаа бүү зовогтун. Барон фон Гольдрингийг гомдоохгүй үйлчилнэ гэж ахмад хариулжээ. — Барон фон Гольдринг гэж дуудах нь миний чихэнд хөгжмийн эгшиг шиг, бага байхдаа сонсоод мартсан хөгжмийн эгшиг шиг сонсдож байна шүү. Одоо энэ хувцсыг тайчаад хаячихвал би энэ дэлхий дээр дахин төрснөөс өөрцгүй санагдах бизээ гэж Генрих хэлсэнд — За тэгвэл тэрнийгээ бушуухан амжуулж үз. Коккенмюллер чамд тусалж, юм болгоныг хангаж өгнө гэж хурандаа хэллээ. Генрих хурандаад ёслоод Коккенмюллерийг даган гадагш гарах гэснээ тээнэгэлзэн зогсож: — Эрхэм хурандаа та уучлаарай. Бас нэг юм асууя. Тэр нэг орой миний унагааж орхисон ерөнхий сайд Бисмаркийн баримал бүрэн бүтэн үү? гэсэнд — Бүтэн, бүтэн. Чи удахгүй өөрийнхөө нүдээр үзнэ гэж найдаж байна хэмээн хурандаа өгүүлжээ. Генрихийг гарснаас хойш Бертольд цонхны дэргэд очиж, цэлийтэл онгойлгоод алс тэнгэрийн хаяаг удтал ширтэв. Намрын лүглэгэр бараан үүлс дорно зүгээс газар дээгүүр намхан нүүгэлтэх нь моддын орой, 1—Ц хэлтсийн албан байрласан сургуулийн дээвэр, сургуулийн хашааны эсэргэн талд байгаа модон сүмийн хазайсан оронг шүргэн шүргэн алдана. Энэ бүхэн бүүр залхааж, ой гутмаар авч удахгүй өөрчлөгдөх нь магад! ... Өнөөдөр үнэхээр азтай сайхан эхэллээ! Гиммлертэй ярьж, их учиртай уг дуулаад байтал барон фон Гольдрингийн хүүтэй бас учирлаа. Генрихийг Эльза, Лора хоёртойгоо заавал уулзуулах юм шүү. Энэ бүгд эцэстээ юу болж дуусахыг хэн мэдэх билээ гэж хурандаа бодолхийлнэ. Хурандаа энэ өдөр сурсан зангаа хоёрдахь удаагаа орхиж, элдвийг мөрөөдөв. Хурандаа мундирээ дугтран засаж, нуруугаа цэх болгон царайгаа төв ихэмсэг дүртэй болгоод буйдангийн түшлэгт зоосон дөрвөлжин толь тийш ойртож очихыг харваас их л алсуур юм хүсэн мөрөөдсөн нь илт. Толь дотор жижигхэн бор нүдтэй, шаргал хөмсөгтэй, угаараа нарийхан атал үзүүр нь монцойсон хамартай, малийсан өргөн нүүртэй ихэрхэг дүр харагдав. Хурандаа «la Adolt» 2 маягийн

шаргал сахлаа сойздож засаал буйданд ойртож очлоо. Одоо толь дотор толгой нь үл харагдах боловч их бие нь харагдав. Хар захтай, төмрийн өнгөт мундир нь түүний чийрэг мөр, өргөн цээжийг эвтэйхэн барьж, цайвар өмд нь ганц ч үрчлээгүй гөлчийхийг хараад хурандаа сэтгэл хангалттай болжээ. Сайтар цэвэрлэсэн урт түрийтэй савхин гутал нь гялалзана. Цэргийн хүн аян дайнд яваа цагт ч гэсэн ийм л өөгүй цэвэрхэн байх ёстой гэж бодно. Үнэхээр хурандаа Берггольд өнөөдөр ийм азтай эхэлсэнд сэтгэл өег байлаа. — Юм болгон урагштай, юм болгон бүтэлтэй байна! гэж хурандаа ганцаар яриад алгаа үрж, ширээ рүүтээ очоод Генрихийн бичиг баримтыг дахин үзлээ. Вильгельм Берггольд германы тагнуулд он удаан жил алба хаасан болохоор ямарваа хүнд өчүүхэн төдий ч итгэхээ бүрмөсөн больжээ. Хүн бүхнийг эрт орой нэгэн цагт гестапогийн мөрдөн байцаагчид өчиг мэдүүлэг өгөх ёстой гэмт хэрэгтэн байж магадгүй гэж сэжиглэдэг, хүн болгон шунахай эрх ашгийг юу юуны өмнө урьтал болгоно гэж боддог байна. Берггольд нэгэн цагийн сэтгэлийн хөөрөлд хөтлөгдөн урьдаас бодож боловсруулсан төлөвлөгөөгүйгээр Генрих фон Гольдрингийг халуун дотно байдалтай угтан авчээ. Юу вэ гэвэл тийм төлөвлөгөө зохиож байх амжил болсонгүй, Гэвч сүүлд нь өөрийн зан байдлыг цэгнэж үзээд хөгшин Зигфридийн ариун цагаан сэтгэлтэй, уян зөөлөн найзын дүр үзүүлэн тийм чадварлаг жүжиглэсэндээ өөрөө өөртөө баярлаж, сэтгэл хангалттай үлджээ. Чухам ийм дүр үзүүлэх нь хурандаад хамгийн илүү ашигтай байв, Хэрэв дагаар орж ирсэн хүн өөрийгөө барон фон Гольдрингийн хүү гэсэн нь шалгалтаар нотлогдоод тэр хүү эх оронч сэтгэлдээ хөтлөгдөн хүрч ирсэн нь үнэн байвал Берггольд энэ залууд ч гэсэн, командлалынхаа өмнө ч гэсэн сайн хүн болж үзэгдэх нь лав. Берггольдын ийм буянт үйл бүтээснийг хүмүүс шагшин ярьж, ухаантай цэцнээр барахгүй, шударга журамт элгэмсэг хүн гэлцэх болно. Генрих фон Гольдрингийн тухайд гэвэл өөрийн нь ачийг насан турш санаж явах болно. Харин фон Гольдринг гэдэг нэрийн цаана дайсан этгээд нуугдаж байгаа бол Вильгельм Берггольд өөрөө дайсны сонор сэрэмжийг алдагдуулан түргэн зуур илчлэхийн тулд аятайхан аргадсан болж, мөн л туршлагатай хашир тагнуулч гэдэг алдар нь улам батжих болно. Аль нь ч байсан Берггольдод хожоотой. Зугтаж ирсэн хүний бичиг баримт, эцэгтэйгээ төсөөтэй байдал, хамгийн гол нь хүүхэд байх цагаа мартаагүй санаж яваа жижиг сажиг зүйлс, энэ бүхэн нь Вильгельм Берггольд үнэхээр багынхаа найзын хүүтэй хамгийн түрүүнд уулзсаныг гэрчилнэ, Гэвч шалгахад илүүдэхгүй, Ийм юман дээр өөрийн зөн билэгт ч итгэж болохгүй. Нэг удаа алдаж эндсэнээс гурав дахин шалгасан нь дээр. Түүнээс гадна Генрих фон Гольдринг Зөвлөлт Холбоот Улсад шингэчихэж болох байсан атал Германы талд ирэх болсны учир нь хараахан тодорхойгүй байна. Уг нь хорин нэгэн настай залуу хүн эцгийнхээ өшөөг авах гэж хүссэн ч юм уу, эсвэл герман эх оронч сэтгэлтэй болж хүмүүжсэн бол эх орондоо буцаж ирэхийг хүссэн байж болох юм. Гэвч гол учир нь үүнд байгаа хэрэг биш дэг. Швейцарийн Үндэсний банкинд хадгалуулсан хоёр сая маркад хамаг учир нь бий дэг. Генрих фон Гольдринг цаашдаа ч Зөвлөлт Холбоот Улсад үлдэж, хүний нэр зээлдэн суусан бол энэ их өв хөрөнгийн барааг харж чадахгүй байсан. «Эсвэл энэ чинь өв хөрөнгөө авч орхиод Орос оронд буцаж очих л гэж ирсэн юм биш байгаа даа? Үүнийг манай тал руу зориуд илгээсэн байж ч магадгүй еэ?» Берггольд ингэж элдвийг эргэцүүлэн бодож тээнэгэлзсээр байгаад шөнөжин унтаж чадсангүй. Тэгээд өглөө эртлэн бослоо. Юм бүхнийг аль болох хурдан тодруулах хэрэгтэй болжээ. Хурандаа

дотроо нэг сайхан юм бодож төлөвлөөд байгаа билээ. Залуу, цэвэрхэн сайхан барон бас ... хоёр сая марктай. Лоратайгаа суулгахад юу нь эс болох вэ? Үүнээс илүү нөхөр олодохгүй. Бертольд хэрэг явдлыг түргэтгэхийн тулд өөрөө шууд гардан эрхлэхээр шийдлээ. Тагнан мэдээлэх хэлтсийн дарга ахмад Кубисийг дуудан ирүүлж, Одесса хотын явган цэргийн сургуулийн сонсогч Антон Степанович Комаровын тухай бүх мэдээ сэлтийг цуглуулах тушаал өгөв. — Гүйцэтгэлийг надад өөрт минь илтгэ. Удаашруулж болохгүй аль болох хурдан гүйцэтгэх хэрэгтэй гэж хурандаа хатуу тушаажээ. Кубисийг агент тагнуултай холбоо барьж байх завсар Бертольд өөрөө өөр шугамаар шалгалт хийлээ. Берлин дахь тагнуулын газрын архиваас Зигфрид фон Гольдрингийн хувийн хэргийг нэхэмжлэв. Хэрэв Генрих эцэгтээ тусалж байсан нь үнэн бол үүнийг олж тогтооход хялбархан бөлгөө. Одоогоор Генрих фон Гольдринг тун даруу төлөв байлаа. Генрих хэзээ ч өөрийн дураар Бертольд дээр орж ирдэггүй, бүхэл өдөржингөө сонин уншихаас өөр ямар ч юмыг онцлон сонирхдоггүй, хааяа хуучин архивын бичиг л үздэг байжээ. Олон жил хол хөндий байсан эх орон нь юугаар яаж амьдарч байгааг мэдэх гэж хорхойтож байгаа болохоор тэгэх нь хир бизээ. Бертольд анхны уулзалтаас хойш барагцаалбал долоо хоногийн дараа Генрихийг гэртээ дуудав. Бертольд хоёр хүний хоол бэлтгүүлж ширээн дээрээ архи дарс тавилаа. Гольдринг гоёмсог хэрэгслээр сайхан зассан ширээг харж сонирхоход нь сэтгэл ханасан хурандаа: — Чи надтай хамт хоол идэхгүй юу? гэвэл — Ай эрхэм хурандаа! Би гэр орны тохилог байдал, герман хэлээ хичнээн их санаж, ер нь соёлт боловсон байдлыг хичнээн их санасныг минь та мэдсэнсэн бол ингэж асуухгүй байсан болов уу гэсэнд — За тэгвэл сайн байна. Суу. Юу уух вэ? Ер нь асуух ч юу байх вэ. Бодвол орос архинд дассан байлгүй дээ. Би ч гэсэн үнэнээ хэлэхэд орос архинд дуртай. Манай шпанстай зүйрлэх юмгүй шүү гэхэд нь, — Таныг зөвшөөрвөл дарс ууя. Би ерөөсөө архи уудаггүй юм ... гэв. Энэ үг хурандаад баахан сэжиг төрүүлэв. Хурандаа өөрөө тагнуулчдад зан байдлын тухай заавар өгч, ялангуяа хөлчүүрүүлэх ундаан хэрэглэхгүй байх нь тагнуулч хүний нэг тэргүүний үүрэг гэдгийг бишгүй олон сургаж хэлдэг билээ. — Ерөөсөө архи уудаггүй юм уу? гэж хурандааг лавлахад — Нэг хундага коньяк, нэг аяга цэвэр дарснаас илүү уудаггүй юм гэсэнд — Дарс байна. Коньяк одоо авчирна гэж Бертольд хэлээд үйлчлэгч цэрэгт зохих тушаал өгөв. Хоол идэж дуусах ойртож, Генрихийн хацар нь архи уусандаа улайгаад байсан үед Бертольд огт санаандгүй байдлаар асуусан нь: — Генрих ээ! Чи Нечаевын хэргийг санаж байна уу? гэсэнд — Василий Васильевич уу? Аав бид хоёрын сууж байсан Алс Дорнодын тэр хотын улс төрийн газрын дарга байсан уу? гэж лавласанд — Тийм, тийм гэж Бертольд батлав. — Саналгүй яах вэ! Би тэр хүний чинь тухай нэргүй захиа бичсэн юм шүү дээ. — Тэр хэргийн гол утгыг ярьж өгнө үү. — Нечаев ан хийж яваад манай эцэгтэй танилцсан юм. Хожим хоёулаа анд үе үе хамт явдаг болсон. Гэтэл мянга есөн зуун гучин долоон оны үед Нечаев манай аавыг сэжиглээд байх шиг санагдах болсон байна. Бидний ажлын тухай материал олж авсан байж магадгүй гэж аав айгаад тэр Нечаевыг дөнгөхөөр шийдсэн юм. Тэгээд аав нэргүй захиа зохиож, би хуулж бичээд улс төрийн ерөнхий газрын дээд байгууллагад явуулсан. Тэр захидалдаа Нечаевыг энэ районд ажиллаж байгаа японы тагнуултай холбоо барьж нууц мэдээ дамжуулахын тулд ойд ан хийх нэрийдлээр явж байна гэж бичсэн юм. Нэргүй захидалд бичсэнийг үнэмшээд Нечаевыг баривчилсан. Нечаев түүнээс хойш

чухам яасныг аав огт мэдэж чадаагүй гэж Генрих ярив. — Хүн удмаа дагадаг гэж үнэн юм байна шүү. Чи эцгийгээ дууриасан ой сайтай хүн байна. Тагнуулч бидэнд ой сайтай байна гэдэг хамгийн тэргүүн зэргийн зэвсэг байдаг юм, Чи эндээс очсон тушаалын нууц түлхүүрийг тайлах, мэдээг нууц түлхүүрт оруулахад эцэгтээ тусалдаг байсан гэж ярьж байсан. Би өчигдөр хуучин бичиг хараа үзэж суутал санамсаргүй нэг сонин бичиг дайралдлаа. Энэ байна. Үүнийг үзээд чиний санаанд юм орно уу? гэж Бертольд хэлээд цаг удаж нэгэнт шарласан хуудас цаасыг Генрихт өгөв. Тэр хуудсан дээр дөрөв дөрвөөр нь янз янзаар хослуулан бичсэн гуравхан мөр тоо байжээ. Генрих тэр тоог анхааралтай үзэж суух зуур Бертольд санаа амарлингуй тамхи татаж, зочныхоо бодлогоширсон царайг үе үе харж суулаа. Энэ бол ийм нууц түлхүүр дээр олон жил ажилласан хүн л гүйцэтгэж чадах их хүнд даалгавар гэж хурандаа лавтай мэдэж байжээ. Нилээд удаан сууцгаав. Бертольд арай дэндүү нарийн төвөгтэй аргаар шалгав уу даа гэж харамсаж суулаа. Үнэндээ дөрөв таван жилийн өмнө ердөө хэдхэн удаа хэрэглэсэн нууц түлхүүрийг мартахагүйн тулд хашир туршлагатай тагнуулч байх хэрэгтэй. Түүнээс биш, тагнуулчид тусалж байсан залуу хүн яаж таниж чадаа аж. Эцэст нь Генрих толгойгоо өндийлгөж, гунигтайхан инээмсэглээд — Энэ бичиг энд байсан юм бий. Аав энэ мэдээг их хүлээж, зөндөө зовсон юмсан. Хүлээж ядаад өөрөө бие даан шийдвэр гаргаж, өөрийнхөө санаснаар ажиллах болсон юм. Бүх ажлыг нэгэнт гүйцэтгэчихсэн хойно л түүнд талархсан товч мэдээ эндээс явуулсан байсан. Энэ чинь «Таубе» ажиллагааг явуулах заавар мөн байна шүү дээ. Оросууд тайгад нууц завод байгуулж байгаа тухай манай эцгийг мэдээлсний дараа эндээс «Барилгын эхлэлтийг бүхий л аргаар саатуулах хэрэгтэй» гэсэн хариу өгсөн юм. Тодорхой үүрэг өгнө гэсэн боловч түүнийг нь бид хүлээж ядсан билээ. Тэгээд аав өөрөө «Б—49» агентаар дамжуулан «Таубе» ажиллагааг гүйцэтгүүлсэн юм. Тэр тагнуулч ажилчдын суух саравчнуудыг шатааж, ажилчид нь тарж зугтсан ... Тэгээд түүнээс хойш таван жил өнгөрсөн хойно тэр үед бидний тэсэж ядан хүлээж байсан зааврыг би одоо гартаа бариад сууж байна гэж хэлээд гунигтайяа толгой сэгсэрч, юм бодож суулаа. — Чамайг гунигт муу юм дурсахад хүргэснийг минь уучлаарай. Гэвч тагнуулч бид чулуун зүрхтэй, хатан болд сэтгэлтэй байх ёстой юм шүү гэж Бертольд хэлэв. Бертольд Генрихээс Дорнодод ажиллаж байсан тухайг нь асууж, хүмүүсийн нэр овог, цаг хугацаа, баримт зэргийг сонирхон удтал ярилцлаа. Генрих ч дуртайяа хариулж, өнгөрсөн юмыг нэхэн дурсах нь сайхан санагдсан мэт байжээ. Генрихийг шөнө орой болсон хойно явсны дараа Бертольд соронзон хальсанд буулгаж авсан зүйлийг Берлинээс ирүүлсэн бичиг баримттай тулган шалгаж удтал суув. Зигфрид фон Гольдрингийн 1937 оны тайлан мэдээ нь 1941 оны намар Генрих фон Гольдрингийн ярьсныг бүрэн дүүрэн нотолж байлаа. Ингэхлээр Бертольд найзынхаа хүүг үрчлэхээр шийдсэн нь зөв болсон байжээ.

АНХНЫ АЮУЛ, АНХНЫ ДААЛГАВАР Генрих фон Гольдринг дороос нь шөвгөөр хатгасан юм шиг орноосоо огло үсрэн босов. Генрих фронтын шугам давж ирснээс хойш өнгөрсөн хэдэн долоо хоногийн дотор шинэ байдалд ер дасаж чадахгүй, айдгийгаа авдартаа хийсэн гэж нэг л итгэхгүй байжээ. Үнэндээ юм болгон өөрт нь, урагштай, тэр ч байтугай тун бүтэмжтэй байлаа. Чухам ийм урагштай байгаа нь аюултай хэрэг биш биз? Юм бүхэн санасанчилан бүтээд байхлаар хүний анхаарал суларч, хэлэх үг, хөдлөх

аашаа цаг алгасалгүй хянаж цагдаж байдгийгаа болино. Наад зах нь хурандаа Бертольд өөрт нь дэндүү элэгсэг найртай байгаа нь жигтэй юм биш биз? Генрихт офицер цол олгоогүй байхад ажил байдалтай танилцуулсан нь ямар учиртай юм болоо? Хурандаа Бертольд корпусын дарга дэслэгч генерал Иорданы дэмжлэгийг авсан л даа. Тэр генерал залуу барон фон Гольдрингийн хувь заяаг ихэд сонирхож, Генрихт офицер цол олгох тухай ерөнхий командлалд өөрөө асуудал тавьж хөөцөлдсөн байна. Зөвлөлтийн офицерын сургууль германыхаас дутуугуй мэдлэг олгодог гэж генерал Иорданы хэлсэн нь зөв байжээ. Генрихийг штабт үлдээж, мөн 1—Ц хэлтэст Бертольдын шууд удирдлагын дор ажиллуулахаар шийдэхдээ генералтай ярилцаж тохиролцсон байж таарна. Тэгэхээр энэ талаас онцын аюулгүй бизээ. Гэтэл яагаад сэтгэл битүү түгшээд өөртөө сэтгэл дундуурхан байна вэ? Генрих сүүлийн хэдэн хоногийн явдлыг нэгд нэгэнгүй эргэцүүлэн бодож үзлээ. Генрих штабын бүх офицертой найрсаг харилцаа тогтоохын оронд хэлтсийн ажлыг шууд судалж эхэлсэн нь алдаа болжээ. Өөрт нь атаархаж, өөрийг нь нүд үзүүлэж, тэр ч байтугай баахан хардаж сэрдэж байгаа нь зүйн хэрэг. Өглөөний найман цаг болсон атал тасалгаанд таг харанхуй хэвээр. Цонхны цаана бороо хөшиглөн шаагиж сааралтана. Генрих тамхи асааж аваад дахин орондоо орж, өчигдрийн бүх явдлыг өчүүхэн жижиг зүйл ч үлдээлгүй бүгдийг нарийн нягт сэргээн санах. Генрих өглөө болгон ийнхүү боддог нь өглөө босоод нүүр гар угаахтай адил заншил болжээ. Өчигдөр их тэмдэглэлтэй өдөр боллоо. Юу вэ гэвэл Генрихт Германы армийн дэслэгч цол олгоход энэ учралыг тохиолдуулан Бертольдын зөвлөснөөр 1—Ц хэлтсийн офицеруудад зориулж үдэшлэг хийлгэв. Генрих өөрөө үдэшлэгийн эзний хувьд офицеруудын гуанзны үүдэн дээр офицеруудыг тосон уулзахад тэд нар ямаршуу хайхрамжгүй ихэмсэг мэндэлж байсныг санах. Гэтэл Бертольдыг хундага өргөсний дараа зочдын зан байдал хичнээн өөрчлөгдсөнийг яана! Бертольд үнэндээ их сайхан хундага өргөж, чухмыг хэлбэл товч оршил үг хэлсэн байна. Хурандааг тийм уран үгтэй хүн гэж Генрих огт санаагүй юмсанж. Бертольд залуу бароны эх орныхоо өмнө байгуулсан гавьяаг эвтэйхэн цухуйлгаж дурдаад эх орондоо олон эрэлхэг тэмцэгч, байлдан дагуулагчдыг төрүүлж өгсөн фон Гольдрингийнхны удмын уламжлалын тухай ярьжээ. Бас хурандаа өөрийн найз Зигфрид фон Гольдрингийн гавьяа зүтгэлийн тухай хэдэн үг хэлэхийн ялдамд залуу бароны эцгийн нь оронд эцэг болохыг их нэр төртэй хэрэг хэмээн үзэж байгаагаа тэмдэглэв. Энэ сүүлчийн үг нь штабын офицеруудад их сэтгэгдэл төрүүллээ. Бүгд босоцгоон хундагаа дээр өргөж, Зигфрид фон Гольдрингийн гэгээн дурсгалыг хүндэтгэн уугаад дараа нь хурандаа Бертольд, Генрих хоёрын төлөө хундага өргөв, Ингээд байдал даруй өөрчлөгдөж, офицерууд Гольдрингт хүйтэн хөндий, илт ихэмсэг дээрэлхүү хандах нь болилоо.

Бас Зигфрид фон Гольдрингийг хүүдээ яруу алдарт нэрээ үлдээгээд зогсоогүй, хоёр сая гаруй маркийн өв хөрөнгө үлдээснийг хурандаа үгийн далимд дурссанаас хойш үдэшлэгт оролцогчдын нүднээ өөрт нь ая тал зассан байдал илэрхий байгааг Генрих ажиглав. Генрихийн төлөө олон хундага өргөлөө. Үдэшлэгт оролцсон хүн бүр хамт ажиллах шинэ нөхрийнхөө дэргэд очиж, найзлах хүсэлтэйгээ илэрхийлэхийг өөрийн үүрэг гэж үзжээ. Үдэшлэгийн төгсгөлд офицерууд бүгдээрээ халамцав. Ийм үед

нийтийн яриа тасардаг болохоор цугласан хүмүүс хэсэг бүлгээрээ тасарч, хэсэг бүр аль дуртайгаараа наргиж, уух нэг нь ууж, алиа хошин үг ярилцах нэг нь ярилцаж, нөгөө зарим нь ямар нэг юмны тухай цэц булаалдан маргалдаж, бас зарим нь дэмий балай, завхай самуун үг хэлж хундага өргөхөөрөө уралдан архиралдацгааж байв. Генрих найрсаг зочломтгой эзний ёсоор хэсэг бүхнийг дамжин хэсэг бүрийн дэргэд хэдэн мннут саатан сууж байлаа. Тэгж байтал хошууч Шульц, ахмад Кубис гэдэг хоёр офицерын ярилцахыг санамсаргүй сонсов. Шульц нь их л агаархсан байдалтай: — Манай хурандаа мөн азтай хүн юм даа. Энэ залуу бароны эцгийн оронд эцэг нь болох гэж улайж байхыг харав уу! Хурандаа энэ залууг охинтойгоо суулгаж аваад хоёр сая маркийг нь талхны хоёр заводтайгаа нийлүүлнэ гэж би мөрий тавих байна. Тэр цагт Кубис чи бид хоёрыг байтугай, алба тушаал ахихыг ч нулимж орхино доо! гэхэд нь Кубис инээд алдаж, — Шульц чи охингүйдээ харамсаж байна уу? — Өө ямай байнаа! Охин ч хэрэггүй, хоёр сая марк ч хэрэггүй, өндөр албан тушаал ч хэрэггүй. Би энэ хорвоо дээр нүцгэн төрсөн, хорвоогоос мөн нүцгэн чигтээ талийна. Ингэж байснаас архи уусан нь дээр. Энэ дайн бушуухан дуусаж, чи бид хоёр Орос оронд нэг нэг засаг захиргааны албан тушаалтай болох болтугай гэж ууя, Тэгвэл чи бид хоёр овоо хөлжинө шүү ... Харин саяын энэ «Төмөр нударга» шиг юм болоод байвал ч ... гэв. Генрих улам чих тавин чагнаж байтал тэр хоёрын дэргэд хурандаа Берггольд ирж, цаад хоёр нь дуугүй болсноос Генрих тэр «Төмөр нударга» гэдэг ажиллагааны дүнг олж мэдэж чадсангүй. Энэ хурандаа даанч хэрэггүй цагаар хүрч ирлээ. За яах вэ, тэр ажиллагааны дүнгийн тухай мэдээ хэлтэст байгаа биз. Генрих сэжиг төрүүлэхгүйн тулд өөрөө мэдье гэж хэрэг болгон сонирхоогүй байж байтал «Төмөр нударга» ажиллагааны тухай санамсаргүй олж мэджээ. Генрихт Гитлерийн армийн дэслэгч цол олгохоос хэдэн хоногийн өмнө түүнийг Берггольд дууджээ. Шөнө орой болсон хойно дуудсан болохоор үнэндээ Генрихийн сэтгэл их түгшээд элдвийг эргэцүүлэн бодож зориуд удаан хувцаслав. 1—Ц хэлтсийн дарга бас л эргэлзсээр байна гэж үү? Эсвэл эргэлзээгүй байтал нэг шинэ юм гарч ирэв үү? Чухам юу байдаг юм бол оо? Хурандаа бүр анхнаасаа үл итгэх байдал мэдэгдсэн бол дээр байжээ. Тэгвэл Генрих эрх ашгаа хамгаалан Берггольдтой бүүр анх уулзахдаа үнэнээ хэлсэн гэдгийг нотолж, хууль ёсны эрхээ нэн даруй сэргээж өгөхийг шаардаж болох байсан. Ингээд юм бүхэн ёсоороо болж, хэрэг нэг тийшээ шийдэх байсан юм. Гэтэл одоо шөнө дунд босон харайж, элдэв хүнд бодлоор тархиа зовоож байхад хүрч байна. Коккенмюллер, даргыгаа шөнө орой болтол ажилтай байх үед ажил дээрээ байдаг заншилтай болохоор тэндээ баахан бичиг цаас онгичиж суулаа. Генрих гэнэт орноос нь дуудаж босгосны учир нилээд сэтгэл түгшиж гайхсан байдлаар: — Намайг ноён хурандаа дуудав уу? гэж асуухдаа Коккенмюллерийн царайны байдал буюу хариу хэлэх дууны өнгөнөөс Берггольдын чухам юун тухай дуудсаныг тааварлах гэж найдсан байна. Хурандаагийн туслах ерийн зангаараа хүйтэн хөндий, дуу цөөтэй байлаа. — Яаралтай хэрэг гарсан бололтой гэж ахмад хэлээд босож, автомат цоожны түлхүүрийг эргүүлэв. Берггольд ширээ тохойлдон зогсоод газрын том зураг үзэж байлаа. Хурандаа нэг ажиллагааны төлөвлөгөө судалж байгаа нь харангуут илт байна. Тэгээд дээш бололгүй: — Түр хүлээгээрэй гэж хэлэхэд нь — Би жаахан хожимдсон бололтой. Уучлаарай. Коккенмюллер дээр хүлээж байх уу? гэж Генрих лавласанд — Чи харин ч цагаас арай эрт ирсэн байна. Би одоохон завтай болно. Энд

хүлээж байна биз. Ингэхэд өчигдөр орой надад авчирч өгсөн тэр шальгүй эдийг үзэхгүй юу гэж Бертольд хэлээд тасалгааны булан руу заав. Тасалгааны баруун буланд байгаа сандал дээр үнэт чулуу шигтгэсэн сүмийн алтадмал тосгуур байхыг Генрих сая л ажиглаж харлаа. Сандлын дэргэд алгуурхан дөхөж очоод тосгуурыг болгоомжлон гартаа авч анхааралтай үзэхэд нь, — Аятайхан эд байна уу? гэж Бертольд асуух зуур газрын зургаа хуйлав. — Ёстой л урлагийн бүтээл байна шүү. Таны энэ шальгүй эд гээд байгаа юмны үнийг ч багцаалж чадахгүй юм байна. Энэ чинь музейн үзмэр байна. Тэгэхээр үнэ тогтоох аргагүй. Хуучны эд юмс цуглуулагчийн хувьд таны нарийн мэдлэгтэйг шинээр олж авсан энэ зүйл чинь харуулж байна гэж Генрих хэллээ. Хурандаа сэтгэл хангалуун инээмсэглэсэн боловч юу ч хариулсангүй. Тэгээд тасалгаан дотуур элдэвт санаа зовсон хүний байдалтай нуруугаа үүрч нааш цааш нүсэр алхална. Хурандаагийн царай удах тусмаа улам улам барайж байгааг Генрих ажиглаад сэтгэл түгших нь бас нэмэгдлээ. Хурандаа Бертольд энэ тосгуурыг үзүүлж гайхуулах гэж шөнө дунд болж байхад дуудаагүй нь лав шүү дээ. Үнэхээр ч 1—Ц хэлтсийн дарга цуглуулгаа яаж арвитгахыг бодоогүй, харин Генрихийг ашиглах алс хэтийн төлөвлөгөөгөө бодож байсан юмсанж. Хэд хоногийн дараа Генрихт офицер цол олгох тухай тушаал ирэх ёстой. Ингээд Генрих Райхын харьяатаар батлагдаж, Зигфрид фон Гольдрингийн хөрөнгийг залгамжлах ганц хүн гэсэн эрхээ сэргээн эдлэх болно. Бертольд өөрөө туслаагүй бол энэ хэрэг ийм амархан, ийм түргэн бүтэхгүй л дээ, Энэ бол хурандаагийн сэдэж байгаа тоглоомд гол хөзөр болно!

Харин хурандаа ямар нэг юман дээр эндсэн байвал яана? Хоёр сая маркад толгой нь эргээд анхнаасаа буруу зүйлээс иш авч, буруу ташаа дүгнэлт хийсэн байвал яана? Тэгвэл сүйрчээ, бүүр сүйрч! Үгүй, тийм байх ёсгүй. Нарийн нягт шалгасан шүү дээ. Бас ярьсан бүхнийг нь соронзон хальсанд буулгаж авсан. Даанч Зигфрид фон Гольдрингийн хувийн хэрэгт Генрихийн хурууны хуаюур үлдээгүй нь харамсалтай. Тагнуулын ажиллагааны дүрэм ёсоор тагнуулчийн өөрийн нь хурууны хуаюурыг авахаар барахгүй, хамт явах гэр бүлийнхний нь хуаюурыг авах ёстой шүү дээ. Нэг нь мартаж орхисон юм уу, эсвэл үрэгдүүлсэн бололтой. Энэ бол гэмт хэрэг хийснээс өөрцгүй салан задгай явдал болжээ. Бертольд ч өчигдөр Берлинд ингэж мэдэгдсэн байна. Одоо тэгээд маргашгүй баримт хэрэглэхийн оронд сэтгэхүйн бас нэг дайралт хийх төдийгөөр сэтгэл ханах хэрэгтэй болж байна, Генрих маш сайн ойтой хүн юм. Гэсэн ч энэ залуу бага балчир насныхаа юм бүхнийг тэр болгон санахгүй байж ч болно. Тэгэхлээр хурууны нь хуаюур архивт бий гэж итгүүлэх хэрэгтэй юм. Генрих ямаршуу байдалтай авирлах бол? Шөнө ингэж дуудсанд Генрих сэжиглэж байгаа нь лав. Хэрэв хурууны хуаюур өгөхөөс айх шалтгаан бий бол биеэ эзэмдэхэд тийм амаргүй л байх ёстой ... Хурандаа ингэж бодож байснаа гэнэт Генрихийн өмнө очиж зогсоод: — Чамайг шөнө орой болсон хонно дуудсанд гайхаж байгаа биз дээ? гэж асуув. — Гайхахаар барахгүй, сэтгэл жаахан түгшиж байна, Чухам юу болоо вэ? гэж асуусанд — Өө гойд юм байхгүй. Ёсыг дагуулах нэг ажил байна. Энэ жаахан эвгүй ч гэсэн чиний бүх бичиг баримтыг бүрмөсөн шийтгэж олгоход зайлшгүй хэрэгтэй юм гэв. — Би ч хоёрын хооронд байдалтай байсаар бүүр залхаж гүйцлээ. Тэгэхээр хичнээн эвгүй байлаа ч гэсэн ёсыг дуртайяа дагах байна. — Чиний юу бодож, яаж тэсэж ядаж байгааг ойлгож байна. Тийм болохоор төвөг

чирэгдлээс бушуухан салж үзье ... Чи хурууны хуаюурын тухай мэдэх үү? Германаас явахын чинь өмнө чиний хурууны ... гэхэд нь — Намайг явахын өмнө миний хурууны хуаюурыг авсан гэж та хэлж байна уу? Чухам яалаа, бодоодхоё ... гэж Генрих хэлээд магнайгаа илж байснаа, Үгүй, санахгүй байна гэлээ. — Чи гойд ой сайтай ч гэсэн зарим юмыг мартах учир бас байдаг юм шив дээ гэж Бертгольдыг хэлэхэд — Ай даа, хүүхэд байхад сонирхсон юмаа л тогтоодог юм. Би тэр явдлыг тоглоом гэж бодоод анхаараагүй өнгөрсөн байж болох юм. Хэрэв миний хурууны хуаюурыг авсан байгаад жаал хүүхдийн хуаюурыг сонирхох хүн байсан юм бол тэр биз дээ гэсэнд — Үүнийг тагнуулын байгууллага л сонирхсон хэрэг юм. Аз болоход хуаюур нь үлдсэн байна гэв. — Таны ямар ёс гүйцэтгэнэ гэж яриад байгааг одоо л ойлголоо гэж Генрих хэлээд дургүйцсэн байдалтай ярвайж, дал мөрөө хавчив. — Үүнийг одоо ч гэсэн тоглоом гэж бод. Ер нь тоглоомноос өөрцгүй албан ёс юм даа. Надад ч гэсэн тун эвгүй, тун гомдмоор байна ... Энэ ажлыг гаднын хунд мэдэгдэхгүй гэж би өөрөө гүйцэтгэхээр болсон гэж Бертгольдыг хэлэхэд — Эрхэм хурандаа тантай учирсан мнө яасан их аз вэ! гэж Генрих хариулжээ. Бертгольд ширээннй дэргэд очиж, шургуулга дотроос хэвлэлийн шинэхэн будаг гялалзсан төмөр ялтас, бяцхан хэсэг цаас гаргаж ирээд — За хүү минь нааш ирээд баруун гараа надад аль. Эрхий хуруугаа сунгаад алга тийшээ дар. Ингээд ... гэж хэлэх зуур сурамгай хөдөлж. Генрихийн хурууг ялтас дээр хажуугаар нь тавьж, аяархан дарсхийгээд эргүүлэв. Ингэхэд эрхий хурууны дотор талд хэвлэлийн будаг жигдхэн наалдлаа. Дараа нь Бертгольд Генрихийн хурууг цаасан дээр дарсанд тольгор цагаан цаасан дээр хурууны хуаюур тодхон гарлаа. Бүх хурууны хуаюурыг авч дуусахад хурандаа сая нэг амарсан янзтай санаа алдав. Генрих энэ сорилтыг давсан болохоор Вильгельм Бертгольд эндүүрээгүй байж! Генрих ч гэсэн сэтгэл хангалуун байв. Энэ бүх үйлдлийг гүйцэтгэх завсар түүний урт нарийн хурууны нэг нь ч чичирсэнгүй. Газрын зураг дахин дэлгэж байгаа хурандаад хандаж: — Би одоо явж болох уу? гэсэнд — Явж болно. Надад багагүй ажил үлдээд байна. Манай штабт энэ ажиллагааг «Төмөр нударга» гэж сүржин нэрлэсэн юм. Тэгэхлээр дайсныг базах нударга маань нээрээ төмөр нударга гэсэн нэрэндээ таарахаар болтол ажиллах хэрэгтэй байна гэж хурандаа хэлэв. Генрих тэр зургийг нь харсан ч үгүй, хурандаад өөрийгөө ажлаар ингэж их дарж байгаад нь харамслаа илэрхийлж, мэхийн ёслоод гадагш гарав. Генрих хурдан зуур хувцаслаж, үйлчлэгч цэргийгээ орж ирэхэд бэлэн зэлэн болсон байлаа. — Ноён дэслэгч ээ, цайгаа зооглох уу? гэж асуухад нь — Аяга кофе, махтай зүсэм талх л хэрэгтэй байна гэв. Үйлчлэгч цэрэг нь зэмлэсэн янзтай толгой сэгсэрсэн боловч Генрихийн хүйтэн харцтай тулгараад олон үг ярилгүй цай бэлтгэж эхлэв, Шинэ ажилтны мэдэлд Коккенмюллерийн явуулсан шар үстэй туранхай Эрвин Бреннер Генрихийн санаанд таарсангүй. Ялангуяа хүний өөдөөс эгц харахгүй ямагт дальдарч, ийш тийш гөлөлзөж байдаг, муурын нүд шиг жижигхэн шаравтар нүд нь эвгүй сэтгэгдэл төрүүлнэ. «Үүнийг солих хэрэгтэй юм байна» гэж Генрих бодлоо. Генрих нэг аяга кофе хурдхан ууж орхиод штабт очив. Генрих онцгой даалгавар гүйцэтгэх офицерын хувьд хурандаагийн шууд мэдэлд байх бөгөөд өглөө бүр даргаасаа ямар нэг даалгавар авах гэж очдог билээ. Бертгольд одоо болтол ивгээлдээ байгаа залууг ажлаар нэг их дарсангүй. Түүний аар саар даалгаврыг штабаас гаралгүй гүйцэтгэж болох ажээ. Гэвч дээр өгүүлсэн үдэшлэгийн өмнөхөн Генрихт нилээд төвөгтэй, хариуцлагатай даалгавар удахгүй өгнө

гэж сануулсан юм. Бертольд хэдийн албан тасалтаандаа сууж байв. Даргын нь сэтгэл нэг зүйлд догдолсон байхыг Генрих нэн даруйд ажиглав. — Ирсэн чинь маш сайн банна. Чиний хойноос хүн явуулах гэж байсан юм гэж хурандааг хэлэхэд Генрих цагаа хараад: — Одоо яг есөн цаг болж байна, ноён хурандаа. Тэгэхлээр би нэг ч минут хожимдсонгүй. Та өнөөдрийнхөө ажлыг их эрт эхэлж дээ гэсэнд — Бас тийм ч аятай биш эхэллээ гэж хурандаа ууртайяа бавтнахад — Фронтос сэтгэд зовмоор мэдээ ирээ юү? гэж Генрих санаа зовнингүй асуув. Бертольд хариу хэлэлгүй, тасалгаан дотуур алхалж байснаа Генрихийн урд ирж зогсоод түүний өөдөөс эгцлэн анхааралтай ширтэж: — Чи «Төмөр нударга» гэж нэрийдсэн ажиллагааны төлөвлөгөөг мэдсэн үү? гэж асуухад нь, — Тийм ажиллагаа явуулна гэж танаас сонссон. Гэсэн ч би штабт албан ёсоор батлагдаагүй, ерөөс манай армийн офицер цол ч аваагүй байсан болохоор түүнийг сонирхох эрхгүй гэж бодсон юм ... Манай штабын ажил хэргийг хайхрахгүй байгаагийнх гэж та битгий санаарай. Ердөө л ямарваа ажилд захирагдагч хүний давж болохгүй тодорхой зааг байх ёстой гэж би үздэг юм. Тэр заагийг мэдрэхгүй бол жинхэнэ сахилга бат байхгүй. Би бол багаасаа эцгийнхээ тагнуулын ажилд тусалсаар байгаад энэ зарчмыг баримталж сурсан юмаа гэсэнд хурандаа сэтгэл амарсан янзтай санаа алдаад, — Тийм ч гэж мэдсэн юм! гэжээ. — Чухам ямар хэрэг явдал болоо вэ, хэлж өгөөч! Өнөөдөр таны сэтгэлийг догдолгосон эвгүй явдал надаас боллоо гэж үү? гэсэнд хурандаа, Генрихийг сугадаж, хамтаар тасалгаан дотуур яваад — Шууд чамаас болсон юм биш. Хүү минь, манай штабын офицеруудын дотор бусдыгаа урагштай өөдтэй явбал өөрийн аж байдал, алба тушаал, нийгмийн доторхи байдал, тэр ч байтугай эмэгтэйчүүдэд тоогдоход саад тотгор болсон хэрэг гэж боддог тийм хүн байдаг нь тоогүй. Өөр бусдад үргэлж атаархаж явдаг тийм хүн ойр дотныхондоо, төвөг гээр болох учрал тохиолдвол төвөг удаж байдаг байна. Тэгвэл өөрсний нь аз жаргал алдар нэр, хөрөнгө мөнгө нэмэгдэх юм шиг санадаг байна шүү гэлээ.

— Тэр ч тийм л дээ. Харин надад ямар хамаатай юм бол оо? — Чамд атаархаад байгааг ойлгохгүй байна уу? Тэгээд чамайг хорлох гээд байгаа юм. — Би одоо бүр юу ч ойлгохоо байлаа, эрхэм хурандаа. Хэн надад атаархаж, хэн намайг хорлох гээд байгаа юм бэ? Би энд ирээд хэдхэн долоо хоног болох энэ завсар хүнд гэм хийсэнгүй, гэм хийх санаа ч байсангүй. Нэг ч хүнийг гомдоогоогүй шиг санах юм. Бас энэ бүхэнд «Төмөр нударга» ажиллагаа ямар хамаатай юм бэ? Эрхэм хурандаа та надад бүх учрыг хэлж өгнө үү. — Тайвшир! Чамд учрыг хэлж өгөлгүй яах вэ. Энэ бүх намтар чиний сэтгэл догдлоод баймаар ч юм биш. Харин чи хэлчих, хошууч Шульц та хоёр ямар харилцаатай байдаг вэ? гэхэд нь Генрих гайхаж, — Хошууч Шульцтэй юу? Өндөр нуруутай, махлаг зузаан биетэй, жимгэр уруултай хүн үү? гэвэл — Сүрхий онож байна гэхэд нь, — Би түүнтэй өчигдөр үдэшлэг дээр л анх удаа ярилцсан. Тэгэхдээ хундага өргөсний нь хариуд талархаж хэдхэн үг сольсон юм. Урьд нь бид хоёр мэндтэй зөрөх төдий байсан. Тэгэхлээр сайн, муу харилцаатай байдаг гэж яриад байх юм огт алга гэлээ. Хурандаа юм бодсон байдалтай, тайрмал сахлаа имэрч байснаа Генрихийн гарт хүрч, намайг дага гэж нүдээрээ дохиод ханын дэргэд очиж, цэргийн стратегийн ажиллагааны том газрын зураг халхалсан хөшгийг яраад их л нухацтайгаар өгүүлсэн нь: — Ийм учиртай явдал болоод байна. Өчигдөр өглөөний дөрвөн цагт штабын «Төмөр нударга» гэж нэрлэсэн

өнөөх ажиллагаа эхэлсэн юм. Чамд хэрэг явдлын учрыг ойлгуулахын тулд үзүүлж тайлбарлая гээд Бертгольд заах мод авч, Яг энэ хэсэг дээр танкийн хоёр бригадаар дэмжүүлсэн манай хоёр дивиз өчигдөр давшилт хийж эхэлсэн юм. Моторжуулсан хоёр хороо давшин цохилт өгөх бүлгийн бэлтгэл болж, энд байрласан юм. Манайхаас урагшаа байгаа хэсэг дээр генерал Корндорфын командалсан зэргэлдээх цэргийн бүлгийн нэг дивиз дайсны анхаарлыг сарниулж хүчийг нь бие тийшээ татах зорилгоор зургаан цагийн түрүүн давшилт хийж эхэлнэ гэж болзож тохироод байлаа Ер нь дайсны хүч тийм их биш, бас түрүүчийн тулалдаануудад суларсныг бид мэдэж байсан юм. Манай фронтын энэ хэсгийг оросууд одоо болтол хоёрдугаар зэрэгт үзэж байлаа. Энэ нутагт зам хүрэлцээгүй, нэлэнхийдээ их намаг бамбалзууртай. Зөвлөлтийн командлал чухам энэ хэсгээр манай цэргийг давших бололцоогүй гэж тооцож байгааг бид мэдлээ. Үүнийг бас шуурхай тагнуул, байнгын тагнуулын мэдээ ч гэрчилж байлаа. Дээр хэлсэн дивиз, танкийн бригадууд гэнэтийн цохилтоор энэ нутагт зөвлөлтийн цэргийн фронтыг сэтэлж, бүсэлж аваад цаашаа Калинин хот орох зам нээх ёстой байлаа. Манай командлал бүх тооцоогоо санамсаргүй байхад нь гэнэдүүлэн дайрахад үндэслэж зохиосон юм. Бэлтгэлийг нууцаар хурдан зуур хийсэн. Байлдааны ажиллагааны төлөвлөгөөг тоотой цөөхөн хүн мэдэж байсны дотор би бас мэдэж байсан билээ. Байлдааны ажиллагааны төлөвлөгөөтэй газрын зураг корпусын штабт нэг, цохих бүлгийн даргад нэг, надад нэг байсан юм гэж ярив. Генрих заасан газар бүрийг сонирхон харлаа. Хурандаа үргэлжлүүлэн ярьсан нь: — Өчигдөр орой манай цохих бүлгийн ангиуд давшилт эхлэхээс хэдэн цагийн өмнө энэ районд хүч хуралдсан юм. Энэ хотгорт хоёр дивиз, танкийн хоёр бригад байрлахад маш хэцүү байсныг бодолцох хэрэгтэй. Дэндүү нягт шигүү байрлахад хүрсэн боловч манай командлал ингэхээс өөр арга байсангүй. Гэтэл хэрэг явдал бидний санаснаас огт өөр тийшээ эргэж, давшилт эхлэхээс хоёр цагийн өмнө оросууд энэ хэсэг тийш их буугаар урьд үзэгдээгүй их хүчтэй гал нээж, тэр ч байтугай одоо хүртэл энд байгаагүй тийрэлтэт их буу хэрэглэвээ. Ердөө нэг мөчийн дотор дайсан этгээд манай давшилт хийхээр хүч хуралдсан цэргийг хиартал цохиж, их буугийн гал намдсаны дараа оросууд энэ хэсэг тийш дайрагч хүчний хэдэн арван нисэх онгоц явуулдаг байна. Тэгээд нисэх онгоц бүүр зүйл дуусгах нь тэрээ. Нисэх онгоц далд орж амжаагүй байтал манай бут цохигдсон ангиудын үлдэгдлийн урдаас оросын танк, моторжуулсан явган цэрэг гарч ирээд түрүүнд их буу, нисэх хүчин хоёрын цохилтын дараа амьд мэнд үлдсэнийг чухам л газрын хөрснөөс арчаад хаячихлаа. Аз болоход оросууд энэ ялалтаа ашигласангүй, хуучин байрлалдаа эргэж очсон. Корндорфын дивиз ч гэсэн бас л туйлын хүнд байдалд орсон байна. Учир нь оросууд манай цохих бүлгийг зүйл дуусгаж орхиод бүх бэлтгэл хүчээ тэр дивиз тийш хаясан байна. Тэр дивизийг, чухамдаа гэвэл үлдсэн цөөн хэдийг нь ерөнхий командлалын бэлтгэл хүчин очиж аварчээ гэж яриад хурандаа газрын зургийн дэргэдээс холдож, зөөлөн сандалд суув. Өчигдөр бид чамд офицер цол олгосны баяр гэж наргиж байх үед оросууд ажил явдлаа бүүр дуусгаж байжээ. Хэдэн офицерыг, түүний дотор намайг үдэшлэг дээрээс шууд штабт дуудаж аваачсаныг чи ажигласан байж магад гэж хурандааг хэлэхэд, — Та нарын гарахыг ажигласан. Зүгээр л амрахаар гарсан юм байх гэж бодсон гэж Генрих хариулбал — Аа тийм байсан ч болоосой! гэхэд нь, — Эрхэм хурандаа таны харамсах нь хэр. Харин энэ «Төмөр нударга» надад ямар хамаатай юм

бэ? гэж Генрих тэсгэлгүй асуув, Хурандаа шууд хариулсангүй. Хэлэх үгээ урьдаар сайн бодох гэсэн шиг алчуур гаргаж нүүрээ удаан нягт нямбайлан арчсаныхаа эцэст — Ийм юмаа. Оросууд энэ хэсэг дээр давшилт хайх гэж төлөвлөөгүй байсан байна. Тэгээгүй бол оросын цэрэг анхныхаа байрлалд буцаж очилгүй, цаашаа ахих байсан. Оросууд манай төлөвлөгөөг мэдэж аваад их буу, нисэх хүчин, моторжуулсан явган цэргийн хүч хуралдуулжээ гэдэг дүгнэлт аяндаа гараад ирнэ. Миний саяын чамд ярьсан газрын зурагнуудаас гадна ... зөвлөлтийн командлалд бас нэг зураг байсан бололтой гэж болгоомжтой ярьж эхлэхэд Генрих огцомхон тасалж, — Уухай, тэгээд хошууч Шульц тэр дөрөв дэх зургийг Оросуудад намайг өгсөн гэж сэжиглэж байгаагаа хэлсэн юм шив дээ? Тийм үү? гээд сандлын түшлэгийг шажигматал чанга атгав. — Хаанаас даа, тиймэрхүү үг цухуйлгах л гэж оролдсон юм хэмээм хурандааг хэлэхэд — Би түүнийг ална! гэж Генрих хилэгнэн дуу алдав. Генрихийн царай нь зөвхийрч, уруулаа тас жимийгээд нүд нь улаанаар эргэлдэж, гар нь маузерымхаа гар тийш огцомхон хөдөллөө. Генрихийг ухаан жолоогүй хаалга тийш ухасхийхэд нь хурандаа босгон дээр хүчээр зогсоогоогүй бол гараад гүйх байсан бизээ. — Зогс! Чи цэрэгт байгаагаа мартав уу? гэж хурандаа Берггольд сүртэй хашгираад Генрихийн гараас маузер бууг нь хүчээр салган авч гэрэнд нь буцаан хийж товчлоод, — Тайвшир, Шульцийн цухуйлрасан битүү үгийг хэц ч тоож анхаараагүй гэж чамд хэлж байна шүү. Бүгдээрээ түүнийг учир утгагүй балай үг гэж үзээд штабын дарга хошууч генерал Даниель Шульцэд сануулга өгсөн. Би өөрийнхөө тухай бол хэлээд ч яах вэ. Шульц бүр энд, зөвлөлгөөн дээр олны нүүрэн дээр учраа хэлж, уучлал гуйхад хүрсэм юм гэлээ. Генрих лаг хийтэл сууж, толгойгоо бариад шал гөлрөн уруу царайлав. Хурандаа үргэлжлэн ятгаж: — Ингэсэн нь дээр! Жаахан сууж, юм бүхнийг тайван бодоод үз. Чи одоо яах гээ вэ? Чи хорин нэгэн настай залуудаа эх орондоо гавьяа байгуулсан, дэслэгч цолтой болсон, дориун их хөрөмгөний эзэн болчихсон байхад Шульц одоо болтол олигтойхон ёслолын дүрэмт хувцас олоод авах чадалгүй байна. Шульцийн мөнгөнд шуналтайг бүгдээрээ мэднэ. Тэгэхлээр өмнө нь алба тушаал ахих ийм сайхан зам нээлттэй байгаа баян залуу хүнд атаархалгүй яах вэ дээ. Түүнийг огт тоосны хэрэггүй. Би чамайг мэдэж аваг гэж энэ бүх намтрыг ярьсан юм. Мааинь энд хов жив, нууц мэдүүлэг туйлдаа хүртэл дэлгэрээд байгаа юм. Чамд улс атаархаж байна. Хойшид хаана, юу хийж явсан ч атаархах болно гэхэд нь — Би тэр Шульцтэй ярина даа! гэж Генрих шүд зуун өгүүлсэнд — Даргын чинь хувьд тэгж болохгүй гэж тушааж, эцгийг чинь орлох гэж байгаа хүний хувьд зөвлөж байна. Чи түүнийг тоохгүй байж болно. Харин энэ тухай ярих хэрэггүй ... Юу ч мэдээгүй юм шиг байгаарай. За юу? гэхэд нь — Харин ... гэсэнд — «Харин» гэх юмгүй. Жаахан ч үг цухуйлгахгүй гэж надад офицер хүний ёсоор андгайл гэхэд нь Генрих дуугарсангүй. — Чи андгайлах уу? гэхэд нь — Эрхэм хурандаа ... гэсэнд — Би чамайг офицер хүний ёсоор андгайлахыг шаардаж байна. Би чиний эцгийн найз төдий биш, чиний дарга гэдгийг дахин хэлье гэхэд нь Генрих дуртай дургүй: — За яах вэ, энэ тухай яриа гаргахгүй гэж офицер хүний ёсоор андгайлъя. Харин учрал тааралдвал Шульцээс хариугаа авах эрхтэй үлдэнэ гэсэнд — За тэгвэл ярьж тохирлоо. Одоо чи бид хоёр учраа ойлголцсон хойно өөр нэг зүйл ярья гэхэд нь, — Та өчигдөр нэг даалгавар өгнө гэж ярьж байсан байхаа? гэвэл — Чухам тэр тухай одоо чамтай ярилцах гэж байна. Анхааралтай сонсоорой. Шинэ ажиллагааны тухай, чухам нарийн хэлбэл ажиллагааны бэлтгэлийн

тухай ярьж байгаа юм. Энэ ажиллагаа нөгөөх бүтэлгүй «Төмөр нударга» гэдгээс хэмжээгээр бага ч гэсэн өөрийн онцлог шинж, бэрхшээл бий. Яагаад вэ гэвэл партизаны томоохон отрядыг устгахтай холбоотой юм гэж хурандаа ярив. — Ердөө энэ үү? гэж Генрихийт урам хугарсан байдалтай дуугарахад — «Ердөө энэ үү?» гэнэ шүү гэж хурандаа дооглон дууриаж хэлээд гэнэт уур нь буцалж, Чи энд саяхан ирсэн болохоор энэ газар ямаршуу түгшүүртэй байдгийг мэдээгүй байна. Фронт дээр бол үүнээс амар. Урд маань дайсан бий гэж мэднэ. Энд бол гудамжинд явсан ч, албан тасалгаанд сууж байсан ч, орондоо унтаж байсан ч минут бүр дайсан хаанаас гараад ирэх бол гэж сэтгэл зовж сууна ... гэхэд нь Генрих тоомсоргүй инээмсэглэж, — Ойлгохгүй байна. Бүх Европоор ялгуусан аялал хийсэн Германы арми ар талдаа үлдсэн партизаны бүлэг дээрэмчдийг устгах хүч хүрэхгүй байна гэж үү? гэсэнд Бертольд эгдүүтэйгээр хөхөрч: — Чи түймэр гарахыг үзсэн үү? гэж гэнэт асуув. — Үзэлгүй яах вэ. — За тэгвэл нэг байшин ч юм уу, тэр ч байтугай бүхэл бүтэн хороо түймэрт шатаж байхад түймэртэй тэмцэж болно. Гал команд хүрч ирээд түймэр гарсан газрыг хүрээлж, түймрийг хэсэг хэсгээр нь дарна. Гэтэл асар их ой модонд түймэр гарвал гал команд дарж дийлэхгүй. Тийм түймэр юм бүхнийг үнс чандруу болтол шатааж байж сая унтарна. Партизаны хөдөлгөөн бол хээр талд гарсан түймэр гэсэн үг ... Үгүй, хуурай модтой ойд гарсан түймэр гэвэл илүү ононо. Тэнд ерийн арга хэмжээ аваад нэмэргүй. Одоо энэ тусгайлан бэлтгэж байгаа шиг жижиг сажиг юм бүхнийг нь нэгд нэгэнгүй нарийн бодож боловсруулсан туйлын онцгой ажиллагаа хэрэгтэй. Чи инээд алдаад байна уу даа? — Миний туршлагагүйг бодолцоод хүлцэхийг хүсье ... — Чамд даалгаж байгаа зүйлийн бүхий л хариуцлагыг гүйцэд ухамсарлуулахын тулд нөхцөл байдлыг тоймлож, бидний авахаар завдаж байгаа арга хэмжээг товчхон танилцуулъя. Марьяновк тосгоноос баруун урагш оросын партизаны томоохон отряд байрлаж байна. Тэр отряд манай корпусын ар талд байгаа болохоор түүнийг устгах нь манай шууд үүрэг. Одоо үүнийг гүйцэтгэх хамгийн тохиромжтой цаг болоод байна. Юу вэ гэвэл бид нөгөө «Төмөр нударга» гэдэг бүтэлгүй ажиллагааны үед бут ниргүүлсэн дөчин дөрөв, арван хоёрдугаар дивизийн үлдэгдлийг өөрчлөн байгуулна. Партизаныг устгахад тэр ангиудыг ашиглаж болно гэж зөвшөөрсөн. Гэвч тэр хүч хүрэлцэхгүй, партизан отрядын хүн хүчний тооны талаар манайд эрс тэс зөрөөтэй мэдээ бий. Юу ч гэсэн тэр отряд нилээд том, зэвсэг сайтай, зөвлөлтийн командлалтай тогтмол харилцаа барьж байдаг нь тодорхон байгаа юм. Энэ бүх нөхцөл байдлын улмаас бид ажиллагаагаа аль болохуйц сайн бэлтгэх хэрэгтэй. Одоо түүний бэлтгэлд чи оролцох тухай ярья. Өөрчлөн байгуулах гэж байгаа зөвхөн тэр хүчинд найдаж болохгүй гэдгийг би хэлсэн. Түүнийг бололцоотой бүх аргаар хүч нэмэгдүүлэх хэрэгтэй. Бид янз бүрийн тосгонд байгаа цагдаа нараар тэгж хүч нэмэгдүүлэх гэж төлөвлөж байна. Бүх цагдаа нарыг дайчилбал бид хоёр батальон байгуулж болно. Түүнийг бас л партизан отрядыг устгахад явуулах юм. — Ашгүй би ганц ч атугай партизаныг нүдээрээ үзэх нь байна! — Партизанууд өрсөөд чамайг харчих вий, мэдээтэй яваарай. Тэд нар тун мэргэн бууддаг, эцсээ хүртэл тулалддаг юм шүү Ер нь хэрэг бүтэлтэй болж дуусах биз гэж найдаж байна. Чиний мэдэлд нэг хөнгөн тэрэг, хуягт машин, хоёр пулемёттой арван таван цэрэг өгнө гэхэд нь Генрих дал мөрөө хавчсан боловч хариу өчсөнгүй. — Одоо чиний үүргийг хэлье. Чи тэр цагдаа нэртэй муусайн новшнуудын байгаа газруудаар явж, байлдааны чадварыг нь шалгах хэрэгтэй.

Эргэж ирээд энэ тухай хүний тоо, зэвсэглэл зэргийг нарийн тодорхойлсон илтгэл бичиж өгнө. Одоохондоо «Ногоон зугаалга» гэж нэрлэсэн ажиллагааг бид хир зэргийн хүчээр эхэлж чадахаа мэдэхийн тулд туйлын оновчтой нарийн мэдээ цуглуулах хэрэгтэй. Ойлгов уу? гэхэд нь — Ойлголоо! ... Эрхэм хурандаа танаас нэг зүйл асуухыг зөвшөөрнө үү ... — Болно. — Та цагдаа нарыг муусайн новш гэж байгаа болохоор тэдний тухай төдий л сайн биш бололтой байгаа юм шив дээ? — Сайн биш гэв үү? Арай дутуу хэллээ, хүү минь. — Тэгвэл тэднийг зэвсэглэж зохион байгуулсны хэрэг юу байна? гэсэнд Берггольд гунигтайхан инээмсэглэж, — Манайд хот суурин газар бүр жинхэнэ цэргээ үлдээж байх хүч хүрэлцэхгүй байна. Нэгдүгээрт энэ. Хоёрдугаарт, хамгийн гол нь цагдаа болсон хүмүүс партизаны заналт дайсан болохоос өөр зам байхгүй. Цагдаа нар ядаж л амиа хоохойлохын тулд партизануудтай тэмцэх хэрэг болно. Цагдаа нарыг их төлөв хэрэг төвөг тарьсан, оросын цэргээс оргосон хүмүүсээс элсүүлдэг нь тоогүй. Цэргээс оргосон хүн бол юуны өмнө аймхай байдаг болохоор ямар цэргийн хувцас өмссөн ч аймхай хулчгар хэвээрээ үлдэнэ гэв. — Тушаалыг хэзээнээс биелүүлж эхлэх вэ? — Хэдэн цагийн дараа явахад юм бүхэн бэлэн болно. Чи өнөө маргааш хоёр шалган байцааж зааварлаад нөгөөдөр өглөө арван цагт илтгэлээ өг. «Ногоон зугаалга» ажиллагааг гэнэт эхлэх болж магадгүй. Цэргийн ангиудыг түгшүүрийн дохиогоор босгоно. Ингэхэд цагдаа нарын түгшүүрийн дохиогоор цугларах бэлтгэлийг хангавал зохино. Энэ нь ялангуяа Подгорный тосгоны районы Цагдаагийн отрядад онцгой холбогдоно. Тэр отрядад чи Подгорныйгоос Ивановка хүртэлх хэсгийн ойг бүслэн хаах тушаал өгөөрэй. Энэ хийх гэж байгаа ажиллагааны тухай хэн ч мэдэх байтугай, ажиг сэжиг авах ёсгүй юм шүү. Ойлгов уу? — Ойлголоо. Явж болох уу? — Явж болно. Сайн амарч авахыг бодоорой ... Байз, бас нэг юм мартаж шахлаа. Өнөөдөр манай гэрээс захиа ирсэн. Энд чамд хамаатай хэдэн мөр байна. Энэ үз гэж Берггольд хэлээд захидлын хэрэгтэй хэсгийг хумсаараа зурж, цаасны дээд талыг нь нугалаад Генрихт өгөв. Генрих тэр зурж тэмдэглэсэн хэсгийг гүйлгэж уншаад хурандааг уярсан нүдээр нэг харснаа дахин нэг удаа яаралгүй уншсаны эцэст — Одоо даруйхан фрау Эльзад захиа бичье. Би одоо захиа бичихэд болно гэж бодож байна хэмээн сэтгэл догдлон дуу алдаад захиаг эргүүлж өгөв. — Энэ ч чиний хүмүүжил сайтайг харуулж байна. Би одоо захиа явуулах гэж байна. Чи хүсвэл хэдэн мөр нэмээд биччих. Чиний тасалгаанд энд суугаад бичихэд болно гэж Берггольд хэллээ.

Генрихийн захиа хэдэн мөрт багтсангүй. Түүний бичсэн нь: *«Эрхэм хүндэт фрау Берггольд оо! Дөнгөж саяхан ноён Берггольдын ачаар би цаг зуур сэтгэл баясан жаргалаа. Таны захидлаас миний тухай бичсэн хэсгийг ноён Берггольд надад уншуулав. Та миний хүүхэд байх үеийг мартажгүй санаж, намайг орь ганцаар үлдсэнийг минь сонсоод эх хүний сэтгэлээр чин үнэнээсээ өрөвдөн хайрласныг тань мэдээд сэтгэл хязгааргүй догдоллоо. Би дахиад гэр бүлтэй болж байгаагаа бодоход сайхан байна. Ноён Берггольд, намайг хүүгээ гэж, би түүнийг эцгээ гэж үздэг болсон. Одоо таны соёрхлоор би ээжтэй хүн гэж бодож явах болно. Надад бас охин дүү бий гэж санаж явбал болох болов уу? Би тантай сүүлчийн удаа уулзах үед хэдийгээр бага балчир байсан боловч намайг сайн сэтгэлээр энхрийлэн хайрладаг байсныг тань мартаагүй, мартаж ч үгүй. Танд олон зүйлийн тухай бичихийг хүсэх бөгөөд биеэр уулзахыг бүр их хүснэм. Тийнхүү тантай*

уулзана гэж бодохоос сэтгэл баярлах юм. Би тантай уулзахыг эрмэлзэн хичээж, түргэн уулзах өчүүхэн төдий бололцоог боловч ашиглана. Тэр болтол танаас бяцхан ч атугай захиа ирүүлэх болов уу гэж найдаж байна. Миний өмнөөс Лораг үнсээрэй. Золтой л «бяцхан Лора» гэж бичсэнгүй. Юу вэ гэвэл миний санаанд бяцхан хүүхэд хэвээр санагддаг юм. Лора өөрөө өгөөмөр сэтгэлээр намайг төрсөн ахын адил үзэж захиа бичвэл би улам их баярлах билээ. Таны соёрхлоор таныг үнсэн ёсолъё. Таны хүү барон фон Гольдринг» гэжээ.

Генрих бичсэн захидлаа хурандаад өгч, — Эрхэм хурандаа та уншаад үзнэ үү. Би арай хэтэрхий зоримог бичээгүй бангаа даа гэж айж байна ... гэсэнд Бертгольд түүний үгийг таслан гар зангаад захидлаас нүд салгалгүй ширтэж, — Чи эх эцгээ хайрлан хүндэтгэдэг хүүгийн ёсоор бичсэн байна гэж сэтгэл уяран өгүүлээд Генрихийг тэврэв. — За одоо яв. Замд гарах боллоо. Автомат авч явахыгаа тун битгий мартаарай гэж хурандаа захилаа. Генрихийг бүр үүдэнд очоод байтал Бертгольд дахин дуудаж, — Чамд нэг сонин мэдээ дуулгахаа мартжээ. Зөвлөлтийн цэргийн шүүх чамайг эх орноосоо урвасны учир эчнээ буудан алах ял заасан байна. Энэ тухай надад ахмад Кубис мэдээлсэн. Кубис байнгын тагнах албаны шугамаар ажилладаг юм. Манай тагнуулын алба тэнгэрийн өршөөлөөр одоо сайн сайн байнгын төлөөлөгчтэй байгаа юм гэхэд нь, — Нээрээ сонин мэдээ байна гээд Генрих тас тас хөхөрснөө гэнэт инээхээ больж, царайгаа төв болгон нүд нь цогтой гялалзаж — Би ямар ч нөхцөл байдалд амь үрэгдэж мэднэ. Харин хэзээ ч Эх орноосоо урван тэрслэхгүй гэдгийг баттай мэдэж байна! гэж хэлээд өсгийгөө тов хийтэл хавсран ёсолж, тасалгаанаас гарлаа. Бертгольдтой ярилцсан нь Генрихийн сэтгэлийг догдлуулжээ. Бертгольдын штабт ажиллаж эхэлсэн анхны үед өчүүхэн ч сэжиг төрүүлэх ёсгүй. Гэтэл тийм хэрэгт сэрдэгдэж байдаг! Хурандааг хурууны нь хуаюур авч байх үед Генрих ширээн дээр байгаа зурагнаас зориуд нүүр буруулсан шүү дээ. «Зөвлөлтийн командлалд тэр ажиллагааны төлөвлөгөөг хэн өгсөн байж таарах вэ? Чухам хэн бэ?» гэж Генрих бодно.

ПОДГОРНЫЙД БОЛСОН ХЭРЭГ ЯВДАЛ Германы цэргийн сүүлчийн бүтэлгүй давшилтын үед бут цохигдсон ангийн оронд шинэ сэргэг хүчин шилжүүлэн авчрахад нь гитлерчүүдэд аль болохоор саад хийж, ямар ч атугай заавал «хэл» барьж авах хэрэгтэй гэсэн ээлжит даалгаврыг Их газраас партизан отрядын штабт радиогоор дөнгөж хүлээн аваад байтал Подгорный тосгонд нэгэн офицероор удирдуулсан германы багшиг отряд ирлээ гэсэц мэдээ иржээ. Тэр отряд германы корпусын штаб байрлаж байгаа Турнавино тосгоноос ирсэн гэж мэдээ хүргэж ирсэн холбоочин батлан хэлэв. Ийм учраас уг отрядыг командалж яваа дэслэгч өөрөө бас штабын офицер байх ёстой гэсэн бодол аяндаа төрөв. Тэгвэл энэ нь боломжтой «хэлнүүдийн» дотроос хамгийн шилдэг сайн нь мөн билээ. Юу вэ гэвэл германы командлалын төлөвлөгөөг штабын хүн сайн мэдэхгүй, өөр хэн мэдэх билээ дээ? Ингээд хоёр ротыг байлдаанд оруулж, Подгорный тосгоныг бүслэн аваад офицерыг нь ямар ч байсан амьдаар олзолж авахаар шийдвэрлэжээ. Бусад тосгоноос ирсэн холбоо баригчдын мэдээлснийг үзвэл вчигдөр тэр тосгонуудад бас нэг хуягт машин, суудлын машин очиж, офицер нь цагдаа нарын отрядыг цутлуулан заавар өгсөн байжээ. Ингэхлээр партизаны эсрэг томоохон ажиллагаа бэлтгэж байгаа нь илт

байлаа. Учир иймд гитлерийн офицерыг олзлон баривчлах нь бүүр чухал болжээ. Подгорныйд байгаа гитлерчүүдийг атаклах үүрэгтэй хоёр сумангаас гадна автоматчидын отряд илгээж, Подгорныйгоос Турнавино, ялангуяа Марьяновка хүрсэн замыг хаах үүрэг өгөхөөр шийдвэрлэсэн байна. Учир нь Марьяновка тосгонд зөвхөн цагдаа нар төдийгүй, герман цэргээс бүрдсэн хүчит гарнизон байрлаж байв. Автоматчидын тэрхүү бүлэгт Турнавино буюу Марьяновкаас германчуудын цэрэгтээ туслуулахаар илгээж болох ангийг саатуулан барих, хоёрдугаарт Подгорныйд байгаа гитлерчүүдийг дайрах үед мултарч амжсан дайсанд зугтан зайлах бололцоо олгохгүй байх, ийм давхар үүрэг хүлээлгэв. Холбоо баригчдын мэдээлснээр дээр хэлсэн машинууд тосгон бүрд цаг хагас буюу хоёр цагаас илүү зогсохгүй байгаа тул байлдааны ажиллагааг нэн даруй эхлэх ёстой болов. Партизаны лагериас Подгорный тосгон хүртэл арваад километр зайтай, үүнээс дөнгөж долоо нь ой модон дотуур, бусад гурав нь задгай цагаан газраар өнгөрсөн байжээ. Байлдааны ажиллагааг биеэр удирдах гэж шийдвэрлэсэн партизан отрядын дарга ойгоос дөнгөж гармагц цэргээ хоёр анги болгож хуваагаад тосгоныг аль болох түргэн бүслэхийн тулд мориныхоо хар хурдаар давхицгаахыг тушаав. Гитлерчүүд аюулыг эрт ажиглаж мэднэ гэж партизаны дарга сэтгэл зовсонгүй. Баруун талаас нь тэдний замыг машин буюу морьтой хүн байтугай явган хүн ч тэр бүр нэвтрэхийн аргагүй их намаг газар таглажээ. Тэр их шигдэмхий намаг дундуур гарсан нарийн жимийг мэдэх хүн цөөн. Ингэхлээр гитлерчүүд нэг бол партизануудын санасанчилан тулгаран байлдах, эсвэл зугтахыг оролдож үзэх, ийм хоёрхон зам байв. Гитлерчүүдийн зугтаж болох хоёр зам хоёул намгийн хажуугаар гарна. Нэг нь умар зүг Турнавино тосгон тийш, нөгөө нь өмнө зүг Марьяновка тоогон тийш хөтөлсөн хоёр зам байгаа. Партизанууд дайсны ухрах эдгээр замыг амжин тасалж, дараа нь жагсаалаа дэлгээд Подгорный тосгон тийш давшихын тулд мориныхоо хурдаар давхисан байна. Генрих Подгорный тосгонд бусад газраас арай удаан саатав. Зам зуур гэдэс нь өлссөн учир гэртээ хоол иднэ үү гэсэн нутгийн цагдаагийн дарга Барановскийн урилгыг дуртайяа хүлээн авчээ. Түүний дээр Барановскийг итгэлтэй хүн төдийгүй, зочдоо, ялангуяа ноён офицеруудыг дайлж чаддаг сайн эзэн гэж районы цагдаагийн дарга вахмистр Вольф хэлсэн байжээ. Генрихийг дагалдан яваа автоматчидын отрядын дарга Вурцер анхандаа Подгорныйд удаан саатахгүй байхыг дэслэгчид зөвлөж, гэгээтэй байхад штабтаа буцаж очихыг шаардсан боловч Барановскийг зочломтгой эзэн гэсэн Вольфын уран ярианд хорхой нь хөдлөөд эцэс сүүлдээ өөрөө ч амттайхан хоол олж идэх завшааныг ашиглахаас буцахгүй болов. Барановский гэдэг өндөр нуруутай, эв дуйгүй биетэй тэр хүн гэрт нь барон хун хоол идэх болсонд баярласандаа хөл нь газар хүрэхгүй хөөрөв. Зочдыг урьж суулгаад чухам юунаас эхлэхээ мэдэхгүй тэвдэн ийш тийш гүйхэд гулжгар бие нь бур ч инээдэмтэй нахилзана. Ханцуй дээрээ зурвас тэмдэгтэй хуучин герман мундир тэр цүдгэр гэдэстэй. мах мяраа ихтэй хүнд хүүхдийн хувцас шиг багаджээ. Цагдаагийн дарга цүдгэр гэдсээ мундирээр яагаад ч нуух арга байсангүй. Дунд талын товч нь байн байн мултарч, дээд, доод талын товч нь товчлоостой хэвээр үлдэхэд дунд талын онгорхойгоор герман мундирт огт зохиогүй хатгамал хээтэй цагаан цамц цухуйж үзэглэнэ. Үлгэр жишээ цагдаа гэж дуулсан тэр хүнийг Гольдринг хараад инээдээ барьж ядан байлаа. Барановский эхнэртээ торойн мах шарж, ер нь энэ бароныг «Берлинд очсон хойноо ч мартахгүйгээр» хоол хийхийг тушаажээ. (Цагдаагийн дарга

Гольдрингийг орос хэл мэдэхгүй гэж бодоод элдэв үг хэлэхээс ичсэнгүй). Үүний дараа Барановский Вольфын тушаалаар нууц мэдээлэгчдийн нэрсийн жагсаалт гаргалаа. Генрих шалган байцаасан тосгон бүрээс тийм жагсаалт гаргуулж авчээ. Жагсаалт бэлхэн болсон хойно Генрих түгшүүрийн дохио өгөхийг тушаав. Гольдринг цаг харж байгаад шалгахад гурван минутын дараа Подгорный тосгоны цагдаагийн отряд бэлэн жагссан байлаа. Гольдринг өөрөө Барановский, Вольф хоёртой хамт жагсаалын өмнүүр явж үзээд — Жагсаалтад хорин гурван хүний нэр байна, Гэтэл хорин нэгэн хүн бэлэн жагсаад байна гэсэнд — Хорин хоёр дахь нь би өөрөө, хорин гуравдахь нь гонхон дээр манаанд бий гэж Барановский долдогонон тайлбарлав. Гольдринг тэр заасан зүг рүү нь харвал тэнд үнэхээр нэг цагдаа зогсоод алсыг анхааралтай дурандаж байлаа. — Танай үүгээр партизан олон ирдэг үү? гэж Генрих асуусанд — Тэнгэрийн өршөөлөөр гайгүй байгаа гэв. Яг энэ үеэр сүмийн гонхон дээрээс манаачийн буу тас хийлээ — Ай эцэг минь! Хэл ам хүрчээ! гэж Барановский уулга алдаад толгойгоо барин доош суув.

Гольдринг Вольфыг дагуулан сүмийн гонхон дээр гүйж гарвал орчин тойронд юу болж байгааг дурантай дурангүй харж болох байлаа. Юу вэ гэвэл өдий төдий морьтой, тэрэгтэй партизан тосгон тийш хар хурдаараа давхилдаж, хэдэн морьтой, хүн, пулемёттой тачанк урагшаа түрүүлэн гарч бүүр ойртож ирэв. Манааны цагдаа доор жагсаж байгаа цагдаа нарыг харж байгаад партизан нар ойртож ирснийг тэр даруйд мэдээгүй бололтой. Гольдринг баруун тийш харвал нишингэ ургасан том намаг үзэгдэв. Генрих хэсэг зуур нүдээ онийлгон нэгэн төлөвлөгөө бодож боловсруулах мэт тэр намгийг ширтэн зогслоо. Үнэхээр нэг юм бодож амжсан бололтой, гонхон дээрээс хурдан зуур гүйн бууж, энэ завсар отрядаа байлдаанд бэлхэн болгоод байсан Вурцерт тушаасан нь: — Цагдаагийн отрядыг өөрийн командлалд авч, автоматчдын хамтаар хойт зүг Турнавино тийш дайрагтун. Тэр чиглэлд дайсны хүч арай нимгэн юм шиг санагдаж байна гэв. — Эрхэм дэслэгч та яах вэ? гэхэд нь — Миний төлөө санаа зовох хэрэггүй, тушаасныг гүйцэтгэ ... гэж Генрих хариулаад Вольфд хандаж, Та надтай хамт яв! ... үгүй. Эхлээд Барановскийнд очиж, миний цувьг аваад ир. Бушуул! гэж тушаалаа. Вольфыг цув авчрахаар явсан хойгуур Генрих цагдаагийн газрын албан тасалгаанд шагайж үзлээ. Дэслэгч энэ хүнд бэрх үед гайхалтай тайван байлаа. Вольфын ширээн дээр орхисон нэрсийн жагсаалттай хавтсыг бушуухан шүүрэн авч ширээний шургуулганд хийв, Вахмистрыг уухилж амьсгаадсаар гүйж ирэхэд Генрих огт ажиггүй янжуураа имэрч байжээ. — Эрхэм дэслэгч ээ, бушуулаарай! Дуулж байна уу? Буудалцаж байна шүү ... гэж Вольфыг хэлэхэд — Буудалцаж л байг. Та бид хоёр байлдаанд оролцохгүй, намаг тийш явна. Бид ямар ч болтугай цуглуулсан бүх материалаа штабт хүргэж өгөх ёстой. Тэгвэл бидэнд шууд намаг дундуур чигээрээ явах ганц л зам бий гэлээ. Генрихийг намаг тийш бөгтийн гүйхэд овор биетэй, дөчин настай Вольф хойноос нь арай ядан гүцнэ. Барон бол хурдан сайн гүйдгээр барахгүй, ёстой дайчин анд нөхөр байсан юмсанж. Вольфын хоцроод байгааг Генрих мэдээд гүйдлээ удаашруулж, хамт яваа хүнээ хүлээв. — Вольф оо, бүү сандар! Хамраараа амьсгал. Гараа хаялаад гүй, ингээд! Нэг, хоёр, гурав, дөрөв! Нэг, хоёр, гурав, дөрөв! Вольф, дэслэгчийн өөдөөс талархан харав. Үнэхээр дэслэгчийн зөвлөгөө тус болж, удалгүй овоо хурдан гүйж чадах боллоо. Тэр завсар тосгоны тэнд буудалцах нь улам ширүүсэв. Хүнд пулемётын

тачигналт дээр автоматын ээлж нэмэгдэж, удалгүй гранат дэлбэрэх чимээ сонсох болов. — Хурдлаарай, Вольф оо! Хурдан зайлах нь бидний амь гарах ганц зам шүү гэж амьсгаадан байгаа вахмистерыг дэслэгч яаруулна. Тэгсээр намаг хүрэв. Зөвхөн миний гишгэсэн мөрөн дээр гишгэж яв! гэж Генрих тушаагаад өөрөө өтгөн зэгс дундуур зоригтой орлоо. Дэслэгч хэд алхаад эргэж харвал Вольф согтуу юм шиг гуйвж байлаа. Сая айж сандарсандаа хөл дээрээ тогтож ядан байгаа нь тэр ажээ. Гэтэл нэг орвол хэзээ ч эргэж гаршгүй аймшигт намагт шигдэхгүйн тулд дэслэгчийн мөрийг алдахгүй гишгэх хэрэгтэй байдаг. Гольдринг зогсож, хамраараа хэдэнтээ гүн амьсгаа аваад — Бид хэдхэн минут амарч болох байна гэхэд Вольф амьсгаагаа жаал дараад, — Манайхан бүслэлтээс гарч чадах болов уу, ноён дэслэгч та юу гэж бодож байна? гэж асуувал — Яах бол гэж айж байна. Хүч даанч тэнцвэргүй байна. Хүүе, вахмистр аа, нөгөө мэдээлэгчид, цагдаа нарын нэрсийн жагсаалт хаа байна? Нэрсийн жагсаалттай хавтсыг та цагдаагийн газрын ширээн дээр тавьсан шүү дээ гэсэнд вахмистрын царай зэвхий цагаан болж: — Би ... би бодохдоо таныг ... гэж ээрсэнд — Та мартаж орхисон юм шив дээ? Та юу хийснээ мэдэж байна уу? гэхэд — Үгүй, би бодохдоо ... гэж вахмистр чичирхийлсэн уруулаараа арай ядан дуугарлаа. — Мөн бодож дээ! Тэр нэрсийн жагсаалт партизануудын гарт орвол юу болохыг та мэдэж байна уу? Үүнийхээ хариуцлагыг та хурандаагийн өмнө хүлээхэд хүрнэ гэдгийг ойлгож байна уу? гэсэнд — Эрхэм дэслэгч ээ, өршөөгөөч. Намайг бүү хөөдөөч! Би тийм үед тэр жагсаалтыг ямар завандаа санах билээ. Жагсаалтыг Вурцерт байсан гэж хэлье гэлээ. Алсад хүн орилох сонсоно. Пулемёт тачигнахаа больж, хааяа нэг буун дуу гарна. — Ээ харла! Гардан байлдаан эхэлжээ. Вахмистр аа, шалавлая! гэж Гольдринг хэлээд хурдан хурдан алхалсаар намгийн гүнд орлоо. Үхлийн аюул тулгарсан үед амиа авч гарах гэсэн хүний хүчинд хэмжээ хязгаар байдаг болов уу? Вольф өөрийгөө өвдөгцөө усан дундуур бүхэл шөнөжин явж чадна гэж огт санасангүй. Вольф зууралдсан намаг дотуур хөлөө аран ядан зөөж, нялцгай хөрс биеийн хүндэд дарагдан үргэлж бамбалзах тул зогсож ч болохгүй, жаахан л хазгай гишгэвэл ёроолгүй бамбалзуурт шигдэх аюулдөртөнө. Өчигдөр өглөөнөөс хойш хэл дээр юм тавиагүй учир тамир нь бүүр алдарчээ. Дэслэгч үе үе битүү ширэнгэлсэн нишингэ дотроос ганц өөрийн мэдэх нэг ургамал тастаж, Вольфт өгөөд яаж цэвэрлэж, яаж идэхийг зааж өгөх боловч тэр идээнээс нь Вольфын дотор муухай болно. Бас дэслэгч, вахмистр хоёр хоёулаа өлөн өвсөнд гараа цус гаргал олон удаа зүссэн учир гар нь өвдөнө, Нишингэ ургасан намаг дотуур аялах ийм аюултай байж болно гэж Вольф хэзээ ч санасангүй. Үүрээр бүрмөсөн сульдаж тамирдсан Вольф: — Эрхэм дэслэгч ээ! Бид хир удаан ингэж тэнэх юм бол? гэж асуулаа. Вольф даарсандаа бие нь хөхөрч, дагжин чичирч байлаа. — Намаг руу буудаж байгааг та өөрөө сонссон биз дээ. Биднийг эрж байх магадгүй. Партизануудыг явсан гэж баттай мэдсэн цагтаа л бид эндээс хөдөлнө гэж Генрих хэлсэнд — Үгүй, бид буцаад байна шүү дээ гэхэд нь — Олон таван үггүй намайг дагаад яваач гэлээ. Гольдринг өөрөө ч тамир алдарч байгааг мэдрэв, Арай ядан хөдөлж чимээ чагнаж байгаа ч юм уу, амарч байгаа ч юм уу, байн байн зогсоно. Эцэст нь Генрих бүүр зогсоод — Бид энд машинны чимээ дуулдах хүртэл зогсоно гэсэнд

— Эндээс дуулдах уу? гэж. Вольф хэлээд горьдлого тасарсан байдалтай гараа сэгсрэв. — Бид замаас зуугаад метр зайтай газар ирээд байна. Хурандаагийн тушаал ёсоор би өчигдөр орой буцаж очсон байх ёстой. Би өчигдөр орой очсонгүй, өнөө өглөө эрт ч очиж чадахгүй. Тэгэхлээр штабынхан сандарч, есөн цагаас оройтолгүй эрж эхлэх болно. Арван цагийн хирд машинтай цэргүүд энд ирэх болно гэж Генрих ярив. Тусламж санаснаас эрт ирлээ. Годьдрингийн буцаж ирэхийг зөвхөн хурандаа, 1—Ц хэлтсээр барахгүй, бүх штаб сонирхож байгааг бодолцоогүй байжээ. Бертгольд Гольдрингийг хүлээж ядаад шөнийн гурван цагийн үед гэрт нь очиж, дэслэгчийн ерөөс эргэж ирээгүйг мэдэж, бүх штабынхныг босгожээ. Үүр хаяармагц моторт явган цэргийн хүчит отряд Подгорный тийш хөдлөв. Ядрахын туйлд хүрч, шавхай шавар болсон, гар нь боолттой энэ залуу хүнийг үргэлж хээнцэр ганган байдаг штабын офицеруудын нэг фон Гольдринг гэж танихад бэрх болжээ. Барон бүхэл өдөржин, шөнөжингөө унтав. Маргааш өглөө нь нүдээ нээгээд хамгийн түрүүн Бертгольдыг олж харлаа. Хэвт, хэвт. Амарч бай. Болсон бүх явдлын тухай надад Вахмистр илтгэсэн. Гэвч чи бид удахгүй партизан гэж юу байдгийг мартах болно. Энэ нүгэлтэй орноос бүрмөсөн явна гэж хурандааг ихэд нууцгайлан шивээнэхэд нь — Юу гэнээ? гэвэл — Манай корпусыг Францад шилжүүлэх болсон гэжээ.

КУБИСИЙН УРХИ Аятай тохитой байшин байхгүйн улмаас хөдөөгийн эмнэлгийн жижиг байшин хоёр давхар үүрэг гүйцэтгэдэг байжээ. Өдөр нь тэнд офицерууд хооллох бөгөөд тэгэхэд том танхимд ширээг «Т» хэлбэртэйгээр тавилна. Үсгийн богино тал нь болсон ширээний ард дээд командлалын төлөөлөгчид сууж, цаашлаад дарга нарын хувийн үзэмж. цол зэргийн эрэмбээр офицерууд дараалан сууцгаана. Орой бол цол хэргэмийг үл баримтална. Шарз дарс ууж байгаа буюу хөзөр тоглож байгаа алин болохоос шалтгаалан ширээг ямар ч замбараагүй, Нэг бол хоёр хоёроор нийлүүлж, эсвэл ганц ганцаар энд тэнд тавина. Энэ үед тэр байшингийн ханыг хичнээн маажиж малтаж, шалыг нь хичнээн угаавч арилдаггүй эм, ариутгагч бодисын үнэр гойд тодорхой мэдэгдэнэ. Тийм үнэр ууж байгаа архи дарсны амт, уусны дараа гардаг хэрүүл маргааныг онцгой ширүүн болгодог ажээ. Ахмад Пауль Кубист энэ үнэр өнөөдөр урьд урьдынхаас ёозгүй муухай санагдаж, учир тодорхойгүй нэг шалтгаанаар Италийн хилийн нэг өртөөний галт тэрэгний бяцхан буудлыг санагдуулжээ. Ахмад тэндээс өөрийн авга ах генералын дуудлагаар Германд очсон гомсанж. Тэр галт тэрэгний буудал дээр бас ариутгах бодисын үнэр ханхалж. Пауль Кубисийн дотор нь муухай болж байсан болохоор энэ зүйл санаанд нь орсон юм болов уу даа. Ер нь ахмадын сэтгэл өнөөдөр тун тавгүй байжээ. Тэгэлгүй ч яах вэ дээ. Ромд хоёр жил сургууль ном үзэж, шашны санваартан болохоор биеэ бэлтгэж байтал энэ золигийн дайнаас болж ийм огцом эргэлт гарч, сахил санваар хүртэхийн оронд мэдээлэн тагнах хэлтэст ажил хийх хэрэгтэй болжээ. Чухмыг хэлбэл Пауль жанч нөмрөхөө больсондоо нэг их харамссангүй. Цэргийн дүрэмт хувцас царайд нь сүрхий зохижээ. Мундирийн хар зах ахмадын цайвар царайг онц гайхалтай тодруулж, нүдийг нь гүн харцтай болгоно. Фрейлейн3 Клара ахмадын нүдийг учир битүүлэг гэж хэлэх нь бий ... Хэдий тийм боловч Ромд хоёр жилийг барсан нь харамсалтай. Тэр үед Пауль өөрийгөө дээрээс заяат хүн хэмээн итгэж, олон олон юманд сэтгэл хөөрөн догдолдог байсан цаг билээ. Тэсэж ядан хүлээх, үл итгэх,

шунан тачаалын сэрлийг дахин мэдрэхсэн гэж хүснэ. Энэ бүх сэрэл яасан их мохов оо! Одоо бол хөзөр тоглох үед хөзрөө эхэлж харах ганц тохиол дээр л сэтгэл нь догдолдог болсон байна. Пауль Кубис хамт тоглочихмоор хүн хайж тасалгаан дотуур харав. Энэ барон Гольдрингийг урьдаг юм бил үү дээ? Аргал хоргол шиг арвин их мөнгөтэй хүн. Тэгээд би хөнгөмсөг загналгүй, дотроо бодолтой, дороо суурьтай тогловол ч ... Сүүлийн үед Кубисийн аз нь харьжээ. Аливаа мөрийтэй тоглоомчны адил одоо л юу юугүй тоглоомд эргэлт гарч, алдсанаа хэд нугалан эргүүлж авна гэж итгэнэ. Азын тэнгэр наашаа харсан тэр мөчийг л алдахгүй юмсан. Өнөөдөр тийм байж мэднэ ... Кубис ингэж бодоод танхим дундуур хурдан алхалж, Коккенмюллертэй нэг юм хөгжүүн ярилцаж байгаа Гольдрингийн дэргэд очоод — Барон та надтай хоршиж тоглохгүй юу? Та бриж4 тоглодог биз дээ? гэсэнд Гольдринг чин үнэнээсээ харамссан байдалтай гараа дэлгэж,

— Тоглоом Мэддэггүйдээ тун их харамсаж байна. Тэр талаар би бүр таг шүү. Сурвал уг нь сайхан сан гэсэнд Коккенмюллер хажуунаас нь — Пауль чамайг татгалзахгүй бол би чамтай хоршиж болох байна гэв. — Өөр хэнийг урих вэ? гэсэнд — Яагаа вэ, Шульцийг, бас ... гээд Коккенмюллер эргэн харж. — За яах вэ, Вернорийг ч болтугай урья ... Вернер ээ! Чи тамга, боол хоёрыг ялгаж чадахтай байна уу? гэж дуудав. Нэг ширээний дэргэд уруу царайлан шарз ууж суусан Вернер дуртай дургуй өндийв. Нүд нь илт хөлчүү харагдах боловч хөдөлтөөн нь цэх шулууныг үзвэл архи ер уугаагүй юм уу гэмээр Коккенмюллер сандал засаж тавилаа. Тэр өнөөдөр их л хөгжилтэй хөөрүү байна. Ахмад өнөө өглөө гэр орныхондоо муусайн новшийн даавуу шаавуу биш, үнэхээрийн үнэ цэнэтэй бэлэг илгээсэн байжээ. Тэгээд ийм азтай өдөр заавал хожих ёстой гэж боджээ. Шульц одоо хөзөр тоглох гэж байгаа биш нэг их чухал хэрэгтэй ажил хийх гэж байгаа хүн шиг албархуу маягтай суув. Би таны хажууд суугаад жаахан харж сурахыг хичээвэл та татгалзахгүй биз? гэж Кубисээс Гольдринг асуув. Пауль Кубис хөзөр тоглож байхад хажуунаас хүн харахад төдий л дуртай биш байдаг. Хүн харахаар зүрх нь хөөрдөг байна. Гэвч баронд үгүй гэж хэлж чадсангүй, найр тавин сандал дөхүүлж өглөө. Тоглоом анхандаа назгайхан байв. Кубис буурь суурьтай тоглоно гэснээрээ бие барьж ер бишийн болгоомжтой тоглов. Коккенмюллерт хөзөр очихгүй байлаа. Шульц хэзээний зангаар байдлыг ажиглан хүлээзнэнэ. Ганц Вернер л архинд халсандаа бусдаас илүү хор шартай тоглоно. Тэгээд огт санаанд оромгүй осолтой хөзрөөр явах тул дараа дараагаар хожиж, бусдыгаа гайхуулна. Пауль Кубис ч бас хор шар нь буцалжээ. Кубис болгоомжтой тоглоно гэснээ мартаад хувь илүү мөрий тавилаа. Гэтэл даанч арчаагүй муу хөзөр иржээ. Ядаж түүнтэй хоршин тоглож байгаа Коккенмюллер, дээр дээрээс нь алдаа хийнэ, Шульц сэтгэл дүүрэн, ширээн доогуур гараа хавирна. Вернер тэр хоёр нилээд мөнгө хожжээ. Гэтэл Кубис бүүр солирсон юм шиг амалсныхаа талыг ч гүйцээж чадахгүй атал давхар мөрий тавилаа. Үгүй, энэ удаа Пауль Кубисийн азын тэнгэр бас. л харьжээ. Шульц, Вернер хоёр хожих учиртай байсан болохоор хожлоо. Коккенмюллер үрчийж ярвайж байж, алдсан мөнгөний тэн хагас болох 315 маркийг ширээн дээр гаргаж тавилаа. Кубист бэлэн мөнгөгүй учир харамч хявцаг Шульцийг хажуу тийш дуудаж, маргааш болтол хүлээхийг гуйхаас өөр арга байсангүй. Шульц маргааш бас нэр төрийн өр төлөөстэй учир үд хүртэл хүлээхийг зөвшөөрөхөө их л ёсорхуу хэлжээ. «Нэр төр» гэдэг үгийг их л хүчлэн хэлэхэд нь алдсан

мөнгөө цагт нь. өгөхгүй бол бөөн хэрүүл яриа гарна гэдгнийг Пауль Кубис ойлголоо. Кубис сэтгэл гансарснаа бусдаас нуух гэж танхимд үлдэж, Гольдринг, Вернер хоёртой хамт нэг лонх шарз хувааж уув. Шульц шарзын үнэ төлөхөөс зайлсхийж, тэр даруй алга болжээ. Вернер ёстой офицер хүний ясаа харуулж, ширээнийхээ дэргэд ирсэн хүн болгоныг дайллаа. Дараа нь Гольдринг хоёр лонх шампаан дарс захиж, түүнийг гарахын өмнө бүгд зогсоогоор уун. Үдэшлэгийн эцэст Кубисийн толгой нь шуугиж, тасагтаа яаж хүрснээ ч мэдсэнгүй. Хаанаас мөнгө олж, Шульцийн мөнгийг төлдөг билээ гэж сэтгэл шаналан зовохгүй, даруй унтаад өгсөн нь нэг талаар сайн хэрэг болжээ. Пауль Кубис толгой их л хүндтэй сэрж, нэг эвгүй явдал хүлээж байгааг бүрэг бараг санана. Чухам юун явдал болохыг тэр даруйд санахгүй байснаа нүүр гараа угаах, цай уухаар суусан хойноо Шульцэд мөрий алдсанаа сая саналаа. Тэр бүдүүн золигоос өөр ямар ч хүнтэй учраа ололцож болохсон, «Нэр төрийн өр төлөөс» гээд байгаа шүү! Тэр өөрөө нэр төр гэдгийг мэдэх юм уу?! Хэрэгтэй мөнгөний хагасыг ч болтугай зээлдүүлэх хүн дайралдаж магадгүй гэж Кубис штабт зориуд эртлэн ирэв. Коккенмюллерийн хармаанд дөнгөж хорин марк байжээ. Хурандаа юм уу, генералаас мөнгө гуйлтай биш дээ. Кубис хоёр гурван найздаа, цаадуул нь байгаа хэдэн мөнгөө архи, мөрийтэй тоглоомд өгч дууссаныг мэдсээр байж утасдаж үзлээ. Тэтээд эцэст нь «за дүүрсэн хэрэг, юу болбол болог» гэж шийдээд ажлаа хийхээр бичиг цаас дэлгэв. Хаалга аяархан тогшиход нь «Шульц хүрээд ирэв үү?» гэсэн бодол зэрсхийж цочин цаг харвал дөнгөж арав болж байх тул дотор онгойж санаа алджээ. — Түр хүлээнэ үү гэж Кубис чанга дуугараад төмөр бүрээстэй хаалганы автомат цоожийг онгойлговол гудамд дэслэгч Гольд ринг зогсож байхад нь үнэнээсээ баярлаж. — Ор, ор, барон! Яасан хачин юм бэ? Нэгэн хэрэгт таныг л надад тус болж чадах хүн гэж би сая бодож байтал сайн хүн санаагаараа гэж та хүрээд ирлээ гэсэнд — Сонсоход бэлэн байна. Надад ч гэсэн тантай уулзах хэрэг байна. Чухамдаа нэг жижиг зүйл гуйх гэсэн юм гэж Генрих хариулжээ. Ахмад Кубис зочноо бичгийн ширээний дэргэдэх зөөлөн сандалд суухыг урьж, бөөн бичиг цаасыг хайхрамжгүй түлхэж зайчлав. Азаар энэ барон Гольдринг хүрч ирснийг бодоход Кубис хувь Тавиландаа гомдож таармааргүй байж, Нэгдүгээрт Шульцтай өр ширээ бодож дуусахын тулд гурав-дөрвөн зуун марк салгачихаж болох биз. Ийм бэлэн зэлэн бололцоо байгааг түрүүн яагаад санасангүй вэ? Хоёрдугаарт, Бертгольдын өгсөн даалгаврыг биелүүлэх хамгийн тохиромжтой учрал тохиолдлоо. Бароныг энэ тасагтаа ганцааранг нь үлдээгээд «маш нууц» гэсэн тэмдэгтэй бичиг цаасаа ширээн дээр задгай орхиж, төмөр шүүгээг онгорхой «мартаж» орхих юм шүү дээ. Фон Гольдринг найдваргүй хүн юм бол ийм завшаант учралыг алдахгүй нь лав ... Тэгвэл төмөр шүүгээний дэргэд ямарч хүн ажиглаж мэдэхээргүй уран нарийн зоосон дурангаар харж байгаад бароныг эд мөрийн баримттай барьж авна. Үүнийг яаж гүйцэтгэвэл таарах вэ? Кубис өөрөө урьдаас бэлтгэсэн бол бүгдийн нь эвийг олж болохсон. Захиргаандаа байдаг хүмүүсийн нэгэнд өөрийгөө утсаар дуудаарай гэж даалгаж орхиод баронд хүлцэл өчиж, хүлээхийг хүсээд өөрөө гараад явчихна. Тэр хоорондуур ... Өө дөө, үүнийг бодоод яах билээ. Нэгэнт одоо Гольдринг санамсаргүй гэнэт ороод ирсэн хойно ганц өөрийн самбаа зальд надайж, нэг ухаан сийлэх хэрэгтэй болжээ. Гольдрингийг жаал удаан саатуулж, нэгд мөнгө гуйх, хоёрт бароныг шалгах энэ хоёрыг зэрэг гүйцэтгэж, нэг сумаар хоёр туулай алахын тулд юунаас яриа үүсгэдэг билээ? — За тэгээд би танд юугаар тус болж

чадах байна? гэж Генрихийг асуухад Кубис үгээ цэгнэн яаралгүй хэлсэн нь: — Би өөрийн ажилтай холбогдсон нилээд асуудлын талаар таны саналыг мэдэхсэн гэж маш их хүсэж байна. Миний удирдаж байгаа тагнан мэдээлэх ажлыг хэлж байгаа юм гэсэнд — Таны асуултыг дуртайяа хариулья... гэв. — Та Орос оронд ажиллаж байсан болохоор оросуудын практикийг сайн мэдэх нь лав. Зөвлөлтийн сөрөг тагнуул манай агент төлөөлөгчдийг илрүүлэн барьж авсан байвал түүнд тэндээс мултрах ямар нэг бололцоо бий юу? — Хайруул дээр шарагдаж байгаа загас голын усанд буцаж орох найдлага хир байх вэ, түүнээс илүүгүй л найдлагатай байх. — Энх тайван цагт бол манай тагнуулч үнэн сэтгэлээс ялаа хүлээх ч юм уу, өөр ямар нэг аргаар хөнгөвчлөлт горьдож бас болохтой ... Дайны үед бол ... Дайны цагийн хууль хатуу байдгийг та өөрөө эс мэдэх биш. Хэрэв манай тагнуулч амиа аврахын тулд ч юм уу, эсвэл их шан аваад зөвлөлтийн тагнуулд ажиллахыг зөвшөөрвөл яах вэ? — Тийм явдал байхгүй. Зөвлөлтийн тагнуулын боловсон хүчнийг манайхаас огт өөр замаар сонгож авдаг юм. Манайд бол хөлсний агент төлөөлөгчдийг ашиглах явдал байдаг. Зөвлөлтийн тагнуулын ажилтан нар бол эд мөнгөний сонирхлоор ажилладаггүй, үзэл суртал баттай миний санахад хэнхэг улс байдгаараа хүчтэй байдаг. — Зүйтэй, зүйтэй ... гэж Кубис өгүүлээд одоо өөрийн хамгийн их сонирхож байгаа асуудалд шилжих сэжүүр эрж дуугүй. Тэгтэл Гольдринг өөрөө түүнд тус болжээ. Генрих хайхрамжгүй байдлаар өгүүлсэн нь: — Эрхэм ахмад таны үгийг тасалсныг минь өршөөгөөрэй. Би таны өмнө өөрийгөө нилээд буруутай хүн гэж сэтгэл зовоод болдоггүй. Үнэн шүү. Та урьдаар миний үгийг дуустал чагнаад дараа нь болоорой. Юу вэ гэвэл та нарыг хөзөр тоглохоор суухад тань би шавь орох гэж шалж байж, мэдээжээр хэрэг, таны анхаарлыг сарниулж, таны хөзрийх үргэлж харж санаа сэтгэлийг чинь үймүүлсэн байх. Ай би өөрөө ч гэсэн шатар тавьж байхдаа ард минь хүн зогсож байвал сэтгэл үймрээд болдоггүй юм. Тэгэхлээр өчигдөр таны хожигдоход миний буруу их орсон гэж бодож байна. Та надад муу саналгүй учрыг зөв ойлгоорой. Та тэр Шульцийн өмнө зарим талаар эвгүй байдалд оров уу гэж өчигдөр бодсон гэсэнд — Барон та таачихлаа. Би хошууч Шульцэд гурван зуун тавин маркийн өр тавьсан. Үнэнээ хэлэхэд энэ байдлаас яаж мултрах аргаа олохгүй байна шүү гэхэд нь. — Өө яасан яльгүй юм бэ. Та энэ цөөн мөнгийг надаас зээлэхийг зөвшөөрвөл үнэн голоосоо баярлах байна гэж Генрих хэлээд өмднийхээ арын халааснаас баглаатай шинэхэн мөнгөн тэмдэгт гаргаж, яах вэ гэсэн байдалтай Кубисийг харжээ. — Эрхэм барон танд хязгааргүй их баярлаж байна. Уг нь надад эвгүй л юм даа. Та бид хоёр бие биенээ сайн танихгүй шүү дээ гэж Кубисийг өгүүлэхэд — Хүн анх уулзсан даруйдаа чин зүрхнээсээ талархах сэтгэл төрөх ч байдаг. Тийм биз дээ? Гэж Генрих инээмсэглэн хэлээд мэхэсхийсэнд Кубисийн дотор онгойж санаа алдаад — Эрхэм барон та ёстой офицер хүн юм. Үнэнээ хэлэхэд таны найр тавьсныг дуртайяа ашиглая. Удахгүй эргүүлж өгнө л дөө гэсэнд — Өө яарах явдалгүй. Энэ 350 марк байна. Хүрэх үү? гэхэд нь — Элбэг хүрнэ гэж Пауль Кубис хариулаад тэмдэглэлийн дэвтрээс нэг хуудас таслан авч мөнгө зээлсэн тухай баримт бичээд Гольдрингт өгсөнд түүнийг нь хайхрамжгүй авч халаасандаа хийх зуур — Илүүц ажил. Та ингэх хэрэгтэй гээд байгаа бол яая гэх вэ гэв. — Заавал ингэх хэрэгтэй. Одоо бидний сайхан танилцсан учралд нийцүүлэн тантай нэг нэг хундата шарз ууя. За юу? Үнэнээ хэлэхэд өчигдөр оройныхоос толгой минь дүйрээд байна ... — За толгой засах гэж байгаа юм бол би нөхрийн зовлонгоос хуваалцаж үзье

гэж Гольдринг инээмсэглэн зөвшөөрчээ. — Тэгвэл таныг таван минут түр орхихыг зөвшөөрнө үү. Би гэртээ гүйж очоод ирье гэж Кубис хэлээд хариу хэлэхийг хүлээлгүй хаалга тийш алхахад нь барон түүнийг зогсоож, — Түр хүлээнэ үү. Та нууц бичиг цаасаа ширээн дээр задгай орхиод явах юм уу? шүүгээнд далд хийвэл дээр биш үү? гэсэнд Кубис гар сэгсрэн зангаж, — Бага хэрэг. Дэслэгч та өөрөө надаас дутуугүй чухал чухал нууцыг мэдэх хүн. Түүнээс гадна би таны даруу занд найдаж байна гээд гарчээ.

Автомат цоож дан хийж, Кубис цааш алхлан одох нь сонсдоо. Генрих тэр бичиг цаасыг халт харж, янжуур гаргаж удтал имрээд цонхны дэргэд очлоо. Хаалганы цаана хүний алхаа сонсдоход Гольдринг ер дуулаагүй юм шиг эргэж харсангүй. Кубис орж ирээд — Өршөөгөөрэй. Таван минут болно гэсэн чинь долоон минут болчихлоо гэж хэлээд төмөр шүүгээний дэртэд очиж, сайтар хаасны эцэст сая нэг халааснаасаа лонхтой архи, нөгөө халааснаасаа хоёр хуванцар хундага гаргаж, шарз хундагалж эхлэв. — Надад хожоо болж эргэсэн алдааны төлөө! гэж ахмадыг хундага өртөхөд нь — Тэгвэл бас миний хожооны төлөө! гэж Гольдринг үгийг нь дагуулж хэлээд хундагаа өргөжээ. «Бас нэг шалгалтыг давлаа!» гэсэн баясгалант бодот Генрихийн толгойд зэрхийв.

ХОШУУЧ ШУЛЬЦИЙН ЦОМОГ Олон өдрийн турш анх удаа үүлний цаанаас нар гялайж, газар дэлхийд хурц гэрлээ цацав. Завсарлагаанаар офицерууд Дан мундиртэйгээ штабын хашаанд гарч ирээд зарим нь нарны гэрэлд анивчин довжоон дээр нарлаж, зарим нь хэсэг хэсгээрээ хашаан дотуур хүүрнэлдэн холхино. Бас замын дагуу, шгабын хаалганы эсрэгэн талд байрласан газар гэрийн дэргэд олон хүн цуглажээ. Тэнд офицерууд агаарын довтолтооны үед их төлөв орж нуугддаг юм. Одоо энд штабын хамгийн мэргэн буудагч Шульц, Коккенмюллер хоёр буудлагын өвөрмөц тэмцээн хийж байв. Тэмцээний болзол ёсоор буудагч хүн гучин метрийн зайд газар гэрийн шороон дээвэр дээр тавьсан архины лонхны хүзүүг тас буудах ёстой. Мэргэн оновол өрсөлдөгч хүнээсээ хоёр шил шарз буюу түүний өртгийг авна. Сум нь шилний хүзүүг онолтгүй, их биеийг оновол буудагч хүн өрсөлдөгчдөө нэг шил шарз төлж, огт онохгүй бол давхар торгууль хүлээж, хоёр шил шарз төлнө. Эхлээд Коккенмюллер буудлаа. Ахмад ахлах цэргийн гараас том гар буу аваад сайтар нягтлан үзэж, газар зурсан шугамын дэргэд очиж, бай тийш хажуулдасхийн зогсоод шагайж шагайж буудлаа. Шилний дээхэн баруун цаад талд нь бөөн шороо манасхийв. Коккенмюллер уруулаа зуугаад дахин шагайлаа. Энэ удаа сум лонхны тэг голд тусаж хагалав. Гурав дахь сум нь бас л шилийг хагаллаа. Шүүгчийн үүрэг гүйцэтгэж байгаа офицер: — Дөрвөн шил торгуультай, нэгийг ч хожсонгүй гэж инээмсэглэн зарласанд — Би дараачийн ээлж дээр нэхнэ. Одоо яаж шагайхыг мэдэж авлаа гэж Коккенмюллер тайван хариулжээ. — Штабынханд ашигтай л сургууль байна гэж хажууд нэг хүн дуугарахад нь бүгд эргэж харвал штабын дарга генерал Даниель, хурандаа Бертгольд нар цугларагсад дээр хүрч ирсэн байжээ. Хошууч Шульц тэдэнд тэмцээний болзлыг хэлж өгөв. Цугларагсдын дотор Гольдрингийн байгааг Бертгольд хараад — Генрих чи тэмцээнд оролцохгүй юу? гэж асуухад нь — Даанч намайг ирэхэд тэмцээн нэгэнт эхэлчихсэн байлаа гэсэнд — Өө, эрхэм дэслэгч ээ! Энэ зөвхөн эхний тойрог явж байна. Түүнээс гадна би ер нь нэмүүхэн хожих дуртай хүн шүү гэж Шульц тоглоомоор үг хаяв. — Та хожино гэж бат итгэж байна уу? гэж Генрихийн нүдээ онийлгон асуусанд хошууч Шульц бардам дүртэй

инээмсэглээд хариу хэлэхийн оронд Генрихт гар буугаа сарвайжээ. — Үгүй, одоо таны ээлж, Би дараа нь буудна гэж Генрих хэлэв. Хошууч Шульц бараг шагайлгүй гурав дараагаар буудаж, нэг лонх хагалж, хоёрдахийн хоолойг тас буудаж, гурав дахь сум нь оносонгүй. — Бузгай байна гэж генерал Даниель магтлаа. — Барон таны буудах ээлж гэж Шульцийг урихад Гольдринг вальтер буугаа гэрнээс нь гаргаж, буудах байран дээр очив. — Та энэ муу бядгүй юмаар буудах гэж байна уу? гэж Коккенмюллер гайхан асуусанд — Болохгүй дүрэмтэй юм уу? гэж Генрих лавлав. — Болох нь болно. Харин таныг энэ вальтераар арван алхмын газраас лонхны хоолой онохгүй гэж мөрийцөх байна гэж Коккенмюллер өгүүлсэнд хэдэн офицер түүний үгийг дэмжлээ. — Та тэмцээнд оролцогч бусад хүмүүсээс өөрийгөө илүү хүнд нөхцөлд оруулж байна гэж генерал Даниель хажуунаас нь хэлсэнд — Гэхдээ офицер хүн ямар ч зэвсгийг аль болох сайн эзэмшдэг байх хэрэгтэй биз дээ, ноён генерал аа. Миний хувьд өөр буугаар буудахыг зөвшөөрснөөс хошууч Шульцэд буудалт бүрийн арван шил шарз алдсан нь дээр гэж үзэх нь байна гэж Генрихийг өгүүлэхэд — Таны ам алдсанаар болог. Буудалт бүр арван шил шүү гэж Шульц хэллээ. Гольдринг үг дуугүй буугаа өргөж, тэрхэн агшинд дараагаар гурвантаа буу тас хийлээ. Эхний лонх хага үсэрч, нөгөө хоёр нь хүзүүгүй хоцорлоо. Цугларагсдын шагшин магтахыг Гольдринг эс анхааран — Муу байна! Өөр лонх тавина уу гэж ахлах цэргээс хүсэв. Дахин гурав буудахад бүх нийтээр шагшин шуугилдлаа. Гурван лонхны хоолойг хутгаар тас огтолсон юм шиг тас бууджээ. — Хожсон нь тавин шил. Алдсан нь арван шил. Хошууч Шульцээс дөчин лонх шарз авах боллоо гэж шүүгч хөгжилтэй чанга хэлсэнд эргэн тойрон тас тас хөхрөлдлөө. Хошуучийн харамч хявцгийг бүгдээр мэдэх тул түүний зузаан царай улаан толбоор дүүрэхийг бүгд сонирхон ажиглав. — Хошууч Шульц гурав буудах дутуу шүү. Хошууч таны вальтер бий юу? гэж Генрихийг хэлэхэд Шульц хөөрхийлөлтэйгээр бууныхаа гэрийг тэмтрээд улам ч улайж, — Уг нь парабеллумаар буудна гэж болзсон юмаа хэмээн түгдчин хариулахад нь Генрих хөгжилтэй инээгээд — Арван шил гэж тоглосон юм шүү, хошууч аа. Ганцыг өгвөл боллоо гэсэнд — Тэгвэл та оройн есөн цагт очиж хожсон архиа хувааж ууна уу гэж Шульц хэлээд Генрихийг наад зах нь том дайллагад урьж байгаа юм шиг их ёсорхуу мэхийн ёслоход нь — Хүндэтгэн хүлээж авъя. Яг есөн цагт очно гэж Генрих хариулаад инээдээ нуух гэж тонгойлоо. Коккенмюллер Генрихтэй хамт штабт буцаж явахдаа: Би хувьдаа барон тантай буудалцахыг хүсэхгүй нь байна. Ингэхэд та өнөөдөр айхавтар өстөн дайсантай боллоо гэв. — Би Шульцтэй сайхан танилцлаа гэж бодсон юм шүү. Би хожсон юмаа бараг аваагүй шүү дээ гэж Генрихийг өгүүлэхэд Шульц манай штабын тэргүүн зэргийн мэргэн буудагч гэдэг алдрыг нь булаасан хүнийг хэрхэвч уучлахгүй дээ. Одоо болтол түүний гайхуулдаг ганц юм нь байсан юм гэж Коккенмюллер учрыг тайлбарлав. Гольдринг, Коккенмюллер хоёрыг тасалгаандаа орж ирэхэд хурандаа дээр одоо генерал Даниель, хурандаа Лемберг хоёр байгаа гэж жижүүр илтгэлээ, — Лемберг ээ? гээд Генрих Коккенмюллерийн өөдөөс асуусан байртай харж, нэг юм санаж ядах мэт хөмсөг зангидахад — «Ногоон зугаалга» ажиллагааг удирдахыг түүнд даалгасан юм гэж ахмад учрыг хэлэв. Тэр хоёр өөр өөрсдийн ширээнд сууж, бичиг цаас үзэж байтал таван минут хэр болоод хурандаагийн үүдний өрөөн дотуур генерал Даниель офицеруудын зүг харалгүй явж өнгөрөхөд хойноос нь тоосонд дарагдаж, алжаасан хурандаа Лемберг дагалдан гарчээ.

Дутуу хаагдсан хаалганы завсраар Бертгольд тасалгаан дотуураа хойш урагш холхиж байгаа харагдан. Энэ бол хурандаагийн сэтгэл төвшин биш байгаагийн шинж. Гэвч Лембергт найдварласан үүргийн тухай Коккенмюллерийн үгийг ихэд сонирхсон Генрих зүрх гарган даргынхаа үүдийг тогшив, Бертгольд Генрихийг хараад баргар царай нь тэнийж, — Аа чи юу. Амжилтад чинь баяр хүргэе. Чи маш сайн мэргэн буудагч юм байна гэхэд нь — Чухам тийм учраас эрхэм хурандаа тан дээр ирлээ. Буу зэвсэг эзэмшиж чаддагаа шарзны хоосон лонхон дээр туршиж байхын оронд ёстой дайснаар бай хийж, «Ногоон зугаалга» дээр үзүүлбэл зүйтэй биш үү? гэсэнд Бертгольдын царайд инээмсэглэл тодроод — «Ногоон зугаалгыг» гүйцэтгэчихсэн гэв, — Гүйцэтгэчихсэн? Хэдийд тэр вэ? гэж Генрих гайхан, урам хугарах хосолсон дуугаар өгүүлсэнд — Өнөөдөр үүрээр яг зургаан цагт эхлээд арван хоёр цагт дуусгачихсан гэж хурандаа хэлэв. Генрихийн уруу царайлсныг хурандаа хараад чин үнэнээсээ хөхиж, — Үгүй, чи нээрээ хачин хүн юм. Надад үнэнээ хэл. Тэр ажиллагаанд оролцох гэж юунд нь тэгж их дурласан хүн бэ? гэхэд нь — Танд даргын хувьд тань биш, миний эцгийн оронд эцэг болох хүний хувьд нуулгүй хэлэхийг зөвшөөрнө үү гэвэл — Чи надад хэзээ ч үнэнээ нуулгүй хэлж байна гэдэгт итгэж байна гэлээ. Генрих хамгийн нууц нандин бодлоо илчлэн хэлэх үү, байх уу гэсэн мэт эргэлзэж байснаа өгүүллүүн: — Та надад их тус болеон. Таны ачаар би ийм түргэн офицер цол авлаа. Та намайг бас сонирхолтой ажилд оруулж өглөө. Харин ... гэхэд — Үг хэлбэл дуустал гэдэг юм. Чи юунд үгээ дутуу орхив? гэсэнд — Би штабын офицеруудад атаархаж байна. Тэд нар бүгд гавьяа байгуулсан, чухал ажиллагаанд оролцож явсан бололтой, энгэрт нь шагналын тэмдэг ярайж байх юм ... гэсэнд Бертгольд биеэ барьж чадахгүй тас тас хөхөрч, Генрихийн үгийг тасалдууллаа. Хурандаа инээж инээж, эцэст нь: — Ердөө энэ үү? ... Ай чи бас гэнэн байна даа. Штабын офицерүүд тэр одонгийн ихэнх хагасыг штабынхан ч гэсэн герман орныхоо өмнө гавьяа байгуулсан улс гэж фронтынхонд итгүүлэхийн тулд шагнасан хэрэг гэж батлан хэлэхэд болно. Чухам үнэндээ бол тэр гавьяа зүтгэл нь хөдөө газрын захиргааны бичээч түшмэлийн гавьяанаас хэтрэх юмгүй байхаа. Ер нь одон шагнуулахын тулд заавал партизаны суманд толгойгоо тавьж өтөхийн хэрэг байхгүй. Тэр хэрэгт чам шиг ариун цустай хүнээс арай өөр улс олдоно. Чамайг тэр ажиллагаанд явуулаагүй миний ачийг санаж байвал дээр ... гэв. — Яагаад вэ? — Манайхаас хоёр зуун арван есөн цэрэг, арван зургаан офицер алагдаж, цагдаа нарын тэн хагас нь устсан ... — Тэгэхээр ... — Тэгэхлээр «Ногоон зугаалга» гэдэг маань олон хүний сүүлчийн зугаалга болжээ. Манай ангиуд бүх гарцыг хаагаад партизаны хүрээнд ойртож очиход хов хоосон байсан гэнэ. Партизаны хүрээ, түүний ойр орчмын газарт зай завсаргүй мина зоосон байжээ. Үүний дээр партизанууд манай ар талаас гэнэт дайрч, ихээхэн хохирол учруулаад агшин зуур алга болсныг нэмж хэлэх хэрэгтэй. Ингээд тэр ажиллагаа шившигтэйгээр нурлаа, Ганц үр дагавар нь гэвэл тэр тосгоны ойролцоох хүүр тавих газар хоёр зуу гаруй шинэ загалмай босгосон байна, — Тэгвэл хурандаа Лемберг ... — Тэр Лембергийг чөтгөр алгадаасай. Би түүний бүтэлгүйгээс болж сэтгэлээр унахыг хүсэхгүй. Дээд командлалын өмнө өөрөө өөрийгөө өмөөрөг ... За дэслэгч ээ, хоёул нэг орой хот орж тархиа сэргээх юм биш үү? — Баяртай зөвшөөрнө — Баярлахыг мэдэж байна. Залуучууд бөглүү буйд газарт дургүй, нөхцөл байдлаа сольж байх нь агаар шиг хэрэгтэй байдаг, Ингээд өнөө орой туувал яасан юм бэ? — Маргааш дээр. Намайг өнөө

орой хошууч Шульц урьсан, юмсан гэсэнд хурандаа ярвайв. — Та дургүй байна уу? — Сэтгэл зовж байна. Хошууч Шульц өнөөдөр чамаас болж шившиг болсондоо өсөрхөх болно. Архи уутаад агсамнан чамайг доромжилж мэднэ. Чам шиг түргэн зантай хүн ... — Би эрхэм хурандаа тан шиг биеэ эзэмдэж, мөс шиг хүйтэн байя. — Тэгсэн ч миний сэтгэл амрахгүй байна. — Яагаад? Танд андгайлж байна шүү дээ ... — Чи даанч залуугаараа байна. Дайн болоогүй бол ... — Би таны хүү гэж нэрлэгдэх аз жаргалтай завшаан олдохгүй байсан байж магадгүй гэж үү? ... — Тэр ч үнэн ... За яах вэ, оч. Хошуучтай тун болгоомжтой харилцах хэрэгтэйг санаж байгаарай. Эрт ирвэл над дээр ороорой. — Мэдлээ, эрхэм хурандаа! Ёслолын шинэ мундир өмссөн Генрих болзсон цагт хошууч Шульцийн байрны хаалгыг тогшсонд хошууч өөрөө хаалга тайлж өгөөд — Эрхэм хүндэт барон Гольдринг морилж айлд! гэж уриалгахан янз үзүүлэхийг хичээсэн боловч хошуучийн царайд талархахаасаа тал засаж долигоносон байдал илүү тод байжээ. Генрих Шульцийн байрыг хурдан зуур тойруулан хараад Шульцийн үйлчлэгч цэрэг нь даргынхаа байрыг тохилог болтох санаатай нэг газраас савхин бүрээстэй хос зөөлөн сандал чирж ирсэнд Шульц тэр даруйд сандлын савхин бүрээсийг хуу татан авч, авдар шиг том чемодандаа далд хийсэн гэж Кубисийн ярьсныг санаад инээдээ барьж ядан байв. Уг нь энэ тасалгааг жаахан тохижуулж таармаар даанч дэндүү ханхай хоосон, ёозгүй ажээ. Тавилга нь гэвэл бүдүүн салдааз хөнжлөөр бүтээсэн нарийн төмөр ор, нэг ширээ, дөрвөн сандлаас өөр юмгүй. Бас үнэндээ авдар гэмээр, төмрөөр бүсэлж эмжсэн нөгөөх том чемодан нь байна. Дотор нь юу байдгийг үзэхсэн ... Бодвол офицер хөнжлөө эвтэйхэн эвхээд ёроолд нь хийчихсэн биз. Энэ Шульц гэрэл зургийнхаа аппаратыг яаж хананд өлгөөстэй орхив доо. Эсвэл зочин ирэхээс өмнөхөн гайхуулах гэж ил гаргасан байлгүй. Хошуучийнд бас өөр хүн ирэх бололтой, ширээн дээр нь хоёр шил шарз, дөрвөн хундага тавиастай байв Генрих ширээний зүг толгой дохиж, — Өөр хүн ирэх юм уу? гэсэнд Коккенмюллерийг мөрийд алдсан архиа өг гэсэн болохоор түүнийг урьсан юм. Арван минутын өмнө надад зурвас бичиж, хурандаагийн даалгавраар юманд явах болсон, ирж амжихгүй гэж мэдэгдсэн байна. Кубис ирэх ёстой байсан нь бас ажил гарчээ. Ингээд та бид хоёр хоёулаа суух болж байна. Та татгалзахгүй биз дээ гэвэл — Тантай хамт энэ оронг өнгөрүүлэхэд баярлана гэж Генрих хариулав. Ер нь тэр орой аятай сайхан болмоор шинж бага байжээ, Гэрийн эзэн, зочин хоёрын хэн хэн нь чухам юун тухай ярихыгаа олж цөхнө. Шульц бол штабын ажил явдлаас өөр юм нэг их сонирхдоггүй хүн. Тиймээс хурандаа Бертгольдын тухай яриа эхлэхэд л хошууч баахан сэргэж, хурандаагийн албан ажлын их туршлага хувийн чанарыг магтахын сацуу сүүлийн үед Бертгольд өөрт нь баахан хүйтэн хөндий, тэр ч байтугай муу хандах болсныг харамсан ярив. — Та үүнийг юунаас болсон гэж бодож байна вэ? гэж Генрих асуугаад Шульцийн нүдийг анхааралтай ширтсэнд хошууч нэг дальдарснаа биеэ барьж, бас Генрихийн нүдийг эгцлэн харж: — Үнэнийг хэлбэл энэ зүйлд таныг зарим талаар нөлөөлсөн гэж бодож байна гэхэд нь, — Надад таныг дайсагнан үзэх юм уу хурандаад нөлөөлөх өчүүхэн ч шалтгаан байхгүй шүү дээ гэсэнд — Ямар нэг хов жив юм уу, эсвэл миний үгийг мушгиж дамжуулснаас ... гэж Шульцийг эхлэн ярихад нь — Та бид хоёр офицер улс болохоос биш хов жив хөөцөлдөж байдаг тогооч автай нар биш дээ ... Миний хувьд гэвэл миний нэр төрийг гутаан доромжлохыг би хэрхэвч хүлцэн тэсвэрлэхгүй хүн. Харин явган хов живийг огт тоодоггүй ... Тэр бол миний нэр төрөөс доогуур хэрэг гэхэд

— Тэгвэл та бид хоёрын хооронд хэзээ ч ямар нэг зөрөлдөөн гарахгүйн төлөө хундага өргөө ... — Барон та дөнгөж ам хүргээд тавьчихлаа шүү дээ гэхэд нь — Би ер нь ганц хоёр хундаганаас илүү уудаггүй. Энэ хоёр дахь хундага маань болохоор цэнгэлийн ундаан гэж удаан уухыг зөвшөөрнө үү гэсэнд — Залуу хүн гэхэд сайшаалтай хэрэг байна. Хөгшин бид нар бол оногдсон асар их ажлаа нугалах гэж өөрснийгөө иймэрхүү юмаар ташуурдаж шавхуурдаж байх хэрэгтэй болдог юм даа гэв. — Ноён хошууч танд амрах зав чөлөө бас ч гардаг бололтой гэж Генрих хэлээд орны ард өлгөөстэй байгаа гэрэл зургийн аппаратыг нүдээрээ заасанд — Би хүүхэд байхаасаа гэрэл зураг сонирхдог болсон юм. Одоо бол цомгоо дүүргэх тун сайхан бололцоо нээгдээд байна. Хичнээн ч хот орноор явж, хичнээн ч үйл явдалд оролцов доо! Өтлөх насандаа дэлгээд үзэхэд өөрийн амьдралын бүх зам битгий хэл, тэр замын алхам бүрийг дахин үзнэ шүү дээ гэж Шульц ярилаа. Хошууч архи их уусан учир цэхэр нүд нь цийлэлзэж, зууван шар царай нь улайжээ. — Хэрэв амин хувийн нарийн нууц биш бол таны цомгийг үзэхэд сонин байхсан гэж Генрих хэлээд нүдээ ирмэсэнд — Хаанаас даа! Би эхнэр хүүхэдтэй хүн. Шалиг самуун юм юу ч байхгүй гэж Шульц сүйд боллоо. Хошууч Шульц чемодан руугаа тонгойж, цоожтой нь нэг хэсэг ноцолдсоны дараа Генрихийн өмнө асар том цомог гаргаж тавилаа. Нээрээ ч арвин их зурагтай цомог байна. Бельги, Норвеги, Чехословак, Франц, Польшид авсан зураг байна ... Хошууч Шульцийн урьд алба хааж байсан ангийн туулсан бүх замыг үзэж болох ажээ. Бас «Орос улс» гэдэг том хэсэг гарч ирэхэд Генрих цомгийн хуудсыг алгуурхан эргүүлж эхэллээ. Нурж эвдэрсэн хот тосгоны зураг байна. Өргөст төмөр торны цаана байгаа өлсөж тамирдсан хүмүүсийн зураг байна. Дүүжлүүр, түүнд дүүжилж алсан хүний зураг байна. Бас нэг дүүжлүүр, олсны гогцоо нь бараг хүүхэд гэмээр залуу хөвгүүний толгой дээр харагдана. Энэ бүх зураг зөвхөн дэвсгэр болжээ. Наад талд нь офицерууд, их төлөв Шульц өөрөө зогсож байна. Зураг авахад нь нэг хүн тусалдаг бололтой. Бас Шульц ганцаараа зогсож байгаа бүхэл биеийн зураг байна. Ихэмсэг царайд нь биеэ тоосон инээмсэглэл үзэгдэж, өрөөсөн хөлөөр алагдсан хүний хүүр гишгэжээ, Сайтар арчиж цэвэрлэсэн савхин гутал нь наран сөрөг гялалзаж байгаа харагдана. Генрих тэр зургийг анхааралтай хараад — Учир тодорхой зураг байна гэж өгүүлсэнд — Би бол утга төгөлдөр зураг гэнэ гэж хошууч залруулан хэлэв, — Энэ зургийг баримт болгож хадгалах хэрэгтэй юм гэсэнд — Аугаа их эрин үеийн баримт болгож хадгална гэж хошууч хөөрөн өгүүлжээ. Генрих дээшээ харвал мэдэгдчих вий гэсэн шиг доош тонгойн цомгийн хуудсыг эргүүлнэ. Хошууч, түүний гарыг барьж, гэрэл зургийн буланд тэмдэглэсэн сар өдрийг заагаад — Энэ миний хамтийн сүүлчийн авсан зураг байна гэв. Тэр зураг нь хошууч генерал Даниель албан тасалгаандаа байгаа зураг ажээ. Генерал гартаа нэг бичиг бариад бичгийн ширээний дэргэд зогсож байна. Цаад талд нь асар том газрын зураг өлгөсөн харагдана. Зургийн зураас шугам нь балархай боловч бүдүүн бүдүүн зурж тэмдэглэсэн сумнууд тодхон харагдана.

Газрын зураг дээр «Төмөр нударга» ажиллагааны төлөвлөгөөг тэмдэглэсэн байгааг Генрих төвөггүй тааж мэдлээ. — Тун сайхан зураг байна, хошууч аа. Та тусгай мэргэжлийн шилдэг гэрэл зурагчидтай өрсөлдөж чадах хүн байна шүү. Үнэнийг хэлэхэд өнөөдрийн энэ уулзалтын дурсгал болгож та нэг зургаа өгвөл баярлах байна гэсэнд —

Хоёр хувь байгаа зурагнаас дуртайгаа шилээд ав гэхэд нь, — Тэгвэл таны сүүлчийн авсан зургийг авъя. Ширээн дээр минь генерал Даниелийн зураг байж байвал сайхнаа гэсэнд — Өө бололгүй яах вэ. Ийм зураг надад хоёр бий. Нэг хувийг нь генералд өгөх гэж байсан юм. Гэтэл нөгөө «Ногоон зугаалга» бүтэлгүй болсноос хойш ... гээд хошууч цомогноосоо тэр зургийг авч Генрихт өгөхөд нь Генрих гарыг нь түлхэж. — Үгүй, ийм янзаар авахгүй. Дурсгалын үг бичих хэрэгтэй шүү дээ гэсэнд — Тийм бол ... гээд Шульц үзэг авч зургийн ар дээр: «Дэслэгч фон Гольдрингт хошууч Шульцээс» гэж гүйлгэн бичив. Генрих гэрэл зургийг авч мундирийнхээ дотуур халаасанд хийгээд — Баярлалаа, маш их баярлалаа ... Таны хэлдэг үнэн. Генерал Даниел өнөөдөр бэлэг авахтай манатай байгаа. Хоёрдахь ажиллагаа нь дараагаараа нурсан гэсэнд — Нэгдэх нь «Төмөр нударга» гэж та үзэж байна уу? гэхэд нь — Тиймээ, одоо «Ногоон зугаалга» гэсэнд — Эрхэм дэслэгч та үүний учрыг юу гэж тайлбарлах вэ? гэж Шульц асуугаад Генрихийн царайг анхааралтай ширтсэнд тэр хоёрын харц тулгарлаа. Генрих өгүүллрүүн: — Би хүүхэд байхын тагнуулч хүн. Манай Корпусын тагнуулын газрын бүх офицерын дотор хамгийн бага цолтой нь би ч гэсэн штабт маш айхавтар шургалан орсон дайсны татнуулч лав байна гэсэн бодлыг минь хэн ч өөрчилж чадахгүй гэв. Шульц энэ үгийг дуулаад сандлын түшлэгийг налан гэдийж, хамрын нь нүх улайн үнэр авсан юм шиг үл мэдэг саргалзаж, нүд нь онийн нарийхан зураас шиг болоод — Та тэгж бодож байна уу? гэж сөөнгөтсөн дуугаар Генрихээс лавшруулан асуухад нь — Тэгж бодож байна. Ер нь гарцаагүй итгэж байна, Гэхдээ хошууч та бид хоёр өнөөдөр зугаацаж цэнгэх гэж цуглаад одоо бодоход штабын офицер бндэнд тааламжгүй ийм эмзэг асуудлын тухай яриа дэлгээд юу хийх вэ дээ гэсэнд — Тэр зөв, Нээрээ өөр юм ярья гэж Шульц зөвшөөрлөө. — Эрхэм хошууч та ийм олон зургийн хальсыг яаж хадгалдаг юм бэ? гэж Генрих сонирхон асуусанд — Хальсыг нь шатаадаг юм. Зураг нь байхад илүү ачаа тээж явахын хэрэг юу байх билээ. Та үүнийг юунд сонирхоо вэ? гэхэд нь — Ямар нэг хуучин гэрэл зургийг дахин буулгах хэрэг гарч болно шүү дээ. Тэгвэл хальс нь хэрэгтэй байхгүй юу гэсэнд — Одоо болтол тийм хэрэгцээ гараагүй байгаа юм гээд хошууч дал мөрөө хавчив. — Таны аль нэг гэрэл зургийг Гестапо сонирхлоо гэж бодъё. Тэгвэл яах вэ? Тэгвэл энэ цомогноос хуу татаж аваад танд хуулбар нь үлдэхгүй шүү дээ гэж Генрихийг өгүүлэхэд Шульцийн нүд том болж сэтгэл түгшсэн байдал илт үзэгдээд — Миний гэрэл зургийг гестапо юу гэж сонирхох юм бэ? гэхэд нь Генрих гэнэт инээмсэглэхийг больж хошуучийг хүйтэн хөндий, дайсагнасан байдалтай ширтээд — Хүн бүхэн хошууч таны санадаг шиг итгэмтгий үтэл амьтад биш шүү гэсэнд — Таны үтийг ойлтохгүй байна. Энэ чинь юу гэсэн үг вэ, учрыг хэлнэ үү. Би доромжлохыг тэсвэрлэхгүй гэдгийг барон танд дуулгачихъя. Та чинь доромжлох байрын үг цухуйлгаж байна. Би дэслэгч танаас хэргэм зэрэг илүү, бас энэ ажилд арав шахам жил болж байгааг бүү мартаарай гэж хошууч хэлэхдээ зэвүү нь хүрч хоолой нь хяхнав. — Энд хэргэм зэргийн ёс хамаа алга, хошууч аа. Бас доромжлогдсон хүн болж бүү маягла. Та сая миний аваад халаасанд хийдэг гэрэл зургийн хальсыг оросуудад ямар үнээр худалдсан бэ, үнэнээ хэлчих гэсэнд хошуучийн амьсгаа нь дээр гарч, царай нь зэвхий цагаан болоод цийлэнхий нүд нь бараг харанхуйлах шиг болж, — Юу?! Та юу хэлэв? гэж эцэст нь арайхийн дуугарав. — Дахин хэлж болно. Та энэ гэрэл зургийг, чухамдаа гэвэл хальсыг нь оросуудад ямар үнээр худалдсан бэ? гэж Генрихийг хэлэхэд, — Үхээрийн шаар! гэж Шульц хашгираад

суудлаасаа босон харайж, орны толгойд өлгөөстэй байсан гар бууны гэрийн оосроос шүүрэхэд нь Генрих дуугаа чангаруулалгүйгээр — Тайвшир, хошууч аа! Би танаас илүү бууддагийг санаарай, Таныг буугаа гаргах хооронд вальтер буундаа байгаа сумны тоогоор сийчиж дөнгөнө шүү. Тайвшир! Ёр нь ёс дэглэмтэй улс бие биедээ буу гаргалгүйгээр учраа ололцож болдог шүү дээ гэв. Генрихийн тайван дуунд юм уу, эсвэл сүрдүүлэгт Шульц сая сэхээ орж, гэртэй гар буугаа орон дээр шидэж орхиод ширээний дэргэд ирж — Дэслэгч та миний офицер нэр төрийг доромжиллоо. Үүнийг би зүгээр орхихгүй! Гэж хилэгнэсэндээ салганан өтүүлэхэд нь — Аятайхан уурладаг юм байна. Хошууч та сүрхий жүжигчин байна. Харин таны саяын жүжиглэсэн үзэгдэл надад өчүүхэн ч сэтгэгдэл төрүүлсэнгүй дээ гэсэнд — Та надаар яах гэсэн хүн бэ? гэж Шульц хэрчигнэв. — Урван тэрсэлсэн гэж сэжиглэгдсэн улсыг Гестапод эрүүдэж байхыг та үзсэн болов уу? гэж танаас асуух гэсэн юм. За даа тодорхой яриад яах вэ. Гестапод үхсэн хүнийг ч үг хэлүүлж чадахаар ажилдаа гаршсан тийм улс байдгийг та юу эс андах билээ гэж Генрих урьдын адил тайван өгүүлсэнд — Та заавал надтай ийм юм ярьдаг нь ямар учир вэ? Энэ надад ямар хамаатай юм бэ? гэж Шульцийг асуухад — Бүүр шууд хамаатай. Та их болгоомжгүй хөдөлж, таны яагаад гэрэл зурагт их хорхойтой болсныг гестапо сонирхох шалтгаан байна гэдгийг одоо болтол ойлгоогүй байна уу? гэсэнд Шульц баахан тайвширч, — Би офицер хүний үүргийг ямагт чин шударга биелүүлж ирсэн болохоор намайг зэмлэх шалтгаан байхгүй гэхэд нь — Эд мөрийн баримт байна. Үгэнд итгэхээсээ эд мөрийн баримтад илүү итгэдэг юм гэсэнд — Та тэгээд надад ямар буруу өгөх санаатай байна? гэж хошууч дахин шатахад нь — Тэнгэр өршөө, хошууч аа. Би танд ямар ч буруу өгөөгүй байна. Та анхнаасаа миний хэлснийг буруу ойлголоо. Би таныг маш их эвгүй хэрэгт өртүүзэй гэж сануулах гэсэн юм. Гэтэл та намайг золтой л буудчихсангүй ... гэв. Хошууч лонхтой шарзыг шүүрэн авч, шууд амаар нь хэд залгихдаа эрүү нь дагжиж, шилийг торжигнуулж байв, — Барон та надад ямар буруу өгөөд байгаагаа хэлээд аль! Шульцийг уйлах шахан өгүүлэхэд Гольдринг түүнийг хүйтнээр зогсоож, — Тайвшир, хошууч аа! Та офицер хувцас өмссөн эр хүн байж, шивэгчний хормогч өмссөн эм хүн шиг бүү аягла! Учир юу вэ гэвэл хэдэн долоо хоногийн өмнө штабт зөвлөлгөөн болж, «Төмөр нударга» ажиллагаа нурж унасан шалтгааныг хэлэлцэх үед та германы командлалын зохиосон зургийн хуулбар нь оросын командлалд байсан байна гэдэг яриа гаргасан байна лээ. Тэгэхдээ миний биеийг сэжиглэсэн үг ил цухуйлгасан байна лээ гэсэнд — Тэр чинь таавар төдий юм. Та өөрөө ч үг цухуйлгасан хэрэг гэж хэллээ шүү дээ гэхэд нь — Тэр бол гэмээ бусдад тохих гэсэн оролдлого байжээ. Буруугаа булж сурсан улсын шалгарсан арга даа. Таны их сүрхий сонор сэрэмжтэй дүрэм гаргаад байгаагийн учрыг би бүүр тэгэхэд ойлгосон юм. Одоо нотолгоог нь олж авлаа гэж Генрих хэлээд ширээн дээрээс цомгийг авч, генерал Даниелийн зурагтай хуудсыг нээж үргэлжлэн ярьсан нь: — Өөрөө хар. Энэ зураг дээр үнэн хэрэг дээрээ ажиллагааны газрын зургийг татсан байна. Генерал Даниель бол танд хүний анхаарлыг хөндийрүүлэхэд л хэрэгтэй байж. Энэ гэрэл зургийн хальсыг нь өсгөдөг аппаратаар тодруулбал стратегийн газрын зургийн яг оновчтой нарийн хуулбар гарна. Та энэ зургийг 12-ны өдөр буюу өөрөөр хэлбэл уг ажиллагаа эхлэхээс өмнө авсан гэдгийг өөрөө тэмдэглэсэн байна. Оросуудтай уулзахаар бэлтгэхэд нэг их цаг ороогүй биз. Таны мөнгөнд шуналтайг бүгд мэднэ. Тэгэхлээр газрын зургийг оросуудад их

мөнгөөр худалджээ гэдгийг үнэмшинэ ... Үр дүн нь юу болов оо гэвэл манай хоёр дивиз үнэн хэрэг дээрээ сөнөсөн байна ... Хальс нь танд алга, тэгэхлээр оросуудад байж таарна. Тийм шив дээ? гэв. Хошууч ухаан алдах шахаж, царай нь хувхай цайгаад айсандаа хүүхэн хараа нь томорсныг Генрих харлаа. — Та энэ зэмлэлийг хоосон үгээр биш, бодит баримтаар няцааж лав чадах уу? гэсэнд — Бн генералын зургийг авснаас биш, газрын зургийг нь аваагүй юм гэж Шульц дуу алдсанд — Энэ үгээ нотлох хэрагтэй. Та хальсыг нь оросуудад өгөөгүй гэж нотолж чадах уу? гэв. Хошууч дуугарсангүй, эрүү нь чичирч байлаа. Өөрт нь ямар аюул заналхийлж байгааг Шульц сая л ухамсарлав бололтой. Энэ зэмлэлийг зөвхөн амаар эсэргүүцэж чадахаас баримтаар эсэргүүцэж чадахгүй. Гэтэл хоосон үгэнд хэн итгэх билээ. — Барон, энэ чинь аймшигтайяа! гэж хошуучийг гайхаш тасран дуугарахад нь — Ашгүй та нэг ойлгов уу? гэв. — Би таны хэлж байгаа хэргийг энэ насандаа хийгээгүй болохоор аймшигтай байна. — Хошууч таныг би зэмлэж байгаа хэрэг биш, танаас болж үр хүүхэд нь өнчин хоцорсон олон зуун хүн зэмлэж байна. — Ээ тэнтэр минь! гэж хошууч уулга алдав. — Би германы офицер хүний ариун нэр төрийг бодож энэ тухай дээд байгууллагад нэн даруй мэдэгдэх ёстой ... гэсэнд Шульц Генрихийн гарыг шүүрэн авч мөргөх шахаад — Барон! ... гэхэд нь Генрих үгээ зориуд сунжруулан — Гэвч ... Гэвч би юу ч хэлэхээ байя. Таныг, танай садан төрлийнхнийг өрөвдсөндөө ч тэр биш. Үнэнээ хэлэхэд Штабын зөвлөгөөн дээр таныг болгоомжгүй үг цухуйлгалаа гэж өсөрхсөндөө таныг барьж өглөө гэж хүн бүү бодоосой гэсэн хэрэг. Та миний үгний учрыг ойлгов уу? гэсэнд — Ай барон! гэж айж хэлмэгдээд гүйцэд сэхээ авч чадаагүй байгаа Шульц ухаан алдталаа баярлан дуу алдав. — Та тэгвэл миний тус болсныг мартаагүй биз гэсэнд — Би үүнийг үүрд санаж, ачийг чинь юугаар ч хариулахад бэлэн байна! гэж Шульц хэллээ. — Мөнгөөр ач хариулах яриа байж болохгүйг та сайн мэдэж байгаа биз. Та хэзээ нэг цагт хэрэг гарвал надад нөхөр журмын тусламж үзүүлээрэй. Хошууч та зөвшөөрөх үү? Тохиролцох шив дээ? гэж Генрих хэлсэнд — Танд чадахын хирээр баяртайяа тусална гэхэд нь — Та германы армийн офицер миний нэр төрийг ганц ч удаа доромжлох юм бол ... гэсэнд — Тэнгэр өршөө! Хэзээ ч ямар ч нөхцөлд тэгэхгүй! гэж Шульц алдав. — За сайн байна. Бид үг хэлээ ололцож таарлаа. Гэтэл та буу гаргах гээд байлуу гэсэнд Шульц гар буу тийшээ нэг харж, дэлгээстэй байгаа цомгийг нэг хараад мөшийн инээмсэглэж, нэг юм асуух гэснээ шийдэж зүрхэлсэнгүй. Генрихийн өгүүлсэн нь: — Би ойлгож байна. Хошууч та хэлсэн үгэндээ эзэн болж, надад тус болбол энэ гэрэл зургийг танд эгүүлж өгнө гэж амалъя. Та тэгж гуйх гэсэн биз дээ? гэсэнд хошууч дуугүй толгой дохилоо. Генрих гэртээ ирж, мундирээ тайлчихсан хойноо хурандаа дээр орно гэж амалснаа сая санаж, мундирээ дахин өмсөх гээд хэсэг эргэлзэн зогссоноо сандал дээр шидэж орхилоо. Генрих хуруугаа ч хөдөлгөх тэнхээгүй болжээ. Чинээндээ тултал хөвчирсэн сэтгэл мэдрэлээ амраахын тулд нэн даруй унтах хэрэгтэй байлаа. Гэтэл Генрих тэр орой удтал унтаж чадсангүй. Хошууч Шульцийн цомгийг хуудас хуудсаар дахин эргүүлж үзэх мэт нүдний нь өмнө үзэгдэж байлаа. «Аугаа их эрин үеийн баримт» гэж тэр гэрэл зургуудыг Шульц хэлж байсан. Баримт мөн нь мөн. Харин яллах баримт юм. Хошууч Шульцийн цомгийг хүн бүхэн үзэх цаг ирэх биз.

ЗАМД ТӨРСӨН БОДОЛ Ихэд дарагдан хохирсон корпусыг Францад шилжүүлж,

оронд нь өөр корпус ирнэ гэсэн мэдээ түргэн зуур тархан бүх офицерын сэтгэлийг хөдөлгөсөн нь мэдээжийн хэрэг. Энэ тухай одоохондоо асар их нууц мэт шивэр авир ярилцаж байгаа боловч бүгд баярлан сэтгэл хөөрсөн байдалтай байлаа. Гэсэн ч офицеруудын заримыг Дорнод фронт дээр үлдээх юм гэж дуулдах тул баахан сэтгэл зовоож үл итгэх бодол төрүүлнэ. Энэ нь фронтынхонд хамаарахаас биш, штабын ажилтан нарт хамаагүй гэж офицерууд бие биеийнхээ сэтгэлийг засна. Корпусыг шилжүүлэн байрлуулах албан ёсны тушаал өгсөн хойно л бүгдийн сэтгэлийн түгшүүр сая намдав. Яг тэр өдөр Бертольд энэ баярт мэдээг сонстохоор Генрихийг дууджээ. — Ашгүй нэг тушаал ирлээ. Ингээд бид явна. Үнэнээ хэлэхэд биднийг энд үлдээх нь үү гэж айж байлаа шүү ... гэж хурандааг хэлэхэд — Эрхэм хурандаа та явах бодсонтой уялдуулан ямар нэг даалгавар өгөх гээ юу? гэсэнд — Чи буудал дээр очиж манай хэлтсийн эд хогшлын ачаалалтыг хянах хэрэгтэй байна. Хоёр өдрийн дотор амжуулна биз гэв. — Амжина гэж найдаж байна. — Явах болсныг дуудаад чи онц их баярлахгүй байх шив дээ. Сүүлийн хэд хоног яагаад ийм уруу царайтай байгаагийнхаа учрыг надад хэлэх үү. — Би Дорнод фронтоос явахыг онц хүсэхгүй байна. — Үгүй, чи маш хачин бодолтой хүн юмаа даа. — Би орос хэл, оросын зан заншил, Орос орны ерөнхий нөхцөл байдлыг сайн мэддэг болохоор чухам энд байхыг илүү ашигтай гэж бодсон юм. — Өөрийгөө бас бодох хэрэгтэй шүү. Чи энэ бөглүү нутагт бишгүй удаан суулаа. Францад бол ... Ай Франц сайхан шүү! Тэнд хэдхэн хоног болоод сэтгэл чинь дороо сэргээд ирнэ. Ингэхэд хошууч Шульцийг өөр ангид шилжүүлэх болсныг мэдсэн үү? — Аа тийм үү? Тэр чинь мөн хулчгар эр юмаа гэж Генрих хэлээд учиртай инээмсэглэсэнд — Чи түүнтэй энээ тэрээ болоогүй биз? гэв. — Үгүй, энгийн нэг найрсаг ярилцсан. Тэр ч байтугай хошууч надад сайн санааны дурсгал болгож гэх үү дээ, нэг жижиг зүйл бэлэглэсэн. — Шульц өөрөө шилжүүлж өгөөч гэсэн хүсэлт тавьж, түүнийг дээд дарга нарын мэдэлд шилжүүлсэн. Шульц өчигдөр явсан. Энэ тухай юу хэлмээр байна? — Түүнийг чөтгөр аваг! Надад хошууч Шульцийн хувь заяаг бодож байх чөлөө алга. Хэдийд явахыг тушаах бол? — Маргааш өглөө. Чамайг ажил амжуулна гэж бүрэн найдаж байгааг санаарай. — Бүгдийг аль болох сайн гүйцэтгэе. — Бас хөгжилтэй цовоо бай. Үзэсгэлэнт сайхан Франц нутагт сайн сайхан юм бүхэн чамайг хүлээж байгааг санаарай гэж хурандаа хэллээ. Бертольдтой ярьсны дараа ч Генрихийн сэтгэл сэргэсэнгүй, маргааш нь бүүр дорджээ. Үргэлж найрсаг хөгжилтэй байдаг Генрих хэлтсийн эд хогшлыг вагонд ачиж байгаа цэргүүдийг зантран загнаж, өөрийн үйлчлэгч цэрэг Эрвин Бреннерийг бүүр залхаасан тул цаадахь нь Генрихийн нүдэнд өртөхгүйг хичээх болов. Ямагт тайван байдаг бароныг бүүр өөр хүнээр сольчихсон юм уу гэмээр байлаа. Маргааш өдөр нь орой тийшээ хэлтсийн эд хогшлыг ачиж дуусав. Өгсөн үүргийг цаг тухайд биелүүлсэн боловч дэслэгч фон Гольдрингийн санаа сэтгэл сэргэсэнгүй. Генрих офицеруудын гуанзанд уруу царайтай ирээд танхимд хүнгүй шахам байсан боловч цонхны дэргэд байгаа хамгийн цаад талын ширээнд очиж суув. Хоол зөөтч хүүхэн захиалга авч байх үед Генрихийн сууж байгаа ширээний дэргэд өндөр нуруутай туранхайвтар ахлах дэслэгч ирээд — Эрхэм дэслэгч таны дэргэд суухыг зөвшөөрнө үү гэхэд нь — Болно. Тантай хамт хоол идэх нь надад тааламжтай байна гэж хариулав. Ахлах дэслэгч мэхийн хүндэтгээд сууж хоолны цэсийг үзэж гарлаа. — Хоолны цэс дээр пиво байгаа эсэхийг бичээгүй байна, Би одоо нэг аяга хар пиво дуртайяа

уухсан гэхэд нь Генрих тэр офицерыг анхааралтай ажиглаад — Бий байх гэж бодож байна. Та явуулын хүн юмаа даа? гэсэнд — Тиймээ. Эх нутгаас дөнгөж сая ирлээ гэжээ. Ингэж ярилцаж байтал хоол зөөгч хүүхэн Генрихийн хоолыг авчирч яриаг тасалдуулав. Хоол зөөгч эмэгтэн ахлах дэслэгчээс: — Та юу захиалах вэ? гэж асуусанд ахлах дэслэгч пиво бий эсэхийг ч асуусангуй: — Нэг аяга хар кофе, хэдэн нарийн боов авъя гэхэд тэр эмэгтэй захиалсан зүйлсийг авчрахаар одлоо. — Та амраад ирэв үү? гэж Генрих сонирхсонд — Гэртээ хэсэг байж байгаад одоо дахин фронтод очиж явна гэж ахлах дэслэгчийг өгүүлэхэд — Эх нутгаар сонин юу байна? гэсэнд — Бүгд хуучин хэвээрээ. Ингэхэд надад Дрездений сонин байна. Энэ сониноос та шинэ сонин зүйлийн тухай бүгдийг олж үзнэ гэж ахлах дэслэгч өгүүлээд эвхэж нугалсан сонин гаргаж Генрихт өгөв. — Маш их баярлалаа, Завтай цагтаа дуртайяа уншъя гэж Генрих хариулаад халааснаасаа нэг товхимол гаргаж, — Би өнөөдөрхөн энэ жижиг номыг уншаад байна. Маш сонин юм. Та хүсвэл энэ номыг танд бэлэглэе гэсэнд ахлах дэслэгч уг номын нэрийг ч харалгүй далд хийж, аягатай кофегоо тайван ууж дуусгаад ширээн дээр мөнгийг тавьж. Генрихт мэхийн ёслоод гарч одлоо.

Гольдринг мөчийн дараа өөрт нь хоёр хоногийн турш түр байр болж байгаа вагоны өрөөнд хүрч ирэв. Өнөөдөр штабтаа буцаж очно гэдгийг урьдаас дуулгасан үйлчлэгч цэрэг нь юм хумаа баглаж янзалж байлаа. Генрих явахыг яарсангүй. Хаалгаа түгжиж, хөшгөө буулгаад нөгөө сониныг гаргаж, тун сонирхолтой зүйл олсон бололтой удтал уншив. Харин их л хачин, дороос дээш унших агаад үе үе зарим үг үсэг дээр хүртэл удаан саатан зогсоно. Уншсан сонин нь түүнд их таатай байсан бололтой. Яагаад гэвэл Генрих хагас цагийн лараа штаб орохоор машинд суухдаа сайхан зантай болсон байгааг Эрвин ажиглажээ. Генрих зам турш дуу аялж, үйлчлэгч цэрэгтэйгээ урьд ер тэгдэггүй байснаа алиа хошин үг ярьж явжээ. Галт тэрэг өрнө зуг алгуурхан хөдөлнө. Урд нь хэдэн зуун метрийн зайтай газар уурын бух тэрэг ачаатай тавцангуудыг чирж явах бөгөөд энэ нь галт тэрэг зорьсон газраа саадгүй хүрэхийн баталгаа байв. Партизанууд зам төмөр дор мина зоосон бол юуны түрүүн тэр уурын тэрэг, тавцангууд зад үсэрч, цэргийн цуваа нь бүрэн бүтэн үлдэнэ. Тэр цуваанд яваа хүмүүс бүгдээрээ Белоруссын нутаг дэвсгэрээр тайван өнгөрнө гэж найдаж байлаа. Партизанууд одоо хүртэл их төлөв өрнөөс дорно зүг яваа галт тэргийг голлон анхаардаг байжээ. Гэвч болгоомжлоход илүүдэхгүй. Тийм ч учраас ачаатай тавцангууд бүхий уурын тэргийг түрүүнд нь явуулсан байна. Барааны вагонуудын нээлттэй хаалгаар хүнд пулемётын ам ёрдойж харагдах бөгөөд цэргүүд бүгд буу зэвсгээ дэргэдээ авч явжээ. Ноён офицеруудын сууж яваа шилдэг вагонуудад аюулын тухай бага бодно. Офицерууд илүү зүрхтэй улс болоод ч тэр биш, ердөө тийм юм бодох завгүй явжээ. Зарим нь ууж хөлчүүрсний дараа унтаж амарч, нөгөө зарим нь шараа тайлж, бусад зарим нь ердийн адил зав чөлөө л гарвал хөзөр тоглоно. Генрих, хурандаагийн хамт цувааны дунд талын шилдэг вагоны нэгэнд сууж явлаа. Захын өрөөг үйлчлэгч цэргүүдэд зориулж, түүнээс цааш офицерууд нэг өрөөнд зарим нь хоёр хоёроороо, зарим нь гурав гурваараа суужээ. Хурандаа, Коккенмюллер, Генрих гурав тусгай тусгай өрөөтэй байлаа. Дэслэгч өөртөө тусгай өрөө өгсөнд нь Бертгольдод үнэнээсээ талархана. Энэ нь түүнд ганцаар элдвийг эргэцүүлэн бодох бололцоо олгожээ. Бодол нь тийм ч хөгжилтэй сайхан биш байв. Вагоны цонхны дэргэдүүр танил нутгийн

байгалийн байдал алгуурхан өнгөрнө. Генрих энэ нутгийг хэдийд дахин үзэх бол? Энэ харийн гутамшигт муухай мундирээс хэзээ нэг салж, өөрийн ерийн хувцсыг өмсөж, ойд очиж өвөл бол цасанд дарагдсан моддын дундуур санаа амар тэнэж, зун бол ногоон зүлгэн дээр гэдэргээ харж хэвтээд хязгааргүй хөх тэнгэрийг тайван ширтэж байх цаг хэзээ ирдэг бол? Эцэг нь үргэлж дуулж өгөөч гэж гуйж байдаг өөрийн дуртай дууг нууж хаалгүй тэнхээ мэдэн дуулж болох цаг хэзээ ирдэг бол? Ер нь эцэгтэйгээ хэзээ нэгэн цагт нүүр учран золгодог болов уу? Анд нөхөд, танил хүмүүстэйгээ уулздаг болов уу? Дайнаар тасалдсан хичээл сургуулиа үргэлжлүүлэх бололцоо олддог болов уу? Генрих төрөл садныхандаа бол «Сураггүй алга болсон» хүн. Эцэгт нь тийм мэдээ өгөх болно. Эцэг нь тийм мэдээ аваад хичнээн их гуниг зовлонд унах бол? Гэтэл ингэх хэрэгтэй. Хэрэгтэй! Өөрийн бүх төрөл төрөгсөд, танил хүмүүст бол Генрих үхсэн амьд нь үл мэдэгдэх, сураггүй алга болсон хүн. Гагцхүү Москвад одоо Генрих фон Гольдринг гэсэн нэр зүүж яваа хүний энэ завсар юу хийж амжсаныг мэдэх хэдхэн хүн бий. Тэр хүмүүс л одоо өөрийн нь хаана яваа өнөөдөр юм уу маргааш юу хийх ёстойг мэдэж байгаа. Генрих өөртөө даалгасныг биелүүлэх ч болно. Үүний тулд амиа өгөх хэрэгтэй боллоо ч гэсэн биелүүлнэ. Үүнийг Эх орныхоо төлөө, одоо өөрийн нь хойноос уй гашуу болж байгаа, олон жил уй гашуу болох эцгийнхээ төлөө хийнэ, Шульцийн цомгийг үзсэн тэр орой яаж зовсон гэж санана. Генрих өөрийгөө илчилж, хошууч тийш ухасхийн дайрмаар үе тохиолдсон билээ. Биеэ барих гэж хичнээн хүч чармайлт гаргасныг нь хэн хэзээ ч мэдэхгүй. Биеэ барих хэрэгтэй байсан болохоор барьж чаджээ. Одоо улам хүнд хэцүү болно. Үүнээс хойшид зөвхөн дайсны дунд байхаар үл барам, бас харийн нутагт байх болно. Корпус нь Белоруст байхад бол илэрлээ гэхэд ойд, партизанууд дээр зугтан очиж болох байлаа. Энд дайсны дунд байгаа ч гэсэн гэртээ, эх нутагтаа сууж, ард түмнийхээ үлэмжийн их хүч, нүдэнд үл үзэгдэх дэмжлэг, барагдашгүй их сэтгэлийн тэнхээг нь цөм ямагт мэдэрч байлаа. Тэгвэл одоо харь газар очиж суух болж, ямар нэг гай тохиолдвол ганц гарах зам нь өдөр шөнийн эргэлтэд биенээсээ салгадаггүй бяцхан гар буу болжээ. Гэсэн ч Гольдринг амьд явах болно. Чөтгөр алгад! Дайсныг тэгэхээс тэгэх гэж удаан амьд явах болно. Түүнд гестапогийн эрүүлч тагнуулчдыг мөрөөрөө оруулахгүй байх хүч хүрэлцэнэ. Үнэндээ барон фон Гольдрингийн нэр зүүж явах нь зарим үед ой гутмаар муухай санагдах ажээ. Хэзээ нэг цагт энэ тухай төрөл садан, анд нөхөддөө ярих ч болно. Одоо бол би хэн билээ, юуны тулд дайсны ичээнд намайг илгээлээ гэдгийг хоромхон зуур ч мартажгүй санаж, дув дуугүй байх хэрэгтэй. Хэдий тийм боловч Генрихт хүнд хэцүү гэхэд туйлын хүнд хэцүү байна. Театрын жүжигчин бол завсарлагааны үед амарч болно, жүжигчид бүхэл өдөржингөө өөрөө хэн бол хэр янзаараа байж болно. Гэтэл Генрих хоромхон зуур ч зогсолгүй цаг ямагт рольдоо жүжиглэж бас аль болохуйц сайн жүжиглэх ёстой. Шөнө ч амрах цаг байхгүй. Юу вэ гэвэл шөнийн цагт ч сэргэг байж, зүүдэлж үг алдахгүй биеэ манаж байх хэрэгтэй. Гэтэл амрах цаг өдий байна. Ер нь дайн дуусахыг үздэг болов уу? Ийм ёроолгүй нүхний амсар дээгүүр явж байгаад уначихдаггүй байгаа? Үгүй, энэ бодлоо зайлуулъя! Одоо бол би чинь барон фон Гольдринг. Тэгвэл зүгээр ч үгүй барон хэргэмтэй фон Гольдринг юу бодох ёстой вэ? Хөзрөөр бирж тоглох, Францад очиж зугаалж цэнгэхээ бодож, Лорагаас ирсэн, одоо болтол уншаагүй байгаа захидлыг бодох хэрэгтэй. Генрих, Лора хоёрын захидал харилцааг тасалдуулахгүй гэж хурандаа анхааралтай ажиглаж байгаа болохоор

тэр захидлыг унших ч хэрэгтэй. Коккенмюллер Бертгольдын өрөөнөөс гарч ирээд — Таныг эрхэм хурандаа ороод ирнэ үү гэж байна гэлээ. — Хамт хоололцгооё, эрхэм ноёд оо. Би ганцаараа уйдаад байна гэж дивизийн дарга офицеруудыг урив. Үйлчлэгч цэрэг нэгэнт зассан ширээн дээр хоёр лонх архи авчирч тавиад чимээгүй гарч одлоо. Хоол идэж байх үед Коккенмюллерийг: — Бид Варшав хотод нилээд удаан зогсох юм гэдэг үнэн үү? Эрхэм хурандаа? гэж асуухад — Та үүнийг юунд сонирхоо вэ? гэв. — Энэ гайтай Белоруссаас бүр залхаж гүйцлээ. Аятайхан шиг хотын гудамжаар алхаж үзмээр байна гэсэнд Бертгольд жуумалзаж, — Та нарын яаж зугаалдгийг эс мэдэх биш! Та нар эмс хүүхэнгүй бол уснаас гаргаад хаячихсан загас шиг байдаг. Уйдаж хагсаж орхиод Варшавын хөөрхөн хүүхнүүд найрсаг угтана гэж горьдож байна уу? гэхэд нь Коккенмюллер Варшавын хүүхнүүдийг магтаж гарлаа. — Зургаан цаг орчим зогсох байх. Тэгэхлээр та нарт зугаалж цэнгэх боломж олдоно гэж хурандаа туслахынхаа сэтгэлийг тайвшруулав. — Хамт зугаалах уу, барон? гэж ахмадыг өдөхөд — Би нэг хүнд ам өчиг өгчихсөн! гэж Генрих хариулав. Хурандаа гайхсанаа нууж чадсангүй. — Уухай! гэж дуу алдсанд — Би фрейлейн Лорад эмэгтэйчүүдтэй танилцахгүй гэж ам өгсөн юм. Мэдээжээр фрейлейн Лора өөрөө танилцуулбал жич хэрэг гэж Генрих учирлав. — Аа та нар чинь цагийг дэмий өнгөрүүлэхгүй, шуудан харилцааг ажлаар дарж байгаа улс байна! гэж хурандаа хуруугаа гозолзуулан тоглоомоор занаж, царайд нь баярын инээмсэглэл тодрон. — Та фрейлейн Лоратай уулзсан юм уу? гэж хурандаагийн туслахыг асуухад, — Бид бага байхдаа уулзсан юм. Одоо эчнээгээр дахин танилцаж байна гэсэнд — Генрих чамд удахгүй чөлөө өгч болно байх. Тэгэхлээр Лоратай уулзах болно гэж Бертгольд амлажээ.

Дивизийн цуваа Оросын нутаг дэвсгэрийн хилээс гараад зөвхөн том өртөөн дээр түр саатан зогсож, урьдынхаас ихээхэн хурдан явах боллоо. Энэ нь Берлинд ядаж богино хугацааны амралтын чөлөө авахаар горьдож байсан олон офицерын төлөвлөгөөг эвджээ, Командлалаас нэг ч хүн үлдээлгүй тогтоосон цагт томилогдсон газраа бэлэн очихыг хатуу тушаасан байлаа. Цуваа дөрөв дэх хоногтоо Францын хилийг давж, мөн тэр өдрийнхөө орой тийш томилогдсон газар болох Францын жижиг хотод Ирэв. Маргааш өглөө нь Генрих хамаг цагаа 1—Ц хэлтсийн албан ажлыг зохион байгуулахад зарцууллаа. Тэгээд ч үдийн хоолны үед хурандаад юм болгон бэлэн болж, маргааш ажилдаа орж болох болсныг илтгэх бололцоотой болов. Гэтэл хурандаа, Генрихийн үгийг чихний үзүүрээр сонсож, өөрөн их дурладаг аар саар аятай тохьтой зүйлийг өчүүхэн ч сонирхохгүй байгааг Генрих гайхаж жаахан гомдоод — Эрхэм хурандаа таны сэтгэл дундуурхан байна уу? гэж асуусанд — Энэ ажил чи бид хоёрын хэн хэнд хамаагүй болсон шүү, хүү минь гэж Бертгольд ёсорхуу өгүүлэв. — Би учрыг ойлгохгүй байна ... — Тоогүй юм болж, бид хоёр түр зуур холдож салах хэрэгтэй боллоо. Өнөө шөнө намайг Гиммлерийн мэдэлд шилжүүлэн томилох тушаал ирсэн. Намайг чухам ямар ажилд тавихыг одоогоор мэдээгүй байна. Ямар ч атугай энд эргэж ирэхгүй байх Берлинд үлдэх болж магадгүй. Генрихийн царайд харамссан, бүр сандарсан байдал илрэв. Хурандаагийн явах болсон нь Генрихийг төвөгтэй байдалд оруулжээ. Шинэ дарга нартай ямаршуу харилцаатай болохыг хэн мэдэх билээ. Бертгольд ч гэсэн хагацах болсондоо сэтгэл догдолж уярсан бололтой, өгүүлсэн нь: — Битгий гуньхар, хүү минь!

Бидний харилцаа үүгээр тасрахгүй. Би чамайг анхаарч халамжлахыг өөрийн ариун үүрэг гэж үзэж байна. Тэгээд бага сага хэрэг бүтээлээ. Би чухам ямар ажилд томилогдох гэж байгаагаа товтой сайн мэдсэнсэн бол нэг ч минут эргэлзэлгүй чамайг хамт аваад явахсан. Одоо тэгэхэд амаргүй байна. Ганцаар л явахаас биш. Хожим чамайг татаж авья. Чамайг энд үлдээмээргүй байна. Манай корпусыг татан буулгах сураг бий. Чамайг зэлүүд бөглүү газар томилчихож магадгүй. Миний эртний танил, ялдамд хэлэхэд чиний эцгийг бас таньдаг генерал Эверс одоо Францад дивиз командалж байгаа. Өнөө өглөө би түүнтэй утсаар ярьсан. Тэр чамайг штабтаа бас онцгой даалгавар гүйцэтгэх офицероор авахыг зөвшөөрсөн. Би ч чамайг аль сайнаар тодорхойлж магтсан. Тэгээд генерал Эверс, чамайг аль болохоор дэмжин тэтгэж, ажлаар их дарахгүй байна гэж амласан. Энд бас зохих улстай ярьж өнөө орой чамд хэрэгтэй бүх бичиг баримтыг шийтгэж олгуулахаар болсон. Чи маргааш юм уу, хамгийн цаанадаа нөгөөдөр генерал Эверсийн штабт очих хэрэгтэй. Би маргааш өдрийн арван хоёр цагт Берлин руу явна. Намайг явуулчихаад өөрөө мордох биз гэхэд нь — Миний чухам хаашаа явах ёстойг та надад хэлээгүй шүү гэсэнд — Эверсийн дивиз янз бүрийн хот тосгонд байрласан юм. Тэр дивиз цэргийн холбогдолтой газруудыг хамгаалж байдаг. Штаб нь Сен-Ремид байрласан байна. Тэр бол Францын өмнө зүгт байдаг рашаан амралтын бага шиг хот байгаа юм. Чамд сануулах юм байна. Сүүлийн үед Францад цаг тайван биш болоод байгаа. Бодоод үзээч, тэнд бас герман офицеруудыг авладаг партизанууд бий болсон байна шүү. Булангийн цаанаас буудах явдал ердийн үзэгдэл болжээ. Тэгэхлээр болгоомжтой, тун болгоомжтой байгаарай гэхэд нь — Эрхэм хурандаа танаас салахад маш их гунигтай байна. Та ажилд томилогдохоороо надад хэл мэдээ өгөх биз дээ? гэсэнд — Аль болох хурдан мэдэгдэнэ. Би Эверсийн дивизийн хаягийг бичиж авсан. Юм бүгд тодорхой болсон даруй чамд захиа бичнэ. Чи ч гэсэн надад тогтмол захиа бичиж, бүх ажил явдлын тухай мэдээлж байх хэрэгтэй. Генерал Эверст миний өгсөн тодорхойлолтыг чи бүрэн баталж чадна гэж найдаж байна гэхэд — Та миний өмнөөс нүүр улайхгүй гэсэнд — Бас фрау Эльзад захиа бичиж байхыг бүү мартаарай. Эльза, чамд төрсөн хүү шигээ байдаг юм. Миний бодоход Лора ч гэсэн чамаас захиа хүсэж суугаа даг. Би эндүүрээгүй биз? гэхэд нь — Өө та намайг ариун үүргээ мартаж хүн гэж бодно уу гэсэнд — Одоо ингээд гүйцэх нь шив. Явж амар. Би маргааш явахынхаа өмнө завтай байхыгаа бодож хагас цагийн дараа ажлаа хүлээлгэж өгч эхэлнэ гэлээ. Маргааш нь өдрийн арван хоёр цагт Бертгольд Берлин рүү явж, Генрих галт тэрэгний буудал дээрээс шууд Сен-Реми орохоор машинаар гарлаа.

МОНИКА БУУЛТ ХИЙВ Засмал зам нь таримал модтой сайхан гудамж шиг санагдах Генрих байгалийн байдлыг харж нүд хужирлах гэж Эрвинд хурдаа саахыг тушаав. Байгалийн байдал үнэхээр үзэсгэлэнтэй сайхан ажээ. Тэгш тал ард үлдээд одоо замын дагуу ногоогоор хучигдсан дов толгод үргэлжилнэ. Гүвээ толгод улам улам өндөр болж, Альпын нурууны бэлийг дэлдэх асар их давалгаан мэт нэг нэгийгээ халхална. Зам мурилзаж эхлэхэд Эрвиний оронд Генрих өөрөө жолоо барья гэлээ. Генрих машин муугүй барьдаг туршлагадаа найдсан боловч машины зам асар их байц хад буюу ууланд тулж очих шиг болох бүрийд өөрийн эрхгүй бие арзасхийнэ. Зөвхөн холоос тэгж харагддаг байжээ. Ойртоод очиход засмал зам, түүний хажуугаар явсан төмөр зам

хонгил нүх рүү орж, төдхөн байц хад буюу уулын цаад талаар нэвт гарсан байдаг байв. Замын нэг тохой тойроод засмал зам, төмөр зам хоёул багахан мөртлөө ширүүн урсгалт уулын жижиг голыг дагаж, тэр голтой хамт мурилзан оджээ. Баруун хойт талаас голын эрэгт уулс маш ойрхон тулж ирсэн тул замыг одоо л таглаад авах нь уу гэж санагдах агаад голын урсгал уулыг тойроод огцомхон эргэж мурилзана. Голын ус хөдөлж яваа амьд зам заагч шиг урсах тул Генрих машины жолоог баруун, зүүн тийш эргүүлэн мушгихад засмал зам хязгаар төгсгөлгүй юм шиг дугуйн доогуур жирэлзэн өнгөрсөөр байлаа. Тийм нэг тохой тойртог Сен-Реми нутаг Генрихийн нүднээ гэнэт үзэгдлээ. Сен-Реми, байгаль дэлхий өөрөө энд хүн сууг гэж зохион бүтээсэн юм шиг хотгорт байрлажээ. Шилмүүст модоор хучигдсан намхавтар салаа уулс тэгш талыг зүүн хойт зүгийн салхинаас халхална. Баруун өмнө зүгт асар том тэгш өндөрлөг сүндэрлэн харагдана. Голын эргийн бүүр дэргэдээс усан үзмийн тариалан эх авчээ. Засмал зам хотын гол гудамжаар гарсан байна. Тэр гудамжны хоёр талаар Сен-Реми аль олигтой байшин, албан газар байрлажээ. Генрих штабын байрыг удаан эрэх хэрэг гарсангүй Анх түрүүн асуухад генерал Эверс, энэ хотын шилдэг сайн байхад суудаг, дивизийн штаб хамгийн том «Европа» зочид буудалд байрладаг гэж хариулав. Генрих таван минутын дараа «Дивизийн даргын туслах ахмад Лютц» гэсэн бичигтэй хаалга тогшиж байв. — Орогтун! гэж аятайхан хүнгэнэсэн дуутай хүн дуугарлаа. Ширээний араас Лютц өөрөө мөн бололтой, өндөр туранхайвтар ахмад, Генрихийг тосон босож ирэв. Ахмадын биеийн бүхий л төрх байдал, ялангуяа дүрлэгэр том бор нүд нь ихэд алжааж ядарсныг харуулна. Бас Лютцийн хайш яйш самнасан үс нь ч гэсэн ихэд ядарч, биеэ хайхрахаа больсныг илтгэнэ. Өтгөн хар үсээ овойлгож самнасан байх боловч ахмадыг өчүүхэн төдий хөдлөх бүр үргэлж дух руу нь унжина. Генрих өөрийгөө танилцуулж: — Би дэслэгч фон Гольдринг байна гэсэнд ахмад Лютц ширээ тойрч, Генрихийн өөдөөс хэд алхаад — Би дивизийн даргын туслах ахмад Лютц байна. Та суухтун гэхэд нь — Би танай дивизийн штабт томилогдсон гэж Генрихийг эхлэн ярих гэтэл Лютц түүний үгийг тасалж: — Таны томилолтыг мэднэ. Таныг өнөөдөр ирнэ гэж хүлээж байсан юм гээд Лютцийг ширээний ард байрандаа очиж суухад нь, Генрих бичиг баримтаа гаргаж өгөв. Лютц түүнийг дуугүй авч үзсэнээ томилолтыг нь үлдээж, бусдыг нь Генрихт эргүүлж өгөөд — Бароны таны ирсэн явдалд маш их баярлаж байна гэж инээд алдаад, Үнэнээ хэлэхэд хувиа бодоод баярлаж байгаа юм. Та миний ажлыг бага зэрэг хөнгөлж өгнө биз гэж найдаж байна. Ажил их, юм болгонд ганцаардаад хэцүү байна гэж нэмж хэллээ. Ахмад илүү дутуу маяггүй энгийн харилцаатай хүн ажээ. — Таны сайн туслагч болохыг хичээе гэж Генрихийг өгүүлэхэд — Харамсалтай нь та миний туслагч болохгүй. Та онцгой даалгавар гүйцэтгэх офицероор томилогдсон. Маргааш тушаал гарна. Би одоо хүртэл туслагчийн үүргийн зэрэгцээгээр таны үүрэгт ажлыг хавсран хийж байсан болохоор таны ирсэн нь миний ажлыг үнэндээ их хөнгөвчилнө. Ер нь ажил явдлаар ч гэсэн эрхэм дэслэгч та бид хоёр үргэлж уулзаж байх болно. Та бид хоёр нөхөрлөх байгаа гэж найдаж байна гэхэд нь — Энэ талаар надад өчүүхэн ч эргэлзээ алга, эрхэм ахмад аа гэсэнд — За сайн байна. Одоо танд байрыг чинь зааж өгье. Би штабын байранд суудаг, Бид эндхийн хоёр давхрыг эзэлдэг юм. Хэдэн тасалгааг офицеруудын сууцанд зориулан гаргасан. Одоо сул байр байхгүй. Нэгдүгээр давхарт харуул манаа, манай офицеруудын гуанз байдаг. Ингэхлээр та өөр зочид буудалд суух болно. Тэр буудал «Европын» өөдөөс

харж байдаг. Ер нь тэнд суусан нь дээр гэж бодож байна. Аюулын аятайхан зочид буудал байгаа юм гэж Лютц ярьжээ.

Генрихт зориулж бэлтгэсэн байр «Темпль» зочид буудлын хоёрдугаар давхарт байв. Нэгдэх жижиг өрөөнд нь угаагуур, буйдан дугуй ширээ, хоёр сандал байв. Хоёрдахь том тасалгааг нь илүү сайн төхөөрөмжилсөн байлаа. Өргөн модон ор, бичгийн ширээ, зөөлөн сандал, шүүгээ, том толь, чемоданы тавиур багш. Генрих ийм тохилог байх юм гэж огт санасангүй. Ахмадын хөөцөлдөж тус болсонд нь үнэн сэтгэлээсээ талархлаа. — Та эндээс хотын байдлыг сонирхон харж болно гэж ахмад хэлээд хаалга онгойлгож хоёул тагт дээр гарлаа. — Нээрээ сайхан харагдаж байна гэж Генрих зөвшөөрсөнд — Бас хөөрхөн хүүхэн харуулдаж байх тохиромжтой газар шүү гэж Лютц хэлээд унадаг дугуйнаас бууж байгаа бүсгүйг нүдээр заав. Тэр бүсгүй машин өнгөрөхийг хүлээж байгаа бололтой, гудамжны наад талд зогсож байлаа. — Нээрээ их хөөрхөн хүүхэн байна. Хэн гэдэг юм бол? гэж Генрихийг асуухад Лютц инээмсэглээд — Аа-хаа. тийм байна уу? Эиэ бол таны буусан зочид буудлын эзэгтэй охин. Мадемуазельб Моника гэдэг юм гэхэд нь — Хөөрхөн хүүхэн байна гэж Генрих бодлогоширон өгүүлснээ, Ганц барон та тэгж үзэж байгаа бишээ. Манай бүх офицерууд Моникатай наалдаж налиганах гэж оролдоод хэрэг нь бүтээгүй юм шүү. Манайхныг ердөө хүн гэж тоодоггүй юм. Аз болоход хүүхэн болгон ийм хатуу биш. Энд хэдэн аятайхан хүүхэн бий. Тантай танилцууламз гэхэд нь. — Би аятайхан хүүхэн болгонд дуртай биш, гэхдээ надад ухаан нь ... энэ Моника шиг хүүхэн илүү тааламжтай байдаг. За ер нь эндхийн гоо хүүхнүүд, тэдний зан байдлын тухай сүүлд нэг завандаа ярьцгаая. Одоо юмаа төвхнөө гэв. Генрих ингэж хэлээд тагтын хайс дээгүүр тонгойж, дор машины дэргэд үлдсэн үйлчлэгч цэргээ дуудаж, юм хумаа оруулж ирэхийг тушаав. — Санасан минь яамай. Та энэ үйлчлэгч цэргээ авч үлдэх үү, эсвэл өөр хүн хэрэгтэй юу? гэж Лютцийг асуухад — Үгүй. Энэ хүн машинтайгаа буцна гэсэнд — Тэгвэл тан дээр нэг цэрэг явуулъя. Таныг санаандаа таарсан хүн олтол түр үйлчилж байг. Би хувьдаа үйлчлэгч цэргийг өөрөө шилж авах хэрэгтэй гэж үздэг гэхэд нь — Таны хэлснийг бүрэн зөвшөөрч байна гэлээ. Эрвинийг хоёр том чемодан оруулж ирэхэд: — Эрвин та одоо чөлөөтэй. Үүрээр буцаарай! Өнөөдөр зугаалж, миний эрүүл мэндийн төлөө уугаарай гээд Генрих зуун франкийн дэвсгэр гаргаж өгөв. Эрвинийг гарсан хойно Лютц: — Та мөнгөө ингэж тараагаад байх юм бол шинэ үйлчлэгч цэргээ хэт эрхлүүлж орхино шүү гэхэд нь. — Үүнийг би наагуураа бодолтой хийсэн юм. Энэ жолооч өнөөдөр архины мухлагт очиж архи уугаад цэргүүдэд миний өглөгч өгөөмрийг магтан ярих болно, тэгээд бүгдээр миний үйлчлэгч цэрэг болох гэж зүтгэх болно гэсэнд — Та хамгийн их зүтгэснийг нь авах юм биз дээ? Гэхэд — Хаанаас даа. Гэсэн ч би дуртайгаа шилэх бололцоотой байх болно. Дэргэдээ журамтай сайн хүн авч байхсан гэж хүсэх байна шүү гэж Генрих хэлжээ. Лютц инээд алдав. Генрих бас инээмсэглэсэн боловч мөшийх төдий инээхэд царайд нь ядарсан ч юм шиг, гунигласан ч юм шиг байдал үзэгдэхийг ахмад гайхлаа. Ахмадыг явахад Генрих гар барилцаад түр зогсоож, — Эрхэм ахмад та өнөө орой хаана хооллох вэ? гэж асуусанд — Бид гуанзанд бүгдээр хамт үдийн хоол иддэг юм. Ингэхийг генерал шаарддаг. Өглөөний цай, оройн хоолыг бид хаа дайралдсан газраа ууж иднэ гэхэд нь — Тэгвэл таныг өнөө орой надтай хоол идэхийг урья гэсэнд — Их баярлалаа. Таны урилгыг дуртайяа хүлээн

авья гэж Лютц хэлээд мэхийн ёслоход нь — Тэгвэл би есөн цагт таныг очиж авна гэж Генрих хэллээ. Генрих ганцаар үлдээд юм хумаа төвхнүүлж эхлэв. Бүх юмаа янзалж, хувцас хунараа гаргаж шүүгээнд өлгөв. Замын тоосоо угааж арилгамаар санагдана. Лютцийн явуулсан үйлчлэгч цэрэг бүх ажлыг хурдан зуур амжуулж, ус халааж, ор дэвсгэр зассан тул Генрих усанд ороод унтахаас өөр ажил байсангүй. Шинэ үйлчлэгч цэрэгтээ хэд хэдэн аар саар зүйл тушаасны дотор франц-герман, герман-франц хоёр толь бичиг заавал худалдаж авчир гэж тушаагаад Генрих өөрөө мэдэлгүй тэр дороо унтаад өгчээ. Генрих найман цагт сая сэрэв. Түүний бүх даалгаврыг биелүүлж, хувцас хунарыг нь сайн цэвэрлэж индүүдсэн байна. Цайвар үстэй, дэлдэн чихтэй Фриц Зеллер сүрхий сайн үйлчлэгч цэрэг байлаа. Орондоо жаахан хэвтмээр, бүр өглөө болтол босмооргүй санагдана. Генрих их ядарчээ. Гэвч Лютцийг хоолонд урьсан, бас генералтай уулзахаас өмнө нутгийн нөхцөл байдалтай танилцах нь чухлыг санаад яаран бослоо. Генрих нэг мөчийн дараа «Темпль» зочид буудлын жижиг боловч тохитой, тавилга сайтай зоогийн танхимд оров. Зоогийн танхим тэр үед хүнгүй байлаа. Гагцхүү зүүн ханын бараг тэн хагасыг эзэлсэн асар том эрэгнэгийн дэргэд нэг тарган авгай цааш хараад зогсож байв. «Зочид буудлын эзэгтэй байж таарна гэсэн бодол Генрихийн толгойд зэрсхийлээ. Ер нь Генрихийн анхаарлыг тэр авгай татсан нь бус. Генрих зориуд алгуурхан авгайтай чанга чанга ярьж байгаа бүсгүйг сайн харав. Тэр бол түрүүнд Лютцийн заасан дугуйтай хүүхэн мөн байлаа. Түрүүн Генрих тагт дээрээс хараад ахмадын хэлснийг зөвшөөрч, Моникаг нээрээ хөөрхөн хүүхэн байна гэж хэлсэн бол одоо тэр хэлсэн нь даанч хэвийн нэг, энэ бүсгүйд чамлалттай тодорхойлолт шиг санагдав. Бүсгүйн царай, түүний гоолиг биеийг харахад гоо сайхнаас илүү нэг юм байх шиг. Бүсгүйн юугаараа ийм гайхалтай санагдсаны учрыг Генрих тэр даруйдаа ойлгосонгүй. Туяарсан харцтай дүрлэгэр том нүд нь тэр үү, баримал юм шиг өргөн магни дээрх жирвийсэн хөмсөг нь үү, аль эсвэл булбарай зууван цагаан царайг нь эвтэйхэн хүрээлсэн долгиолог хар үс нь үү? Моникагийн хамар нь зөв биш хэлбэртэй мөрглөө уруул, эрүүнийхээ төрх байдалтай зохицон хосолжээ. Үнэхээр царайн төрх, нүд, үс, ялигүй сортойсон урт сормуусны өнгө бүгд нийцтэй хосолсон нь бүсгүйн царайг сэтгэл булаамаар хосгүй үзэсгэлэнтэй болгожээ, Генрих хоёр эмэгтэйд эелдгээр мэхийн ёслоод эхэд нь хандаж: — Ахай та герман хэл мэддэг үү? гэж асуусанд — Жаахан мэднэ. Та барон Гольдринг мөн болов уу? Таныг ирнэ гэж ноён Лютц хэлсэн. Эрхэм барон таныг манай зочид буудалд буусанд тань их баярлаж байна гээд эзэгтэйн царайд мэргэжлийнхээ эрхээр бусдыг үйлчлэх албатай хүний салшгүй шинж болсон хэвийн найрсаг инээмсэглэл үзэгдлээ. Моника Генрихийн хажуугаар өөр нэг юм ширтжээ. Ганцхан минутын өмнө цовоо сэргэлэн байсан түүний царай одоо хүйтэн хөндий болсон байв. — Ахай! Би оройн есөн цагт хоёо хүний хоол захих гэсэн юмсан гэж Генрихийн өгүүлэхэд — Аа бололгүй яах вэ. Та юу захиалахсан бол гэхэд нь? — Тулбага загас, франц маягаар шарсан тахианы мах, төмсөн хачиртай, бас шанцай захиалъя гэсэнд — Одоо хүнсний зүйл ховор хэцүү байна. Гэсэн ч буудалдаа суудаг хүнд ... Хоолыг тусгай өрөөнд бэлтгэх үү? гэхэд нь — Тиймээ. Та одоо миний өрөөнд нэг шил бордо дарс, шарз, хоёр шил жимсний ликер, нэг шил шоколадын ундаан явуулна уу гэж Генрих хэлээд лангуун дээр мөнгө гаргаж тавиад, — Хариулт хэрэггүй гэж хайхрамжгүйхэн хэлээд германаар бичсэн хоолны нэрсийн цэсийг авч үзэж эхлэв. Энэ

завсар эзэгтэй охин доо: — Энэ бароныг их баян хүн гэж Лютц хэлсэн шүү дээ гэж францаар аяархан хэлэх нь сонсогдсонд охин нь — Дээрэмдэж амжаа биз! гэж ууртай өгүүлэв. — Моника чи амаа тат! — Энэ тэртэй тэргүй юу ч ойлгохгүй өлийгөөд зогсож байна. — Захисан юмыг нь аваачиж өг гэж эх нь тушаав. Генрих инээдээ барьж ядан хоолны цэсийг лангуун дээр тавьж орхиод тасагтаа оров. Таван минут ч болоогүй байтал хаалга тогшиж, Моника дарстай цар барьсаар өрөөнд нь орж ирлээ. Авчирсан юмаа ширээн дээр тавиад үг дуугүй хаалга руу эргэхэд нь — Та түр хүлээнэ үү, мадемуазель аа! гэсэнд Моника бүүр хаалганы дэргэд хүрч зогсоод юу хэлэхийг хүлээв. — Та герман хэл мэдэх үү? гэж Генрих асуусанд — Мэдсэн ч ярих нь цөөн. Яагаад вэ гэвэл герман хэлэнд ч дургүй, бас ... гээд үгээ дутуу орхиход нь — Германчуудад ч дургүй юм биз дээ? гэж Генрих гүйцээж хэлсэнд Моника дуугарсангүй. — Та зоригтой хүн байна. Гэсэн ч герман офицеруудад ийм юм ярихгүй байхыг зөвлөе. — Хүн хүний дур өөр. Надад бол орос хэл илүү сайхан санагддаг. Их аялгуу сайхан хэл. — Би орос хэлийг сонсох завшаантай байсан. Би Дорнод фронтоос ирсэн шүү дээ. — Дорнод фронтоос оо? гээд Моникагийн нүдэнд үнэнээсээ сонирхсон байдал үзэгдэхийг Генрих ажиглав. — Орос эмэгтэйчүүд герман офицерт ийм үг хэлдэггүй гэж би танд баглан хэлж чадах байна. — Доромжлохыг үг дуугүй хүлцэж байдаг юм уу? — Үгүй. Орос эмэгтэйчүүд бууддаг. Өөрснийхөө дайсан гэж үзсэн улсыг бууддаг юм гэж Генрих францаар хариуллаа. Моникагийн нүд нь их болж, Генрихийг хэсэг зуур гайхан харж, хариу хэлэх гэсэн байдалтай уруулаа хөдөлгөж байтал үйлчлэгч цэрэг орж ирэхэд бүсгүй яваад өглөө. Яг есөн цагт Генрихийг Лютцийн ажлын тасалгаанд очиход Лютц ажлаа хийсээр байв. — Эрхэм ахмад аа! Ажил тийм их байна уу? Одоо есөн цаг болчихоод байна шүү дээ. Гэтэл та ажлаа хийсээр суудаг гэсэнд — Таныг хүлээж байх зуураа дэмий суухаар гэж маргаашийн жаал зугаа юм бэлтгэж байлаа. Барон та наж төвхнөв дөө? гэж хавтастай бичгээ хамхихад нь — Аятайхан төвхнөлөө. Эзэгтэй, охин хоёртой танилцаж амжсан гэв, — Моника, таны өөдөөс хэгжүүрхэж амжаа биз? гэхэд нь — Жаахан тэгсэн. Гэхдээ бид хоёр яваандаа учраа ойлголцоно гэж бодож байна хэмээн Генрихийг хэлэхэд Лютц үнэнээсээ гайхаж — Уухай! Таныг Моникатай аятайхан харилцаатай болж чадвал манай офицерууд бүгд атаархаж, таныг аугаа их дипломатч юм байна гэж бодно вий гэжээ. Удалгүй ахмад тэр хоёр тохилог тасалгаанд оройн хоол идэж суулаа. Зоогний газрын эзэгтэй Тарваль авгай ёстой сайн дарс явуулсан байх агаад хоолыг ч маш сайхан хийсэн байх тул ахмад их дуртай хооллов. Шарсан тулбага загас авчирч өгөхөд Лютц гайхан дуу алдаж, — Оо-ёо! Та Моникад нүүр олж чадаагүй юмаа гэхэд Тарваль авгайд нүүр талтай болсныг харж байна. Тантай танилцсан анхныхаа өдрөөс таныг ийм сайхан хоолоор дайлж эхэлж байна шүү дээ гэж өгүүлжээ. Хоолны дараа Генрих дахиад нэг лонх шарз, хайрцаг навчин янжуур захиалж авчруулав. Генрих хундагатай архиндаа уруул хүргээд, — Ажил их бодно гэж та хэлэв үү? гэсэнд — Урьд амар байсан юм. Дивиз цомхон байхад штаб маань Экслебенцэд байрлаж, ажил хавьгүй бага байлаа гэж Лютц шүүрс алдан хэлэв. — Дивизийн байрлалыг сольсон нь ямар шалтгаанаас болоо вэ? — Ийм юмаа. Францчууд анхандаа номхон тайван байснаа манайхныг Москвагийн дэргэд дарагдсанаас хойш эднүүс толгойгоо өндийлгөж эхэлсэн. Маки7 гэгчүүд гарч их төлөв булангийн цаанаас, бас голдуу офицеруудыг бууддаг болоод байна. Төмөр замын шугам, гүүр, аягүй бол

цэргийн холбогдолтой газрыг дэлбэлэх явдал гардаг. СС-ийн анги, цагдаа нар дангаараа тэднийг хүч хүрэхээ больжээ. Ингээд л манай дивизийг Сен-Мишегээс бүүр Шамберн хүртэлх ерэн километр газар янз бүрийн хэсэгт тарааж байрлуулах хэрэгтэй болсон юм. — Тэгээд түүнээс хойш макиуд номхорсон уу? — Үгүй чиш. Бүүр улам идэвхижсэн. Тэдэнд нутгийн ард иргэд тусалдаг дээрээс хэрэг бүүртөвөгтэй болж байна. Хоёр долоо хоногийн өмнө макийн отряд олзлогдсон орос цэргийн лагерийг дайрсан. Ялдамд хэлэхэд дэндүү хэнэггүй байсан манай харуул хамгаалалтынхныг францын партизанууд хядаж орхиод хэдэн зуун орос тэдэнтэй хамт ууланд гарсан. Нэхэж мөрдөөд ямар ч үр дүн олсонгүй. Таныг ирэхээс хэдхэн хоногийн өмнө макиуд өнөөх оросуудтайгаа хамт байлдааны хэрэгсэл тээж явсан автомашины цувааг дайрсан. Макиуд одоо манай өөрсний зэвсгээр сайн зэвсэглэж авсан даа гэж Лютцийг ярихад — Би Дорнод фронтоос энд ирээд сайхан амарна гэж горьдож байсан юмсан. Оросуудын хэлдгээр чонын амнаас барын аманд орж ирсэн хэрэг байна гэж Генрих өгүүлэв. Лютц партизаны эсрэг саявтар явуулсан залхаан цээрлүүлэх ажиллагааны тухай дэлгэрэнгүй ярилаа. Генрих анхааралтай сонсохын хамт Лютцийн хундагыг хоосон байлгахгүйг үл мартана. Ахмад удалгүй нилээд халамцжээ. Гольдринг, Лютц хоёрыг «Темпль» зоогийн газрын тохилог өрөөнд хооллож байх завсар Моника унадаг дугуйгаар Понтемафре гэдэг бяцхан тосгон тийш жирийлгэж явлаа. Тэр тосгоны ойролцоо орчны суурин газрыг эрчим хүчээр хангадаг цахилгаан станц бий аж, дөрвөн километр засмал замаар Моника ганцхан мөчийн дотор давхиж хүрэв. Тэгээд танил слесарьчид хандаж

— Франсуатай уулзахаар ирлээ. Хоол авчирсан юм гэсэнд — Мадемуазель Моника танд түүнийг газар дороос ч болтугай олоод ирнэ. Ай энэ Франсуа азтай золиг юм даа! Ийм сайхан хүүхэн өөрөө түүн дээр давхиад ирж байх юм гэж тэр хүн илт атаархсан байдалтай өгүүлжээ.

Энэ слесарьч, ер нь цахилгаан станцынхан бүгдээрээ Моникаг Франсуагийн болзоот хүүхэн гэж итгэдэг, тэр хоёр ч өөрснөө үүнийг нь худал гэж мэлздэггүй байжээ. Харин ч Моника тэр залуу ажилчинтай ойр дотно байдгаа харуулах гэж бяцхан боодолтой хоолоо зориуд олны нүдэн дээр Франсуад өгөв. Франсуа, бүсгүйг хашааны цаад буланд аваачиж, банзан дээр суулгаад боодлыг задлав. Холоос харахад тэр хоёрыг нээрээ янаг хоёр байна гэмээр. Харин тэр хоёрын яриаг хүн олж чагнавал их гайхах бизээ. Энэ хөөрхөн хүүхэн, өндөр туранхай, хөдөлгөөн ихтэй, богинохон засуулсан үстэй залуу хоёрын ярьж байгаа зүйл нь сэтгэлтэй улсын голдуу ярилцдаг энгийн дэмий сул яриатай огт адилгүй байв. Франсуаг хоол идэх зуураа: — Юу болоо вэ? гэж сэтгэл зовнин асуухад Моника өнөөдөр Гольдрингтой уулзсанаа, юу юу ярьснаа нэгд нэгэнгүй хэлэв Франсуа хэсэг бодоод — Лав өдөө л биз. Бүтэлгүй эхэлж дээ. Тэр барон чинь залуугийн эрхээр амаа татаж сураагүй эр бололтой. Бүхий л байдлаас үзэхэд тэр барон штабт чухал үүрэг гүйцэтгэх байх. Тийм биш бол түүнд урьдаас орон байр бэлтгэхгүйсэн. За тэгэхлээр Моника чи ... гээд бүсгүйн царай барайсныг харж аяархан инээгээд, За за, хөгжилтэй бай. Намайг юу ч хэлээгүй байхад чи хөмсөг зангидаад эхэлдэг, үгүй, чи битгий уурла гэм! Уурлаж үрчийгээд байвал атриа сууж, цагаас өмнө өтөлнө. За за, битгий уурла, эс тэгвэл би чамайг барьж аваад үнсчихнэ шүү. Би чинь чиний болзоот хархүү шүү дээ гэсэнд — Ээ Франсуа чи яасан төрхгүй амьтан бэ. Чамд чухал ажил итгэж хариуцуулсан шүү дээ гэж Моникаг хэлэхэд — Буурь суурьтай байна гэдэг чинь нэгийгээ үхүүлчихсэн юм шиг уруу царайлаад явна гэсэн үг биш шүү, хонгор минь. Аз муутай байхад ч гэсэн сэтгэл тэнүүн байна гэдгийг чи мэдэх үү? Тэгвэл чи бидний аз тун муухан байна. Яагаад вэ гэвэл энэ муусайн ногоон мэлхийнүүд ямар хорон санаа өвөрлөж байгааг бид мэдэхгүй байна. Тийм дээрээс тэр чалчаа барон чинь чамд хэрэгтэй байна ... гэхэд нь — Франсуа! .. гэвэл — Бас ахиад л уурлалаа. Миний үгэнд ор. Чамд ёс бус юм хэлж зөвлөхгүй. Зүгээр л тэр баронтой танилц. Чи түүнийг маллаж чадахгүй юм бол ямар хүүхэн байх билээ. Хичнээн аятайхан тохиол болоод байгааг бод ... Нэгд, ээжийн чинь зочид буудалд герман офицер сууж байна, хоёрт лав штабт ажиллана, гуравт амаа сайн татаж чаддаггүй хүн байна, дөрөвт өдөр болгон хөөрхөн хүүхэнтэй уулзаж байна. Чамаас юу шаардагдах вэ гэвэл хааяа нэг инээмсэглэж, нүдээ ингэж цавчилж, өөрөө бага ярьж, их чагнаж байх хэрэгтэй. Тэгээд бид тэдний штабт юу юу болж байгааг мэдэж авна. Энэ бидэнд хичнээн хэрэгтэйг мэдэж байна уу? гэв. — Тэр барон нэг л ... нэг л бусадтайгаа адилгүй юм билээ Наалдаж налиганахгүй, бэлэг зэлэг барихгүй, ядаж тоглоомын үг хэлэхгүй, огт тоомсоргүй байдалтай байх юм ... — Тэр ч чамаас шалтгаалах хэрэг. — Намайг хамт хоол идье гэх юм уу, кино үзье гэж уривал яах вэ? — Очилгүй яах вэ. Нүгэлтэй бид нар халамцахаараа үг олонтой болдог юм. — Мөн дөө. Сүүлд нь макиуд гитлерчүүдтэй явсан хүүхэн бүхнийг цааш харуулдаг шигээ намайг цааш харуулж орхино. — Энэ талаар санаа бүү зов. Чи өөрөө хэн нэгний толгойг автал чиний толгойн нэг ч үсийг

хөдөлгөхгүй. За ингээд яриа таарах шив дээ? Бас чамд ийм юм даалгасныг, тэр бароноос чиний мэдэж авсан зүйлийг хэн ч, төрсөн эх чинь ч мэдэх ёсгүй гэсэнд Моника санаа алдаад — Хэрэгтэй юм бол яая гэх вэ ... гэжээ. — Маш хэрэгтэй. Үүгээрээ чи бидэнд туслана, ахдаа ч тус болно. Далимд хэлэхэд чи удахгүй Жантай уулзана гэхэд нь Моника баярлан — Хэзээ? гэсэнд — Цагийг нь болохоор чамд хэлэмз. Бодвол энэ цахилгаан станц дээр байх. Аз болоход германчууд энэ станцын эрчим хүчийг хэрэглэдэггүй болохоор биднийг сонирхдоггүй юм. Гэсэн ч онцын хэрэггүй бол наашаа битгий ирж бай. Хэдийгээр бүгдээрээ чамайг миний болзоот хүүхэн гэж бодож байгаа боловч болгоомжлоход илүүдэхгүй. Ер нь чамайг энэ замаар олон явж байгааг германчууд харвал дэмий гэж Франсуа хэлжээ. Моника, Франсуа хоёр босож, хаалга руу явлаа. Франсуагийн ердийн алиа хошин зан нь дахин сэргэж: — За миний хүзүүгээр тэврээд аваач. Болзоот хархүүгээсээ салахад чамд хичнээн хүнд байгааг улс хараг. Эсвэл ядаж алчуураа гаргаад нүдээ арчиж байгаа дүрэм үзүүлээч гэж бүсгүйг цаашлуулсанд Моника инээд алдаж, нүдэнд нь залирхаг инээмсэглэл үзэгдээд гэнэт Франсуад наалдаж, хацар дээр нь шов хийтэл үнсэв. Цаадахь нь ичиж сандарсандаа шилээ маажгаад — Миний сургаал заавар чамд тус болж байх шив дээ? гэж зовнисхийн хэлсэнд — Чи эмэгтэй хүнтэй харилцахдаа амаар ярьдаг шигээ тийм туршлагатай, зүрхтэй эр биш шивдээ гэж Моника бүүр хаалганы тэндээс хашгирлаа. Зэгсэн сайн согтсон Лютцийг Генрих зоогийн танхимаас гаргаж өгч явахад Моника гэртээ ирчихээд дөнгөж саяхан хүлээж авсан эвгүй хэцүү даалгавраа бодож хэвтлээ. Маргааш өглөө нь яг есөн цагт Генрих штабт ирэв. Лютцийн байдлыг харвал хүнд өвчин тусаад дөнгөж өчигдөр өндийсөн хүний байдалтай ажээ. — Өчигдөр арай хэтрүүлчихээ бололтой. Толгой хүнд гэж жигтэйхэн гэж ахмад томорхоод тэртэй тэргүй төдий л нямбай биш самнасан үсээ үрж сэгсийлгэв. Дивизийн даргыг ирэхээс өмнө Лютц хамт ажиллах шинэ хүндээ ажил төрлийн байдлыг танилцуулж амжлаа. Генерал Эверс ажлынхаа тасалгаанд орох зуураа туслагчийнхаа өрөөнд түр саатан зогсов. Генерал хэдийгээр нас ахисан боловч танхил маягийн зууван царайтай, бас гоолиг хэвээр эр ажээ. Зузаан зовхи, нүдний доод талын хавагнасан бүлцэн түүнийг жинхэнэ байдлаас илүү догшин сүртэй болгожээ. Генерал туслахдаа хандан — Шинэ сонин юу байна, Лютц ээ? гэсэнд — Шинэ үү? Онцгой даалгавар гүйцэтгэх шинэ офицер ирээд байна гэж Лютц хошигнох янзтай өгүүлсэнд генерал Эверс Генрих тийш эргэж харахад нь. — Би дэслэгч фон Гольдринг байна гэж илтгэсэнд — Аа! Миний эртний найз хурандаа Бертгольд, таныг дэргэдээ авна уу гэж надад хэлсэн юм. Та дотогшоо орно уу гэлээ.

Генералын албан тасалгаанд бичгийн ширээ тийш шахаж тавьсан бяцхан ширээн дээр рашаантай хэдэн шил харагдав. Генерал нэг аяганд рашаан хийж өмнөө тавиад — Энэ муухай давстай гашуун юмаар таныг дайлаад яах вэ. Би өөрөө л ууж байхаас. Элэг муу. За даа, та нар залуу улс. Ийм юмыг сонирхох биш ... За тэгээд хурандаа яагаа бол оо? Ямар ажилд томилогдсон нь мэдэгдээгүй юу? гэхэд нь — Өөрөө Берлинд үлдэх болов уу гэж байна лээ гэсэнд — Өө тэгвэл Бертгольдод баяр хүргэхэд болох юм байна. Гиммлерийн дэмжлэгтэйгээр Бертгольд дээгүүр явчихна. Дэслэгч та азтай хүн байна. Бертгольд шиг түшигтэй хүн тэр бүр олдохгүй шүү. Түүгээр барахгүй таныг төрсөн хүүгээсээ өөрцгүй үзэж байна гэж хэлж байсан гэхэд нь — Эрхэм Бертгольд, надад маш

ээлдэг байдаг юм. Хурандаа манай эцэгтэй үерхэж байсан болоод намайг нээрээ төрсөн хүү шигээ угтсан гэж Генрих хэлжээ. — Тийм, тийм, таны намтрыг Бертольд надад ярьж байсан. Тун сонирхолтой юм билээ. Би ч гэсэн Зигфрид фон Гольдрингийг таньдаг, энгийн нөхөрсөг харилцаатай байсан юм. Түүнийг цаг бусаар нас нөхцөнд их харамссан. Гэсэн ч та эцгээрээ бахархаж болно. Тэр бол ёстой цэрэг эрийн үхэл байсан! Таныг эцэгтээ их тусалдаг байсан гэж хурандаа надад ярьсан гэхэд нь — Тиймээ, би эцэгтээ чадах чинээгээрээ тусалж, мэдээ цуглуулж, явуулах мэдээг нууц түлхүүрт оруулж, радиогоор даалгавар хүлээж авдаг байсан гэв. — Таныг залуу хүн гэхэд Герман эх орныхоо төлөө багагүй юм хийсэн хүн, тийм болохоор фронтод явуулбал шударга биш хэрэг болно гэж Бертольдын үздэгийг би бүрэн зөвшөөрч байна гэв. — Эрхэм генерал та намайг ямар ажилд тавих гэж байна вэ? — Та миний дэргэд онцгой даалгавар гүйцэтгэх офицероор ажиллана. Ийш тийш явах ажил их гарна. Та залуу хүн аялах жуулчлах дуртай биз. — Надад даалгасан ажлыг аль болох сайн биелүүлэхэд саад болохгүй бол аялахдуртай, Дайны үед хувийнхаа хүслийг хойш тавих хэрэгтэй болох юм. — Маш зүйтэй санал байна гэж генерал хэлээд уснаас нэг балгаж, ярианы амин хувийн өнгийг өөрчилж, албан ёсны байдлаар нэмж хэлсэн нь: — Даалгаврыг шууд надаас юм уу. Лютцээр дамжуулж авч байна. Та түүнтэй танилцаж завдсан биз? — Тиймээ, эрхэм генерал аа. Их сайн офицер шиг санагдсан. — Танд тэгж санагдсан нь яамай ... Та нар үргэлж хамт ажиллах улс шүү дээ ... За дэслэгч ээ, бид үдийн хоолон дээр гуанзанд дахин уулзана, тэгэхлээр баяртай гээд ч яах вэ гэж генерал Эверс хэлжээ. Генрихийг Эверсийн тасалгаанаас гарч ирэхэд Лютц: — Таныг генерал ямар шүү хүлээж авав? гэж асуухад нь — Овоо эелдэг найртай хүлээж авлаа. Та бид хоёрыг үргэлж шахуу хамт ажиллах болно гэж сануулаад таныг надад сайхан сэтгэгдэл төрүүлсэн гэж хэлсэнд сэтгэл хангалттай байна лээ гэв. — Барон танд их баярлалаа. — Намайг даалгавраа шууд өөрөөс нь юм уу, танаар дамжуулан авч бай гэж генерал хэллээ. Өнөөдөр би чухам юу хийх ёстой байна вэ? — Одоохондоо амарч, хотын байдлыг үзэж байна биз. Би өнөөдөр ажил хиймээр дур хүрэхгүй байна. Яаралтай ажил гарвал танд мэдэгдье. Таны хаана очсоныг үйлчлэгч цэрэг чинь мэдэж байвал сайнсан. Хоолон дээр хожигдоход генерал их дургүй байдаг юм. Яг нэг цагт үдийн хоол иднэ. — Оройн хоолыг хоёул өчигдрийнхөө идсэн газар иднэ гэж Генрихийг үг нэмэхэд — Дэндүү үнэтэй юм уу даа гэж Лютц тээнэгэлзэв. — Эрхэм ахмад та тийм шальгүй юманд санаа бүү зовогтун! гэж Генрих хайхрамжгүй хэлчихээд гарлаа. Хотын байдлыг үзэж танилцахад тийм их цаг орсонгүй, Сен-Ремийн гол гудамжаар автомашины их засмал зам дайрч гарсан юм байна гэж Генрихийн өчигдөр ажигласан нь зөв байжээ. Тэр гудамжинд зочид буудал, хувийн байшин, кино театр, дэлгүүр, хотын захиргаа зэрэг төвлөрчээ. Энэ гол судаснаас салаалсан бусад жижиг гудамж нь нилээд бохир, муруй тахир агаад хоёр машин ч зөрж болмооргүй нарийхан ажээ. Генрих хотоор бага зэрэг тэнэж, зочид буудалдаа эргэж ирээд хоолноос өмнө толь бичиг дээр ажиллаж амжив. Франц хэлнийхээ мэдлэгийг хурдан сэргээж авахыг хүсчээ. Нэг цаг болохоос хэдэн минутын өмнө Генрих офицеруудын гуанзанд очив. Тэнд штабын офицер гучаад хүн цугларсан байлаа. Офицерууд цагаан бүтээлэгтэй урт ширээний хавиар нааш цааш холхино. Ширээн дээр халбага сэрээ өрсөн агаад хоол зөөгч хоёр эмэгтэй, аягалах том халбагатай шөлний том том сав зөөж байлаа. Генрих өөр дээрээ хэд хэдэн хүний сониуч

харц тусахыг ажиглав. Генрих зөвхөн ёслолын дүрэмт хувцас оёдог үнэтэй эдээр хийсэн мундир өмссөн нь тэр хүмүүст сэтгэгдэл төрүүлсэн бололтой. Генералыг орж ирэхэд бүгдээр биеэ эгцлэн зогсов. Эверс ширээний эхэн дэх өөрийн байранд очоод сандлынхаа ард зогсоход офицерууд бас өөр өөрийн сандлын ард очиж зогслоо. Эверс хуруугаараа Гольдрингийг дохин дуудаж, өөрийн баруун гар талын сандлыг зааж өгөв. Генерал цугларагсдад хандан өгүүлсэн нь — Ноён офицерүүд аа! Манай штабын шинэ офицер дэслэгч фон Годьдрингийг та бүхэнд танилцуулахыг соёрхоно уу гэхэд нь. Генрих цугларагсдад мэхийн ёсоллоо. Генерал цааш үргэлжлүүлэн — Энэ дэслэгч, миний онцгой даалгавар гүйцэтгэгчээр ажиллана Дэслэгч фон Гольдринг эдүгээ хүртэл генерал Иорданы командалсан корпусын 1—Ц хэлтсийн даргын дэргэд онцгой даалгавар гүйцэтгэх офицероор ажиллаж байсан юм гэсэнд цугларагсдын зарим нь Генрихийг хүндэтгэх байдалтай харлаа. — Та бүхэн ажлын явц дунд сайн танилцана биз гэж генерал хэлээд суудалдаа суув. Генералын дараагаар офицерууд суув. Генерал өөртөө шөл хийж авахад офицерууд ээлж дараагаар тавагтаа шөл хийж авлаа. Цугларагсад бүгдээр даргыгаа дууриах гэж хичээж байгааг ажиглаад Генрихийн инээд хүрнэ. Хоол удаан үргэлжлэв. Эцэст нь генералыг босоход офицерууд бас бослоо. Генрих сая санаа амарч шүүрс алдан. Хоолноос гарч явахдаа Лютцээс: — Би танд үдээс хойш хэрэгтэй юу? гэж асуусанд, — Ингэхэд ер нь маргаашаас эхэлье. Өнөөдөр ажилд нэг л сэтгэл явж өгөхгүй байна. Тэгээд ч генералын элэг нь өвдөөд гэртээ суух болно гэв. — За тэгвэл оройн есөн цаг хүртэл баяртай. Би тантай штабт дайралдахгүй бол миний байранд шууд яваад очоорой гэж Генрих хэлэв. Зочид буудлын үүдний өрөөнд Генрих Моникатай тулгараад, — Сайн байна уу, мадемуазель аа гэж нилээд хүйтэвтэр мэндэлсэнд бүсгүй харин өөдөөс нь инээмсэглээд — Сайн байна уу, барон! гэж хариу мэндлэхэд нь гайхав. — Та инээж чаддаг юм уу? гэж Генрих гайхсан дүр үзүүлэн асуусанд — Би амьд хүн байна гайхах юу байх вэ гэв. — Танай утга зохиолд «Инээмтгий хүн» гэж гайхамшигт сайхан роман байдаг. Та уншсан биз. Харин таныг энд «инээдэггүй хүүхэн» гэж нэрлэдэг юм байна. Манай офицерууд таны нэг ч удаа инээмсэглэж байхыг хараагүй гэж ярьсан. — Тэдэнд инээмсэглэх алба уу. — Тэгвэл та намайг онцгойлж үзсэн юм шив дээ? Моника бодвол Франсуагийн өгсөн даалгаврыг санаад хариу хэлэхийг түдгэлзэн уруулаа зуув бололтой. Гэвч тэсвэрлэж бас чадсангүй. — Барон та өөрийгөө их дээгүүр боддог хүн байна. Таныг танай нөхдөөс илүү боловсон хүн шиг санагдахаар нь илүү найртай хандсан юм гэсэнд — Та герман офицер биднийг нэг л хэмжүүрээр хэмжиж, үргэлж муу санадаг байна гэв. Моника гүн санаа алдаад нүднийхээ хилэнт галыг нуух гэсэн байртай хариу хэлэлгүй зовхио буулгалаа. Генрих эвлэрэнгүйгээр: — Дайн болсон хойно яая гэх вэ, мадемуазель аа. Дайныг та ч эхлээгүй, би ч эхлээгүй шүү дээ гэв. Бүсгүй хариу эс дуугаравч бас зайлж явсангүй. Генрихт гэнэт зоригтой бодол төрж: — Мадемуазель Моника! Таныг надад өчүүхэн найр тавьж туслана уу гэж зүрхлэн гуйвал та намайг дэндүү налигануур хүн гэж тооцох болов уу? гэсэнд — Би танд тус болж чадах юмуу даа? гэхэд нь — Өө таныг надад тусалж чадна гэж бат итгэж байна. Та герман хэл мэддэг шүү дээ. Тэгэхлээр надад франц хэл сурахад минь туслахад төвөггүй байх болно гэсэнд — Та нарт байцаалт явуулах хэлмэрч бий гэхэд нь — Мадемуазель та юу бодох нь энэ вэ ... Би СС-ийн офицер биш, цэргийн албанд дайчлагдсан ерийн нэг офицер шүү дээ. Би бүүр дайнаас

өмнө танай аялгуу сайхан хэлийг үзэж эхэлсэн юм. Одоо тэгээд ийм сайхан боломж тааралдаж байхад ... гэсэнд — Та нарт маш сайхан боломж, францчууд бидэнд маш уйтгартай боломж ... Гэсэн ч ... гээд Моника толгойгоо сэжиж, долгиолог үсээ арагш нь болгоод — Франц улс аугаа их гүрэн болно гэж би итгэж байна гэхэд нь — Би ч гэсэн итгэж байна, мадемуазель аа. Эрх чөлөөг эрхэмлэдэг ийм яруу алдарт түүхтэй ард түмнийг яаж өвдөг сөхрүүлж чадах билээ гэж Генрихийг хэлэхэд бүсгүйн ам жаахан хүүхдийнх шиг гайхсандаа ангайж хоцорлоо. Генрих хэлсэн үгээ ямар сэтгэгдэл төрүүлснийг огт ажиглаагүй байдал гарган, — Та тэгээд надад туслахыг зөвшөөрөх үү? гэж асуусанд Моника шууд хариу хэлэхээс булзаж, — Хэл сурахад тийм амаргүй. Үүний тулд толь бичиг, сурах бичгээс гадна багш, сурагч хоёрын авьяас чадвар хэрэгтэй. Танд надаас илүү сайн туслагч олдоно гэж бодож байна гэхэд нь — Үгүй. Энэ бүгдийг би сайн бодсон. Чухам танд л их найдлага тавьж байна. Надад зав чөлөө бага гардгийг та бодоорой Би танай зочид буудалд сууж байгаа маань ажилд тустай. Та бид хоёрын хэн хэн нь завтай байж таарсан тийм цагтаа надад хичээл заана. Та үүгээрээ зөвхөн надад тус болж байгаа хэрэг биш. За юу гэж хэлэлтэй юм бэ дээ, нэг ард түмнийг нөгөөгөөс тусгаарласан хаалт хашилтыг эвдэж байна гэх юм уу даа. Хүн харь хэл сурахдаа өөрийн эрхгүй тэр ард түмний санаа сэтгэлийг шингээж авдаг юм. Тийм биз дээ? Тэр ард түмний соёл, хүсэл эрмэлзлийг илүү сайн ойлгодог болно ... Би энэ бүгдийг танд тун эв дуй муутай, хольж хутгаж ярилаа. Гэхдээ үнэн сэтгэлээсээ хэлгэн юм гэсэнд Моника сүүлдээ зөвшөөрч, — За яах вэ. Харин толь бичиг, сурах бичиг хэрэгтэй дээ гэхэд — Бүгдийг авсан. Та одоо завтай бол очиж үзэхийг хүсье. Өөр ном авах хэрэгтэй байж магадгүй гэхэд Моника тээнэгэлзэв, Тэгж эргэлзсэний шалтгааныг Генрих ойлгоод, Таны аюулгүй байдлыг бүрэн хангана гэдэгт чин сэтгэлээс итгэж болно гэсэнд бүсгүй царай үл мэдэг улайгаад Генрихийн байр байдаг хоёрдугаар давхар өөд гарсан шатаар өгслөө. Генрих Моникаг түрүүндээ оруулаад үүдний өрөөнд түр саатан зогсож, үйлчлэгч цэрэгтээ шивээнэн өгүүллрүүн: — Фриц ээ! Энэ мөнгийг аваад яв. Хамгийн сайн чихэр, жимс авчир гэлээ. Генрихийг өрөөндөө ороход Моника ширээний дэргэд суугаад толь бичиг үзэж байхад нь: — Таарах уу, та юу гэж бодож байна? гэж асуусанд — Муу биш толь бичиг байна. Энд хэлний зүйн дүрэмтэй, төгсгөлд нь хамгийн их хэрэглэгддэг өгүүлбэрийг хавсаргасан юм байна. Жуулчдад ... бас байлдан дагуулагчдад их тохиромжтой толь бичиг байна ... гэхэд нь — Мадемуазель та яасан хатуу хүн бэ! За ер нь сурагч надад багшийн хатуу нь тустай. Тэр их хэрэглэгддэг өгүүлбэрийн тухайд гэвэл би түүнийг овоо гадарлах болсон болохоор биднийг анх танилцах үед таны ээждээ хэлсэн үгийг сайн ойлгосон гэсэнд — Миний үг тогтоож авмаар тийм чухал үг байсан юм уу? гэхэд нь — Мартахын аргагүй гомдмоор үг хэлсэн. Та намайг их юм дээрэмдсэн хүн гэж хэлсэн шүү дээ гэсэнд Моникагийн царай улайж, — Таныг францаар ойлгодог гэж мэдээгүй хэлчихсэн юм. Тэгэхлээр та намайг уучлал гуйна гэж бүү бодоорой гэхэд нь — Бид хичээлээ хэзээ эхэлж болох вэ гэдгийг хэлж өгөөрэй гэж хүлээж байна. Би эхлээд танай ээж хүндэт Тарваль авгайтай ярьж тохирох ёстой л доо гэсэнд — Ээжтэй би өөрөө ярьж тохиролцоно. Харин ... гээд Моника хэсэг дуугүй болсноо — За маргааш эхэлсэн ч болно гэж шийдэмгий хэлээд хүйтнээр толгой дохиод гарч одов.

ГЕНРИХИЙГ ГЕСТАПО СОНИРХОВ — Гольдринг танд генералаас яаралтай

даалгавар өгсөн. Минометоор туршлагын буудлага хийх тохиромжтой газар эрж олох хэрэгтэй. Талбайн урт нь зургаан зуун метрээс доошгүй өргөн нь хоёр зуун метр байх ёстой. Газар нь мод ургамалгүй, бас харуул манаа гаргахын хэрэгцээгүй байвал сайн гэж Лютцийг хэлэхэд — Өвс саад болохгүй юу? гэж Генрих асуув. — Газар дээр нь баримжаалаарай. Шатаагч шинэ мина турших юм гээд Лютц ширээн дээрх газрын зураг зааж, — Энд Сен-Ремигээс баруун хойш бидэнд таарах магадгүй тэгш өндөрлөг бий. Түүнийг үзээрэй. Энэ ажлыг үдээс хойш хийнэ. Түүгээр машин явж болдоггүй юм. Мориор явах болно. Комендантын сумангаас хоёр цэрэг дагуулж, өөрөө заавал автомат буу авч яваарай. — Миний шинэ арван зургаа үсэрдэг гар буу, автоматаас дутахгүй — Болгоомжтой яваарай. Хотын орчмоор партизанууд тэнэж явна гэсэн мэдээ бий — Одоо даруй явъя, эрхэм ахмад аа. Генрих буу зэвсгээ авч, мөчийн дараа автоматаар зэвсэглэсэн хөтөч цэрэг дагалдуулан тэгш өндөрлөг тийш явлаа. Таван километр хиртэй яваад зам дуусаж, цаашаа тэгш өндөрлөг тийш огцомхон өгссөн нарийн жим явжээ. Эгц цавчим өөд авирахаас айсан морьд халгах болов. — Энд морьдоо хараад намайг хүлээж бай гэж дэслэгч нөгөө цэрэгтээ тушаалаа. Генрих мориныхоо жолоог тэр цэрэгт бариулж орхиод нарийн жимээр дээш мацаж, удалгүй тэгш өндөрлөг дээр гарч ирэв. Тэр бол өндөр байц хадны ёроолд тулж очсон уртаашаа нэг километр хиртэй, өргөөшөө дөрвөн зуугаад метр үнэхээр том талбар байлаа. Тэнд өвснөөс өөр ямар ч мод бут байхгүй, байгаль өөрөө бүтээж өгсөн зэвсэг турших тэр талбайн гагцхүү баруун ирмэг дээр нь хэдэн саглагар том мод ургажээ. Генрих тэгш өндөрлөгийг хөндлөн гарч, асга хаданд тулж очлоо. Бүх талбайг эргэн тойрон том том бул чулуу хүрээлжээ. «Яг таарах газар байна» гэж Генрих бодоод бүх талбайг тойрч үзэхээр цааш явлаа. Байц хаднаас баруун тийш эргэж, модны дэргэд очтол хүн ярих чимээ сонсдов. Эргэж харвал тэгш өндөрлөгийн нөгөө эсэргэн талаас энгийн хувцастай хоёр франц хүн хадны цаанаас дөнгөж гарч ирэхийг харлаа. Ахимаг настай нэг нь хүзүүндээ герман автомат буу зүүжээ. Нөгөө нь зэвсэггүй байв. Тэр хоёр чанга чанга ярин усан үзмийн тариалан тийш явж байна. Эгзэгтэй байдалд орлоо гэсэн бодол Генрихийн толгойд зэрсхийв. Одоо яавал таарах вэ? Автомат гар буу нь гацахгүй ажиллана. Гэтэл энэ хоёр хүн ядаж ийш тийш эргэж харахгүй, санаа амарлингуй алхаж байна. Ойртуулж байгаад тэднийг харж завдахаас нь өмнө буудаж орхих уу? Эд нар дайсан биш шүү дээ! Эд нар бол өөртэй нь адил, дайсантай тэмцэж байгаа анд нөхөд байна. Дайсан нь бол Генрихийн ч дайсан, эдний ч дайсан. Урьдаас нь тосож очоод эв зүйгээр ярьж дуусгах уу? Гэтэл өөрөө ганц үг ч хэлж завдахгүй шүү дээ. Партизанууд мундирыг нь хармагцаа гал нээж эхэлнэ. Модны цаагуур нуугдах уу? Тэртэй! тэргүй партизанууд өөрийг нь олж харна. Партизанууд модны цаанаас залгаж авсан усан үзмийн тариалан тийш явж байна шүү дээ. Генрих модны цаагуур нуугдаж, гар буугаа чанга атгаад нөгөө хоёрыг нүд салгалгүй ширтлээ. Тэр хоёр ойртож ирэв. Партизануудыг тав зургаан метр ойртож ирэхэд Генрих нуугдсан газраасаа гэнэт ухасхийн гарч, сэтгэл хөдөлсөндөө дэндүү чангаар: — Олюмэ!⁸ гэж хашгирлаа. Партизанууд чухам юу болсныг гүйцэд ойлгож завдалгүй зогтусаж, өөрсөд тийшээ чиглүүлсэн гар бууг хараад гараа алгуурхан өргөцгөөв. — Турнэ ву!⁹ гэж Генрих хатуу тушаав. Партизанууд гараа буулгалгүй цааш эргэж харлаа. — Та нарыг өчүүхэн төдий хөдөлбөл буудна шүү! гэж Генрих сануулав. Түүнийг дэргэдээ очиход партизанууд хөдлөхгүй зогсож байв. Офицер хүч давуу байгаа

болохоор тэгэхээс биш яах билээ. Генрих партизануудын ар нуруу руу чиглүүлсэн гар буутай гараа буулгалгүй тэдний дэргэд тулж очоод ахимаг настай хүний хүзүүнээс автомат бууг нь мултлан авч, дараа нь баривчлагдсан хоёр хүний халаасыг нэгжин ахимагийн нь халааснаас нэг гранат, залуугийн халааснаас бельги браунинг гар буу гаргаж ирэв. Нэгжиж дуусаад хурааж авсан буу зэвсгээ өөрийн халаасанд хийж, автоматыг нь хүзүүндээ зүүв. — Гараа буулгаад тэр сүүдэрт оч! гэж Генрих тушаагаад ойр хавьд өөр хүн байгаа эсэхийг шалган тийш тийш харав. Макиуд тушаасныг дуулгавартай дагаж, одоо Генрихийн өөдөөс харан зогсоцгоох тул царай зүсийг ажиглаж болох байв. Ахимаг нь дөчөөд настай, залуу нь Гольдрингийн үеийн хүн шиг байв. Залуу эр дүрлэгэр том нүдээрээ герман офицерыг үзэн ядаж, жигшин зэвүүцсэн байдалтай ширтэх аж. — Партизанууд уу? Маки юу? гэж Генрихийг асуухад — Тийм гэж бага нь ажиггүй хариулав. — Та нар хаа очиж яваа вэ? — Зэргэлдээх тосгонд. Үүнин эх нь нас барсан юм гэж залуу нь ахмад нөхрийгөө заав. Ахмад нь газар ширтгээд дуугүй байлаа. — Тэгвэл та нар юунд буу зэвсэгтэй яваа юм бэ? Хоёул хариу дуугарсангүй. — Ангайсан тэнэгүүд! Буу зэвсгээ бэлэн зэхий авч явж чадахгүй зугаалж яваа юм шиг! гэж Генрихийг уурсан өгүүлэхэд Партизанууд бие биеэ харав. — Тэр хадны дэргэд оч! Буу зэвсгийг чинь, би тэр замын хажууд тавина. Намайг тэгш өндөрлөгөөс буусны дараа буу зэвсгээ аваад явцгааж болно. Энэ сургамжийг сайхан мэдэж, саруулхан санаж аваарай гэж Генрих хэлжээ.

Партизануудын нүднээ нэгэн агшны төдий баярын оч гялсхийснээ даруй унтарч, царай нь түгшүүртэй болж хоёул хөдлөхгүй зогсов. Өөрийн нь тушаалыг партизанууд хар муу санаа гэж бодож байгааг Генрих ойлголоо. Ахимаг насных нь залуугийнхаа өөдөөс яах вэ гэсэн янзтай харахад залуу өөдөөс нь: — Биднийг буруу харахтай зэрэг араас буудах гэж байгаа биз хэмээн ууртай дуугарав. — Миний гарт хоёр гар буу байж байхад одоо та нарыг буудчихад надад юу саад болох юм бэ? Гохыг нь дарж орхивол та хоёр хоёул нөгөө ертөнцөд одно ... Илүү дутуу юм ярих хэрэггүй. Партизанууд буу зэвсгээ бэлэн зэхий авч явах ёстой гэдгийг зөвлөе. Та нар халаасандаа хийчихээд рашаан амралт дээр байгаа юм шиг явж байна. Үхсэн хойноо партизан бол! За олон таван Үг хэрэггүй. Турнэ ву! Гүйгээд! гэж Генрих тушаалаа. Залуу партизан алгуурхан эргэж цааш алхалсанд хижээл партизан хойноос нь хөдөллөө. Тэр хоёр анхандаа ар нуруу руугаа буудна гэж бодсон бололтой, аяархан алхалж байснаа алхаа нь улам хурдасч, сүүлдээ үе үе эргэн харсаар гүйлдэв. Генрих өөрөө ч тэгш өндөрлөгөөс буухаар уруудлаа. Партизанууд хадны дэргэд гүйж хүрээд энэ хачин герман офицерын юу хийж байгааг анхааралтай ажиглана. Гольдринг саяхан өөртөө олзлогдсон тэр хоёрын зүг найрсгаар гар даллаад тэгш өндөрлөг дээрээс хурдан бууж эхэллээ. Партизануудыг хадны тэнд тулж очиход Генрих хэдийн холдсон байжээ. Гагцхүү хотын зүг хоёр морьтон хүн давхиж явахыг макиуд харсан байна. — Та ямар учиртайг мэдэв үү? гэж залуу нь ахмадаасаа гайхан асуусанд — Учрыг нь огт олохгүй байна гэж хариулжээ. Энэ бүх явдлыг усан үзмийн тариалан дотроос сэмхэн ажиглаж байсан тариачин эмгэн бас л юу ч ойлгосонгүй гайхжээ. Тэр эмгэн бутан дунд цөмцийн суугаад Жан Тарпаль, Пьер Корвиль хоёрыг герман офицер барьж авахад айсандаа үнхэлцэг нь хагарах шахаж, буун дуу дуулахгүй гэж чихээ хүртэл таглажээ. Гэтэл буун дуу гарсангүй. Маш хачин

яриа хагас дутуу сонсдож эмтэний толгой бүр эргэж орхижээ. Хагас цаг өнгөрөөгүй байтал сэтгэл сэргэж хөгжсөн Генрих шинэ миномет туршихад зориулан маш сайхан талбай эрж олсноо ахмадад илтгэж байв. — Туршилтыг чухам хэзээ хийх юм бэ? гэж Лютцээс асуусанд — Ойрын өдрүүдэд хийнэ. Манай генерал хүлээн авах комиссын гишүүн. Хугацааг генерал тогтооно. Хойш тавихгүй байх гэж бодож байна. Ер нь минометыг түүгээр харвах минатай нь энд үйлдвэрлэдэг юм чинь гэхэд нь, — Үгүй, та эндүүрч байгаа байлгүй. Сен-Ремийн орчин тойронд тиймэрхүү үйлдвэрийн газар нэгийг ч би үзээгүй гэсэнд Лютц инээмсэглэж, — Та тэр талбай тийш очиж явах замдаа засмал замын баруунтаа жижигхэн завод байхыг ажигласангүй юу? гэхэд нь — Бүтэн хагас километрийн тэртээ юу? гэв. — Тиймээ. Тэр чинь байхгүй юу. — Яасан ч үнэмшихгүй. Түүнийг чинь завод гэмээргүй зүгээр нэг гар дархны газар юм шиг билээ. — Гаднаас нь харахад л тэр. Гадна талд нь үнэндээ цэргийн заводтой төстэй юм юу ч байхгүй. Яагаад вэ гэвэл ... гээд Лютц хэлэх үгээ жинтэй болгох гэж түр зогсоод, ... Яагаад вэ гэвэл заводыг нь газар дор нуучихсан юм. Тэнд мянга гаруй олзогдсон орос, франц, польш, чех зэрэг ер нь товчоор хэлэхэд нарны гэгээ хэзээ ч үзэхгүй хүмүүс ажиллаж байгаа. Тэд нар газар дор ажиллаж, хооллож, унтаж түүгээр ч барахгүй газар дороо үхэж байдаг. Тэднийг газар дор нь оршуулдаг юм. — Зальтай бодож шүү! гэж Генрих дуу алджээ. Ийм сонин мэдээг Генрих санамсаргүй сонсоод үнэхээр гайхаж, командлалдаа нэн даруй мэдэгдэх хэрэгтэй юм байна гэж бодов. Лютц үргэлжлүүлэн: — Тэднийг тэнд оршуулдаг гэж хэлсэн нь газар дор хүүр оршуулах газар байдаг гэсэн үг биш юм шүү. Үхсэн хүний хүүрийг шатаагаад үнсийг нь нутгийн тариачдад тариалангийн газрын бордоо болгож хямдхан худалддаг юм. Худалдан авагчид тэр бордооныхоо гарал үүслийн тухай юу ч мэдэхгүй. Ингэж бүрэн дүүрэн ашигладаг байна шүү дээ гэж мушийн инээмсэглэж өгүүлэв. Ахмад сүүлчийн үгээ гашуунаар ёжилсон байдалтай өгүүлснийг Генрих ажиглажээ. Хонх дуугарахад Лютц: — Намайг генерал дуудаж байна. Удахгүй байх. Энд хүлээж байхгүй юу? гэхэд нь — Үгүй, би явж гар нүүрээ угаая. Замд явах зуур тоосонд дарагдчихлаа, хоолон дээр уулзамз гэж Генрих хариулав. Генерал дээр хүн байжээ. Генералын өмнө СС-ийн албаны удирдагч хошууч Миллер сууж байлаа. Гестапогийн энэ биеэ тоосон, ичихийг мэддэггүй офицер Лютц маш дургүй байдаг бөгөөд штабт ирснийг нь үзээд гайхан зэвүүцэв ... Лютцийг гадагшаа гарах хооронд Миллер Эверс дээр орсон бололтой. Генерал, Миллерийн хажуудах зөөлөн сандлыг заагаад Лютц ээ! Хошууч Миллер ажил хэргээр ирсэн байна. Үүнийг хэлэлцэхэд таныг оролцуулах гэсэн юм. Манай онцгой даалгавар гүйцэтгэх шинэ офицер, дэслэгч фон Гольдрингийн талаар таны юу бодож байдгийг ноён Миллер сонирхож байгаа юм байна гэхэд нь Лютц гайхан генералын өөдөөс нэг харснаа Миллерийн өөдөөс харав. Нээрээ ямар ёозгүй муухай царай вэ. Ялангуяа хошуучийг тайга нохойтой адил болгосон шөвгөр хамар, эрүү нь. Онигор жижигхэн нүд нь ярьж байгаа хүнээ зүүгээр хатгах мэт нэвт шувт ширтэнэ. — Би дэслэгч Гольдрингийг манай штабт анх ирсэн өдөр нь танилцсан. Энэ бол боловсон, чадварлаг, маш бат найдвартай офицер гэж хэлж чадах байна гэж Лютцийг хэлэхэд — Миллер та дуулав уу, манай туслахын бодол миний саналтай таарч байна гэж Эверс өгүүлсэнд — Эрхэм генерал аа! Би ч гэсэн барон фон Гольдрингийг бат итгэлтэй хүн гэдэгт эргэлзэхгүй байна. Гэвч бидэнд дохио ирсэн гэж Миллер өгүүлээд хуруугаа их учиртай гозойлгож, — Чухам ямар

дохио ирснийг хэлж болохгүй байна. Түүнээс гадна нууц бичиг баримттай хавьтдаг шинэ офицер бүрийг шалгах явдал манай үүрэгт багталцдагийг та бэлхнээ мэдэж байна. Чухам ийм учраас би эрхэм генерал танд хандсан юм. Энэ талаар та надад туслах учиртай гэхэд нь генерал өгүүлрүүн: — Ямар нэг үл таних хүн биш, хүүхэд байхаас нь хурандаа Бертгольдын мэдэх барон фон Гольдрингийн тухай яригдаж байгааг Миллер та харгалзах хэрэгтэй шүү дээ! Энэ тухай хурандаа өөрөө надад ярьсан. Хурандаа Бертгольд бол райхын сайд Гиммлерийн дотно нөхөр. Түүнээс гадна хурандаа Бертгольд Берлин хотод ноён Гиммлерийн штаб-байранд ажиллаж байгаа. Энэ шалгалтыг Бертгольд мэдвэл юу болохыг Миллер та сэтгэлдээ төсөөлж байна уу? гэсэнд — Бид хүн бүгдийг нэгд нэгэнгүй шалгаж байх заавартай. Тэгээд би өчигдөр дэслэгч фон Гольдрингийн намтрыг тодорхой сайн мэдэхгүйн харгайгаар бидний авсан дохионы тухай даргадаа утасдаж орхисон минь тун балай хэрэг болж гэдгийг би одоо лавтай мэдэж байна. Манай дарга нэн даруй шалгах хатуу тушаал өгсөн. Үүнийг Гольдринг өөрөө мэдэхгүй өнгөрнө гэж танд баттай хэлье гэж Миллерийг ярихад — Тэгвэл энэ бүх хэрэгс чинь бид ямар ходбогдолтой юм бэ? гэж Эверс ялимгүй унтууцсан байдалтай асуусанд — Бидэнд таны тусламж хэрэгтэй байна. Та бароныг Лион хот руу явуулах хэрэгтэй. Энэ нь бидний боловсруулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тусална. Гольдрингт дугтуйтай бичиг өгөөд корпусын штабт явуулбал сайн. Бусдыг нь бид гүйцэтгэнэ Шалгалтын дүнг би танд биеэр мэдэгдэнэ. Эрхэм генерал таныг туслах болов уу гэж найдаж байна. Энэ тухай хэн ч мэдэхгүй гэж танд батлан хэлье хэмээн Миллер тайлбарлав. — За тэгье. Биднээс өөр юм битгий шаардаарай. Бароныг чухам хэзээ явуулах вэ? гэж Эверс лавласанд — Өнөөдөр. Галт тэрэг арван зургаа дөчид гарна гэхэд нь — Хошууч таныг манай офицерт холбогдолтой асуудлын талаар дахиад биднийг зовоохгүй биз гэж найдаж байна гэхэд — Үнэнээ хэлэхэд фон Гольдринг Бертгольд хоёрын ямар харилцаатайг танаас сонсоод энэ түүх мий сэтгэлийг ч зовоогоод байна. Гэтэл би хатуу заавар авч, түүгээр барахгүй энэ бяцхан ажиллагааны төлөвлөгөөг даргатайгаа хэлэлцэж таарсан болохоор ухарч буцахад оройтжээ. За ингээд бид яг ярилцаж таарлаа. Баяртай гэж Миллер хэлээд мэхийн ёсолж, тасалгаанаас гарч одов. Миллерийг гарснаас хойш генерал Эверс туслахдаа: — Энэ сэдлэг миний санаанд таарахгүй байна шүү, ахмад аа. Гэтэл бид татгалзах эрх алга. Ямар ч атугай шалгах гэж байгааг Гольдрингт өөрт нь мэдэгдэхгүй байх хэрэгтэй. Эс тэгвэл Бертгольдоор дамжуулаад бидэнд багагүй төвөг удна. Ноён Гиммлертэй хэрэг төвөг удна гэдэг бол дарьтай торхон дээр суучихаад тэслэх утасны асаасан үзүүр гартаа барьж байна гэсэнтэй адил хэрэг гэж уцаарлан өгүүлэв. — Гольдринг шиг хатуу самрыг Миллер мэтийн хүн даахгүй. — Бид өнөөдрийн дотор бароныг Лион руу явуулах ёстой шүү дээ. — Гольдринг онцгой даалгавар гүйцэтгэх офицер болохоор корпусын штабт энгийн нэг армийн зурвас хүргүүлэхээр явуулсан ч ажиг сэжиг авахгүй. Дугтуй дотор юу байгааг ч Гольдринг мэдэхгүй. Бусад нь бидэнд хамаагүй хэрэг. — Тэгвэл дугтуйтай бичиг бэлтгээд миний нэрийн өмнөөс дэслэгчид өгч, Лионд хүргэж өг гэж тушаа. Үг алдавзай, мэдээрэй. — Эрхэм генерал та санаа бүү зовогтун.

«Темпль» зочид буудлын үүдэнд Генрих нэг тариачин эмгэнтэй дайралдлаа. Тэр эмгэн өөрийг нь энхрий зөөлөн харцаар удтал ширтэж, эхлэн мэндлээгүй бол Генрих

түүнийг ажиглахгүй өнгөрөх байсан бизээ. — Бонжур, мосье! гэж эмгэнийг мэндлэхэд Генрих ихэд гайхан — Бонжур, Мадам гэж хариу мэндэллээ. Францчууд герман хүнтэй мэндлэхээс зайлсхийдгийг Генрих өөрийн биеэр үзэж мэдсэн билээ. Генрих зочид буудалд ороод шууд байрандаа орох гэтэл замд нь Тарваль авгай тосож уулзлаа. Энэ удаа тэр авгайн царайд зочид буудлын эзэгтэйн мэргэжлийн инээмсэглэл тодрох нь бус, харин сэтгэл нь ихэд хөөрөн догдолж, уруул нь чичрэн байлаа. Нүдний нь харц ер бишийн энхрий ялдамхан агаад гайхаж асуусан байдалтай ажээ. — Гадаа их халуун байна шүү, барон гэж Тарваль авгай өрөвдсөн байдалтай өгүүлэхэд нь — Нээрээ би өдийд ийм халуун байхыг үзээгүй юм гэж Генрих зөвшөөрөв — Та сэрүүцүүлэх ундаан уухгүй юу? — Танайд юу байна вэ? — Ай, танд бол нэг лонх гайхамшигтай сайхан шампан дарс олдоно гэж авгай хэллээ. Генрихийг танхимд ороход Тарваль авгай нэг тийшээ гүйгээд явчихлаа. Ганц минутын дараа хундага, лонхтой дарс барьсаар эргэж ирэв. Генрих дарснаас нэг балгаад — Нээрээ маш сайхан дарс байна. Францын шампан дарсны алдар нэр алс хол тарсны учрыг одоо л ойлголоо гэж магтсанд — Харамсалтай нь энэ сүүлчийн ганц лонх юм. Би үүнийг онцгой баярт учралыг тохиолдуулан хэрэглэж гэж хадгалж байсан юм гэв. — Тэгвэл энэ дарсыг гэр зуураа хувааж уух ёстой байж шүү дээ. Би учрыг ойлгохгүй байна. — Ай барон! Өнөөдөр надад маш аз жаргалтай өдөр болоод байна. — Даруу биш зан гаргахыг хүсэхгүйсэн. Гэсэн ч таны тэр баярын төлөө дуртайяа ууя. Та яагаад өөртөө хундагалахгүй байна вэ? Тарваль авгайг дахин нэг хундага авчрахад Генрих өөрөө архи хийж өгсөнд алтлаг шар дарс нимгэн шилний цаанаас оч цацруулан гэрэлтэж, шуугин хөөсөрч ирэв — Ахай! Бид ямар ерөөл тавьж уух вэ? гэж Генрихийг асуухад — Юуны өмнө барон ганы эрүүл мэндийн төлөө уухыг хүсэж байна. Чухам таны ачаар ... чухам та ... гээд Тарваль авгайн хоолой нь чичирч, танхимд хүнгүй атал эргэж хараад — Ай барон! Та надад мартагдашгүй ач боллоо! гэж хэлжээ. Генрих учрыг олж ядан зочид буудлын эзэгтэйг гайхан харахад авгай тонгойж тэдний яриаг хүн сонсчих вий гэсэн шиг нууцгайхан шивэгнэж: — Үнэн шүү. Нээрээ мартагдашгүй ач болсон. Даанч энэ тухай ил хэлж болохгүй байна. Ай ноёнтон минь. Энэ аймшигт цагт дуугүй байх хэрэгтэйг би мэдэж байна. Харин та санаж яваарай. Тарваль авгай ачийг хариулж чадах хүн. Би үргэлжийн цагт ... Гэхэд нь Генрих бүүр гайхан сандарч, түүний үгийг таслаад — Ахай таны урмыг хугалах нь байна. Үнэндээ юун тухай яриад байгааг тань огт гадарлахгүй байна шүү гэсэнд — Барон таныг ойлгож байна. Би дуугүй байна. Цаг нь болтол дуугүй байж чадна ... Цагийг нь болохоор бүхэнд дуулдтал ... гэхэд нь — Тарваль авгай таны сэтгэл их хөөрсөн байна. Таны хэлээд байгаа тэр цагийг болтол энэ яриаг хойш тавья гэж Генрих хэлээд өндийж, ширээн дээр мөнгө гаргаж тавих гэтэл Тарваль авгай: — Барон та өнөөдөр миний зочин гэжээ. Тарваль авгайн зан байдал, зочил буудлын үүдэнд дайран тариачин эмгэний эелдэг харцын учрыг олохгүй гайхсан Генрих энэ бүгд ямар учиртай хэрэг болов? гэж эргэцүүлэн бодож, тасалгаан догуур хойш урагшаа холхино. Гэвч энэ явдлын учрыг тайлж чадсангүй. «Бодвол өнөөдөр надад бас азтай өдөр юм байлгүй дээ» гэж эцэст нь шийдээд үдээс өмнө хичээллэж эхэлнэ гэж өчигдөр Моникатай хэлэлцэж таарснаа санаж, толь бичиг авлаа. Энэ үед Моника гэрээсээ хол явжээ.

Моника бидний нэгэнт мэдэх цахилгаан станцын хашаанд зогсож Франсуаг тэсэж

ядан хүлээхдээ ирэхгүй удаад байгаад нь уурлана. Франсуа хүрч ирээд — Чамайг онцын хэрэггүй бол битгий ир гэж тушаасан шүү дээ гэж хэлснээ Моникагийн сэтгэл түгшсэн царайг хараад — Юу болоо вэ? гэж асуув. — Үнэмшмээргүй юм болсон. — Чухам юу болоо вэ? гэж Франсуа сэтгэл зовнин тэсэж — Хагас цагийн өмнө Дюрель авгай гүйж ирээд ууланд тэдний усан үзмийн тариалангийн дэргэд герман офицер манай Пьер Корвиль хоёртой дайралдахыг нүдээрээ үзсэнээ ярилаа ... гэхэд нь — Ай тэнгэр. Жан, Пьер хоёр баригдчихжээ гэж Франсуа зүрх шимшрэн дуу алдав. — Чи байз гэм! Огт үгүй шүү. Тэр хоёрыг тавьчихсан байна ... Түүгээр барахгүй, явахад нь болгоомж алдлаа гэж загнасан байна. — Юу-уу-уу? Чи галзуураа уу? Эсвэл тэр Дюрель авгай солиороо юу? — Дюрель авгай ухаан саруул хэвээр байна. Тэгээл чухам яг ийм явдал болсон гэж андгай тангараг тавьж байна. Тэр ч байтугай герман офицерыг тавьсан байна. — Хэн байгаа вэ? — Барон Гольдринг. Дюрель авгай түүнийг манай зоогийн танхимд байхад нь харсан юм. Ээж тэднийхээс дарс авдаг болохоор Дюрель авгай үе үе манайхаар ирдэг юм. — Бас л Гольдринг! гэж Франсуа амандаа үглээд унжуу хамраа бодлогоширсон янзтай арчаад вандан дээр суув. Моника дарайг нь анхааралтай ажигласан боловч гайхширснаас өөр юм олж харсангүй. — Чи тэгээд үүнийг ямар учиртай гэж бодож байна? гэж Моника тэсгэлгүй асуув. — Одоохондоо мэдэхгүй байна, Өмөөдөр ямар ч атугай Жантай уулзаж асууж лавлаад энэ бүгд үнэн байвал ... — Тэгвэл яах вэ? — Одоо хэлэх юм алга. Би өөрөө ч гэсэн учрыг ойлгохгүй байна. Фашистын офицер, барон хүн хоёр партизаныг барьж аваад тавьчихана гэдэг чинь ... Үгүй, энд нэг учир бий. Тэд биднийг өдөөж, бидний итгэлийг олж авах гэж байгаа байж магадгүй .. Үгүй, дүгнэлт хийхэд их болгоомжтой хийх хэрэгтэй ... Чи ч гэсэн тэр Гольдрингийг улам анхааралтай ажиглаж, мэдээтэй байгаарай. Ингэхэд та хоёрын харилцаа ямар болж байгаа вэ? — Намайг хэл сурахдаа туслаач гэж гуйсан. — Чи зөвшөөрсөн биз дээ? — Чиний хатуу тушаалыг санаад зөвшөөрөх ёстой болсон. — Тэр тэгээд ямаршуу зан байдалтай байна нэ? Юм хум олж мэдэж чадав уу? — Үгүй. Тэр чинь их томоотой, эелдэг мөртлөө надтай налиганаж наадах гэхгүй юм. — Та хоёр юу ярьдаг улс вэ? гэж Франсуа лавлав: Моника франц хэлний тухай, Францын ирээдүйн ту хай Генрихтэй юу ярьснаа Франсуад дамжуулав. Франсуа бүсгүйгээс Гольдрингт холбогдолтой өөр бас хэд хэдэн юм асуусан боловч энэ учрыг тодруулахад онцын нэмэр болсонгүй. Франсуа өндийж: — Тэр барон чинь учир битүүлэг хүн байна даа. Ямар ч атугай санамсаргүй буудаж орхиузай гэж манайханд хэлэх хэрэгтэй юм байна. Тэр үнэндээ фашизмыг эсэргүүцэгч болоод бидэнд тусалъя гэж хүсэж байгаа байж болох юм. Энэ бүгдийг сайн нягталж шалгах хэрэгтэй. Одоохондоо болгоомжтой байгаарай Франц хэлний хичээлийг ашиглаж, аль болох их юм мэдэж авахыг хичээ гэж хэлэхэд нь. — Ойлгож байна гэв. — Ээждээ, Дюрель авгай хоёрт хэнд ч юу ч бүү ярь гэж хэлээрэй. Чи өөрөө юу ч мэдээгүй юм шиг байгаарай гэж Франсуа хэлээд Моникагийн дугуйг түлхсэнээ, — Тэр муу барон ахыг чинь суллаж тавьсны ачийг талархаад түүнд дурлаж орхив доо гэж тоглоом хийсэнд Моника ууртай ширвэж хараад дөрөөгөө жийв. Хоол идэж дуусмагц бүгд суудлаасаа босож, Лютц Гольдрингийн дэргэд ирээд — Дэслэгч танд генерал чухал даалгавар өгсөн. Лион хот орох хэрэг болоод байна. Штабт очье. Тэнд очоод бүгдийг тайлбарлаж өгнө гэлээ. Үргэлж яриа хөөрөөтэй байдаг Лютц штаб орох замдаа үг дуугарсангүй. Түүний сэтгэл тавгүй байгааг Генрих мэдээд өөрөө яриа үүсгэсэнгүй.

Лютц албан тасалгаандаа ороод генералын даалгаврын тухай тэр даруйд бас ярьсангүй. Тэгээд Генрих генералын туслахын энэ хачин зан байдалд сэтгэл түгшиж эхэллээ. — Эрхэм ахмад аа! Генерал чухам ямар даалгавар өгсөн юм бэ? гэж Генрих албанцар дуугаар асуусанд Лютц цагаа хараад — Барон таны мэдэлд нэг цаг дөчин минут үлдээд байна. Арван зургаа дөчид Лион орох галт тэрэг явна. Та корпусын штабт чухал бичиг хүргэх ёстой. Дугтуйтай бичиг бэлэн болсон. Одоо авсан ч болно гээд Лютц төмөр шүүгээнээс хэд хэдэн лацтай том дугтуй гаргаж Генрихт өгөв. Генрих дугтуйг нь яаж битүүмжилж наасныг анхааралтай үзээд юм бүхэн ёсоор байна гэж шийдсэн бололтой, мундирийнхээ дотуур халаасанд хийгээд — Ёсоор гүйцэтгэнэ, эрхэм ахмад аа гэж хэнэггүй хэлээд Лютцийн өгсөн дэвтэрт гарын үсэг зурлаа. Генералын туслах өөрийг нь уйтгартай харах шиг санагдахад — Лютц таны сэтгэл өнөөдөр баахан тавгүй байна уу даа? гэж найрсгаар асуусанд цаадахь нь хачин ярвайж, гараа нэг сэгсэрч орхиод тасалгаан дотуур хойш урагшаа холхив. Тэгснээ Генрихийн урьд ирж зогсоод түүний нүд өөд эгцлэн ширгэж Өгүүлрүүн: — Гольдринг оо, та хамгаалалтгүй явах гэж байна. Замдаа сэрэмжтэй яваарай. Энэ бичиг бол нууц бичиг учраас нүдний цөцгий мэт хамгаалах хэрэгтэйг битгий мартаарай. Энэ бичгийг Штабын даргад өөрт нь юм уу, туслахад нь гардуулаад заавал гарын үсэг авах хэрэгтэй юм шүү гэхэд нь — Та намайг ерийн нэг ажил гүйцэтгүүлэхээр явуулах гэж байгаа биш, фронтын чухал хайгуулд явуулах гэж байгаа юм шиг ярьж байна даа гэж Генрих хошигносонд — Ар талд ажиллах, фронт дээр байлдах хоёрын аль нь доорыг ялгахад удахгүй бэрх болж мэднэ. Ийм учраас болгоомжтой болгоомжтой, бас болгоомжтой гэж танд дахин сануулья гэхэд нь — Таны зөвлөлгөөг санаж явъя, Лютц ээ. Баяртай гээд хоёр офицер бие биеийнхээ гарыг чанга атгалаа.

Генрих замд төхөөрөх зуураа өнөөдрийн уулзсан улсын хачин зан байдлыг үргэлж бодсоор байлаа. Эхлээд тэр тариачин эмгэн, дараа нь Тарваль авгай, түүний учир битүүлэг үгс, эцэст нь одоо Лютцийн сэтгэл тавгүй байдал, болгоомжтой явахыг сануулсан үг ... Лютц өнөөдөр яасам хачин зантай байх юм бэ? Нээрээ дугтуйтай бичгийг штабын дэргэд байдаг зарлага офицероор явуулахгүй, заавал онцгой даалгавар гүйцэтгэх офицероор явуулдаг нь юу вэ? Энэ дугтуйгай бичиг тийм чухал юм бол дүрэм ёсоор өгөх ёстой хамгаалалтыг яагаад өгдөггүй юм бэ? Энд нэг жиг бий. Лютц мэдэх атал хэлэхгүй байх шиг байна Энэ ч бас жигтэй хэрэг. Лютцтэй нөхөр журмын дотно харилцаатай болсон шүү дээ. Лютц юм хэлэхгүй байгаа болохоор дуугүй бай гэж тушаасан байж таарна ... Яах вэ, ямар ч атугай хамгийн олиггүй юм болно гэж бэлтгэх хэрэгтэй байна. Генрих дургуйтай бичгийг дахин анхааралтай үзээд гялгар уутанд нямбайлан хийж, дотуур халаасандаа хийгээд хичээнгүйлэн товчлов. Дараа нь вальтер буугаа тамхины асаагууртай хамт өмднийхөө баруун халаасанд хийлээ. Генрихийг гарах гэж байтал Моника үүд тогшив. Генрихийн замд төхөөрснийг үзээд гайхаж. — Бидний хичээл хийх яалаа? гэв. — Намайг Лионоос буцаж иртэл хойшлуулахаас даа, мадемуазель аа. — Та явах нь уу? Гэнэт үү? Маш яаралтай ажил гараа юу? — Зүгээр, нөхөдтэйгөө уулзахаар хоёр хоногийн чөлөө авсан юм. Мадемуазель танд юу авчрах вэ? Танд захих даалгах зүйл байна уу? — Захих юм алга. Эелдэгхэн санал тавьсанд тань талархая. Надад юу ч хэрэггүй. Сайн яваад хурдан эргэж ирээрэй. — Та үнэнээсээ ерөөж

байна уу? Эсвэл ерийн нэг эелдэг ёсыг дагуулж байна уу? — Үнэн голоосоо хэлж байна гэж Моника тээнэгэлзэнгүй хэлчихээд дайсны армийн энэ офицерыг буцаж ирээсэй гэж үнэнээсээ хүсэж байна шүү гэж бодохдоо хацар нь үл мэдэг улайж, Генрихийн өмнө биеэ цагаатгах гэсэн юм уу, яаран нэмж хэлсэн нь: — Та надад гэм хийгээгүй шүү — Гэхдээ тус болоогүй шүү дээ. — Та францчууд бидэнд талтай сайн ханддаг. Энэ чинь их юм. Та ер нь бусадтай адилгүй хүн шиг санагдах юм ... — Моника та тун сайн бүсгүй байна. Таны амьдрал ч гэсэн тантай адил сайн сайхан байгаасай гэж сэтгэлийн угаас хүсэж байна. Харин битгий их итгэмтгий байгаарай, ялангуяа тал засаж байдаг улсад итгэж болохгүй. Итгээд хууртах явдал олон байдаг юм. Найртай сайн байгаагаа батлахад зөвхөн талтай байх нь бага хэрэг. Үнэн нөхөр гэдгээ үйл ажлаар батлах хэрэгтэй. Та миний хэлснийг зөвшөөрч байна уу? — Анд нөхөр байхыг хүссэн хүн ам хэлээр биш, ажил үйлээр тусалъя гэвэл хэзээ ч чадна гэж Моника аяархан хариуллаа. Генрих өөд харсан бүсгүйн нүдэнд хариу хүлээсэн, бас жаахан айсан байдал үзэгдэнэ. Моникагийн бодох нь: би эндүүрч, энэ хүн анд нөхөр биш байвал яана? Амьдрал ахуйн өчүүхэн ч туршлагагүй би үүнийг яаж ялгаж таинх вэ? гэж бодно. Генрих, бүсгүйн тэр учиртай харцыг огт ажиглаагүй юм шиг байдал гаргана. Яагаад вэ гэвэл Генрих өөрөө ч гэсэн өмнө нь зочид буудлын эзэгтэйн охин, зүгээр нэг сайхан хүүхэн зогсож байна уу, эсвэл ... гэдгийг мэдээгүй байгаа билээ.. — Моника! Бид дараачийн хичээл дээр энэ тухай ярья. Одоо би явахгүй бол галт тэрэгнээс хожигдох нь гэж Генрих өгүүлээд бүсгүйн гарыг чанга атгаад гадагш гарлаа. Галт тэрэгний буудлын тавцан дээр явахын өмнө хөл хөдөлгөөн болж, төмөр зам алс тийш зурайн байхыг Генрих үзэхдээ ямагт нэгийг хүлээн сэтгэл нь түгшдэг билээ. Өнөөдөр тийм сэтгэл бүүр ч хүчтэй эзэмджээ. Үл мэдэгдэх зүг тийш бас нэг аялал хийх боллоо. Лионд гэнэт томилон явуулж байгаа нь ямар учиртай юм бол? Лютц салахдаа ийм хачин зантай байдаг нь юуных вэ? Дугтуйтай бичгийг маш чухал гэж хэлээд боломжтой явахыг зөвлөсөн мөртлөө харуул хамгаалалтын тухай ичингүйрэн дуугүй өнгөрдөг нь юу вэ? Учир нь ойлгогдохгүй байна огт ойлтогдохгүй байна. За ер нь Лион хүртэл зай байна. Зам зуураа бүгдийг сайн эрэгцүүлэн бодъё. Генрих үргэлжид түгших сэтгэлийг зоригийн хүчээр дараад офицеруудын вагон тийш хурдлан алхлаа. Үйлчлэгч цэрэг нь тэнд нэг гартаа жижиг чемодан, нөгөө гартаа бөөн сонин бариад зогсож байв. — Наадхыгаа купед оруулж тавьчихаад явж болно гэж түүнд Генрих тушаалаа. Үйлчлэгч цэрэг нь нэг л зовсон янзтай хөлөө зөөж байснаа: — Эрхэм дэслэгч танд нэг захиа ирлээ. Таныг машинаас дөнгөж гаргал шуудан тараагч жаал хүү авчирч өгсөн. Та урагшаа яваад өгсөн болохор тэр даруй ... гэхэд нь үйлчлэгч цэргийн цаашид биеэ өмөөрч ярихыг үл сонсон дугтуйтай бичгийг авч хайхрамжгүй халаасандаа хийж орхиод — За, за, яв гэжээ.

Генрих вагонд орсон хойноо л сая дугтуйг анхааран үзэв. Захиаг өөрт нь хаяглажээ. Задалж үзвэл богинохон зурвасын дор хүний нэр байсангүй. *«Таныг мөрдөн ажиглаж байна. Болгоомжтой яваарай!»* гэж үл мэдэгдэх хүн сануулсан байна. Генрих тэр зурвасыг санамсаргүй эргүүлж харвал ар талд нь харандаагаар бас л товчхон намж бичсэн нь: *«Нүд нь боолттой ахмадыг анхаарагтун»* гэжээ. Энэ чинь юу вэ? Лютцийн бас нэг сануулга уу? Үгүй, Ингэж нууцгайлж байдаг нь түүний зан биш ... Тэгвэл зурвасыг Моника бичээ юу? Сүүлд уулзахдаа Моника баахан сэтгэл зовнисон

байдалтай байсан. Аюул учрах гэж байгааг хэлэх гээд шийдэж зүрхлээгүй байж болох юм. Ээ, энэ ч шал дэмий бодол. Надад аюул заналхийлж байгааг тэр бүсгүй хаанаас олж мэдэх билээ. Энэ сануулга өөр уг сурвалжтай байвал яах вэ? Өөрийн нь жинхэнэ нөхөд байж болох биш үү? Тухайн үедээ нэг хүн оросын командлалд «Төмөр нударга» ажиллагааны тухай мэдээлсэн байсан шүү дээ. Тэр хүн Генрихийн хажууд бас л өөр шиг нь нуугдаад ажиллаж байсан байна. Тэр хүн одоо хажууд нь байгаа ч юм билүү. Үгүй дээ, бас л тийм байж болмооргүй. Тагнуулч хүн ийм гэнэн ажиллахгүйсэн. Лионд явах даалгавар авсан үед иймэрхүү нэргүй сануулга ирсэн нь тун гайхалтай хачин хэрэг ... Ингэж таарсан нь учиртай юм биш биз? Генерал гэнэт даалгавар өгсөн ... Лютц хачин зан авиртай болсон. Одоо энэ захиа ... Энэ бүгд үзүүр сэжүүр нь огт баригдахгүй байгаа нэг гинжийн гархинууд шиг байна. Ямар ч атугай тодорхой дүгнэлт хийхээсээ өмнө мөрдөн ажиглаж байгаа гэдэг нь үнэн эсэхийг шалгах хэрэгтэй. Тэр үнэн байвал ... Генрих тамхиа асаагаад өрөөнөөсөө гарч вагоны нөгөө үзүүрт хэсэг офицер хүүрнэлдэж байгааг харвал ахмад цолтой нэг хүн нүдээ хар юмаар боосон байлаа. Генрих арван есөн цаг хорин минутад Шамбери өртөөн дээр буув. Тэнд өөр галт тэргэнд шилжин суух ёстой байсан боловч Лион орох галт тэрэг маргааш өглөөний найман цагаас нааш явахгүйг комендатурт очоод мэджээ. Ингээд шөнөжин хүлээх хэрэгтэй боллоо. Комендант нь Генрихт галт тэрэгний буудлын дэргэд байдаг зочид буудлыг зааж өгөв. Комендатурын ойролцоо ердийн адил цэргийн олон хүн бужигнана. «Миний нөгөө *а*а* харуул энд байгаа биз» гэж Генрих бодтол баруун нүдээ хар юмаар боосон хүний танил дүрийг тэр даруй олж харлаа. Тэр хүн толгойгоо шувуу шиг ийш тийш нь эргүүлэн хүмүүсийг ээлжлэн харна. Генрих ачаа зөөгчийг дуудаж чемоданаа өгөөд — Намайг энд хүлээж бай. Бн буфетэд очоод ирье гэв. Нөгөө ахмад чимээ чагнаж байгаа бололтой толгойгоо гилжийлгэв. Генрих эрэгнэг тийш очиж явахдаа «энд хүрээд ирнэ дээ» гэж бодов. Янжуур худалдаж авах зуур нүдний булангаар хаалга руу харж байтал үнэхээр нөгөө мөрдөгчийн яршиг болсон танил нүүр үзэгдлээ. «Мэдээтэй байгаарай, чамайг мөрдөж байна шүү гэж мэдүүлэх гэсэн юм шиг нүдний өмнө үргэлж сүүтэгнээд байдаг нь юу вэ! Туршлагатай мөрдөөч бол болгоомжтой хөдлөх хэрэгтэй гэдгийг мэдэх учиртайсан. Үгүй, энэ мөрдлөг биш байж таарна. Энэ бол мөрдөж байгаа дүрээр сэтгэхүйн дайралт хийх гэсэн нарийн тоглоом байна. Намайг айлгаж сэтгэлийг минь дэнсэлгэх нь хэн нэг хүнд хэрэгтэй байж л дээ. Эд ямар нэг тодорхой юм мэдсэн бол ингэхгүйсэн ... Нэгэнт тийм болохоор бүх хөзөр миний гарт байгаа хэрэг. Хамгийн гол нь миний эргэн тойрон элдвийн юм зохиож байгааг огт тоосон шинжгүй байх хэрэгтэй юм. Юу ч болоогүй юм шиг, юу ч мэдээгүй юм шиг дүр үзүүлье. Гол цохилтыг няцаахын тулд хүчээ хайрлах хэрэгтэй ...» гэж Генрих бодов. Арваад минутын дараа Генрих буудлын дэргэдэх талбайг тайван өнгөрч, зочнд буудлын үүдний танхимд орлоо. Хоёрдугаар давхарт шатны дэргэд байр аваад дахин доош зоогийн танхимд орж, хоол зөөгчийн өгсөн цэсийг үзсэн ч үгүй, — Хөнгөн зууш, шарсан мах, аяга аагтай кофе гэв. — Танд ямар дарс барих вэ? — Дарс хэрэггүй. Ингэхэд танай энд гар угаачихмаар газар бий юу? гэсэнд хоол зөөгч танхимын үзүүр тийш заав. Угаалгын тасагт шээс шинхэг үнэртэх учир Генрих таван минут тэнд саатна гэж төлөвлөснөө арайхийн өнгөрүүлэв. Ширээн дээрээ эргэж ирэхэд санаж бодсон нь үнэн болж, алчуурын дор дөрөв нугалсан зурвас байхыг үзлээ. Мөн л түрүүчийнх шиг арагш их налсан үсэгтэй, мөн л

туруучийнхтэй адил цаасан дээр бичжээ. Агуулга нь илүү тодорхой, дэлгэрэнгүй байлаа. «Та бид ярилцах хэрэгтэй байна. Бильярдын тасалгаанд уулзая. Би гаргаа саарал велюр бүрх малгай барьсан байх болно. Танд туслахыг хичээе. Найз чинь» гэсэн байлаа. Генрих гайхан дал мөрөө хавчаад хоол зөөгчийг дуудаж, — Энэ ширээг цэвэрлээд орхино уу гэж уцаарлан дуугараад нөгөө бичгийг сэжиглэсэн юм шиг хурууны үзүүрээр барин шидэж орхив. — Эрхэм дэслэгч танд хэлэхэд ... гэж хоол зөөгчийг ам ангайхад нь — Дахиад хэлье. Ширээний хогийг цэвэрлээтэх гэсэнд хоол, зөөгч тасгийн эрхлэгч өөдөө сандран хараад нөгөөх гайтай зурвасыг хумин авч, ширээг алчуураар яаран гүвж гарлаа. Генрих танхимын доторхийг уйтгарласан байдалтай эргэн тойрон харав. Энд суугаа улсын дотроос нэг нь түүнийг ажиглаж байгаа даг. Тэр тусмаа сайн. Зурвасыг зохиогч үл мэдэгдэх этгээд одоо цохилт нь оноогүйг баттай мэдэж авна. Барон фон Гольдринг нэргүй зурвасыг хог новш хэмээн үзээд хажуу тийш нь шидэж орхиод тэр даруй мартчих нь энэ. Өдрийн турш үзэж өнгөрүүлсэндээ ядарсан Генрих хоол идсэн даруй өрөөндөө орлоо. Одоо л нэг амрах бололцоотой болов. Генрих мундирээ тайлж хаячихаад тасалгаан дотуур явж, хөшигний цаагуур, шүүгээ дотор үзэхэд хэн ч байсангүй. Одоо хаалгаа түгжээд ямар ч атугай гар буугаа хуйнаас нь гаргаж өмднийхөө баруун халаасанд хийх хэрэгтэй. Гудамд хүн сэмхэн алхлах чимээ сонсдоход Генрих болгоомжтой чагнав. Үйлчлэгч эмэгтэй юу? Үгүй, үйлчлэгч бол хаалга тогших ёстой. Гэтэл хаалганы цаана байгаа хүн хаалганы бариулыг мэдэгдэхгүй сэмхэн эргүүлэх гэж оролдож байлаа. Генрих огцомхон түргэн хөдөлгөөнөөр гараа өмднийхөө халаасанд хийж, тасалгааны голд зогсоод хүлээлээ. Хаалга гэнэт агшин зуур онгойж, мөн агшин зуур хаагдав. Үүдний тэнд саарал пальтотой, мөн тийм саарал велюр бүрх малгайтай өндөр хар хүн зогсож байлаа. «Аан, нөгөө бильярдын тасагт уулзъя гэж болзоо тавьдаг этгээд мөн байна» гэсэн бодол Генрихийн толгойд зэрсхийгээд халаасан дотроо маузер буугаа чанга атгав. Үл таних хүн урагшаа нэг алхаад — Та барон фон Гольдринг мөн үү? гэж асуухад нь, — Та өрөөнд минь дайран орж ирэхдээ миний хэн болохыг мэдсэн байлгүй дээ. Та урьдаар уучлал гуйж, нэрээ хэлээд ингэж ёс журамгүй орж ирснийхээ учир шалтгааныг тайлбарлавал зохих биш үү? гэсэнд — Хоосон ёсорхож цаг үрэхээ байя, барон! Надад ч гэсэн танд ч гэсэн цаг бага байна. Бүгдийг товчхон тайлбарлахын тулд би бол танд туслахыг хүсэж, таныг эртнээс эрж яваа найз нөхөр чинь гэдгийг л хэлчихье. Та миний уулзъя гэсэн саналыг хүлээж аваагүй зайлсхийсэн болохоор би өөрөө хүрч ирэх боллоо. Одоо та намайг суухыг зөвшөөрөх болов уу? гээд үл таних хүн урихыг хүлээсэн ч үгүй, бичгийн ширээний дэргэд очиж, хажуу дахь сандал дээр нь суув. Генрих өөдөөс нь харж суугаад өмнөө нэг хайрцаг янжуур гаргаж тавилаа. — Бид шууд ажил төрлөө ярьж эхэлбэл зүйтэй гэж бодож байна. Та зөвшөөрөх үү? гэж гэнэт ирсэн тэр хүн асуухад нь, — Таны үгийг сонсоё гэж Генрих хүйтэн хөндий өгүүлээд өмднийхөө баруун халаасанд гараа алгуурхан хийв. Үл таних хүн тэр хөдөлгөөнийг нь сэжиглэсэн байдалтай ажиглаж байлаа. Генрих асаагуураа яаралгүй гаргаж ирээд тамхиа асааж, асаагуураа дахин халаасандаа хийлээ. Үл таних хүн сандлын түшлэгийг налан хөлөө жийж, тухлан сууж аваад — Би товч оршил үг хэлье. Таны огт танихгүй хүн намайг шулуухан хэлэхэд өрөөнд чинь ёс журамгүй дайран орж ирснийг та гайхаж байгаа биз. Би чухал хэрэгтэй болоод ингэж ёсыг зөрчсөн юм. Та намайг урьд өмнө үзээгүй. Би болоод миний сайн нөхөд бол барон таныг аль хэдийнээс

ажиглаж, тантай холбоо тогтоохыг оролдож байна. Бидэнд одоо болтол тайван тухтай ярих тийм нөхцөл бололцоо таарсангүй. Таны Лион орж яваа тань бидэнд аятайхан тохиолдол боллоо ... Таныг бараг ухамсарт бүх амьдралынхаа турш Орос оронд сууж байсныг бид мэднэ. Бас тэнд таны ямар ажил хийж байсныг мэднэ. Одоо бид үүнийг нэг их сонирхохгүй байна. Яагаад вэ гэвэл аль нэг улс оронд урт удаан хугацаагаар суухад тэр хүний байдалд эрхбиш нөлөөлдөг гэж бодож байна. Зөвлөлт Холбоот Улсад амьдран сууж байсан чинь таны үзэл санаа, сэтгэхүйд нөлөөлсөн биз. Намар та Комаров нэртэйгээр германы талд шилжин ирснийг чинь бид мэднэ. Үүнийг ч нэг их онцолж анхаарахгүй байна. Тэр бол залуу хүнийг зориг бадрангуй санаа шингэсэн гэмээр эх оронч тэмүүлэл байлаа. Хагуу хөтүү бодит байдалтай анх тулгараад таны урам хугарсан байх. Та бол зан чанарын хувьд герман гэхээсээ илүү орос хүн шүү дээ. Та насан турш Орос оронд сууж байсан шүү дээ гэв. Үл таних хүн Генрихийн хариу хэлэхийг хүлээн хэсэг дуугүй болов. Наадахь нь — Цааш нь гэхээс өөр юм хэлсэнгүй. — Одоо болтол би таны өнгөрсөн амьдралын тухай ярилаа. Одоо ирээдүйн тухай ярья. Барон та энэ дайнд нөгөө лагерийн хүч бололцоог бодолцолгүй Германы талд орж ирсэн чинь дэмий ажил болжээ. Германы чадал нэгэнт барагдаж, Зөвлөлт Холбоот Улс, Америкийн Нэгдсэн Улс, Англи мэтийн том гүрнийг дийлэхгүй болсон нь учир мэдэх ухаалаг хүн бүрд илэрхий байна. Үүнийг фашистуудад боолчлогдсон бүх улс түмэн ойлгоод партизаны тэмцэл хийж эхэллээ. Англи-америкийн цэрэг Францын Ла-Маншийн хоолойн эрэгт өнөө маргаашгүй буух гэж байна. Энэ бүх баримтыг та эрхбиш харгалзах ёстой. Одоо герман офицерын хувцас өмссөн аливаа хүн ирээдүйгээ бодох ёстой. Та залуу, баян хүн. Хамаг амьдрал чинь өмнөө байна. Харин Герман ялагдах юм бол та бусдын хийсэн нүглийн өр төлөөсийг биеэрээ хариуцахад хүрнэ. Тэгвэл та энэ дээрмийн дайнд оролцсоноо юугаар зөвтгөх юм бэ? Юугаар ч зөвтгөж чадахгүй Бид танд тийм бололцоо олгохоор шийдлээ.

Генрих үл таних хүний яриаг тасалдуулалгүй, хөшсөн юм шиг сууж байв. Яах вэ, ярих юмаа дуустал яриг. Байдлыг харж байгаад яахыгаа шийдье. — Та германы армид алба хааж байсан ч гэсэн францын эх орончдод тусалж байсныг нотлох бичиг баримт, гэрч нартай болохыг хичээвэл таарна. Энэ ямар учиртайг та ойлгож байна уу? Генрих үл таних хүнийг нүдээ анийлган ширтэв. Хэлсэн саналыг нь эргэцүүлэн бодож байх шиг байлаа. Түүнийг дуугүй байхаар урамшсан нөгөө хүн үргэлжлүүлэн: — Та миний үгийг анхааран чагнаж байгаа тань сайн хэрэг. Одоо би нэрээ хэлье. Би Эсэргүүцлийн хөдөлгөөний нэг хэсгийн удирдагч, коммунист Пьер Кеспи. Бид таны хүчин зүтгэлийг хэрэглээд бидэнд өгсөн мэдээний хэр чухлыг харгалзан эд материалын талаар хариу туслах болно гэв. Одоо бүгд тодорхой боллоо. — Та надаар юу хийлгэх вэ? гэж Генрих асуугаад хичнээн тайван дуугарснаа өөрөө ч гайхав. Өөрийгөө Пьер Кеспи гэж нэрлэсэн хүн баярлаж, — Энэ чинь зөв асуулт байна! Товчхон хэлэхэд та үе үе бидний сонирхож байгаа мэдээг бидэнд өгч байх болно. Та дивизийн штабт ажилладаг болохоор үүнийг гүйцэтгэхэд төвөггүй байх болно. Мэдээлэл юм уу, баримт бичиг бүрийн үнийг та өөрөө хэлж байх болно. Эхлээд та одоо авч яваа дуттуйтай бичгээ надад өгнө үү. Нэг цагийн дараа танд яг хэвээр нь буцаан өгнө. Бичгийг нь үзсэнийг нэг ч хүн мэдэхгүй гэв. Генрих тэр хүний өөдөөс тайван ширтэн дуугүй сууж байлаа. Энэхэн үед элдвийн бодол тархинд нь багтаж ядан эргэлдэж байв. Дугтуйтай бичиг авч явааг минь энэ хүн мэдсэн

байж! Тэгэхлээр Лионд томилон явуулсан нь нэг ёсны сорилт шалгалт байгаа юу? Ингээд гүйцээ юу? Эд нар миний герман эх орондоо үнэнч эсэхийг шалгаж байгаа юм уу? Яах вэ, үзүүлээд өгье гэж Генрих боджээ. Генрих янжуураа яаралгүй имрэх зуур өмднийхөө халаасанд гараа хийв. Гестапогийн өдөөн хатгагч хүн бас нэг янжуур авч, хуруун завсраа үнгэн Гольдрингийн асаагуураа гаргаж ирэхийг хүлээж байлаа. Гэтэл гестапогийн хүн янжуураа зуугаад тамхиа асаахаар тонгойтол асаагуурын оронд нүүр рүү нь гар бууны ам тулгасан байв. Бусад нь ганцхан агшин дотор боллоо. Гестапогийн хүн хөлийнхөө хар тэнхээгээр ширээг өшиглөж орхиод Гольдрингийг дайвж, гар буугаа хоромхон зуур доош болгох самбаанд тасалгаанаас гүйн гарав. Генрихийг гадагш гүйж гарахад хутган үймүүлэгч гудмаар гүйж явлаа. Буун дуу дараа дараагаар хоёр дахин тас хийж хүн чарлах чимээ гараад бараг нэг зэрэг хүний бие луг хийтэл хөсөр унах дуулдан. Генрих эргэж харвал гудамд хүн байсангүй. Гэвч тэр даруй хүний хөлийн чимээ дуулдаж, СС-ийн дүрэмт хувцастай офицер, нэг бага дарга, хоёр цэрэг гарч ирлээ. «Бэлтгээд байж шүү!» гэсэн бодол Генрихийн толгойд зэрсхийв. Нөгөө офицер холоос: — Битгий буудаарай. Би эргүүл байна гэж хашгирахад нь — Бичиг баримтаа үзүүл гэж Генрих эрс хэллээ. Гестапогийн офицер бичиг баримтаа гарган Генрихт үзүүлж, Цэргүүд нь хэвтэж байгаа хүн тийш ухасхийв. Тэр хүн амьд боловч ухаан алдсан байжээ. — Юу болсон бэ? гэж офицерыг асуухад — Зочид буудалд францын партизан нартай холбоотой дайсны тагнуулд шурган орж ирээд зохих шангаа авсан нь энэ гэж Генрих хорсолтой өгүүлэв. Барон фон Гольдринг тасагтаа ороод үл таних этгээдийн юу ярьсныг нэгд нэгэнгүй дамжуулан ярихад бага дарга өчгийг бичиж аваад Гольдрингоор гарын үсэг зурууллаа. Та шөнөдөө хаалгаа сайн түгжээрэй гэж нөгөө офицерыг явахдаа хэлэхэд нь — Та нар зочид буудлын хамгаалалтыг анхаарвал таарна. Гадаадын тагнуулчид офицеруудын зочид буудалд гэртээ орж байгаа юм шиг нэвтэрч байна гэдэг юу гэсэн үг вэ! гэж уурлан хэлэхдээ дотроо тачигнатал хөхөрмөөр санагдаж билээ.

ХОШУУЧ МИЛЛЕР ГОЛЬДРИНГТОЙ НАЙЗЛАХЫГ ХҮСЭВ Генерал Эверсийг офицеруудын гуанзанд очиж хооллохоор бэлтгэж байтал Лютц орж ирээд — Эрхэм Миллер өөрийгөө хүлээж авахыг хүсэж байна гэсэнд — Тэр яагаад манайх руу гүйгээд байдаг болов? Дахиад юугаа бодсон юм бол? Эсвэл намайг бас шалгах гэж байгаа юм болов уу? гэж Эверсийг уцаарлан хэлэхэд нь — Таныг шалгахаасаа өмнө намайг шалгахаар ирсэн байж магадгүй гэж Лютц хэлсэнд — Оруул гэжээ. Миллерийт орж ирэхэд генерал: — Та дахиад ямар нэг эвгүй хэргээр ирэв үү? гэсэнд — Үгүй, энэ удаа тавд тааламжтай мэдээ авчирлаа, ноён генерал аа! гэж Миллер хэлээд суув. Тааламжтай мэдээ авчирлаа гэж хэлсэн боловч хошуучийн царай баахан яравгар байлаа. — Бид өчигдөр төлөвлөгөө ёсоор танай онцгой даалгавар гүйцэтгэх офицер, дэслэгч фон Гольдрингийг шалгалаа гэж Миллерийг өгүүлэхэд — За тэгээд юу болоо вэ? гэж Генерал сонирхон асуув. Миллер Шамберийн зочид буудлын өрөөнд болсон хэрэг явдлыг дэлгэрэнгүй нарийн ярьж, тэр бүх яриаг соронзон хальсанд буулгаж авсныг ч нуулгүй хэлж, төгсгөлд нь: — Лангхейний баруун уушгинд хоёр сум туссан. Одоо эмнэлэгт хэвтэж байгаа. Мөд гарахгүй байх ... гэхэд нь генерал чин зүрхнээсээ хөхөрч, Лютц бас дагаж хөхөрлөө. — За ноён Миллер та Гольдрингийн бат итгэлтэйг одоо сэнхэрч мэдээ биз дээ? гэсэнд — Лавтай мэдлээ гэжээ. — Лютц та өнөөдрийн дотор

дэслэгч фон Гольдрингийг хоёр дугаар зэргийн загалмай одонгоор шагнуулах тухай санал төлөвлөж бэлтгэ гэхэд нь — Ёсоор гүйцэтгэе! гэж Лютц хариуллаа. — Өмнө нь СС-ийн оберштурмбанфюрер¹⁰ Лангхейн сууж байгааг дэслэгч мэдээгүй биз дээ? Тийм үү, ноён Миллер ээ? гэж генералын асуухад. — Яг тиймээ. Барон өөртэйгөө хэн ярьж байгааг тааварласан бол энэ шалгалт цус урсгалгүй дуусгах байсан гэж бодож байна. Бид одоо барон фон Гольдрингийн бат найдвартайг эргэлзээгүй мэдлээ гэхэд нь. Одоо ноён Миллер та бидэнтэй хамт хооллохгүй юу? гэж Эверс урив. Фон Гольдрингийг шалгасан тухай Миллерийн яриаг генерал сонсоод илт сайхан зан нь хөлөлжээ. — Хүндтэйеэ хүлээж авъя, ноён генерал аа! гэж Миллер мэхийн ёслол. Урьд урьдынхыг бодвол их хөгжил шуугиантан болсон хоолны үед фон Гольдрингийн баатар зоригийн тухай бүгдээр шагшин хэлэлцлээ. Хоолны төгсгөлөөр генералын сэтгэл их хөөрч, Дорнод фронт дээр эхэлсэн давшилтын төлөө хундага өргөж, тэр давшилт энд байгаа хүмүүсийн олонхид энэ жилийн дотор Москвад очих бололцоо олгоно гэж хэлэв. Шамберид болсон хэрэг явдлын сураг Сен-Ремид тийм хурдан дуулдана гэж Генрих огт санасангүй. Гэтэл алдар нь түүнээс түрүүлээд ирсэн байжээ. Генрих ирээд штабт очихоор явжбайтал хаалган дээр штабын офицер ахлах дэслэгч Фельднер түүнийг зогсоогоод — Аа барон уу. Сайн явж ирэв үү. Таны баатарлаг үйлсийн тухай бид бүгд дуулсан. Танд анх түрүүн баяр хүргэхэд таатай байна гэж эелдэг бөгөөд хүндэтгэлтэй өгүүлэхэд нь Генрих тэр даруй учрыг ойлгосонгүй. — Юун баатарлаг үйлс вэ? гэсэнд — Битгий даруу зан гарга даа. Таны баатарлаг үйлсийн тухай өчигдөр хоолны дараа бүх офицеруудад генерал ярьсан. Генералд эрхэм Миллер бүгдийг ярьж өгсөн юм байна гэхэд нь — Аа, түүнийг хэлж байгаа юм уу ... Баяр хүргэсэнд тань талархая гэж хариулжээ. Генрих үүдний танхимд ороод шатаар өгсөх гэтэл дэслэгчийг хараад вандан дээрээс босон харайж, эгцлэн зогссон нэг цэрэг түүний анхаарлыг татлаа. Тэр бол арван ес-хорин настай, цайвар үстэй, туранхайвтар, ухаалаг цэнхэр нүдтэй залуу байв. Чухамхүү нүдний нь харц Генрихийг саатан зогсоход хүргэжээ.

Тэр залуугийн харцад ихэд гуниглан цөхрөнгөө барсан байдал байхыг ажиглахгүй өнгөрөхийн арга байсангүй. Хөлийн нь дэргэд үүргэвч нь байлаа. — Чи хэн бэ? гэж дэслэгч асуусанд — Би ахлах цэрэг Курт Шмидт байна, эрхэм дэслэгч ээ гэж тэр. цэрэг тодхон хариулав. — Хаанаас явж байна вэ? — Зуун арван долдугаар хорооны хоёрдугаар батальоны хоёрдугаар суманд алба хааж байгаад одоо Дорнод фронтод томилогдоод байна гэж тэр хүүхдээрээ шахуу залуухан цэрэг хэлэхдээ нүдэнд нь нулимс мэлтэгнэн байв. — Таныг яагаад тийш нь шилжүүлж байгаа юм бэ? — Сумангийн дарга аглагч дэслэгч Фельднерийн илтгэснээр гэхэд нь — Та ахлах дэслэгчийн өмнө ямар гэм хийсэн юм бэ? гэсэнд — Дөрвөн хоногийн өмнө ахлах дэслэгч Фельднер жаахан халамцуу байсан. Тэгээд би түүнтэй юхих ёсоор мэндлээгүй шиг санагдсан юм байхаа. Уг нь би үнэнээ хэлэхэд дүрмийн ёсоор мэндэлсэн юм. Тэгээд ахлах дэслэгч, намайг «Хэвт!», «Бос!» гэж тушаагаад л байлаа. Би тушаалыг нь тамираа барагдтал гүйцэтгэсэн. Би удалгүй эцэж орхилоо. Би ерөөс сул биетэй хүн, тэгээд өндийж чадахгүй болсон ... Ахлах дэслэгч намайг харааж зүхээд дараа нь тушаал биелүүлэхээс татгалзсан гэдэг илтгэл бичиж дорнод фронтод явуулахыг хүссэн юм гэв. — Таны ярьж байгаа энэ бүгд үнэн юм уу? — Чин үнэн, эрхэм дэслэгч ээ. Тэнгэрийн өмнө очсон ч! гэж залуу

цэрэг хэлээд Гольдрингийг машид царайчилсан байдалтай харахад нь цэрэг шинельтэй тэр жаал хүүг Генрих өрөвдөөд — Тэ Дорнод фронтод очихоосоо их айж байна уу? гэв. — Эрхэм дэслэгч ээ, Дорнод фронт дээр миний хоёр ах алагдсан юм. Эх маань ганц надтай үлдээд байгаа юм. Намайг Дорнод фронтод явуулсныг ээж маань мэдвэл тэсэхгүй дээ. — Та энэ тухай генералд ярихгүй яасан юм бэ? — Хороон дарга хүртэл надтай ярихыг хүссэнгүй ... гэхэд нь Генрих бага зэрэг бодоод: — Томилолтын тухай тушаал чинь танд байна уу? гэсэнд — Энэ байна. Намайг энд Шамбери орох замын машин харж бай гэж тушаасан юм гэхэд нь, — За Курт ээ, би генералтай яриад үзье. Харин таныг энд үлдээхийн тулд нэг шалтаг заах хэрэгтэй. Татгалзахгүй бол би таныг өөрийн үйлчлэгч цэргээр авья гэж хэлье. Зөвшөөрөх үү? гэсэнд — Би таны бүх тушаал зааврыг ёсчлон биелүүлж, хэнээс ч илүү ажиллана гэхэд нь — Бичиг баримтаа нааш нь аль. Намайг энд хүлээж байгаарай гэж Генрих хэллээ. Тэр цэрэг офицерыг хэлсэн үгээ буцчих вий гэж айсан юм шиг. дэслэгчид бичиг баримтаа өгөхдөө гар нь салганан чичирч байв. Генрих хоёрдугаар давхарт гарч, Лютцийн өрөөнд ороход Лютц ширээнийхээ цаанаас босож ирээд Генрихийн гарыг чанга атгаж: — Аа Гольдринг уу. Уулзсандаа баярлаж байна. Таныг генерал өөр дээрээ даруй оруул гэсэн гэжээ. Генрих дугтуйтай бичгийг хүргэж өгсөн тухай штабын бичгийг ахмадад өгөөд генералын тасалгаанд орлоо. Генерал Эверс Гольдрингийг хармагцаа: — За дэслэгч ээ, юу юу болсныг ярь гэхэд нь Генрих болсон бүх явдлыг нэгд нэгэнгүй ярив. — Таныг хоёрдугаар зэргийн гөмөр загалмай одонгоор шагнуулах санал оруулсан гэхэд нь, — Маш их баярлалаа, ноён генерал аа! Би өнөөдрийн дотор энэ тухай Бертгольдод захиа бичнэ. Миний төлөө халамж анхаарал тавьж байгаад тань хурандаа Бертгольд танд талархана гэж бат итгэж байна гэсэнд энэ хариулт генералын сэтгэлд нийцэж. — Хурандаад мэхийн ёсолж байгааг минь дамжуулаарай гэв. Эрхэм генерал аа. танд нэг хүсэлт тавихыг зөвшөөрнө үү. — Болно. — Энэ дор үүдний танхимд ахлах дэслэгч Фельднерийн рапортаар Дорнод фронтод томилогдсон нэг цэрэг хүлээж байна. Би уг нь энэ тухай яримааргүй байна. Гэвч ялангуяа тэр цэрэг бие махбодын хувьд сул дорой, бас хоёр ах нь Дорнод фронтод амь үрэгдсэнийг бодолцох юм бол ахлах дэслэгч арай хилсдүүлсэн бололтой. Надад үйдчлэгч цэрэг хэрэгтэй байгаа юм. Тэр цэргийг миний үйлчлэгч цэргээр үлдээнэ үү гэж хүсье, эрхэм генерал аа! — Ердөө энэхэн үү? гэж генерал ихэд шалгарсан офицертоо илүү тус болж чадахгүй нь гэж жаахан урам хугарсан байдалтай өгүүлэв. Генерал, Генрихийн гараас Куртийн бичиг баримтыг авч, нэг бичиг дээр өөрийн түрүүчийн хийсэн цохолтыг дараад дээд талд нь том бичгээр: «Дэслэгч барон фон Гольдрингийн үйлчлэгч цэргээр штабын дэргэд үлдээ» гэж цохлоо. — Маш их баярлалаа, эрхэм генерал аа! Та миний нэг дэх хүсэлтийг ийм хурдан биелүүлсний дараа хоёр дахь хүсэлтээ тавихыг зөвшөөрнө үү гэсэнд — Түүнийг чинь ч бас биелүүлж болох магадгүй гэж Эверс инээмсэглэхэд нь Тэгвэл Лион хотоос танд тусгайлан зориулж эрж олсон арван лонх хуучин франц шампан дарсыг надаас хүлээн авахыг хүсье. Таныг сайн шампан дарсанд дуртай гэж ахмад Лютц ярьж байсан юм гэхэд нь Эверс инээд алдаж: — Таны энэ хүсэлтийг түрүүчийн хүсэлтээс илүү дуртайяа гүйцэтгэе гэв. — Явж болох уу? — Явж болно. Ар гэрийн байдлыг харгалзан долоо хоногийн чөлөө олгохыг хүссэн өргөдлөө өнөөдөр өгөөрэй. — Ай, маш их баярлалаа, эрхэм генерал аа. Би энэ тухай хэдийнээс хүссэн боловч гуйж зүрхлээгүй юм. Генрихийг доош бууж ирэхэд Курт

Шмидт вандан дээрээ босон харайж, цол зэргийн ёсыг мартаж орхиод дэслэгч тийш гүйн ирэхэд нь — За Курт ээ! Та одоо миний үйлчлэгч цэрэг болсон гэж Генрих өгүүлэв. Залуу цэргийн царайд баяр баясгалан тодорсон нь Генрихт бас нөлөөлж, цэрэг хувцастай тэр залуухан хүү даавуу малгайгаа алгандаа шингээчих гэсэн юм шиг хүчлэн базалж байгааг хараад ялдамхан инээмсэглэв ... Курт Шмидт, дэслэгчийг нүд салгалгүй ширтэж, нүдэндээ нулимс мэлтэгнүүлэн хацар нь улайгаад — Эрхэм дэслэгч таны ачийг яаж хариулахаа мэдэхгүй байна гэхэд нь — Үүрэгт ажлаа сайн гүйцэтгэж ачийг хариулаарай. Одоо миний хуучин үйлчлэгч цэрэг Фриц Зеллерийг эрж ол. Тэр чамд юу хийхийг зааж, ер нь бүгдийг тайлбарлаж өгнө. Чи хаана суухыгаа штабаас мэдэж аваад штабын өөдөөс харсан «Темпль» зочид буудалд очоорой гэв. Генрихийг зочид буудал тийш явж байтал замын дунд штабын бичээч гүйцэж очоод: — Ноён дэслэгч танд захиа иржээ гэж захидал өгөв. Гольдринг тэр захиаг хайхрамжгүй авч, халаасандаа хийчихээд тасагтаа орсон хойно л Бертгольдоос ирсэн захиа байхыг сая үзлээ.

Бертгольдын бичсэн нь: *«Хүү минь, би чамайг төрсөн хүү шигээ санаад байна. Ажил их байсан учир захиа бичилгүй удлаа. Одоо би штабт байранд нэг хэлтсийн удирдагчаар ажиллаж байна. Гурван хоногийн өмнө надад хошууч генерал (группенфюрер) цол олгосон. Чамайг одоо дэргэдээ татаж авах бололцоогүй байна. Тийм бололцоо гарсан даруйд чамайг татаж авна. Фрау Эльза, чиний дүү Лора хоёр чамтай уулзахыг маш их хүсэж, танай генералаас чөлөө авч өгөхийг надад шаардаж байна. Миний найз эрхэм Эверс намайг бодоод үүнийг ёсоор болгох биз гэж найдаж байна. Татгалзвал нь надад бичээрэй. Ер нь чи захиа бичиж байхад болохсон.*

Вильгельм Бертгольд ёслол»

гэжээ. Генрих захиаг уншиж дуусгаад хурдан зуур хувцсаа тайчиж орондоо оров. Хичнээн их ядарснаа сая л мэдлээ. Шамберид өнгөрүүлсэн шөнө сэтгэл асар их чилсэндээ ч тэр биш. Өнөөдөр ч гэсэн дээ! Санаа амар, хөгжилтэй дүр үзүүлж байх хэрэгтэй байв. Гэтэл Лионы сонинд Дорнод фронтоос ирсэн сурвалжилгаа, гэрэл зураг, мэдээ дүүрэн гарч, гитлерийн дээрэмчдийн том давшилт эхэлсэн тухай бичиж, сонинуудын үгээр бол давшилт зогсолтгүй, саадгүй өрнөж байгаа ажээ. Хэн бүхний мэдэх Геббельсийн хэтрүүлгийг харгалзах хэрэгтэй ч гэсэн энэ мэдээнд үнэний хувь байж таарна. Ингээд гитлерчүүд давшиж байгаа ажээ. Генрих энэ бүхнийг хаяж орхиод улаан цэргийн ерийн шинель өмсөж гартаа автомат барьж тулалдвал яасан дуртай байхт бол! Фронт дээр германчууд ялж байна гэсэн мэдээ уншиж тэр мэдээнд баярлаж байгаа дүр үзүүлж, үнэндээ гар буугаа хуйнаас нь гаргаж ирээд нэг ширээнд суугаа улсаа буудаж орхимоор байтал ялалтын төлөө уух хэрэг болж байна. Гэвч ингэх хэрэгтэй гэж тушаасан билээ. Рольдоо цаашид ч жүжиглэж ... хүлээгээд байх хэрэгтэй. «Хүлээнэ» гэдэг хичнээн аймшигтай үг болохыг ийм хурц мэдэрдэг хүн байхгүй бизээ. Галт тэргэнд суугаад сэтгэл маш их яарч яваа хүнд зам ч уйтгартай. галт тэрэг ч дэндүү удаан явж байх шиг санагдах агаад зорьсон газартаа хурдан хүрэхийн тулд амьдралаасаа энэ замд зарцуулах цагийг хасахаас ч татгалзахгүй билээ. Залуу хархүү болзоонд иртэл бүсгүй нь болзсон цагаасаа хожимдсон байхад сэтгэлтэй болсон тэр залуу элдвийг эргэлзэн ингэж хүлээж зовж байхын оронд амьдралынхаа хэдэн минутыг яасан дуртай

өгөх бол. Хувь заяа дуулгавартай болбол хүний хүсэлд захирагддагсан бол олон хүний нас их л богинохон байхсан. Хүн тэсвэрлэшгүй хүлээхийн зовлонт минут, цаг, өдрөөс ангижирч зорьсондоо түргэн хүрэхийн тулд насаа өөрснөө богиносгох байсан бизээ. Генрих ч гэсэн одоо эх орондоо очихын тулд насныхаа тэн хагасыг дуртайяа өгөх билээ. «Хувь заяа дуулгавартай байдагсан бол» гэнэ шүү! Ямар балай бодол төрөв вэ? Бид хувь заяагаа өөрснөө мэдэх ёстой шүү дээ. Үүний тулд хоосон бясалгаад суулгүй, минут бүрийг хэмнэн тэмцэх хэрэгтэй. Хэрэв шаардагдвал шүдээ зууж байгаад хүлээх хэрэгтэй. Минут бүр осолдон унаж болох ёроолгүй нүхний амсар дээгүүр хэнэггүй алхлах хэрэгтэй. Одоо ч гэсэн тасалгаанд нь хүн орж ирээд юм бүгд дуусаж болох шүү дээ. Хэдий тийм боловч Сен-Ремийн ойролцоо, газар дор ажиллаж байгаа хүмүүст өөрөөс нь хэдэн хувь хэцүү байгаа. Генрих өөрөө болгоомжтой байвал ялалтын саруул сайхан өдрийг үзнэ. Юм бүгд ганц өөрөөс нь, өөрийн зориг самбаа, чадвараас шалтгаална. Гэтэл тэр газар дор хаягдсан, нарны гэгээ үзэх, эрүүл агаар амьсгалах, ертөнцийн сайхныг харах, эх орондоо буцаж элгэн садан, ойр дотныхонтойгоо уулзах ямар ч найдлагагүй орос франц, чех, польш хүмүүс өөрснийгөө аврахын тулд юу хийж чадах билээ? Тэд бас дайсанд ажиллаж, дайсныг шинэ миномет, бүүр их үхэл таригч минометоор зэвсэглэхэд хүрч байна. Миномет бүр нь тэдний өөрсдийн үхлийг ойртуулж байгаа шүү дээ, Газар дор хаягдсан гэр хүн бүхний аймшигт үхлийг ойртуулж байгаа хэрэг. Газар дор завод байдаг гэж Лютц тэр нэгэн удаа гэнэ алдсан нь аз болжээ. Чухам тийм үхлийн лагерь байлгахгүйн төлөө Генрих тэмцэх ёстой. Үгүй, өөрөө ядрах, амрах эрх алга! Генрих сэтгэл алжааж ядарна гэдгийг мэдрэх ёсгүй. Яагаад вэ гэвэл биелүүлсэн даалгавар бүр ялалтын цагийг ойртуулна. Энэ бол өөрийг нь амраад хэвтэж байгаа энэ минутад хүүр хайлах газар шатаж байгаа хүмүүсийн өшөөг авч буй хэрэг. Амрах цаг байхгүй, амрах ч ёсгүй. Генрих орноосоо босон харайж, хувцсаа өмсөж эхэллээ. Шатаар бууж явахдаа генералд амалнаа санаж, зоогийн танхимд оров. — Сайн байна уу, ахай! гэсэнд Тарваль авгай — Аа та хүрээд ирээ юу. Таныг бүр өглөөгүүр ирнэ гэж бодож байсан болохоор зүгээр яваа байгаа даа гаж сэтгэл зовж байлаа. Та суу л даа гэхэд нь — Тарваль авгай танаас хүсэх чухал зүйл байна. Та үүнийг биелүүлж өгвөл үнэн сэтгэлээсээ баярлана гэв. — Таны төлөө чадах л юм байвал хийнэ гэдгийг барон та мэднэ шүү дээ. — Надад арван шил сайн шампан дарс хэрэгтэй. Тэгэхдээ та намайг явахын өмнө дайлдгаас дутуугүй сайн дарс шүү. — Надад өөрт байхгүй ... Гэсэн ч олдох газар бий. Хагас цагийн дараа олж өгье. — Та боож бэлтгээд байгаарай. Би шинэ үйлчлэгч цэргээ явуулна. Тэр хэрэгтэй газар нь аваачиж өгнө. Генрих цааш эргээд явах гэтэл энэ үед хажуугийн хаалга нээгдэж, Моника гүйн орж ирээд — Ээж ээ, та мэдэх үү би ... гэснээ Генрихийг хараад зог тусаж, царай нь улайв. — Сайн байна уу, мадемуазель Моника. Таны бие ямар байна? гэсэнд эх нь охиныхоо өмнөөс — Бие нь сайн. Харин та нарын хичээл урагшгүй байна гэж сэтгэл нь зовоод байгаа гэхэд — Ээж ээ! гэж охин нь зэмэлсэн байдалтай дуугарахад нь — Би үүнээс хойш хичээнгүй сайн сурагч болно. Бяцхан багш маань хичээлд хожигдохгүй ирж байг гэж Лионоос үүнийг авчирсан ... гэж Генрих хэлээд халааснаасаа жижигхэн хайрцаг гаргаж, Моникагийн гарыг бариад бүсгүйн бугуйд жижигхэн цаг зүүж өгөх гэсэнд Моника гараа татан авч: — Яах юм бэ! гэв. — Мадемуазель аа, үүнийг бэлэг гэж битгий бодоорой. Таны надад хичээл заах гэж зарцуулдаг цагийн өчүүхэн хөлс гэж бодоорой. Ер нь та герман офицер

зүгээр нэг талархах сэтгэлээр үнэгүй хичээл заавал хачин хэрэг шүү дээ. — Харин ... гээд бүсгүй дуугүй болов. Генрихийн хэлсэн үг Моникаг илт сандаргажээ. Үнэндээ юу боллоо гэж зав чөлөө цагаа энэ офицергой хичээллэхэд зарцуулж байдаг билээ? Аягүй бол өөрийг нь ихэд хүндэтгэж, баярлуулж байна гэж бодож магад. Гэтэл Моника ямар ч байсан энэ баронтой харилцаагаа нэг эвийг нь олох ёстой шүү дээ ... Эс тэгвэл юу ч олж мэдэж чадахгүй. Одоо яах билээ? ... гэж бүсгүй .бодох зуур эх өөдөө яах вэ гэсэн байдалтай харсанд — Чи баронд талархвал дээргүй юу? гэж Тарваль авгай өгүүлсэнд — Баярлалаа, барон! гэж бүсгүй дуулдах төдий шивэгнэв. — Та завтай бол өнөөдөр яг зургаан цагт хичээлээ эхэлье. — Тэгвэл хоёулаа цагаа шалгаж тааруулья. Харав уу, бараг таван минутын зөрөөтэй байна. Та бид хоёрын хэн нь амьдралдаа яарч, хэн нь хожимдож байгаа юм бол доо? — Би л яарч байгаа байхаа даа. Сая наашаа бууж ирэхийнхээ өмнөхөн цагийн эргэлтийг хурдатгахын тулд насныхаа хагасыг өгмөөр санагдаж байсан юм. — Яагаад тэр билээ? гэж Моника төв байдлаар асуухад нь — Зорьсондоо түргэн хүрэх гэж. — Ямар зорилго вэ? — Мадемуазель танд хэзээ нэг цагт хэлэх ч магадгүй. Тэр цагийг хүлээх хэрэгтэй байна гэж Генрих тоглосон ч юм шиг, үнэнээсээ хэлсэн ч юм шиг хариулаад эх охин хоёрт мэхийн ёслоод гарав. Генрих штабын байшингийн үүдэнд нэг машин, түүний хажууд Эверс, Лютц хоёр зогсож байхыг хараад дэргэд нь очиж: — Ноён генерал аа, танд хошууч генерал Бертгольдоос мэнд уламжлахыг зөвшөөрнө үү гэсэнд — Уухай! Хошууч генерал болчихоо юу?

— Тиймээ. Би саяхан захиа аваад байна. Эрхэм Бертгольд одоо ноён Гиммлерийн штаб байранд ажиллаж байгаа гэж бичсэн байна. — Оо-ёо, чин сэтгэлийн угаас баяр хүргэе гэж Эверс учиртай дуугарчээ. Генерал, Бертгольд биш, барон фон Гольдринг л Гиммлертэй ажиллах их нэр төрийг олсон юм шиг Генрихийн гарыг удтал атгаад — Ахмад Лютц бид хоёр ажлаар явлаа. Тэгэхлээр биднийг үдийн хоолон дээр хүлээсний хэрэггүй гэж хэлээрэй гэж Эверс машинд суусан хойноо өгүүлэв. — Тэгвэл оройн хоол захиалахыг зөвшөөрнө үү, «Темпль» зочид буудлын хоол нь их сайн гэсэнд — Тантай хамт маш дуртайяа оройн хоол идье. Таны азтай баатар гавьяатай буцаж ирснийг тэмдэглэх хэрэгтэй шүү дээ. Ахмад та яах вэ? — Би баронтой хэдэн удаа оройн хоол идсэн. Барон франц хоол гоц сайн мэддэг хүн гэдгийг хэлэх хэрэгтэй байна гэхэд нь — Хоолыг хэдэн цагт захиалах вэ? гэж Генрих асуув. — Бид найман цагт ирнэ гэж генерал хариулав. Лютц Гольдрингт хандан — Эрхэм дэслэгч ээ, төмөр шүүгээнийхээ түлхүүрийг танд үлдээе. Шүүгээний дээд талд нь бичигтэй хавтас байгаа. Та тэр бичгүүдийг үзэж танилцах хэрэггүй. Миний тасалгаанд сууж байгаад уншаарай. Түлхүүр хаяузай. Уншсан бичиг бүрийнхээ дор гарын үсэг зураарай гэхэд нь Генрих ярвайж, — Үнэнээ хэлэхэд бүх бичиг зохиолын дотроос эрхэм ахмад таны унш гээд байгаа тиймэрхүү төрлийн бичигт би хамгийн дургуй хүн шүү гэсэнд генерал инээд алдаад жолоочдоо явахыг тушаав.

Лютцийн хэлсэн хавтас нь «Маш нууц» гэсэн тэмдэгтэй ажээ. Генрих тасалгааг дотроос нь түгжээд хавтсан доторхи бичгийг үзэж эхэллээ. Ихэнх нь сонирхол багатай зүйлс байв. Генрих хурдан гүйлгэн уншиж, бичиг бүрийн эцэст гарын үсгээ үлдээв. Харин нэг баримт түүний анхаарлыг татлаа. Энэ нь танк эсэргүүцэх хориглолтын аргын тухай заавар, түүний зураг байжээ. Үүнд дайсны танкийг устгаж, бэхэлсэн цэгийг дарахад зориулсан «Голиаф» гэдэг одой танкийн тухай зүйл байв. Асар их дэлбэлэх хүчтэй тэр «Голиаф» танкийг радиогоор жолооддог бөгөөд нэн сайн маневрлах чадалтайн дээр 90 километр хүртэл хурдалдаг байна. Өөр танктай мөргөлдөх буюу удаан цагийн бэхлэлт дээр гараад өөрөө дэлбэрч, цохисон тэр саадаа агшин зуур устгадаг байна. Энэ бол шинэ зүйл байлаа. Генрих тэр заавар түүнд хавсаргасан зургийг хэд дахин гэрэл зураг татууллаа. Одоо хавтсыг хамхиж, шүүгээг түгжиж болох боллоо. Гэртээ харимааргүй санагдана. Гадуур жаахан явдаг юм уу? Дараа нь яг зургаан цагт Моникатай хоёул толь бичиг, дэвтэр бариад сууна. Бяцхан багш нь Генрихийг алдаа хийх буюу үгийн өргөлтийг буруу дуудах бүр хөмсөг зангидна. Хичээл дууссаны дараа хоёул хэдэн үг сольж, аягүй бол маргалдана. Тэгээд хоёул жинхэнэ бодлоо бие биеэс нууна. Тэр хоёрын яриа уралдаан тэмцээнтэй адил байх бөгөөд багш, сурагч хоёул жадаа зөрүүлэн бие биеийн өөдөөс харж зогсоод онож хатгаж болох цагийг анан хүлээж байгаа туялзуур жадчингуудтай адил санагдана. Сүүлийн үед Моника арай элдэг болж, тэр ч байтугай нэг л хачин жигтэй хардаг болсон юм. Чухам энэ нь Генрихийн сэтгэлийг хамгаас илүү түгшүүлнэ. Бүсгүй өөрт нь тун аятайхан санагдах болсныг Генрих мэдэж байлаа. Гэтэл бүсгүйг таашаан үзэх эрх байна уу? Генрихийг өөрийн ард түмний дайсан биш, жинхэнэ анд нөхөр нь, францын эрх чөлөөний төлөө тэмцэгч хүн бүхний санаа нэгтэн нь гэж мэдсэн байлаа ч гэсэн энэ бүсгүйтэй харилцаагаа хайр дурлал болтол лавшруулах эрх байхгүй. Моникатай ямар ч гэсэн ханилан сууж

чадахгүй шүү дээ. Тэгвэл ямар найдлага байна вэ? Түр зуур янаглах уу? Үгүй, Генрих хэзээ ч тийм юм хийхгүй. Энэ гайхалтай бүсгүй жинхэнэ жаргал үзэх ёстой. Гэтэл Генрих энэ бүсгүйг өөртэйгөө хамт ёроолгүй гүн нүх рүү татаад оруулчихаж магадгүй гэж бодно ... Үүний хажуугаар Бертгольд Генрихийг охиныхоо болзоот хархүү болгох гэж найдаж байгаа нь илт байна. Генрих одоохондоо Бертгольдын урмыг хугалахгүй л дээ. Тэгвэл Гиммлерийн штабт ажилладаг тийм нөлөө ихтэй хүн лүгээ харилцаагаа муутгана гэсэн үг болно. Хэрхэвч тиймд хүргэж болохгүй. Гиммлерийн өөрийн нь штаб-байрын нэг хэлтсийн даргын араар өөрөө айх юмгүй сууж болно. Эверс өөрт нь сайн хандаж байгаагийн учир тодорхой. Генрих фон Гольдринг бол дээгүүр албан тушаалтай тэр гестапогийн хүний нэрлэсэн хуурай хүү гэдгийг Эверс мэднэ. Тийм дээрээс Генрихийг Лоратай сууна гэж Бертгольдыг аль болохоор горьдоох хэрэгтэй болж байна. Лорагийн ядаж нэг захиаг Моника олж уншвал хөх инээд нь хүрэх байх. Бэртэгчин уярангуй байдал, дээгүүр тушаалтай түшмэлийн охины омог дээрэнгүй зан, тэнэгшээр байдалтай нийлсэн нь мэдэгдэнэ. Ийм хүүхэнд юм бүхэн бүрэн байна. Харин гоо үзэсгэлэнт, хурц ухаант Моника зоогийн танхимд согтуу герман офицеруудад үйлчлэх хэрэгтэй болж байна. Моника шиг зан чанартай хүнд энэ амар уу?! Уг нь Моника тэднийг өөрөөсөө жаахан айдаг болгож чадсан байна. Гэвч бүсгүй ганцхан болгоомжгүй алхам хийж орхивол түүний халдашгүй гэдэгт итгэл гуйвж. офицерууд хэл амаа билүүдэж, гараа зоргонд нь тавих болно ... Бүсгүйн өөрт нь хэлний хичээл заадгийг хэнд ч мэдэгдэхгүй, ер нь түүний нэрийг өөртэйгөө холбоогүй байлгах хэрэгтэй юм. Генрих хэрэг төвөгт орвол бүсгүйг заавал Гестапод дуудаж аваачина. Тэгээд энэ бүх хэрэг юу болж дуусахыг хэн мэдэх билээ. Моника Генрихийн хэрэг явдалд холбогдолгүйгээ баталж чадах биз. Гэтэл партизануудтай холбоотой байвал яана? Моникаг партизануудтай холбоотой гэж Генрих бараг эргэлзэхгүй байлаа. Моника шиг ийм омог бардам, бие даасан, ёстой эх оронч бүсгүй ард түмнийхээ дайсантай хийж байгаа тэмцлээс хөндий байж чадахгүй. Энэ лав тийм гэж Генрих бүр бат итгэж байжээ. Үүнийг яаж мэдэж авах вэ? Бяцхан багш нь үргэлж биеэ манаж, өөрөө ярихаасаа асууж лавлах нь илүүтэй байдаг ... Уг нь Моникаар дамжуулаад орон нутгийн партизаны хөдөлгөөний удирдагчидтай холбоо тогтоовол юутай сайн билээ. Генрих өөрөө тэдэнд, тэд өөрт нь маш их хэрэг болохсон. Ингээд энэ бүсгүйтэй цаашид ч гэсэн зүгээр нэг үерхэж нөхөрлөхөөс хэтрэхгүй байх хэрэгтэй юм байна. Зүрхээ дарж, жигд тайван байх хэрэгтэй. Хажууд нь гоо үзэсгэлэнтэй, сэтгэл татсан сайхан бүсгүй байж байхад хорин хоёр настай залуу тайван байна гэдэг тун бэрх. Гэсэн ч тийм байх нь хэн хэндээ илүү дээр ажээ. Генрих ингэж шийдээд дотор нь уужрах шиг болж, хичээлийн үед урьдынхаас илүү жигд тайван төвшин байжээ. Үүнийг нь Моника баахан гайхаж, тэр ч байтугай сэтгэлийг нь хөндсөн бололтой. Моника бас албархаг ёсорхуу байдалтай байлаа. Ингээд тэр хоёрын тэсэж ядан хүлээж байсан хичээл сонирхолгүй, уйтгартай болж өнгөрчээ. Оройн яг найман цагт «Темпель» зочид буудлын тохилог нэг тасалгаанд генерал Эверс, дивизийн штабын дарга, дуу цөөтэй зожиг хурандаа Кунст, ахмад Лютц, Гольдринг дөрөв оройн хоол идэхээр цугларлаа. Эверс ширээний засал, зууш, дарсыг хараад сэтгэл дүүрэн байгаа бололтой. Генрихийн мөрөн дээр гараа тавьж: — Барон та ёстой онцгой даалгавар гүйцэтгэх офицер юм. Даргынхаа юунд дуртайг хүртэл тааж мэддэг байна гэлээ. Тарваль авгай өнөөдөр үнэхээр гараа гаргажээ. Янз янзын хоол

ээлж дараагаар ирж, хоол бүрд онцгой дарс барьж байлаа. Элэг өвчтэй гэж үргэлж үглэж байдаг Эверс сайхан хоолонд их дуртай. дарсны чанарыг муугүй мэддэг хүн юмсанж. Тарваль авгайн хоолны чанар, шилж авчирсан дарсыг генерал их үнэлэв. Кунст, Лютц хоёр ерөөс хоолонд муугүй улс бөгөөд одоо дөрвөн хүний дайтай идэж ууж, Генрих өөрөө тэдний өмнөх хундагыг хоосон байлгахгүйг хичээнэ. Тарваль авгай амтганд жимс, шарз, нимгэхэн зүссэн бяслаг тавьжээ. Навчин янжуур аль хэдийн авчирч ширээн дээр тавьсан байлаа.

Анхны хундага шарзыг ууцгаасны дараа яриа хөөрөө дэлгэцгээлээ. Дуу цөөтэй хурандаа Кунстхүртэл сүүлдээ ам ангайж, хэзээний зангаар аль амандаа орсныг хамаагүй ярилаа. Түүний хэлсэн зүйл нь нийтийн наргианд огт таарахгүй үг байв. Кунстийн ярьсан нь: — Эрхэм генерал та дуулсан уу? Өнөө шөнө манай дивизийн хэсэг дээр Сен-Жюльен, Лантерно хоёр суурингийн хооронд ахмад Вейснер, дэслэгч Рейхер гэдэг СС-ийн хоёр офицер алга болчихсон. Хоолны өмнө таны сэтгэлийг үймүүлэхгүй гээд энэ тухай танд илтгээгүй юм гэж хөлчүүрхэн инээмсэглэхэд нь: — Алга болчихсон гэдэг чинь юу гэсэн үг вэ? гэж генерал гайхан асуусанд — Тэд Лантерно тосгоноос шөнө гараад тогтоосон цагт эрхэм Миллерийн хүлээж байгаа Сен-Жюльенд очих ёстой байсан юм. Тэдний гарсныг Мюллерт мэдэгдсэн байна. Тэднийг зохих цагтаа ирэхгүй болохоор нь Миллер зовоод Лантерно тосгон руу утастдсанд офицерууд тэндээс аль хэдийн машинаар гарсан гэж хариулжээ. Миллер бүр их сэтгэл түгшээд тэдний өөдөөс хэдэн мотоцикль явуулсанд тэдэнтэй дайралдах нь битгий хэл, машиныг нь ч олсонгүй. Тэгээд манай арван нэгдүгээр хэсэг дээр түгшүүр зарласан байна. Офицеруудын эрэлд суман цэрэг гаргаж, бүр өглөө болсон хойно замаас хол, голын дэргэд Вайснер, Вейхер хоёрын сууж явсан машиныг онхолдуулсан байхыг олжээ. Тэд өөрснөө одоо болтол олдоогүй байгаа. Эрэл үргэлжилж байна. Үүнд зориулж би дахиад нэг суман цэрэг гаргасан гэсэнд — Чөтгөр алгад! гэж Эверс хараагаад, — Удахгүй бид шөнө гудамжинд гарч чадахаа байх нь шив. Эрэлд илүү олон хүн гаргах хэрэгтэй. Буруутай этгээдүүдийг ямар ч байсан ол. Олсон цагтаа бусдад сануулга болохуйц сайн цээрлүүлэн шийтгэ гэлээ. Кунстийн ярьсан зүйл Гольдрингийн зочдын сэтгэлийг үймүүлэв. Эверс цагаа харж, — Ноёд оо! Би явж амрах цаг боллоо гэж хэлээд суудлаасаа босож, оройн хоолны өөртөө оногдох хувийн үнийг төлөх гэж түрийвчээ гаргахад нь Генрих түүнийг зогсоож: — Хоолны үнийг төлчихсөн гэсэнд генерал түрийвчээ дуртайяа далд хийгээд — Аа бүүр тэгсэн үү. Тэгвэл баронд дахин талархлаа илэрхийлье. Бүгд тун аятайхан боллоо гээд штабын даргад хандаж. — Кунст ээ! Барон фон Гольдринг дэслэгчийн погон нилээд удаан зүүж яваа юм шиг санагдахгүй байна уу? Баронд ахлах дэслэгчийн погон илүү зохих бус уу? гэсэнд — Таны хэлснийг бүрэн зөвшөөрч байна, эрхэм генерал аа! гэж хурандаа баталсанд — Тэгвэл маргааш зохих бичиг баримтыг бэлтгээрэй гэж генерал өгүүлээд Генрих тийш эргэж, — Та хэзээ амралтаар явах вэ? гэж асуухад нь — Алга болсон, яагүй бол алагдсан офицеруудыг эрж олоход тусалчихаад явна гэхэд нь — Тун магтууштай үг байна. Зовлонд учирсан нөхдөө орхихгүй байх нь офицер хүний үүрэг. Герман офицерынх шүү гэж Эверс онцлон хэллээ. Тун учир битүүлэг нөхцөл байдалд алга болсон гестапогийн офицеруудыг гурван өдөр дараалан эрэв. Эрэлд Генрих ч бас оролцлоо. Бертольддын албан тушаал

түргэн ахиж байгааг генерал Эверс мэдээд онцгой даалгавар гүйцэтгэх офицертоо улам анхааралтай, улам талтай хандах болов. Генералын тушаалаар Гольдрингийн хувийн мэдэлд шинэхэн «Опель-капитан» машин гаргаж өгчээ. Энэ нь Генрихийн хүлээсэн үүргээ биелүүлэх явдлыг ихээхэн хөнгөвчилнө. Одоо үйлчлэгч цэргийн үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээгээр жолоочийн үүргийг хавсран гүйцэтгэх болсон Курттэй хоёул Генрих Лантерно, Сен-Жюльен хоёр тосгоны хоорондох замын метр бүрийг шахам шинжин үзсэн боловч алга болсон хүмүүсийн ямар ч ул мөр олдсонгүй. Миллер ч амжилт олсон гэж гайхуулах юм байсангүй. Дээд дарга нар нь эрлийн явцын тухай өдөр бүр лавлах удаа бүр Миллер: — Шинэ зүйл алга гэж хариулахад хүрч байлаа. Баронд тун урагштай, хутган үймүүлэгч этгээдэд урагшгүй болж дууссан нөгөөх шалгалтаас хойш Миллер Гольдрингт хязгааргүй итгэх болжээ. Үүнд нь хошууч генерал Бертгольд Миллерийн шууд дарга болсон явдал хамгийн их нөлөөлж тус болсон байна. Гольдринг хуурай эцэгтээ Миллерт өчүүхэн төдий дургүйцсэн байдал илэрхийлэн бичвэл хошууч Францад суухын оронд Дорнод фронтод очих хэрэгтэй болж мэднэ. Өөрийн гавьяа зүтгэлээр сайрхаж, ая нь таарвал л 1933 оны фашист үймээнд оролцсон. Гитлер өөртэй нь гар барьсныг ярих дуртай гестапогийн хуучин офицерын санаанд тийм хэтийн төлөв тааламжгүй санагдана.

Ийм учраас Миллер сүүлчийн хоёр өдөр Гольдрингийн машинаас гарсангүй, өчүүхэн л бололцоо гарвал дэслэгчийн авьяас чадварыг хичнээн өндөр үнэлж байгаагаа мэдүүлэхийг хичээж явлаа. Өнөөдөр Миллер, Гольдринг хоёр өдрийн хоёр цагаас хойш буцаж ирэв. Тэд нэгэнт үдийн хоол идсэн учир гуанзанд очих хэрэг байсангүй. Хоолны цагаас хожимдсондоо ч харамссангүй. Ерөөс хоол идэх дургүй байжээ. Явдалдаа ядарч, аагим халуун наранд зүдэрсэн тэр хоёр зүгээр зуны зуушийн газар орж, аяга хүйтэн сект11 уухаар шийджээ. Сэрүүн ундаан ч Миллерийн сэтгэлийг сэргээсэнгүй, дотор нь шатсаар байлаа. Түүнийг одоо харвал мөр аллаж орхиод хилэгнэн уурлаж байгаа эргүүлийн нохойтой адилхан харагдана. — Барон та бид хоёр ингээд юу ч олохгүй гэж үү? Өнөөдөр би утасны харилцуур авахаасаа ч ичиж байна. Би юугаа хэлдэг билээ гэж гомдол тавихад нь — Хоёр хүн ул мөргүй алга болох ёсгүй, бага ч гэсэн ул мөр заавал байх ёстой. Нэгэнт мөр байгаахойно бид олно доо. Халуун жаахан намдтал амарч байгаад дахин явна. Энэ удаа азын тэнгэр наашаа харж магадгүй гэж Генрих тайвшруулсанд — Горьдож л сууя гэж Миллер хэлжээ. Миллер хамт яваа хүнтэйгээ салах ёс гүйцэтгэж, сүүлд уулзах газраа болзож тогтлоо. Генрих асрын дорхи ширээнд суусаар хоцров. Энэ үед гудамжаар явах хүн цөөн, бүгд сүүдэр бараадсан тул Моникагийн танил дүрс Генрихийн нүдэнд тэр даруй туслаа. Бүсгүй гудамжны нөгөө талаар гучаад насны өндөр туранхай франц хүнтэй ярилцан яваа харагдана. Тэр хүн Моникаг сугадаад их хөгжилтэй юм ярьж яваа бололтой. Франц хүн унжуу хамраа цаг үргэлж үрчилзүүлж, үе үе тас тас хөхрөн бүсгүйн өөдөөс харна. Атаархах сэтгэл Генрихийн зүрхийг хөндлөө. Генрих Моника, хөгжилтэй франц хоёрыг харахгүй гэж нүүр буруултал хаалганаас гурав дахь ширээн дээр хажуулдасхийн суусан хижээл насны франц хүнтэй харц тулгарав. Тэр хүн бүдэг өнгөтэй хар шил шиг нүдээ Генрихээс салгалгүй ширтэж жимийсэн уруулын нь булан таталдана. Тэр франц хүний сууж байгаа ширээний дэргэд хоол зөөгч эмэгтэй дөхөж очиход тэр хүн мөнгөө төлөх гэж

түр зуур өөр тийш харснаа дахиад л Генрихийг нүд салгалгүй ширтээд байлаа. Генрих тэр хүний авир араншин, царайн байдлыг сонирхоод бас хэдэнтаа анхааралтай харав. Цаад хүн өөрийгөө герман офицерын ажигласныг лавтай мэдээд хүн ажиглаж байна уу, үгүй юу гэж лавласан маягтай түргэн зуур эргэж хараад халааснаасаа нэг дугтуй гаргаж ширээн дээр тавиад дээрээс нь хуруугаараа тогшиж, тэр дугтуйг герман офицерт зориулан үлдээж байгаага мэдэгдээд. Франц хүн дахин нэг эргэж харчихаад гарч явлаа. «Дахиад хутган үймүүлж байна» гэсэн бодол Генрихийн толгойд зэрсхийлээ. Генрих мөнгөө ширээн дээр тавьж орхиод бас суудлаасаа босож, нөгөө франц хүний сууж байсан ширээний дэргэдүүр өнгөрөхдөө дугтуйтай бичгийг хүнд мэдэгдэлгүй авч, мундирийнхээ халаасанд хийлээ. Ядаргаа нь даруй арилав. Генрихийн сэтгэл дахин хөвчилж, тархи нь хурдан бөгөөд туйлын оновчтой саруулхан ажиллах болов. Генрих хоёр минутын дараа өрөөндөө орж ирлээ. Үүдний өрөөнд суугаа Куртэд хүн оруулахгүй байхыг тушаагаад үүдээ сайн хааж, нөгөө дугтуйг гаргаж үзвэл ямар ч хаяг, бичиг тэмдэггүй, цав цагаан дугтуй байлаа. Генрих дугтуйг гартаа эргүүлж тойруулан үзээд захыг нь болгоомжтой огтолсонд дөрөв нугалсан жижигхэн бичиг шал дээр уналаа. Генрих тэр бичгийг уншиж үзээд хэмжээлшгүй их гайхаж, сэтгэл нь догдолжээ.

Захиаг муухан герман хэлээр бичсэн байх боловч бараг дармал бичгийн хэлбэртэй тодхон бичжээ. Үл мэдэгдэх хүний бичсэн нь: *«Би франц хүн боловч германчууд та бүхэнд хамаг сэтгэлийн угаас үнэнч байдаг. Ийм учраас нэгэн зүйлд та нарт туслахыг өөрийн үүрэг гэж үзэж байна. Би энэ захиаг чухам хэнд өгөхөө мэдэхгүй байгаа учир хэнд ч хандан бичээгүй юм. Би өөрөө штабт очих арга алга. Намайг германчуудад талтай байдаг гэж орон нутгийн хүмүүс ажиг сээжиг авсан учир та нарт тусалж байна гэж мэдвэл макиуд ална. Энэ захиаг аятай учрал тохиолдоход герман офицерт өгөхөөр бичлээ. Авсан хүн зохих газар нь хүргэж өгөх буйзаа. Та нар макиудад баривчлагдсан хоёр офицерыг хэдэн өдөр эрж байгааг би мэднэ. Та нар тэднийг олоогүй, хэрэв би туслахгүй бол олох ч үгүй. Хоёр офицерыг алж, хүүрийг нь та нарын машиныг нь олсон газраас зүүн тийш байгаа өнчин царсны дэргэд булсан юм. Тэднийг алахад дөрвөн маки оролцсон. Түүний хоёрыг нь би мэднэ. Энэ нь Понтемафре тосгоны Жорж Марот, Пьер Гортран хоёр болно. Нөгөө хоёрыг нь би нэр мэдэхгүй боловч зүс үзвэл танина. Хэрэв та нар нэр дурдсан хоёрын баривчилбал миний танихгүй нөгөө хоёрын нь тухай мэдэж авч чадна гэж бодож байна. Та нарт миний тусламж хэрэгтэй болсон цаг тухай бүр хүчин зүтгэхэд бэлхэн байна. Харин намайг хэзээ ч битгий дуудаарай. Энэ бол надад үхэл гэсэн үг. Өөр ямар нэг арга олох буйзаа. Жишээ нь намайг баривчилж аваад ярилцсаны дараа суллан тавихад болох юм. Надад эрхбиш та нарын сонирхох өөр зарим мэдээ бий. Хүчин зүтгэсний шан харамжийг хангалттай өгөх буйзаа гэж найдаж байна.*

Миний хаяг: Потерн тосгон, Жюльен Левек»

гэжээ. Захидал дээр сар, өдөр байсангүй. Генрих эрэгцүүлэн бодлоо. Энэ чухам юу вэ? Гестапод сайн дураар туслагчийн захиа юу, эсвэл хутган үймүүлсэн бичиг үү? Хэрэв хутган үймүүлсэн бичиг бол Шамберид болсноос бүүр эв дүйгүй хэрэг болж дээ. Захидлыг очиж очиж цаг ямагт хөндлөнгийн хүн харчихаж болох зуушийн газар гардуулдаг нь юу вэ? Анхны шалгалтын үед Генрих сорилтыг давж гараагүйсэн бил үү?

Үгүй дээ, энэ ерийн нэг хов байж таарна. Харин энэ өөдгүй амьтан Генрихийг Миллертэй хамт хоёулаа сууж байхад мэдэгдэхгүй хаячихаад явахгүй яасан юм бол? Тэгвэл энэ этгээд захиагаа германы командлалд заавал илэрхий болно гэж багтай итгэж болохсон. Энэ ер нь хутган үймүүлсэн зүйл байвал яах вэ? Энэ захиаг нуучихлаа гэж бодъё ... Тэгвэл Генрихийг санаатайгаар нуун дарагдуулсан хэмээн ял хэлэлцэж, дахиад л шалгаж, дахиад л ухаж төнхөж эхэлнэ. Тэгээд барон фон Гольдринг нэрийн дор чухам хэн нуугдаж байгааг олоод мэдчихэж ч магадгүй ... Үгүй дээ, ийм осолтой ажил хийж болохгүй. Нэг арга олох хэрэгтэй. Ямар арга байна вэ? Захиаг Эверст өгөх үү? Генерал энэ захиаг Миллерт шилжүүлэх нь гарцаагүй. Энэ бол наад зах нь Францын хоёр эх орончийг буудан алахад хүргэнэ гэсэн хэрэг. Партизануудад хэл өгөх үү? Яаж тэгэх вэ? Үгүй, бүгдийг өөр нэг аргаар хийх хэрэгтэй. Энэ захиаг генералд өгөх ёстой. Харин ... гэж бодох зуур Генрих үйлчлэгч цэргээ дуудаж, — Курт ээ! Одоо мадемуазель Моникаг дуудаад намайг завтай байна гэж хэлнэ үү. Түүнийг ирэхээр чи өөрөө штабт очиж жижүүрээс захиа байна уу, үгүй юу, асуугаарай. Тэндээс надад утасдаарай. Ойлгов уу? гэсэнд — Мэдлээ. Ёсоор биелүүлье гээд Курт гарч одов.

Генрих захиаг дахин нэг уншиж. «офицеруудыг алахад дөрвөн партизан оролцсон» гэсэн үгс нь нугалсан цаасны дээд талд таарч уншихад амар байхаар тааруулан болгоомжтой нугалав. Одоо энэ нугалсан бичгээ ширээн дээр, Моникагийн суудаг сандлын урд талд тавих үлдлээ. Моника тасалгаанд орж ирээд дургүйцэн ярвайж, — Пөөх, яасан их тамхи татаа вэ! гэж хэлэхэд нь — Та тамхи татдаг хүнд дургүй юу? гэсэнд — Дэндүү их татдаг хүнд дургүй гэж Моника хэлээд цонхны дэргэд очиж цонх онгойлголоо. — Тэр хүн чинь хир тааруу татдаг юм уу? гэж Генрих асуусанд — Ямар хүн? гэхэд нь — Тантай өнөөдөр гудамжаар хамт явж байсан хүн. Өндөр туранхай, бас их хөгжилтэй хүн шиг билээ гэсэнд — Аа, та намайг ... гэснээ Моника уруулаа хазаж дуугүй болов. — Та тэр хүний нэрийг хэлэхээс айв уу? — Нэрийг нь мэдээд танд хэрэг юу байх вэ дээ. Тэр чинь надад хамаагүй, миний жирийн нэг сайн нөхөр ... — Та намайг хэзээ нэг цагт сайн нөхөдтэйгөө танилцуулах уу? гэж Генрих асуугаад бүсгүй их л тэнсэн харсанд — Та танилцуулж болох хүн гэдгээ баталбал нь танилцуулна гэж бүсгүй их учиртай үг хэлжээ. — За тэгвэл би өнөөдрийн дотор тийм бололцоо олохыг хичээнэ. Хэлэлцэж тохирох шив дээ? Гэж Генрих бас үг бүрээ онцлон хэлсэнд — Тохирлоо. Одоо хичээлдээ орьё гэж Моника хэлээд сандалдаа суув. Генрих орны дэргэдэх жижиг шүүгээ дээр байгаа янжуураа авах дүрэм үзүүлэн тасалгааны гүн тийш очих зуур нүдний булангаар бүсгүйг ажиглаад байлаа. Бүсгүйн хамаг бие хөвчирч, толгойгоо ялимгүй урагш тонгойн хөдөлгөөнгүй болсныг хараад захидлын нугалсан өгүүлбэрийг уншжээ гэж мэдэв. «Курт утасдахгүй яасан удна вэ!» гэж Генрих бодтол яг энэ үед утас дуугарсанд Моника цочив. Генрих харилцуурыг авч: — Сонсож байна ... За, за ... Одоо очлоо гээд утасны харилцуурыг тавьж, Моникад хандан: — Мадемуазель аа, өршөөгөөрэй, Би ердөө таван минутын дотор штабт очоод ирэх хэрэг гарлаа. Ирээд таныг эрж байхгүйн тулд намайг энд хүлээж байна уу. За юу? гэсэнд — За. Та битгий удаарай гэж бүсгүй дуртайяа зөвшөөрчээ. Генрих тасалгаанаас гарахдаа бүсгүйн царай зэвхий цагаан болж, сэтгэл нь их хөөрснийг ажиглав. Генрих, Курт хоёр таван минутын дараа биш, арван минутын дараа хамт эргэж ирлээ. Тэднийг ирэхэд Моника тасалгаанд

байсангүй. Толь бичиг дээр товчхон зурвас орхисныг үзвэл *«Таван минут өнгөрсөн учир би явлаа. Бүсгүй хүнийг хүлээлгэх нь эвгүй хэрэг. Ялангуяа түүнийг хөгжилтэй нөхөд нь хүлээж байна! Би таныг хэзээ нэг цагт тэдэнтэй танилцуулж магадгүй»* гэжээ. Генрих тэр зурвасыг жижигхэн жижигхэн тастаж хаялаа. — Курт ээ, эзэгтэйгээс халуун индүү гуйгаад ир. Мадемуазельд намайг хожигдсондоо уучлал гуйж, одоо хүлээж байна гэж хэл гэж үйлчлэгч цэрэгтээ тушаав. Курт дорхноо буцаж ирэхдээ индүү авчирсан боловч Моникаг олсонгүй. Тарваль авгай охины нь толгой тамхины утаанд өвдөөд салхинд гарахаар явсан гэж хэлжээ. Моника захиаг уншсан нь илт байлаа. Левекийн захиаг Генрихийн үлдээснээс огт өөр янзаар, бас хуучин байснаас нь өөр газар тавьжээ. Ер нь Моникагийн орхисон зурвасыг үзсэн ч учир тодорхой байна. Моника энэ зурвасыг хичнээн ухаалаг бичээ вэ. Өөлөх юм байхгүйн дээр үг бүр нь их учиртай болжээ. Анд нөхөр бол ойлгоно, дайсан этгээд бол учрыг олохгүй ... Бас гарын үсэг ч тавьсангүй. Нууц ажиллаж сурсан хүний шинж байна. Эхийн нь хэлснээр бол толгой нь өвдөөд салхинд гарахаар явсан гэж байгаа. Одоо ч макиудад хэл хүрэх нь тодорхой боллоо. Энэ захиаг Эверстэд өгөхөд болох байна. Генрих үрчийсэн цаасыг индүүдэж эвхэхэд энэ үеэр цэвэрлэсэн мундир шүүгээнд өлгөх гэж орж ирсэн Курт гомдож: — Эрхэм дэслэгч ээ, наадхыг чинь би хийчихэж чадахгүй юм гэж үү? гэхэд нь — Хүнд итгэж болохгүй зүйл бас байдаг юм шүү гэсэнд — Та надад юу ч байсан итгэж болно. Яагаад вэ гэвэл танд над шиг үнэнч хүн байхгүй. Миний ээж л илүү байж магадгүй юм биз ... гэхэд нь — Танай ээж энд ямар хамаатай юм бэ, Курт ээ? гэсэнд — Ээж надад захиа бичсэн байна ... Юу гэж бичсэнийг нь сонсоно уу гээд Курт халааснаасаа захиа гаргаж, сэтгэл нь хөдөлсөндөө түгдэрсхийн уншсан нь: *«Хүү минь, би чиний тэр дэслэгчийн төлөө орой болгон залбирч байна. Тэр дэслэгч, чамайг зайлшгүй үхлээс аварч, чамтай хамт намайг аварчээ. Хүү минь, надад ганц чи л үлдсэн шүү дээ. Тэр хүндээ үнэнч зүтгэ. Ээж чинь чамд тушааж байна. Ачийг ачаар хариулах хэрэгтэй. Эс тэгвэл хайрт хүү минь чамайг ч, намайг ч Эзэн тэнгэр цээрлүүлнэ ...»* гэжээ. — Курт ээ, ээж чинь чамд их хайртай, сайн хүн байна. Ээждээ намайг сэтгэлийн угаас баяр хүргэж байгааг бичээд би ээжийнхээ тушаалыг сайн биелүүлж байна гэж бичээрэй. — Таны төлөө гал, усанд ороход бэлхэн байна гэдгээ ээжид бичсэн л дээ. Үнэндээ би өчүүхэн ч эргэлзэхгүй тэгнэ. — Чи миний тушаалаар галд орох хэрэг гарахгүй. Харин чамд зөвхөн чи бид хоёроос өөр хүн мэдэх ёсгүй зарим нэг зүйл даалгаж мэднэ. — Одоо ч тушаасан болно. — Одоогоор тийм хэрэгцээ алга. Хэрэгцээ гарахгүй ч байж магад. Одоо миний хувцсыг аваад аль. Генрих, генерал дээр очиж, Жюльен Левекийн захиаг аваачиж өгөхөөр хувцсаа өмссөнөө цагаа хараад сандалд сууж ном барив. «Дөнгөж хорин минут өнгөрөөд байна. Арай багадна. Моникагийн буцаж ирэхийг хүлээх хэрэгтэй юм» хэмээн бодлоо. Миллер баярласандаа хөл нь газар хүрэхгүй байв. Энэ бас аз аа! Даргадаа маргааш өглөөнөөс хэтрэхгүй, алагдсан офицеруудын хүүрийг олж, алсан этгээдүүдийг шийтгэсэн гэдэг мэдээ явуулна. Миллер ойр хавь даяар шагшин ярилцтал шийтгэж чадна чиг. Илтгэлдээ дэслэгч Гольдрингийн идэвх хичээлийг бас тэмдэглэнэ. Миллер өөрөө бароны намтрын тодорхой зүйлсийг мэдэхгүй юм шиг, Бертгольдтой ямар хамаатайг нь мэдэхгүй юм шиг дүрэм үзүүлэх хэрэгтэй. Тэгвэл дээр. Дарга нь Миллерийн авъяастай залуу офицеруудын тухай үнэн бодитой мэдээлдэг юм байна гэж бодог. Ая нь таарвал энэ тухай Гольдрингт бичих юм уу. хэлэх болно. Энэ нь бид хоёрын найрсаг байдлыг улам

багатгана гэж бодлоо.

Миллер Гольдрингтой үерхэж нөхөрлөвөл алдар нэр олж албан тушаал ахих зам гэж үзжээ. Тэр зам бол ганцаар яваад юм уу, мөлхөөд ч гэсэн эцсийн зорилгод хүрчихэж болмоор тийм бартаагүй зам биш билээ. Миллерт уг нь нэгэн цагт фашист самуунд оролцож явсан гавъяа бий боловч үүнийг одоо нэгэнт мартаж эхэлжээ. Миллер хошуучийнхаа погоныг солих цаг хэдийн болсон, ажлын хэмжээг ч нэмэгдүүлэх болсон баймаар. Дивизийн энэ хэсэг чухал гэдгийг үгүйсгэж болохгүй боловч Сен-Реми шиг ийм жижигхэн хотод шигдэж байхын оронд Парист юм уу, түүний ойролцоо сууж байвал аштай юу. Миллер өөрийн илтгэлийг даргадаа ямар сэтгэгдэл төрүүлэхийг сэтгэлчлэн бодов. Илтгэлээ яаж бичихийг дотроо хэдийн бодож боловсруулжээ, Үүнд үг цөөтэй боловч эрлийн үед хичнээн их бэрхшээл давах хэрэгтэй болсныг мэдэгдэхээр бичнэ. Төгсгөлд нь гэмт этгээдүүдийн гэр бүлийг яах хэрэгтэй вэ гэж асуух юм шүү. Тэднийг яах ёстойг Миллер өөрөө сайн мэднэ л дээ. Гэвч ажил нэгэнт бүтсэн хойно гэнэхэн дүрэм үзүүлж, дээд дарга нараас асуухад болно. Дарга нар нь өөрсдийгөө макийн эсрэг ажиллагаанд оролцож байгаа юм шиг санаж энэ тухай Гиммлерт өөрт нь мэдээлэхдээ дурдаг. Үгүй, энэ овжин залуу бароныг дивизийн штабт явуулсныг бодоход хувь заяа үнэндээ Миллерт таалалтай байгаа юм байна. Эрэл хийх, тэр Левекийг хуурамчаар баривчлахад Гольдрингийг оролцуулах нь тун зүйтэй, Генерал Эверс дээр зөвлөлгөөн хийхэд Миллер өөрөө хичнээн нарийн зальтай дипломат аргатай байснаа санаад сэтгэл нь хөөрч алгаа хавирлаа. Наад зах нь ингэж хэлснийг бодоод үз. «Гарцаагүй улайран эсэргүүцэх гэмт этгээдүүдийг баривчлахад дэслэгч Гольдрингийг оролцуулж аминд нь хал бал болгож болохгүй гэж бодож байна. Түүнд Жюльен Левекийг баривчлах ажлыг даалгавал дээр. Энэ хуурамчхан баривчлалт огт аюулгүй юм. Түүнээс гадна дэслэгч тэр Левекийн зүсийг таних учир энэ нь ажлыг хөнгөвчилж, ямар нэг алдаа эндэгдэл гарахаас биднийг ангижруулна. Понтемафрад хийх ажиллагааг би өөрөө биеэр хариуцна» гэж Миллер хэлсэн билээ. Ухаалаг зальжин үг биш гэх үү? Миллерийн саналыг Эверс, штабын дарга хоёр дэмжсэн. Тэгэхлээр энэ ажиллагааны гол баатар нь Миллер өөрөө болж, Гольдринг завсардаж үлдэнэ. Ингэхэд дэслэгч буцаж ирэх болж байгаа бололтой билээ. Тэр долоон цагт гарсан, одоо арван цаг болж байна. Жаран километр газар явах ёстой ... Нээрээ аль хэдийн эргэж ирэх болсон байна. Үгүй бол ... Гольдрингт нөгөө хоёр офицер шиг гай тотгор учирсан байж болзошгүй гэж Миллер бодохлоо нуруу руу нь хүйт оргиод ирлээ. Тэгсэн байвал алба тушаал ахидаг ч өнгөрч францад сууж байдаг ч өнгөрөх нь тэр. Бертгольд ийм явдлыг уучилж өнгөрүүлэхгүй. Наад зах нь Орос руу явуулах болно доо. Миллер суудлаасаа босон харайж, хонхны даруулгыг хар чадлаараа дарлаа. Туслахыгаа тасалгаанд орж ирэхэд нь: — Дэслэгч Гольдрингийн урьдаас мотоцикльчдын салаа нэн даруй угтуулан явуул гэж тушаав. Мотоцикльчид мотоциклоо асааж завдаагүй байтал СС-ийн албаны байрласан байшингийн дэргэд Гольдрингийн «Опель-капитан» машин хүрч ирэв. Миллер түүнийг цонхоор хараад ширээнийхээ ард шалавхан очиж. хийх ажиллагааны газрын зураг дээрээс тонгойн суухдаа: — «Намайг цаг дэмий өнгөрүүлээгүй байна гэдгийг үзэг!» гэж болсон нь тэр байжээ. Тэр ч байтугай хаалга тогшиход даруй хариу дуугарсангүй. Хаалга дахин тогшиход л сая: — Орогтун! гэж хашгирлаа. Цэх нуруугай

Гольдрингийг орж ирэхэд Миллер суудлаасаа өндийж, — Сайн явж ирэв үү, барон! гэсэнд — Тийм ч сайн биш гэж Гольдринг хөндийхөн дуугараад Миллерт нэг бичиг сарвайхад нь — Энэ чинь юу вэ? гэж Миллер сандран асуужээ. Чухам юу болохын Миллер дөнгөж харангуутаа мэдсэн байна. Миллер ийм бичиг нэг биш удаа гартаа барьж үзсэн агаад агуулгыг нь сайн мэддэг байлаа. — «Францын ард түмнээс урван гэрслэгч этгээдэд үхэл ... наана чинь тэгж бичсэн байгаа биз дээ? гэж Гольдринг алжаангүй өгүүлээд зөөлөн сандалд суухад — Тэгээд Жюльен Левек ... гэхэд нь — Биднийг очихоос нэг цагийн өмнө цээж рүү нь хоёр буудаж алсан байна гэж Гольдринг хэлэв. — Алсан этгээдийг барьсан уу? — Түүнийг хэн ч хараагүй. — Лебекийг мөрдөн ажиглаж байсан бололтой гээд Миллер духан дээгүүрээ шүүдэр шиг бурзайсан хүйтэн хөлсөө арчив. — Левек өөрөө ч нутгийн хүмүүс өөрт нь эелдэг биш ханддаг, ажиг сэжиг авсан гэх байрын юм захиандаа бичсэн байсан шүү дээ. Түүний алхах гишгэх бүрийг ажиглаж байсан байж болох юм гэж Генрих хайхрамжгүй дуугарсанд — Тэгвэл хамаг хэрэг нурж унах магад. Лебекийн ховлосныг тааварласан улс макиудад ч хэл хүргэчихэж болно гээд Миллерийн царай зэвхийрэн шүүрс алдахад — Би та байсансан бол ганц ч минут алгуурлахгүйсэн гэж Гольдринг зөвлөсөнд — Таны хэлдэг зөв, зөв! гэж Миллер тэвдэн үүд рүү гүйж очоод туслахаа дуудаж. — Түгшүүр зарла! Нэн даруй түгшүүр зарла! гэлээ. Таван минутын дараа СС-ийн баг цэрэг ачааны машинд суугаад Сен-Ремийн гол гудамжаар Понтемафре тийш давхив.

... Өглөө нь Миллер буцаж ирлээ. Түүнийг харваас өрөвдөлтэй ажээ. Явуулган ажиллагааны цорын ганц олз болсон офицеруудын хүүрийг түрүүчийн машин дээр ачсан байлаа. Левек үнэн хэлсэн байжээ. Алагдсан офицеруудын хүүрийг өнчин царсны дэргэдээс олсон байв. Герман офицеруудыг алсан хэрэгт холбогдолтой гэж Лебекийн захидалд нэр дурдсан нөгөө хоёр макийн тухайд гэвэл тэднийг баривчилж чадсангүй. Тэдний хэн нь ч тосгонд байсангүй. Тэд нар өөрснөө төдийгүй гэр бүлийнхэн, ойрын төрөл садан нь хүртэл ул мөргүй алга болжээ. Миллерийн ажил ийнхүү бүтэлгүй болсныг Лютцийн ярихад Генрих харамссан янзтай санаа алдсанаа царай нь даруй туяарч. — За би одоо амарч болох боллоо! гэсэнд — Үгүй, таныг генерал нэг хоёр хоног хүлээнэ үү гэж гуйж байсан гэж Лютц түүний урмыг хугалав. — Ямар шалтгаанаар тэр вэ, мэдэв үү? гэж Генрих асуусанд — Мэдсэнгүй. Генерал өөрөө хэлэх байлгүй дээ гэж лютц шууд хариулахаас зайлсхийжээ. Гэтэл Эверс юу ч хэлсэнгүй, Генрих ч асууж лавласангүй. Миллерийн бүтэлгүй ажиллагаанаас хойш хоёр хоног өнгөрсөн боловч Генрихийн амралтын тухай асуудал шийдэгдээгүй л байлаа. Гуравдахь өдөр нь Генрих хоолноос өмнө машинаар жаал зугаалахаар шийдэв. Тэр өдөр даалгагдсан ажил байхгүй болохоор зугаалах санаатай байгаагаа Лютцэд мэдэгдсэнд генералын туслах: — За яах вэ, яв л даа. Хоолноос битгий хожигдоорой. Таныг хоолны газар цагт нь байлга гэж генерал надад зориуд тусгайлан хэлсэн гэхэд нь — Тэгвэл явахаа болихоос доо. Генерал хоолноос өмнө ажил даалгах болов уу? Чухам ямар учиртайг та мэдэв үү? гэсэнд Лютц дал мөрөө хавчив. — Ингэхэд ахмад та сүүлийн хэдэн өдөр надтай нөхөрсөг биш харилцдаг болоо юу даа? — Та юун дээрээс намайг өөртөө нөхөрсөг биш хандаж байна гэж үзэв? — Таныг миний асуусан зүйлд шууд хариу өгөхөөс үргэлж зайлсхийгээд байхаар чинь. Миний явахыг генерал яагаад саатуулсныг

та мэдэж байгаа мөртөө хэлэхгүй байна. Үдийн хоолон дээр намайг заавал бай гэсний учрыг лав мэдэж байгаа мөртлөө үг дуугарахгүй байна. Бас нэг хачин инээмсэглээд ... Хариу хэлэхийн оронд дал мөрөө хавчиж байна. — Эрхэм барон минь! Би хүнийг гэнэт баярлуулахад дуртай. Эвгүй зүйл байсан бол би танд заавал урьдаар хэлэх байсан шүү дээ. — За тийм бол үгээ буцаан авлаа гэж Генрих хэлжээ. Лютцийн тэр баяртай мэдээ гэдгийн тухай Генрих хоолны өмнөхөн бүх офицерууд цугласан хойно дууллаа. Генерал цугларагчидтай мэндлээд дээд командлалаас дэслэгч фон Гольдрингийг хоёрдугаар зэргийн төмөр загалмай одонгоор шагнаж, ахлах дэслэгч цол олгосныг ёслол төгөлдөр зарлав. Бүгдээрээ баяр хүргэхээр хөл босцгоолоо. Генрих олон хүнтэй гар барилцаж, бас ийм хоёр сайхан учрал давхацсаныг найзан дундаа тэмдэглэвэл зохино гэж үг хаяхыг бишгүй сонслоо. Генрих генералаас зөвшөөрөл аваад дарсанд явуулсанд үдийн хоол лут их найр болж хувирчээ. Залуу ахлах дэслэгч энэ насандаа ингэж их архидаж байхыг үзсэнгүй. Хөгшин залуугүй бүгдээр архи ууж удалгүй офицерууд зэрэг цолын ялгааг мартсанаар барахгүй, генералын байгааг ч тоохоо больжээ. Генрих хоёр, гурав, дөрөв дахин дарс шарз захиалахад хүрэв. Офицеруудын зарим нь хэдийн унажээ. Генерал Эверс ч хөл дээрээ сайн тогтохгүй байсан боловч биеэ бариад нэр хүндээ алдахгүйн тулд явах хэрэгтэйг ойлгожээ. Эверсийг штабын дарга, хэдэн ахлах офицерын хамт явснаас хойш архидалт бүүр гаарч, бөөн шуугиан боллоо. Генрих, Лютц хоёр л эрүүл байжээ. Дээд дарга нар явсны дараа нэг тийшээ алга болсон дэслэгч Кронбергийг орж ирэхэд офицерууд учир тоймгүй хашгиралдан угтав. Кронберг ширээн дээр гарч зогсоод: — Гершафтен, гершафтен!¹² Эрхэм хүндэт ахлах дэслэгч барон фон Гольдрингт хатагтай нар баяр хүргэхээр ирлээ гэсэнд — Цонхны хөшгийг буулга! гэж нэг нь хашгирлаа. Арай багашиг согтсон нэг нь цонх руу ухасхийж, хөл дээрээ тогтнозож байгаагийн ихэнх нь тасалгаанд орж ирээд инээмсэглэхчээн аядаж, айсандаа нүд нь бүлтэгнэгэн тэр «хатагтай нар» гэгчийг угтахаар ухасхийцгээв. Тэр хүүхнүүд хамаг сайхан гэснээ ичгүүргүй ил гаргасан задгай хувцастай, жигшмээр ч юм шиг, өрөвдмөөр ч юм шиг, инээд хүрмээр ч юм шиг амьтад байв. Генрих ой гутах, өрөвдөх, эгдүүцэх сэтгэл зэрэгцэн танхимын булан тийш холдсонд Лютц дэргэд нь очоод эмэгтэйчүүдийг татаж чирч байгаа офицеруудын зүг толгой дохиж. — Тэнгэрийн орны найр юм байх! гэж сэжиглэсэн янзтай мушийн инээгээд — Адгуусны тачаалыг дураар нь тавьж бие эзэмдэж чадахаа больсон хүн шиг шившигтэй юм байхгүй шиг санагдахгүй байна уу, барон танд? гэв. — Тэгээд та бага уусан юм уу? — Би ер нь олонтой дарвиж уух дургүй. Та ч гэсэн дөнгөж уруул хүргээд тавьж байхыг харсан. — Миний толгой их өвдөж байна. — Минийх ч бас. — Тэгвэл сэмхэн яваад өгөх үү? гэж Генрих санал гаргасанд — Дуртайяа зөвшөөрье гэж Лютц хариулжээ. Генрих офицеруудын гуанзны эзнийг олж, уусан бүх архины тооцоог өөртөө явуулахыг хүсээд Лютцтэй хамт арын хаалгаар гарав.

Тэр өглөө Моника уурлаж уцаарласан байдалтай явлаа. Эхийгээ «яагаа вэ?» гэж асуухад бүсгүй хариу дуутарсангүй. Бас нутгийн шашны баярыг тохиолдуулан ганц нэгэн аяга дарс уух гэж Тарваль авгайн зоогийн танхимд орж ирсэн, байнга ирдэг хэдэн франц хүнтэй ч Моника төдий л эелдэг биш харилцжээ. Оройн цагаар зоогийн танхимд герман офицер олон цуглах тул францчууд орой орохыг зайлсхийж, өдөр юм уу, өглөө л орж ирдэг байжээ. Өнөөдөр өглөө эрт байсан атал ая нь таарсангүй, францчуудыг ганц

ганц аяга дарс ууж завдаагүй байтал зочид буудлын өмнө ачааны машин ирж зогсоод погон дээрээ хохимой толгойн дүрстэй зургаан германцэрэг зоогийн танхимд орж ирэв. Урилгагүй зочид, тэр мөртөө СС-ийнхнийг хараад францчууд чанга ярихаа болив. Хүн бүр зөвхөн хажуудахтайгаа шивэгнэн ярьж, герман цэргүүдийн суусан ширээний зүг харахгүй байхыг хичээв. СС-ийнхэн зам гудас хундаганд уруул хүргэсэн нь цөөнгүй бололтой, дэндүү дураараа авирлаж, бусад хүмүүсийг элдвээр дайрсан үг хэлж, Тарваль авгайд шалиг самуун үг хэлж, «Грап» гэдэг усан үзмийн хатуу архийг зуушгүй дангаар нь ууж байв. Хагас цаг хирийн дараа тэр цэргүүд бүрмөсөн согтжээ. Шаргал үстэй лүглийсэн том цэрэг ширээ шааж: — Хүүе! Дахиад нэг шил грап! гэж хашгирахад нь — Тэдэнд энэ шилтэйг аваачиж өгөөд эдний нүднээс далд орж бушуухан өрөөндөө оч гэж Тарваль авгай охиндоо тушаагаад өөрөө шанцай бэлтгэж байлаа. Моника захиалсан архийг нь ширээн дээр тавьчаад эргэтэл нөгөө шаргал үстэй СС-ийн цэрэг гараас нь барьж, хүчээр өвөр дээрээ суулгахад нь: — Тавиач! гэж Моника хашгираад ухасхийн зүтгэв. СС-ийн цэрэг тас тас хөхөрч, Моникаг бэлхүүсээр нь чанга тэвэрсэнд нөгөөдүүл нь бас даган хөхрөлдлөө. — Тавь гэж байна шүү, таныг! гэж Моника арга ядан хашгирлаа. Энэ үед Лютц, Миллер хоёртой хамт үүдний танхимд орж ирсэн Генрих ингэж хашгирахыг нь сонсчээ. Генрих зоогийн танхим руу ухасхийв. Чухам юу болсон нь дөнгөж хармагц тодорхой байлаа. Генрих сайтар дасгалжиж дадсан хөдөлгөөнөөр нөгөө шаргал үстийн бугуйнаас барьж, царвууг нь базсанд шар гал үст өвдсөндөө дуу тавин орилж, хөл дээрээ босон харайгаад гэдрэг нэг алхав. Гэвч хожигджээ. Генрих баруун гараа тохойгоор нь нугалсхийж байгаад эрүү рүү нь хамаг хүчээрээ цохисонд СС-ийн цэрэг гэдрэг унахдаа ширээ түлхэж унагав. Шаргал үстийн хамт яваа цэргүүд Генрих рүү ухасхийтэл тэрхэн мөчид өмнө нь гар бууны төмөр гялсхийлээ. — Эндээс зайл! гэж Генрих хилэгнэн хашгирав. Генрихийн араас Лютц, Миллер хоёр гар буу барьсаар гарч ирэв. СС-ийн цэргүүд зэвсэгтэй гурван офицер, тэдний дотор бас Гестапогийн офицер байхыг хараад бие биеэ түлхэж дайрсаар хаалга руу ухасхийцгээв. Генрих юу ч болоогүй юм шиг тайвнаар Лютцэд хандан: — Ахмад аа, та миний байрыг мэдэхээрээ эрхэм Миллерийг, дагуулж аваачина уу, би энд жаал зугаа юм захиалъя гэлээ. Согтуу цэргүүдтэй машин явсныг Лютц, Миллер хоёр лавтай мэдээд Генрихийн өрөөнд орохоор дээш гарав. Моника ч өрөө рүүгээ гүйлээ. Гомдсондоо нүдэнд нь нулимс гүйлэгнэсэн харагдана Генрихийн дэргэдүүр гүйж өнгөрөхдөө «Баярлалаа!» гэж явуут хэлчихээд хаалганы цаагуур далд оров. Генрих эрэгнэгийн дэргэд очиж, — Миний байранд нэг лонх сайн шарз явуулна уу гэж Тарваль авгайд хүсээд мөнгө тоолон өгч, — Энэ миний саяын хөөж гаргасан малуудын өмнөөс төлж байгаа юм. Тэд таны мөнгийг төлөөгүй явчихсан биз дээ гэсэнд Тарваль авгай гар сэгсэрч, — Юу гэсэн үг вэ, юу гэсэн үг вэ! Тэртэй тэргүй бид танд их өртэй улс гэхэд нь Генрих Тарваль авгайн татгалзахыг үл хайхран лангуун дээгүүр тонгойж, мөнгийг өөрөө кассад хийв. Генрихийг өрөөндөө очихоор эргэтэл зоогийн танхимд байсан нэг франц хүн дэргэд нь ирээд — Эрхэм офицер оо! Хүнлэг сайхан чанарын төлөө хундага тогтоохыг зөвшөөрнө үү гээд Генрихт мэхийн ёслол. Тэнд байгаа хүмүүс бүгд босож хундага өргөлөө. Генрих лангууны дэргэд ирж, Тарваль авгайн гараас дарстай хундагыг аваад тэнд байгаа хүмүүсийн зүг мэхийн ёслол. Цөм нэгэн зэрэг хундагатайгаа тогтоолоо. Генрих гарч одов. Галт тэрэг хөдлөхөөс хориод минутын өмнө Курт, даргынхаа юм хумыг машинд аваачиж аччихсан хойно

Генрих, зочид буудлын эзэгтэй, Моника хоёртой салах ёс гүйцэтгэхээр зоогийн танхимд орж: — Би долоо хоногийн амралтаар явах гэж байна. Тэгээд ахай, мадемуазель та хоёртой салах ёс хийхээр ирлээ гэсэнд — Эрхэм барон та их эелдэг найртай хүн байна. Сайн яваад бушуухан ирээрэй. Бид хүлээж байна. Моникаг одоо дуудъя гээд Тарваль авган Генрихтэй салах ёс гүйцэтгээд охиноо эрэхээр явлаа. Генрих жижиг ширээний дэргэд очиж суув. Нэг минут, хоёр минут өнгөрсөн боловч Моника гарч ирсэнгүй. Генрих бүүр горьдлого тасраад байтал бүсгүй гарч ирээд: — Эрхэм фон Гольдринг та надтай уулзах гээ юу? гэж хүйтэвтэр өгүүлэхэд нь — Юунд ийм ёсорхог байна вэ? Би таны өмнө ямар буруутай хэрэг хийснээс та миний өөдөөс харах ч дургүй байна вэ? гэсэнд бүсгүй зөвхий царайлан доош харж, хөмсөг зангидаад — Үгүй, харин ёстой эр хүний зан гаргасанд тань маш их талархаж байна гэв. — Би амралтаар явах гэж байна. Тэгээд тантай салах ёс гүйцэтгэхээр ирсэн юм, — Та шинэ погон, төмөр загалмай одонгоо мялаахад хамт наргисан хатагтан нартайгаа салах ёс хийчихсэн үү? гэж зориуд тоомсоргүй байдлаар асуух дууны нь өнгөнд уйтгарлаж гашуудсан байдал илэрхий сонсдоход — Моника, сайн багш минь! Би тэднийг чинь олигтой харж ч амжаагүй шүү дээ. Тэднийг орж ирмэгц ахмад Лютц бид хоёр гэртээ харьсан гэсэнд — Та биеэ өмөөрч байх шив дээ. — Та намайг зэмлэж байх шиг байна шүү дээ.. — Би таны багшийн хувьд зэмлэж байна гээд Моника энэ удаа инээмсэглэхэд нь — Би тэгвэл сурагчийн хувьд учраа гаргаж байна. Та тэгээд миний амралтын үед ямар үг сургаж захих вэ? — Танд миний сургаж захих үг хэрэгтэй юм уу? Та хуурай эх ... охин дүү хоёр дээрээ очихоор явж байгаа биз дээ. Тэд чинь таныг сайн асарч харгалзах бизээ гэхэд нь — Та «охин дүү» гэдэг үг дээр юунд түгдрэв? — Танихгүй бүсгүйг яагаад дүү гэж нэрлэж болдгийг мэдэхгүй байна. Та долоон настай жаал байхдаа л тэр бүсгүйг үзсэн гэж өөрөө хэлсэн шүү дээ ... — Тэгээд та надад захих хэлэх юм байхгүй юу? — Томоотой яваарай ... Хурдан эргэж ирээрэй. — Таны энэ хоёр захиаг дуртай биелүүлье гэж Генрих хэлээд Моникагийн гарыг чанга атгаж, түргэн зуур гадагш гарлаа. Генрих галт тэрэгний буудал орж явах замдаа «Энэ бүсгүй надад сэтгэлтэй юм биш байгаа даа?» гэж бодоод баярламаар, нэгэн бодоход уйтгарламаар санагджээ.

ЗАГАСЧИН, ЗАГАС ХОЁР Гольдрингийн Мюнхенд ирэх тухай цахилгаан утсыг Бертольд үдэш орой болсон хойно хүлээж авлаа. Бертольд бүтэн өдөр ажилласны эцэст штаб-байрыг орхиж, амрахаар явах гэж байжээ. Бертольд утас ирэхийг удаан хүлээсэн билээ. Генрихийн Мюнхенд ирэхийг хурдатгахын тулд бололцоотой бүхнийг хийсэн юм. Одоо энэ бүгд тун тохиромжгүй цагаар таарчээ. Бертольд одоо гэртээ харих арга тун байхгүй. Гэтэл Эльза, Лора хоёр юм бүгдийг зохих ёсоор гүйцэтгэж чадах болов уу? Бертольд тэр цахилгаан утсыг барьсаар ширээний дэргэдэх том зөөлөн сандалд сууж бодлогоширов. Генрихийг ирэхээр тэгнэ, ингэнэ гэж хичнээн их юм төлөвлөж, хичнээн юм хүсэж байлаа! Одоо ийм болдог байна. Бертольдыг өөрөө ганц өдөр ч атугай явах бололцоогүй үеэр Генрих ирэх болжээ. Гольдрингийн ирэх тухай Бертольд эхнэртээ хэд хэдэн удаа захиа явуулсан юм. Тэр үеэр Бертольд заавал гэртээ очно гэж эхнэртэйгээ хэлэлцэж таарсан юмсанжээ. Одоо очиж чадахгүй гэсэн цахилгаан явуулах хэрэгтэй болж байна. Өөр арга олж болохгүй юм болов уу? Штаб-байранд урьд урьдынхаас их ажилтай байгаагийн харгайгаар хамаг төлөвлөгөө нь чөтгөр шулам руу

хийсэж орхих хэрэг үү? Берггольд тагнуулын байгууллагад ажиллаж өнгөрүүлсэн ухамсарт бүх амьдралынхаа туршид гэр бүлийнхээ төлөө албан ажлынхаа эрх ашгийг хойш тавьж байсан удаа нэгээхэн бээр үгүй билээ. Берггольд хорин найман жил тагнуулын албанд ажиллаж байна. Хорин найман жил болчихсон билүү? Гэтэл залуухан офицер байхдаа Австри-Унгарын армийн штабт ажилд орж өөрийн дарга, ахлах дэслэгч Брандтад штабын офицеруудын санаа сэтгэл, зан байдлын тухай тогтмол мэдээлж байхаар Вена хотод очиж байсан үеийн бүх явдал санаанд нь тов тодхон хоногшжээ. Тэр үед албан тушаал ахих хичнээн сайхан найдлага, залуу насны хичнээн бадрангүй хүсэл байгаа вэ! Вильгельм Берггольд бол гарал үүсэл, боловсрол, мэргэжил аль ч талаар угийн тагнуулчин хүн. Итгэмтгий, үнэнч шударга, цагаан цайлган, дээгүүр албан тушаалтай буюу нэр гараагүй ч гэсэн эрхэлж байгаа албан тушаалынхаа байдлаар нууц ажил хэрэг мэддэг хүмүүсийг авлах тийм авлалтыг их эмч, шашны номын багш ч юм уу, уул уурхайн инженертэй л адил хэрэгтэй чухал мэргэжил гэж Берггольдын удам угсаа үздэг байжээ. Тэгэхэд залуу Берггольд Венад очихдоо эхтэйгээ хамт сүмд орж, гэнэн цагаан, тэнэг хүн олон байх тусам ажил нь амжилттай байдаг тагнан мэдээлэх хүнд ажилдаа дэмжин тэтгэхийг хүсэн Эзэн тэнгэрт сүслэн залбирч байжээ. 1916 он хүртэл залуу Берггольд хувь заяандаа гомдох үндэсгүй байлаа. Азын тэнгэр Берггольдод ээлтэй болж, энэ нь түүний ажлын тухай Брандтын магтсан олон магтаалд илэрч байжээ. Гэтэл 1916 онд Вильгельм Берггольд хүлцэж болшгүй алдаа хийжээ. Юу вэ гэвэл Австри-Унгарын жанжин штабын дээд тушаалын нэг офицерыг германы мэргэжлийн тагнуулчин гэж таньж мэдэлгүй, ээлжит рапортдаа түүний үйл ажиллагааг аль сүүдэртэй талаас нь тодорхойлон бичсэн байжээ. Түүнээс хойш Берггольдын азын од удаан хугацаагаар далд орсон байна. Түүнийг ажлаас нь хөөгөөгүй боловч огт тоохоо больж, нусгай жаал ч гэсэн биелүүлчихэж чадахаар хялбархан ажил гүйцэтгүүлдэг болсон байна. Берггольд 1918 он хүртэл өөртөө ийнхүү тоомсоргүй хандахыг үг дуугүй хүлцэн өнгөрүүлж байтал азын тэнгэр дахиад нааш харж инээх шиг болов. Эзлэн авсан Украинд явуулахын тулд туйлын олон янзын мэргэжлийн тагнуулчид бүрэн цуглуулах хэрэгцээ гарчээ. Берггольдтой багаас үерхэж, тагнуулын сургуульд нэг тогооноос хоол идэж байсан Зигфрид фон Гольдринг түүнийг дурсан санасан байна. Барон хэргэм нь тэр Зигфридэд зөвхөн өндөр албан тушаалын дарга нарын албан тасалгаанд саадгүй нэвтрэх бололцоо олгож байснаар барахгүй, тэдний эхнэрүүдийн зочлох өрөөнд нэвтрэх бололцоо олгож байжээ. Гольдринг, Берггольд хоёр өөр өөр даалгавар авч Украинд хамт очсон байна. Зигфрид нь тээвэр эрхэлж, мэдээлэх тагнуулчид элсүүлэх, Вилли нь Өмнөд Украины эдийн засгийн тухай мэдээ цуглуулах ёстой байжээ. Вильгельм Берггольд хуучин нүглээ цагаатгахын тулд амрах, алжаахыг мэдэхгүй зүтгэн ажиллаж байв. Берггольд земийн хуучин бичиг хар, тоо бүртгэлийн мэдээ, геологи хайгуулын тоосонд дарагдсан илтгэх хуудсуудыг судалж байлаа. 1918 оны намар германы арми хувьсгалт Украины нутгаас зайлах үед Берггольд бас хамгийн үнэ цэнтэй зүйл гэж үзэж сүмээс яаран хулгайлж авсан Козельданы эх дагинын хөрөг, бас Өмнөд Украины эдийн Засгийн тухай өөрийн илтгэх хуудсыг аваад зугатахад хүрчээ. Эх дагинын хөргийн шигтгээ чулуу нь хожим мэдэхэд хуурамч чулуу байсан агаад илтгэх хуудсыг нь хэн ч тоож шагайсангүй. Герман улс сүйрлийнхээ даваан дээр очоод байсан болохоор тийм юм сонирхохтой манатай байжээ.

Хуучин дарга ахлах дэслэгч Брандт нь түүнийг дурсан санаагүй бол удам судраараа тагнуулчийн албан тушаал ахих нь тэгээд өнгөрөх байсан билээ. Дарга нарын зүгээс анхаарал халамж тавьж байхыг үзэж дасаагүй Бертольд сэхээ авч завдаагүй байтал Брандтын орлогч бөгөөд нэг зэрэг эцгийнхээ өндөр албан тушаалаас өөр инж хөрөнгөгүй охины нь эр нөхөр болов. Эцэг нь хоёр жилийн дараа ач охин Лорагийнхаа гарахыг үзээд насан эцэслэхдээ хагас зуун жил шахам цуглуулсан шуудангийн маркийн цуглуулгаас өөр өв хөрөнгө үлдээсэнгүй. Бертольд энэ эасандаа ямар нэг хүнтэй бат зузаан нөхөрлөх нь байтугай, зүгээр нэг эв найртай болж үзээгүй хүний ёсоор охиндоо хязгааргүй хайртай байжээ. Бертольд хэзээний зожиг зантай хүн бөгөөд бусадтай харилцахдаа зөвхөн өөрийн алба тушаал ахих ашиг тусыг л хардаг байлаа. Ийнхүү сэтгэлгүй Эльза хүүхний эр нөхөр нь болж одоо ч гэсэн хүнийрхүү хэвээр үлджээ. Эр эм хоёрыг холбож байгаа ганц юм нь гэвэл Лора охин нь байжээ. Эцэг эх хоёул охиныхоо хувь заяаны төлөө сэтгэл зовно. Бяцхан Лора булцайсан гар хөлтэй, ягаахан хацартай, алтан шар үстэй ховорхон хөөрхөн охин байлаа. Охиныхоо сайхны үзэж хөөрсөн эцэг эх нь түүний галибар яваандаа өөрчлөгдсөнийг ажигласангүй. Лорагийн нуруу өндөр болох тусам нүүр царай нь зууван болж, энэ нь охинд ер чимэг болсонгүй. Лора арван хоёр-гурван настай байхдаа тун эв дүйгүй биетэй, бас өөдгүй хачин зантай жаал бүсгүй болов. Үүнд Лора хаалганы дэргэд очиж томчуудын яриаг сэм чагнах, шагайж харах дуртай байжээ. Амьдралын зарим нарийн нууц юмыг олж мэдсэн нь түүний насны охидын мэддэгээс их л хэтэрсэн байна. Лора чухам ийм насан дээр очоод эрэгтэй хүүхдүүд тийш тэсгэлгүй тэмүүлэх болов. Эх нь энхрийлж эрхлүүлэхийн дээр эцэг нь албан ажлаар байн байн гадагш явдгийг далимдуулан охин нь нэг ангийнхаа эрэгтэй хүүхдүүдийг хэд хэдээр нь гэртээ дагуулан ирж, эрэгнэгээс сэм хулгайлж авсан чихэр боовоороо элбэг дэлбэг дайлаад дараа нь үнсэлцдэг тоглоом зохион тоглох болсны жинхэнэ шинж байдлыг фрау Эльза эцэст нь олж мэдлээ. Сэтгэл зовсон эх нь Лораг гэртээ эрэгтэй хүүхэд дагуулж ирэхийг хориглосноор уг хэргийг бүүр дордуулжээ. Жаал охин тэр зугаа цэнгэлээ хүүхдүүдийн зан авирыг харж ажиглаж байхад бүүр ч бэрхтэй байдаг хашаан дотор шилжүүлсэн байна Фрау Эльза охиноо харж хандаж чадаагүй үнэнээ нөхөртөө хэлэхээс айгаад энэ бүгдийг тас нуужээ. Нэг өдөр Бертольд өөрөө ганц охин нь эрэгтэй хүүхдүүдтэй яаж тоглож байгааг цонхоор харан. Тэр цагаас хойш Лораг эхтэй нь хамт л гадагш гаргах болж, сургуулиас буцаж ирэх цагийг нь хатуу хянаж цагдах боллоо. Охин нь зөрж эсэргүүцэж, элдэв ааш араншин гаргасан боловч эцэг нь хөдөлсөнгүй. Энэ зөв зүйтэй арга хэмжээ Лорад сайнаар нөлөөлсөн юм шиг байлаа. Бүсгүйн зан байдал төлөв төвшин болж гадаад төрх нь ч их өөрчлөгдөж, ногоон цоморлиг дотроос тансаг сайхан цэцэг дэлбэрэн гарч ирэх шиг болсон нь арай дэндүү тансаг юм уу гэмээр байжээ.

Одоо Лора өөрөө бүсгүйчүүдтэй нийлэхийг хичээх болж, шүлэг дуу хуулж бичсэн дэвтрээ солилцож, амралтын хугацаанд үүрд үнэнч үерхэнэ гэж андгай тангараг тавьсан хөөрүү үгтэй урт урт захиа солилцох болов. Эцэг эх хоёрын нь санаа амарч, охиныхоо санаашрангуй харцтай цэнхэр нүд, урт будуун алтан шар үсийг өхөөрдөн харж суух болов. Эцэг эх нь охиныхоо хэтэрхий монцгор хамрыг сүүлдээ зүгээр болно гэж сэтгэлээ хууран ажиглахгүйг хичээнэ. Гэхдээ Лора заримдаа хэвийн байдлаас хадуурах

явдал гарна. Тийм үед дахиад л зөрүүд зан гаргаж, дэндүү цочмог ууртай муухай ааштай болж, нэг бол гэнэт энхрий эелдэг налиганаж нэг бол гэнэт учир шалтгаангүй уурлаж, хавь ойрынхныхоо үйлийг үзнэ. Ингээд байхаар нь Берггольд эмч нартай хүртэл зөвлөсөн боловч эмч нар нэгэн дуугаар сэтгэлийг нь засаж: — Шилжилтийн насны ердийн үзэгдэл. Эрд очиж хүүхэд төрүүлэхээрээ зүгээр болно гэж баталжээ. Берггольд Лора охиноо эрд очиж, бүүр XVII зууны сүүл үеэс эх аваад Вильгельм Берггольд дээр тасрах шахсан удам угсаагаа залгамжлах хүү төрүүлэхийг нь үзэхийг аль эртээс хүсэн мөрөөджээ. Хайртай эцэг нь ганц охиныхоо нөхөр болох хүн охиныг нь инж багатай гэж голохооргүй болгохын тулд бололцоотой бүхнийг хийснийг үнэнээр нь хэлбэл зохино. Охинд нь инж багагүй бий. 1933 онд гитлерийн үймээний дараа Берггольд урьд Мюнхен дахь хөгжмийн профессор еврей хүний өмч байсан байшинг бэлэгт авчээ. Хожим Гиммлертэй холбоо сүлбээтэй болсны ачаар бас талхны хоёр завод олж авчээ. Генерал бас Дорнод фронтод байснаа ч Лорагийн ирээдүй, өөрийн өтлөх насыг юмаар дутахгүй болгох ховорхон завшаан гэж үзсэн байна. Тэгэхдээ бусад хүнтэн адил хувцас хунар, хогшил, хоол хүнс мэтийн аар саар юм хөөцөлдсөнгүй. Даргад нь хуучинцагийн орос мөнгөн эдлэл шилдэг сайн бэлэг болдгийг захирсан бүх хүмүүс нь мэднэ. 1—Ц хэлтсийн даргад зориулан тийм мөнгөн эдлэл зориуд эрж сурвалжилдаг байжээ. Берггольд ямар нэгэн мөнгөн эдлэл олж аваад гэртээ фрау Эльзад явуулахынхаа өмнө ганцаар удтал анхааралтай харж суух дуртай билээ. Берггольд өөрийгөө урлаг нарийн сайн мэддэг хүн гэж тооцоод бүр залуугаасаа алдартай уран баримлын хямдхан хуулбар худалдан авч байрныхаа бүх тасалгаанд үйлдвэрийн хийцтэй хивс өлгөдөг байлаа. Одоо бол уран баримал, хивсний шуналаа хангаж, удаан хугацааны турш урлагийн жинхэнэ бүтээлийн оронд хуурамчхан юмаар сэтгэлээ хуурч байсны өр төлөөсийг олох бололцоо гарчээ. Сүүлд шунал нь улам нэмэгдэж, юмны сайн мууг ялгаж таних нь ч сайжирсан байна. Одоо бол зөвхөн музейд тавьсан уран баримал, хивсийг авдаг болжээ. Энэ нь түүний цуглуулгад хуулбар буюу хоёрдугаар зэргийн эд орохгүй байхын лавтай баталгаа болно. Берггольд угийн нямбай хүн тул шинэ «олз» бүрээ явуулахын өмнө баримал, хивс бүрд тэр баримал хивсийг бүтээсэн хүний нэр, аль нэг хивсийг нэхсэн зууны үе, тэр ч байтугай авсан музейн хаяг зэрэг мэдэх зүйл бүхнээ бичсэн бяцхан пайз зүүх буюу наадаг байв. Тэр бүх пайзыг нь аливаа нямбай хүн бүр өтлөх насандаа амь зуухад хэрэгтэй юмыг хадгалахын адил фрау Эльза эр нөхрийнхөө тушаалаар дарж хадгална. Гэргий нь Берггольдод долоо хоног тутам хоёр удаа гэр бүлийн бүх сониныг мэдээлнэ. Тэдний энэ захидал харилцааны гол сэдэв нь Лора охины эрүүл мэнд, зан байдал, санаа сэтгэлийн тухай зүйл байдаг байна. Эх нь одоо асар их ажилд дарагдаж байгаа эр нөхрийнхөө сэтгэлийг зовоохгүй гэж, охиныхоо тухай гомдол тавихаас зайлсхийдэг байна. Гэтэл сүүлийн үед түүний захидалд Лора нэг л болохгүй байна гэсэн ноцтой үг цухалзах нь олон болжээ. Чухам юу болсныг бич гэсэн Берггольдын эрс хатуу шаардлагын хариуд фрау Эльза урт захидал бичиж, Лорагийн огт санамсаргүй талаас илэрсэн зан авирыг тодорхойлоход хүрэв. Юу вэ гэвэл нэг жилийн өмнө Мюнхений ойролцоо Берггольдын авсан фермийг Лора их сонирхох болсон нь герман эмэгтэйчүүд бүхэнд байдаг аж ахуйн ажлын сонирхол биш, харин огт өөр шалтгаантай байжээ. Берггольд тэр фермийг бараг сул шахуу олж авсан юм. Тэр фермдээ их найдлага тавьж байжээ. Тийш нь зөвхөн голланд үүлдрийн сайн угсааны

үнээ явуулсан болоод ч тэр биш, хөлсгүй ажиллах хүчин гол орлогыг оруулах ёстой байлаа, Бертольд Дорнод фронтод байхдаа есөн белорус бүсгүйг партизануудтай холбоотой гэж худал сэрдэн фермд явуулсан байжээ. Лора анхандаа эцгийнхээ шинэ хөрөнгийг тоохгүй байснаа сүүлийн үед фермд очих нь олширч, түүгээр үл барам манааны оронд хэрэглэдэг нохдыг ташуурдах урт ташуур худалдан авчээ. Охин нь замд яаж төхөөрч байгааг фрау Эльза анхандаа хараад сэтгэл огт зовохгүй байлаа. Тэр ч байтугай охиноо их сайн эзэгтэй болно гэж танил улсаа магтан сайрхдаг байв. Нэг өдөр фрау Эльза охиныхоо хойноос ферм орох хэрэг гарсан байна Тэнд очоод үзсэн зүйлдээ хирдхийн цочив. Лорад ташуурдуулж байгаа белорусс бүсгүйчүүдийг фрау Эльза ямагт загнаж зандран шавдуулж байвал зохих ажлын мал шиг үздэг байжээ. Эльза авгай гэр бүсгүйчүүдийн уйлан хайлах, гаслан ёолохыг үзээд гайхан хирдхийсэн нь бус харин охиныхоо царайг хараад тэнгэрт ниргүүлсэн юм шиг гөлийн зогсов. Охины нь царайд хүмүүн бусын бах нь ханасан байдал тодорч, санаашрангүй нүдний нь хүүхэн хараа томроод галзуу хүнийхтэй адил болсон харагдав. Энэ бол нэгэн цаг зуур бадарсан уур хилэнгийн гал биш байжээ. Бүсгүй ажилчин эмэгтэйчүүдийг зодож бахаа хангахын тулд л ферм дээр ирдэг байсан юмсанж. Бертольд гэргийнхээ бичсэний үнэн худлыг өөрийн биеэр үзэж лавлах, хэрэв шаардагдвал Лорагийн эрүүл мэндийн байдлыг бүхий л талаар шинжлүүлэхийн тулд эмч нарын зөвлөлгөөнөөр оруулах гэж дээд дарга нараасаа чөлөө авч, Мюнхенд давхиж ирэхээс өөр аргагүй болсон байна. Энэ удаа эмч нар түрүүчийнхийг бодвол төдий л нааштай үг хэлээгүй боловч бүсгүйг нэн даруй эрд өгөхийг дахин шаардсан байна. Эмч нар Лораг ферм тийш явуулахыг тас хориглож. Энэ хүнийг тамлан зовоох хандлагыг даамжруулан улмаар сэтгэхүйн болон бэлгийн хэвийн амьдралаас элдвээр гажихад хүргэж болзошгүй гэж хэлжээ.

Ингээд эцэг эхийн нь өмнө охиноо аль болох хурдан эрд өгөх асуудал тулгарав. Охин нь эр нөхөртэй, үр хүүхэдтэй болж хэвийн байдлаар аж төрөх ёстой байлаа. Бертольдын удам угсааг эрүүл саруул хүн залгамжлах ёстой шүү дээ, чөтгөр алгад! Охиноо эрд өгнө гэж хэлэхэд амархан. Бертольд өөрийн захиргаанд байдаг офицеруудын дотроос их, бага алин боловч боломжийн нэг хүн шилж олж авах л даа. Ядуухан онцын нэр гараагүй нэг дэслэгч олж, улмаар өөрийн хүргэн болгохын тулд дэвшүүлээд авч болох юм. Гэвч хадам эцгийнхээ эрхшээлд ингэж бүрэн автах нь хүчээр тулгаж өгсөн эхнэрээ энхрийлэх сэтгэл төрөхөд хичнээн бага тус болдгийг Бертольд өөрийн туршлагаас мэднэ. Эльза элдэв юмаар онц дутагдаж гачигдахыг үзээгүй, сүүлийн хэдэн жил бол баян чинээлэг байсан гэж хэлж болохуйц боловч хэзээ ч жаргалтай байгаагүйг хэлэх хэрэгтэй, Вильгельм Бертольд өөрөө ч гэр бүлийн амьдралаас жаргал олсонгүй. Эр эм хоёр хөндлөнгийн хүний дэргэд хоорондоо эвтэй эелдэг, бие биедээ анхааралтай ханддаг боловч хоёулханаа үлдэхээр юун тухай ярих учраа олохыг больж хөндлөнгийн хоёр хүн шиг хүйтэн хөндий байна. Лорагийн тухай яриа гарахад сая хоёул сэргэнэ. Үнэндээ тэр хоёрын сэтгэлийг онгойлгодог ганц юм нь Лора охин байжээ. Хашир хянуур Бертольд охиныхоо ирээдүйн тухай элдвийг төлөвлөн бодож санааширна. Бертольд Мюнхенд анх очихдоо Лора охиноо Мюнхен хотын язгууртан ихсийн хүрээнд оруулах гэж чадах бүхнээ хийжээ. Эльза тэр харилцааг бататгаж чадаагүй нь ямар ч гэсэн Бертольдын буруу биш. Юу ч гэсэн Лорагийн санаа

нийлсэн хүнээ олж болох язгууртны хүрээ хаалттай үлдсэн учир Бертольд охиноо нөхөрт өгөх гэсэн төлөвлөгөөгөө, ч орхиход хүрэх нь гэж сэтгэл түгших болов. Ядаж Лорагийн царай зүс их эвдэрсэн нь гайхалтай. Нүүрийн нь тэг дэндүү дугуйрч, хамар нь монцойсноос нүд нь жинхэнэ байдлаасаа жижиг онигор юм шиг харагдах болжээ. Бүсгүйн үс нь л хувирсангүй, өтгөн алтлаг шар хэвээр үлджээ. Бертольд бүр хурандаа байхдаа Генрих фон Гольдрингийг албан тасалгаандаа анх орж ирэхэд нь ерөөлөөр ирсэн бэлэг гэж үзжээ. Үнэндээ түүний талийгаач найзын хүү, хоёр сая маркийн хөрөнгөтэй энэ залуу барон чухамхүү Бертольдтой тааралдаж уулзсаныг зөвхөн хэрэг явдлын аз завшаант тохиолоор тайлбарлаж болох байлаа. Талийгаач Зигфридийн хүүтэй уулзсандаа сэтгэл нь хэрсөн хурандаа тэр үед Генрихт эцгийн нь оронд эцэг болно гэж бүр үнэн голоосоо хэлсэн байжээ. Гагцхүү шөнө нь юм бүхнийг эрэгцүүлэн бодож хэвтэхдээ хичнээн мэргэн алхам хийснээ ойлгов. Лорад үүнээс илүү сайн нөхөр олдохгүй. Нас залуу, герман орны өмнө байгуулсан гавьяатай. Харин Шульцтай муудалцсан байдлаас үзэхэд тагнуулч хүнд зохимооргүй баахан түргэн зантай мэт байх боловч Гольдринг тагнуулын албанд цаашид ажиллаад ирэхлээрээ сахилга баттай болно. Гольдринг зэрэг тушаал ахих гялалзсан сайхан бололцоотой гэж үзэх үндэс байна ... Хамгийн гол нь их баян, бас барон хэргэмтэй шүү. Одоо үед сурвалжит язгуурыг онц их тоохоо байсан нь үнэн боловч Лора маань барон хүний хатан болоход илүүдэх нь юу байх вэ. Ер нь Гольдрингийг гаднаас нь харсан ч өргөн магнайтай, хянгадуу шөвгөр хамартай, ухаалаг тунгалаг хүрэн нүдтэй, голшиг нуруутай цэвэрхэн төрсөн залуу. Үгүй, ер нь эрд очих болсон хичнээн зөрүүд шилэмтгий бүсгүй боловч ийм хүнтэй суухаас татгалзахгүй гэж Бертольд боджээ. Бертольд өөрийн төлөвлөгөө, найдлагыг тэр даруй эхнэртээ мэдээлж, хуурай хүүдээ аль болох энхрий хайртай хандахыг тушаажээ. Лорад сануулж хэлэхийн хэрэг байсангүй, тэртэй тэргүй хувь заяа нь сонин учралаар дүүрэн тийм офицер ахтай болсондоо хөөрөн баярлажээ. Генрих, фрау Эльза, Лора нар хоорондоо захидлаар үргэлж харилцах болов. Ингээд юм бүгд их урагштай байна. Бертольдын боловсруулсан төлөвлөгөө ёсоор Генрихийг фрау Эльза, Лора хоёртой анх уулзуулах нь асар их учир холбогдолтой байжээ. Бертольд энэ уулзалтын хэсэг бүхнийг нэгд нэгэнгүй нарийн бодож, сайн найруулагч мэт ролийг хуваарилсан байна. Гол ролийг өөртөө үлдээсэн нь мэдээжийн хэрэг. Тэгэхдээ Бертольд өөрөө сайн жүжиглэж чадахаар барахгүй, бүх хэрэг явдлыг удирдаж чадна. Гэтэл Бертольдыг өөрөө Мюнхенд эзгүй хойгуур Генрих очих болж байгаа тул хамаг төлөвлөгөө нь нурахад хүрч байна. Нэг өдрийн чөлөө гуйгаад үзвэл яадаг юм бол? Ердөө ганцхан өдөр шүү дээ. Бертольд маргааш нөгөөдрийн дотор нэг тийш болговол зохих бүх яаралтай ажлаа бодож үзэв. Бертольд ингэе гэж боджээ: Өнөө шөнөжин, маргааш өдөржин сууж ажиллаад орой тийшээ нэг өдрийн чөлөө авч, мөн тэр орондоо Мюнхен тийш гарна. Зам маш сайн, бөмбөгдөлтөнд гэмтээгүй. Тэгэхлээр францын «Рено» машин нь түүнийг найм-есөн цагийн дотор гэрт нь хүргээд хаячихна. Тэгээд бүхэл өдөржингөө гэртээ байх бололцоотой болно. Тэгвэл нэг өдрийн дотор уулыг ч урвуулж болно. Ямар ч атугай эхнэртээ харьж чадахгүй гэж утас цохих хэрэгтэй, Фрау Эльза нөхрийнхөө явуулсан цахилгааныг үзээд сэтгэл их түгшнэв. Генрих ирээд ганцхан өнжиж байхад Эльза авгай цаглашгүй их ядарчээ, Энэ бол Гольдрингийн буруу биш. Үгүй шүү, энэ залуу бароныг эелдэг зантай, хүмүүжилтэй хүн гэсэн эр нөхрийнхөө саналыг Эльза авгай бүрэн

дүүрэн зөвшөөрч байлаа. Түүгээр ч барахгүй залуу барон Эльза авгай л их сайхан сэтгэгдэл төрүүлсэн учир нөхрийнхөө сануулан хэлэхээс өмнө энэ ариухан сайхан дүртэй, Швейцарийн банкинд хоёр сая марктай. голшиг цэвэрхэн офицерыг охиныхоо болзоот хархүү болгож, улмаар эр нөхөр нь болгохын гулд арга бүхнийг сүвэгчилжээ.

Генрихийг өглөө түүнийг ирнэ гэж бодоогүй байсан Эльза авгай Лорад хуурай ахтайгаа яаж харилцвал зохихыг заан сургаж амжаагүй байна. Бүсгүй өөрийн дураар осолтой авирлаж, дараа дараагаар алдаа хийгээд байх шиг Фрау Эльзад санагдлаа. Лора, Генрих хоёр ах дүү хоёр гэж яваа болохоор хоор хөндлөнгийн улсын дагавал зохих ёс журмыг нэг их дагахгүй байж болох л доо. Генрих анх түрүүн уулзахдаа бүсгүй дүүгээ «Та» гэж дуудаж чадахгүй гэсэн нь зөв юм. Генрих Лора хоёр уулзаж мэндлэхдээ үнсэлцсэн нь бас зүйн доторхи хэрэг байлаа. Ах дүү хоёр гэж яваа болохоор тэгэх нь арга байж уу. Гэвч Лора өөрөө зориуд удаан үнсэж, ер нь ах дүүгийнхээ сэтгэлийг дэндүү халуун илэрхийлээд байгаа нь Эльза авгайн ажигч хашир нүдний хажуугаар өнгөрсөнгүй. Энэ нь бароныг түлхэж хөндийрүүлэх буюу эсвэл өөрөө хүзүүнд нь асаад байгаа бүсгүйг амархан эрхэндээ оруулж авахад хүргэж болно. Тэгвэл хамаг төлөвлөгөө найдлага талаар болох нь тэр! Үгүй, Биллийг иртэл Лора, Генрих хоёрыг хоёулхныг нь үлдээж болохгүй юм байна гэж Эльза авгай бодоод хамаг ажлаа орхиж, өдөржингөө охин, зочин хоёрыг хаашаа л бол хаашаа даган явах ажилтай болжээ. Өглөөний цайны дараа тэр гурав цэцэрлэгийг үзэж, хотын гудамжаар зугаалж, хоолноос өмнө машинаар явж зугааллаа. Генрих жолоо барьж, Лора түүний машин сайн жолооддогийг шагшин магтаж, өөртөө машин жолоодохыг зааж өгнө гэсэн амыг нь авав. Лора биеэ авч байж чаддагсан бол үүнд хачирхмаар, үл болохоор зүйл байсангүй л дээ. Гэтэл Лорад итгэж тун болохгүй. Эльза авгай өөрөө бас хамт явахаас биш яая гэх вэ. Авгай үхтэлээ ядраад маргааш нь тэнхээ хүрэх нь үү, үгүй юу, мэдэхгүй байжээ. Барон бод Лоратай эелдэг боловч зохих ёсны дотор биеэ барин харилцаж байх юм. Хоёулхнаа үлдэхээр яахыг хэн мэдэх билээ? Фрау Эльза нөхрийгөө шөнө ирэх байх, тэгвэл энэ бүх хүнд ажил хариуцлагаас салж санаа амарна гэж найдаж байлаа. Гэтэл нөхөр нь ирж чадахгүй гэсэн утас явуулжээ. Тэгээд өөрийнхөө чадах ядахаар үзээд байхаас ондоо зам үлдсэнгүй. Үдийн хоолны дараа Эльза авгай Генрихийг замд ядарсан, одоо амрах хэрэгтэй гэдгээр шалтаглан охиноо зочны авчирсан бэлгийг үзье гэж дүйвүүлэн өөрийн өрөөнд дуудаж аваачив. Охин нь Генрихийн авчирсан бүх юмыг сайн үзэж завдаагүй учир үгийг дуртайяа дагажээ. Лора бэлгийн бошинз, туфлийг өмсөн үзэж, олон даавуу, торгыг царайдаа тааруулан үзэж, үнэтэй хүзүүвчийг зүүж маяглаж байсан учир эхийн хэлсэн үг нэг чихээр нь ороод нөгөө чихээр нь гарна гэгч болжээ. Өөрийн хэлсэн үг охины ухаанд хүрэхгүй байгааг авгай мэдээд бүүр цөхрөнгөө барав. Тэгээд эцсийн арга хэрэглэхэд хүрч: — Энэ хүн өнөөдөр чиний хуурай ах гэж яваа боловч маргааш болоход чиний болзоот хархүү, дараа нь чиний эр нөхөр болж магадгүй юм гэдгийг битгий мартаарай гэсэнд Лора гэнэт цочирдсондоо луг хийтэл сууснаа агшин зуур босон харайж, эхийнхээ хүзүүнд асав. Фрау Эльзагийн сэтгэл уярч, охиныхоо толгойг илээд — Ай тэнгэр минь, мөн л гэнэн хонгор байна даа. Нялхаараа амьтан! гэжээ. Эх нь охиндоо хамаг үнэнийг дэлгэсэн нь зөв болжээ, Бүсгүй даруй царайг төв болгож эхийнхээ бүх зөвлөлгөөг анхааралтай сонсов. Энэ цэвэрхэн залуу офицерын эхнэр болж, барон фон

Гольдрингийн хатан гэж нэрлүүлбэл сайхнаа! Лора охин үүнээс хойш эхийнхээ үгэнд орж, Генрихийн өөртөө ярьсан болгоныг үг үлээлгүй эхдээ хэлж байхаар болов. Тийм шүү, аав ээж хоёр нь охиноо жаргалтай яваасай гэж хүсэж байгааг Лора өөрөө ойлгож байна. Эцэг эхийн хэлсэн бүхнийг ёсоор дагана ... Энэ завсар Генрих хувцсаа тайчаад орондоо орлоо. Хичнээн их ядраа вэ! Тэнэг бүсгүй, энэ охиндоо эр нөхөр эрж байгаа халамжит эх хоёртой хагас өдрийг өнгөрүүлнэ гэдэг ийм хэцүү байх юм гэж Генрих огт санасангүй. Үүнд орвол Бертольдтой өөртэй нь хамт байсан нь дээр юм, Энэ бүгд ой гутмаар инээдэмтэй балай хэрэг боловч өөр арга алга. Ялангуяа Бертольд дээгүүр албан тушаалын чухал хүн болоод байгаа одоо цагт харилцаагаа муутгахгүйн тулд элдэв шалтаг зааж энэ явдлыг удаахан үргэлжлүүлэх хэрэгтэй байна. Энэ тонож дээрэмдсэн баялгийн дунд сууж байх хэрэг болжээ. Эльза авгай Оросын музейнүүдээс нөхрийнхөө авчирсан олзыг хичнээн бахархан үзүүлж байсныг яана! Хоол идэж байх үед эртний орос мөнгөн хэрэглэлийг Генрихт мэдүүлэх гэж хичээнгүйлэн оролдож байсныг яана! Ер нь энэ байшинд байгаа юм бүхэн хулгай дээрмээр олсон зүйл байж магадгүй ... Хуучнаас юу үлдээ вэ гэвэл Бесмаркийн хүрэл баримал үлджээ. Энэ баримлыг хүүхэд ахуй цагийн нь хонгор сайхан дурдатгал болгох гэж Генрихийн тасалгаанд зориуд авчирч тавьсан байжээ. Лора өнөөдөр энэ баримтыг уулзалтын дурсгал болгож Генрихт бэлэглэв. Генрих Бертольдтой анх уулзаж ярилцахдаа мөн энэ баримлын тухай цухуйлгаж байснаа дурсан санаад инээмсэглэв. Ямар ч атугай Генрихийн ажилд ийм жижиг сажиг зүйл их учиртай байдаг байна. Генрих Юнкерийн хоёрдугаар эзэнт улсын үндсийг тавигчийн барималд хандан: — За ноён Бисмарк аа! Дахин уулзах хүртлээ баяргай! гэж хэлчихээд нөгөө хажуугаараа эргэж, толгой дээгүүрээ хөнжил татаж нөмрөөд тэр даруй хүнд ажилд ядарсан хүний ёсоор бөх унтжээ. Орой болсон хойно Генрихийг шивэгчин хүүхэн Айна дуудаж сэрээв. Хаалганы цаанаас Лора дуудаж: — Яасан их унтдаг залхуу амьтан бэ! Ээж бид хоёр босоод гурван цаг болж байна. Одоохон хувцасла. Зочид цуглачихаад байхад зочдыг хэрэг болгож урьсан хүн маань одоо болтол унтаж байдаг гэхэд нь — Ганцхан минутын дараа чамд хүчин зүтгэхэд бэлэн болно гэлээ. Үнэхээр сайн унтаж амарсан Генрих таван минутын дараа ёслолын дүрэмт хувцас өмсөөд Лорагийн өмнө зогсож байв. Бүсгүй ч бас хувцас хунараа сольж, тансаг цагаан платые өмсөж, энгэртээ амьд улаан сарнай цэцэг хатгажээ. Алтан шар үсээ цээж рүүгээ унжуулсан нь бараг өвдөгтөө хүрсэн харагдана. — Маргарита байна! Фаустын ухаангүй дурласан Маргарита байна гэж Генрихийг хэлэхэд Лора гомдож — Битгий дэмий юм ярь, Генрих ээ. Фауст чинь Маргаритаг хөнөөсөн шүү дээ, Бас тэр бүсгүй биеэ ер авч байж чаддаггүй хүн байсан гэхэд нь Генрих инээдээ барьж ядан — Ай Лора! Би огт өөр юм бодож хэлсэн билээ. Би тэр бүсгүйн үзэсгэлэн сайхан царай, урт үсийг бодож хэлснээс биш, биеэ яаж авч байдгийг нь хэлээгүй юм гэсэнд — Тэгвэл уучилья ... гэж Лора хэлээд Генрихийн гарыг чанга атгаж, хоолны өрөөний үүдийг нээлээ.

Генрих хурц гэрэлд нүд гялбаад зочдыг тэр даруйд сайн харж чадаагүй боловч их олон зочин цугларсныг ажиглав. Ширээг тойрч, зочин бүртэй гар барилцах хэрэг болов. Энд гестапогийн офицеруудын гэргий, охин дан эмэгтэйчүүд цугларсан байлаа. Хөгшин, залуу, тарган, туранхай, цагаан царайтай, шаргал үстэй, сайхан, муухай янз

бүрийн эмэгтэйчүүд байна. Гэтэл хоорондоо нэг л адилхан юм шиг санагдана. Бүгдээр Генрихийг сонирхон харсан сониуч байдлаараа тэгж адилхан санагдсаныг Генрих сүүлд нь тааварлажээ. Нэг л эмэгтэй бусдаасаа жаахан ялгаатай байсан нь анхандаа Генрихийг өчүүхэн ч анхаарахгүй байснаас тэр бизээ. Тэр бол хорин найм, есөн настай, үсээ богинохон тайрсан, гантиг шиг зэвхий цайвар царайтай, том хөх нүдтэй, царайлаг хүүхэн байлаа. Хоёр сэжүүр нь бараг санчигтаа хүрч, цохон дээрээ бараг нийлэх шахсан урт хар хөмсөг, мөн тийм хар сормуус нь нүднийхээ өнгөтэй аятайхан хослон зохицохын зэрэгцээгээр нүдний нь жигтэй хачин харцыг тодруудна. Тэр бүсгүй СС-ийн оберштурмфюрерийн дүрэмт хувцас өмсчээ. Оёдол хийц сайтай ёслолын мундирийнхээ зүүн халаасны дээд талд шинэхэн төмөр загалмай одон зүүсэн харагдана. Лора тэр садныхаа эмэгтэйг Генрихтэй танилцуулж, — Миний үеэл эгч, Дорнод Прусс дахь оросын олзлогдогсдын лагерийн дарга, оберштурмфюрер13 Бертина Граузамель! гэж ёсорхуу ч юм шиг, тоглож байгаа ч юм шиг өгүүлэв. Генрих тэр Бертина хүүхний бяцхан чийрэг гарыг барихдаа «Хүүхэн хараа нь томорсныг үзэхэд хар тамхичин бололтой» гэж бодов. Лора, Бертина хоёр Генрихийг дундаа суулгаж, тэр гурав оройжин салахгүй хамт байж таарлаа. Бертина анхандаа Генрихтэй төдий л эелдэг биш байснаа Генрихийг хоёр гурван хурц үг хэлж, өөрийг нь аятайхан магтаж тал зассанаас хойш хөгжилтэй болж, тоглоомын үгийг тоглоомын үгээр хариулж, Генрихтэй дуртайяа бүжиглэх болов. Эр хүн гэвэл ганц Генрих байсан тул бүх эмэгтэйчүүдийг ээлж дараалан урьж бүжиглэх ёстой болжээ. Бертина Генрихтэй бүжиглэж явахдаа Гольдрингийг суух хүнээ олж шилж чадсангүй гэх байрын үг шууд цухуйлгав. Генрих оройн турш Лораг үйлчлэхийн сацуу бас Бертинаг мартаж орхисонгүй. Тэр гурав маргааш өглөө нь дахин уулзаж, гурвуул хотоос гадагш явахаар болзож тохирлоо. Дараагийн гурав хоног Лора, Бертина, Генрих гурав салсангүй, гурвуул машинаар хотоос гадагш явж. Мюнхен хотыг үзэж, театр, концертод очиж цагийг өнгөрүүлнэ. Эльза авгай анхандаа Бертинагийн хамт яваа нь Лора, Генрих хоёрыг харж цагдаж байх илүү төвгөөс ангижируулж байна гэж дотроо баярлаж байсан боловч алдаа хийснээ удалгүй ойлгожээ. Эльза авгай охиндоо хайртайн учир охиноо гоо үзэсгэлэнтэй гэж санах боловч Лора Бертинатай энэ талаар өрсөлдөхөд хэцүү гэж үнэнийг хүлээх ухаан бас хүрэлцжээ. Тэгээд Эльза авгай охиноо нөхөрт өгөхийг хүсэж байгаа эхийн хүнд хүчир, чимхлүүр үүргийг дахин биедээ хүлээхээс ондоо аргагүй болов. Ер нь Генрихийн зан байдалд ч сэтгэл түгших болов. Генрих Лорагийн дэргэдээс салахгүй эргэлдэж, охинтой нь эелдэг найртай байх боловч одоо хүртэл ах дүүгийн цааш илүү гармаар юмны ажиг сэжиг үзэгдсэнгүй. Энүүнд нь Бертина буруутай байж магадагүй юм. Генрих Бертинад арай л дэндүү садан төрөлсөг хандаж үеэл эгч гэж дуудан машинаар зугаалах үед тэр хоёр машинаа ээлж ээлжээр жолоодож, хөөрхий Лора ганцаар арын суудал дээр ганцаар уйдаж суудаг байна. Генрих, Лора, Бертина хоёрын аль алиныг адилхан үзэн ядаж байгааг Эльза авгай мэдсэнгүй, мэдэх ч арга байсангүй. Бертгольдийнд болсон үдэшлэгээс хойш тийнхүү үзэн ядах болжээ. Өглөө нь болзсон ёсоор Бертина Лора дээр ирэхдээ нэгэн бэлэг барьсан нь залуу бүсгүйд даанч хачин этгээд бэлэг байлаа. Энэ нь хожим мэдвэл Бертинагийн тусгай захиалгаар хийсэн гурамсан ташуур байв. Лора тэр бэлгийг аваад галзууртлаа хөөрөн баярлаж, үеэл эгчийнхээ хүзүүгээр тэврэн бүтэж үхтэл нь үнсэж сүйд болон дараа нь мөн тэр

тасалгаандаа нөгөө ташуураар хүн ташуурдаж байгаа юм шиг хий даллан савлаж эхэллээ. Генрих «охин дүүгээ» хараад Лораг цохиод авахгүйн тулд хамаг тэсвэр тэвчээрээ дайчлан биеэ барьжээ. Бүсгүйн царай, түүний нүд, саргалзах хамар, биеийн бүх төрх нь гартаа ташуур баримагц түүний биеийг эзэмдсэн зэрлэг араатны тачаал бахыг илтгэнэ. Бертина үеэл дүүгээ инээмсэглэн ажиглах зуур: — Энэ бол лагерь дээр миний барьдаг ташууртай ив ижилхэн ташуур гэж тайлбарлахад нь Генрих дуугүй толгой дохилоо. Лораг бэлгээ эхдээ үзүүлэхээр гүйн одмогц Бертина: — Та надад хаягаа өгнө үү. Захидлаар харилцаж байя гэж санал тавихад нь Генрих огт өөр юм бодох завсар хаягаа хэллээ. Лорагийн аймаар муухай хувирсан догшин араатны дүрт царай нүдэнд нь үзэгдсээр байжээ. Лора эргэж ирээд — Ферм дээр очихыг ээж зөвшөөрөхгүй байна гэж уйлах шахан хэлэхэд нь — Ферм дээр очиж яах гээ вэ? гэж Генрих учрыг онлгохгүй лавласанд — Ташуураа туршиж үзье. Тэнд орос бүсгүйчүүд ажил хийдэг юм ... гэж Лора хариуллаа. Генрих Лорагийн гараас ташуурыг суга татан авснаа тэр даруй сэхээ авч, зөвхөн үзэх гэж авсан байдал гаргав. Гаднаас нь харахад энгийн нэг суран ташуур байх боловч сурны нь завсраар уян төмөр утас хавчуулж томсон ажээ. Генрих ташуурыг хар хүчээрээ далайж, зөөлөн сандлын түшлэгийг цохив. — Хүүе, хараач, сандлын савхин бүрээс хуга үсэрчээ гэж Лора хөөрөн дуу алдав. Бүгд тонгойвол сандлын савхин бүрээс ташуурын ормоор яз үсэрсэн байлаа. — Би Генрих таныг лагерьтаа харгалзагчаар дуртайяа авахсан гэж Бертина хэлээд Гольдрингийг их учиртай харав. — Танд ташуур хэрэглэх хэрэг их гардаг уу? гэж асуусанд Бертина лагерийн дэглэмийн гухайдэлгэрэнгүй ярьж гарлаа. Тэр хүүхэн өөрснийхнийхөө дунд байгаа гэж үзээд юу ч нууж хаасангүй. Харин ч фрейлейн Граузамель залуу офицерт лагерийн дарга гестапогийн эмэгтэйн ширүүн догшин байдлаа харуулахыг бүхий л хүчээр хичээв. Генрих тэр анх мэт яриаг нударга зангидан шүд зуун чагнах зуур үе үе Лораг харвал тэр эм яргачны ярианаас ганц ч үг унагнахгүй сонсох гэж хүзүүгээ сунган нүд салгалгүй ширтэж байлаа. Энэ мөчөөс эхлэн Генрих Бертина, Лора хоёрыг үзэн ядах болов. Дураар болдогсон бол Генрих энэ бүхнийг хаяж орхиод Сен-Ремид Моника дээр яасан дуртайяа очих билээ. Генрихт одоо Моника хол байгаа мөртлөө ойрхон юм шиг, хязгааргүй дотно санагдаж, дайсныг үзэн ядахдаа ч хүртэл ховор сайхан байдгийг нь дурсан санав. Гольдринг энэ бүгдийг орхиод Сен-Реми орох арга алга. Фрау, генерал хоёр олон удаа цахилгаан утас солилцож, Бертгольд өөрөө өнөө маргаашгүй Мюнхенд ирэх магадгүй байлаа. Тэгээд Генрих энд үлдэж, сэтгэлтэй болсон хүний дүрэм үзүүлэх хэрэгтэй байжээ. Ой гутмаар туйлын муухай санагдах боловч ингэх л хэрэгтэй. Эльза авгай хэдэн өдөр хирнээсээ хэтэрсэн баатарлаг чадал гаргаж, залуучуудыг хаашаа л зугаалбал салахгүй дагаж, зугаа цэнгэлд нь хүртэл оролцож, бүжгийн үед хөгжимчний үүрэг гүйцэтгэж байлаа.

Генрихийг явахын урьд өдөр Бертгольд шөнө орой болсон хойно хүрч ирээд эхнэрийхээ тэр баатарлаг чадлыг үнэлэн тэмдэглэжээ. Залуучуудын зан байдлын тухай, охиныхоо эрх ашгийг царайлаг үеэл эгчийн нь халдлагаас хамгаалахын тулд авсан арга хэмжээний тухай эхнэрийнхээ дэлгэрэнгүн тайланг Вильгельм Бертгольд сонсоод түүний цулцгар хацрыг энхрийлэн илж, — О, майне катцехен14 гэж магтав. Эр нөхрийнхөө ингэж энхрийлсэнд «муужгай» нь сэтгэл уяраад золтой л хайлчихсангүй.

Өглөө нь Генрихийн сахлаа хусаж, хувцсаа өмсөөд байтал өрөөнд нь сэтгэл хөөрсөн хөхүүн хөгжилтэй Бертольд орж ирлээ. Хуурай эцэг, хүү хоёр үнэхээр халуун дотно уулзан золгов. — Юм бүгд сайхан болж байна, сайхан болж байна! гэж генерал алгаа хавиран дуртай үгээ давтан давтан хэлнэ. — Эрхэм Бертольд танд генералын погон их зохиж байна шүү гэж Генрихийг өгүүлэхэд — Бүгд сайн сайхан болж байна, хүү минь. Орост манай давшилт маш сайхан өрнөж байгаа. Дахиад нэг, хоёр хүчилбэл Дорнодын асар их гүрэн Герман орны өмнө өвдөг сөхөрнө. Дайн дуусна. Тэгэхлээр бид өнөөдөр ч гэсэн ирээдүйг мөрөөдөж болох байна. Бодоод үзвэл чи бид чухам юу хийж, ялалтын дараа амьдралаа яаж зохиох вэ? гэхэд нь — Энэ ялалт миний шууд оролцоогүйгээр бүтэх нь байна даа гэж Генрих санаа алдсанд — Тэгж бүү харамс, хүү минь, бүү харамс. Оросууд үхэх үйлээ мэдсэн юм шиг улайран үзэлцэж байна. Хүнд шархтантай галт тэрэт дорно зүгээс өрнө зүг тасралтгүй цувж байна. — Ай даа, манай гарз хохирол асар их байна. Гэхдээ юм бүхэн ёсоороо болно. Хүү минь, тэгээд ирээдүйнхээ тухай чиний юу бодож байгааг мэдэж авахсан гэж хүсэж байна гэхэд нь — Миний албан ажлын байдал таны өршөөл хайр, эцэг ёсны зөвлөлгөөнөөс бүрэн шалтгаална гэсэнд — Чи энэ талаар надад хэзээ ч найдаж болно. Харин амин хувийн ажил явдлаа яая гэж байна? Чамайг Сен-Ремид буцаж очихыг нилээн хэдэн франц хүүхэн тэсэж ядан хүлээж байгаа биз дээ? Тийм үү? гэхэд нь — Би Лорад амалсан үгэндээ хүрнэ, өөр бүсгүйчүүлтэй танилцахгүй, Лорагийн үерхдэг бүсгүйчүүдтэй л танилцана гэсэнд — Нөгөө хэн гэлээ ... Яагаа вэ, чиний суудаг зочид буудлын ззэгтэйн охин чинь? Би бүгдийг дуулсан шүү гэхэд нь «Энэ тухай Миллер ховлож мэдүүлэв үү?» гэсэн бодол Генрихийн толгойд зэрххийгээд — Ай эрхэм генерал аа! Танд батлан хэлье. Франц хэлний хичээлээс өөр ... гэсэнд Бертольд үгийг нь тасалж, — Генрих чи аан гэж бай. Би чамтай л адил цэрэг эр. Тэгээд бидэнд ... чамд юу гэж хэлэлтэй юм бэ дээ, бие махбодын шаардлагаар ч гэх юм уу, зугаалж цэнгэх, танилцах явдал байж болно ... Ичиж улайх явдалгүй. Би эцэг хүн, чамтай илэн далангүй шулуухан ярьж болно. Би тийм элдэв хэлний багш энэ тэртэй байхыг хорихгүй, өөр юм хэлж байна. Чиний ирээдүйн төлөвлөгөөг, буурьтай бодсон төлөвлөгөөг мэдмээр байна. Чиний насан дээр энэ тухай бодвол таарна гэхэд нь — Бодсон гэв. — Нууц биш бол надад хэлэхгүй юу? — Надад танаас нуух юм байхгүй. Миний ирээдүй танай гэр бүлтэй, Лорагийн ирээдүйтэй л холбоотой байж болно гэсэнд Бертольд сандлаасаа босон харайж, тасалгаан дотуур хойш урагшаа холхив. Сэтгэл нь хөдлөхөөрөө ингэдэг зантай ажээ. — Лорад энэ тухай Ярьсан уу? гэж Бертольдыг асуухад — Үгүй. — Яагаад? — Лора одоохондоо хүүхдээрээ гэнэн хонгор хэвээр байна Ерийн нэг шохоорхлыг жинхэнэ хайр сэтгэлээс ялгаж чадахгүй байж мэднэ ... — Чиний зөв ... Тэгэд чи яахаар шийдэж байна? — Одоо Лора бид хоёр танилцлаа. Миний занг Лора бага сага мэдэх болсон. Бид урьдынхаасаа олон захиагаар харилцаж байх болно. Өвөл тийшээ зохих ёсоор надад ээлжийн амралт байх болно. Би дахин Мюнхенд ирж, Лоратай сайн ярилдана гэж Генрих хэлэв. Бертольд хэсэг зуур эргэлзлээ. Шаардаж шавдуудж байгаад хурдлуулбал яасан юм бэ? гэж нэг бодсоноо энэ нь эелдэг биш, тэнэг ажил болно гэж мэдээд Генрихийн хэлснийг зөвшөөрч, — Зөв дөө, Генрих ээ! Магтууштай байна. Чиний хэлснийг бүрэн зөвшөөрч байна ... Ингэж болзье. Хоёрдугаар сарын дөрвөнд Лорагийн төрсөн өдөр. Тэр өдөр ... гэхэд нь — Лорад ирээдүйн тухай үг ярих нь нэг ёсны бэлэг болно гэж та бодож байна уу? гэв. — Ай тэгэлгүй яах вэ ... Ямар

ч атугай тийм гэж би Лорад итгүүлнэ. За одоо явж цайгаа ууя. Бертольд Генрихийг бүслэхүйгээр нь нэг тэврээд хоолны өрөөнд дагуулан аваачихад тэнд Лора, фрау Эльза хоёр тэднийг хүлээж байлаа. Бертина урьд орой нь маргааш өглөө салахын өмнө заавал ирж хамт цай ууна гэж Генрихт шивэгнэсэн атал байсангүй ... Бертольдынд Генрихийн чөлөөний сүүлчийн өдөр санаа амар, хөгжилтэй өнгөрөв. Бүгд хөхиүн баясгалантай байлаа. Зугаалах үед ч гэсэн, бильярдын өрөөнд орж тоглоход охин нь Генрихийг хожино гэж, эх нь Виллигээ хожино гэж мөрий тавьж тоглох үед ч үдийн хоолон дээр ч генерал, Генрихийг үргэлж манай хүү гэж дуудан, эхнэр өөдөө хөгжилтэй нүд ирмэж байлаа. Генерал өөрийгөө удтал шаналан хүлээсний эцэст лут том алгана загас барьсан загасчин шиг бодож байжээ. Генрих фон Гольдринг ч гэсэн гутрахын үндэс байсангүй. Сүй тавих ёслолыг хэдэн сараар хойшлуулж чадлаа. Энэ завсар юу ч болж болно. Харин Генрих одоо хадам эцэг болох хүнийхээ элдэв дэмжлэгт бат найдаж болно. Тэгвэл гестапогийн генерал, тэр мөртөө Гиммлерийн өөрийн нь сайн найзын өмөг түшигт багтана гэдэг офицер болгонд олдох хувь биш. Чухам хэн нь загасчин, хэн нь загас болохоо үзье! Эльза авгай, Лора хоёрын тухайд гэвэл баярласандаа бүүр маасайж орхижээ. «Бертольдтой өглөөний ярьсаныг эд нар дуулсан бололтой» гэж Генрих бодлоо. Бертольдынхон гэр бүлээрээ Генрихийг гаргаж өгөхөөр галт тэрэгний буудал дээр очлоо. Үдэлт баахан уйтгартай болов. Авгай нулимсгүй нүдээ алчуур гарган арчиж, Лора нь Генрихийн хүзүүгээр тэврэн үнэн голоосоо уйлав. Бертина галт тэрэгний буудал дээр ирсэнгүй.

ҮХЛИЙН ДАВААН ДЭЭР Моника сурсан зангаар бямба гаригийн өглөөнөөс өөрийн тасалгаанд их цэвэрлэгээ хийв. Угааж цэвэрлэж болох юм болгоноо угааж цэвэрлэж гүйцээд одоо зөөлөн цагаан хилэнгээр жижиг сажиг юмаа арчиж байв. Сэтгэлд дотно дурсгалтай хөөрхөн хөөрхөн юмнууд! Энэ хөөрхөн чихрийн савыг Моникаг найман нас хүрэхэд эцэг нь бэлэглэж билээ. Дотор нь чихэр биш, ёстой алтан зүүлт байхад жаал охин хичнээн бахархсан билээ. Энэ зүүлтийн дотор хэдэн жилийн дараа эцгийнхээ сүүлчийн удаа авахуулсан бяцхан зургийг хийх болно гэдгийг тэр өдөр эх нь ч, Жан ах нь ч, бяцхан охин өөрөө ч мэдсэнгүй. Энэ нүүр гарын хэрэглэлийг эх нь Моникаг адис хүртэх 15 өдөр бэлэглэсэн юм. Ай тэнгэр, энэ хичнээн эртний явдал вэ, тэр үе Моника өөрөө хичнээн тэнэг жаал охин байгаа вэ! Цагаан платыг өмсөж, цагаан цэцэг бариад өөрийгөө энэ дэлхийг эзлэнхэн захирсан хатан хаан шиг санаж байж билээ. Наран хүртэл ганц түүний төлөө хурц гэрлээ тусган ивээж, толгой дээр нь хэлхэн ороосон анхилуухан үнэрт наргил цэцэг ганц түүний төлөө цэцэглэж, баг бишгүүр хөгжим ганц түүний төлөө тийм ёслол төгөлдөр, сүр жавхлантай эгшиглэж байх шиг санагдаж билээ. Моника жигүүртэй юм шиг хөл нь газар хүрэхгүй дэгдэн дэрвэж, Жан ах нь түүнийг үргэлж «Христусын хүүхэн» гэж даажигнан эрэгтэй хүүхдүүдийг ядаж нүдний булангаар тоож харахгүй байна гэж цаашлуулж байсан билээ. Жан тэр өдөр дүүдээ бас нэг бэлэг барьсан нь Вольтерын бяцхан хүрэл баримал байлаа. Энэ бэлгийг ээжийн нь дүүгийн нөхөр Андре ах үзээд элгээ хөштөл инээсэн билээ. Андре ах нь энэ бэлэг одоо үеийн үйл явдалтай тохирохгүй байна гэж хэлээд Вольтерын тухай Жантай удтал маргалдсан юм. Жан бол Вольтерыг Францын хамгийн цэцэн цэлмэг ухаантан гэж батлахад Андре ах нь Вольтерыг зөвхөн аман дээрээ оюун ухаан, эрх чөлөөг магтан

алдаршуулаад өөрөө язгууртан ихэс, меценатуудад зарагдаж байсан ичих нүүргүй амьтан байсан учир Вольтерын сэтгэлд эрхэм ариун юм юу ч байгаагүй гэж батлан маргалдаж билээ. Моника одоо Андре ахынхаа хэлснийг бүрэн зөвшөөрөх болжээ. Моникагийн хүндэтгэн тахигладаг Жанна д'Аркийг дайран доромжилсны нь учир Вольтерыг үзэн яддаг байлаа. Үнэндээ Вольтерт эрхэм ариун юм юу ч байсангүй. Францын баатар эмэгтэйг тэгж доромжилсныг бодоход Франц орноо дуслын төдий ч хайрладаггүй хүн байж дээ. Моникагийн тасалгаанд Жанна д'Арк хуяг дуулга агсаж, гартаа илд барин их цэргийн манлайд явааг дүрслэн үзүүлсэн зургийн хуулбар бий. Моника одоо орой бүр унтахаар хэвтэхдээ Орлеан нутгийн мөнхийн яруу алдарт тэр охиноос дэмжин тэтгэхийг хүсэж залбирах мэт энэ зургийг хардаг юм. Моника үнэхээр Франц орон, эх нутгийнхаа яруу алдрыг дуурсгах гавьяа байгуулахыг мөрөөднө. Учир нь Жанна д'Аркийн нэг адил ард түмнийхээ дайсныг үзэн яддаг билээ. Төрөлх нутгаа харийн түрэмгийлэн эзлэгчдээс чөлөөлөхийн тулд энэ бүсгүй юу ч хийхээс буцахгүйсэн. Моника олон шөнө нойр хулжиж, орондоо урван хөрвөн хэвтэхдээ байлдан дагуулагчдаас яаж өшөө авч, ялалтын цагийг яаж ойртуулах арга бүхнийг сэтгэлдээ эрэгцүүлэн бодно. Түүний толгойд эс орсон баатарлаг үйлс ховор бизээ. Гэтэл дивизийн штабын хаалганы дэргэдүүр нааш цааш явж байгаа харуулын алхааг сонсмогц мөрөөдөл нь замхарна. Шөнийн нам гүмд бөглүүхэн дуулдах тэр нүсэр хүнд алхаа цээжийг нь бачимдуулж, тархийг нь дарж, амар заяа үзүүлдэггүй байлаа. Моника нойргүй хоноод өглөө босоод ээждээ тусалж, зоогийн танхимд үзэн яддаг хүмүүст үйлчлэх хэрэгтэй болно. Гэхдээ үүнийг Франсуагийн тушаалаар гүйцэтгэж байгаа юм. Согтуу хөлчүү офицерууд дэндүү далан задгай үг дэлгэх нь олонтаа. Тэдний болгоомжгүй алдсан ганц үгний сэжүүрээс партизанууд буюу нутгийн ард иргэдийн эсрэг хийхээр сэдэж байгаа аль нэг ажиллагааны хамаг учрыг партизанууд ойлгох удаа бий. Гэтэл Франсуад дамжуулах тийм үг цөөхөн олж сонсдог нь яасан харамсалтай вэ! Моникагийн төрсөн ах Жан ууланд партизануудтай хамт яваа. Моника өөрөө бас Жантай хамт явах гэтэл Франсуа өөр холбоо барих хүн олдохгүй гэж үзээд Моникаг Сен-Ремигээс холдож болохгүй гэж хатуу тушаажээ ... Тэгтэл одоо ээжийн нь зочид буудалд Генрих сууж байдаг. Моника германы штабын офицер барон фон Гольдрингийг зүгээр нэрээр нь нэрлэж дотночлон бодчихоод түүнээсээ зовж царай нь улайв. Моника сүүлийн үед өөрөө өөрийгөө мэдэхээ байжээ. Одоо болтол юм болгон учир тодорхой, энгийн хялбар байлаа. Моника Генрихтэй найрсаг харилцаатай болж, чалчаа яриаг нь ашиглахын тулд Гольдрингт франц хэлний хичээл заах ёстой байжээ. Урьд нь германы нэг ч офицерт нүүр өгдөггүй, хоол зөөхдөө ч инээмсэглэдэггүй байсан бүсгүй одоо болоход энэ эрх жаргалаараа баронтой хэдэн цагаар бараг л найзархаг яриа дэлгэж, уулзахдаа эелдэг мэндэлж, түүгээр үл барам үе үе түүний зүг сээтэн хаях хэрэгтэй болж байна. Аяа, энэ анхандаа хичнээн тэсвэрлэшгүй хүнд байсан билээ.

Генрихтэй хичээллэсний дараа Моника тасалгаандаа гүйн ирж, орон дээрээ ойчдог байлаа. Өөрөө тусгай тасалгаатай нь юутай сайн бэ. Эргэн тойрон хүүхэд ахуй цагаас таних мэдэх зүйл хүрээлж байх нь «Чи энд сурсан дассан зангаар байж болно. Чи заримдаа эд юмаа тоохгүй байдаг нь хамаагүй. Урьд бол их дуртай өмсдөг байсан гоё сайхан платъегаа өмсөхгүй, урьд хөгжим дарах их дуртай байсан атал төгөлдөр хуур

хөгжмийнхөө тагийг нээхгүй байгаа чинь яах вэ, зүгээр цэцэггүй амьдрал байж болно гэж төсөөлдөггүй байснаа ширээн дээрээ шинэхэн цэцэг тавихаа больсон чинь хамаагүй. Германы цэрэг эзэмшсэнээс хойш кино, жүжигт ганц ч очоогүйг чинь мэднэ. Яагаад тэгснийг гадарлаж байна. Моника чи зүрхэндээ эмгэнэн гашуудаж яваа шүү дээ. Эдэлж хэрэглэдэг эд юм чинь бяцхан Моника чамайгаа магтаж сэтгэл дүүрэн байна. Үгүй, чи биднийг, төрсөн гэр орон, хотоо, төрөлх франц орноо худалдсангүй. Одоо чиний хийж байгаа чинь биднийг эрх чөлөөтэй, жаргалтай болгохын тулд хийж байгаа ажил шүү дээ!» гэж ятгах шиг санагдана. Ингэхэд хананд өлгөөстэй Жаннад д'Аркийн зураг Моникаг хараад ялдамхан инээмсэглэх шиг болно.

Сүүлийн үед Моника хайртай зургаа харахаас зайлсхийдэг болжээ. Жанна д'Арк, өөрийн нь зүрх сэтгэлийг дэндүү тодорхой мэдчих вий гэж айсны учир тэр. Зүрх сэтгэлдээ болж байгаа зүйлийг Моника өөрөөсөө ч нуухыг оролдоно. Жан ахыг нь өөр нэт макитай Гольдринг суллаж тавьсан тэр цагаас хойш Моника энэ офицерт өөрийн эрхгүй урьдынхаас нэг л ондоо хандах болжээ. Гольдрингт халуун дотно хандах болсон хэрэг ч биш. Чухам ямар шалтгаанаас тийнхүү суллан тавьсныг Моника мэдэхгүй байгаа шүү дээ. Ердөө л энэ хачин офицер Моникагийн сониуч занг хөдөлтөсөн байжээ. Энэ офицер чухам ямар хүн бэ, яагаад бусдаас этгээд ондоо авир араншинтай байна вэ? Бүсгүй тасалгаандаа орж ирээд түүний хэлсэн үг, хөдөлсөн хөдөлгөөн бүрийг нэгд нэгэнгүй эргэж санах. Үнэндээ энэ офицер бусадтай адилгүй юм. Энэ нь ямар нэг учир холбогдолтой хэрэг үү? Ямар ч байсан дайсан этгээд дайсан хэвээр байна шүү дээ. Эсвэл дайсан биш байвал яах вэ? Германчуудын дотор ч гэсэн аргагүйн эрхэнд үйл ажнллагаагаа нууж үзэл санаагаа ил хэлэхгүй байх хэрэгтэй болдог фашизмыг эсэргүүцэгчид бий шүү дээ. Тэгээд Генрих Моникатай өөртэй нь нэгэн адил фашизмын сөнөх сайхан өдрийг хүлээж байгаа байж болох бус уу? Тэр ч байтугай тэр өдрийг ойртуулахсан гэж хүсэж байгаа байж болох бус уу? Тэр нэгэн удаа Лебекийн бузар муухай хов захиаг уншуулах гэж Моникаг тасалгаандаа зориуд үлдээсэн нь ямар ч эргэлзээгүй ил шүү дээ. Бас Моникагийн найз нартай танилцахсан гэж онцлон цохож хэлснийг нь яана. Моникагаар дамжуулан макиудтай холбоо барихыг найдсан байж болох юм ... Гольдрингийн зан араншин нь аймшигтай хутган үймүүлэлт байж болно гэж Франсуагийн хэлсэн үнэн байвал яана? Моникаг үргэлж тийм сайхан дотно ялдамхан хардаг том хүрэн нүдэнд гестапогийн хорон санаа нуугдаж байна гэж үү? Гольдринг Лебекийн захиаг унших бололцоо олгосноор нэр дурдсан хоёр маки, тэдний гэр бүлийнхний амийг аварсан. Тэглээ гээд юу болох вэ? Эд нар урьдаар хоёр партизаны амийг өршөөж итгэл олж аваад сүүлд нь олон хүний амийг аваачихын тулд ингэсэн байж бүрнээ болох билээ. Үгүй, үгүй, тийм байх ёсгүй. Үйл явдлын шалтгааны холбоог бодоод үзэхэд ийм явдал тохиолдож болох боловч ерийн нэг учир шалтгаанаас илүү эрхэм дээд юм бас байдаг билээ. Жишээ нь зөн совин гэж байдаг. Тэгвэл Генрихийг гэмт хэрэг хийх юм уу, урван тэрслэх хүн биш гэж Моника зөн совингоороо мэдрээд байна. Тийм шүү, зүрх сэтгэлийн учир шалтгаан гэж бий! Моника ингэж бодоод толгойд нь ийм бодол төрснөөс өөрөө хирдхийв. Эсвэл Моника энэ дайсны цэргийн офицерт сэтгэлтэй болж орхив уу? Энэ офицерын толгойг эргүүлэх гэж байж өөрөө дурлаж орхив уу? Өөрөө өөрөөсөө нуулгүй, үнэн голоор нь бодоод үз. Үүнийг чинь хэн ч мэдэхгүй, ганц өөрөө л мэдэх шүү дээ ... Генрихийг загалмай одонгоор шагнуулсан өдөр үдэшлэг дээр хүүхнүүд авчирсныг мэдээд эвгүй санагдсан нь үнэн шүү дээ ... Бас Гольдрингийг буудаж алчихгүй байгаарай гэж макиудад сануулж хэлэхээр Франсуаг амлахад баярласан шүү дээ. Гольдрингийг Лион орохоор явахад нь тэндхийн партизанууд юу ч мэдээгүй учир түүний төлөө сэтгэл зовж байсан нь үнэн. Генрихийг Мюнхен орж, хуурай охин дүү нэртэй байлаа ч гэсэн залуу бүсгүйтэй нэг гэрт сууна гэж бодохоос тэсэшгүй гашуун гунигтай санагдаж байсан. Тэгэхлээр Моника Генрихийг жөтөөрхөх болж, амь насны нь төлөө санаа сэтгэл зовж, буцаж ирээсэй гэж хүлээж байтаа хэрэг байна Аяа, энэ яасан аймшигтай, яасан сэтгэшгүй, яасан байж болшгүй хэрэг вэ! Моника босон харайж, цонхны дэргэд гүйж очоод цонхоо цэлийтэл онгойлголоо. Энэ юу

вэ? Танил машин байна! Бүсгүйн зүрх хүчтэй цохиллоо. Генрих одоо машинаасаа гарч ирээд зочид буудал руу алхална, Үгүй, штаб тийш эргээд үүдэнд нь хүрч, дотогшоо орчихлоо ... Моника суудалдаа алгуурхан суухад царай нь тайван боловч арай дэндүү цайвар юм шит. Айсандаа нүд нь их болж, зүрх аь шимшрэн өвдөх шиг боллоо. Үнэхээр Моника германы офицер, дайсан этгээдэд сэтгэлтэй болчихжээ. Энэ бүхний тухай хэндээ ярилтай вэ? Хэнээс зөвлөлгөө авбал зохих вэ? Эхээсээ юу? Үгүй дээ, эх нь зөвлөлгөө өгч чадахгүй. Жаныг суллаж тавьснаас хойш эх нь Генрихийг бүүр энхрийлэн хайрлах болсон хүн. Тэгвэл Франсуатай зөвлөх үү? Үгүй, яасан ч тэгэхгүй. Ийм сэтгэлтэй болсныг нь өөр хүн мэдчихвэл Моника ичиж үхнэ. Андре ах байхгүй нь харамсалтай.

Моника ингэж элдвийг эрэгцүүлэн бодох зуур Жанна д'Аркийн зураг өөд царайчилсан мэт харсан боловч Орлеан нутгийн бүсгүй хариу дуугарсангүй. Жанна д'Арк бүсгүйг буруушаасан мэт ширүүн харна. Тэгэхэд нь Моника дэрэн дээрээ нүүрээ даран унаад өөрийн эрхгүй мэгшин уйллаа. Моника энэ дэлхийн бүсгүй хүн бүрийн адил хайр дурлал бол асар их жаргал гэж итгэдэг байжээ. Гэтэл хайр дурлал гэдэг зовлон байж ч болох юм байна. Их гаслан зовлон байж болох юм байна. Өөрт нь гашуун зовлон учруулж байгаа тэр хүн хэдхэн хоногийн дараа магнай руугаа сум зоох уу эсвэл хэдэн минут хүлээх үү? гэдэг асуудал шийдвэрлэх болно гэдгийг Моника мэдсэнгүй. Мэдэх ч арга байсангүй. Лютц Гольдрингийг үнэхээр баярлан угтаж: — Генрих та эргэж ирсэн нь яасан сайн хэрэг вэ. Би таныг их үгүйлж байлаа гэж дуу алдахад нь — Би ч гэсэн Карл таныг саналаа. Би ганц тантай л илэн далангүй энгийн нэг ярьж чадах юм гэхэд — Бид хоёр чинь сэтгэлтэй болсон хоёр шиг сүйд майд болж уулзах шив. Генерал хүлээж байгаа. Генерал хэдэн удаа таныг ирсэн үү гэж сурагласан гэлээ. Генерал Эверс Гольдрингийг үзээд үнэхээр баярлаж: — Миний найз генерал Бертгольдын лагшин тунгалаг уу? гэж асуухад нь — Их сайн байгаа. Танд чин сэтгэлийн баяр хүргэж, эрүүл энх ажлын амжилт хүсээрэй гэж тушаасан гэсэнд — Их баярлалаа. Берлин. Мюхенээр сонин сайхан юу байна? гэв. Генрихийн үзсэн сонссон бүх зүйлийн тухай яриаг генерал төдий л анхаарамжгүй сонсоод шууд ажил явдалд орж: — Үнэнээ хэлэхэд таны буцаж ирэхийг тэсэж ядан хүлээж байлаа. Юу вэ гэвэл бусдад амархан нүүр тал олж чаддаг ганц бароны таны л гүйцэтгэж чадах нэг эгзэгтэй ажил гараад байна гэхэд нь — Та миний хир чадлыг арай хэтрүүлж байна даа, эрхэм генерал аа гэсэнд — Хумсын чинээ ч хэтрүүлээгүй. Манай дивизийг одоо болтол ар талынх гэж үзэж ирснийг та бэлхнээ мэднэ. Ийм учраас фронтын ангиудын зэвсэглэлд хэдийн очсон шинэ автомат зэвсэг манай энд ирээгүй байгаа юм гэж эхлэн ярихад нь Генрих анхааралтай сонслоо. Генерал үргэлжлэн ярьсан нь: — Одоо байдал өөр болж байна. Англи улс хоёрдугаар фронт нээхээр хурдавчлан бэлтгэж байна гэсэн мэдээ бий. Үүнтэй холбогдуулан арынх гэгдэж байсан манай дивизийг ч хүч зузаатгаж байна. Манай дивизийг шинэчлэн зэвсэглэх тушаал нэгэнт гарсан. Бид тэр зэвсгийг хийдэг Бонвилийн хуваарилах хэсгээс зэвсэг авах наряд авсан. Тэр зэвсгийг юуны өмнө фронтод явуулж, зөвхөн илүүдлийг бидэнд өгч байгаа нь ойлгомжтой хэрэг. Би тэр шинэ зэвсгийг аль болохуйц хурдан олж аваад хурдан зуур эзэмшин сурч. Хэрэв хэрэг явдал гарвал англи, америкчуудад Дюнкеркийн 16 тэндэх шиг юм дахин болгож өгөхийг хүсэж байна. Та миний хэлсэнийг

ойлгож байна уу? — Сайн ойлгож байна. — Таны үүрэг гэвэл манай дивизид зэвсэг ачуулах ажлыг хурдатгах хэрэгтэй юм. Та үүнийг ямар ч атугай үнээр гүйшэтгэх хэрэгтэй. Ийм ажилд шаардагдах баримт бичиг, мөнгийг би нэгэнт бэлтгэсэн. Таныг маргаашийн дотор явна уу гэж хүсэж байна. Ойлгов уу? — Ойлголоо, эрхэм генерал аа. Зэвсгийг илгээхэд бэлэн болсны дараа хэн дагалдах ёстой вэ? — Та тэр тухай корпусын холбоогоор нэн даруй мэдэгдээрэй. Бидний яриаг завсраас чагнаж магадгүйг харгалзах хэрэгтэй. Тэгэхлээр та янжуур худалдаж авсан, жишээ нь зуун хайрцаг хэрэгтэй гэж мэдэгдэхээр болзож таарья. Энэ бол зэвсэгт олсон, хамгаалалтын зуун хүн ч юм уу, та өөрөө хэдий хир хэрэгтэй гэж үзвэл тэр тоогоо хэлсэн хэрэг болно. Та ачаалалтыг хянаад тэр цуваагаар ирэх буюу машинаар ирж болно. Тийшээ өөрийн машинаар явах юм байгаа биз дээ? — Тиймээ. — Тэгвэл жолоочоос гадна хоёр цэргээр хамгаалуулж явбал таарна. — Би бол тэгэхгүй байх зөвшөөрөл хүсмээр байна. Хамгаалалт их болох тусам францын партизанууд намайг хурдан анхаарах болно. — Таны зөв. Бонвильд очоод болгоомжтой байгаарай. Тэнд макиуд их идэвхтэй байгаа гэж генерал сануулав. — Маргааш гарах уу? — Өнөөдөр замын алжаалаа гаргаж амраад бэлтгэлээ хийж, маргааш өглөө замд гар. Танаас сэтгэл тайвшруулах мэдээ нэн удахгүй хүлээж авах биз гэж найдаж байна. — Боллоцоотой бүхнийг хийе, эрхэм генерал аа!

Эверсийн даалгавар Генрихийн өөрийн нь төлөвлөгөөтэй яв цав таарсан учир жаахан айх шиг болов. Тэгээд юмаа чемоданд хийж байх зуур: Би нэг л азтай байх чинь. Азын тэнгэр гэдэг адтай билээ ... Замын турш яасхийгээд Бонвильд очъё гэж бодол болж явсан чинь харин одоо намайг чухам тэр Бонвильд явуулж байна. Тэнд надад ямар даалгавар өгөх юм бол? ... Бодвол их ноцтой ажил байгаа байх. Эс тийм бол урьдаас сануулахсан ... Нэг бол намайг эртнээс сэтгэл нь бүү зовог гэсэн байх эсвэл нөхцөл байдлыг судалж байгаа байх ... Ямар ч гэсэн хамгийн хэцүү юм болно гэж бэлэн байх хэрэгтэй юм ... гэж боджээ. Генрих тасалгаан доторхи зүйлээ анх удаа ... бас эцсийн удаа харж байгаа юм шиг тойруулан харав. Энд эргэж ирэхгүй ч байж мэднэ. Моникатай дахиад хэзээ ч уулзахгүй байж мэднэ ... Моника өөрийн нь дэргэд анд нөхөр ажиллаж байсныг хэзээ ч мэдэхгүй өнгөрнө. Генрихийн өнөөдөр үг цухуйлгах гэж байгаа зүйлийг хүртэл штабын залуу офицерын болгоомжгүй үг алдсан чалчаа яриа гэж үзээд хэл амыг нь ийм амархан татаж чадсандаа бахархах болно ... Моника яагаад ирэхгүй байна вэ? Түүнийг Курт олсонгүй юу? Эсвэл гэртээ алга байна уу? Тэгвэл одоо яадаг билээ? Генрих ямар зорилгоор явах гэж байгаагаа Моникад дуулгахгүйгээр явах арга байхгүй. Генрих тэр зэвсгийг зохих газар нь хүргэе гэж огт бодохгүй байгаа шүү дээ ... Өөрөө Моникаг эрдэг хэрэг үү? Генрих доош буух гэж байтал хаалгыг нь хүн тогшлоо. Моника мөн! Ганц Моника л ингэж гурван удаа ойрхон дайтай аяархан тогшдог. Тасалгаанд үнэхээр тэр бүсгүй орж ирлээ. Царай нь шаналсан байдалтай, нүд нь улайсныг Генрих даруй ажиглаад сэтгэл түгшиж, өрөвдөхдөө зүрх нь базаллаа. — Моника ... та уйлаа юу? Юу болоо вэ? гэж Генрих сэтгэл зовнин асуугаад бүсгүйн гарыг тавилгүй атгаж, нүдийг нь харахыг хичээв. Моника харцаа буруулаад, — Үгүй чиш. Сая би ээжид шанцай хийхэд нь тусалсан юм. Сонгино хөшиглөөд нүд улайж орхилоо ... — Өө яасан шальгүй юм бэ. Уг нь би бол уйлсандаа улайсан байгаасай гэж хүсэхсэн. Би дахиад явах гэж байна шүү дээ ... Бонвильд ер нь нилээд удах байх. — Бонвильд оо? гэж

бүсгүй асуугаад гар нь чичрэхийг Генрих мэдрэв. — Та юуг нь гайхаа вэ? — Зүгээр ээ, би нэг ... Тэнд миний үеэл эгч байдаг юм л даа ... — Танай тэр эгч тийм хүн аймаар амьтан юм уу? — Түүнээс бишээ, макиудаас ... Үеэл эгч хоёр хоногийн өмнө манайд айлчилж ирэхдээ тэнд байдал тун түгшүүртэй байгаа гэж ярьсан. — Тэгээд юу гэж? — Зүгээр л танд сануулах гэсэн юм. — Баярлалаа. Та их сайхан сэтгэлтэй бүстүй байна ... Ингэхэд байна шүү, та бас Бонвиль орж үеэл эгчтэйгээ уулзвал яасан юм бэ? Таныг машинаар тийш нь хүргээд буцаагаад аваад ирж болох байна ... — Хаанаас даа. Ээжийг яаж орхих вэ. Ажил гэж жигтэйхэн ээж гав ганцаархнаа. — Тэгвэл байна шүү, ингэе. Би зэвсгээ ачуулмагц ... — Зэвсэг ээ? Ямар зэвсэг? гэж Моника гайхав. — Ээ би ам алдчихлаа. Штабын офицер хүн байж захын авгай нар шиг хэл амаа билүүдэх юм даа, би! гэж Генрих өөртөө дургүйцсэн байдалтай дуугарсанд — Тэгвэл нууц юм уу? Та тэгээд намайг нууц задруулчих вий гэж айгаад ... гэхэд нь — Үгүй, үгүй, танд итгэж байна. Энэ тухай санамсаргүй үг алдаж хүнд хэлэхгүй байхыг туйлаас гуйя. Эс тэгвэл тэр зэвсэг манай дивизид ирж чадахгүй, макиудын гарт орчихно. Макиуд сүүлийн үед зэвсэг их сонирхох болоод байгаа. Даан ялангуяа автомат зэвсэг юм гэдгийг мэдчихвэл... Тэр зэвсгийг хэзээ явуулахыг ганц би л мэдэх юм ... Үгүй, ингэхэд та бид хоёр юу яриад ойчив оо, энэ ер нь таны чих шиг ийм жижигхэн ягаан чихэнд зохимжтой яриа огт биш ... За тэгээл Бонвильд очих тухай юу гэж шийдэх вэ? гэсэнд Моника эргэлзэсхийж, — Мэдэхгүй байна, явж магадгүй ... Людвина эгч их баярлана л даа гэхэд нь — Тэгвэл болзож тохирлоо. Миний ажил шувтрах тийшээ хандмагц танд утас явуулж, галт тэрэгний буудал дээр угтъя гэсэнд — Би ялангуяа намайг таних хүнгүй Бонвильд герман офицертой хамт явж харагдахыг хүсэхгүй байна. — Намайг герман хүн гэж миний нүүрэн дээр бичээстэй байгаа биш. Таныг очихоос наана энгийн хувцас олж авна гаж амалья. Бонвиллоос бид машинаар хамт буцъя ... Ингэж тохирох шив дээ? гэсэнд бүсгүй тийм их шийдмэг бишээр: — Тохирлоо. Танаас утас ирэхийг хүлээж байя. Одоо замдаа сайн яваарай гэж хэлжээ. Маргааш өглөө нь Сен-Ремийнхнийг унтаагаар Генрих, Курт хоёр Бонвиль орохоор гарав. Генрих цагт ерэн километр хурдтай явбал зорьсон газраа үдийн хирд хүрнэ гэж боджээ. Курт машинаа хурдлуулж хурдын хэмжүүр зуу давах нь олон байлаа.

«Би ийм замыг хаана үзлээ дээ?» гэж Генрих дурсан санах. Иймэрхүү газрыг нэг л үзсэн шиг санагдана. Үлгэрт гардаг үлэмж биетэнийг энд тэнд тараагаад хаячихсан юм шиг, хоорондоо нэг нуруу болж нийлээгүй уулс үзэгдэнэ. Уулс бие биеэс сондгой сүйдэрлэж, завсраар нь өтгөн өвс ногоо ургаж, түүний дундуур өргөн биш боловч түргэн урсгалт, нулимс мэт тунгалаг уст уулын горхи шоржигносон нуга үргэлжилнэ. Доор өтгөн ой мод ургаж уул өөд өгсөх тусам улам нэг хэвийн намхан модод болно. Мөн . эргэн тойрон ой модоор хүрээлэгдсэн алгын чинээ чөлөө газар гэнэт үзэгдэнэ. Генрих дайнаас өмнөхөн Станиславаас Ярем ч орохдоо чухам ийм замаар явсан юм. Түүнээс хойш хичнээн их удаа вэ ... Генрих өөрийн бодлыг сэм мэдчих вий гэсэн шиг Курт өөд сэжигтэй харав. Курт машины жолоог чанга атгаад алсыг анхааралтай ширтэн суужээ. Сэрүүвтэр байсан боловч Куртийн нүүрний хөлс бурзайсан байлаа. Жолооноос өрөөсөн гараа ч салгахыг айхдаа ам руугаа урсаж ирсэн хөлсийг зайлуулах гэж тургина. — Аль вэ, чи хэсэг амар гэж Генрих хэлээд жолооны ард суулаа. Ингэвэл дээр байж.

Мурилзсан зам их анхаарал шаардаж. элдэв юм бодож байх завгүй болно. Энэ нь гол байлаа. Генрих чухам өнөөдөр урьд урьдынхаас сэтгэл уужуу тайван байх ёстой Генрих дөнгөж очсон даруйдаа өнөөдрийн дотор биелүүлбэл зохих даалгавар авч ч магадгүй билээ. Зам улам хэцүү булан тохой улам олон болоон тул нэг үе эгц өөд анирч, нэг үе машинаа тоормослон уруудаж. хурдаа байн байн солих хэрэгтэй болов. Бонвильд оройн таван цагт л хүрч ирлээ. Герман офицеруудад зориулсан зочид буудалд жижүүрийн хэлснээр бол хоёр хүний сул өрөө байсангүй. Гэвч бичиг баримтынхаа завсар томхон дэвсгэрт хавчуулаад өгтөл байдал даруй өөрчлөгдлөө. Таван минутын дараа Генрих, Курт хоёр усанд орохоор бэлтгэв. — Чи түрүүлээд усанд ор. Дараа нь эндхийн аль сайн зоогийн газар хаана байгааг мэдээд ир гэж Гольдринг жолоочдоо тушаав. Өөрт нь өгөх даалгавар Бонвильд ирмэгц тодорхой болно гэж Гольдрингийн бодсон нь ташаарсангүй. Куртийг зоогийн газар эрж явах хооронд энд хичнээн аюултай байдал бий болсныг Генрих завдан мэдэж авлаа. Юу вэ гэвэл Альпийн нурууны хормойд байдаг Бонвиль болон энэ хавийн бүх район, Францын зүүн өмнө зүгт партизаны хөдөлгөөний өвөрмөц төв болсон байжээ. Гестапо партизануудтай удаан хугацааны турш ширүүн тэмцсэн боловч ямар ч үр дүнгүй өнгөрчээ. Харин их төлөв орон нутгийн гэм зэмгүй ард иргэдийг хэрцгий догшин нухчин дарсан нь партизануудын эгнээг улам нэмэгдүүлсэн байна. 1942 оны хоёрдугаар сарын эхээр хэний ч санаанд ороогүй нэг явдал болж, нууц байгууллагын идэвхтэй гишүүний нэг бөгөөд түүний шилдэг холбоо баригч, бүхний хайрыг татсан хөгжилтэй сэргэлэн, хурц үгтэй Дежене гэдэг хүн урвагч этгээд байсан нь илэрчээ. Хорлон сүйтгэх ажлыг олон удаа өөрөө санаачлан үүсгэж, хамгийн нарийн төвөгтэй даалгаврыг гүйцэтгэхээр биедээ дуртайяа хүлээж авдаг байсан Деженег урвагч этгээд гэхэд анхандаа үнэмшмээргүй байлаа. Гэтэл эсэргүүцлийн хөдөлгөөний гурван удирдагчийг баривчилсны дараа Дежене багаа хуу татаж хаяад таван жилийн өмнө гестапогийн даалгавраар Бонвильд Парисын ажилчны дүрээр ирэхдээ тайлсан СС-ийн офицерын дүрэмт хувцсаа дахин өмсчээ. Ингэж хутган үймүүлсэн явдал партизаны хөдөлгөөнд асар ихохирол учруулж олон идэвхтэн оролцогчид баривчлагдсан боловч байгууллагыг бүрмөсөн ниргэж хараахан чадсангүй. Эсэргүүцлийн хөдөлгөөний баригдаагүй үлдсэн удирдагчид уулзалтын байр, хөдөлгөөнд оролцогч олон хүний хаяг, нэр овог, байх газрыг түргэн зуур сольж өөрчилжээ. Деженег партизанууд алхах бүрд нь отон гөрөөлөх болов. Дежене одоо өөрийнхөө жинхэнэ нэрээр Вилли Мейер гэж нэрлэж явах болжээ. Хутган үймүүлэгч Дежене-Мейерийг илэрсний дараа эхний долоо хоногийн дотор түүнийг тав дахин буудсан байна. Үүнд түүнийг гудамжинд отож, энэ завсар гурван удаа сольсон байранд нь отож эцэст нь зоогийн танхимд хоол зөөгч эмэгтэй, Мейерийн цээж рүү хоёр сум зоожээ. Хүнд шархтсан Мейерийг Бонвиллоос цэргийн нэг эмнэлэгт аваачснаас хойш хэдэн сар түүний тухай сураггүй байлаа. Гэвч Дежене-Мейер гестапогийн шинэ дарга хурандаа Гартнерийн туслагч болоод Бонвилийн гудамжинд дахин үзэгдэх болсонд орон нутгийн партизануудын гайхсаныг хэлэх үү! Тэр хутган үймүүлэгч этгээд эсэргүүцлийн хөдөлнөөнд оролцогч олон хүнийг зүс таньдгийг бүгд мэднэ. Тэгээд одоо хүртэл сонин тараагч, ногоо, сүү худалдагчийн дүрээр хотын гудамжаар сэтгэл амар явдаг байсан партизанууд хутган үймүүлэгчийн нүдэнд өртөхгүйн тулд нуугдах хэрэгтэй болжээ. Үүний дээр хурандаа Гартнерийн өөрийн нь үйл ажиллагааны улмаас үүссэн бэрхшээл нэмэгдсэн байна. Тэр бол хамгийн

нарийн ярвигтай газар илгээж байдаг гестапогийн хуучин хашир туршлагатай ажилтан байжээ. Гартнер ирсэн даруйдаа хөл хорих цагийг хүчингүй болгож, шөнө эргүүл хийхийг зогсоож дэглэмийг ийнхүү зөөлрүүлснээрээ бага сага нэрд гарсан байна. Гартнер олон хоригдлыг шоронгоос сулласны дотор жинхэнэ эрүүгийн гэмт хэрэгтэн цөөнгүй байжээ. Тэдний олонхийг Гартнер хахуульданд элсүүлж авсан байлаа. Хэдэн өдрийн өмнө Берлинд Гартнерийн явуулсан мэдээг партизанууд зуураас нь олж авч чаджээ. Гартнер мэдээндээ эсэргүүцлийн хөдөлгөөний томоохон удирдагчдыг хамгийн ойрын хугацаанд устгахаар амлаад германы армийн өөрийн нь эгнээнд байгаа нэг нууц байгууллагын мөрийг илрүүлж чадсан гэж цухуйлгасан байлаа. Хурандаа өөрийн туслагч Мейерийг магтаж түүний тусламжтайгаар партизаны хөдөлгөөнд оролцогч томоохон хүмүүст нууц ажиглалт тавих болсныг дурджээ. Гартнер маш хашир болгоомжтой хөдөлж байлаа. Макиуд гестапогийн байшинг тэслэх гэж амжилтгүй оролдсоноос хойш Гартнер чухам хаана ажил хийдэг болсон нь мэдэгдэхээ байж, гадагш гарахдаа заавал автомат буутай гестапогийнхныг дагуулахын хамт нөгөө Дежене-Мейерийг дэргэдээсээ төө ч холлуулахгүй дагуулж явдаг болжээ. Гартнер өдөр шөнөгүй харуул хамгаалалттай байдаг офицеруудын «Савойя» ресторанд хооллодог байв. Гартнер, Мейер хоёрыг аль болох хурдан устгах хэрэгтэй нь тодорхой байлаа. Тэр хоёр партизаны удирдлагын бүх штабыг илрүүлж магад гэж үзэх бүхий л үндэстэй байжээ.

Генрих элдвийг бодож суусаар жолоочийнхоо эргэж ирснийг ч мэдсэнгүй. — За Курт ээ, сонин юутай вэ? — Хүн бүгд офицеруудад зориулсан «Савойя» рестораныг хамгийн сайн гэгцгээж байна. — Эндээс хол юм уу? — Зэргэлдээх гудамжинд юм. Арван минутын дараа Гольдринг тэнд очсон байлаа. Рестораны эзэн нь урьд франц хүн байсан боловч хуучин эзнийг нь саявтар баривчилж, рестораныг гитлерийн тахир татуу хүнд шилжүүлжээ. Харуул манаа зогссон орох хаалганы нь дээд талд «Зөвхөн германы офицерууд орж болно» гэсэн бичиг байхыг Генрих үзэв. Эрэгнэгийн лангууны ард үсээ хуссан, шар сахалтай бүдүүн хүн байхыг хараад — Рестораны эзэн нь таныг мөн болов уу гэж найдаж байна гэсэнд — Яг тиймээ, эрхэм ахлах дэслэгч ээ. Би рестораны эзэн Швальбе байна гэж тэр хүн цэргийн дүрмээр хариулав. — Эрхэм Швальбе! Би дөнгөж саяхан ирсэн хүн. Танай рестораныг энэ хотын хамгийн шилдэг ресторан гэж дуулж амжлаа. Та намайг хоёр гурван долоо хоног эндээ хооллохыг татгалзахгүй болов уу гэж найдаж байна. — Аа, дуртайяа зөвшөөрнө. Миний рестораныг сайн гэж хэлсэн хүн эндүүрээгүй гэдгийг батлах байна. — Тэгвэл танилцахыг зөвшөөрнө үү. Би ахлах дэслэгч барон фон Гольдринг байна. — Ийм өндөр хэргэм зэрэгтэй зочинд баяр хүргэх завшаантайдаа баярлаж байна. — Бид танилцсаны баярт нийлүүлэн нэг нэг хундага сайн дарс увал зүгээр бус уу? гэж Гольдринг санал болгосонд — Нэр төртэй хэрэг гэж үзнэ гээд Швальбе шүүгээ тийш догонцон очив. Түүний зүүн хөл нь модон хөл ажээ. Рестораны эзэн нэг лонх дарс цар дээр тавиад Генрихийн сууж байгаа ширээний дэргэд очив. Генрих халааснаасаа нэг хайрцаг сайн гавана навчин янжуур гаргаж ширээн дээр тавихад — Оо-ёо, яасан мундаг эд вэ. Одоо ёстой гавана янжуур олж татах нь ховор болжээ гэж Швальбе дуу алдан магтахад нь Генрих нэгийг асааж аваад бусдыг нь Швальбед өгч, — Та ав. Би ийм тамхи олж чадна, Сен-Ремид миний суудаг зочид буудлын эзэгтэй олон жил хүрэх ийм тамхи нөөсөн юм билээ гэсэнд — Энэ чинь надад

маш сайхан бэлэг боллоо. Та тэгээд манай энд хир удах вэ? — Хоёр-гурван долоо хоног юм уу сар ч болж магадгүй гэж Генрих хэлээд хундага өргөхөд — Швальбе бас хундагаа өргөлөө — Таны эрүүл мэндийн төлөө! гэж Генрихийг ерөөхөд — Бидний танилцсаны баяр! гэж Швальбе мэхийн ёслоод, Эрхэм барон та хоолоо өөрөө захиалах биз. Ширээ юм уу, тусгай өрөөг өөрөө шилж аваарай гэхэд нь — Би тусгай өрөөнд хооллох дуртай юмсан. Та завтай бол өрөөг одоо үзмээр байна гэсэнд — Эрэгнэгийн цаад талын хаалгаар орно уу гэлээ, Генрих рестораны эзнийг даган явсаар баруун, зүүн хажуугаараа олон хаалгатай урт гудамд хүрч ирэв. — Ийшээ орж болох уу? гэж Гольдринг асуугаад нэг хаалганы бариулаас татсанд — Энд болохгүй, энэ өрөө өдөр бүр хоёр цагаас дөрвөн цаг хүртэл эзэнтэй байдаг. Энд хурандаа Гартнер, туслахтайгаа хооллодог юм. Та өөрөө хэдэн цагт хооллож байх вэ? — Яг нэг цагт. Гэвч би яаруу хооллож сураагүй. Тэгэхлээр энэ өрөө надад таарахгүй гэсэнд — Тэгвэл өөр нэгийг үзнэ үү гээд рестораны эзэн Гартнерийн хооллодог өрөөний өөдөөс харсан хаалгыг нээхэд нь Гольдринг тэр баян тансаг тавилгатай өрөөг тойруулж хараад — Энэ өрөө надад таарна гэлээ. Генрих маргаашийн хоол захиалчихаад зочид буудалдаа эргэн ирж, оройжин гэртээ байх зуур худалдаж авсан сонингоо унших гэхээсээ өөрийн цаашдын ажиллагааны төлөвлөгөөг бодож боловсруулав ... Гольдринг маргааш өглөө нь шинэ автомат зэвсэг хуваарилах ажил эрхэлсэн офицер дээр очив. Тэр офицер Генрихийн яриаг сонсоод нарядыг ч харалгүй уг захиалгыг биелүүлж болох хугацааг ядаж ойролцоогоор ч хэлж чадахгүй байна гэж хариулжээ. Харин гар цайлгана гэсэн үг цухуйлгахад нөгөө халгаахгүй байсан офицер жаал зөөлрөв. Тэгэхэд нь Гольдринг тэр офицерын ард нэг баглаа шинэхэн мөнгө шулуухан гаргаж тавиад энэ бол зөвхөн урьдчилсан шан гэж хэлсэнд тэр офицер их л эелдэг сайхан зантай болж, — Хоёр долоо хоног хүлээвэл танд хугацаа нь хэтэрхий удаадахгүй болов уу гэж найр тавин асуухад нь — Яг таарах хугацаа байна гэж Генрих хариулав. Гольдринг тэр офицертой ярьсны дараа хагас цаг болоод генерал Эверст утасдаж, «янжуурыг» хоёр долоо хоногийн дараа худалдан авч чадах магадгүй гэж сануулсанд генерал маш их баярлаж, Шагнал өгнө! Дахиад заавал шагнал өгнө. Барон танд батлан хэлье гэж харилцуураар хашгирч байлаа.

Гольдринг өдрийн яг нэг цагт ганц ч минутын зөрөөгүй ресроранд хүрч ирлээ. Улирах цагийн эргэлтийн ул мөрийг эс гэхэд залуу насаа зоогийн газраар хэсэн наргиж өнгөрүүлсний ул мөрийг зузаан будаг, оо энгэсгээр халхлахыг хичээсэн герман хүүхэн хоол зөөж үйлчлэнэ. Гольдринг тэр хоол зөөгч хүүхний санаанд нийлүүлэн хоёр гурван үг хаясанд хүүхэн ам хамхилгүй эдвийг ярьж, ганцаардаж байдгаа цухуйлган илт наалинхай зан гаргалаа. Эцэст нь тэр зөөгч хүүхнийг сав суулга хурааж аваад гарахад нь Генрих хонгил тийш гарсан хаалгыг ялимгүй онгойлгоод шарз алгуурхан шимэн суув. Хоёр цагт арван мииут дутуу байхад гестапогийн хоёр хүн Гартнерийн хооллодог өрөөнд ороод нэг минутын дараа гудамд гарч ирэв. Эсрэг талын хаалга онгорхой байхыг тэд ажиглаад хаалга тогшиж зөвшөөрөл авалгүй орж ирлээ. Яагаад чөлөө зөвшөөрөлгүй хамаагүй орж ирэв? гэж Гольдринг уурсан асуусанд — Эрхэм ахлах дэслэгч таны бичиг баримтыг бид шалгах үүрэгтэй юм гэж ахлах цолтой бага дарга нь хэллээ. Генрих офицерынхоо үнэмлэхийг тоомсоргүй гаргаж ирээд ширээн дээр чулуудсанд бага дарга

эхний хуудсыг анхааралтай уншиж үзээд — Аа, эрхэм барон та уучлаарай. Бид аргагүй ийм үүрэгтэй юм гэж хүндэтгэлтэн өгүүлээд үнэмлэхийг буцааж өглөө. — За сайн. Би хоёр долоо хоногийн турш яг энэ цагт энэ өрөөнд хооллоно гэдгийг бодолцоорой гэж Генрих өгүүлсэнд — Бололгүй яах вэ. Энэ чинь бидэнд илүү тохиромжтой байна гэж бага дарга хариулжээ. Яг хоёр цагт бөгтөр нуруутай хурандаа Гартнер өөрийн туслах, өөр хоёр гестапогийн хүнийг дагалдуулан орж ирлээ. Генрих хэдэн минут суугаад гадагш гарав. Маргааш өдөр нь мөн энэ бүгд дахин давтагдлаа. Хоёр цагт арван минут дутуу байхад нөгөө хоёр гестапогийн хүн байрыг үзээд гарав. Бага дарга нь Гольдрингийн суугаа хаалгыг нээснээ Гольдрингт ёслоод гарлаа. Яг хоёр цагт нэг ч минутын зөрөөгүй хурандаа өөрийн бие хамгаалагч нар болон туслахаа дагуулан оров. Хоол зөөгч хүүхэн энэ удаа ширээний дэргэд удтал эргэлдсэн боловч Генрих түүнд царай өгсөнгүй. «Энэ хүүхнийг өрөөнд удаан саатдаггүй болгож сургах хэрэгтэй юм» гэж Генрих боджээ. Генрих энэ өдөр хоолоо удаан идэв. Гурван цагт гудамд гарахад нь Гартнерт амтат зууш оруулж яваа харагдлаа. Ийм байдалтай таван хоног өнгөрөв. Зургаадах өдөр нь Генрих үүр цайхаас өмнө сэрээд дахин унтаж чадсангүй. Өнөөдөр болох ёстой явдлыг бодохгүй, сэтгэлээ элдвээр самууруулах гэж оролдоод нэмэр болсонгүй. Тэгээд Куртийг сэрээхгүйн тулд орноосоо аяархан өндийж, дотуур цамцныхаа дотор талд жижигхэн уут оёлоо. Тэр уутанд жижиг гар буу нь уужуухан багтав. Генрих жижиг гар буугаа уутанд дахин дахин хийж, гаргаж үзэв, маш тохиромжтой болсон байлаа. Буугаа гаргаж завдах болно. Моникад зурвас бичээд Куртгээр өгүүлдэг юм бил үү? Генрих хэдэн мөр юм бичсэнээ тэр дороо урж хаяв. Илэрч баригдахад хүрвэл тэр бүсгүйд үүнтэй үүнгүй олон эвгүй явдал тохиолдоно. Моникаг согтуу цэргүүдээс Генрихийн яаж өмөөрч хамгаалсныг Миллер үзсэн шүү дээ. Тэгвэл энэ нь тэр бүсгүйгээс өө сэв эрэхэд хангалтай шалтаг болно. Курт сэрлээ. — Манай машин бүрэн бүтэн үү? гэж асуусанд — Бүрэн бүтэн гэв. — Өнөөдөр хоолны дараа гадуур явж магадгүй. Машинаа бэлэн байлгаарай гэж Генрих тушаав.

Генрих яг нэг цагт ресторанд очлоо. Түүнийг ороход Швальбе эрэгнэгийн дээрх том цагийг хараад — Барон таны ирэхээр цаг шалгаж болох юм байна гэсэнд — Цаг чинь зөв явж байтаа юм уу? гэв. — Өдөр болгон радиогоор шалгаж тааруулдаг юм. — За би хоолоо идэх боллоо. Генрихийг өрөөнд дөнгөж ортол хоол зөөгч хүүхэн гүйж ирлээ. Хүүхэн урьдын адил Генрихийг загас идэж дуусахыг хүлээн дэргэд нь зогсоод байхаар — Та зоориноос шууд авчирсан дарсанд дуртай юу? гэж асуусанд — Маш дуртай гэв. — Танайд тийм дарс байвал надад нэг лонхыг авчирч өгнө үү. Тоосыг нь битгий арчаарай лонхыг нь энд авчраад онгойлгоорой гэсэнд — Аа би дарс яаж барихыг мэдэлгүй яах вэ гэж зөөгч хэлжээ. Генрих тэр яршигтай авгайгаас арайхийж саллаа. Хүүхэн удахгүй эргээд ирнэ. Иймд яарах хэрэгтэй болов. Генрих халааснаасаа хоёр төмөр сэртэнтэй жижиг мина гартаж ирээд тэслэх оньсны нь цагийн зүүг коёр цаг гучин таван минут дээр тааруулаад гудамд гарав. Энэ үеэр тэнд хүн байсангүй. Генрих агшин зуур Гартнерийн хооллодог өрөөнд орж, минийг ширээний хавтангийн доод талд хэдхэн секундйн дотор бэхэлж амжлаа. Хоол зөөгч хүүхнийг лонхтой дарс барьсаар аахилан гүйж ирэхэд Генрих загас идээд тайван сууж байв. Хоёр хундага дарс уусны дараа зөөгч хүүхэн урьдынхаас бүүр ч илүү наалинхай зантай болов. Генрих тэр хүүхнээс салахын тулд хотоос гадагш машинаар хамт зугаална гэж амалжээ. Гольдринг хоолоо яаралгүй

идэв. Нэгдүгээр хоолоо идэж дуусах үед нь хоёр цагт арван таван минут дутуу байлаа. Дахиад таван минут өнгөрсөн боловч Гартнерийг ирэхээс өмнө ирж шалгадаг гестапогийн хоёр хүн ирээгүй л байлаа. Тэд нар хоёр цаг ч ирсэнгүй, хоёр цаг арван таван минутад ч ирсэн Генрих хоолоо идэж дуусаад шарз ууж суухдаа амтыг нь огт мэдэхгүй байлаа. Гартнер өнөөдөр энд хооллохоор ирэхгүй нь бололтой. Генрих минийг буцааж авъя гэж бодсоноо болилоо. Үдийн хоолны цаг болсон учир гудамд хүмүүс алхлах чимээ үргэлж сонсдов. Ингээд мина дэлбэрч, үүнээс хойш Гартнер бүүр их болгоомжтой байх болно. Хоёр цаг хорин минут болоход Гестапогийн нөгөө хоёр ирсэнгүй. Генрих малгайгаа өмсөж, мундирээ дугтарч засаад хаалга тийш яаралгүй алхав. Гудмаас нийтийн танхим руу орж явахдаа танил гестапогийнхонтой тулгарлаа. Тэд нар Генрихтэй мэндлээд ресторанд оров. Генрих эрэгнэгийн дэргэд очсон цаг харвал цаг хорин долоон минут болж байлаа. Ингэхлээр Гартнер өнөөдөр ч гэсэн гестапогийнхны дараа арван минут болоод ирвэл дөнгөж хоёрхон минут хожиндох нь байна ... Генрихийн тархи нь хурдан бөгөөд саруулхан ажиллав. Гартнер ресторанд ирэхдээ үргэлж гудамжны баруун талаар ирдэг: Генрих яг хоёр цаг хагаст түүнийг тосож гараад гудамжинд гар буугаар буудаж орхино. Тэгээд юу болбол юу болог. Рестораны өөдөөс харсан хашааг түрүүнд шалгахгүй яав даа. Нэвт гарч болох юм уу? Битүү юм уу? үзэх байж. Хоёр цаг гучин минут боллоо ... Яарч байгаагаа өчүүхэн төдий хөдөлгөөнөөр ч мэдэгдэж болохгүй. Генрих Швальбед эелдгээр мэхийн ёслоод гарах хаалга тийш яаралгүй алхаллаа. Тэгээд хаалганы тэнд Гартнер, түүний туслах хоёртой мөргөлдөв. Хойноос нь гестапогийн хоёр цэрэг яваа харагдав. Гольдринг хурандаад ёслоод тэднийг өнгөрөхөд цагаа харав. Хоёр цаг гучин хоёр минут болж байна. Гартнер хоолны өрөөнд орж амжих болов уу? Үгүй болов уу? Тийм үү, үгүй юү? Жаахан явж байгаад эргэж ирье. Генрих гудамж хөндлөн гарлаа. Гуч алхахад гучин километр явснаас илүү удах шиг санагдав. Тэгтэл хүчит тэсрэлтийн чимээ сая дуулдав. Генрих хэдхэн секундийн дараа ресторанд эргэж ирэв. Нийтийн танхимд аймшигтай их үймэн сандарсан боловч эрсдэж хэлмэгдсэн хүн алга. Гагцхүү эрэгнэгийн дэргэдэх ханын хэсэт ховхорч хүнгүй ширээн дээр унажээ. Асар том онгорхойгоор Гартнерийн өрөөнд бөөн тоос, утаа бужигнаж байгаа харагдав. Генрих бусад хүмүүстэй хамт уг хэрэг болсон газар тийш ухасхийлээ. Дөнгөж харангуут Гартнер, түүний туслах хоёр хойшид Бонвилийн партизанууд болон оршин суугчдад аюулгүй болсон нь тодорхой байлаа. Генрихийг ресторанаас гарч гудамжны нөгөө талд гарахад булангийн цаанаас гестапогийнхонтой машин давхин гарч ирэв. Генрих эргэж харалгүй, зочид буудал тийшээ алгуурхан алхаллаа. — Зугаалахаар явах уу? Машин хаалганы дэргэд байгаа гэж Куртийг асуухад нь — Би чамайг машинаа зочид буудлын дэргэд байлга гэж тушаасан юм уу? — Үгүй. Гэхдээ таныг хоол идсэн даруйдаа явах болов уу гэж бодсон юм. — Би хаашаа ч явахгүй. Хэдэн минутын өмнө золтой л хэзээ ч эргэж ирдэггүй зугаалгад явчих шахлаа! гэж Генрих алжаасан янзтай өгүүлсэнд — Юу болоо вэ? гэж Курт хирдхийн асуув. — Ресторанд яг миний хоол иддэг өрөөний өөдөөс харсан өрөөнд тэсрэлт гарсан. — Сая нэг их чимээ гарсан нь тэр байх нь ээ. — Тиймээ. Бөмбөг тэсэрч гестапогийн хэдэн хүн амь үрэгдсэний дотор хурандаа Гартнер үхсэн ... Би өрөөндөө орж унтахыг бодъё. Чи өрөөндөө суугаад хэнийг ч бүү оруулаарай. Хэн нэг хүн шалж шаардаад байвал яах вэ. намайг сэрээнэ биз. Ойлгов уу? — Ёсоор ойлголоо!

Генрих хувцсаа тайлалгүй буйдан дээр хажуулав. Саяхан сэтгэл нь ихэд дэнсэлсний дараа бие нь ихээхэн алжаажээ. Нүдээ анин хэвтсэн боловч унтаж чадахгүй нь байна гэж мэдлээ. Энэ халдлагын хэрэгт өөрийг нь сэрдэх болов уу, үгүй болов уу гэсэн бодол тархийг нь өрөмдөх шиг зовооно. Хардаж сэжиглэвэл баривчлах болно. Сүүлд нь суллаж тавилаа ч гэсэн урьдынх шиг итгэхээ болино. Иймд хүрвэл илэрч баригдсанаас өөрцгүй хэрэг. Тэгэхлээр гестапогийнхныг ирэхэд тэдний гарт орохын хэрэггүй юм байна. Урдаас ньбуудах хэрэгтэй ... Генрих босож автомат гар буу, маузер хоёроо дахин шалгалаа. Буунууд нь ердийн адил цэнэгтэй байв. Гестаногийнхонд амиа үнэ хүргэж өгнө дөө. Гэвч ... Генрихийг байцаах нь алба. Тэсрэлт гарсан өрөөний өөдөөс харсан өрөөнд зургаан өдөр хооллосон шүү дээ. Гольдринг хоол идэх тасалгаагаа өөрөө шилж авсныг Швальбе мэдүүлэх нь лав. Тэгэхлээр гарцаагүй сэрдэж сэжиглэх болно. Гэвч шууд батлах баримт байхгүй. Гестапогийнхон Генрихийг зүгээр гэрчийн хувьд байцаахаар ирж болох юм. Тэгэхлээр шууд урдаас нь буудаад эхэлбэл түүгээрээ өөрөө өөрийгөө илчилж өгнө. Тэгвэл амь гарна гэж найдах аргагүй ... Гэтэл зэвсэг хийдэг газар дорхи заводын тухай яагаад ч болов мэдэх хэрэгтэй. Энэ бол Гартнерийг устгахаас ч илүү чухал даалгавар ... Үгүй, урдаас нь буудахаа больё ... Гэтэл байцааж байх үед ч сэжиг төрж магадгүй юм. Өөрийг нь байцаагчийн дэргэд баривчилж мэднэ. Тэгвэл зэвсгээ ашиглаж амжихгүй. Байцаагч дээр буу зэвсэг авч очих уу даа? Тэгвэл улам сэжиглэхэд хүрнэ. Ингэхлээр маузер, брауниг хоёртой л очихоос өөр замгүй. Бага л юм, гэсэн ч яая гэх вэ. Генрих цонхныхоо хөшгийг буулгаад хувцсаа тайлж, унтахаар хэвтлээ. Үүрээр түүнийг Курт дуудаж сэрээгээд — Эрхэм ахлах дэслэгч ээ! Тантай уулзахаар хүн ирээд байна гэж бароныг аяархан түлхэж шивэгнэн хэлэхэд нь — Хэн бэ? гэсэнд — Гестапогийн хоёр хүн гэж Курт айсан байдалтай шивэгнэв. — Намайг хувцсаа өмстөл хүлээж бай гэж хэл хэмээн Генрих зэргэлдээх өрөөнд дуулдахаар чанга хэлээд орноосоо үсрэн босов. Курт гарлаа. «Хүлээж байна. Баривчлахаар ирсэн бол Куртгэй хамт орж ирэх байсан» гэж бодоод баахан сэтгэл тайвшрав. Генрих ерийнхөөс удаан хувцаслалаа. Тасалгаанаас гараад нацистын ёсоор гараа сунган ёсолсонд гестапогийнхон хариу ёслов. «Баривчлагдсан хүнд бол хариу ёслох учиргүйсэн» гэсэн бодол зэрсхийлээ. — Та нарын үгийг сонсоё гэсэнд — «Савойя» ресторанд гарсан тэсрэлтийн талаар таныг нэн даруй ирж мэдүүлэг өгөхийг эрхэм хошууч Лемке тушаасан гэж бага дарга хариулав.«Тушаасан» гэв үү, уг нь «хүссэн» гэж хэлбэл зохихсон гэж бодох зуур: — Та нар яагаад хоёулаа, бас автоматтай яваа юм бэ? — Одоо харанхуй байна. Шөнийн цагт хотоор явган, машинтай аль нь ч гэсэн явахад аюултай байдаг гэж нөгөө бага даргын дүрэмт хувцастай нь хэлэв. Генрих цаг харвал таван цаг дөчин минут болж байлаа. — За явъя гэж Генрих хэлээд цуваа өмсөж, хаалга тийш чиглэв. — Үйлчлэгч цэргийг бас ир гэж тушаасан хэмээн бага дарга дуугарав. — «Энэ ч муу байна. Маш муу байна» гэж Генрих бодлоо. Куртийг автоматаа авах гэтэл — Зэвсэг авсны хэрэггүй гэж бага дарга нь тушаалаа. — Зочид буудлын эзэнгүй өрөөнд зэвсэг орхих нь аюултай биш үү? гэж Генрихийг өгүүлэхэд — Энэ зочид буудлыг сайн манаж хамгаалдаг юм гэж бага дарга хэлээд самгардсан Куртийн гараас автоматыг нь авч сандал дээр тавилаа. — Явъя гэж Генрих хэлээд тасалгаанаас түрүүлэн гарав. Хойноос нь Курт, түүний араас гестапогийнхон даган гарлаа. Гадаа үүдний дэргэд долоон хүний суудалтай том машин хүлээж байв. Хажууд нь гестапогийн хоёр хүн зогсож байлаа. Тэд

нар Генрихийг харангуут даруй урдталын суудалд суув. Бага дарга машины арын хаалгыг нээж, дунд талын суудлыг заагаад Генрих, Курт хоорыг суу гэж дохив. Бага дарга нөгөө цэрэгтэйгээ арын суудалд суулаа. «Баривчилсантай адилхан болж байна. Би байцаалтад очихоор зөвшөөрсөн маань алдаа болоогүй байгаа даа? За тэртэй тэргүй хожигджээ. Тэвд очиж байж яахыгаа шийдэхээс биш. Куртийг өрөвдмөөр байна. Энэ залуу гэм зэмгүй байж үрэгдэх нь» гэж бодов.

Толгойд нь янз бүрийн бодол эргэлдэнэ. Айхгүй байлаа. Өчигдөр ресторанд эрэглэгийн дэргэд зогсоод цаг харж, секунд тоолж байсан шигээ тархи нь саруулхан ажиллаж, бүх мэдрэл нь хөвчилжээ. Гестапогийн байцаагч дээр очих замд таван минут ч болоогүй атал Генрихт дэндүү удаан яваад байгаа юм шиг санагдана. Байцаагчийн тасалгааны хаалганы дэргэд автомат буутай манаа зогсож байв. Курт Генрихийг даган орох гэтэл манаа түүнийг зогсоож Генрих ганцаараа дотогш орлоо. Хаалганы дэргэд түр саатан зогсох хооронд тавил сайтай уудам том тасалгааг хурдан зуур тойруулан хараад «Эндээс зугтах нөхцөлгүй юм байна» гэж бодлоо. Цонхыг нь төмөр хайсаар бэхэлж хаалгыг бат бэх бөгжилжээ. Бичгийн том ширээний ард намхан зөөлөн сандал дээр байцаагч хошууч Лемке сууж байв. Энэ нэрийг Генрих хаалганы гадаа уншиж амжсан юм. Хошууч мэндэлсэн ч үгүй, өөрийн урдахь сандлыг үг дуугүй заасанд Генрих суулаа. Хэсэг зуур Генрих, Лемке хоёр бие биенээ ажиглан ширтэв. Генрих бүүр ч сониурхан харжээ. Юу вэ гэвэл Лемкегийн царайг нэг харсан хүн мартмааргүй ажээ. Нарийхан зууван царайг нь гэнэт уруулаар төгссөн харагдана. Эрүү гэмээр юм байсангүй. Эрүүний оронд шууд хүзүү рүүгээ орсон жижигхэн зураас харагдана. Том төвөнх нь нэгэнтаа амандаа хүртэл дээшилж, нэгэнтаа хүрэн цамцны өндөр захны цаагуур далд орно. Хошууч хямдхан навчин янжуур татаж, хуруугаараа ширээ тогшиж байлаа. Нэг хуруунд нь хохимой толгойтон мөнгөн бөгж бүдэгхэн гялалзаж, нөгөө хуруунд нь гэрлэлтийн том алтан бөгж харагдана. «Энэ аймаар муухай амьтныг тоож гэрлэх хүүхэн олдсон байж дээ!» гэж Генрих бодоод гэнэт хөгжилтэй болж, инээмсэглэв. — Тамхи татаж болох уу? гэж байцаагчаас хайнгадуухан асуусанд хайцагтай янжуураа үг дуугүй түлхэж дөхүүлэв. — Би өөрийн тамхийг татмаар байна гэж Генрих хэлээд гараа өмдний халаасанд хийх гэж хөдөлтөл тэр даруйд: — Цаашаа! гэж сүртэй чанга хашгирах сонсдов. Лемке ширээний дэргэд зогсоод тасалгааны гүн рүү анхааралтай харж байв. Генрих эргэж харвал асар том дог нохой шүдээ ярзайлгаад өөдөөс нь харж байлаа. — Энэ нохойг тасалгаанд байлгах юм бол би таны нэг ч асуултад хариу өгөхгүй гэж Генрих эрс хэлсэнд — Яагаад тэр билээ? гэв. — Бүх үүлдрийн нохойг үзэж чаддаггүй юм гэж хариуллаа. Лемке хонхны товчлуур дарж, — Зайлуул! гэж тушаасанд автомат буутай цэрэг нохойг авч гарлаа. Генрих нэг хайрцаг гавана янжуур гаргаж, яаралгүйхэн асаасанд — Та гавана янжуур хаанаас олдог юм бэ? гэж Лемкег тайван асуухад нь — Та надад тамхи нийлүүлдэг хүний хаягийг мэдэхийн тулд шөнө дунд намайг сэрээж, автомат буутай хоёр цэргээр харгалзуулан нааш нь авчирсан юм биш биз дээ? гэж Генрих өөдөөс нь асуусанд хошуучийн зүүн хацар таталдан: — «Савойя» ресторанд юу болсныг та мэдэх үү? гэв. — Мэдэхээр барах уу. Тэсрэлтийн уршгийг өөрийн нүдээр үзсэн. Харин би тэр дороо яваад өгсөн ... — Яагаад? — Цус харахад эвгүй санагдсан юм гэсэнд Лемке жигшсэн янзтай мушийн инээмсэглээд — Эрхэм ахлах дэслэгч та цаг

ургэлж ар талд байлдаж бай-саи болохоор цус хараад ... гэхэд нь Генрих түүний үгийг ууртай тасалж. — Эрхэм хошууч аа! Би богинохон наслах энэ завсар таны үзсэнээс хавьгүй илүү цус үзсэн гэж батлан хэлж чадах байна ... гэж хэлэх зуур «үүнтэй ер нь ингэж ширүүн ярихын хэрэг байна уу» гэж бодоод эргэн харж, өөр зөөлөн дуугаар: — Тэр бол дайсны цус байсан, гэтэл энд манайхны ... гэв. — Та энэ хотод албан томилолтоор ирсэн үү? — Тиймээ ... — Хэд хонож байна вэ? — Өнөөдөр наймдахь хоног нь. — Хэдийнээс эхлээд «Савойя» ресторанд хоол идэж байгаа вэ? — Ирснийхээ маргаашаас. Хэн таныг тэнд хоол идэж бай гэж зөвлөсөн бэ? — Би жолоочоо хаана сайн ресторан байгааг мэдээд ир гэж явуулсан юм. Нэг нь «Савойя» сайн гэж хэлсэн байна лээ гэж Генрихийг хариулахад — Шалга! гэж Лемке тайван дуугарлаа. Гольдринг түүнийг гайхан харав. «Шалга» гэдэт үгийг хөшигний цаанаас гарч ирээд гадагш гарсан дэслэгчид хэлсэн юмсанж. «Гэнэтийн юмаар гайхуулж байна. За яах вэ, цааш нь юу болохыг үзье» гэж Генрих бодоод инээмсэглэв. Лемке түүнийг нүд салгалгүй ширтэх зуур: — Та хэдэн цагт хоолоо иддэг вэ? гэв. — Дандаа нэг цагт. — Хэдийд дуусдаг вэ? — Янз янз даа. Хоол идэх дур, хоолны тоо хэмжээнээс болдог юм. — Та өчигдөр ресторанаас хэдэн цагт гарсан бэ? — Санахгүй байна. — Тэсрэлтийн үед хаана байсан бэ? — Гадаа хаалганаас хэдхэн алхмын зайд. Би гэртээ харьж явсан юм. — Хоёр цагаас хойш хэдэн минут болоод тэсрэлт болсон бэ? — Мэдэхгүй. Би цаг хараагүй. Намайг зочид буудалд ирэхэд гурван цагт таван минут дутуу байсан гэсэнд хошууч хорсолтойгоор мушилзаж: — Гольдринг таны бодоход ... гэхэд нь — Эрхэм фон Гольдринг гээрэй! гэж Генрих залруулж хэлсэнд Лемке босон харайх гэсэн юм шиг суудал дээрээ өндөлзөв. Хилэгнэсэн онигор нүд нь Генрихийг цоо ширтэх мэт харна. Генрих өөдөөс нь эс тоомсорлосноо нуухгүй харж суулаа. «Энэ тоглоомыг дуусгах юм бил үү? Энэ хошууч, бас туслахаар түрүүлж ирсэн хоёр гурван хүнээр хязгаарлахаас. Өөртөө хоёр сум үлдээх хэрэгтэй. Нэг илүү байхад гэмгүй, үгүй, жаахан хүлээе» гэж бодох зуур Генрих дутуу татсан янжуураа үнсний саванд хийгээд халааснаасаа шинэ янжуур гаргаж ирэх зуур «намайг байн байн халаасандаа гараа хийдэг юм байна гэдгийг мэдэж аваг» гэж боджээ. — Эрхэм ахлах дэслэгчийн сэтгэл догдлоод байх шив дээ? гэж Лемке бүүр илэрхий дайрсан байдалтай өгүүлэхэд нь — Сэтгэл догдолсон юм биш, уур хүрээд байна! гэж Генрих залруулж хэлсэнд — Герман цэргийн офицер хүн тэсрэлт гарсан газар очоод багагүй чухал учир холбогдолтой гэдгийг мэдсээр байж цагаа хараагүй нь хачин хэрэг бус уу? гэхэд нь — Би өөрийгөө тэсрэлтийн цагийг тодорхойлох ганцхан гэрч болох юм гэж санасангүй гэсэнд — Өө, тийм биш. Манайд олон гэрч байна. Таны санаснаас олон гэхэд — Тийм тусмаа танд сайн гэв. — Аа танд бол ямар бэ? — Битгий үгний өө эрээд байгаарай. — Үнэмлэхээ! гэж Лемке хашгираад ширээ шаав. «Дүүрчээ. Одоо л цаг нь боллоо. Эс тэгвэл хожигджээ» гэж Генрих бодов. Генрих Лемкегийн нэг адил сандлаасаа өндийж, янжуураа үнсний саванд хийгээд үнэмлэхээ гаргах гэж мундирийнхээ товчийг алгуурхан тайлав. «Энэ хошууч үнэмлэхийг минь үзэхээр буудья» гэж Генрих санаа шулуудаад сэтгэл тайван байгаагаа өөрөө ч гайхав. Генрих үнэмлэхээ гаргаж ширээн дээр тавилаа. «Одоо авах гээд тонгойхоор нь ...» Хошууч үнэмлэхийг нь аваад тэр даруйдаа үзсэнгүй. Хоёул өөд өөдөөсөө нүүрэлдэн зогсоод уурласанаа нууж чадахгүй бие биеийн нүдийг эгц ширтэцгээж байлаа. Хаалга чимээгүйхэн онгойж, босгон дээр түрүүн хөшигний цаанаас гараад явдаг дэслэгч орж

ирлээ. Лемке түүний өөдөөс асуусан байдалтай харсанд — Нотолж байна гэж цаадахь нь аяархан хариуллаа. «Үхэх үйлээ хүлээсэн бас нэг хүн нэмэгдлээ ... Үүнийг урагшаа явахыг нь хүлээхээс дээ ... Уг нь түргэхэн хөдөлбөл ч ...» — Дэслэгч Гольдринг та юуны учир хоёрдугаар зэргийн төмөр загалмай одонгоор шагнуулсан юм бэ? гэж Лемкег асуухад — Танд хамаагүй! гэж хариулав. «Одоо яасан ч яах вэ. Юу ч болтугай энэ дэслэгч жаахан ойртож ирэг. Тэгэхлээр нь ...» — Дэслэгч ээ. Үнэмлэхийг шалга гэж Лемке ууртай дуугараад Генрихээс нүд салгалгүй ширтэх зуур гараа ширээний нүдэнд хийлээ. «Сэжиг аваад гар буугаа авав уу даа?» гэж Генрих хирдхийн бодов. Нөгөө дэслэгч ширээний дэргэд очиж, Генрихийн үнэмлэх бичгийг аваад хажуу тийшээ боллоо. Генрихийг гараа халаасандаа хийсэнд Лемке цочиж, хамаг биеэ хөвчиллөө. Гольдринг хайрцагтай янжуураа тайван гаргаж ирэв. — Эрхэм хошууч аа, эрхэм хошууч аа! гэж нөгөө дэслэгч айх, гайхах зэрэгцсэн дуугаар өгүүлэхэд нь — Юу болоо вэ? гээд Лемке хэсэгхэн зуур эргэж харлаа. «Буудья, одоо даруйхан буудья» гэж бодтол нөгөө дэслэгч юу болох нь энэ вэ? Үнэмлэх бичиг шалгасан тэр дэслэгч, Гольдрингийн үнэмлэхийг дэлгээстэй чигээр нь хошуучид үг дуугүй сарвайлаа. Тэнд ард нь «Генрих фон Гольдрингт, эцгээс чинь» гэсэн бичигтэй СС-ийн албаны хошууч генерал Бертгольдийн гэрэл зураг хавчуулаастай байжээ. — Эрхэм хошууч генерал Бертгольд, таны эцэг үү? гэж Лемке асуув. Буун дуу гарсан бол энэ гэрэл зураг гарч ирснээс илүү гайхахгүй байсан бололтой. — Энэ таны эцэг үү? гэж гайхширсан Лемке дахин асуухад нь — Энэ шийгээ зогсоо! гэж Гольдринг огцомхон босон харайв. Лемкегийн хайрцагтай янжуур тасалгааны булан тийш үсрэн одов. Генрих үргэлжлүүлэн: — Та нар намайг ямар үндэстэй болоод шөнө дунд сэрээж, цаг гаруй байцааж байгаа юм бэ? гэж сүртэй өгүүлсэнд — Эрхэм Гольдринг оо, гэхдээ ... гэхэд нь — Юу «гэхдээ» гэж! Даруй машин гаргаж, намайг зочид, буудалд минь хүргэж өг. Маргааш болоход энэ бүгдийг Бертгольдод дуулгана гэлээ. «Давшлаад л байх хэрэгтэй. Гестапогийн генералын залуу хүү ямар байвал таарах вэ, тийм л омогтой ширүүн давшлаад байх хэрэгтэй» гэж Генрих бодов. — Алагдсан хурандаа Гартнер бол генерал Бертгольдын онцгой даалгавар гүйцэтгэгч офицер байсан юм шүү дээ гэж Лемке аман дотроо дуугарахад нь — Тантай тангуй мэднэ гэлээ. Генрихийн хамаг бие цогцост үгээр хэлэхийн аргагүй их баяр баясгалан дүүрэхийт өөрөө мэдрэв ... «Өө дөө, аятай сайхан юмыг гутаагаад ч хэрэггүй юм уу даа. Энэ тэнэгүүдийг чөтгөр алгадаг!» гэж Генрих бодов. — Бид мэдээгүй юм шүү дээ гэж дэслэгч хажуунаас нь гарахад — Хундага шарз! гэж Генрих хэлээд сандалдаа лаг хийтэл суув. Дахиад нэг агшин өнгөрвөл хамаг чадлаараа тас тас хөхрөх буюу эсвэл энэ гестапогийн байцаагчийн өрөөнд дуртай дуугаа дуулчихмаар санагджээ Генрих баярласнаа мэдэгдэхгүйн тулд алгаар нүдээ таглав. — Эрхэм барон, эрхэм барон! гэж хүндэтгэлтэй аяархан дуудахад нь Генрих гараа авлаа. Урд нь нөгөө дэслэгч нэг лонх шарз хэдэн хундага тавьсан цар бариад зогсож байлаа. Лонхтойг эхлээд орхисон байжээ. Генрих тэр лонхны шошгыг хараад «эд нар чинь тийм муугүй шарз уудаг юм байна» гэж боджээ. Дэслэгчийг шарз хундагалан өгөхөд Генрих ганцхан хөнтөрч орхиод дараа нь хайрцагтай янжуур гаргаж, дэслэгчид барив. Цаадахь нь янжуурыг их л яаран шүүрч авсанд Генрих инээд алдчихгүйн тулд шүдээ зуулаа. Лемке бас ширээн дээгүүр дамнан тонгойж, нэг янжуур авлаа» Гурвуулаа Генрихийн асаагуураас тамхиа асаав. — Эрхэм ахлах дэслэгч фон Гольдринг таныг баахан тайвширсан хойно ... гэхэд нь «Чи

саяхан намайг зүгээр Гольдринг гэж дуудаж байсан биш бил үү? ...» гэж Генрих дотроо бодлоо. Лемке үгээ үргэлжлүүлэн — ... Бидний байдлыг та ойлгох биз. Хурандаа Гартнер шиг том хүнийг алсан байхад тэсрэлт болохоос өмнөхөн ресторанаас гарсан хүн гэвэл ганцхан та байна ... Гэтэл утас дуугарлаа. — Энэ Берлинээс утасдаж байх шиг! гэж хошууч хэлээд утас руу ухасхийж, — Сонсож байна! гэснээ харилцуурыг гараараа таглаад, — Дахиад генерал Бертгольд утасдаж байна. Өнөөдрийн дотор гурав дахь удаагаа утасдаж байгаа нь энэ гэснээ гараа авч, — Харамсалтай нь шинэ юм алга гэсэнд Генрих харилцуур өөд гараа сарвайсанд, Лемке: — Эрхэм хошууч генерал аа! Тантай ахлах дэслэгч фон Гольдринг ярихыг хүсэж байна. Тиймээ, Энд байна гэж хэлээд харилцуурыг Генрихт өгөхдөө генералд өөрт нь өгч байгаа юм шиг их л хүндэтгэлтэй хандав. Генрих харилцуурыг аваад — Тиймээ, би байна ... Албан томилолтоор ирсэн. Намайг ийм орой болсон хойно яагаад энд байгаа юм бэ гэв үү? гээд хошууч, дэслэгч хоёр өөд харсанд наад хоёр нь битгий хэлээрэй гэж нүдний харц, дохиогоор гуйхад нь — Миний эцгийн офицерыг алан хядагчид алсан байхад би яаж тайван суух вэ дээ? ... Туслалгүй яах вэ ... Тэр яагаа вэ? Лораг миний өмнөөс үнсээрэй ... Ахын нь хувьд ч, болзоот хархүүгийн нь хувьд ч тэр ... Өөрт нь үүнийг битгий хэлээрэй. Би өөрөө хэлэх гэсэн юм. Удахгүй баяртай уулзъя ... гээд харилцуурыг тавилаа. Лемке уучлал гуйж, — Барон фон Гольдринг та өнөөдрийн энэ эндүүрлийг мартахыг маш их гуйя. Бид анх танилцахдаа ийм эвгүй уулзсан ч гэсэн ... гэхэд нь — Энэ тохиол надад эцэгтэйгээ ярих бололцоо олгосноор миний сэтгэлийг овоо заслаа гэж Генрих хөгжилтэй өгүүлсэнд — Та хэдэн минут саатаж, тэсрэлтийн үед амь үрэгдсэн бол яана? гэж Лемке хэлээд энэ бодлоос өөрөө хирдхийн цочиход нь — За би ядарч байна, машин өгөхийг тушаана уу гэвэл — Аа тэгэлгүй яах вэ. Харин та, бидэнд тусаяна гэж амалснаа мартахгүй биз дээ? гэхэд нь — Чадах ядахаараа тусална гэж Генрих мэхийн ёслоод гарлаа. Генрих мөчийн дараа бөх нойронд нэгэнт дарагдсан байлаа.

МОНИКА БОНВИЛЬ ОРОВ Тарваль авгайг эрхэм дээд зорилго өөд тэмүүлнэ гэх буюу өөрөөс нь эд материалын ямар нэг гарз шаардах зорилго өөд тэмүүлнэ гэж үнэмшихэд бэрхтэй. Саяхан болтол Тарваль авгайн сонирхлын хүрээ нь талийгаач нөхрөөсөө өөрт нь дамжиж ирсэн зочид буудал, түүний дэргэдэх зоогийн танхимыг өргөтгөдөггүй юм гэхнээ ядаж нэгэнт хүрсэн хэмжээнд нь байлгах хүслээр хязгаарлагдаж байлаа. Ер нь Тарваль авгай талийгаач нөхрийгөө нэр төртэй залгамжлагч, түүний гэрээсийг биелүүлэгч болохоо харуулсныг хэлэх хэрэгтэй. Ажил төрөл нь урагштай болоход авгайн аж ахуйн авьяас тус болоод зогсоогүй, зарим нэг өвөрмөц нөхцөл тус болсон байна. Аршаан амралтын хотхон гэж алдаршсан Сен-Ремид намар орой болсон үеэс бусад жилийн бүх улиралд энд тэндээс ирсэн хүн дүүрэн байдаг байжээ. Тэр хүмүүс Тарваль авгайн зочид буудалд дуртай сууж, хоолыг нь дуртай иддэг байлаа. Юу вэ гэвэл эзэгтэй зочид буудлаа тохьтой болгож, журамтай дэглэмтэй газар гэсэн нэрийг нь батжуулж чадсан юм. Бас Тарваль авгайн хоёр хүүхэд, хүү Жан, охин Моника хоёр нь амрагчдын хөлд хөшилдөөд байдаггүй, эхдээ чадахын хирээр тусалдаг байсан нь тиймэрхүү сэтгэгдлийг улам баттай болгодог байсан байж болох юм. Хүүхдүүд нь бага балчир наснаасаа эхлээд амьдралд ямар ч юм зүгээр олддоггүй гэдгийг мэдэж авах ёстой гэж Тарваль авгай үздэг байжээ. Жан, Моника хоёр нь том болж, юм болгон

бүтэмжтэй сайхан байх шиг санагдаж байсан тул Тарваль авгай хүүхдүүдийнхээ ирээдүйг яаж хангахаа урьдаас төлөвлөн бодож байлаа. Охиндоо зоогийн танхимаа, Хүүдээ зочид буудлаа үлдээхээр төлөвлөсөн байжээ. Гэтэл дайн болж хамаг төлөвлөгөөг нь эвдэв. Гэхдээ зочид буудал нь хоосон байдаггүй, өрөөний ихэнхийг Парисаас буюу ер нь умар зүгээс зугтаж ирсэн хүмүүс эзэлжээ. Зугтаж ирсэн хүмүүс эзэмшлийн илүү хатуу дэглэм тогтоосон тэр газраа эргэж очихыг яарахгүй байлаа. Сен-Ремид бол германы командлал болон Вишийн засгийн газрын хооронд байгуулсан «районыг хамгаалах тухай» гэрээ гэгч хуурамчхан ч атугай гэрээгээр эзэмшлийн дэглэмийг халхалсан байжээ. Зугтаж ирсэн хүмүүс зоогийн танхимд хооллох боловч урьдынхтай адил орлого олохоо байлаа. Тарваль авгайн ажил төрөл гуйвж эхлэв. Урьдаас зориуд мөнгө хурааж байгаад зугаалж цэнгэхээр ирсэн амрагчид гэдэг нэг хэрэг, харин хөрөнгө мөнгө нь хэдий хүртэл хүрэхийг мэдэхгүй, тэр ч байтугай хэдийд гэр орондоо эргэж харьж чадахыг мэдэхгүй болохоор улаан мөнгө бүрийг хайрлаж хямгадаж байдаг байнга суугчид бол огт өөр хэрэг билээ. Түүний дээр Тарваль авгай, дүү хүүхэнтэй нь хамт Травельса тосгонд суудаг эхээ үргэлж тэтгэн туслах ёстой байлаа. Дайнаас өмнө Тарваль авгайн дүү Луйза Парис хотод суудаг байв. Түүний нөхөр, нисэхийн инженер Андре Ренар тэнд ажил хийдэг байжээ. Гэтэл Андре Ренар 1939 онл цэрэгт татагдаж, нисэх хүчинд алба хааж байгаад алагдсан бололтой. Юу вэ гэвэл Луиза энэ завсар нөхрөөсөө ганц ч захиа авсангүй. Удалгүй гитлерчүүд Андре Ренагын бүх хөрөнгийг хураасан тул эхнэр Луиза нь Парисыг орхиж Сен-Ремигээс гучаад километрийн зайд оршдог бяцхан тосгонд эх дээрээ ирж суухад хүрчээ. Уг нь, бүгдээрээ хамт суувал дээрсэн. Дүү нь зоогийн газрын ажилд тус болно. Гэтэл Тарваль авгай тэгэхийн аргагүй байжээ. Дүүдээ хайргүй болоод тэгсэн хэрэг биш, Зүгээр болгоомжилсон байна. Ренарын эхнэр эгчтэйгээ хамт сууж байгааг гестапогийнхан мэдвэл зоогийн танхимыг нь, бас түүний эзэгтэйг ч найдвартай биш гэж үзэх болно. Тэгээд герман офицерууд зоогийн танхимд орохыг хориглох болно. Ингэвэл ажил төрөл нь улам доройтоход хүрнэ. Ямар ч байлаа гэсэн орлогын ихэнх хэсэг нь чухам зоогийн танхимд байнга хооллодог герман офицеруудаас ирж байгаа билээ. Тэгэхлээр дүүгээ дэргэдээ авч байлгана гэж санахын ч хэрэг байсангүй. Тарваль авгай ялангуяа Жаныг партизан болсноос хойш дүү хүүхэнтэйгээ захидлаар харилцахыг хүртэл чандлан цөөрүүлжээ. Түүний ганц хүү бяцхан Жан нь партизан болох ёстой байв. Энэ явдал болсноос хойш Тарваль авгай хоромхон зуур ч сэтгэл тайван байж чадахаа больжээ. Энэ тухай гестапогийнхон шиншиж мэдээгүй байгаа нь бас яамай. Тэд Жаныг фронтод яваад байлдаанд амь үрэгдсэн юм уу, эсвэл олзлогдсон гэж бодож байгаа. Гэтэл үнэнийг нь мэдэж орхивол яана? Түүнийг нэг удаа ууланд барьсан шүү дээ. Аз болоход энэ барон дайралдсан байна. Бодвол эхийн сүсэглэн залбирсны ачаар энэ барон хүүг нь суллан тавьсан биз. Тийм биш бол энэ хачин явдлын учрыг юу гэж тайлбарлах вэ? Эсвэл барон, Жаныг Моникагийн ах гэж таньсан юм болов уу? Үгүй тийм байх ёсгүй. Жан бол хэнэггүй тэнэг жаал хүү байсан тэр хэвээрээ үлджээ. Моникагийн ах боловч хөнгөмсөг жаал бүсгүйгээс доор байдаг билээ. Моникадаа бол итгэж болно. Моника тиймгүй. Германчуудыг үзэн ядаж заримдаа дэндүү ширүүн байдаг нь үнэн. Гэвч бас зохих хэмжээнээс хэтрүүлдэггүй. Барон фон Гольдрингт хүртэл франц хэлний хичээл заахыг зөвшөөрсөн байна. Энэ барон ч уг нь герман хүнтэй огт адилгүй юм. Ёстой франц хүн

шиг эелдэг зантай, бас элгэмсэг найртай хүн юм. Энэ барон, Жан хүүг нь суллаж тавьсан тэр цагаас хойш Тарваль авгай өдөр ирэх тутам бароны шинэ шинэ сайн чанарыг ажиж мэдэх болжээ. Ёстой журамт эр л ингэж чадна. Жан энэ бүх явдал болоход гайхсандаа бүүр хөшиж орхисон гэж Моникадаа ярьсан байна лээ. Ингэхэд Моника Жаны тухай хаанаас олж мэдэв? Охин нь дугуйгаар их явдаг болсныг Тарваль авгай санаад хамаг бие нь арзасхийв. Моника ч гэсэн партизануудтай холбоотой болсон байвал яана? Тарваль авгай урьд анзаарахгүй өнгөрдөг байсан зүйлүүдээ харьцуулан дүгнэж эхэллээ.

Үнэндээ Моника өдөр дунд ажил зөндөө байхад хамаг ажлаа орхиод толгой өвдөж байна гэж шалтаглан нэг тийшээ яваад өгөх нь олон байдаг ... Дараа нь Жан ах таны амар мэндийг эрж байна гэж хэлдэг ... Жанаас Моникаар мэдээ ирэх нь нэг л олон байх юм. Бас «Ээж танаас хүн асуувал Франсуаг миний болзоот хархүү гэж хэлж байгаарай» гэснийг бодоод үз. Тарваль авгай үүнийг анх сонсоод тоглгоомын үг гэж бодож. инээд нь хүрсэн билээ. Үзэсгэлэн гоо Моника нь унжгар хамарт Франсуатай суух гэж үү?! Гэтэл одоо Тарваль авгай инээхтэй манатай. Охин нь нэг юм нуугаад байгааг Тарваль авгай яваандаа мэдлээ. Ай тэнгэр минь, энэ тухай хүн мэдчихвэл яана! Жан бол ууланд байгаа болохоор бас ч аюул багатай. Моникаг бол хэзээ ч бариад авч магадгүй шүү дээ. Ай тийм юм бодохоо больё. Бодоод байвал галзуурч мэднэ. Тэгээд Тарваль авгай аймшигт сэжгийг зайлуулж өөрөө өөрийгөө зүхэж, өөрийгөө аймхай амьтан гэж элдвээр сэтгэлээ хуурах боловч сэтгэлийн түгшүүрийг бүрмөсөн арилгаж яахан чадах билээ. Тарваль авгай өөрийнхөө сэжгийг Моникад нэг ч удаа цухуйлгасангүй. Охиныхоо занг юу эс андах вэ дээ. Халуун хайртай мөртлөө зөрүүд нь хачин. Сануулж хэлбэл уурыг нь хүргэж, зэмлэлийн үг дуулна. Моника германчууд хооллодог зоогийн танхимын орлогоор амь зууж байна гэж бодохоос байж сууж чаддаггүй байлаа. Аягүй бол толгойгоо мэддэг том хүн болох гээд хэрэг төвөг тарьж мэднэ. Үгүй, аюултай тулгарсан гэмээн хяруул шиг нүдээ аньж, толгойгоо нуугаад юу болохыг хүлээж, явж явж дайн дуусахыг хүлээхээс өөр зам алга. Моника нэг цахилгаан утас аваад Бонвиль орно гэж хэлсний дараа Тарваль авгай ямар айхавтар алдаа хийснээ сая ойлгожээ. Эх нь хаалгаа түгжиж, түлхүүрээ халаасандаа хийгээд, — Чамайг хааш нь ч явуулахгүй! гэж эрс хэлсэнд — Ээж ээ, би заавал явах ёстой гэхэд нь Тарваль авгай юмны учрыг бага сага төсөөлөхөө охиндоо анх удаа цухуйлгаж, — Ондоо хүн явуулах юм байгаа биз. Учир нь мэдэгдэхгүй нууц даалгавраар ийш тийшээ явдаг нь бүсгүй хүний ажил биш гэсэнд — Ёстой л бүстгүй хүний ажил юм шүү дээ, ээж ээ. Ганц би л Гольдрингоос мэдэж ... гээд Моника үгээ дутуу орхисонд — Чи Гольдрингоос юу мэдэж авах ёстой юм бэ? Юу вэ? Чамаас асууж байна. Надад хэлэхгүй бол би одоо даруй Генерал дээр нь очно гэсэнд — Яах вэ, оч л доо. Далимд нь манай Жан партизануудтай хамт байгааг марталгүй хэлчихээрэй. Тэгвэл тэднийг бүгдийг нь тахианы дэгдээхэй шиг алаад дуусна. Партизануудад буу зэвсэг байхгүй шүү дээ. Зэвсэгтэй болох бололцоог нь та тасалж байна. За юунд зогсоод байгаа юм бэ! Яваач! Өнөөх Левек шиг ёстой франц хүн мөнөө үзүүлээд өгөх юм байгаа биз. Тэгвэл танд охин ч байхгүй, хүү ч байхгүй болно гэдгийг мэдээрэй гэлээ. Буу зэвсгийн тухай Тарваль авган дуулаад сандал дээр лаг хийтэл сууж царай нь зэвхий даасанд бүсгүй эхийгээ өрөвдөөд хүзүүгээр нь тэвэрч, Ээж ээ, айх юм юу ч байхгүй гэж

танд баглан хэлье. Тангараглая, энэ зүгээр нэг хөгжилтэй зугаалга болно. Би зугаалахын ялдамд хэрэгтэй хүний чихэнд хэдэн үг шивэгнэчихвэл гүйцэх юм гэжээ. Тарваль авгайн сэтгэлийг тайтгаруулахад тийм амар биш байжээ. Авгай уйлж, гуйж, сүрдүүлж нэг үзсэнээ дахин уйлав. Моника эхийгээ өвчтэй хүн асарч байгаа юм шиг асарч сувилах боловч хэлснээ буцсангүй, явна гэж хатуу зүтгэсээр, хэлсээр байлаа. Охиноо үхлийн аюулаас аврах гэсэн эх, ард түмнийхээ төлөө амиа өгөхөд бэлэн байгаа охин хоёрын энэ өрсөлдөөнд охин нь дийлж гарлаа. Эх нь хувь заяаны эрхийг дагажээ. Моника өөрийн очих тухай Генрихт утас явуулсангүй. Цагдаа, гестапогийнхон үргэлж олон байдаг галт тэрэгний буудал дээр Генрихтэй хамт явж байхыг нь хүн харуузай гэсэн байжээ Тэгээд бүүр ирсэн хойноо садангийнхаасаа шууд зочид буудалд нь утас явуулж уулзах цаг, газрыг болзов. Генрих хэлсэндээ хүрч, энгийн хувцастай хүрч ирэв. Нүд хорсгодог герман офицерын дүрэмт хувцсыг бодвол Генрихт энгийн хувцас илүү зохих юм байна гэж бүсгүй бодлоо. Нэгэн үе Генрих тэр хоёрын хооронд байгаа саад арилсан юм шиг Моникад санагджээ. Генрихийн чийрэг дулаан гарыг түшээд зэрэгцэн явахад таатай сайхан байв. Юм ч яримааргүй байлаа. Түүний сэтгэлийн байдлыг Генрих ойлгосон бололтой бас үг дуугүй алхална. Дайн болоогүй, хэзээ ч болохгүй бол юутай сайхан билээ гэж Моника сэтгэлдээ төсөөлөн санаашрав. Тэгвэл сэтгэлээ нууж байхын хэрэггүй, Генрихтэй хоёул хүн шиг хэвийн харилцаатай байхсан. Гэтэл бараг алхах бүрд эргүүл дайралдаж, тэдний гутлын хүнд чимээ бүсгүйд яагаад ч юм бэ авсны дээрээс хаяж байгаа анхны бөөн шорооны чимээг санагдуулна. Үгүй, эзэмшилд байгааг мартагын арга байсангүй. Моника хайрт хүнтэйгээ уулзахаар ирсэн биш, партизануудад маш чухал хэрэгтэй мэдээ олж авахаар ирснийг бодит байдал үргэлж сануулна. «Чухам олоо л бидэнд зэвсэг маш чухал хэрэгтэн байна» гэж явахын нь өмнө Франсуагийн хэлсэн үг чихэнд нь үргэлж дүнгэнэнэ. Моника өөрөө үүнийг хэлсэн хэлээгүй мэднэ. Тэгэхлээр Моника партизануудыг зэвсэгтэй болгохын тулд хэрэгтэй бүхнийг хийнэ. «Харин үүнээс болж Генрихт эвгүй явдал, бүүр бөөн төвөг учирч магадгүй» гэж бүсгүй гэнэт бодов. Генрих одоо өөртэй нь зэрэгцэн үг дуугүй алхалж явна. Гэвч бас л аз жаргалтай байгааг нь мэдэрч байлаа. Гурван гудамжны уулзвар дээр тэр буланд Моникаг анх хараад нүд нь хичнээн халуун баяртай туяарсан билээ. Моникагийн одоо юу бодож байгааг тааж мэдвэл яах бол? Эргүүл дуудаж авчраад гестапод хүргүүлэх болов уу? Тийм байх ёсгүй! Моникагийн дотроо бодож байгааг тааж мэдлээ ч гэсэн тэгэх хүн биш. Буу зэвсгийг зохих газар нь хүргэж чадаагүйн учир Генрихийг өөрийг нь баривчиллаа ч гэсэн Моникаг мэдүүлэхгүй. Моника үүнийг бүхий л бие цогцсоороо мэдэрч байна. Хэдий тийм боловч бүсгүй бүүр илэн далангүй байх арга алга. Яагаад вэ гэвэл өчүүхэн төдий ч атугай эргэлзээ байгаа цагт ганц өөрийн сэтгэлд хөтлөгдөн нийтэд осолтой алхам хийх эрх байхгүй. Генрихийг тэр галт тэрэгтэй нь хамт яв гэж тушаасан ч гэсэн үү? Генрихт үнэхээр тийм тушаал өгч болох юм гэдгийг санаад Моника цочин чичрэв. — Моника та даараа юу? гэж Генрих санаа зовсон байдалтай асуусанд — Тиймээ жаахан даарч байна гэж бүсгүй хариуллаа. Уг нь намар орой болсон боловч тэр өдөр гайхалтай дулаан байжээ. — Эндээс хоёрхон алхмын газар миний сууж байгаа зочид буудал бий. Тэнд орж дулаацаж, амрах юм биш үү? гэсэнд Моника толгой сэгсэрч. — Өө, юу гэсэн үг вэ? гэв. — Та бид хоёр хоёулхнаа үлдэж байсан удаа ганц биш биз дээ? Би таныг өөрөөсөө айхаар өчүүхэн ч шалтаг өгөөгүй шиг санах юм.

Ялдамд хэлэхэд би энэ үед гэртээ байх учиртай. Надад чухал зүйл мэдээлэх ёстой юм ... гэсэнд — Та ажил явдлаа дуусгасан уу? — Бүх ажлаа дуусгасан. Галт тэрэг хөдлөх цагийн тухай утсаар хоёр минут ярьчихвал бүрмөсөн чөлөөтэй болно. Та хоёр минутаас илүү уйдахад хүрэхгүй байх гэж амалъя гэвэл — Гэсэн ч ... гээд бүсгүйг тээнэгэлзэхэд — Тэр зочид буудалд таны байхыг хүн харуузай гэж айж байна уу? Хэмээн Генрих асуусанд — Тиймээ. Энд намайг таних хүн нэг ч байхгүй болохоор нөгөөх хүүхнүүдийн нэг гэж бодож магадгүй ... Энэ зочид буудал чинь офицеруудын буудал шүү дээ. — Энэ гудамж хүн цөөтэй. Хүн дайралдсан ч бид хүлээж байгаад өнгөрүүлнэ гэлээ. Моника дуугүй толгой дохиж, алхаагаа хурдасгав. Өөрийг нь хүлээж байгаа эвгүй явдлаас бушуухан салахын түүс болсон мэт санагдав. Курт өрөөндөө байлаа. — Хэн ч ирсэн намайг байхгүй гэж хэлээрэй гэж Генрих явуут тушаагаад Моникаг өрөөндөө оруулав. Одоо анх уулзсан минутын адил дуугүй байх нь эвгүй боллоо. Тэгээд бүсгүй аян замынхаа тухай ярьж, нэг сонин юм олоод хэлчих гэж дэмий л оролдовч тийм юм олж чадаагүй бантан ичингүйрэв. Генрих ч гэсэн бүсгүйгээс дутуугүй сэтгэл түгшжээ.

«Савойя» ресторанд гарсан тэсрэлтийн тухай яриа л яриаг сонирхолтой болгов, Моника сормуусаа буулган яриаг чагнаж суулаа. Нүдэнд нь ерийн нэг сониуч зангаас илүү юм байгааг Генрих олоод үзчих магадгүй гэж айсан нь илт ажээ. Генрих ярианы далимд өөрөө амь үрэгдэх шахсаныг дурссанд бүсгүй бас цочоод тэрнийгээ булзааруулан: — Би бас л даараад байна гэж тайлбарлахад нь — Танд одоо нөмрөх юм өгье гэж Генрих хэлээд пиджак цамцаа нөмөргөх гэтэл энэ үеэр Куртийн байгаа өрөөнд хүний хөлийн чимээ гарсанд Генрих уруул дээр хуруугаа тавьж, зочин бүсгүйг чимээгүй бай гэж дохив. — Ахлах дэслэгч фон Гольдринг гэртээ байна уу? гэж хаалганы цаана сөөнгө дуутай хүн дуугарах сонсдов. — Байхгүй, гадагшаа гарсан гэж Куртийг хариулахад — Шмидт чи яагаад энд байж байдаг билээ? Чамайг Дорнод фронтод явуулах ёстой байсан шүү дээ гэж нөгөө сөөнгө дуу дахин гарсанд — Намайг ахлах дэслэгч фон Гольдринг өөрийн үйлчлэгч цэргээр шгабын дэргэд үлдээхийг хүссэн юмаа, эрхэм ахлах дэслэгч ээ гэж Куртийн хариулах сонсдоод — Чамайг ямаршуу этгээд болохыг таниагүй юм байж л дээ Би түүнд хэлнэ ... Одоо дуулж бай. Битгий хутгаж орхиорой. Долоон зуун наян долдугаар галт тэрэг маргааш орой найман цагт явна гэж ахлах дэслэгчид дамжуулаарай. Өөрөө бидэнтэй хамт явахыг хүсвэл эртхэн шиг хэлнэ биз. Бид өрөө бэлтгүүлье. Мэдэв үү? Өглөө би өөрт нь дахин утасдана. Тэгэхгүй бол тэнэг минь чи хольж хутгаж орхино биз гэсэнд — Ойлголоо. Хольж хутгахгүй. Ахлах дэслэгчийг эргэж ирэх буюу утасдсан тухайд нэн даруй дамжуулья гэж Курт хариулав. Энэ яриа болсон өрөөний хаалга хаагдах сонсдов. — Та бас тэр галт тэргээр явах юм уу? гэж бүсгүй асуухдаа сэтгэлийн догдлолыг нуух гэж оролдсон боловч чадсангүй. Дууны өнгө, нүдний харц, биеийн байдал, аль алинд сэтгэл хөдөлсөн нь нэвт мэдэгдэж байлаа. «Нууц тэмцэгч хонгор минь, чи мөн ч туршлагагүй байна даа!» гэж Генрих хэлэн алдаад биеэ барьж, хайхрамжгүй өгүүлсэн нь: — Фельднер хориод цэрэгтэй өөрөө дөнгөнө. Зургаан вагонд энэ харин ч ихдэх юм. Бид машинаар явна, тийм биз дээ? Бид тэгж болзсон шүү дээ. Маргааш хотоор зутаалъя. Хоолны дараа явахад болох юм гэсэнд — Үгүй, би өнөөдөр эргэж харих ёстой. Би ээжид амалсан. Ээжийн бие муухан байгаа гэхэд нь — Нөгөө үеэл эгч чинь яалаа? Та түүнтэйгээ уулзаж амжсан уу? гэсэнд —

Эгчид ээжийн илгээсэн юмыг өгчихсөн. Бидэнд яриад байх гойд юм байхгүй. Үеэл эгч саяхан манайд очоод буцсан юм л даа. — Тэгвэл би Фельднерт машинаар буцна гэж хэл өгье. Тэр завсар та төхөөрч бай. Таныг хаана очиж авах вэ? — Яг хоёр цагийн дараа та бидний өнөөдөр уулздаг гурван гудамжны билчрийн булан дээр таныг хүлээж байя. Таны санаанд таарч байна уу? — Бүрэн болно. Түүгээр үл барам таныг үеэл эгч дээр чинь хүргэж өгөх цаг ч байна. — Үгүй, үгүй, тэр хэрэггүй. Үеэл эгч цонхоор харчихаж магадгүй, тэгээд юу ч бодох юм билээ! гэж бүсгүйг сандрахад нь Генрих инээмсэглэн Моникагийн өөдөөс харсанд бүсгүй доош харав. Моникаг гарсны дараа Генрих өнөөдөр машинаар буцна гэдгээ Фельднерт хэлээд галт тэрэгний харуул хамгаалалтад холбогдолтой сүүлчийн зааврыг өгөв. Лемке дээр ороод гарах жаахан цаг үлдсэн байв. Генрихийг хошууч их хүндтэй бөгөөд эелдэгхэн угтлаа. Харин «Савойя» ресторанд болсон халдлагыг зохион байгуулагчдын ул мөрийг олсон гэж сайрхах юм байсангүй. Генрих явах болсон учир гэмт этгээдийг эрэхэд нь гестапод туслах бололцоогүй болсондоо харамсаж байгаагаар илэрхийлэв. Генрих хоёр цагийн дараа болзсон газар ирэхэд намрын намираа бороо шаагиж байлаа. Моника хараахан ирээгүй байх тул Генрих машинаа гудамжны буланд зогсоож хүний анхаарал татахгүй тулд жаахан цааш ярахаар шийдлээ. Хоёр хороолол өнгөрч явтал Моникагийн танил дүр, өндөр нуруутай, цайвар үстэй, цув өмссөн нэгэн хүүхэн хоёр харагдлаа. Тэр эмэгтэй, Моникатай салах ёс гүйцэтгэж, цуваа Моникад нөмөргөх гэж хүчлэн оролдож байгаа харагдав. Генрих машинаа зогсоох гэснээ дүрэмт хувцастай яваагаа санаад цааш өнгөрч тойрч яваад болзсон газраа эргэж ирэхэд Моника нэгэнт ирээд хүлээж байхад нь — Та цувыг нь авахгүй дээ. Бид хоёрт хэрэг болж юу магад гэсэнд бүсгүй нүдээ ууртай гялалзуулаад — Тэгвэл ..., тэгвэл ... Танд миний мөрийг шагайж байх эрх хэнч олгоогүй байхаа! гэхэд нь — Санамсаргүй ийм болсон юмаа. Гэвч би энэ санамсаргүй тохиолдолд баярлаж байна. Яагаад гэвэл таны уулзсан хүн үеэл ах биш, үнэхээр үеэл эгч тэр мөртөө сайхан хүүхэн мөнийг нүдээр үзлээ. — Аа та сайхныг нь бас ажиглаж амжаа юу. — Миний нүд ер нь хурц шүү. Таны огт тааварлахгүй байгаа олон юмыг би ажиглаж байдаг юм даа, хонгор багш минь гэлээ. Удалгүй машин Сен-Реми орох замаар хурдалж явлаа. Бороо намдсангүй. Хоёул Генрихийн цувыг хувааж нөмрөхөөс өөр аргагүй болов. Дутуухан хаасан цонхны завсраар борооны хүйтэн ус шүршинэ. Генрих Моникатай хамт Бонвиллоос үдээс хойш гарсан болохоор Курт болохоор гэгээтэйд Сен-Ремид амжиж хүрэхийн тулд машинаа хар хурдаар нь давхиулав. Шөнө энэ газраар явахад аюултай байдаг. Куртийн ард суусан хоёр хүн машины хурдан явдлыг ажигласангүй. Тэр хоёр бие биедээ наалдан үг дуугүй суухдаа бие биедээ ийм ойрхон байж, хоёр биеийн халуун илчийг мэдэрч байхаас илүү сайхан юм энэ дэлхий дээр байсангүй. Ингээд л үргэлж давхиад баймаар, ингэж явсаар байгаад, үнэн нүүрээ нуухыг хэрэггүй, хоёрдмол утгатай тоглоом ч биш, шоглоом ч биш битүү үг хэлж байхын хэрэггүй, харин одоо хоёулангийн нь аман дээр гарч ирээд байгаа боловч хэлэхээс айгаад байгаа: — Хайртай! гэдэг ганцхан үгийг шулуухан ил хэлж болох тийм газар хүрэхсэн гэж хүснэ.

ГАНЦ ДАЙЧИН ГАНЦДАХГҮЙ ДЭД ДЭВТЭР ЮРИЙ ДОЛЬД МИХАЙЛИК

НҮГЭЛТ ХӨНДИЙН НУУЦ Сен-Ремигээс хэдэн километрийн газар дор мина, миномет үйлдвэрлэдэг завод бий гэж Лютц хэлсэн нь эндүүрсэн байжээ. Ахмад өөрийн мэдсэнийг, бас генерал Эверс, штабын бусад хэдэн офицерын мэдсэнийг хэлсэн нь тэр. СС-ийн албаны удирдагч Миллер хүртэл тэгш өндөрлөгт хүрсэн замаас баахан хажуу тийш байгаа бага шиг барилга бол тэр цэргийн заводод орох хаалга гарцаагүй мөн гэж итгэж байлаа. Тэгээд энэ «нууц» гэдгийг мэддэг хүн бүхний толгойд үнэн хэрэг дээрээ хов хоосон газар хамгаалж байгаа юм байна. Энэ бүх барилгыг өнгөлөн далдлах зорилгоор барьсан юм байна гэдэг бодол огт орсонгүй. Германы командлал тэр маш чухал үйлдвэрийн жинхэнэ байгаа газрыг нууцлахын тулд туйлын их санаа тавьсан юм байжээ. Газар доорхи завод байх нь байжээ ... Тэр завод дээр үнэхээр зэвсэг хийдэг байлаа. Газар дор Гитлерийн эзэлсэн бүх орноос олзлогдсон хүмүүс ажиллаж байв. Харин энэ бүгд Сен-Ремийн ойролцоо биш, тэр хотхоноос 25 километрийн зайтай газар, Нүгэлт хөндий гэгчид болж байгаа хэрэг юмсанж. Тэр хөндийг малчид тэгж нэрлэсэн байна. Малчид ийм нэр өгөхдөө энэ нэр нь сүүлдээ тэгж сүрхий онож таарах юм гэж огт санасангүй. Ердөө л тэр хөндийд огт нэвтэрч болохгүй, сайхан нугыг нь билчээр болгон ашиглах нөхцөлгүйд зэвүү нь хүрэхдээ нүгэль хөндий гэж нэр өгсөн байна. Туршлагагүй залуу малчид ахмад хүмүүсийн үгэнд оролгүй, малаа заримдаа тэр хөндийг тал бүрээс нь хүрээлсэн эгц элгэн халил хадны дэргэд аваачдэг байжээ. Гэтэл уруудчихаж болмоор арай налууухан шиг газар олох гэсэн тэдний бүх оролдлого талаар болдог байна. Хөндийг гагцхүү дээрээс харж болох бөгөөд тийнхүү дээрээс харсан хүн болгонд нэгэн аварга биетэн лут том гортигоор дугуй тэг зураад, дараа нь тэр асар том хотгорын ёроолыг бүрхсэн арвин тансаг ногоон хивсэн дээр хүний хөл гишгүүлэхгүйн тулд эргэн тойрон эгц халил хад өрөөд тавьчихсан юм уу гэмээр санагдана. Тойрон аялагчид байгалийн тэр бүтээлийг сонирхон үзэж, үзэсгэлэн сайхныг нь харж нүд хужирлах боловч салхинд элэгдэн борооны усанд угаагдсан байц хадан дээр доош буухдаа бариад авмаар бут сөөгний зүйл үл үзэгдэх тул хөндийд бууж зүрхлэх хүн үл гарна. Ийнхүү Нүгэлт хөндий 1941 оны эцэс болтол атар онгон хэвээр үлджээ. Тэр үед Зөвлөлт Оросыг ялагчийн өмнө өвдөг сөхрүүлэх ёстой байсан цахилгаан дайны онол төдий л их нэр хүндгүй болоод байсан юм. Тэгээд хэдийгээр Гитлерийн дээд командлал тэр онолоо хараахан орхиогүй боловч Москвагийн дэргэд ялагдсаны дараа дайн сунжирч магадгүй, шинэ давшилтад нарийн нягт бэлдэх хэрэгтэй гэдэг нь олон хүнд тодорхой болсон байна. Энэ бэлтгэлд нь армийн зэвсэг төхөөрөмж, ялангуяа цэргийн заводод үйлдвэрлэгдэж байгаа бөгөөд гитлерчүүдийн тооцоогоор бол дайсны армийн ар талын санаа сэтгэлийг алдагдуулах «гайхамшигт зэвсгүүд» нилээд үүрэг гүйцэтгэх ёстой байжээ. Гэтэл Зөвлөлтийн болон холбоотны нисэх хүчний дайралт улам хүчтэй болж байлаа. Цэргийн чухал чухал үйлдвэрийн газрыг бөмбөгдөлтөөс халхлах ёстой болов. Чухам ийм учраас Москвагийн дэргэд бут цохигдсоны дараа зүүн өмнөд Франц болон умард Италид газар дор цэргийн завод байгуулах тохиромжтой газар эрж яваа цэрэг хувцастай өдий төдий мэргэжилтэн үзэгдэх болсон байна. Тийм нэгэн бүлэг Нүгэлт хөндийтэй тулгарчээ. 1942 оны нэгдүгээр сараас хойш Сен-Реми машин дүнгэнэх чимээ тасрахаа байлаа. Дандаа нягт нямбай өнгөлөн далдалсан том том

машин бяцхан хотын дундуур бүхэл бүтэн цуваагаар өнгөрч, цэргийн завод мөн гэж Лютцийн үзэж байсан барилгын дэргэд түр саатан зогсоод дахиад л шинэ тавьсан замаар орж, өмнө зүг нэг тийшээ давхидаг байлаа. Тэр зам хаана хүрснийг хэн ч үл мэднэ. Тэр замаар цэргийн машин явахыг хүртэл хориглосон байв. Францын партизаныуд тэр замын хаана хүрснийг мэдэх гэж оролдсон нь талаар болов. Замд хүрэх газрыг далангийн дагуу байрлуулсан түр цагийн галын цэгүүд дангинатал батлан хаажээ. Гуравдугаар сарын сүүл болоход Нүгэлт хөндийн баруун, зүүн талаас уулын зузаан чулуулгийг нэвтэлсэн асар том хонгил гаргаж, зун нь тэр хотгорт гүн газар дор ирээдүйн заводын анхны цехүүд ажиллаж эхэлсэн байна. Ингээд одоо Нүгэлт хөндий нүгэлт гэсэн нэрэндээ бүүр таарах болж, тэр хөндийг ямар ч эргэлзээгүй Нүгэлт гэж нэрлэж болох байлаа. Польш Шенье буюу үнэнийг хэлбэл энэ нэрийн дор нуугдаж байгаа хүн нүгэлт хөндийг хэзээ ч үзээгүй билээ. Гагцхүү Сен-Ремийн ойролцоох бяцхан тосгонд төрсөн өөрийн эхнэрээс тэр хөндийн нэрийг дуулсан байжээ. Бас тэр өдөр өмнө зүгийнхэн юм болгонд сүртэй нэр өгч байдаг гэж тоглоом хийсэнд залуу эхнэр гомдож, Луизатайгаа анх удаа муудалцсан болохоор Нүгэлт хөндийн нэрийг тогтоосон байлаа. Тэгээд хоёул тэр орой дахин хэзээ ч хэрэлдэхгүй гэж бие биендээ тангарагласан боловч амласнаа зөрчсөн нь бас нэг биш удаа болсон юм. Тэр хоёрыг анх муудалцахад хүргэсэн Нүгэлт хөндий тэдний амьдралд ийм аймшигт үүрэг гүйцэтгэх юм гэж хэний нь санаанд орсонгүй. Олзлогдсон 2948 дугаар хүн хуарангаар нэг дуулдтал чанга орилохгүйн тулд уруулаа зуув. Энэ эртний дурдатгал харанхуйг нэвт гийгүүлснээ Польш энэ гэгээг алдахгүй гэж хичнээн хичээвч алсын гэгээ шиг замхран үгүй боллоо. Ер нь энэ бүгд үнэн болсон явдал мөн билүү? Польш Шеньег газар дор оруулж ирсэн тэр цагаас хойш үнэн бодит байдлыг мэдрэх чадлаа алджээ. Түүнээс хойш болсон юм болгон хар дарсан зүүд шиг санагдана. Энх амгалан хөндийд газар дор нарны гэгээг хэзээ ч үздэггүй, дахиад хэзээ ч олж үзэхгүй хэдэн мянган ажилчинтай оршиж байна гэдгийг ер үнэмшиж болох уу даа? Өнөөдөр хөгшин генералтай ярьсан яриагаар аваад үзье! Иймэрхүү юм байж болно гэж хэний зүүд зөнд орох билээ.

Польш Шенье агшин зуур нүдээ аниад дахин нээв. Үгүй өөрөө амьд байна, унтаагүй байна. Тэгэхлээр генералын хэлсэн зүйл ч үнэн байж. Бүгдийг сэтгэлдээ сэргээн санах хэрэгтэй юм. ... Польш Шеньег нэгэн тасалгаанд оруулжээ. Тасалгаа нь бас энд, газар дор байдаг, цонхгүй тасалгаа юм. Цэргүүд түүнийг оруулаад гарлаа. Уудам том тасалгаа байна. Бичгийн ширээ, хажууд нь зураг овоолсон бас нэг ширээ байна. Бичгийн ширээн дээр хайрцагтай навчин янжуур харагдана. Ширээ рүү гүйж очоод янжуураас нэгийг авч татмаар санагдсаныг яана! Энд тамд орж ирсэн цагаас хойш нэг ч тамхи татаагүй шүү дээ ... Энд ирээд хир болж байгаа билээ? Нэг сар уу, хоёр сар уу? Польш үүнийг мэдсэнгүй. Польш нэг өрөөнд хоригдож байгаа нөхдийнхөө нэг адил өдөр хоногийн баримжааг алджээ. Энд ямар өдрийг хэн ч үл мэдэх тул «өнгөрсөн ээлжинд» гэх буюу «түүний түрүүчийн ээлжинд» гэж ярилцана. Польш тэр янжуурыг харахгүйн тулд ширээнээс нүдээ зайлуулав. Гэтэл харц нь хоёр хурц шөвөг шиг юман дээр тээглэлээ. Огт сормуусгүй хоёр дугуй нүд өөрийг нь цавчилгүй ширтэнэ. Тэр хатсан навч шиг үрчийсэн хөгшин нүүрэн дээр нүд нь л амьд хүн байгааг гэрчилнэ. Мөрөн дээрээ генералын погонтой нэгэн өвгөн хаа нэгтгээгээс гэнэт гарч ирээд: — Та юунд

тасалгааны дунд зогсоо вэ? гэж асуухад нь: — Би ширээнээс дэргэд очихоос зовсон юм. Тэнд баахан зураг байна. Нууц зураг ч юм билүү, яаж мэдэх вэ ... гэсэнд хажууханд нь хүн инээж байгаатай төсөөтэй хүл хүл дуугарах сонсогдлоо. Поль тэр чимээ хаанаас гарч байгааг ойлгосонгүй эргэж харсан боловч тасалгаанд өөр хүн алга. Тэгээд сая л өвгөн генерал инээж байгаа юм байна гэдгийг мэдлээ. Тэр генерал нэг л жигтэй хачин инээнэ. Омойж үрчийсэн уруул, нүүрний нэг ч булчин хөдөлсөнгүй. Гагцхүү цүдгэр том гэдэс нь хүлхэгнэн оволзож, мундирийн нь товч юу юугүй тасрах нь уу гэмээр агаад нарийн улаан судас сүлжилдсэн хамрын том нүх ялимгүй сарталзана. — Манай заводын нууцыг та мэдлээ гээд бидэнд ямар хор, танд ямар ашиг болох юм бэ? Өөр улсад өгөх үү дээ? гэж генералыг асуухад Поль дуугарсангүй, ер нь ч түүнээс хариу дуулах гэж асуусан хэрэг биш байжээ. Генерал үргэлжлүүлэн: — Та манай заводын тухай юм бүгдийг мэдэж болно. Ойлгож байна уу? Бүгдийг шүү! Энэ завод хаана байрласны мэдэх нь танд сонин байна уу? Хэлж бололгүй яах вэ? Баруун өмнөд Францын уулсын дунд Нүгэлт хөндий гэдгийн дор байгаа юм гэхэд нь Поль дуу алдахгүйн тулд шүдээ зуулаа. Генерал инээдэндээ хахаж цацан гүзээ нь улам их түнхэлзэж: — Бид юу үйлдвэрлэдгийг та сонирхож байна уу? Энэ асуултад ч хариулж болох байна. Автоматаар бөмбөг хаях оптикийн (хараа зүйн) багаж хэрэгсэл үйлдвэрлэдэг юм ... та одоо намайг яагаад тантай ийм илэн далангүй ярьж байна вэ гэж асуух биз дээ? гээд генералын нүд хортой гялалзаж, нүүрийн үрчлээс нь татвалзан хөдөллөө. Тэгэхэд нь Поль: — Эрхэм генерал танаас ганц л юм асууя. Та ямар үндсэн дээр намайг энд барьж байгаа юм бэ? Би олзлогдсон хүн биш, гэмт хэрэгтэн биш, Францын нисэх онгоцны заводтой гэрээ байгуулаад биеийн хүчин үнэлэн ажиллаж байгаа хүн. Над дээр шөнө танихгүй улс очоод заводын захиргааны өмнөөс яаралтай зөвлөлгөө авахаар нэн даруй хамт явахыг хүссэн юм. Гэтэл хотоос гадагш гараад намайг битүү машинд хүчээр түлхэн оруулж хааш авчирсныг мэдэхгүй байна. Эрхэм генерал аа! Би ийм явууллагыг эсэргүүцэж байна. Энэ бол наад захын хууль ёс, хүний эрхийг зөрчсөн, үзэгдэж дуулдаагүй хэрэг байна гэсэнд генерал гэнэт инээхээ больж ширээгээ шаагаад: — Боллоо. Хууль ёс, хүний эрх гэнэ шүү ... Энэ үгээ та хурал цуглаан дээр хэлэх юм байгаа биз. Та бид насанд хүрсэн улс байна, ийм бачит үггүй ойлголцож болно. Энэ дэлхий дээр байдаг маргашгүй ганц эрх гэвэл хүч дийлэх эрх юм. Тэгвэл хүч бидний талд байгааг та биеэр үзэж мэдсэн. Та бол нисэх онгоцы авьяастай зохиойн бүтээгч, тийм учраас бидэнд хэрэгтэй байна. Үүнээс үндэслэн бидний эрх, таны үүрэг гарч байгаа юм. Ойлгов уу? — Сайн ойлгосонгүй. Танай ёс суртахууны хуульд нэг сүрхий дутагдал, буруу тооцоо байхад болно. Та нар бие махбодын хар хүчин хэрэглэж болох юм биз. Хэрэглэсэн ч байна, харин таны хэлснээр миний авьяасыг хүчээр ашиглахын тухайд гэвэл ... гэсэнд, — Өө, биднийг тийм гэнэхэн улс гэж бодно уу? Бид ийм туйлын арга хэмжээ авахдаа буруу тооцоо хийгээгүй, ёстой хамгийн нарийн тооцоог удирдлага болгосон юм. Хүнийг эхлээд туйлын хүнд нөхцөлд оруулаад, аврагдах өчүүхэн ч найдлагыг нь тасална. Та бодвол манай эндхийн журамтай танилцаж, хүүр шатаах газрыг үзсэн биз. Дараа нь амь гарах цорын ганц бяцхан найдлага төрүүлнэ гэж генерал өгүүлэхдээ сүүлчийн өгүүлбэрийг хүн тамлаж сурсан байдлаар бах нь ханасан янзтай сунжруулан хэлээд ярилцаж байгаа хүндээ ямар сэтгэгдэл төрүүлснийг царайнаас нь олж үзэхийг хичээн ажиглав. Поль цөхрөнгөө барж, хилэгнэснээ нуухын

тулд хамаг хүчээ дайчилж — Тэр найдлага нь ямар найдлага юм бэ? гэж жигд тайван дуугаар асуугаад өрийн ийм тайван байгааг өөрөө гайхав. — Ха-ха-ха. Та намайг хамаг байдгаа нэгмөсөн дэлгэж орхиосой гэж бодно уу? Ер нь дэлгэсэн ч яах вэ дээ. та манай завод дээр үзэж амжсан, цаашид үзэх юм бүхний тухай хойт насандаа бурхан тэнгэрт л очиж хэлэхгүй бол өөр хэнд ч хэлж чадахгүй шүү дээ! Та одоо Поль Шенье биш, хоёр мянга есөн зуун дөчин наймдугаар хүн. Ер нь эндээс үхсэн хүнийг ч гадагш нь гаргадаггүй юм. — Тэгвэл таны хэлээд байгаа ганц найдлага гэдэг чинь чухамдаа байхгүйтэй адил юм шив дээ. — Бусад хэн бүхэнд бол тийм. Танд болоод тан шиг хэдэн хүнд бол тийм биш. Хэрэв та учир зүйтэй сэтгэж чаддаг бол ... Ингэхэд та суугаад янжуур татаж болно. Сайн янжуур учир зүйтэй сэтгэхэд тус болдог юм гэж генерал хэлээд хайрцагтай навчин янжуурыг Польш ойртуулж өгөөд өөрөө асаагуур барив. Шенье тамхи асаагаад нэгэнтаа шунан сорсонд гэнэт толгой нь эргэлээ. Генералын харжигнасан дуу тэртээ холоос сонсогдох шиг болж, — Тамхи татаагүй удсан уу? Өө тэр гайгүй! Одоо зүгээр болно гэж генерал, Шеньетэй жирийн нэг уулзаж ярилцахаар уулзсан хэзээний танил юм шиг дуугаар өгүүлэв.

Поль тамхиа дахин нэг сорсонд толгой нь эргэхээ болилоо. «Сэтгэл хөдөлснөө мэдэгдэхгүй биеэ барьж байгаад энэ хөгшин чөтгөрийн юу хэлэхийг бүгдийг нь сонсох юм шүү ... би эдэнд нэг хэрэгтэй бололтой, түүнийг нь ашиглая. Хамгийн гол нь цаг хожиж, гарах арга зам эрээд байх хэрэгтэй!» гэж Поль дотроо боджээ. — Танд тамхи олгож байж болно гэж генерал үгийн далимд хэлэхэд нь,

— Та надад энэ таатай мэдээ дуулгах гэж дуудаагүй биз дээ? гэж ёжлон асуусанд — Зарим талаар үүний тулд ч дуудсан юм. Та ухаантай хүн гэдгээ үзүүлбэл таны байдлыг зүйлээр хөнгөвчилж болох байна. — Би ухаантай хүн юм гэж бодъё. Тэгвэл ... — Тэгвэл та ингэж бодох ёстой ... Герман ялах нь хэрэв би тэр ялалтанд тус дөхөм үзүүлбэл миний амь гарах цорын ганц найдлага юм. Учир нь Герман ялагдвал энэ завод тэс үсэрч, заводтай хамт би ч тэс үсэрнэ гэж бодох ёстой ... — Генерал та сэтгэхүйн элдэв аялал хийлгүйгээр надаас юу шаардаж байгаагаа шулуухан хэлчихэж болохгүй юу? — За яах вэ шулуухан ярья. Та овоо учир мэдэх хүн шиг байна. За ингээд: манай бөмбөгдөгч онгоцны шагайх хэрэгсэл бидний сэтгэлд хангалтгүй байна. Би энд хэд хэдэн тэргүүн зэргийн инженер цуглуулсан. Тэдний яс үндэс, улс төрийн үзэл баримтлал мэтийн газар дээр бол их учир холбогдолтой байдаг элдэв аар саар юм бидэнд хамаагүй. Тэднээс болоод танаас бидний шаардах юм гэвэл: уг багажийг төгс боловсронгуй болгох талаар хийж байгаа ажлын явцад бидний өмнө тулгарсан техникийн зарим нэг бэрхшээлийг шийдвэрлэхэд туслах хэрэгтэй. Хэрэгтэй бүх зураг, техникийн тооцоог та маргааш ерөнхий инженерээс аваарай. Таны мэдэлд номын сан, туслагч нар өгнө. Та бүх цехэд чөлөөтэй орох бололцоотой байх болно. Нэг сарын дараа та саналаа бидэнд тавих ёстой. Бид үзээд таныг зөв замаар явж байна гэдгийг мэдвэл бидний тавьсан болзол хүчинтэй болж, бид таны амийг хэлтрүүлж, завод нууц биш болсны дараа газар дээр гаргана. Миний хэлээд байгаа ганц найдлага гэдэг нь энэ л байна ... гэжээ. ... Поль Шенье хажуудах хүнээ сэрээхгүйн тулд нарийн ханзан дээр аяархан эргэв. Гэвч Стах Лещинский унтаагүй байжээ. Тэр уруулаа Полийн чихэнд тулгаад: — За чи юу гэж шийдэв? гэж шивэгнэн асуухад нь — Чамд хэлсэн шүү дээ. Хамаг зургийг нь юу ч үгүй урж тасдаад ерөнхий инженерийнх нь нүүрлүү чулуудаж орхино гэв. — Тэнэг хэрэг! Чи өгсөн бичиг баримтыг нь хүлээж авах ёстой. Техникийн бүх тооцоо, ер нь тэр багажтай хамаатай юм болгоныг нь цээжилж тогтоож авах ёстой. — Генералын хэлснээр тур тухай бурхан тэнгэрт ярихын тулд уу? — Үгүй, хэрэв бид чамайг аварч чадвал гадагш нь дамжуулахын тулд, — Бид бүгдээр бүтэшгүй горьдлогоор сэтгэлээ хуурч байна. Генералтай ярьсны дараа би үүнийг баг ноттой мэдлээ. Зугтах өчүүхэн төдий ч атугай бололцоо байсан бол нууц зураг төслийг надад итгэж үзүүлэхгүй байсан. — Гэвч үйлдвэрлэсэн хийцийг боож баглаж, дамжуурга дээр тавьдаг юм. Түүнийг энд газар дор үлдээдэг байх ёсгүй. Хайрцагтай юмыг төмөр замаар хаа нэг тийшээ илгээдэг бололтой. Чамд олгосон нэг сарын хугацааг аминд хамгийн аюул багатай аргаар ашиглах хэрэгтэй юм ... Баглах хэсэгт Андре Сюзен, Вацлав Вашик гэж манайхны хоёр хүн байгаа. Би өнөөдөр тэдэнтэй зөвлөнө. — Бид нууц байгууллагыг бүгдийг нь нурааж магадгүй. — Бид энэ байгууллагыг тэмцэхийн тулд байгуулсан юм. Тэгвэл тэмцэл гэдэг бол заавал осолтой байдаг. Ослыг хамгийн бага болгох нь бидний үүрэг. Энэ бол хорооны мэдэх зүйл болохоос чиний мэдэх зүйл биш. — Энэ олон улсын дотроос яагаад чухам ганц надад амь гарах бололцоо олгож байгаа юм бэ? Чи ч юм уу Жюль, Андре нарын хэн ч ажил хэрэгт хавьгүй илүү тус хүргэж чадна. Та нар өргөн холбоотой, нууц ажил хийсэн туршлагатай улс, би бол Эсэргүүцлийн хөдөлгөөний жирийн нэг гишүүн. — Энэ тохиолдолд Поль Шенье чи л ажил явдалд илүү их тус болох байна. Чи бол инженер хүн. Шинэ зэвсэглэлийн нууцыг зохих газар шилжүүлэх явдал бидний гол зорилт болж байгаа юм. Би чамд хорооны өмнөөс тушааж байна: Чи генералын

сарвайсан ганц хоёр сүрлийг хоёр гараараа зууран авсан юм шиг дүрэм үзүүлэх хэрэгтэй ... — Чи хорооны төлөөлөгчийн хувьд тушааж байгаа юм бол — Байз! Чи эхлээд ийм осолтой ажил хийх зүрх хүрэх үү, үгүй юу гэж өөрийгөө сайн тэнсэж шалга. Сайн бодож үз. Бие ангийг хийсэн хайрцаг хаана очдогийг бид мэдэхгүй, хэзээ ч мэдэж чадахгүй. Вагонд ачихаас өмнө дахин шалгадаг ч байж болох юм. Чиний тэр түр орогнох газар чинь авс болж магадгүй гэдгийг битгий мартаарай. Тэр хайрцгийг яаж тээвэрлэдэг юм бэ, чи хайрцаг дотроос гадагшаа гарч чадах юм уу, үгүй юу гэдгийг бид огт төсөөлөхгүй байна шүү дээ. Чи ийм ажил хийхэд бэлэн байна уу? — Би нууц хорооны ямар ч даалгаварыг биелүүлэхэд бэлэн байна. — Тэгвэл маргаашийн дотор төлөвлөгөөгөө боловсруулаад түүнийг хэрэгжүүлэхэд бэлтгэж эхэлье. Би ажиг сэжиг авахуулахгүйн тулд бусдаас хөндий байх хэрэгтэй. Чиний ажил гэвэл газар дээр гарсан хойноо манай анд нөхдөд хэрэг болж болох юм болгоныг цээжилж тогтоож авах хэрэгтэй ... За одоо унт. Бид бүгдээрээ саруулхан толгойтой байх хэрэгтэй гэж Стах хэлээд нэг ханзан дээр байдаг хүнээсээ биеэ холдуулж тэр даруй унтаад өглөө.

Поль Шенье дахиад удтал нүдээ харан хэвтэв. Ханзны нь дээрээс намхан бетон тааз лүглийнэ. Тэгээд өөрийн нь дээрээс үнэхээр авсны таглаа дарах гэж байгаа юм шиг санагдлаа. Эндээс газар дээр гарах ганц арга гэвэл өөрийгөө хайрцагт хийлгэх хэрэгтэй юм гэж үү? Тэглээ ч гэсэн өдрийн гэгээг үзэж, хүмүүст Нүгэлт хөндийн нууцыг ярих өчүүхэн ч атугай горьдлого байгаа юм гэж үү? Зуугийн дотроос ганц юм уу, түүнээс цөөн тохиолдох өчүүхэн бага горьдлого байгаа юм даа. Бас сул чөлөөтэй болохоосоо өмнө бүтэж үхэхгүй гэхийн баталгаа хаана байна?! Өөрийг нь хийх хайрцаг хамгийн дор, бүх ачааны доод талд орчихож болох шүү дээ. Тэгвэл ч ... гэж Поль бодохдоо хамаг бие нь чичирч, бүр одоо л амьсгалах агаар олдохгүй болсон юм шиг цамцныхаа захыг урав. Айж байгаа хэрэг үү? Мэдээжээр айж байна. Харин айна гэдэг бол аймхай байна гэсэн үг биш. Поль өөрийгөө амьдаар нь харанхуй авсанд хийхийг эрүүл ухаантай байхдаа сайн дураар зөвшөөрсөн юм. Тэгээд эндээс гарна чиг! Даалгасан зүйлийг нь биелүүлнэ чиг! Поль тохой дээрээ өндийн хуаранг харлаа. Хатавчны үзүүрт хоёр давхар ханзны хоорондуур тэртээ тэнд бяцхан цахилгаан ламп бүдэгхэн ёлтойно. Тэр чийдэнгийн гэрэл харанхуйн дундаас хаалганы дэргэдэх ханз, дээр нь атиран хэвтсэн хүний дүрсийг гэрэлтүүлнэ. 1101 дүгээр олзлогдогч байна! Тэр хүн оройноос халууран чичирч эхэлсэн тул өглөө тийшээ өндийж чадахгүй болох биз. Тэгээд түүнд ганцхан зам үлдэнэ. Үгүй, эндээс зайлъя. Тэгэхдээ ганц өөрийгөө аврахын тулд биш, энэ аймшигт зэвсгийг дайсны гараас алдуулах ёстой. Энэ зорилгод хүрэх өчүүхэн төдий ч атугай найдлага байвал тэр найдлагыг Поль ашиглах ёстой. Полийг унтах үед Луизийн царай дахин нүдэнд нь нэг үзэгдээд өнгөрөв. Луиза бодвол Парисаас гараад эх дээрээ, эндээс хэдхэн километрийн газар суугаа биз. Луиза энэ хоёр бие биедээ хичнээн ойрхон мөртлөө хичнээн хязгааргүй хол байгааг мэддэг болоосой. Энэ хоёр уулзаагүй гурван жил болох шахаж байна. Парисыг эзлэгдэхийн өмнө коммунист Андре Ренарыг нэрээ сольж, гитлерчүүдийн хурааж авсан нисэх онгоцны заводад ажиллахыг зөвлөсөн байна. Тэгээд Поль Шенье хэмээх Андре Ренар эхнэртээ ч захиа бичих бололцоогүй болжээ. Хожим нь түүнийг баривчилж энд авчирсан байна.

ГЕНЕРАЛ ЭВЕРСИЙН ХҮНД ӨДРҮҮД Ижил мөрний хөвөөн дэх тулалдаан

Германы командлалын мэдээнд гол суурь эзлэх болсон цагаас хойш генерал Эверсийн сэтгэл тайван байхаа больжээ. Гэхдээ урьдын адил сахлаа мөлчийтөл хусаж, хувцсаа цэмцийтэл нямбай өмсөөд өглөөний яг арван цагт штабтаа, өдрийн яг нэг цагт хоолны газар очдог хэвээр. Зармдаа аль нэг офицерын талаар тоглоомын үг хүртэл хэлнэ. Энэ нэгэнт тогтож заншсан журмын цаанаас зан нь хувирч сэтгэл зовнин, бүр учраа олохоо байсан хүний байдал мэдэгдэнэ. Генералтай бусдаас илүү олон уулзаж хавьтаж байдаг ганц Лютц л генералын зан хувирсныг ажигласан байж болох юм. Одоо генерал Эверс Сталинградын тулалдааны газрын зураг дээрээс бүтэн цагаар тонгойж, өчүүхэн төдий өөрчлөлтийг боловч тэмдэглэж байх болжээ. Генерал Эверсийг гитлерийн командлал нүд үзүүрлэх болсон юм. Бүр 1938 онд нэгэн сэтгүүлд генералын нийтлүүлсэн нилээд дэлгэрэнгүй өгүүлэл үүний шалтгаан болсон байна. Кайзерийн үеийн тактик, дипломат бодлогыг Эверс шинжлэн дүгнээд Герман улс Өрнөд Дорнод хоёр фронт дээр зэрэг тэмцэхээс ямагт айж, оросыг номхотгох бодлого явуулдаг байсныг Эверс сануулан дурдсан байжээ. Эверсийн энэ өгүүлэл тун цагаа олоогүй зүйл болсон байна. Тэр үед Гитлерийн штабын хамгийн нууц хэлтсүүдэд шинэ дайны төлөвлөгөөг улайран бэлтгэж байлаа. Риббентроп орон орноор доншуучлан явж, айлгаж сүрдүүлэх, элдвийг амлах замаар Төв Европын улсуудын холбоог бэхжүүлж байв. Гэтэл яг энэ үеэр олонд нэр гараагүй генерал, хоёр фронт дээр дайтахаас сэрэмжлэн сануулсан өгүүлэл нийтлүүлжээ. Сайн нөхөдд нь санаа тавьж туслаагүйсэн бол Эверс тэр өгүүллийг бичсэний улмаас эмгэнэлт байдалд орж болох байжээ. Зүйд нийцэмгүй өгүүлэл зохиогчийг штабт олны нүдний булай болгож байхгүйн тулд Берлинээс яаравчлан холдуулж, нийслэлээс тэртээ хол байдаг нэг хорооны даргаар томилсон байна. Түүнээс хойш генерал дахин хэвлэлд юм бичсэнгүй. Оростой дайтаж эхлэхэд Дорнод фронтын командлагчаар томилогдсон генерал Браухичтай уулзаж ярилцахдаа орос цэргийг «алах нь хангалттай биш, түүнийг унагахын тулд түлхэх хэрэгтэй» гэсэн хоёрдугаар Фридрихийн алдартай үгийг иш татсан юмсанж. Үүнээс болж генерал Эверсийг ар талын ангид үлдээх болж, Францын өмнө зүгт шилжүүлэн, дивизийн даргаар томилоод тэр үеэс хойш бүр мөсөн мартаж, шагнал өгөхөд тойрч өнгөрдөг болсон байна. Эверсийг Орост талархалтай байдаг хүн гэж зэмлэж болохгүй билээ. Эверс оросуудыг үзэн яддаг, түүнийгээ ч нуудаггүй байлаа. Харин тэгж үзэн ядахдаа эрүүл ухаанаа алдсангүй. Тэгээд генерал сайн нөхөдтэйгээ ярихдаа Оростой байлдах явдал Германд аюултай гэсэн бодлоо хамгаалсаар байжээ. Эверс Оросын цэргийн хүчин чадлын тухай германы жанжин штабын мэдээний үнэн зөвд эргэлзэж, Оросын аж үйлдвэр, хүн амын мэдээнд итгэдэггүй байлаа. Түүгээр ч үл барамхэрэв дайн сунжирвал дайсан этгээд тооны талаар давуу учир германы арми зөвлөлтийн армитай халз тулах нь Германыг сөнөхөд хүргэнэ гэж үнэнээсээ итгэдэг байжээ. Эверс сүүлийн үед өөрийн үзэл саналыг зөвхөн ойр дотны нөхөддөө итгэж ярих болов. Гэхдээ Сталинградын төлөө тулалдаан эхэлснийг гитлерийн командлалын хамгийн том алдаа гэж үзэж байгаагаа хамгийн ойр дотны нөхөддөө хүртэл ярьсангүй. Оросууд тэр асар том махны машин шиг юманд гитлерийн армийн аль шилдэг сайн ангиудыг нухчих бололцоо олж авчээ. Оросууд Сталинградыг тавьж өгдөг юмаа ч гэсэн германы дивизүүд тэртэй тэргүй хамаг цусаа урсгаад Москва тийш давших тэнхэлгүй болохсон. Эверс Паулюсийг ялалт хийгээсэй гэж чин сэтгэлийн угаас хүсэн ерөөж байлаа. Гитлерийн ангиуд Сталинградын

фронтын аль ч хэсэг дээр өчүүхэн төдий урагшилсан мэдээ сонсмогц газрын зураг дээр тэмдгээ их л баяртайяа зөөж тавьдаг байлаа. Гэтэл сэтгэлийн нь гүнд бүх дайны хувь заяа ямар болж дуусах бол гэсэн түгшүүр улам улам хуран зузаарсаар байжээ. Мэдээнд «оросуудын давшилтын» тухай үг анх дуулдахад Эверс өвчин тусах шахав. Мэдээнд энэ ач холбогдол багатай үгнээс өөр гойдын сэтгэл түгшмээр юм байгаагүй боловч аливаа цэргийн хүний адил фронтын байдлыг сайн мэдэх генерал Эверс өөрөө дутууг гүйцээн уншиж сурсан билээ. 1942 оны арван нэгдүгээр сарын 24-ний шөнө Эверс цурам хийсэнгүй. Элэг нь өвдөөгүй, сэтгэл зовоох өөр ямар ч шалтгаан байхгүй атал нойр нь нэг л хүрч өгөхгүй байжээ.

«Өтөлж байна даа!» гэж генерал гуниглан бодоод цаг харж, хүлээн авагч залгатал энэ үеэр өглөөний мэдээ дамжуулж байлаа. Генерал энхийн өгүүлбэрийг сонсмогцоо шөвгөөр хатгуулсан юм шиг орноосоо босон харайв. Зөвлөлтийн цэрэг Сталинградын дэргэд германы 6 лугаар арми, танкийн 4 дүгээр армийг бүсэлсэн байжээ ... Эверс хувцсаа яаран өмсч эхлэв. Хувцсаа хагас дутуу өмсөөд орон дээрээ дахин лаг хийтэл суув. Одоо хаачих билээ дээ? Юу хийж, юугаар тусалж чадах билээ. Энэ бол генералын үхтлээ айж, сэрэмжлэн сануулаад байдаг нөгөө төгсгөлийн эхлэл мөн байлаа. Одоо хамгийн нэр хүндтэй цэргийн зөвлөл дээр Дорнод фронтод болсон байдлыг шинжлэн дүгнэж, дайн хийх цаашдын хэтийн төлөвийн тухай ярихыг хичнээн их хүсэх билээ. Ай даа, тэгвэл Гитлерий стратеги, тактикийн хамаг бурууг хүү татан харуулахсан. Гэтэл одоо юу хийж чадах байна? Юу ч хийж чадахгүй, дуугүй л байхаас өөр аргагүй. Нэг ч үг алдахгүй, одоо толгойд нь эргэлдэж байгаа бодлыг мэдэгдэхгүй байх хэрэгтэй. Дайныг амжилттай дуусгахын тулд Адольф Гитлерийг устгах хэрэгтэй гэж хэлэх нь байтугай, бодохоос ч аймаар шүү дээ. Тиймээ, өөрөө өөрөөс үнэнийг нуухгүй хэлэхэд фюрерийг устгах хэрэгтэй. Ямар ч хамаагүй үнээр нэн даруй Америк, Англи, Францтай салангид гэрээ байгуулж, Өрнө зүгт гараа суллаж аваад хамаг хүчээ дорно зүгт хаях хэрэгтэй. Зөвлөлт холбоот улстай эвлэрнэ гэж санахын ч хэрэг байхгүй. Ингэхлээр бий болсон байдлаас гарах замыг зөвхөн Өрнө зүгт л эрэх ёстой. Энэ бол одоогоор цорын ганц зам юм. Аврагдах цорын ганц найдвар энэ. Тэгэхлээр ажиллаж эхлэх, тэр мөртөө нэн даруй эхлэх хэрэгтэй байхнээ? Харин юунаас эхлэх вэ? германыг аврахын төлөө ч гэсэн, төрийн эргэлт гаргах тийм аюул осолтой хэрэг хийж зүрхлэх хэн байна? Эверс өөрийн бүх сайн нөхөд, санаа нэгтний нэрийг нэгд нэгэнгүй бодож үзэв. Тийм хүн дээд командлалын дотор ч бий. Одоо тийм хүн бүүр олон болоо биз. Уулзаж, ярилцаж зөвлөх хэрэгтэй юм. Нэн даруй хөдлөх хэрэгтэй, эс тэгвэл хожимдоно. Генерал босч албан тасалгаандаа оров. Байшингийнхан бүгд унтаж байжээ. Үүр цайж, өглөөний нам гүмд байшингийн дэргэдэх цардсан замаар алхлах харуулын цэргийн хүнд гутлын чимээнээс өөр анир үл сонсоно. Харуулын цэрэг жигдхэн тов тов алхална. Ирээдүйдээ бат итгэсэн хүн л ингэж алхалдаг бизээ. Тэгснээ генерал ийм хүнд тахтай гутал өмссөн цэргүүд хээр талын дундуур оросуудаас хар хурдаараа зугтан гүйх хэрэгтэй болохыг төсөөлөн бодов. Цэргийн ийм хүнд тахтай гутал өмссөн мянга түмэн хөлийг Эверс төсөөлөн бодов. Тэд нар хар чадлаараа гүйж, цасанд шигдэн, дахин босч, эцсийн хүчээ шавхан зугтаж байгааг төсөөлөн санав ... Генерал цонхны цаанаас сонсогдох хөлийн чимээг намсгах гэж хөшгөө буулгав. Гэвч тэр хөлийн чимээ цагийн цохилт шиг жигдхэн түг түг хийж,

мэдрэлийг нь хөндөн цочооно. Үгүй, генерал зүгээр сууж байх эрхгүй! Ажиллах хэрэгтэй, ямар ч байсан хөдлөх хэрэгтэй! Цаашдаа улс орны Гитлерийн хөтлөн аваачиж яваа ёроолгүй нүхийг харж чадахаа больж нүдэн балай болсон дээд командлалд үг дуугүй захирагдаж суудгаа болино. Тайван бөгөөд ухаалаг буурьтай хөдлөх хэрэгтэй. Санаа нэгтнийг болгоомжтой эрэх ёстой. Хэрхэвч яарч болохгүй, ялангуяа муу таних хүнд хэтэрхий итгэж болохгүй. Эс тэгвэл хамаг ажлыг бүх эхэнд нь хөөдөж орхино. Генерал бичгийн ширээний ард удтал сууж, төлөвлөгөөгөө бодож боловсруулжээ. Гүн бодолд дарагдан байтал хаалга тогших чимээ гарч, шивэгчин эмэгтэй орж ирээд: — Амрыг эрье! Өглөөний хоол өгч болох уу? гэж асуухад нь — Тэг гэж Эверс товчхон хэлээд цаас гаргаж корпусын даргад илтгэх хуудас бичиж эхэллээ. Генерал хувийн чухал хэрэг бий гэж шалтаглан Берлин орох хоёр долоо хоногийн чөлөө олгохыг хүсчээ.

Генрих генерал Эверсийг ирэхээс урьд Лютцтэй ярилцаж амжихын тулд голдуу арван цагаас хэдэн минутын өмнө штабт ирдэг заншилтай билээ. Энэ үед генералын туслах штабын бүх сониныг сонсож амжаад тэрнийгээ улам их талархан үзэх болсон Генрихт дуртайяа ярьдаг байлаа. Энэ өглөө Лютц дуу шуу цөөнтэй байв. Генрих яриа дэлгэх гэж хэдэнтаа амжилтгүй оролдсоны эцэст: — Эрхэм ахмад өнөөдөр яасан дүнсгэр байх юм бэ? гэсэнд — Таны санаа сэтгэлийн байдалд ямар ч үйл явдал нөлөөлдөггүй юм уу? гэж Лютц хэлээд, Сталинградын фронтоос ирсэн сүүлийн мэдээг Голдрингт өгөв. Генрих эхний хэдэн мөрийг уншаад аяархан исгэрч, царайныхаа байдлыг Лютцээс нуух гэж мэдээрүү улам тонгойлоо. — Та өглөөний мэдээ сонсоогүй юм уу? гэж Лютцийг асуухад: — Би үхсэн юм шиг унтдаг. Тэгээд өглөөгүүр радиогоо ер залгадаггүй гэсэнд — Одоо өглөө оройгүй чагнаж байх хэрэгтэй болно гэлээ. Хоёул дуугүй болж, энэ шинэ мэдээг дор бүрдээ өөр өөрийнхөөр үнэлэн бодов. — Карл, та энэ бүгдийг ямар учиртай гэж бодож байна вэ гэж Генрих эхлэн дуугарсанд — Би ч муухан стратегич шүү. Хэдий тийм боловч зарим нэг дүгнэлт аяндаа гарч ирээд байна. Сэтгэл гонсоймоор дүгнэлт. Тэгээд юм бүгд урагштай сайн байгаа гэж ямар ч суртал нэвтрүүлэг надад үнэмшүүлж чадахгүй. Өнгөрсөн жил Москвагийн дэргэдээс ухарсныг манайхны сонин юу гэж тайлбарласныг та санаж байна уу? Тэгэхэд манай цэрэг өвлийнхөө байранд шилжих ёстой байсан юм гэж баталцгааж байсан шүү дээ. үүнийг үнэмших хүн гарч л байсан. Үнэнийг нууж байдаг энэ бодлогод миний уур хүрээд байх юм. За одоо Паулюсийн армийн бүслэгдсэнийг манай суртал нэвтрүүлэг юу гэж тайлбарладаг бол? Бид ижил хавийн салхинаас зөвлөлтийн цэргийн ар нуруугаар нуугдаж хорогдохын тулд зөвлөлтийн цэргийн бүслэлтэнд орсон гэх юм болов уу даа? Ай Генрих ээ! гээд Лютц үгээ хэлж дуусаагүй байтал нэг хүн хаалганы бариулыг угз татаж, Миллер орж ирээд, мэнд ус ч үгүй: — Генерал тасалгаандаа байна уу? гэж асуухад — Одоохон ирнэ гэлээ. Хошууч тасалгаан дотуур нааш цааш холхиж, сэтгэл нь хөөрөн гараа хавирч, үе үе хаалга өөд харна. Сэтгэл нь ихэд түгшсэн байх тул Лютц, Генрих хоёрын хэн нь ч чухам юу болсныг асууж түвдсэнгүй. Төдөлгүй Эверсийг ирмэгц Миллер түүнтэй хамт албан тасалгаанд нь орсноо нэг ч минут болоогүй байтал генерал өөрөө хоёр офицерыг дуудаж: — Эрхэм хошууч тун ёозгүй мэдээ хүргэж иржээ. Өнөө шөнө Шамберигээс Сен-Реми орох замд партизанууд манай дивизэд зэвсэг авчирч явсан галт тэргийг онхолдуулсан байна. Ахлах дэслэгч Фельднер хүнд шархтаж, хамгаалалтын цэргийн

хэсэг нь алагдаж, зарим нэг нь тарж зугтсан байна гэсэнд — Зэвсэг нь яасан бэ? гэж Генрих, Лютц хоёр бараг нэг зэрэг дуу алдсанд: — Партизанууд зэвсгийн зөвхөн зарим хагасыг булааж авсан байна. Аз болоход шинэ хамгаалалттай гал тэрэг амжин иржээ ... гэж генерал үгээ дуусгаж амжаагүй байтал нуудасчин офицер орж ирэхэд нь — За та юун эдээ авчраа вэ? гэж тэсгэлгүй асуугаад нууцыг тайлсан мэдээг авч уншсанаа тэр бичгийг ундууцан чулуудаж орхиод — Ээ тэр Фауль уу! гэхэд нь — Юу болоо вэ, эрхэм генерал аа? гэж Миллер асуугаад шидсэн мэдээг зөвшөөрөлгүй авч хараахан зүрхэлсэнгүй. — Партизанууд өнөө шөнө нүхэн замд орох амыг хамгаалж байгаа манай арван долдугаар тулгуурт байрыг дайран довтолсон байна ... гэхэд нь — Ганц өдрийн дотор даанч олон хэрэг давхацжээ! гэж Миллер тасалсанд генерал гашуунаар ёжилсон байдалтай өгүүллрүүн: — Та үүнийг санамсаргүй тохиолдол гэж бодож байна уу? Зөвлөлтийн цэрэг Дорнод фронт дээр ялах удаа бүр гүн талд байгаа биш үү? Партизанууд Сталинградын дэргэд манай цэрэг өүслэгдсэнийг манай мэдээнээс олж мэдээд галт тэрэг, тулгуурт байрыг дайрсан гэдэгт би лавтай бодож байна гэсэнд: — Бараг үнэн биз гэж Миллер зөвшөөрсөнд — Эрхэм Миллер та жаахан саатан сууна уу. Бид тантай зарим нэг арга хэмжээний талаар зөвлөе. Эрхэм ахмад та штабын даргыг даруй дууд! Ахлах дэслэгч Голдринг танд би яаралтай даалгавар өгье. Манай арван долдугаар тулгуурт байр байдаг Понтейнд очиж, партизанууд довтолсон тухай бүхий л байдалтай нарийвчлан танилцаад дэслэгч Фаульд өгч, өнөөдөр яг арван есөн цагт надад илтгэ гэхэд нь — Ёсоор гүйцэтгэе, эрхэм генерал аа! гэж Генрих хариулаад генералын албан тасалгаанаас яаран гарсан боловч Лютцийн тасалгаанд түр саатан зогсож — Карл аа! Надад унаагаар туслаач. Манай жолооч, Бонвиль орсны дараа машиндаа үзлэг хийж, нэг юмыг нь задалжэ орхиод байгаа ... Штабын машиныг хэрэглэж болохгүй юу? — Генералын занг чи өөрөө эс мэдэх биш, хэзээ ч хаашаа ч явах болж магадгүй. Мотоцикль аваад яв гэхэд нь: — Энэ чинь харин ашигтай юм байна. Курт гэртээ үлдээд орой болоход машинаа засч дуусна гэсэнд — Ашигтай, ашиггүйг бүү мэд. Хоёулаа бол арай аюул багатайсан! Партизанууд үнэндээ толгойгоо өндийлгөөд байна гэжээ. Генрих хэдийн гараад явсан учир ингэж сануулсныг нь сонссонгүй. Хотоос гадагш ганцаар явах болсондоо баярлаад яарсан байжээ. Гав ганцаар үлдэж, өнөөдөр болсон явдал бүхнийг тайван эрэгцүүлэн бодож үзэх гэжээ. Ганц өглөөний дотор хичнээн олон сайхан мэдээ дуулав!

Сайхан ч өдөр боллоо! Генрих цардмал замаар мотоциклийн хар хурдаар давхив. Дөнгөж саяхан орсон бороонд угаагдсан засмал зам толь мэт гялалзаж, сэрүүн тунгалаг анхилуун агаар цээж дүүрэн Генрихийн сэтгэлийг баясгана. Ингээд зогсох ч үгүй, амрах ч үгүй яваад баймаар санагдана. Харин өмнө зүгт биш, одоо дайны хувь заяа шийдвэрлэгдэж, энэ минутад сая сая хүний зүрх удахгүй ирэх ялалтын баярыг зөгнөн өөрийн нь зүрхтэй нэгэн цохилтоор лугшиж байгаа дорно зүг тийш давхимаар санагдана. Хаана ч явсан Эх оронтойгоо холбоотойгоо мэдэрч, өөрийн нь эх орон тийш бүх хүн төрөлхтний хараа хандаад байгааг санахад хичнээн их баяртай вэ! «Зөвлөлтийн цэрэг Дорнод фронт дээр ялах удаа бүр тэрнийг нь гүн ар талд байгаа бид өөрснийхөө биеэр даруй үзэж мэдэрч байна» гэж генерал хэлсэн байхаа! Ай даа, та нар энэ байтугай, үүнээс их юм үзнэ вий! Партизанууд ямар ч атугай галт тэргийг онхолдуулж чадсан

байна. Харин зэвсгийн зөвхөн зарим хагасыг авч чаджээ. Бүгдийг авч чадаагүй нь харамсалтай. Тэр тулгуурт байрыг ямар зорилгоор дайрсан юм бол? Сонин юм байна. Нэг нүхэн замын тухай генерал ярьж байсан. Нүхэн зам бүр нэг тийшээ орсон байх ёстой ... Нүхэн замыг их төлөв ингэж чанга хамгаалдаггүйсэн ... Ингэхлээр ... Чухам тэнд тулгуурт байр байрлуулах онцгой шалтгаан байсан байж! Сүүлийн үед Генрихийн өөрийн нь үргэлжийн бодол болж яваа цэргийн заводад орох хаалга тэнд ч байж магадгүй ... Үгүй, дүгнэлт хийх гэж яарах явдалгүй юм. Ингэж байгаад буруу замаар орж магадгүй. Тэгвэл цаг алдана гэсэн хэрэг. Одоохондоо нэг л зүйл туйлын тодорхой байгаа нь юу вэ гэвэл, Лютцийн ярьсан завод бол Генрихийн эрээд байгаа завод биш нь гарцаагүй байна. Генрих энэ буруу замаар орчих тун шахлаа! Тэгш өндөрлөг дээр замын хажууд байгаа бага шиг барилгын дэргэд зогсож саатдаг битүү машинууд Генрихийг Лютц болон бусад олон хүний нэг адил төөрөгдүүлсэн байна. Тэр машинууд тэнд хэзээ ч удаан зогсдоггүй, хэзээ ч эргэж ирдэггүй, өмнө зүгт нэг л газарлуу яваад өгдөгийг Генрих ажиглаж мэджээ. Нилээд баримтыг харьцуулаад үзэхэд мөн л газар дорхи завод энүүхэн хавьд өөр нэг газар байгаа юм байна гэсэн бодол төрүүлнэ. Тэгш өндөрлөг дээр туршиж байгаа шинэ миномет, минийг газар дорхи заводад хийсэн гэж штабынхан бүгд ярилцаж байдаг. Тэгвэл түүнийг умар зүгээс ирсэн галт тэрэгнээс буулгасны учир юу вэ? Энэ бүхнийг мэдэхэд маш төвөгтэй боловч цаг дэмий алдаж болохгүй.

Сталинградын дэргэд дарагдсандаа хорсон хилэгнэсэн дайсан этгээд өсөө авч уураа энгийн номхон иргэдэд гаргахын тулд яахаас ч буцахгүй. Генрих нэг цагийн дараа Понтей гэдэг бяцхан суурингаас хоёр километрийн зайтай байгаа тулгуурт байр дээр ирлээ. Суурингаас тулгуурт байр хүртэл асар том бетон хавтан дэвссэн зам тавьжээ. Тэр замыг бага ашигладаг бололтой, хавтангуудын завсраар ганданги өвс ургажээ. Тулгуурт байрны дэргэд гүн хавцлын дээгүүр тавьсан гүүрээр зам дайрч гарна. Урт чулуун байшин цэргүүдийн хуаран болдог байна. Тэнд бас тулгуурт байрны дарга дэслэгч Фауль гэж нас нилээд ахисан, зууван царайтай алжаангуй хөдөлгөөнтэй хүн суудаг байжээ. Генрих өөрийгөө танилцуулаад тулгуурт байрын даргад өнөөдөр партизанууд дайрсан тухай тодорхой ярихыг тушаав. Фауль дөнгөж сая тулалдаанаас гараад дарийн үнэр үзээгүй штабын офицерт сайрхаж байгаа хүний байдлаар хайхрамжгүй, хааш яаш ярив. Энэ нь Генрихийн зэвүүг хүргэж эхэллээ. — Бүх явдал яаж болсныг газар дээр нь заагаад аль гэсэнд Фауль модтой ууланд гаргасан асар том нүхийг зааж, — Бид энэ нүхэн зам, бас гүүрийг хамгаалдаг юм гэв. Нүхэн зам, хуаранг тойруулан мод шороогоор хучсан галын цэгүүдийг хагас дугуйлан байрлуулжээ. Мөн тийм галын цэгүүд гүүрийн хоёр талд байлаа. Фауль яриагаа үргэлжлүүлэн: — Партизанууд уулнаас бууж ирсэн. Гэтэл манай хамгаалалтыг дайсан этгээд суурингийн тэндээс гарч ирэхэд тааруулан байгуулсныг та өөрөө үзэж байгаа биз ... Партизанууд биднийг шөнийн гурван цагт атакласан. Цэргүүд галын цэгүүдэд гүйж хүрэх гэсээр байтал тэднийг пулемёт, автоматаар галлаж байлаа. Байлдаан хагас цаг юм уу, түүнээс ч бага юмуу үргэлжилсэн байж мэднэ. Манай хохирол гэвэл гурван хүн алагдаж, долоон хүн шархтсаны хоёр нь хүнд шархтсан. Түүнээс гадна СС-ийн хоёр цэргийг алсан байлаа гэхэд нь — СС-ийнхэн яагаад ирсэн юм бэ? — СС-ийн цэрэг нүхэн замаас гарах гарцыг хамгаалдаг юм гэв. «Тэхээр нүхэн замаас гарах газрыг илүү нарийн нягт хамгаалдаг юм байна» гэж Генрих дотроо бодлоо. Гольдринг Фаулийг дагуулан гүүрэн дээр гараад: — Түгшүүр зарлахыг

тушаагтун гэсэнд Фауль гар буугаа гаргаж ирээд гурвантаа хий буудав. — Эрхэм дэслэгч ээ! тухайн тохиолдолд партизанууд хойт талаас дайрч ирлээ гэж бодъё. Та яаж шийдвэрлэх вэ? — Би бол ингэх байна ... гэхэд нь, — Ухаархаад байх юмгүй, ажиллагтун гэж Генрих хэлээд хуарангаас гүйн гарч ирсэн цэргүүдийг заалаа. Тэр цэргүүд юу хийхээ мэдэхгүй гүүрийн дэргэд овоолгоотой шорооны дэргэд бөөгнөрөлдөн байлаа. — Эрхэм дэслэгч ээ! би хэрэв хорлон сүйтгэгч байсан болоод дэргэдээ хоёр автоматчинтай байсан бол танай бүх цэргийг тантай хамт цааш нь харуулж орхиод гүүрийг зовох юмгүй дэлбэлчих юм байна гэж Генрих өгүүлэв. Фауль сандарсан байдалтай Генрих өөд хараад цэргүүдэд хойт зүг тийш хандан хориглолтын байр эзлэхийг тушаав. Цэргүүд түргэн зуур хэвтлээ. Генрих нэг цэргийн дэргэд очоод: — Таны өмнө юу харагдаж байна? гэж асуусанд: — Юу ч харагдахгүй байна, эрхэм ахлах дэслэгч ээ! гэж тэр цэрэг үнэнээ өчихөд нь: — Эрхэм дэслэгч ээ! Хориглолтын иймэрхүү системтэй байхад танай цэргүүд юу ч харах аргагүй байгаагаас хамаг учир ургаж байна. эндээс цэргүүдэд ганц тэр өндөрлөг харагдана. Партизанууд ойртож ирвэл тэд нар нэг ч суманд өртөхгүй тийм далд газар байх болно гэлээ.

Фауль цаг үргэлж духныхаа хөлсийг арчин үг дуугүй зогслоо. Генрих бас үг дуугүй эргэж, Фаулийн албан тасалгаа болдог байранд нь очив. — Тулгуурт байрын дэвтэрийг аваад ир! гэж Голдринг тушаагаад уг дэвтэрт шалгасан сэтгэгдлээ бичихээр өөрөө гардаг үзгээ гаргав. Фауль учраа олохгүй сандран зогсож байлаа. — Та цэргээ сургууль хийлгэдэг үү? гэж Генрих арай зөөлөн дуугаар асуусанд — Эрхэм ахлах дэслэгч ээ? Би энд ирээд ердөө долоо хоног болж байна. урьд нь хорооны штабт ажиллаж байсан юм. Би энд ирээд тулгуурт байрын хамгаалалтын талаар сургууль хийлгэж амжаагүй байгаа нь бөөн гай боллоо. Эндхийн цэргүүдийн ихэнх нь Дорнод фронт дээр шархтсаны дараа энд ирсэн шинэ улс гэж Фаулийг хэлэхэд: — Таныг яагаад ийш нь шилжүүлсэн юм бэ? гэсэнд — Манай хүү хэдэн долоо хоногийн өмнө Дорнод фронтоос хөлгүй болоод буцаж ирсэн ... Бодвол илүү үг донгоссон бололтой, түүнийг хорих лагерт явуулсан байна. Тэгээд намайг ийш нь шилжүүлсэн ... Одоо таны дүгнэлтийг уншиж үзээд намайг энд ч байлгахгүй, Дорнод фронтод явуулах биз дээ гэж Фауль өгүүлээд хүндээр санаа алдаж орон дээрээ суув. Генрих дэвтэрт хэдэн үг гүйлгэн бичсэн нь: «Дивизийн дарга дэслэгч генерал Эверсийн тушаалаар 1942 оны арваннэгдүгээр сарын 24-нд миний бие 17 дугаар тулгуурт байрыг шалгаж үзлээ. Зохих газруудыг сайн хамгаалж байгаа юм байна. Байлдааны түгшүүр зарлаж шалгав. Багийн цэргүүдийн байлдааны бэлтгэл, галын хэрэгслийн байрлал өө сэвгүй байна. Шалгалт хийсэн ахлах дэслэгч Фон Гольдринг» гэжээ. — Уншиж үз! гэсэнд бичсэн зүйлийг дэслэгч уншаад — Эрхэм ахлах дэслэгч ээ! Таны ачийг яаж хариулахаа мэдэхгүй байна! гэхэд нь — Танд зөвлөж хэлэхэд энэ газар таны ирээд удаагүй байгааг харгалзан миний хэлсэн бүх алдааг засч залруулагтун ... Би явж болох шив дээ гэсэнд — Намайг яршигтай хүн гэж битгий бодоорой. Гэвч таныг хоолоор дайлахыг хүлээж авбал маш баярлах байна гэхэд нь Генрих урилгыг хүлээн авлаа. Фауль хоолны үед, ялангуяа даосанд халсны дараа үг олонтой болж — Барон та энд хэчнээн уйтгартайг мэдэхгүй байна! Явъяа явах газар байхгүй, ярьяа, ярьчихмаар хүн олдохгүй. Хажууд нь энэ бороо ороод ганц архиар л зугаа гаргаж байх юм гэхэд нь — Таны зэргэлдээ СС-ийн офицерүүд байна шүү дээ

гэсэнд — Бид зөвхөн утсаар харилцаа барьдаг. Биднийг нүхэн замын нөгөө талд очихыг хориглосон юм. Тэд нар чинь утсаар ч гэсэн илүү үг дуугарах улс биш. За тэдний чөтгөр алгад! Бас сүрхий журам тогтоож шүү! Хамгаалчихмаар юм байдаг бол ч бас яахав. Долоо хоноход энэ нүхэн замаар ганц ч машин явж өнгөрсөнгүй ... — Энд дандаа ийм хүнгүй байдаг юм уу? — Дандаа ийм байдаг гэж миний түрүүчийн хүн хэлсэн. Энэ нүхэн зам нүгэлт хөндийд нэвтрэх нөөц хаалга юм байна. жинхэнэ хаалга нь манай эндээс арваад километрийн газар байдаг юм байна. Үгүй, та энэ Нүгэлт хөндий гэдэг нэрийг сонсооч. Ганц нэрийг нь дуулаад солиормоо юм. Гэтэл энд ямар чөтгөртөө хэрэгтэйг мэдэхгүй сууж байна! — Гэсэн ч та чухал газар хамгаалж байгаа гэж бахархаж болох юм. — Танд хэлсэн шүү дээ. бид чухам юу хамгаалж байгааг чөтгөр шулам л мэдэх байх! Хамгаал гэж тушаасан болохоор хамгаалж байна, тэслэ гэж тушаавал тэслэнэ. Бидний мэдэл бага, тушаасныг дагахаас өөр зүйлгүй ... гэж ярив. Дэслэгч Фауль амархан согтож, улам олон юм донгосоон боловч Генрих өөр сонирхмоор юм олж сонссонгүй, Генрих босож: — За эрхэм дэслэгч ээ! Би явах боллоо. Генерал Эверс гэнэт наашаа хүрээд ирвэл би таны өмнөөс нүүр улайхад хүрэхгүй биз гэж найдаж байна гэсэнд, — Бүгдийг гүйцэтгэнэ, эрхэм ахлах дэслэгчээ! Та миний энгийн цэргийн хоолыг голоогүйд тань маш баярлаж байна! Танай офицеруудын хоолны газар илүү сайхан хооллодог байлгүй! Хоноод явах юм биш үү? Ууланд эрт харанхуй болдог одоо цаг оройтож байна. Ялдамд хэлэхэд партизануудад яг тохиромжтой цаг гэхэд нь: — Зүгээр, давхиад гарчихна! гэж Гольдринг хөгжилтэй өгүүлээд мотоциклдоо суулаа

Оройн бүхэнхий үнэхээр уулыг нөмөрсөн боловч Генрих аюулыг огт мартаж орхижээ. Хамаг бодол нь Фаулиас олж мэдсэн зүйл дээр төвлөрлөө. «Нөөц нүхэн замыг хүртэл хоёр талаас нь ингэж хамгаалж байгаа юм чинь, энүүхэн ойролцоо маш чухал газар байх ёстой. Үүний дээр уг газрыг ингэж их нууцалсныг мэдэх юм бол ...» гэж Генрих бодож явлаа. Гэнэт замын ар, өвөр хоёр талаар нь автоматын ээлж тачигнав. Генрих хаазаа нэмж урагшаа ухасхийснээ дараа нь нэг юм мөргөх шиг болоод ойчиж байгаагаа мэдэрчээ. Тулгуурт байр дээр буун дууг сонсоод хэрэг гарсан газар айж ширвэгдсэн дэслэгч Фауль тэргүүтэй мотоцикльчдын отряд нэн даруй давхиж ирэв. Фауль тэр газрыг бүслэхийг тушаагаад өөрөө дөнгөж саяхан хуарангаас хөгжилтэй мордсоноо одоо мотоциклоосоо хэдэн алхмын зайтай шуудуунд хөдлөхгүй хэвтэж байгаа ахлах дэслэгч тийш ухасхийв. Фауль Сен-Реми хүрэх замын туршид Гольдрингт хамгаалалт гаргаж өгөөгүйдээ өөрийгөө зүхэж, генерал Эверстэй өөртэй нь бүү дайралдаасай л гэж хүсч явлаа. Генерал штабт байжээ. Онцгой даалгавар гүйцэтгэгч офицерыг нь ухаангүй авчирсныг Эверс дуулаад энэ өдрийнхөө бүх уурыг Фаульд гаргалаа. Гагцхүү Гольдрингийн амь насанд аюул байхгүй, зөвхөн толгойгоороо хад мөргөж, хүчтэй цохисон байж гэж эмчийг хэлэхэд генерал сая жаахан зөөлөрч, тулгуурт байрын даргыг хатуу цээрлэлгүй тавьжээ.

НӨХӨР, ДАЙСАН ХОЁР МӨР ХӨӨВ «Ээ, толгой яасан их өвдөнө вэ, хичнээн их өвдөнө вэ!» Үнэн юм уу, дэмийрч байгаа юм уу, орны толгой дээрээс эх нь тонгойж байх шиг Генрихт санагдана. Эх нь хүйтэн алгаа хүүгийнхээ духан дээр тавихад хэсэгхэн зуур дотор нь онгойлоо. Хэсэгхэн зуур гайгүй болоод дараа дахиад л санчиг нь лугшиж доргиж эхлэв ... Энэ Миллер, Шульц хоёр хаанаас гараад ирдэг билээ? Энэ хоёр ээлж

ээлжээр толгой руу нь нэг хатуу юмаар цохиод байна. Эд нарт юу хэрэгтэй юм бол? Аа тийм, ёстой нэрийг минь хэлүүлэх гэж байна. ... Би Генрих фон Гольдринг, би Генрих фон Гольдринг ... барон хэргэмтэй хүн. Ханын цаг хаана цохиод байна? дүүжин нь одоохон ганхаад яг санчигийг минь цохих нь ... Хүчилж байгаад гараараа зайлуулах хэрэгтэй юм, гараа ингээд өргөө ... Генрих мөрөөр нь хатгуулж өвдөхөд дуу алдаад сэрлээ. Орны нь толгой, хөл хоёрт байсан хүөр хүний дүрс сандал дээрээ босон харайв. Энэ юу вэ, Курт, Моника хоёр уу? Энэ хоёр яагаад энд байна вэ? Бас толгой минь яагаад ингэж айхтар өвдөнө вэ? — Эрхэм ахлах дэслэгч ээ! Таныг тайван хэвт гэж эмч тушаасан гэж Курт хэлээд тонгойж, Генрихийн дэрийг засч өгөв. Моника дуугүй байна. Моника түмпэнтэй усанд цагаан алчуур хийж мушгиад Генрихийн духан дээр тавилаа. Генрих чухам юу болсныг санах гэж хичээн хэсэг зуур нүдээ аниад хэвтлээ. Жинхэнэ болсон явдал зүүдэндээ үзсэнтэй нь бас л хутгалдсаар байжээ. Гэнэт чанга ярьж дэмийрэн байж магадгүй гэсэн аймшигт бодол төрөхөд Генрих ухаан оров. — Би хар дараад ... нойрондоо хашгирч, юм ярьсан болов уу? гэж хайхрамжгүйхэн асуугаад юу хэлэх бол гэж хирдхийн хүлээв. — Үгүй, эрхэм ахлах дэслэгч ээ, та зүгээр ёолоод байсан. Мадемуазель Моника бид хоёр дахин доктор авчрах юм уу гэж байсан гэж Курт хэлэв. Моника ч гэсэн, Курт ч гэсэн нойргүй хоносондоо нүд нь улайсныг Генрих сая л ажиглаж — Мадемуазель Моника танд, бас Курт чамд их төвөг удлаа гэж сэтгэл уяран хэлээд өндийх гэтэл үгүй, үгүй та хэвт! гэж Моника сэтгэл зовнин дуу алдаад хүйтэн жинг солих гэж Генрихийн дээрээс тонгойлоо ... Танил хөөрхөн царай харагдана. Бүсгүйн царайнаас эх, эгч, хайрт хүний энхрийлэл туяааран байх мэт ... Гар нь ч гэсэн энхрий зөөлөн байна. духанд нь хэчнээн болгоомжтой хүрнэ вэ. хүйтэн алганд нь хацраа наагаад унтахсан. Сайн унтаж нойр авахсан. Генрихт хүч тэнхээ их хэрэгтэй шүү дээ! Миллер ганц өдрийн дотор Голдринг дээр хоёр удаа ирсэн боловч түүнтэй ярилцаж чадсангүй. СС-ийн албаны дарга ахлах дэслэгчийг дайрсан нөхцөл байдлыг тодруулахын тулд хэрэгтэй бүхнийг хийжээ. Ухаан алдсан Генрихийг олсон тэр газрыг Миллер өөрөө нарийн шинжилсэн байна. Нэг бутны дор герман автоматын арваад хонгио байхыг олжээ. Гольдрингийг Бонвиллоос авчрахаар явсан тэр зэвсгээр нь буудсан байж болох юм. Зэвсэг ачсан галт тэргийг довтолсон нь бусад бүх хэрэг явдлын учрыг тайлах түлхүүр болох ёстой. Чухам үүн дээр СС-ийн бүх албан нэг байрандаа дэвхэцсээр байна. одоо болтол галт тэргийг довтолсон нарийн тодорхой байдлыг олж тогтоож чадсангүй, хамгаалалтанд явсан цэргүүдийн мэдүүлэг тун бүрэн дүүрэн биш, ихэнхдээ эсрэг тэсрэг байлаа. Уг нь цувааг дагалдан явсан ахлах дэслэгч Фельднер одоо хүртэл хүнд байдалтай байгаа учир эмч нар уулзуулахгүй байна. тэгээд Гольдрингтой зөвлөн ярилцаж төлөвлөгөөгөө хуваалцахыг машид хүссэн байжээ. Галт тэргийг довтолсны дараа Берлинээс партизануудтай явуулах тэмцлийг хүчтэй болгох тушаал өгөөд нүхэн замыг довтолсон тухай Берлинд мэдсэний дараа партизаны хөдөлгөөнийг дарах талаар авч байгаа арга хэмжээний тухай өдөр бүр илтгэж байхыг Миллерт хатуу тушаажээ. Миллер одоо дээд командлалд авьяас чадвараа үзүүлж болох, үзүүлэх ч ёстой тийм цаг болж, дивизийн хэсгийг бодвол илүү өргөн хэмжээний ажил хийвэл таарахаа батлан харуулах хэрэгтэй боллоо. Чухам энэ талаар Миллерт Гольдринг хэрэг болно. Гольдринг генерал Бертгольдод кахиа бичихдээ СС-ийн нутгийн албаны даргын идэвх санаачлагын тухай хоёр гуравхан үг дурсчихвал Миллер хэргэм тушаал ахих нь

батгай хэрэг. Ялангуяа Гольдрингийг довтолсон этгээдүүдийг олж чадвал сайн. Ай даа, тэгвэл ч Бертгольд Миллерийн төлөө бололцоотой бүхнийг хийх болно. Ингээд Бароныг довтолсон буруутай этгээдүүдийг нэн даруй олох нь чухайл байна ... Тэдний мөр олдохгүй бол яана? За яах вэ, тэгвэл өөр бас нэг арга байна. хэдэн тариачныг баривчлан авч, тэднийг партизануудтай холбоотой гэж ял тулгаад, сүртэйхэн шиг шахаж шаардвал ... Гольдрингийг довтолсон гэдэг өчиг бэлэн болох нь тэр. За энэ ч маргааш өдрийн ажил. Одоо Генрихтэй заавал, аль болох хурдхан уулзах хэрэгтэй байна.

Генрих өнөөдөр орноосоо анх бостол толгой нь дахин өвдөж нүд нь эрээлжиллээ. Миллер ирсэн нь тун зохимжгүй цагаар таарчээ. Түүнтэй ярилцахаас цаашид зайлсхийгээд байх нь аюултай байж болох юм. Ер нь одоо бүх хэрэг явдлыг нэгд нэгэнгүй мэдэж байх ёстой. Германы командлалын мэдээнд Паулюсийн армийг бүслэсэн цагригийг ямар ч хамаагүй үнээр сэтлэхийг хичээж байгаа Манштейны цохих бүлгийн атакийн тухай дурдсан байна. зөвлөлтийн радио фронтын бусад хэсэг дээр зөвлөлтийн цэрэг давшилтад орж байгаа тухай мэдээлж байна. үйл явдал улам бүр түргэн өрнөж байгаа болохоор ийм цагт хэвтээд байж огт болохгүй. Миллер сэтгэл хөөрч баярласан царайтай, Генрихийн өрөөнд орж ирээд: — Генрих ээ, найз минь ... таныг ингэж дуудахыг зөвшөөрнө биз? Би танд халдсан этгээдүүдийг эрсээр бүр хөлгүй болох дөхлөө. Тэднийг олно доо! Заавал олно! Арав, хорин хүн баривчилж, өөрөө байцааж байгаад олно. Үхсэн хүнээс ч үг өчиг авч чадна бий! гээд Гольдрингийн гарыг чанга атгахад нь: — Танд тийм их төвөг удах явдал гарахгүй гэж лавтай итгэж байна, эрхэм Миллер ээ! гэв. — Миллер ий? Та намайг гомдоож байна. намайг Ганс гэж дууддаг. Нэгэнт намайг элдэв ёсорхолгүй, таныг зүгээр Генрих гэж дуудахыг зөвшөөрсөн болохоор ... — Та намайг гялайлгаж байна ... Ганс аа! За тэгээд та хэнийг ч баривчилж, байцаах явдалгүй. Намайг буудсан хүнийг би харсан. Тэр партизануудыг ч гэсэн, галт тэрэг онхолдуулсан партизануудыг ч гэсэн бид хамтаар олж чадна гэж бодож бйана. Энэ сүүлчийнхийг би өөрийн нэр төрийн хэрэг гэж үзэж байгаа болохоор таны эрэлд туслахыг зөвшөөрвөл болохоор таны эрэлд туслахыг зөвшөөрвөл маш их баярлах байна. — Танд чухам ийм санал тавих гэсэн юм, Генрих ээ! Бас үүний зэрэгцээгээр өөрийн төлөвлөгөө, авсан арга хэмжээг танд ярих гэсэн юм. Нэгдүгээрт: Бонвиль орж байгаа буюу тэр хотоос энд ирж байгаа хүн бүрийг шалгана. — Хүн бүрийг шалгаж яах юм бэ? — Бонвиль бол партизаны хөдөлгөөний төв. Чухам тэндээс л зэвсэгтэй галт тэрэгний тухай мэдээ өгсөн нь туйлын тодорхой байна. Манай районд ажиллаж бйагаа партизанууд Бонвильтай байнгын харилцаатай байдаг байж магадгүй. Бид тэр харилцааг нь илрүүлэх ёстой. — Яах вэ, таны зөв ч юм шиг байна. энэ тухай дараа ярья. Миний толгой өвдөөд хагарах нь ээ гэж Генрих хэлэв. Генрих ингэж хэлэхдээ Миллерийг санаа алдаад явах болов уу гэж бодтол цаадах нь харин дахиад бүтэн цаг өуж, Генрихийг үхтэл залхаалаа. Генрих маргааш өглөө нь Моника, Курт хоёрыг хорьсоор байтал штабт очлоо. Лютцийн албан тасалгаанд зөвхөн Генрихтэй нэг штабт ажиллада хүмүүс төдийгүй, дивизийн хамгийн холын хэсгийн салбар ангийг командалдаг офицерүүд цуглараад хөл тавих газар олдохгүй шахуу байжээ. Тэдний дотор Генрихийн анх удаа зүс үзэж байгаа хүн олон байлаа. — Та бүгдийг Генерал өөр

дээрээ урьж байна гэж Лютц хэлэв. Офицерүүд генералын тасалгаанд уван цуван ороход хамгийн сүүлд Генрих, Лютц хоёр орлоо. Эверс онцгой даалгавар гүйцэтгэх офицер хараад найрсгаар мэхийн ёслох завсар штабын дарга Кунст, Миллер, бас дэд хурандаагийн погонтой СС-ийн офицер нэг хүнтэй үргэлжлэн ярилцаар байв. Бүгдээр суудал эзэлсний дараа Эверс өгүүлрүүн: — Ноёд оо! Бидэнд маш чухал үүрэг гүйцэтгэх даалгавар өгсөн. Нууц заводаас франц үндэсний Поль Шенье гэдэг маш аюултай гэмт хэрэгтэн оргож зугтсан нь өчигдөр оройн зургаан цагт тодорхой болсон байна. чухам ямар нөхцөл байдлаар оргоо вэ, гэмт этгээдэд хэн туслаа вэ гэдгийг олж тогтоож чадаагүй байна. Сен-Мишелээс нэг цагийн өмнө хүлээж авсан цахилгаан утсанд сонирхолтой зүйл байгаа нь: тэр заводын бүтээгдэхүүн байсан нэг вагоны шалыг хөрөөдөж цоолсон нүх, нэг эвдэрхий хоосон хайрцаг байсан байна. герман орны дайсан мэдээгүй байгаа, мэдэх ч ёсгүй маш нууц заводаас тэр гэмт этгээд зугтсаныг харгалзах хэрэгтэй. Тэр этгээдийг үхсэн амьд алин боловч баривчлах нь манай нэн чухал даалгавар мөн гээд генерал дуугүй болж, хэлсэн үгнийхээ чухал ач холбогдлыг онцлон тэмдэглэх гэсэн мэт бүгдийг тойруулан ширүүхэн хараад маш албан ёсны дуугаар үргэлжлэн ярьсан нь: — Дивизийн салбар анги бүр штабын дарга Кунтээс нэг өдрийн дотор ганц ч байшин, цэцэрлэг үлдээлгүй нэгд нэгэнгүй нарийн нягт самнан нэгжвэл зохих тодорхой хэсэг газар заалгаж авна. Алыгн чинээ газар ч үлдээж болохгүй. Манай энэ зөвлөлгөөнд суулцаж байгаа дэд хурандаа Кейзнерийн (гээд Эверс тэр СС-ийн офицерийн зүг мэхийн ёсолж) анги өнөө шөнө уулын бүх жим, гарц, давааг хаасан. Гэмт этгээд ууланд партизанууд дээр очиж чадахгүй, манай районд тийм тохьтой цагийг хүлээх болно. Энэ зөвлөлгөөнд суулцсан отрядын дарга бүр өөрсдийн үзэмжээр автоматчдыг томилон гаргаж, салбартаа өөрийн орлогчдоо үлдээгээд зам харгуй, суурин тосгонд хийх эрлийг өөрийн биеэр удирдах ёстой. Гэмт этгээдийг барих аз таарсан офицер түүнийг магадлан танихын тулд энд авчрах ёстой. Баривчилсны шанд нэн даруй таван мянган маркийн шан өгнө гээд СС-ийн дэд хурандаа өөд эргэж харсанд цаадах нь зөвшөөрсний тэмдэг болгож толгойгоо дохив. — Эрлийг хөнгөвчлөхийн тулд та бүхэнд Поль Шеньегийн хажуугаас, урдаас авсан нэг нэг гэрэл зураг өгнө гэж генерал төгсгөлд нь хэлэв. СС-ийн нөгөө офицер суудлаасаа босч: — Ноёд оо! Та бүхэнд өгч байгаа даалгавар бол төрийн маш их ач холбогдолтой даалгавар юм гэдгийг би өөрийн зүгээс сануулах хэрэгтэй байна. Та бүхэнд өгсөн даалгавар, гэмт этгээдийн гэрэл зураг, мөн түүний овог нэр, ажиллаж бйасан газар энэ бүгд маш нууц учраас бид зөвхөн шилмэл офицеруудад итгэмжлэн мэдэгдэж байгаа юм гэхэд нь — Гэрэл зургийг аваад оногдсон хэсгээ мэдэж ав гэж генерал тушаагаад зөвлөлгөөн дууссаныг мэдэгдэж суудлаасаа босов. Офицеруудыг тарж явсан хойно генерал, Генрихийг дэргэдээ дудаж аваачаад: — Барон таны бие ямар байна? — Анхаарал тавьсанд баярлалаа, эрхэм генерал аа! Бие засарч байна. — Ийм үед таны бие муу байгаа нь тун харамсалтай байна. — Би үүрэгт ажилдаа орж чадах байна. эрхэм генерал танд нэг хүсэлт тавихыг зөвшөөрнө үү. — Болно. — Намайг гэмт этгээдийг эрэх ажилд оролцох зөвшөөрөл өгөхийг хүсье, эрхэм генерал аа!

Тэдний яриаг СС-ийн офицер анхааралтай сонсож байгааг Генрих ажиглаад бусад цагт генералтай энгийн дотно харилцаатай байдгийнхаа зах сэжүүрийг ч цухуйлгахгүй

байхаар биеэ барьж байлаа. — Эрхэм дэд хурандаа та танилцана уу. Хошууч генерал Берггольдийн хүү ахлах дэслэгч фон Гольдринг гэдэг хүн гэж генералыг өгүүлэхэд СС-ийн офицер тэр дороо найрсаг царай гаргаж: — Аа маш таатай байна. Эрэлд амжилт олохыг хүсье гэхэд нь — Ахлах дэслэгчид тусламж хэрэгтэй. Гэтэл бүх цэргээ хуваарилчихсан гэж Эверс эргэлзсэнд: — Надад тусгай хэсэг гаргаж өгөдгүй, жолоочоороо туслуулан ганцаар эрэхийг зөвшөөрнө үү гэсэнд генерал СС-ийн офицер өөд яах вэ гэсэн байдалтай харсанд — Тэгвэл харин ч илүү нүдээ олно гэж бодож байна. жолоочтойгоо хоёулхнаа яваа офицер анхаарал татах нь бага, тэднийг эрэлд оролцож байгаа юм байна гэж хэний ч толгойд орохгүй. Барон та оролдоод үзэгтүн. Таван мянган марк гэдэг дориун шагнал шүү! гэж СС-ийн офицер хэлжээ. Генрих штабын даргаас Поль Шеньегийн гэрэл зургийг аваад Лютц дээр орлоо. Лютц өөрийг нь хүйтэн хөндий угтахад гайхаад — Юу болоо вэ, Карл аа! Дахиад эвгүй явдал гараа юу? гэсэнд — Хэнд ямар санагдахыг мэдэхгүй гэв. — Чамд бол? — Эвгүй хэрэг! — Нууц биш бол чухам юу болоо вэ? — Ний нуугүй шулуухан хэлэх үү? — Чи надаас ингэж асууж байж болмоор бололтой билээ гэж Генрих гомдсон байдлаар өгүүлсэнд — За тэгвэл аан гэж бай. Би ер нь ан авд дургүй, ялангуяа хүн авлахад дургүй ... Чамд өөрийн чинь хөрөнгө мөнгө багадаад газар дорхи заводаас зугтсан тэр Поль Шеньег барьж таван мянган марк олохоор шийдээ шив дээ? гэж их л янзгүй хэллээ. Тэр хоёр хэсэгхэн зуур бие биенээ дуугүй ширтэв. Генрих Лютцийн гарыг шүүрч аваад үнэн сэтгэлийн угаас чанга атгамаар санагдсан боловч биеэ барив. Генрих гэртээ ирэхэд штабаас Куртын авчирсан бичиг захидал хүлээж байлаа. Лорагийн ээлжит захидлаас гадна ширээн дээр өөр нэг дугтайтай юм байв. Бертина Граузамель өөрийгөө ийм нэг хүн байдаг шүү гэдгийг Генрихт сануулах гэж, янз янзын байдлаар авхуулсан бүхэл баглаа гэрэл зураг ирүүлсэн байжээ. Зургийн ихэнх нь нэг бол лагерт олзлогдсон эмэгтэйчүүдийг шалгаж байгаа үед, үгүй бол тэдний ажил хийж байгаа үед авахуулсан зураг байна. Зураг бүний наад захад Бертина бүрэн дүрэмт хувцастай, одонтойгоо ханхалзаж байгаа харагдана. Бас гэртээ авахуулсан хэдэн зураг байв. Бертина гэртээ энгийн хувцастай, ширээний дэргэд, цонхны дэргэд, төгөлдөр хуурын дэргэд авахуулжээ. Бертина сүүлийнхээ зургаар Генрихийг бүр гайхуулах гэсэн бололтой. Цаад талд нь бүтээлгийг авсан ор дэр цайран харагдаж, наана нь Бертина өөрөө зогсчээ. Ихэнх хувцсаа тайлж, гуяа хүртэл ил гаргасан хөлөө сандал дээр тавиад, нааш харан инээмсэглэж байгаа зураг байлаа. Зургийн дор: «Бид хэзээ дахин уулзах юм бэ?» гэж бичжээ. Генрих жигшин зэвүүцэж, тэр бэлгийг тасалгааны буланруу шидэж орхиод Поль Шеньег эрэх төлөвлөгөөг бодож боловсруулж эхэллээ. Тэр хүн Сан-Мари, Шамбери хоёрын хоорондох нэг газар зугтсан байна. Энэ хоёр газар хоорондоо гурван зуун километрийн зайтай. Харамсалтай нь галт тэрэг хөдөлсөн цаг тодорхойгүй юм. Бас Шенье кавод дээрээс хэдэн цагт алга болсон нь тодорхойгүй байна. Оргож зугтсаныг нь өчигдөр орой зургаан цагт мэджээ. Яг энэ үед вагоноос харайж буусан гэж бодъё. Одоо өглөөний арван нэгэн цаг болж байна. Энэ хооронд бие маш эрүүл, тэнхээ сайтай хүн ч гэсэн төмөр замын шугамаас жаран километрээс холдож амжихгүй. Поль Шенье шоронгийн хувцастай яваа болохоор их замаас зайлж, уул хад, ой модоор дамжсан илүү аюул багатай замыг шилэх нь мэдээж. Тэгвэл машинтай явах хэрэг юу байна? Эрэлд төвөг чирэгдэл болохоос өөр нэмэргүй. Генрих Миллерт утасдаад: — Ганс аа! Та манай жолооч бид хоёрт хоёр мотоцикл ганц

хоёр өдөр хэрэглүүлж чадах уу? гэсэнд — Дуртай зөвшөөрнө! Генрих та Шеньег эрэхдээ таныг буудсан партизаныг бүү мартаарай. Та надад барьж өгнө гэж амласан шүү — Тэр тухай сануулахгүй байж болно! гэж Генрих худал хэлжээ. Генрих үнэндээ тэр тухай маргчихсан байлаа. Уг нь огт гэм зэмгүй хүмүүсийг баривчлагдахаас аврахын тулд л өөрийгөө нь буудсан хүнийг харсан гэж СС-ийн албаны даргад худал хэлсэн юм.

Куртийг мотоцикл авчирч байх хооронд Генрихт Поль Шеньегийн гэрэл зургийг сайтар судлах хангалттай цаг гарлаа. Тэр гэрэл зураг нь шоронд дандаа тийм байдаг болохоор нэг өдрийн дотор гэрэл зургийн аппаратын өмнүүр шинээр баривчлагдсан олон зуун хүн өнгөрөхөд яаруу сандруу бэлтгэсэн муухан гэрэл зураг байжээ. Хэдий тийм боловч зугтсан хүний нүүр царайн байдлыг төсөөлж болохуйц зураг байв. Генрих Поль Шеньегийн дүрийг хэсэг хэсгээр галт шилээр томруулан харав. Үе үе аль нэг хэсгийг нь сайн нүдэлж тогтоож авах гэж нүдээ аниад дараа нь гэрэл зургийг дахин үзнэ. Генрих өгсөн даалгаврыг аль болох хурдан, аль болох сайн биелүүлэхсэн гэж хэзээ ч ингэж хүсч байсангүй. Фаулийн хэсгийг очиж шалгасан нь Нүгэлт хөндийд нууц газар байдаг юм байна гэдгийг олж тогтоох бололцоо олгосон билээ. Энэ бол заводын хаяг хараахан биш. Тэр завод Нүгэлт хөндийд байдаг юм аа гэхэд үүнийг яаж баттай олж мэдэх вэ? тэр заводад үйлдвэрлэсэн зэвсгийг хааш нь явуулдгийг яаж олж тогтоох вэ? Энэ бүх мэдээг зөвхөн Шеньегээс л олж авч болно. Ямар ч атугай зугтсан хүнийг олох хэрэгтэй, үүний тулд бүх уулсаар мацах хэрэг гарсан ч хамаагүй. ... Гурван хоног үүрийн гэгээнээс аваад үдшийн бүрэнхий хүртэл Генрих, Курт хоёр уул хадаар авирч, хавцал ангалд бууж, бут сөөгийг нэгжиж яваад шөнийн бор хоногт л эцэж ядрахын туйлд хүрч, бохир муухай болоод гэртээ эргэж ирдэг байлаа. Шенье газрын гаваар орчихсон юм шиг байв. Эрэлд гарсан өдий төдий отряд ч зугтсан хүний ул мөрийг илрүүлж чадсангүй. Бүх зам, даваа, уулын жим дээр СС-ийн харуул хаалт зогсож байгаа болохоор зугтсан хүн партизанууд дээр очиж чадаагүй байх ёстой. Эрлийн явцад бас нэг бэрхшээл төвөг гарсан нь: Поль Шенье гэдэг бол ерөөс Шенье биш, чухам хэн болох нь тодорхойгүй байжээ. Заводын мэдээ баримтаар Шенье бол Испанийн хилийн ойролцоо оршдог Эскалье гэдэг бяцхан хотод төрсөн хүн байлаа. Гэтэл Эскальед Поль Шенье гэдэг хүн хэзээ ч сууж байгаагүй, тэр байтугай эцэг эхийнхээ суудаг гэсэн гудамж нь тэр хотод байхгүй гэж урждар тэндээс мэдээ ирсэн байна. Оргодлыг эрэх явдал бүтэлгүй байгаа нь дивизийн штаб байрныхны сэтгэлийг сүрхий түгшээжээ. Берлинээс өдөр болгон утасдаж, өнөөдөр Миллерт: хэрэв гурван хоногийн дотор оргодол этгээдийг олохгүй бол Берлинд тусгайлан ярилцахаар дуудна гэж сануулсан байна. Ингэж дуудна гэсэн нь юу гэсэн үг болохыг СС-ийн албаны дарга сайн мэдэж байлаа. Хамгийн сайндаа л тушаалаас буулгаж, жагсаалын цэрэг болгоод Дорнод фронтод явуулна. Фашист үймээний үед ямар гавъяа байгуулсан гэж хэлэвч нэмэр болохгүй. Миллер шөнө орой болсон хойно Генрихт утасдаж ахлах дэслэгчтэй уулзах чухал хэрэг байна гэхэд нь — Маргааш өглөө болох юм биш үү? би их ядраад унтаж амармаар байна гэсэнд — Би яг таван минутын дараа танайд очъё. Таныг удаан чилээхгүй гэж Миллер гуйхад — За яах вэ, хүрээд ир гэж гуйлаа. СС-ийн албаны даргын төрх байдал хөөрхийлөлтэй болжээ. Мэргэжлийн улмаас буй болж, цаг хугацаа улиран өнгөрөхөд зан чанарынх гол шинж нь болсон давилуун ихэрхэг зан, биеэ тоосон байдал нь ул мөргүй

арилжээ. — Генрих ээ! Ганц та л намайг аварч чадна! — Би юу? — Чухам тийм! Өнөөдөр би генерал Бертольдос өөрөөс нь нөгөө золигийн Шеньег гурав хоногийн дотор олж чадахгүй бол намайг Берлинд тусгайлан ярилцахаар дуудна гэсэн сануулга авлаа. Энэ юу гэсэн үг вэ гэдгийг та мэдэж байгаа биз дээ? — Гадарлаж байна! — Таныг гуйя. Эрэл хийхэд зориулан надад ядаж долоо хоногийн хугацаа өгнө үү гэж генералд захиа бичээч. Таны ачийг хэзээ ч мартаггүй. Би танд хэзээ нэгэн цагт бас тус болно шүү. — Ердөө энэ үү? Иймхэн юмнаас болж харанхуй шөнөөр давхиж ирсэн юм уу? — Генрих танд энэ бол шальгүй зүйл, надад бол албан тушаал аягүй бол амь настай холбоотой хэрэг шүү. — Би маргааш эцэгтээ явуулах захидлыг танд өгөмз. Та өөрөө явуулаарай гэсэнд Миллер Генрихийн гарыг удтал базлаа. Шөнө нь бороо орсон учир өчигдөр бодож боловсруулсан төлөвлөгөөгөө өөрчилж, газар жаахан эврэхийг хүлээхээс өөр аргагүй болов. Энэ нь завшаан болж, Генрих Бертольдод захиа бичнэ гэсэн амлалтаа санаж захиа бичихээр суулаа. Энэ удаа цөөхөн үгтэй захидал бичив. Эрэлд өөрөө оролцож байгааг товчхон мэдээлээд хүнд нөхцөл байдлыг харгалзан тогтоосон хугацааг бас дахин нэг нэг долоо хоног сунгахыг гуйжээ. Генрих захиагаа битүүмжлэлгүй Куртэд өгч Миллерт нэн даруй аваачиж өгөхийг тушаагаад: — Эргэж ирээд Тарваль авгай юм уу, мадемуазель Моника бидний аян замд жаал зугаа юм бэлдэж өгөөч гэж гуйгаад ир гэсэнд — Мадемуазель хоёр дахь өдрөө өвчтэй байгаа ... гэхэд — Курт чи энэ тухай надад өчигдөр хэлэхгүй маш муу байна. намайг өвчтэй хэвтэж байхад мадемуазель зөндөө хл болсон байхад өөрийг нь өвчтэй хэвтэж байхад ядаж эргэж орсонгүй! гэвэл — Бид өчигдөр шөнө орой ирсэн шүү дээ, эрхэм ахлах дэслэгч ээ гэхэд нь — Тэгвэл ингэе: Би одоо мадемуазель дээр мөч хиртэй орж хайхрамжгүй байсныхаа уучлал гуйна. Чи энэ захиаг аваачиж өгөөд замд төхөөр гэсэнд — Би удахгүй! Эрхэм ахлах дэслэгч таныг эргэж ирэхэд юм болгон бэлэн зэлэн болсон байна! гэлээ. — Курт нэгэн тааламжгүй хэргийн учир өөрийн санаснаас нилээд удаан саатахад хүрнэ гэж мэдсэнгүй. Миллер захиаг аваад Куртыг явуулсангүй, хүлээж байхыг тушаав. Миллер захиаг уншиж, битүүмжилж туслахдаа нэн даруй илгээхийг тушааж өгөөд: — Таны овог Шмидт үү? Курт Шмидт үү? тийм үү? гэж асуухад нь — Яг тийм ээ! — Та урьд ахлах дэслэгч Фельднерийн суманд алба хааж байсан уу? — Яг тийм ээ! — Танай хуучин дарга одоо хүнд шархдаад эмнэлэгт хэвтэж байгааг та мэдсэн үү? — Мэдсэн. — Та яаж мэдсэн юм бэ? — Надад ахлах дэслэгч фон Гольдринг хэлсэн. — Та ахлах дэслэгч Фельднертэй сүүлийн удаа хэдийд уулзсан бэ? — Бонвильд тэндээс гарах өдрөө ахлах дэслэгч Гольдрингийн өрөөнд уулзсан. — Ахлах дэслэгч Фельднер тантай юм ярьсан уу? — Тиймээ. Ахлах дэслэгч фон Гольдрингт галт тэрэгний дугаар, гарах цагийг хэл гэж тушаасан. — Хэддүгээр галт тэрэг хэдэн цагт явна гэж хэлсэн бэ? — Санахгүй байна! — Таныг энэ тухай ахлах дэслэгч Гольдрингт мэдэгдэхэд тасалгаанд хөндлөнгийн хүн байсан уу? гэхэд нь энэ үед тасалгаанд Моника байсныг Курт мэдэж байсан боловч: — Байгаагүй! гэж баттай хариулсанд — За мэдлээ, явж болно. Би энэ тухай ахлах дэслэгчтэй өөрөө ярина. Бидний энэ яриаг хэнд ч хэлж болохгүй. Мэдэв үү? — Мэдлээ! Курт явах гэж гүйсээр гэртээ буцаж ирлээ! Зөвхөн цагаас хожимдсондоо тэр биш, сэтгэл нь зовнисондоо тэгж яарсан байжээ. Миллер яагаад өөрөөс нь Фельднерийн тухай асууж эхлэв? Бас гзочид буудлын өрөөнд гадны хүн байсан уу, үгүй юу гэж яагаад их сонирхож байна вэ? Моникаг ямар нэгэн хэрэгт

хардан сэжиглэж байгаа юм болов уу? Мадемуазель Моника тэр галт тэрэгтэй холбоотой байх гэж үү? Яасан балай юм бэ? Курт энэ бүхнийг ахлах дэслэгчид ярих гэж тэсч ядан бйасан тул өрөөндөө байхгүйг үзээд урам нь хугарлаа. Хагас цаг, бүтэн цаг өнгөрсөн атал ахлах дэслэгч эргэж ирээгүй л байлаа.

Генрихийн айлчлал санамсаргүй удааширсан байжээ. Моника салхинд цохиулсан учир Тарваль авгай орноосоо босохыг нь хорьсон байна. Хаалганы цаана Генрихийн дуу гарахыг сонсоод сэтгэл нь хөдөлсөндөө нүдний нь нулимс гарах шахав. Ээж түүнийг нааш нь оруулахыг зөвшөөрсөн юм болов уу? Ер нь яагаад эс зөвшөөрөх билээ? Моника өөрөө өвчтэй хэвтэж байна шүү дээ. Тэгвэл Генрихийг мотоциклоос ойчсоны дараа орны нь дэргэд сахиж байсан болохоор Генрих өөрийг нь эргэж ирэх нь зүйн доторхи хэрэг юм. Генрих ороод бүсгүйн сэтгэл хөдөлж, ичингүйрсний аль алиныг нь ажиглаагүй юм шиг байдал гаргаж, ердийн байдлаар энгийн харилцсанд Моника хамаг эргэлзээгээ тэр дор нь мартаж орхилоо. Генрихийн ирсэнд, хоёул жирийн нэг чөлөөтэй ярилцаж бйагаадаа, Генрих өөрийг нь таалан харж байгаад Моника ихэд баярлажээ. Моникаг хараад сэтгэлдээ таалахгүй байхын арга байсангүй. Задгай үс нь толгойг тойрон цагираглажээ. Цагаан даавуун дээр үс нь эмэгтэй хүний гоо үзэсгэлэнт толгойн хөрөг хийсэн үнэт жааз шиг харагдана. — Моника! Та өнөөдөр гайхалтай гоё харагдаж байна гэж Генрихийн хэлэхэд — Та өнөөдөр хоёр дахь удаагаа ингэж хэлж байна! гэв. — Гурав дахь удаагаа ч хэлж магадгүй гэсэнд Моника эхийнхээ ажил хийж байгаа зэргэлдээ өрөөрүү: — Ээж ээ! Охиныг чинь дооглоод байна гэж хашгирсанд Тарваль авгай тавагтай усан үзэм барьсаар орж ирээд — Чамайг уу? Хэзээ ч үнэмшихгүй! гэхэд нь — Би мадемуазелийг өнөөдөр гоц хөөрхөн байна гэж хэлсэн юм гэж Генрихийн өгүүлэхэд: — Аа, манай охинд цагаан өнгө их зохидог юм. Та Моника адис хүртэх өдөр харсан ч болоосой. Байзаарай, одоо танд зургийг нь үзүүлэе гээд Тарваль авгай гэр бүлийн том цомог гаргаж, Моникагийн адис хүртсэн өдөр авахуулсан зурагтай хуудсыг нээж, Генрихт өгөөд — Энэ байна даа, барон гэжээ. Генрих зургийг хараад золтой л дуу алдсангүй. Тарваль авгай охины нь зураг ийм сэтгэгдэл төрүүлсэн гэж бат санасан учир сэтгэл дүүрэн инээмсэглэж, Моника, Генрих хоёрыг дийлсэн царайгаар ээлжлэн харав. Генрих тэр зургаас нүд салгалгүй ширтэнэ. Тэр зургийг үзээд мэл гайхсан байжээ. Элдвийн санамсаргүй явдлыг бишгүйдээ үзэж, чочоо нь гарч дассан хүн атал сэтгэл догдлолыг арайхийн барьж тогтоов. Тэгэхдээ дан цагаан хувцас өмссөн Моника үнэхээр үзэсгэлэнтэй сайхан байсан боловч залуу бүсгүйн гоо сайхныг үзээд тэгж гайхсан хэрэг биш ээ. Генрих өөр зүйлийг гайхсан байна. моникагийн хажууд хэн зогсож байсан гэж бодно. Поль Шенье зогсож байлаа! Эндүүрэх арга байсангүй. — Моника та энэ гайхамшигт зургийг одоо болтол надад үзүүлээгүй байсны учир таныг торгоно. Торгуулийг та одоо даруй төлөх болно гэж Генрих өгүүлэв. — Чухам ямар торгууль байхаас болно доо! — Аа, торгууль их хүнд байна! Та өөртэйгээ хамт зураг авахуулсан хүн бүхний тухай ярьж өгөх хэрэгтэй. — Тэгвэл тэр сандал дээр, зургийг надад харагдахаар суу гэж Моника инээд алдан зөвшөөрөв. Генрих цомгийн хуудсыг эргүүлж эхэлсэнд Моника гэрэл зураг бүхнийг заримдаа тоглоом наадмын үгээр, заримдаа энгийн төлөв үгээр тайлбарлав. Тарваль авгай энэ тоглоомыг бас сонирхож, сандлаа ойртуулж тавилаа. Гэрэл зураг дээр францын армийн байлдагчийн хувцастай залуу

байхыг үзээд Генрих гайхлаа. Энэ нь тэгш өндөрлөг дээр Генрихийн суллаж тавьсан хоёр партизаны нэг мөн байжээ. — Миний хүү Жан! Сураггүй алга болсон юм гэж Тарваль авгай тайлбарлаад инээмсэглэв. Генрих авгайн нүдийг эгцэлж хараад энэ авгай бүгдийг мэдэж байгаа юм байна гэдгийг ойлголоо. Генрихт их талтай байдгийн учир энэ байжээ! Генрих сүүлчийн хуудсыг эргүүлээд Поль Шеньегийн тусгай зураг байхгүй юм байна гэж мэдлээ. Цомгийн зарим газар хоосон зай байхыг үзвэл зургийн зарим хэсгийг авчихсан бололтой. Моникагийн адис хүртсэн өдөр авахуулсан зургийг эргэж үзэх хэрэгтэй болов.

— Одоо танай бүх төрөл садан, дотно нөхөдтэй би нэгэнт танилцсан болохоор тэр өдөр тантай хэн хэн зураг авахуулсныг таах уу? гэж Генрих өгүүлсэнд — Сайхан мэдээрэй, би таны санадаг шиг цагаан цайлган хүн биш, би бас торгууль бодож олно. За энэ хэн бэ, таа! гэхэд нь — Энэ таны эмээ ээж байна, мадемуазель аа! Аа энэ Тарваль авгай та байна. таны хажууд танай хүү Жан байна ... Одоо жаахан байзаарай ... аа тийм байна, энэ залуу сайхан эмэгтэй бол авгай таны дүү Луиз байна. Мадемуазель Моникагийн дэргэд зогсож байгаа энэ эрэгтэй хүнийг би санахгүй байна. тун хачин юм. Иймэрхүү эрэмгий зоримог байрын хүний царай хүний сэтгэлд тод үлддэгсэн ... Энэ хүний зураг цомогт байгаагүй гэдэгт мөрий тавихад бэлэн байна! гэсэнд — Гайхах юмгүй, Моника бүгдийг нь үгүй хийчихсэн гэж тарваль авгай ондууцан дуугарсанд — Ээж ээ! — За яршиг! Надад бароноос нуух юм байхгүй! Ноён Гольдринг таныг би журамтай хүн гэж бат санадаг болохоор танд итгэхгүй байж чадахгүй. Энэ бол миний дүү Луизагийн эр нөхөр Андре Ренар байгаа юм. — Амь үрэгдсэн юм гэж Моника хажуунаас нь яаран нэмж хэлсэнд, — Амь үрэгдсэн биш, хаашаа нь мэдэгдэхгүй алга болчихсон юм. Та ойлгох биз ... гэхэд Моника эхийнхээ үгийг таслахыг оролдож — Мана төрөл садан болгоны яасныг мэдэх гэж ноён Генрих хаанаас сонирхох вэ гэхэд — Үгүй, би энэ намтрыг их сонирхож байна! Хүн яагаад хаачсан нь мэдэгдэхгүй алга болчихдог билээ? гэсэнд Тарваль авгай гунигтайяа толгой сэгсрээд — Ай одоо цагт уу! Та бодоод үзэгтүн. Нэг муу бэртэгчин амьтан биш, алдар хүндтэй инженер хүн дээр шөнө орой болсон хойно өөрийн нь ажилладаг заводын даргын бичиг барьсан хоёр хүн орж ирээд яаралтай ярьж өгөх юм байна гээд дагуулаад явдаг юм байжээ. Түүнээс хойш тэр хүн алга болчихсон юм. Хөөрхий уу Луиза минь солиорох шахсан даа. Ганц хүний толгой дээрээс хэчнээн олон гай зовлон бууж ирсэн гээ. Эхлээд арга буюу нуугдахад хүрсэн эр нөхөр дээрээ хоёр гурван сард арайхийн ганц удаа нууцаар очиж уулздаг байлаа. Дараа нь түүнийг сураггүй алга болсон гэсэн мэдээ авч хөрөнгөө хураалгасан ... Луиза өөрөө коммунист хүний эхнэр юм болохоор Парисаас нууцаар зугтаж зайлсан юм ... гэж ярихад нь — Ээж ээ! гэж Моника дахин дуудсан боловч Тарваль авгай юу ч гэсэн санаснаа бүрэн хэлэх гэж шийдсэн хүний зөрүүд зангаар үргэлжлүүлэн: — Би ч гэсэн болгоомжлохыг буруушаахгүй л дээ. тэгээд Луизаг нааш нь авчирч зүрхлээгүй, тэр ч бүү хэл захиагаар харилцдаггүй юм. Уг нь би ээж дүү хоёр дээрээ ганц өдөр очоод ирж болох шүү дээ? Үүнийг хүн анзаарахгүй. Тэд нар маань энүүхэн энд, Ла-Травельса тосгонд суудаг юм шүү дээ! Тэгэхэд нь Моника өөрөө тийшээ ганц ч очоогүй, намайг ч явуулахгүй байна. Хөөрхий Андрегийн хамаг зургийг нь хүртэл үгүй хийчихсэн! Ингэж хэтэрхий болгоомжлох нь танд ямар санагтаж байна? гэсэнд — Зүйтэй санагдаж байна!

гэж Генрих баттай хэлсэнд — Дуулаа биз, ээж ээ! гэсэнд — Би ч гэсэн таныг дүүтэйгээ уулзахыг түр хойшлуулж, тэр тосгон ямар билээ, тийшээ очихгүй байхыг зөвлөх байна гэж Генрих хэлсэнд — Ла-Травельса гэдэг юм гэж Тарваль авгай хажуунаас хэлэхэд нь — Андре Ренар чухам яасныг та нар мэдэхгүй байгаа шүү дээ. Түүнийг эрж, төрөл садан нь ямархуу улс байдгийг сонирхож магадгүй юм. Та нар тэртэй тэргүй түүнд тусалж чадахгүй гэж Генрих ярьсанд — Ноён таны сануулж зөвлөсөнд баярлалаа! Усан үзэм идэгтүн, ямар сайхан хонгорцог байгааг хараач! гэхэд нь — Намайг битгий саатуулаарай, би ер нь удаан суучихлаа. Би хол явах хүн шүү гэж Генрих хэлээд эх охин хоёртой салах ёс гүйцэтгээд гарлаа. Генрих шатаар бууж явахдаа «Андре Ренар, Ла-Травельса тосгон» гэж сэтгэлдээ давтан давтан хэлэв.

УУЛЫН НУУРЫН ДЭРГЭД УУЛЗСАН НЬ — Эрхэм ахлах дэслэгч фон Гольдринг танд үг хэлж болох уу? гээд Курт сандлаасаа босон харайж, яг дүрэм ёсоор цэхлэн зогсоход нь — Ахлах цэрэг Курт Шмидт та юу болоо вэ? Юунд ингэж ёсорхов? Хөндлөнгийн хүн байхгүй байна шүү дээ гэж Генрих хэлэв. Сэтгэл догдолсон Курт, Миллертэй ярилцсан яриагаа нэгд нэггүй давтан ярихад нь — Чамайг Фелднертэй ярих үед миний өрөөнд мадемуазель Моника байсныг яагаад хэлээгүй юм бэ? — Би уг нь ... хэлээгүй нь дээр гэж бодсон юм. — Сайн болжээ! Гестапо мадемуазель Моникаг байцааж магадгүй. Гэтэл Сталинградын дэргэд Паулюсийн арми бүслэгдсэнд чи хэр зэрэг буруутай бол галт тэргийг довтолсонд мадемуазель тэр зэргийн буруутай биз. Чамайг ухаантай сайн хүү байна гэж хэлснийг ээждээ бичээрэй. — Эрхэм ахлах дэслэгч таны намайг ойшоон тоож байгааг ээж маань мэдээд их баярлана. Манай эх таныг маш их хүндэтгэж, захиа болгондоо танд мэнд уламжлахыг хүссэн байдаг. Би танд хэлэхийг түвдээгүй юм ... эвгүй юм л даа ... — Курт чи хүүхнүүдтэй харилцахдаа бас ийм зүрх муутай байдаг уу? эсвэл чамд болзсон бүсгүй ерөөс байхгүй юу? уг нь би дайн дууссаны дараа чиний хурим дээр наргина гэж бодсон юмсан. Чи намайг урина биз дээ? Мэдлээ, мэдлээ, урих юм байна. за одоо анхааралтай сонсож бай. Машинаа бэлтгэ ... — Бэлэн! — Машинд чухам хэн сууж явааг мэдэгдэхгүйн тулд хөшгийг нь буулга. Өөрийн автомат, миний автомат хоёрыг аваарай. Түрүүн хэлснээр нэг өдрийн хоол биш, хоёр өдрийн хоол аваарай. Бас сум их аваарай. Бид маш хүнд ажиллагаанд явж байна. Тулалдахад хүрч магадгүй гэдгийг харгалзах хэрэгтэй. — Хоёрын зэрэг гранат авахыг зөвшөөрнө үү. — Илүүдэхгүй л байх! За бэлтгэ! Чухмыг хэлбэл Генрихт тодорхой бодсон төлөвлөгөө байсангүй. Юм бүхэн газар дээрх тухайн нөхцөл байдалөөрийн нь санасан зөв эсэхээс шалтгаална. Поль Шенье, Андре Ренар хоёр бол нэг л хүн мөн нь эргэлзээгүй тодорхой байна. харин зугтсан хүн Ла-Травельсад байгаа гэхийн бат итгэл алга. Нөгөө талаар түүнд өөр орох газар байхгүй. Тэр хүн эндэх газар нутгийг сайн мэдэхийн дээр эндхийнхэн түүнийг найдвартай газар явуулж чадталаа нууж хоргодуулахаас айхгүй. Илэрч мэдэгдэх аюул нь бусад ямарваа газраас илүүгүй. Луизаг Ренарын авгай гэж мэдэх тул түүнийг Шеньегийн нэртэй холбож үзэх санаа хэний ч толгойд орохгүй. Генрих газрын зураг дэлгэж үзлээ. Ла-Травельса бол Сен-Ремигээс баруун тийш гучин тав, зургаан километр зайтай орших бяцхан тосгон юм. Тэгэхлээр тэнд онц их яаралгүй, арван таван цагт хүрч амжина. Тэр тосгон их замаас хол, тэнд цэргийн холбогдолтой газар байхгүй. Тэгэхлээр германы гарнизон ч байхгүй байж таарна. Генрих

жолоочтойгоо зэрэгцэн суугаад: — За Курт ээ, явцгаая гэж хөгжилтэй хэллээ. Курт хааз нэмэхэд хурдны хэмжүүрийн зүү дээш ахилаа. Гэтэл анхны километрийн дараа хурдаа саах хэрэгтэй болов. Зам уул өөд өгсөж, маш их мурилзаж тахирласны дээр засаагүй удсан байжээ. Хайрга чулууны дунд борооны ус тогтсон гүнзгий гүнзгий хонхор хотгор тохиолдох тул машинд цаг үргэлж шавар шавхай үсрэн наалдана. Курт хэд хэдэн удаа машинаас бууж салхины шилийг алчуураар арчих хэрэгтэй болов. Шил цэвэрлэгч шаврыг тарааж нялахаас өөр нэмэр байсангүй.

Генрих, Курт хоёр гурван цаг хагас болж байхад сая л Ла-Травельса тосгонд хүрлээ. Намрын өүрхэг баргар өдөр хүртэл үзэсгэлэнтэй сайхан харагдах тэр тосгоны гоо сайхныг Генрих гайхав. Зууван нуурын зүүн эргийн дагуу хөөрхөн хөөрхөн жижиг байшин хагас дугуйран байрлажээ. Тосгоны ганц нарийвтар гудамж нь мөн л хагас дугуйран зурагдсан байна. Хоёр талаар нь том том саглагар мод эгнүүлэн тарьсан тэр гудамж нуурын усны дээгүүрээс өнгийсөн эгц халил хаданд хүрсэн ногоон хонгил нүх шиг санагдана. Тэр хадны цаана бас нэг бас нэг бүүр өндөр асга хад лүглийн харагдана. Эсрэг талын эрэгт асга хэд эмх замбараагүй шавааралдсан нь цаад талын өндөр уул замдаа тохиолдсон бүхнийг хавчиж шахан түрсэн юм шиг. Генрих Куртэд тосгоны захиргааны байшингийн дэргэд очихыг тушаагаад Тарваль авгайн эхийн овгийг мэдэхгүйгээ сая саналаа. Хүнээс асуухаас өөр аргагүй болжээ. Энэ нь Генрихийн төлөвлөгөөнд огт ороогүй зүйл боловч ухарна гэдэг хожимджээ. Генрих ширээний ард суугаад нэг юм бичиж байгаа өвгөнтэй эхлэн мэндэлж — Сайн байна уу! гэсэнд — Амрыг эрье, ноёнтоон! гэж өвгөн уруухан дуугараад Генрихийг жишүүхэн харахад нь — Та Ла-Травельсийн дарга уу? — Үнэхээр тийм ээ. — Би хожим германы комендатур байрлах байшин эрж олох хэрэгтэй байна гэсэнд өвгөн ихэд санаа алдахад — Та урьд коммунистууд сууж байсан, одоо гэр бүлийнхэн нь сууж байгаа байшинг зааж өгнө үү гэсэнд — Хэн ямар намд байдгийг би мэдэхгүй. Надад тийм бүртгэл байхгүй гэхэд — Тэгвэл танай энд францын националь социалист намын байгууллага бий юу? гэсэнд — Нэг хүн хүрч ирээд, энэ тосгонд эргэлдэж байгаа. Тэр таны ирснийг харчихаад наашаа гүйж явна гэж өвгөн хэллээ. Үнэхээр нэг хүн явуут цувныхаа товчийг товчлон гудамжаар нааш гүйж яваа харагдлаа. — Энэ нутгийн хүн үү? гэж Генрих асуусанд — Тиймээ, нутгийн хүн. Эцэг нь их журамтай сайн хүн юмсан ... гээд тосгоны дарга Генрих өөд харснаа илү үг хэлснээ мэдээд — Эцэг нь өнгөрсөн долоо хоногт нас бараад энэ хүн өв хөрөнгийг нь залгамжлахаар ирсэн нь гэв. Хаалганы тэндээс нацистын ёсоор мэндлэх дуулдахад Гитлер хариуллаа. Ла-Травельса тосгон дахь францын национал-социалист намын ганц төлөөлөгч нь гучаад насны эр байлаа. Тэр Базель гэгчийн шил рүүгээ дарж өмссөн бүрх малгайн дороос яг Гитлерийнхтэй адил самнасан үс цухуйна. Инээд хүрмээр махийсан урт хамар дорхи богинохон тайрсан бараан сахал нь асуултын тэмдэг дор том цэг тавьсан юм шиг харагдана. — Би тантай ярилцах хэрэг байна гэж Генрих тэр ирсэн хүнд хэлсэнд — Та надтай хоёулахнаа ярих хэрэгтэй гэж байна уу? Би таны хэлснийг зөв ойлгов уу? гэхэд нь тосгоны дарга өвгөн — Би явлаа. Юуны тухай хичнээн ярина вэ, дураараа л бологтун гэж хэнд ч тухайлан хандалгүй хэлээд хуучин муу пальтогоо эгэлдэргэлж, захиргаа гэж сүртэй нэрлэсэн тасалгаанаас

гарлаа. — Тосгоны дарга тун найдваргүй хүн байгаа юм. За яахав, би учрыг нь сүүлд олно. Ер нь их хүнд шүү ... гэж Базелийг өгүүлэхэд Генрих үгийг нь таслаад — Үүнийг би сонирхохгүй байна. би германы комендатур байрлах газар аль болох хурдан эрж олох хэрэгтэй байна гэсэнд Базель баярлаж — Ла-Травельсад германы комендатуртай болох нь уу? Яасан таатай сайхан мэдээ вэ! Бодоод үзээч, энд шударга франц хүнийг амар тайван суулгадаггүй болохоор нь төрсөн тосгоноосоо явсан юм. Арга буюу төрсөн гэр орноо орхиж, Понтейд очсон гэхэд нь — Та энд ирээж удаж байна уу? — Долоо хонож байна гэжээ. — Тэнд манай нэг офицерыг партизанууд буудсан гэж би дуулсан юмсан. — Харамсалтай нь тэр үнэн. Намайг нааш гарах өдөр тийм хэрэг гарсан. Энэ партизанууд гэдэг ёстой дээрэмчид шүү. Та энд партизан байхгүй гэж бодно уу? Манай байшинд ганц бүтэн цонх үлдээгээгүй ... гэхэд — Надад германы комендатурын байр хэрэгтэй байна гэж Генрих дахин сануулсанд — Миний байшинг ав л даа! Эцгийнхээ нас барснаас хойш би ганцаар суудаг болсон болохоор дуртайяа ... гэхэд нь — Би шударга францчуулд гар хүрэхгүй. Энд бодвол сэжигтэй улс, жишээ нь коммунистуудын гэр бүл байдаг биз? гэсэнд Базель тамхинд шарласан хурууныхаа үзүүрийг химлэн хэсэг зуур бодол болоход урт хамар нь асуултын тэмдэгтэй бүр ч адилхан болов. Эцэст нь — Бий! Дуртайгаа шилээрэй! гэж баярлан дуу алдаад, халааснаасаа бяцхан дэвтэр гаргаж, түүнийгээ дэлгэж, ширээнд ойртож суугаад — Арван нэгэн айл байна! гэхэд нь — Та энэ жагсаалтыг өөрийн санаачлагаар зохиосон уу? гэж Генрих үгийн далимд асуусанд Базель биеэ тоосон нам дуугаар — Би танай нэг байгууллагын даалгавраар гүйцэтгэж байгаа юм. Уг нь намайг Понтей тосгоны ард иргэдийг хянан ажиглаж бай гэж даалагсан юм. Гэхдээ би энд бйагаа болохоор өөрийн ариун үүрэг гэж ... гэв. — Аль вэ, жагсаалтаа нааш нь. Наана чинь хэн хэн байна вэ? — Оливь Арну. Ямар учиртайг мэдэхгүй, тосгоноос нэг тийшээ яваад өгсөн хүн. — Цааш нь, — Гурван хүн дайнд сайн дураар яваад одоо болтол эргэж ирээгүй байгаа. Тэдний овог нэр нь ... — Цааш нь! — Аа, энэ хэрэгтэй юмаа оллоо. Өвгөн Готардын хүү Лионы төмөр замчдын ажил хаялтад оролцож байсан. Энэ уг нь дайны өмнөх явдал боловч түүнийг би коммунист байх гэж сэжиглэдэг. — Өөр хэн байна? — Гурван айлын залуучууд яваад өгсөн. Төрөл садан нь тэднийг ажил хийж мөнгө олохоор Бонвиль орсон гэдэг боловч би үнэмшихгүй байна. — Ингээд гүйцээ юу? — Хоёр хүнийг би манай байшингийн цонхыг хагалсан гэж сэжиглэж байна. — Муу ажиллаж бйана, чөтгөр алгад! Сэжиглэж байна ... Тосгоноос нэг тийшээ яваад өгсөн ч гэх шиг ... Танай цонхыг хэн хагалсан тухай таны сэжиг таавар надад хэрэггүй. Щц, тодорхой үнэн бодитой баримт хэрэгтэй байна! — Ноён офицер оо! Би энд ирээд дөнгөж долоо хонож байна ... Бас би өөрийн санаачлагаар хийж байгааг бодолцоорой ... гэж Базель хэлэхдээ тэмдэглэлийн дэвтрийн бичгийг зааж байгаа хөх няц болж цус хурсан хуруу нь чичирч — Өөр бас нэг сэжигтэй хүн гэвэл Матран авгай байна гэхэд нь, — Тэр авгай бас танай цонхыг хагалсан уу? гэж Генрих дайран асуусанд Базель ёжилсныг анзаарсангүй — Хаанаас даа! Арай ядан хөдөлж байдаг авгай. Тэднийд Парисаас ирсэн охин нь одоо сууж байгаа гэхэд нь — Уухай, Парисаас ирсэн юм бий! Энэ танд бас л сэжигтэй санагдаж байгаа биз дээ? гэж Генрих мөн л даажигнасан янзтай инээмсэглэн асуусан боловч сэтгэл нь хөдөлсөндөө зүрх нь түг түг цохилж байлаа. Энэ тэнэг эр ашгүй нэг анхааруштай юм хэллээ. Базелийн ярьсан нь — Тэр эмэгтэйн байдал сэжиг төрүүлж

байна. нөхөр нь үхсэн гэх мөртлөө бэлэвсрэлийн хувцас өмсдөггүй. Мартан авгай ч гэсэн юм бүгд дээр хуучны заншлыг дагадаг их сүсэг бишрэлтэй байтлаа бэлэвсрэлийн хувцас өмсөхгүй байна. ер нь мартан авгайн хүргэн, Лиузагийн нөхрийн тухай тэднийг бүр Парист сууж байх үеэс янз янзын яриа дуулддаг байсан. Түүнийг коммунист гэж ярилцдаг юм. Энэ айлыг би жичид нь тэмдэглэж авсан. — Коммунист гэв үү? Энэ чинь харин овоо тодорхой зүйл байна. Тэдний байшин нь том юм уу? — Эндхийнхэнтэй адил хоёр өрөөтэй, гал зуухтай байшин. Эндээс хол тосгоны захад, яг байц хадны дэргэд байдаг юм. — Хянах байранд яг таарах юм байна! Машинд суугаад Матран авгайн суудаг газрыг заагаад аль гэж Генрих хэллээ. Эх охин хоёрын суудаг байшинд хүртэл бүтэн хагас километр явлаа. Тэгээд нэг давхар жижиг байшинд хүрч очив. — Базель та машинд үлд. Зурт чи гараад ир гэж Генрих хэлэв. Генрих цонх өөд хараад нэг цонхны цаана настай эмгэний айж ширвэгдсэн царайг олж үзлээ. — Курт ээ! Байшингаас хүн гарах бий харж байгаарай, харж байгаарай. Хэн нэг хүн зугтах гэж оролдвол хий буудаарай! Хүнийг буудаж хэрхэвч болохгүй. Ойлгов уу? гэж Генрих аяархан хэлсэнд — Ёсоор ойлголоо! гэж Курт хариулав. Генрих гараа цувныхаа халаасанд хийж, гар бууныхаа бариулаас бариад хаалга тийш очлоо.

Гучин тав орчим насны эмэгтэй хаалга тавьж өгсөн нь Тарваль авгайн дүү мөн гэж Генрих даруй танив. Генрих мэнхийн ёсолсон боловч тэр эмэгтэй үг дуугарсангүй, герман офицерт зам тавьж өглөө. Үүдний өрөө тийш харсан өөр хоёр хаалга байв. Генрих ойрхи хаалгыг хөлөөрөө түлхээд гал зуухны бяцхан өрөөнд хүн байхгүй юм бйана гэдгийг харангуут мэдлээ. Ширээн дээр нь угааж цэвэрлээгүй аяга таваг харагдав. «Гурван том, гурван жижиг таваг байна» гэж Генрих дотроо тэмдэглэж аваад мөн л гараа халааснаас гаргалгүй хоёр дахь хаалгыг түлхэв. Генрихийн олсон тасалгаа нь гудамж руу харсан гурван цонхтой том тасалгаа байлаа. Цонхны эсрэг талын ханын дэргэд сүлжмэл сийрсэн сандал дээр настай эмгэн сууж, оймс нэхэж байсан боловч гар нь салганан чичрээд нэхүүрийн зүү нь бие биетэйгээ хавиран үргэлж хангинах сонсоно. Генрих тасалгаан дотуур дуугүй өнгөрч, хоёр дахь нилээд жижиг өрөөрүү шагайж үзвэл хоёр ор байгаа харагдав. — Энд өөр хэн суудаг юм бэ? гэж залуу эмэгтэйгээс асуусанд — Бид хоёулаа гэв. — Тэгвэл орон дээр өдөр хэн унтсан юм бэ? — Ээжийн бие муу, байн байн хэвтэж амардаг юм. Генрих эмгэнийг нэгэнтээ хараад нүд буруулав. Эмгэн Генрихийг агшин зуур цоргих мэт хяламхийн харахдаа харцанд нь эцсээ хүртэл тэмцэхээр сэтгэл шулуудсан хүний хэнэггүй тайван үл тоомсорлох байдал үзэгдлээ. — Би комендатур байрлах байрлах байр эрж явна гэж Генрих хэлэв. Эмгэн гараа өвдөг дээрээ тавьж, нүдээ аниад сандлын түшлэг налав. Одоо эмгэний хуруу үл чичрэх боловч чухамхүү чулуу шиг хөдөлгөөнгүй болсон нь бие сул, настай эмгэн сэтгэлийнхээ догдлолыг нуух гэж асар их хүчдэл гаргаж байгааг харуулна. Генрих доошоо тонгойж, эмгэний үрчгэр гарыг үнсмээр санагдана. Гэтэл ямар ч атугай Андре Ренарын тухай олж мэдээгүй буюу өөрийг нь олоогүй байгаа цагт Матран авгайг тайвшруулахаар эелдэг зөөлөн харах эрхгүй гэдгээ мэдэж байлаа. Энэ завсар залуу эмэгтэй биеэ эзэмдэж чадаад — Та манай байшингаас өөр олигтой байр олсонгүй юу? гэж ёжилсон янзтай асуухад нь — Танай байшингийн арын байц хад хянах байр

болгоход маш тохиромжтой юм. Энэ хоёр тасалгаа, гал тогооноос өөр байр байхгүй юу? гэсэнд — Байгаа нь харсаар байтал энэ шү дээ гэлээ. Генрих тасалгаан доторхийг анхааралтай ажиглав. Эмгэний сандлыг яагаад ийм эвгүй газар тавьна вэ? Настай хүний суух дуртай цонхны дэргэд юм уу, өөр нэг тохьтой буланд тавилгүй, зориуд нэг юм халхлах гэсэн шиг ханын гол дунд тавьсан байна. уулсын тосгонд бяцхан байшинг хэсэгхэн тэгш газар буюу хадан дээр барьдаг болохоор сууцны талбайн метр бүрийг нарийн бодох хэрэгтэй байдаг. Хананд нь нууц шүүгээ хийх явдал их байдаг боловч тэр «нууцыг» нь ганц харангуут тайлах хялбар байдаг билээ. Хямдхан цаасан наамал нь хаалганыхаа захаар амархан элэгдэнэ. Энд ханын наамал цаасны зураг өнгө нь жигд бйах юм. Өнгөн дээрээ тийм ч байж болох л доо, сандлын ард ... оролдоод үзвэл яасан юм бэ? Генрих урагшаа хурдан алхаж, сандлын бариулаас барин дээр нь суусан эмгэнтэй хамт төвөггүй өргөж, урьд байсан газраас нь жаахан зайлуулж тавилаа. Эмэгтэйчүүд сэхээ авч амжсангүй. Ер нь Генрих өөрөө ч гэсэн гар буюгаа гаргаж, хананд ажиглагдах төдий харагдах даруулгыг солгой гараараа яаж дарснаа сайн мэдсэнгүй. Генрих ухаанаас ажиллахаасаа совингоор ажилласан байжээ. Хаалга нь онгойж, нэгэн эрэгтэй хүн шүүгээний гүнд арын хананд наалдан зогсож байлаа.

Хоёр эмэгтэй зэрэг уулга алдаж, охин нь цөхрөнгөө барсан байдалтай, эх нь занасан байдалтай хашгирав. Эмгэн урагш алхаад өөрийн биеэр ханан дахь нүхийг халхлав. Генрих түүнийг үл анхааран гагцхүү гар буюгаа улам дээш өргөөд — Гарагтун! гэж тайван дуугарлаа. Тэр эрэгтэй хүн нэг хөдөлснөө уруулаа хазаж ёолов. Энэ удаа залуу эмэгтэй байрнаасаа ухасхийж, нөхөр өөдөө гүйж очоод сугадан авч, саяхан эхийнхээ сууж байсан сандал тийш болгоомжтой хөтлөв. Тэр эрэгтэй хүн зүүн хөл дээрээ гишгэж чадахгүй байлаа. — Та хэн бэ? гэж Генрих асуусанд — Андре Ренар, Парисын инженер гэв. — Яах гэж нуугдсан юм бэ? — Энд нэвтрэх бичиггүй ирсэн. Довжоон дээр хүний хөлийн чимээ гарав. Генрих Ренарыг түлхэх шахан шүүгээнд оруулаад, хаалгыг нь хааж наана нь сандал тавьж дээр нь хөлөө жийж суугаад ташуураар оролдож байв. Хаалга тогшиж Базель орж ирээд үүдний тэндээс — Ноён офицер оо, би явж болох уу? гэж асуухад нь — Манай жолоочийг дууд гэв. Базель тэр даруй Куртыг дагуулан хүрч ирэхэд нь Генрих үг болгоноо онцлон байж өгүүлсэн нь — Курт ээ! Энэ хүн Понтейгоос ирсэн юм байна. Би энэ хүнийг урьд нэг зүс үзсэн хүн шиг санагдаад бйана. Чи миний хэлж бйагааг ойлгож байна уу? Одоо баривчлагдсан хүнийг машин дотор аваачаад манаж бай. Чи энэ хүнийг толгойгоороо хариуцна шүү гэсэнд хэрэг явдал нэгэнт ингэж эргэсэнд гайхаж хоцорсон Базель — Ноён офицер оо! Эндүүрэл болсон бололтой! Би ... би ... гэхэд нь Курт тэр ховлон мэдүүлэгчийг үг хэлүүлэлгүй хүзүүн дээрээс нь барьж аваад үүдний өрөөнд оруулж, тэндээс довжоон дээр гаргалаа. — Хаалгаа түгж гэж Генрих Луизад тушаав. Тэр эмэгтэй юу ч ойлгосонгүй хэлснийг дагаж цоожны түлхүүрийг эргүүллээ. Тэр завсар Генрих шүүгээний үүдийг дахин онгойлгож — Ноён Ренар аа! Та бидэнд цаг бага байна. Тийм учраас цаг дэмий үрэхээ байя. Та тэр өрөөнд орно уу. авгайчуул эндээ үлдэг. Эднийгээ тайвшруулаад бидэнд хэн ч саад хийхгүй байх талаар ажиглаж бай гэж тушаагтун гэсэнд Андре Ренар эхнэр, хадам эх хоёртоо толгой дохиод зэргэлдээх өрөөнд хөлөөрөө догонцон орсон хойно. — Ноён офицер таны үгийг сонсож байна! гэж тайван дуугарахад нь Генрих халааснаасаа Поль Шеньегийн гэрэл

зургийг үг дуугүй гаргаж ирээд — Таньж байна уу? гэж асуув. Андре Ренарын эцэж ядарсан царай өчүүхэн ч хувирсангүй, гагцхүү үхтлээ алжаасан хүний байдлаар нүдний нь гал унтарч — Та намайг баривчлахаар ирсэн үү? Тэгвэл энэ бүх инээдэмт жүжиг ямар хэрэгтэй юм бэ? Эсвэл таны урьд Поль Шенье байна гэдгийг бүрэн итгэхгүй байна уу? Хоригдлын дугаар гээд Андре Ренар ханцуйгаа шамлаж, Генрих өөд яавал ч яаг гэсэн шиг хараад солгой гараа урагш сунгав. Бугуйн дотор талд төөнөж тамгалсан 2948 гэсэн тоо баарцаглан харагдав. Генрих өгүүлрүүн: — Таны хэлсэн энэ инээдэмт жүжгийг тоглосноор би аминдаа халтай ажил хийж байна. энэ гэрэл зургийг надад харж сонирхож бай гэж өгөөгүйг та ойлгож байгаа биз дээ? Ялдамд сануулахад Поль Шеньегийн эрэлд явуулсан отрядын офицер бүхэнд ийм гэрэл зураг бий. Би таныг баривчлах бүрэн эрхтэй л дээ. гэсэн ч баривчлахгүй. Би тантай тэгш эрхтэйгээр ярилцахаар ирснээ батлахын тулд танд үүнийг өгье гэж Генрих хэлээд Ренарын өмнө гар буугаа тавьж, Бүү ай, авагтун! Цэнэгтэй байна уу, үгүй юу, шалгаад үз. Ингээд та одоо зэвсэгтэй болсон болохоор хэрэг гарвал биеэ хамгаалж чадах боллоо. Та газар дор зовж байснаас эрх чөлөөтэй нэн даруй үхсэн нь дээр гэж үзнэ гэж би итгэж байна гэсэнд,

— Өвдөг сөгдөж амьд явснаас зоргоороо үхсэн нь дээр гэхэд нь — Долорес Ибаррури тэгж хэлсэн шүү дээ гэлээ. Андре Ренарын уруулд анх удаа инээмсэглэх байдал үзэгдэж ярилцаж суугаа хүнийхээ гарыг барих гэсэн мэт нэг хөдөлснөө тэр даруйд нүдэнд нь үл итгэх байдал илэрч: — Та ямар хүн юм бэ, мэдэхгүй байна. Таны энэ хувцсыг харахад ... Үнэнээ хэлэхэд та надаар яах гэснийг ойлгохгүй байна гэв. — Газар дорхи нууц заводын тухай мэдэж авах гэсэн юм! — Энэ мэдээ баримт манай ард түмэнд тус болохоос хор болохгүй гэсэн баталгаа хаана байна? — Эрүүл ухаан тийм баталгаа болно! Би энэ мэдээг та биднээс илүү сайн мэдэх германы командлалд авч өгөх гэсэн хэрэг биш нь илэрхий шүү дээ! — Тэгвэл хэнд өгөх гэсэн юм бэ? — Та гэнэхэн асуулт тавьж байгаа юм биш үү? Би хариулья гэж хичнээн хүсэвч хариулахын нөхцөл байгаа бус уу? гэсэнд Андре Ренар өөрөө өөртэйгээ ярих мэт өгүүлрүүн: — Таны зөв ч юм уу даа. Энэ мэдээ баримт германы командлалд үнэндээ хэрэг байхгүй. Дайсанд хэрэггүй болохоор анд нөхөрт эхэргтэй байж таарна. Танихгүй ч бай, анд нөхөр байж болно. За би бүгдийг ярилаа гэж бодъё. Энэ бүгд германчуудын эсрэг эргэж, улмаар газар дор тарчилж байгаа тэр зовлонт хүмүүсийг аврах ч магадгүй юм ... хэлэхгүй байлаа гэхэд намайг бариад авч магадгүй. Тэгтэл миний мэдэж байгааг энэ дэлхий дээр хэн ч мэдэхгүй өнгөрнө гэхэд нь — Та учир зүйтэй ярьж байгаа боловч даанч удаан байна. бидэнд цаг бага байгааг бодоорой. Та өөрийнхөө аюулгүй байдлыг бодох хэрэгтэй, би ч гэсэн амиа дүйхийг хүсэхгүй байна. Энэ тосгонд бүхэл отряд хүрээд ирж магадгүй шүү дээ. Бүх хэсгийг тусгай тусгай цэргийн ангид хуваарилсан. Намайг тантай энгийн тайван ярилцаж суугааг харвал ... гэхэд нь — Байзаарай. Та намайг оргуулах ажил зохион байгуулсан хүмүүсийг мэдэж авах өөр нэг зорилготой байж болох юм. — Тэр тухай танаас ганц ч үг асуухгүй! — За байз ... Та миний хамаг нотолгоог няцааж орхих шив дээ. За яах вэ, би мэдэх бүхнээ ярихад бэлхэн байна гэж Ренар хэллээ.

Бяцхан өрөөний үүд онгойж, үүдэн дээр Андре Ренар, германы офицер хоёр гарч ирэхэд хоёр эмэгтэй хоёул зэрэг урагш алхав. Тэр хоёр нэг ч үг дуугарсангүй, гагцхүү нүдэнд нь «яав» гэж асуух байдал илэрхий. Андре Ренар хөгжилтэй инээмсэглэв. Герман офицер мөн адил хөгжилтэй инээмсэглэлээ. Сэтгэлийн их хүчдэл сая л тайлагдаж, Луиза эр нөхрийнхөө хүзүүгээр тэврэн цурхиртал чанга уйлж, эмгэн хамаг тэнхээ нь алдраад сандал дээр унаж, толгой гар нь салганан чичирлээ. Генрих сэтгэл хөдлөн: — Би хатагтай нараас уучлал гуйххэрэгтэй боллоо. Миний биеэ цагаатгах ганц зүйл гэвэл бүгд миний хорон санаагаар болж байгаа хэрэг биш юм. Юм бүгд аятай сайхан болж шувтарсныг харж байгаа биз дээ! — Ай ноёнтоон, ээж бид хоёр ёс алдлаа. Гэсэн ч хүн баярласандаа үхдэггүй юм гэнэ лээ. Би таныг дайсан шиг угтсан, одоо бидэнтэй анд нөхрийн ёсоор саатан сууна уу. — Би уг нь одоо таны хүсэлтийг биелүүлэхэд хамгийн их хүсэхсэн. Даанч би тэртэй тэргүй санаснаас удаан саатлаа ... түүнээс гадна гадаах машинд нөгөөх хөөтэй Базель сууж байгааг битгий мартаарай! Түүнийг Сен-Ремид аваачиж, ноён Андре Ренарыг очтол нь барьж саатуулах ёстой байна. — Луиза нэгэнт холбоо барьсан. Өнөө шөнө юм уу, хамгийн цаанадаа маргаашаас хэтрэлгүй манай нөхөд намайг аврахаар ирнэ гэж Ренарыг өгүүлэхэд: — Миний саяны танд өгсөн гар бууг өөртөө үлдээгээрэй. Миний илүү буу юм. Танд хэрэг болно. Юу ч болж магадгүй гээд боодолтой мөнгийг ав гэсэнд, — Хэрэггүй гэв. —

Мөнгө танд бас хэрэг болно. Үүнийг нэг ёсны буу зэвсэг гэж бодоорой. Хамгийн эцэст нь хэлэхэд та бид хоёрын уулзаж ярилцсаныг нэг ч хүн, хамгийн ойр дотны анд нөхөд ч мэдэх ёсгүй. — Миний үгэнд итгэж болно. Эхнэр эмгэн хоёрыг би бас даая гэхэд Матран авгай: — Ай ноёнтоон! Та бидэнтэй дарс уухгүй юм уу? Таны яарч байгааг мэдэж байна. Гэсэн ч цаг их орохгүй шүү дээ гэхэд нь, — Би машинаа өөрөө барих хэрэгтэй байна. Жолооч маань баривчлагдсан хүнийг манана. Харанхуй шөнө, ялангуяа дарс уучихвал ... гэсэнд, — Тэгвэл жаахан хүлээнэ үү! гэж эмгэн хэлээд настай хүн гэхэд санаанд багтамгүй хөнгөн шингэн хөдлөн шургуулга тийш очоод нэг жижиг хайрцаг гаргаж ирэв. Тэр хайрцагт дурсгалын зүйлсээ хадгалдаг бололтой нямбайлж багласан, цаас нь шарласан захидлууд, жүржийн модны[1] хатсан мөчир, бодвол гэрлэх үеий нь бололтой цагаан бээлий байв. Матран авгай доод ёроолоос нь маш сайн тамхилсан хуучны гаанс гаргаж ирээд чичирхийлсэн гараар энхрийлэн илбэх мэт барьж байснаа тамхинд түлэгдэхийсэн толгойд нь уруулаа хүргээд Генрихт сарвайж: — Ноён танд би өөртөө байгаа хамгийн эрхэм үнэт юмаа бэлэглэе. Энэ миний эцгийн гаанс юм. Эцэг маань ариун журамтай, эрэлхэг зоригтой хүн байсан, тэгээд гудамжны бэхлэлт дээр коммунийг хамгаалж яваад ариун журамт эрэлхэг хүний ёсоор амь үрэгдсэн юм гэхэд нь, — Би үүнийг зөвхөн дурсгал болгож хадгалахаар барахгүй эрхэм нандин зүйл болгож хадгална! Бас Матран авгай танд элдэв ёсорхолгүй, хүү нь эхийгээ үнсдэг шиг үнсэхийг зөвшөөрнө үү гээд эмгэний үрчгэр хацрыг үнсэхдээ хэзээ нэгэн цагт эцгийнхээ хацарт ингэж хүрэх завшаан тохиолддог болов уу гэж бодоод зүрх нь шимширчээ. Матран авгай нулимсаа арчаад: — Та хөгшин франц эмэгтэй миний тухай хэзээ нэгэн цагт эхдээ яриарай. Таныг төрсөн хүү шигээ адисласныг хэлээрэй гэхэд нь, — Ноён та, биднийг аварснаа хэлээрэй гэж Луиза аяархан нэмж хэлжээ. Генрих үүдний өрөөнд ороод: — За Андре тантай салах ёс хийе. Та бид хоёр дахин хэзээ ч уулзахгүй биз дээ? гэв. — Би таны хэн болохыг ингээд мэдэхгүй өнгөрөх хэрэг үү? — Анд нөхөр! — За тэгвэл анд нөхөр минь баяртай! гээд Андре, Генрих хоёр тэврэлдэн үнсэлцлээ. Сен-Реми тийш буцах замдаа Генрих машинаа хурдан давхиулав. Явж явж газар дорхи заводын тухай чухал мэдээ баримтыг одоо нэгэнт өвөрлөж явсан болохоор ганц минут ч алдаж болохгүй байлаа. Генрихийг зочид буудлаас Миллерт утасдахад цаадах нь: — За өнөөдөр яав? гэж гомдсон байдалтай асуув. — Баярлуулах юмгүй ирсэн нь харамсалтай байна. харин нөгөө намайг буудсан партизаныг баривчлолтой. — Тэр хаа байна? — Одоо танд Курт хүргэж өгнө. Ямар ч байж болох боловч эндүүрээгүй гэж бодож байна. түүнийг хэд хоног хорьж сайн айлгаж байгаад байцаагаарай. — Хэргий нь хүлээлгэж чадна вий! гэж Миллер харилцуураар маш итгэлтэй хашгирлаа. ... Хэд хоногийн дараа агаараас бөмбөг хаяхад автоматаар хараа тааруулж чиглүүлдэг хараа зүйн багажийн нууцыг Нүгэлт хөндийгөөс олон мянган бээрийн тэртээ судалж байв.

МИЛЛЕР ШАГНАЛ ХҮРТЭВ Поль Шеньег эрэх ажлын үр дүнг генерал Эверс хариуцахгүй, зөвхөн Миллерийн мэдэлд шаардагдах тооны цэрэг, офицер гаргаж өгөх үүрэгтэй байжээ. Эрэл хийж байгаа отрядууд уг ажиллагааны явцын тухай дивизийн штабт илтгэдэггүй, тэндээс заавар авдаггүй байлаа. Юм бүгдийг СС-ийн албан буюу өөрөөр хэлбэл Миллер хийж байв. Эрэл хийх ажил нэг, хоёр өдөр үргэлжлээд дуусна гэж үзэж байсан боловч дөрвөн хоног өнгөрөхөд Поль Шеньегийн мөрийг хэн ч олсонгүй

Эверс үүнд дотроо баярлаж байжээ. Тэгэхдээ зугтсан этгээдийг өчүүхэн төдий ч атугай өрөвдсөндөө тэр биш. Огт тийм бишээ. Шенье хэрэв газар дорхи заводын нууцыг задруулбал герман оронд хичнээн их хор хүргэхийг генерал ойлгож байлаа. Оргодол этгээд Эверсийн гарт орвол өчүүхэн ч эргэлзээгүй буудан алахсан. Харин СС-ийнхэн болон Миллерийн бүтэлгүйтэж байгаа нь генералын гомдлыг зарим нэг хэмжээгээр тайтгаруулна. Генерал өөртөө гүйцэд итгэхгүй байна гэдгийг ойлгосноос хойш гомдох болжээ. Чухамхүү Поль Шеньегийн зугтсан явдал генералын нүдийг нээж, газар дорхи үйлдвэрийн жинхэнэ байрлалыг түүнээс нууж байсныг мэдүүллээ. Оргодлыг эрэх ажилд генералын тусламжийг авсан атал завод чухам юу үйлдвэрлэдгийг хэлсэнгүй. Энэ бол доромжилсон хэрэг байлаа. Ул үндэсгүй ингэсэнд нь генерал гомдов.

Сталинградын дэргэд германы томоохон бүлэг бүслэгдсэн тухай Эверс олж мэдсэн тэр нэгэн тэмдэглэлт шөнө амралтын чөлөө олгохыг хүсч бичсэн илтгэх хуудасны нь хариу чухам тэр үеэр ирж таарав. Уг хариунд амралт олгох тухай хүсэлт тавьсан нь цаг үеэ олоогүйгээр барахгүй «Францад байрлаж байгаа дивизид тухайн нөхцөл байдлаас болж нэмэлт бэрхшээл учирсан» тул илтгэх хуудас өгсөн явдал цаг үеэ олсонгүй гэдгийг шууд хэлсэн байжээ. Энэ нь зэмлэлтэй адил байв. Тэгээд Эверс этр хатуу үгийг залгиж орхиод ямар утгатай үг цухуйлгасныг мэдээгүй юм шиг дүр үзүүлэхээс өөр зам үлдсэнгүй. Дорнод фронтоос ирж байгаа мэдээ улам бүр сэтгэл зовмоор болж, үйл явдлын тухай Геббельсийн суртал нэвтрүүлэг улам бүр үнэмшил багатай болж байлаа. Өдий төдий тойм бичигчид анхандаа бүслэгдсэн армид туслахаар яаран давшиж байгаа Манштейний цохих бүлгийн амжилтын тухай бахархан бичиж, хахаж цацан хашгиралдаж байснаа одоо болоход тэр бүлгийн тухай ичингүйрэх мэт дуугүй өнгөрч харин бүслэгдсэн цэргийн эр зориг, хатуужлын тухай хахаж цацан магтах болжээ. Энэ бүгдэд хууртах хүн олон байдаг юм гэхэд генерал Эверс хууртах хүн биш билээ. Гэтэл олигтойхон хөдөлж, герман орныг аврах арга зам эрж сүвэгчлэх хэрэгтэй ийм үед алс хол францын нэг бяцхан хотод амгалан дүрээр хүлээж, Дорнод фронтын байдлын тухай эсрэг тэсрэг мэдээгээр сэтгэлээ зогоож суух болж байна. Үнэхээр эсрэг тэсрэг мэдээ ирж байлаа! Москвагийн радио Умард Кавказ, Ленинградын районд зөвлөлтийн цэрэг амжилттай давшиж эхэлсэн тухай мэдээлж байхад гитлерийн ерөнхий командлалын мэдээнд «фронтын шугамыг тэгшлэх» тухай тодорхой зүйл гүйлгэн хэлэх төдийгөөр хязгаарласан байна. Генерал Эверс Германы хувь заяа шийдвэрлэгдэж байгаа Дорнод фронтод очихыг бүхий л зүрх сэтгэлээр тэмүүлэвч аргагүй эрхэнд ар талд сууж, «бага дайн» хийхэд хүрч байлаа. Энэ «бага дайн» гэгчид дайсны хохирлын хэмжээг мэдэхэд их төлөв маш хэцүү байх атал өөрийн хохирлыг өдөр тутам нарийн тоолж болно. Өөрийн нь хохирол улам үлэмж болж байв. Анхандаа Поль Шеньег эрж эхлэх үед дивизийн байрласан районд амгалан тайван болж нэг ч буун дуу дуулдахгүй, макиуд герман цэргийг довтолох явдал нэг ч гарахгүй болжээ. Тэгээд цаг ямагт ийм тайван байх шиг санагдаж, партизаныуд бүх зам давааг бүслэн хаасан СС-ийн ангиудын хаалтыг сэтлэж чадна гэж итгэхэд бэрх байлаа. Гэтэл түр зуурын амсхийлт байсан юмсанж. Эрэл эхэлснээс хойш гурав дахь шөнө дээр макиуд арван зургаан цэрэг, буудан алжээ. Бас нэг өнжөөд газар дорхи завод тийш явж байсан машины цувааг зоримог уулгалан дайрчээ.

Түүнээс хойш макиуд бүр их идэвхжсэн учир генерал өдөр бүр дивизийн байрласан районд болсон хэрэг явдлын тухай илтгэх хуудсанд гарын үсэг зурах хэрэгтэй болж байлаа. Энэ нь корпус командлагчийн анхаарлыг татахгүй байж чадсангүй. Генерал бараг биеэ өмгөөлж, учир гаргах хэрэг болов. Эверс нэг илтгэх хуудсандаа макиуд идэвхжсэн нь Эверсийн өөрийн нь салан замбараагүйгээс болсон хэрэг биш, Дорнод фронт дээрх хэрэг явдлаас шалтгаалсан гэж илэн далангүй шууд бичиж орхив. Генерал ийм болгоомжгүй үг алдсандаа тэр даруй гэмшиж, оройжингоо өөртөө дургүйцэв. Маргааш нь Сен-Ремид дээд командлалын төлөөлөгч ирж магадгүй гэсэн мэдээ корпусын штабаас аваад тэгж өөртөө дургүйцэх нь бүүр их боллоо. Өөр цагт Эверс дээд дарга нарыг угтахад бэлтгэх заавар тушаал өгч, энэ тухай дарга нарт мэдэгдэж, ер нь зочныг нэр төртэй угтах бүхий л арга хэмжээг авах байсан билээ. Энэ удаа дургүйхэн ярвайж, тэр мэдээг штабын дарга, өөрийн туслах хоёртоо ч үзүүлэлгүй, бичгийн ширээний шургуулганд далд хийлээ. Сен-Ремид дээд командлалын зүгээр нэг төлөөлөгч биш, генерал фельдмаршал Денус өөрөө хүрч иржээ. Ийм тааламжтай сайхан уулзалт болно гэж Эверс огт санасангүй. Денус бол Эверсийн багш бөгөөд гол нь бараг санаа нэгтэй хүн. Харин Денус гэнэн шавь шигээ хэвлэлд элдэв юм бичиж байсангүй. Хэдий тийм боловч Зөвлөлт холбоот улстай дайн эхлэхээс өмнө Эверстэй аминчлан ярилцахдаа генералын үзлийг бүрэн дүүрэн зөвшөөр байгаагаа мэдэгдэж, ялангуяа хоёр фронт дээр байлдах нөхцөлд Оросыг цахилгаан шиг хурдан ялах бололцоонд итгэхгүй байгаагаа цухуйлгасан юмсанж. Чухам ийм учраас Фельдмаршалын танил дүр нүдэнд харагдахад Эверс баярласан байна. Денус албан ёсоор товчхон мэндлэлцсэний дараа нөхөрсгөөр: — Би чам дээр ганц хоёр өдөр амрах гэж ирлээ. Тэгэхлээр намайг элдэв аялал, үзлэгээр битгий ядраагаарай гэж хэлэхэд нь Эверс бүүр их баярлажээ. — Танд тэгж амрах нөхцөлийг дуртайяа бүрдүүлж өгнө. Миний багш эрхэм зочин та миний байшинд буухыг зөвшөөрвөл өөртөө их аз завшаантай хэрэг гэж үзнэ! гэж Эверс өгүүлээд цээжин дээрээ гараа тавьж мэхийн ёслов. — Урилгыг дуртайяа хүлээн авъя. Би ганцаар сууж чадахгүй. Тэнд чинь бид хоёул багтах зай олдоно биз дээ? — Танд таван өрөөтэй хоёрдугаар давхар багадахгүй бол ... — Надад хоёр өрөө байвал хүрээ. Чи өөрөө дэргэд байгаарай. Нас өтлөхөөр ганцаардахын зовлонг илүү мэддэг юм байна. Туслахуудаас бүр залхаж гүйцлээ ... Фельдмаршалыг гаднаас нь харахад эрүүл чийрэг байдалтай харагдах боловч дууны өнгөнд өтөлсөн хүний яншаа маяг сонсдоно. Эверс машин дуудах гэсэнд Денус татгалзаж: — Үгүй, үгүй, байшин чинь чиний хэлдгээр ойрхон юм бол би дуртайяа явган явах байна. Машин, нисэх онгоц мэтийн ер нь механикжуулсан унаанаас бүр залхаж гүйцлээ. Дайн дажингүйсэн бол ийм юмны сураг ч дуулахгүй нэг бөглүү газар очих юмсан гэхэд нь: — Одоо цас орж байна шүү дээ, эрхэм дээдэс ээ! гэж Эверс сануулсанд Денус өргөн цонхоор хараад — Өө би хөгшин ясаа бүлээцүүлэх гэсэн юмсан! Энд ерөөс цас ордоггүй байх гэж санасан юм. Чиний байшин ядаж дулаахан биз дээ? — Би задгай зууханд гал түл гэж тушаана. Денус бүхэл өдөржингөө орноос босохгүй хэвтэж, ном ч уншихгүй, зурагт сэтгүүл эргүүлж өнжив. Зочин оройн хоолонд ганц хундага шарзнаас өөр юм уусангүй, загаснаас өөр хоолонд ам хүрсэнгүй. Эверс түүнийг өөрийн сонирхож байгаа сэдэв рүү түлхэх гэж хичнээн хичээсэн боловч яриа бас эвлэхгүй байлаа. Генералын урам хугарчээ. Уг нь илэн далангүй ярина гэж найдаж байсан атал Фельдмаршал тийм ярианаас яагаад ч юм бэ

зайлсхийнэ. Замын алжаал нь гараагүй болоод тэр юм болов уу? Эсвэл шинэ хоол авчрах, таваг солих гэж орон гаран бйагаа шивэгчин эмэгтэй саад болоод байна уу? Эверс зөөлөн сандлуудыг галд дөхүүлж тавихыг тушаагаад шивэгчин хүүхнийг явуулав. Одоо зочин, гэрийн эзэн хоёр хоёулхнаа үлдэж тэдэнд саад хийх хүнгүй боллоо. Харин ч задгай галын дөл улалзаж тасалгаанд харуй бүрий болж маш сайн навчин янжуур татаж суухад аминчхан ярих тохиромжтой цаг болсон шиг санагдана. Тэгээд Денус ч ярьж эхэллээ. — Герман аа, чи Дорнод фронтын хэрэг явдлыг эрэгцүүлж бодож байна уу? гэж Денус гэнэт асуув. Эверс шууд хариулахаас зайлсхийсэнгүй. Генерал санасан бодсоноо тайван ярилцаж болмоор хүнтэй уулзаагүй асар удсан болохоор ийм ухаалаг хэрсүү хүнтэй ярилцах аятайхан завшаан тохиолдоод байхад хэрхэн дуугүй байж болох билээ. Денус түүний үгийг тасалсангүй нүдээ онийлгон гал ширтэж, үе үе зөвшөөрсний тэмдэг болгон толгой дохино. Эверс нэг бодлоо л ил хэлж чадсангүй. Юу вэ гэвэл фюрерийг үгүй хийж байж л Германыг аварч болно гэж өөрөө боддог байжээ. — Өрнөд фронт, Африк дахь манай дайсантай нэн даруй эвлэрэх ганц л зам бий гэж чи бодож байна уу? гэж Денус асуухад: — Тэгж бат итгэж байна. — Америкийн Нэгдсэн Улс, Англи хоёрын алин нь ч эвлэрэхгүй, — Тэр ч тодорхойгүй хэрэг. — Гесс тухайн үедээ Англид ямар зорилготой очсон гэж бодож байна? хэмээн Денус асуув. Эверс хариу хэлэх үг аман дээр нь гарч ирсэн боловч дуугарсангүй. Дахиад засч залруулашгүй алдаа хийж орхивол яана? Фельдмаршал өөрөө хэрэг явдлын тухай үзлээ хэлээгүй байгаа шүү дээ. Денус, түүний эргэлзэж байгаагийн учрыг ойлгоод өөрөө тус болж өгүүлсэн нь: — Ахлах цэрэг² дэлхий дахины өмнө нэрээ хугалсан. Тэгэхээр Англи, АНУ хоёрын засгийн газар түүнтэй ямар нэг буурьтай хэлэлцээ хийхийг хүсэхгүй ... гэв.

Хэсэгхэн зуур дуугүй болцгоов. Тэгснээ Денус эхлэж: — Өөр хүн хэрэгтэй байна. Би чам дээр зүгээр амрах гэж ирсэн юм биш ээ ... гэв. Генерал Эверсийн байшингийн задгай зуухны дэргэд гэрийн эзэн, түүний зочин, гитлерийн армийн ахмад генералын нэг, генерал фельдмаршал Денус хоёрын ярьсан энэ ярианы ганц ч атугай өгүүлбэрийг сонсохын тулд Миллер юугаа ч хайрлахгүй байсан биз ээ. СС-ийн албаны дарга энэ үед Сен-Ремид ч байсангүй. Тэрээр германыг аврах тухай бодох завгүй хар амиа аврахыг бодож явжээ. Харин уулын бяцхан голын ёроолоос хар амиа аврах арга олох гэсэн юм шиг, тэр голын ёроолыг өөрөө удирдан нарийн нягт шинжилж байсан нь гайхалтай юм. Миллер шоронгийн хувцастай нэг үл мэдэгдэх хүнийг буудаж унагасан мэдээ Поль Шеньегийн эрэлд оролцож байгаа хүн бүгдийн сэтгэлийг хөдөлгөв. СС-ийн албаны даргын сум чухам тэр аюултай оргодлыг оносон юм уу гэмээр байлаа. Миллерийн өөрийн ярьснаар бол ийм явдал болсон байна: Миллер тэр орой уулын нэг тосгоноос явж байгаад зөргөөс хажуу тийш гартал бутан дотор, хадны цаана нэг хүн харагджээ. Миллер мөр олсондоо сайн итгэсэнгүй, гар буугаа гаргатал хадны цаанаас шоронгийн хувцастай нэг хүн гарч, гол тийш ухасхийсэн байна. Миллер тэр үл таних хүнийг амьдаар барих аргагүй байжээ. Хад нь яг эргийн дэргэд байсан учир оргодол этгээд ус руу харайж завджээ. Буудахаас өөр зам үлдсэнгүй. Бүрэнхийд шагайх төвөгтэй байсан тул Миллер автомат гар бууныхаа бүх сумыг дуусган буудахад тэр гэмт этгээдийг шархдуулсан юм уу, алсан юм уу, ямар ч атугай усанд живээд дахин хөвж гарсангүй. Уул газар дээр нэн даруй цэргүүд дуудаж аваачив. Цэргүүд голын ёроолыг метр метрээр

урт дэгээгээр тэмтэрч эрсэн боловч хүүрийг олсонгүй. Голын түргэн урсгал тэр хүний хүүрийг анх алагдсан газраас хол урсгаж аваачсан бололтой. Өглөө нь дахиад бүр өргөн хэмжээгээр эрэл хийх хэрэгтэй боллоо. Хэд хэдэн тусгай баг голын урсгалын доод талаар нэгэн зэрэг эрэл хийлээ. Миллер өөрөө бүх бүлгийн ажлыг удирдаж, тэр ч байтугай тэнгэр муухай байсан ч гэсэн машин дотроо унтав. Уулын түргэн урсгалтай гол олзыг нь хамар доороос нь булааж аваачаад дооглож байгаа юм шиг нөгөө оргодлын хүүр олдохгүй л байлаа. Хүүр эрэх ажил зургаа дахь үргэлжилж, офицерууд Шеньегийн хэргийн талаар Миллер «нэг сэжмийг усанд нуусан» гэж өөр хоорондоо аминчлан сэм ярилцах нь олон болов. Долоо дахь өдөр нь хүүрийг олсон гэж дуулаад бүгдээр гайхсаныг хэлээд яана! Сен-Ремид түрүүн генерал Эверс дээр зөвлөлгөөн хийлгэсэн СС-ийн нөгөө офицер, энгийн хувцастай өөр нэг хүн дагалдуулан иржээ. Тэд нар нэн даруй нөгөө хүүрийг олсон газар тийш явлаа. Урьдчилсан үзлэг хийхэд тэр бол Поль Шенье мөн нь нотлогдов. Голын ширүүн урсгалд бие нь ялангуяа нүүр нь чулуу мөргөж гэмтсэн байлаа. Том том чулуу мөргөж, усанд удсанаас хөөсөн нүүр нь танигдахын аргагүй болсон тул Поль Шеньегийн зурагтай тулгаж үзэхийн хэрэгцээгүй байжээ. Мөн тэр шалтгааны улмаас хурандаагийн авчирсан хурууны хуаюур ч хэрэг болсонгүй. Тэр хуаюурыг живж үхсэн хүнийхтэй зэрэгцүүлж үзэх бололцоо бас байсангүй. Миллер үнэхээр газар дорхи заводаас зугтсан хүнийг буудаж алсан юм байна гэдэг бодол төрүүлэх нэг маргашгүй баталгаа байсан нь хүүрийн гар дээр 2948 гэсэн дугаар тодхон харагдаж байлаа. Бас заводад хоригдож байгаа хүмүүсийнхтэй адил шоронгийн хувцастай байсан нь гэмт этгээдийг үхсэн хойно ч гэсэн барьж авчээ гэдэг бодлыг нотлов. Харин живж үхсэн хүний хувцас хуучирсан байхад заводаас авсан мэдээгээр бол Поль Шеньег зураг төсөл судлах ажилд ороход нь дан шинэ хувцас тавьж өгсөн байх тул нөгөө энгийн хувцастай хүн бага зэрэг эргэлзэх байдал гаргасан байна. Гэвч оргодол этгээд нь олон хоног уул хавцлаар тэнэх хэрэгтэй байсныг Миллер сануулан дурдахад энгийн хувцастай хүн зөвшөөрч, тийм нөхцөлд өмссөн хувцас нь элэгдэж хуучрах байтугай, юу ч үгүй урагдан тасарсан ч байж болох юм гэж үзлээ. Хэдий тийм боловч алагдсан хүнийг бүрмөсөн танин тодруулж албан ёсны протокол зохиохын тулд тусгай комисс байгуулахаар шийдвэрлэжээ. Тэр комиссын бүрэлдэхүүнд дээр дурдсан СС-ийн офицер, энгийн хувцастай хүн хоёроос гадна Миллер, дивизийн штабын төлөөлөгч Генрих фон Гольдринг нар оролцсон байна. Генрих комиссын цугларах газар тийш их л баргар царайлан явлаа. Эрэл хийж байсан бүх өдрийн турш Генрих Милерээс өөрөөс нь дутуугүй сэтгэл догдолж байжээ. Энэ үнэхээр Поль Шенье буюу Андре Ренар мөн байвал яана? Макиуд түүнийг ууланд аваачиж чадсангүй гэж үү? Тун хачин юм! Ялангуяа шоронгийн хувцастай байдаг нь бүүр хачин гайхалтай байна. Энэ ч бүүр учир тодорхойгүй зүйл байна. Генрих Ла-Травельсад очиж, Ренартай уулзах тэр үед Андре дотуур цамц, гэрийн өмдтэй байсан. Эсвэл Генрихт тэгж санагдсан юм болов уу? Судалтай өмд нь шоронгийн хувцасны нэг байсан байж болох юм. Макиуд зохих цагт амжиж очоогүй болоод Андре хувцсаа ч сольж чадалгүй зугтах хэрэгтэй болсон юм болов уу? Ла-Травельсад дахин очиж, Андре Ренар аюулгүй газар хүрснийг биеэр шалгах ёстой байж. Генрих болгоомжлоод тэгж шалгаагүй нь алдаа болсон байх нээ. Үүний харгайгаар Генрихт их тус болсон эрэлхэг зоригт сайн хүн Андре Ренар амь үрэгдсэн байх нээ. Голын эрэг дээр олон хүн бөөгнөрөн байгааг Генрих холоос харлаа.

Комиссын гишүүд цуглараад байгаа бололтой. Бушуухан очих хэрэгтэй байтал хөлд нь тугалга цутгаж орхисон юм шиг хүндэрч, зүрх нь учиргүй булгилав. Үгүй, царайдаа ердийн хэнэггүй тайван байдал бий болтол алгуурхан очих хэрэгтэй юм байна. Ер нь барон фон Гольдринг нэг их яарах албагүй. Жирийн нэг хүн биш, Бертгольдийн өөрийн хүү гэдгийг мэдэж аваг гэж бодно. Комиссын гишүүд үнэхээр Генрихийг их хүндтэй угтлаа. Жирийн нэг ахлах дэслэгч бол ингэж хүндлэхгүйсэн. Тэгээд тэр даруйдаа хүүрийг үзэж шинжиж эхлэв. Генрих ч гэсэн бусадтай хамт тонгойж үзлээ. Нуруугаар Андретэй адил нүүр нь танигдахын аргагүй эвдэрч, шарх сорви болжээ ... Гар дээрх дугаар нь мөн л Андрегийнхтай адил 2948 байна! Байз, байз, энэ дугаар нэг л биш шиг ... Гарцаагүй тийм байна! Андрегийн дугаарыг бугуйд нь ойрхон шивсэн байсан. Бас тоог зурсан байдал нь өөр, «2»-ын тоонд ийм бяцхан гогцоогүй байсан шүү дээ! Генрих улам доош тонгойж, живж үхсэн хүний их биеийн дагуу алгаар нь доош харуулан тавьсан баруун гарыг нь харлаа. Няцарч цус хурсан хар хумстай гар байв. СС-ийн албаны даргад Генрихийн шилжүүлж өгсөн Ла-Травельса тосгоны ховлон мэдүүлэгч этгээд сэжигтэй хүмүүсийн нэрсийн жагсаалтыг чухам ийм хуруугаар зааж байсан билээ. Базелийн байцаасан нь юу болж дууссаныг Миллер мэдэгдээгүйн учир энэ байж шүү гэж Генрих бодов. Генрих Миллерийг харвал түүний болгоомжилсон харцтай тулгарав. «Юу ч мэдээгүй байдал үзүүлэх хэрэгтэй юм байна. Эс тэгвэл СС-ийн албаны даргын сэтгэл догдолж байгааг комиссын гишүүд ажиглаж орхино!» гэсэн бодол Генрихийн толгойд зэрвэсхийгээд тэр өдрийн баатар Миллерийн дэргэд очиж ялдамхан инээмсэглэн: — Эрхэм хошууч танд Шеньег эрэх ажлыг амжилттай дуусгасанд тань чин сэтгэлийн баяр хүргэхийг зөвшөөрнө үү! гэж хэллээ. Миллерийн нүдний түгшүүрт харц даруй арилж, уруулд нь баясгалант инээмсэглэл тодров. Мөн тэр өдөр офицеруудын хоолны газар хоолны өмнө нөгөө СС-ийн хүн Миллерт оргодол этгээдийг үхсэн хойно нь ч гэсэн баривчилсны учир таван мянган маркийг гардуулан өгөв. Комиссын албан ёсны тогтоолтой дугуйг Берлин хотноо штаб-байранд хэдий илгээжээ. Генрих хоолны дараа Миллертэй хамт гарч явахдаа: — Ганс аа! Та надад өөрийн мөнгөөр энэ орой сайн хоол идүүлэх ёстой гэж бодохгүй байна уу? гэж жаахан догдолсон байдалтай асуусанд: — Аа, баяртай тэгнэ. Би танд өртэй байж магадгүй. Танаас хэд хэдэн удаа цөөн мөнгө зээлж авсан. Бүгдийг нь өгсөн эсэхээ сайн санахгүй байна гэж Миллер хэлэв. Миллер таван мянган маркаар шагнуулсандаа сэтгэл нь хөөрөөд урьд төлдөггүй байсан өрөө төлөхөд бэлэн байжээ. — Би тийм цөөн юмыг санаанд ордоггүй болохоор та бид хоёрын тооцоо юу болсныг санахгүй байна. Харин сүүлчийн нэг юм бий гэж Генрих өгүүлсэнд: — Ямар өр вэ? гэж Миллер тайвуухан сонирхоход нь: — Миний дуугүй өнгөрүүлсний төлөөс гэж Генрих хариулсанд Миллер дороо зог тусч, царай нь зэвхийрэв. — Явъя даа, Ганс аа! Та бид найз нөхөд шүү дээ. найз нөхдөд бие биенээсээ нуух юм юу байх вэ. Үнэнээ хэлэхэд таны авхаалж самбаа, уран аргыг гайхан бахархаж байна. Поль Шеньегийн оронд Базелийг шургуулж орхисон байдаг! гэж Генрих хэлэв.

Генрихийг сугадаж авсан Миллерийн тохой чичрэх нь мэдэгдлээ. Генрих яриагаа үргэлжлүүлэн: — Надад бол тийм ухаан төрөхгүй юм байна ... Үгүй, сэтгэл бүү зовоорой. Ганс аа! Би ч гэсэн тэр баригддаггүй Шеньег эрж уул хадаар тэнэсээр бүүр залхаж орхилоо. Та намайг энэ тааламжгүй үүрэгт ажлаас ангижруулж өгсөнд маш сэтгэл хангалуун байна! гэсэнд — Генрих ээ, та үүнийг яаж мэдсэнээ надад хэлэхгүй юу — Тэр миний нууц гэсэнд Миллер бодлоо цэгцлэх мэт хэсэг дуугүй байснаа өгүүлрүүн — Би бүүр илэн далангүй хэлье. Танд хамаатай нэг нууцыг хэлье. Тэгэх үү? гэхэд нь — Их анхааран сонсох байна гэсэнд — Чухамдаа танд шууд хамаагүй, таны сэтгэлд таалагддаг мадемуазель Моникад хамаатай юм. Макиуд зэвсэг ачсан цувааг дайрахаас хэдэн хоногийн өмнө мадемуазель Моника бонвиль орж, тэнд хэдэн цаг болоод чухам ямар замаар эргэж ирсэн нь мэдэгдэхгүй ирснийг бид олж тодорхойлсон. Галт тэргээр эргэж ирээгүйг бид мэдэж байна. түүнээс гадна танай жолооч Курт Шмидт тэр галт тэрэгний дугаар, Бонвилаас гарах цагийг мэдэж байсан байна. энэ хоёр баримтыг харьцуулж үзээд танд их сэжигтэй юм шиг санагдахгүй байна уу? Саналаа хэлээч гэхэд нь Генрих хэсэгхэн юм бодоод хөгжилтэй инээд алдаж: — Эрхэм нөхөр Ганс аа! Танай СС-ийн албан цаашдаа ч иймэрхүү янзтай ажиллах юм бол таныг Бертгольдийн өмнө яаж өмөөрлөө ч гэсэн дээд дарга нартаа нүүр талтай болж чадна гэж батлахгүй нь байна. Таны над ярьсан нууцын дээр одоо миний ярих зүйлийг нэмчихээрэй. Юу гэвэл мадемуазель Моника Бонвиль орохоосоо хоёр хоногийн өмнө «Амласнаа битгий мартаарай» гэсэн үгтэй нэргүй цахилгаан утас хүлээж авсан юм. Тэр цахилгааныг чухам хэн илгээснийг олж тодорхойлох нь СС-ийн албанд бэрхтэй байгаа бол яг нарийн хэлж чадах байна. Тэр цахилгааныг Генрих фон Гольдринг явуулсан юм! Мөнөөхөн Гольдринг мадемуазель Моникаг Бонвильд очсоны дараа хоёр цаг болоод өөрийнхөө машинаар Сен-Ремийн зүг гарахдаа арын суудал дээрээ нэг хүн суулгаж явсан юм. Тэр нь хэн байв гэвэл мадемуазель Моника байсан юм. Энэ нууцын бусад дэлгэрэнгүй зүйлийг та сонирхохгүй биз найдаж байна гэв. Энэ үед Миллер сандарч тэвдсэн, гомдсон царай гаргахад нь Генрих тас тас инээж: — Хэдий тийм боловч энэ тухай надад хэлсэнд тань баярлан байна. Надаас болж мадемуазель Моникад эвгүй явдал тохиолдвол маш харамсалтай хэрэг болохсон. Үнэнээ хэлэхэд танд их баярлаж байна гэсэнд, — Учир нь ийм амархан олдсон нь яамай Генрих ээ, ингэхэд байна шүү! Та СС-ийн албанд шилжиж ир. Тан шиг ийм авьяас чадалтай, танил талтай хүн алба тушаал сайхан ахиж болохсон. Та бид хоёр маш сайхан ажиллах болно. Би ч гэсэн бага сага ажил бүтээж чаддагийг та зөвшөөрөх биз! гэхэд нь — Энэ тухай бодох нь бодож байсан. Энэ ажилд тэвчээр хүрэлцэхгүй болов уу гэж айж байна. ялангуяа миний зан байдалд залуу насны харгай гэж үзэж болох боловч тэглээ гээд бага болчихгүй дутагдал бийг харгалзах хэрэгтэй. Ганцхан танд үнэнээ нуулгүй хэлэхэд сайхан хүүхэнд дуртай хүн шүү, би гэсэнд энэ удаа Миллер тас тас инээгээд — Танд шинэ мэргэжил саад болно гэж бодож байна уу? Генрих минь огт тийм биш шүү! Таны санаанд таарсан ямар ч хүүхэн элдэв төвөг чирэгдэлгүй таных болно. Эргүүлж барьж цаг дэмий үрэхгүй ... гэхэд нь: — Бодож үзье, Ганс аа. Үнэнийг хэлэхэд таны энэ саналыг таны тэр нууцаас илүү сонирхож байна гэсэнд: — Өө надад таныг гайхуулж чадахаар бас нэг нууц зүйл байгаа. Манайхаар очье. Тэгээд та намайг жинхэнэ анд нөхөр мөн юм байна гэж бат итгэнэ! гэжээ. Тэр хоёр нэг мухар гудамж тойрч СС-ийн албаны байрладаг өтгөн цэцэрлэгтэй

байшингийн дэргэд хүрлээ. Миллер албан тасалгаандаа ороод төмөр шүүгээ онгойлгон хавтастай бичиг гаргаж ирээд нэг жижиг дугтуй гаргаж Генрихт өглөө. Генрих тэр дугтуйг нь хайхрамжгүй аваад шудангийн тэмдгийг нь харснаа: — Монтфлер ээ! Танд Монтфлерээс захиа бичсэн юм уу? Үүнийг юу гэж ойлговол таарах байна, Ганс аа? гэхэд — Би бол тэр хотод таны найз байдаг гэж хэлэхгүй нь байна! — Нэг их урт биш юм бол яах вэ, уншиж болох уу? — Ердөө хагас хуудас юм бий ... Генрих дал мөрөө хавчаад дугтуйгаас дөрөв нугалсан бичиг гаргаж, дэлгэн үзээд юуны өмнө гарын үсгийг харав. Гэтэл нэргүй захиа байжээ. Нэр тодорхойгүй тэр хүн Гольдрингийн германы цэрэгт шилжиж ирсэн байдлыг их, бага алин боловч нарийн тодорхой бичээд «Төмөр нударга» гэдэг ажиллагааны төлөвлөгөөг чухам Гольдринг л оросын командлалд өгсөн байж таарна, «Ногоон зугаалга» гэдэг ажиллагааны төлөвлөгөөг ч бас өгсөн байж магадгүй гэсэн таамаглал хэлжээ. Тэр захиаг бичсэн хүн Гольдрингийг дахин шалгаж үзэхийг зөвлөсөн байна. Генрих захидлын сар өдрийг харвал тэр захиаг Лион тийш өөрийн нь явахаас хэдэн өдрийн өмнө бичсэн байлаа. Тэгэхэд Шамберийн зочид буудалд хийсэн шалгалт энэ захидалтай холбоотой байсан байжээ. Генрих энэ захиаг хоёр дахь удаагаа уншихдаа захиаг ямар нэг учир холбогдолтой юм шиг үзэж байгаагаа Миллерт мэдэгдсэнгүй. Бичгийн бүх онцлогийг дасгалжсан сурамгай нүд дор нь тогтоож авлаа. Танил бичиг байна! Генрих энэ хов мэдүүлгийг чухам хэн бичсэнийг тааварлав. — Баярлалаа, Ганс аа. Та намайг овоо зугаацуулав. Энэ захиаг бичсэн хүн тун гэнэхэн хүн бололтой. Энэ дэмий юмыг Бертгольд үзсэн бол тусгүй юм болох байсан. Танд аминчилж хэлэхэд эрхэм Бертгольд тоглоом даадаггүй болохоор энэ захиаг өөрийн нь эсрэг хандсан материал гэж үнэлж магадгүй юм шүү. Тэгвэл таныг хэзээ ч уучлахгүй шүү дээ гэсэнд Миллер сандарсан байдалтай нүдээ анивчаад: — Ээ тэнгэр минь, Генрих ээ! Би энэ нэргүй балай захиаг хөгийн юм гэж бодоод танд үзүүлэх л гэж хадгалж байсан юм шүү. Одоо та бид нэгэнт инээдэм наадам болсон хойно ... гээд хошууч халааснаасаа асаагуур гаргаж, Генрихийг хорьж завдахын хооронд нэргүй захиаг шатааж орхив. — Энэ ч дэмий хэрэг боллоо, Ганс аа! Ямар ч атугай баримт бичиг шүү дээ! — Хаана ч бүртгэгдээгүй юм. Бид зөвхөн манай агентуудын өгсөн материалыг бүртгэдэг. — Тэгсэн ч гэсэн харамсалтай байна! Энэ захидлыг бичсэн хүн биднийг ингэж хөгжөөн баясгасан байхад бид ачийг нь ингэж хариулж байх гэж дээ. одоо зочин нь гэрийн эзнийг бодох ээлж болсон юм биш үү? Та хичнээн олон шөнө нойргүй хонож, тэр комиссоос болж, хичнээн их ажил удав даа. — Юу гэсэн үг вэ, Генрих ээ! Би тантай уулзахдаа үргэлж баяртай байдаг. Танд үнэн голоос талархалтай байдгаа батлан үзүүлж чадсандаа сэтгэл хангалттай байна. — Би ч гэсэн танд тийм байдаг гэж Генрих хариулжээ. Генрих гэртээ ирэнгүүт хошууч Шульцийн бэлэглэсэн газрын зургийн наад талд генерал Даниелийн зогсож байгаа гэрэл зургийг нарийн нямбай нууж хадгалсан нэг чемодан руугаа ухасхийлээ. Генрих тэр гэрэл зургийг үзсэнгүй, ард нь бичсэн бичгийг анхааралтай ажиглаж, хошуучийн бичгийг нэргүй захидлын бичигтэй харьцуулан үзлээ. Эндүүрэх арга байсангүй. Тэр мэдүүлгийг Генрихийн бодсончлон хошууч Шульц бичсэн нь гарцаагүй боллоо!

ГЕНРИХ ЦААЗЫГ БИЕЛҮҮЛНЭ — Хонгор бүсгүй минь, чи биеэ авч байж

чадахгүй байна. дарс уухаар чам дээр ирсэн болзоот хархүүтэйгээ сууж байгааг бүү мартаарай. Гэтэл чи надтай ханилаад арван жил болчихсон юм шиг, би юу юугүй л энэ шилийг чамруу шидэх гэж байгаа юм шиг тийм нүдээр харж байна гэж Франсуаг хошигноход нь: — Франсуа! Чи юунд дандаа тоглоом хийж байдаг юм бэ? Людвина чухам яагаад ийм аюултай үеэр ирэх болоо вэ, хэлээд өгөөч гэж Моника хэлжээ. Бонвиллоос «үеэл эгч» нь ирэх болсныг Моника дуулаад гайхаж сэтгэл их догдолсноо нууж чадсангүй. — За мишээгээч ... Дарсандаа ам хүр. Биднийг хүн хараад байна шүү! Би ерөөс зоогийн танхимд ирсэн нь болгоомжгүй хэрэг болсон юм. За одоо болж байна! Одоо л чи нээрээ хайр дурлалаас өөр юм бодоогүй бүсгүйн байдалтай боллоо ... Людвина яагаад чухам ирэх болсныг гайхаж байна уу? Яагаад гэвэл, түрэмгийлэн эзлэгчидтэй одоо л ёстой нэг тэмцэл хийж эхлэх янз орж байна. ийм тохиолдолд Бонвильтой байнгын холбоотой байх ёстой юм гэж Франсуаг хэлэхэд: — Түүнд нэвтрэх бичиг байгаа юм уу? гэв. — Надад чамаас илүү мэдсэн юм алга. Людвина Декок ирнэ, угтах хэрэгтэй. Миний мэдсэн нь ердөө энэ байна. — Ямар галт тэргээр ирэх вэ? — Өнөөдөр арван зургаа хорьд ирнэ. — За яах вэ, би түүнийг угтъя. — Хоёулаа угтахаар очно. Харин хамт явахгүй. Би тавцан дээр гол хаалганы баруун гар талд, чи зүүн гар талд нь хүлээнэ. Людвинийг хэн түрүүлж харсан маань ирсэн улстай хамт зэрэгцэн очоод түүнтэй танил гэдгээ мэдэгдэхгүй байна. нөгөө маань хоёр гурван минут хүлээгээд хойноос дагаж мөрдөж байна уу, үгүй юу гэдгийг ажиглана. Галт тэрэгний буудлаас гармагц Людвинатай түрүүлж уулзсан нэг маань Парисын гудамж, Усан үзмийн гудамж хоёрын булан дээр түүнд усны мухлагийн дэргэд зогсох дохио өгнө. Ажиглаж үлдсэн хүн маань хажуугаар нь явж өнгөрнө. Мөрдөж дагаж байгаа хүн байхгүй гэж баттай мэдсэний дараа бусадтайгаа нийлнэ. Сэжигтэй юм харагдвал цаашаа яваад өнгөрнө. Мэдэв үү? — Мэдлээ. Людвинатай хамт мухлагийн дэргэд ус уух хүн юу хийхийг ойлгосонгүй. — Аюул тулгарвал эргэж харалгүйгээр цаашаа яваад өгнө гээд Людвинийн төлөө дахин санаа зовох явдалгүй. Ойр хавьд нь зохих заавар авсан хүмүүс жижүүрлэж байх юм. Галт тэрэг ирэхээс арван минутын өмнө галт тэрэгний буудал дээр очно. — Эртдэнэ. Арван зургаа арван есөд очоорой. Чамайг тавцан дээр байхыг хүн харвал дэмий. Галт тэрэгний буудал дээр зурагт сэтгүүл худалдаж авахаар ирсэн юм шиг байдал гаргаарай. За одоо сарвуугаа аль. Ёстой янаг сэтгэлтэн шиг салах ёс гүйцэтгээд би явж үзье ... гэж Франсуа хэлээд бүсгүйн гарыг удтал атгаж, нүдийг нь ширтэж байгаад эцэст нь «Анхны бүжиг минийх шүү» гэж босгон дээрээс хашгирч, дугуй малгайгаа даллаж, үнэндээ инээмээргүй байсан боловч инээмсэглэв. Генрихт «үеэл эгч» гэж хэлсэн Людвина Декокийн ирэх болсонд Моника маш их сэтгэл түгшгээ. Бонвиллоос гарах, тйишээ очих хүн болгонд гестапо нэвтрэх бичиг олгодог журам тогтоогоод байгаа одоо үед гэнэт тийнхүү ирэх болсон нь ямар учиртай юм бол? Людвина бусад бүх зорчигчдын нэгэн адил, эргэн тойрон цэргээр хүрээлэгдсэн гал тэрэгний буудлын талбай дээр гестапогийнхан бичиг баримт шалгахыг хүлээж хэдэн цаг зогсоход хүрэх биз. тэр шалгалт Людвинад юу болж дуусахыг хэн мэдэх билээ! Түүнийг нааш нь явуулсан хүмүүс даалгавар нь ямар чухал байсан болохоор ийм осолтой хэрэг хийсэн биз. Ер нь гуравхан хоногийн өмнө Моника Людвинад захиа явуулсан шүү дээ. Хөндлөнгийн хүн үзвэл огт гэм зэмгүй, гэр орныхоо ажилд шигдсэн хоёр бэртэгчин эмэгтэйн ерийн нэг харилцаа билээ. Моника бичихдээ Сен-Ремид урьд цас ордоггүй байсан бол байн байн

цас орж байна, хүйтэн жихүүн салхи үлээж байна, хүнсний зүйл маш бэрхшээлтэ, юмны үнэ дахиад их нэмэгдлээ гэж бичсэн юм. Энэ захиаг уншаад: Сен-Ремид хүмүүсийг баривчлах явдал бараг үзэгдэхгүй байснаа одоо олшров, партизанууд идэвхтэй боллоо. Одоо Сен-Ремид ирэх нь осолтой гэж ойлгох ёстой байжээ. Ингэж сануулсаар байтал Людвинаг нааш нь явуулсан байна. тэгэхлээр тун чухал ажлаар ирж байгаа нь эргэлзээгүй! Ер нь одоо үйл явдал өдөр бүр санамсаргүй хэрэг гарахад бэлэн байвал зохих тийм зүгтээ эргэж байна. Оросууд Германы армийг Сталинградын дэргэд бүсэлсэн тэр цагаас хойш Моника ээжтэйгээ хоёул өглөө, орой болгон радио чагнадаг болжээ. Өглөө нь германы командлалын мэдээ чагнаж, хэрэв хэрэгтэй долгионыг барьж амжвал Лондоноос франц хэлээр явуулдаг нэвтрүүлгийг чагнадаг байлаа. Моникад ч тэр, түүний эх Тарваль авгайд ч тэр одоо хүртэл Зөвлөлт Холбоот Улс бол зөвхөн огт тодорхойгүйгээр үл барам огт учир ойлгогдохгүй орон байлаа. Хоёр эмэгтэй хоорондоо «Тэндэхийн юм болгон манай эндэхтэй адилгүй юм» гэж ярилцдаг байжээ. Ялгаа нь чухам юунд байна вэ гэдгийг эд нар мэдэхгүй, мэдэхийг ч хичээдэггүй байжээ. Тэр учир битүүлэг орос орон үл мэдэгдэх алс тэртээгээс гэнэт ойртох болов. Тэгсээр сүүлдээ Моникагийн зүрх сэтгэлд францтай нь бараг адил ойр дотно болжээ. Моника өөрийгөө оросуудад өртэй хүн гэж үзэх болж, тэр өөрөө өөрт байгаа ганц эрдэнэсийн сангаар төлдөг байсан нь: шударга ёсны төлөө тэмцэгчдийн тэр аугаа их армийн санаа сэтгэлийн ялагдашгүй их хүчийг бахархан биширч, өөрөө түүнтэй нийлэн нэгдэхийг чин сэтгэлийн угаас хүсдэг байлаа. Алс холын орос орны нутагт болж байгаа тулалдааны тухай өгүүлсэн сонины мөр бүрийг бүсгүй анхааран уншина. Моника үгийн дотроос үг олж уншихыг Франсуагаас сураад хэрэв германы цэргийн анги аль нэг сууриныг хамгаалан маш баатарлагаар тулалдаж байна гэж бичсэн байвал энэ нь нэг бол оросууд тэр газрыг чөлөөлсөн, эсвэл наанадаж бүсэлсэн гэсэн үг гэдгийг ойлгож, урьдаас бэлтгэсэн байрлал тийш төлөвлөгөөтэй ухарч байгаа тухай мэдээлсэн байвал энэ нь гитлерчүүд хамаг юмаа орхиод ухаан жолоогүй зугтсан гэсэн үг гэдгийг ойлгох болжээ.

Моника сонин уншаад энэ Сен-Ремид Оросын тухай сайн мэдэхийн тулд олж авсан ганц ном нь тусгай тавиастай байдаг номын тавиурын булан өөд талархан ширтэнэ. Хичнээн бага мөртлөө хичнээн ихийг багтаагаа вэ? Энэ бол Толстойн тухай Ромен Ролланы бичсэн жижигхэн ном байлаа ... Энэ жижиг номыг нэг удаа Андре ах нь эднийд мартаад явснаас хойш улаан хугацааны турш хэн ч уншсангүй. Моника хуучин муусайн новш дундаас нэг юм эрж байтал энэ ном дайралдахад нь үнэт эрдэнэ олсон мэт нандигнан тасалгаандаа авчраад шөнөжин уншихдаа ганц хүний сэтгэлээр бүхэл бүтэн ард түмний сэтгэлийг таних гэж хичээн оролджээ. Ромен Ролланы бичсэнийг ойлгох нь бүсгүйд хичнээн хэцүү байсан гэх вэ! Бүсгүй өөрөө Толстойн зохиолын нэг ч мөрийг уншаагүй болохоор уран бүтээлчийн суу залиг биширсэн юм уу, эсвэл насан турш сэтгэл санааны хүнд тэмцэл хийж үнэнийг эрсэн хүний сүр жавхланг биширсэн юм уу, чухам юуг ингэж бишрээд байгаа нь үл ойлгогдох өөрийн эх орон нэгтэй их хүний бодол санааг даган сохор таамгаар явахад хүрч байлаа. Толстой яагаад нүглийг эсэргүүцэж болохгүй гэж бичдэг байна? Нүглийг эсэргүүцэх хэрэгтэй, эс

тэгвэл тэр нүгэлд дарагдана гэдгийг Моника өөрөө сайн мэдэх билээ. Юу гэвэл нүгэлт үйлсэд их буу, бөмбөг, автомат, хорих лагерь, хүчирхийлэл, хар муу санаа, хүнийг үл тоомсорлох хэрцгий байдал зэрэг зэвсэг бүхэн бий ... Тэгэхлээр их хүмүүс бас энддэг байхнээ! Тэгвэл Альпийн нурууны өвөр салаанд орогносон бацхан хотын жирийн нэг эмэгтэй юу чадах юм бэ. Бас тэр үл мэдэх орос хүний тухай уншихдаа зүрх нь хүчтэй цохилдгийн учир юу вэ? Түүний ард түмэн ч гэсэн эсэргүүцэхгүй байхыг зөвшөөрсөнгүй, дарлагчаа эсэргүүцэн босож, тэднийг авч хаяад одоо аж амьдралаа үнэн мөнөөр хамгаалахын тулд гартаа зэвсэг барин босоод байна шүү дээ. Моника заримдаа тэр номын Толстойн хөрөгтэй хуудсыг нээгээд зохиолчийн царайг анхааралтай ширтэн харна. Толстойн өөрийгөө харсан, бас Моникагийн нүд өөд эгцлэн харсан энэ хачин харц чухам юу шаардаад байгаа юм бол? Моникагийн зүрхэнд түгшүүр төрүүлсэн ширүүн, хурц, нэвтэрхий шаардангуй харц байна. Энэ хүн амьдралдаа учирсан хүн бүхэнд ингэж нөлөөлдөг байсан байх. Үнэн мөнийг шаардаж, хэрэв үнэн мөнд хүрэх замыг сонгохдоо эндсэн байвал хүмүүсийг эрэл хийж, үнэнийг олохыг уриалдаг байсан биз! Бодвол, үнэнийг олох ийм халуун хүсэл орос хүн бүхэнд байдаг юм болов уу? Чухам энэ л оросуудыг тэмцэлд ийм ялагдашгүй болгосон юм болов уу? Тэгвэл бас ийм халуун хүсэл Моникагийн өөрийн нь зүрхэнд оршиж удаан цагийн турш сэтгэлийг нь шаналгасаар байгаа бус уу? Урьд Моникад юм болгон хичнээн тодорхой, энгийн хялбар байгаа вэ? Аз завшаанаар Франц шиг үзэсгэлэнтэй сайхан оронд төрөөд үүнд нь хувь заяандаа баярлаж, өөрийн ард түмэн, эх орон юугаан хязгааргүй хайрладаг байлаа ... Ард түмэн нь ч гэсэн, Франц орон нь ч гэсэн бүсгүйд гүйцэд ойлгоё гэхэд даанч өргөн дэлгэр ухагдахуун байжээ. Бүсгүй Франц орныхоо талаар Оросынхоос төдий л илүүгүй мэддэгээ ойлгоод хичнээн гайхсан билээ. Францчуудын тухай ч тэр, Леваль, эх орноо худалдсан Вишийн засгийн газар, шударга хүмүүсийг мэдүүлж, дайсны өмнө хүчин зүтгэдэг Левек мэтийн бузар этгээдүүд байдаг байхад бас Франсуа, Андре ах, Жан мэтийн Гитлер, гитлерчүүдийг дагаагүй, дайсантай тулалдах гэж ууланд гарсан олон зуун мянган хүн байна. Ингэхлээр Францчуудын хоёр лагерь, хоёр Франц байдаг байх нь ээ? Хоёроор тогтохгүй, олон янзын Франц байдаг юм уу? Яагаад чухамхүү эх орноосоо хамгийн бага хишиг хүртсэн хүмүүс нь партизан болов? Эд нар усан үзэм тариалж, ууланд мал хариулж, дархны газар ажиллаж, уулын бэлээр зам тавьж байсан чухам тэр хүмүүс шүү дээ. Тэдний хөдөлмөрийг мөлжин баяжиж байсан этгээдүүд одоо болоход хулгана шиг нүхэнд орж нуугдаад ойр хавьд хүн байхгүй бол эх оронч үзэлтэй, Францад хайртай гэж чалчиж байна. За, гитлерчүүдийг хөөгөөд зайлуулчихлаа гэж бодъё ... Тэгэхлээр яах вэ? Малчид мал сүрэг дээрээ, өрлөгчид барилга дээрээ, усан үзэмчид усан үзмийн тариаландаа эргэн очиж, ажилчид дахиад л суурь машин дээрээ очиж зогсоно. Энэ хулганууд, нүхнээсээ гарч ирээд ард түмний биеийг мэрг, шинэ дэлгүүр, завод нээж, сүүлийн үеийн ганган хийцтэй машин худалдаж аваад ханхалзаж байх хэрэг үү? Энэ хотод тарган цатгалан, шилэмхий голомхой амрагчид дахин ирнэ. Тэгээд Моникагийн төрсөн үзэсгэлэнт сайхан Францад юм бүгд урьдын байдлаар болно. Үзэсгэлэнт сайхан ... үнэндээ тийм гэж бат итгэж байна уу даа.

Аяа гэнэн балчир насны харгайгаар юм мэдэхгүй эрх дураараа байснаа гэнэт

унтсанаас сэргэж, үхсэнээс сэхэх мэт ухаан орж энэ дэлхийн юм бүхнийг өөр янзаар үзэх болсон нь Моника чамд хичнээн зовуурьтай вэ? Ядаж зөвлөж хэлмээр хүн алга! Франсуатай зөвлөдөг хэрэг үү? Франсуад залуу бүсгүйн тэнэг толгойг цэгцэлж өгөх зав байгаа юм уу? Сурсан зангаараа тоглоом хийгээд л өнгөрнө биз ... Хэдий тийм боловч Моника Франсуад хэлээд үзэхээр шийджээ. Гайхалтай нь Франсуа энэ удаа тоглоом наадмаар өнгөрүүлэхийг оролдсонгүй. Энэ завсар хэрэг явдал улам өрнөж, алс тэнгэрийн хаяанд түгшүүрт урт шөнийн дараа нарлаг сайхан өдөр болохыг зөгнөсөн зурвас ягаан туяа татах шиг Моникад санагдав. Людвина чухам маш чухал сайхан мэдээ авчирч яваа юм болов уу? Бүх партизаныг удирдаж байгаа хүмүүс л Людвинаг нааш нь явуулсан байх ёстой. Франсуа энэ тухай Моникад яриагүй л дээ. Моника нялх хүүхэд биш болохоор өөрөө гадарлаж байлаа. Моника «үеэл эгчдээ» галт тэрэгний дугаар, Бонвиллоос хөдлөх цагийг хэлчихтэй зараг л тэр цувааг онхолдуулсан байсан. Людвина уг мэдээг нэн даруй зохих хүмүүст мэдүүлсэн байж таарна. Одоо чухал заавар авчирч яваа биз. Франсуа хэргийн учир тухайг лав мэдэж байгаа боловч Моникаг хүүхэд гэж бодоод байгаа юм. Моника өөрийгөө ямар нэг чухал ажиллагаанд аваад яваач гэж хичнээн олон гуйсан боловч Франсуа зөвхөн инээмсэглээд Моникаг ер санаснаас их юм хийлээ гэж хариулдаг байжээ. Франсуа бас Генрихт ч гэсэн урьдынхаас өөрөөр хандах болж, болгоомжтой байх хэрэгтэй гэж хэлдгээ болиод нэг удаа германчуудын дотор фашизмыг эсэргүүцэгчид байдаг гэж шууд хэлсэн юм. Үгүй, одоо Генрихийн тухай бодох ч хэрэггүй, Людвина ямар даалгавартай ирж байгааг ч бодох хэрэггүй, бүх юмыг эвтэйхэн аргалахыг хичээх хэрэгтэй. Галт тэрэгний дохио дуугарч байна. Галт тэрэг ирэх үеэр буудал дээр бэлэн байхын тул хурдхан явах хэрэгтэй боллоо. Моника тавцан дээр гарч ирээд түүгээр холхиж байгаа гестапогийнхыг үл анхааран гол хаалганы зүүнтээ байдаг номын худалдааны мухлагийн дэргэд очиж, сонин худалдаж аваад сүүлийн хуудсан дээр нь хаврын улирлын ганган хуьцасны маяг загвар хэвлэгдсэн зурагт сэтгүүлийг анхааралтай үзэж зогсов. Галт тэрэг хүрч ирээд зогслоо. Моника галт тэрэгнээс бууж байгаа авгай хүүхэн болгоны өмссөн зүүснийг хөлөөс толгой хүртэл эмэгтэй хүний сониуч зангаар шохоорхон ажиглаж байгаа байдал үзүүлэв. Людвина аль вагонд байгаа юм бол доо? Аа тэр цаана царай нь зэрвэсхэн харагдаад өнгөрлөө. Людвина тэр гараад ирлээ. Дэгжин хийцтэй цайвар өнгийн сэгсгэр пальто өмссөн байх бөгөөд бяцхан хар малгай нь алтлаг өнгийн үсийг үзэсгэлэнтэй сайхан хүрээлэл өнгө хосолжээ. Ганган хатагтай байна. Хэний ч толгойд тийм бодол төрөхгүй ... Ай та минь, энэ чинь юу вэ? Моника дэлгэж барьсан сэтгүүлээр нүүрээ таглаад түүнийхээ дээгүүр Людвинаг харлаа.

Тийм байна ... Гестапогийн нэг хүн баруун гар талд нь нөгөө нь зүүн талд нь, гурав дахь нь ард нь явна. Людвина баривчлагджээ! Үүнийг Франсуа харсан болов уу? Харсан бол яагаад туслахаар ухасхийхгүй байна вэ? Моника урагшаа нэг алхаснаа сэрэмжлэн сануулсан ширүүн харцтай тулгарав. Людвина Гестапогийнхнаар мануулан албаны нэг хаалгаар далд орлоо. Баривчлагдсан Людвинаг дэргэдүүрээ өнгөрөхөд Моника дуу алдалгүй, хөдлөлгүй биеэ барьж чадсан боловч нүд нь эрээлжлээд ирэхэд хөсөр унахгүйн тулд номын худалдааны мухлагийн хананд наалдан налав. — Гэртээ харь. Битгий

тэнэглээрэй гэж Франсуа ууртай шивэгнэх нь тэртээ холоос дуулдах шиг боллоо. Моника яаралгүй эргэж алхав. Зочид буудлын дэргэд Франсуа гүйцэж очоод: — Би арын хаалгаар орно гэж явуут хэлчихээд хашааны хаалгаар далд орлоо. Энэ болсон хэрэг явдал Моникад аймшигт зүүд шиг санагдана. Одоо өөрийн бяцхан цайз болсон тасалгаандаа орохлоор хар дарсан зүүд замхран алга болно гэж горьдов. Үгүй, үнэн юм байж. Сандал дээр царай нь зэвхий дааж, барайсан Франсуа сууж байна. — Франсуа! Бид Людвинаг аварч чадахгүй юм уу? Бид олуул шүү дээ. Гестапог дайраад Людвинаг салгаж авахсан! гэж бүсгүй өөрийн эрхгүй дуу алдсанд Франсуа гашуудалтай мушийн инээмсэглээд — Би чамд сануулах гэж л чам дээр ирсэн юм. Болгоомжгүй хөдөлж, авирлаж яасан ч болохгүй! Людвинаг баривчилсан нь санамсаргүй тохиолдол байж болох юм. Гэхдээ дайсан этгээд ул мөр шинжиж олсон ч байж болзошгүй. Ямар юм болсон ч бэлхэн байх хэрэгтэй. Бичиг цаас, юм хумаа бүгдий нь сайн шалга. Өчүүхэн жижиг зүйл ч гэсэн маш ноцтой уршиг балаг тарьж магадгүй гэдгийг санаарай. Бонвиль орсон билетээ устгасан уу? Цүнхэн доторхио гаргаад дахин шалгаарай. Чи намайг яаж олохоо мэднэ биз. Цаашид жижиг барааны мухлагийн даамлаар дамжуулан холбоо барих болно. Намайг бас баривчилвал тэр хүн цаашид юу хийхийг мэднэ. Би түүнд заавар үлдээнэ. Чамд хоёр зүйлийг тулгаж болох юм. Нэгд Бонвиль орсон хэрэг, хоёрт надтай уулздаг хэрэг. Надтай уулздаг ч яах вэ, би чиний болзоот хархүү гэж яваа болохоор зүйн доторхи хэрэг. Бонвиль орсон тухайд гэвэл ... саналаа. Чи бас миний нэрийг бариарай. Намайг их жөтөөч болохоор Гольдрингтой хоёулхнаа цаг өнгөрүүлэх гэж Бонвиль орсон юм гэж хэлнэ биз. Гольдринг ч үүнийг батлах байх. Ер нь өнгөцхөн харахад тийм байсан шүү дээ. Гольдринг журамтай сайн хүн шиг санагдаад бйана. Юуны өмнө сэтгэл тайван байх хэрэгтэй. Одоо унтаж амар. Энэ болсон хэрэг явдлыг март. — Тэднүүс Людвинаг тамлаж орхино шүү дээ. — Тэднүүс Людвинаг, намайг, чамайг, хэнийг ч гэсэн тамлаж магадгүй. Гэхдээ бид бүгдийг алж барахгүй. Бид ер нь юу хийж байгаагаа мэдэж байгаа улс шүү дээ, тийм үү, жаал минь? За энэ ч яах вэ, юмыг яаж мэдэх вэ гэж хэлж байгаа юм. Юс бүхэн урагштай бүтэмжтэй болно гэж итгэж байна. Тэгээд чиний хурим дээр бүжиглэмз гэхэд нь Моника Франсуаг тэвэрч, шов хийтэл үнсээд — Би бас юмыг яаж мэдэх вэ гэж ингэж байгаа юм. Миний төлөө чиний хийсэн бүхнийг бодоод. Бас ... надад найдаж болно гэдгийг чи мэдэж байгаасай гэж хүсэн юм! гэсэнд, — Мэднэ ... гээд Франсуагийн хоолой чичирлээ. Моника ганцаар үлдэж, сэтгэлээр унаж Людвинагийн царай, дэгжин хийцтэй цайвар польтотой гоолиг бие, дэргэд нь явсан гестапогийнхны аймар дүр нүдний нь өмнө бүрэлзэн үзэгдээд байлаа. Людвинаг аварч болохгүй юм гэж үү? Яргачдын гарт тэгээд амь үрэгдэх юм гэж үү? Моникагийн хамаг бие нь хүйт дааж, арзасхийв. Үгүй, ингээд зүгээр суугаад байж болохгүй, хөдлөх хэрэгтэй. Юуны өмнө бүх захидлаа устгаж, гэрэл зурагнуудаа дахин үзэж, цүнхтэй юмаа шалгах хэрэгтэй. За тэр дээ. Бонвилоос худалдаж авсан эвэр хавчаар нь тэндхийн дэлгүүрийн тэмдэгтэй цаасанд боодолтой байна. Аар саар юм ч гэсэн ноцтой төвөг удаж болно гэж Франсуагийн хэлсэн нь зөв юм. Бонвиль орсон билетээ устгачихсан. Үгүй, ер нь түүнийг нуухын хэрэг юу байна? Галт тэргэн дотор явахыг хүн харсан байж таарна. Харин хаана буусан бэ? гэж асуувал юу гэж хэлэх вэ? Генрихийн тасалгаанд гэж хэлье. Зочид буудлын хаалгач нь Моникаг их сүрхий харж байсан, бодвол нүдэлж авсан биз. Түүнийг гэрч татахад болох юм. «Үеэл эгчтэй» хамт

явсныг маань харснаа битгий хэлээрэй гэж Генрихт хэлэх юм байна. Чухам ямар учир явдалтайг хэлэлгүй, зүгээр л үеэл эгчийг над ирж явахад нь баривчилсан байна, энэ нэг эндүүрэл болсон бололтой гэж хэлье ... Ер нь Генрихийг Миллерээс Людвинагийн тухай асуугаад өгөөч гэж гуйвал яасан юм бэ? би садныхаа хүний төлөө сэтгэл зовж байгаа нь зүйн доторхи хэрэг шүү дээ ... Моника ингэж бодоод үүдний өрөөнд нисэх мэт бууснаа Генрихийн тасалгаа байдаг байшингийн тэр жигүүрийн хоёрдугаар давхарт гарч, өчүүхэн ч эргэлзэлгүй хаалгыг нь тогшлоо.

— Моника та яагаа вэ? Таны царай гэж царай биш болоод гар чинь мөс шиг хүйтэн байна гэж Генрих асуув. Бүсгүйн иймэрхүү байдалтай байхыг үзээд Генрихийн царай бас хувьсхийлээ. Моника хариу дуугаралгүй сандал дээр уналаа. Генрих халуун гараараа бүсгүйн хүйтэн хуруунуудыг атгана. Генрихийн чийрэг гар найдвартай түшиг шиг санагдана. Генрихт итгэж хамаг үнэнээ хэлье. Людвинаг аврахад тус болох биз! гэж Моника шийдлээ. — Генрих ээ! Миний одоо танд хэлэх гэж байгаа зүйлийг би уг нь хэлэх эрхгүй л байх. Би бүүр арга тасраад байна. Бонвильд надтай хамт явж байсан нөгөө үеэл эгчийг минь эндэхийн галт тэрэгний буудал дээр баривчилчихаж. Үеэл эгч наашаа манай руу ... над дээр ирж явсан юм. Намайг ч гэсэн хэзээ хэзээгүй баривчилж мэднэ. Яагаад тэр вэ? гэж битгий асуугаарай. Миний хувийн нууц байсан бол танд итгэхсэн. Гэвч би юу ч хэлж болохгүй байна. Одоо яах вэ? Та тус болж чадах юм биш үү? гэсэнд Генрих бүсгүйн гарыг өвдтөл чанга атгасанд бүсгүй дуу алдах дөхлөө. — Моника, танаас юу ч асууж лавлахгүй, чадах бүхнээ хийе. Энэ хэрэгт баримжаа олоход минь туслах нэг зүйл асууна. Ингэхэд ... Гестапо таныг ямар хэрэгт сэжиглэж болох байна? гэж Генрих асуусанд, — Миний явсныг мэдсэн бол Бонвиль орж, үеэл эгчтэй уулзсаныг минь сэжиглэнэ гэхэд нь, — Бонвиль орсныг чинь гестапо мэдэж байгаа. Таныг надтай уулзахаар очсон гэж Миллерт хэлсэн, үнэмших шиг болно билээ. Миний ингэж хэлснийг уучлах биз. Миллер, таны явсныг партизанууд зэвсэг ачсан галт тэргийг довтолсонтой холбож үзсэн болохоор би аргагүй ... гэсэнд Млникагийн царай час улайгаад: — Таныг ойлгож байна. Баярлалаа, Генрих ээ! Хэрэг гарвал би тан дээр буусан гэж хэлж болох уу? — Бололгүй яах вэ. харин Куртийг Фельднертэй ярилцсан зүйлээ надад хэлж байхад та өрөөнд байгаагүй гэх юм шүү. Ойлгоо биз дээ ... За одоо үеэл эгчийн тухайд гэвэл ... Таны нэрд юугаараа харштай юм бэ? — Над дээр ирэх гэж явсан ганц энэ зүйл л ... — За ойлголоо ... Таны үеэл эгчийг хэн гэдэг вэ? — Наашаа ямар нэртэй ирснийг нь мэдэхгүй байна ... гээд Моника хэсэг зуур эргэлзэж байснаа, — Генрих танд итгэе. Түүний ёстой нэр нь Людвина Декок гэдэг. Өөр нэр хэлсэн байвал та саяын миний хэлсэн нэрийг мартаж ёстой. — Би зочид буудлын эзэгтэйд талархалтай учир төрөл садны нь хувь заяаг сонирхож байна гэсэн шалтаг зааж болох уу? — Болохгүй, Людвина манай төрөл садан биш. — Энэ чинь хэргийг төвөгтэй болгож байна даа. Гэсэн ч би мэдэхийг хичээе. Мэдэж чадна гэж сайн итгэхгүй байна. — Ээ тэнгэр минь, түүнийг аврах өчүүхэн ч найдлагагүй тэгээд өнгөрөх хэрэг үү? Ганц надад хамаатай хэрэгсэн бол би гестапод очоод шаардаж шалахсан ... гэж Моникаг гаслахад нь: — Моника та тэгж болохгүй. Хоёул ингэж болзоё. Та гэртээ очоод хүлээж бай. Гадагшаа бүү гар. Зоогийн танхимд ч орсны хэрэггүй. Людвина Декок хэр зэрэг хүнд

ял тулгаж байгааг мэдэхийг оролдоод үзье. Тэгээд танд нэн даруй хэл өгнө. Тэвчиж байгаарай. Би Миллертэй ямар боловч ойр дотно нөхцөл байдалд уулзах хэрэгтэй. Үүнийг оройноос нааш хийх аргагүй. Ингэж тохирох шив дээ? гэсэнд Моника зөвшөөрснөө мэдэгдэж толгой дохиод ялимгүй ширүүвтэр бяцхан гараа сарвайхад нь Генрих тонгойж, гарт нь хацраа наагаад: — Таны энэ хөөрхөн хуруунуудыг чичрэхгүй байлгахын тулд болох, болохгүй юм бүхнийг хийнэ гэлээ.

Моникаг гарсны дараа Генрих Куртыг дуудаж, Тарваль авгайд зургаан шил шарз, бас нимбэг, чихэр захиж аваад энэ бүгдийг машинд аваачиж тавихыг тушаав. — Хаашаа явах вэ, эрхэм ахлах дэслэгч ээ? гэж Курт асуухад, — Би ганцаараа явна. Одоо жаахан дуг хийж амарья. Миний бие базаахгүй байна. Ер бишийн онцгой хэрэг явдал гарахгүй бол найм хүртэл битгий сэрээгээрэй. Намайг явснаас хойш хуарандаа очиж болно. Би шөнө орой эргэж ирнэ гэсэнд — Ёсоор гүйцэтгэе! гэлээ Генрих орой тийшээ толгой сэргэх биз гэж бодоод унтахаар хэвтсэн боловч унтаж чадсангүй. Моникагийн төлөө сэтгэл зовж, элдвийн эргэлзэл төрөөд нойр нь хулжжээ. «Би энэ ажилд оролцох эрхтэй бил үү?» гэж өөрөө өөрөөсөө дахин дахин асууна. Бонвильд тэсрэлт хийснээс хойш Гольдрингт өөрийгөө аюул осолд оруулж болохгүй гэж сануулсан байжээ. Тэгэхлээр одоо тушаалыг зөрчих болж байна уу даа? Гэтэл зөвхөн тушаалд хамаг учир байгаа юм гэж үү? Генрих илрэхгүй хичнээн удаж чадвал эх орныхоо төлөө өөр ямар нэг хүнээс илүү их юм хийж өгнө гэдгийг өөрөө ч сайн мэдэж байна. Юу вэ гэвэл барон Фон Гольдрингт бүрэн итгэж байгаа шүү дээ. Тун аргагүй үед л осолтой юм хийж болно. Гэвч шударга хүмүүсийн толгой дээрээс аюул нөмөрч байгааг дуугүй ажиглаад суултай биш дээ! Хэрэв Людвина Декок тэсч чадалгүй, Моника дээр ирж чвсан үнэнээ хэлчихвэл ... Миллерийн нэгэнт хардаж сэжиглэх болоод байгаа Моника дээр шүү ... Моникаг гестапогийнхнысаварт орж болно гэж бодохоос Генрихийн хамаг бие хүйт оргино. Үгүй, хэрхэвч тэгүүлж болохгүй. Ер нь Генрих өөрөө бүсгүйг энэ гогцоонд татан оруулсан шүү дээ. Тэр зэвсэг ачсан галт тэрэгний тухай дурсаагүй бол Моника Бонвиль орохгүй, үеэл эгчтэйгээ уулзана гэхгүй, өдийд юм бүгд сайхан байх байсан. Гэсэн ч зэвсгийг зохих газар хүргэхгүйсэн гэж Генрих хүссэн юм. Тэгээд ганц Моникагаар дамжуулан партизануудад мэдээ өгүүлж болох байлаа. Нэгэнт тийм болохоор ... Генрих орноосоо босон харайв. Энэ тухай яагаад даруй санасангүй вэ? Галт тэрэгний тухай Моникагийн мэдэж болох ганц уг сурвалж нь Генрих фон Гольдринг шүү дээ? Моникаг баривчлагдсаны дараахан Генрих өөрөө албан ёсоор өчиг мэдүүлэг өгөх хэрэгтэй болно. Тэгэхээр өөрт нь итгэхээ больж, алхах гишгэх бүрийг нь анхааралтай ажигладаг болно. Тэгвэл тагнуулчийн хувьд нурж унах нь гарцаагүй. Генрих өөрт нь ч бас аюул заналхийлж байгааг мэдээд энэ насандаа анх удаа баярласан нь энэ байж болох юм. Ингээд Генрих өөрөө хожигдоогүй дээр энэ хэрэгт оролцож, Людвина Декокийг аврах хэрэгтэй боллоо. Яг найман цагт Куртыг хаалга тогшиход Генрих дайллагад очих гэж байгаа юм шиг бүрэн дүрэмт хувцастай зогсож байжээ. Шилтэй шарзыг машин дотор оруулж тавьсныг шалгаад жолооны ард сууж, хэдэн минутын дараа Миллерийн аргааний хашаан дотор орлоо. Манааныхан ахлах дэслэгч Гольдрингийг энд өөрийн хүн гэж сайн мэдэх тул нэвтрэх бичгийг ч шалгалгүйгээр машиныг дотогш оруулав.

Миллер албан тасалгаандаа ганцаар биш, түүний өөдөөс хараад дэслэгчийн дүрэмт хувцастай залуу сайхан офицер сууж байв.

— Генрих ээ! Энэ миний орлогч дэслэгч Заугельтэй танилцагтун. Амраад ирсэн юм. Би танд ярьж байсан хүн гэж Миллерийн хэлэхэд, — Их магтаж ярьсныг хэлэх хэрэгтэй. Эрхэм Заугель тантай одоо болтол уулзаж чадаагүйдээ харамсаж байна гэж Генрих өгүүлэв. Дэслэгчийн булбарай ягаан хацар хүүхэн хүнийх шиг час улайв. Мушгирсан алтлаг өнгийн үстэй, том цэнхэр нүдтэй, хүүхдэрхүү зузаан уруултай тэр дэслэгч ерөөс хүүхэн хүний царайтай ажээ. Гагцхүү дэслэгчийн дэндүү урт шувтан эрүү нь ерөнхий нийц зохицлыг алдагдуулж, царай нь цэвэрхэн мөртлөө нүдэнд хүйтэн харагдана. Миллер сэтгэл хангалттай тамшаалаад: — Эрхэм хүндэт зочин ямар азтай сайхан тохиолоор манай энд ирэв? Үгүй, нээрээ танд манай үүгээр шагайх азтай сайхан бодол яаж төрөв? гэхэд нь — Би найз нартайгаа өдөр болгон юм уу, ядахдаа өнжөөд уулзаж сурсан юм. Тантай хоолон дээр дайралдаагүй өнөөдөр гурав дахь өдөр нь болж байна. Ингэхлээр миний ирсэн нь ганцхан таны зүгээс өчүүхэн намайг анхаарахаа больсноор тайлбарлагдана гэсэнд, — Ай барон минь, намайг битгий гомдоогтун! Миний танд ямар байдгийг та эс мэдэх биш. Одоо даанч ажил ихтэй байна! Ядаж босож хөдлөх чөлөөгүй, хамаг бие хөшиж орхилоо гэхэд нь Генрих илт урам хугарсан царай гаргаж: — Энэ чинь намайг таны ажилд саад болж байна гэсэн үг шив дээ! Уг нь хамт сууж, жаахан дэмий ярьж гэж бодоод хэлэн шил шарз аваад ирсэн юмсан гэсэнд, — Ай баорн минь, саад болсон бол би шулуухан хэлэлгүй яах вэ? Бид чинь найз улс шүү дээ. Найз улс бие биетэйгээ ёсорхоод байх юу байх вэ. Эрхэм Заугель та хаалга түгжээд намайг битгий үймүүл гэж тушаана уу. Тэр ид шидтэй шилтэй юмнууд чинь хаана байна? гэсэнд, — Машин дотор байгаа. Боодолтой нимбэг, чихэртэй нь хамт нааш нь аваад ир гэж тушаана уу ... гэсэнд, — Яасан хашир хүн бэ! Одоо туслахдаа тушаая ... үгүй, эвгүй юм уу даа. Эрхэм Заугель та албан ажлын хувиар биш, анд найзын хувиар тэр юмнуудыг миний өрөөнд аваад ирнэ үү. Тэр хооронд би бэлтгэж байя. Генрих ээ, ийшээ ороорой гээд Миллер хамар өрөөний үүдийг нээлээ. Миллерийг гестапод саатаж үлдэхэд энэ өрөө нь унтлагын өрөө, хоолны газар болж өгдөг байжээ. Тэнд өргөн буйдангаас гадна жижиг ширээ, эрэгнэг тавьсан байлаа. Миллер ширээн дээр хундага, таваг өрөх зуур: — Зарц цэргээр үйлчлүүлэлгүй больё. Ингэвэл илүү найртай гэхэд нь, хөндлөнгийн хүн байхгүй бол бүүр сайн. Өнөөдөр би ч гэсэн согттол уумаар байна. чоно болж ульсан ч болмоор сэтгэл хачин байна гэсэнд, — Хэлээд яах вэ, хөгжилтэй юм бага байна ... гэхэд нь, — Биднийг зугаа цэнгэлийн юм юу ч байхгүй ийм бөглүү газар явуулах гэж дээ гэж Генрих гомдол гаргасанд Миллер цаанаа учиртай жуумалзаад: — Мадмаузель Моника яагаа вэ? Уйдаа юу гэхэд нь: — Харин уйдаа амжил болоогүй байна. Тэр чинь аливаа журамтай бүсгүйчүүлийн адил бидний харилцааг бидний санаснаас хавьгүй илүү буйртай үзэх юм. Түүнтэй урьдаар санаа алдаж барих тийм оршилгүйгээр хэрэг бүтэхгүй. Би илэрхий наана цаана нь орж олны анхаарлыг татахыг хүсэхгүй байна. надад болзоот хүүхэн бийг та мэдэх ч магадгүй. Түүнтэйгээ удахгүй бөгж солилцож сүй тавина гэж Генрих ярив.

Заугель орж ирээд ширээн дээр шилтэй архи тавилаа. Миллер сэтгэл хангалттай тамшаалаад: — За тэгвэл эхний хундагыг таны болзоот хүүхний төлөө өргөө. Генрих ээ! Бароны хатан болох тэр хүүхэн чинь хэн бэ? гэхэд, — Лора Бертгольд! гэсэнд, — Хошууч генерал Бертгольдын охин уу? Сайхан хос байна! гэж Заугель хэлэхдээ өөрөө л Бертгольдын охинтой бөгж солилцох болсон юм шиг цэнхэр нүд нь баясгалантай гялалзлаа. Миллер ихэд хүндэтгэсэн төлөв төвшин байдлаар Генрихт баяр хүргээд: — Бароны хатан болох Лорхен Фон Гольдрингийн эрүүл мэндийн төлөө! гэж хундага өргөв. Гурвуулаа нэгэн зэрэг уулаа. Генрих тэр даруй дахин нэг нэг хундагалав. — За одоо барон таныг манай ажилд шилжиж ирэх хэрэгтэй гэж дээд тэнгэр бөө зарлиг буулгалаа. Та генералтай давхар барилдлагатай болж байна. Таны төлөө генерал хэрэгтэй бүхнийг хийх болно. Үүнийг албан тушаал яаж ахих хэрэгтэйг бага сага гадарладаг таны найз, хашир тагнуулч би хэлж байна гэж Миллерийн өгүүлэхэд Заугел бас дэмжиж: — Эрхэм Миллерийн хэлдэг үнэн. Бид гурвуулаа бол хичнээн сайхан ажиллах билээ! гэхэд нь, — Ганс бид хоёр энэ тухай ярьж байсан юм ... Байзаарай дахиад нэг нэг хундагалаа. Хундага хоосон байх нь тусгүй ... За тэгээд Ганс бид хоёр энэ тухай ярьж, би эргэлзэж байгаагаа хэлсэн юм. Миний авьяас хүрэхгүй болов уу гэж айж байна. Гестапод ажиллахад чадвар хэрэгтэй, би бол авьяас билэг хэрэгтэй гэж хэлэх нь байна гэсэнд Миллер дуртай зөвшөөрч: — Таны хэлдэг үнэн. Гэсэн ч манай байгууллагад танаас илүү сайн хүн олдоно гэж бодохгүй байна. Түүнээс гадна таны хуурай эцэг, хадам болох хүн чинь танд олон талаар тусална. Харин ухаан нь ахмад Лютц бол дэндүү өрөвчхөн хүн болохоороо манай байгууллагад бараг л хүний хүн шиг байхсангэсэнд архинд баахан халамцсан Заугель өлгөж аваад, — Барон танд эрхэм Миллер гайхалтай сайхан зөвлөлгөө өгч байна. Намайг аваад үз. Би Гестапод ердөө гурав дахь жилдээ ажиллаж байгаа атал одоо ажлаа өөрчлөх болбол чухам яаж амьдрахаа ч мэдэхгүй байна гэж үнэнээ хэллээ. Шарзын нөлөө мэдэгдэж эхэллээ. Заугелийн булбарай хацрын ягаан нь улам тодорч, бараг хөх гэмээр цэнхэр нүд нь устжээ. Миллер илүү эрүүл байх боловч захныхаа товчийг тайлаад хөлөрсөн духаа байн байн арчиж: — Заугел төрөлхийн байцаагч хүн юм. Өглөөнөөс орой болтол байцааж байгаад санасандаа хүрч чадах хүн. Үлгэрлэн хэлбэл байцаалтын яруу найрагч байгаа юм даа гэхэд нь — Яруу найрагчид онгод хэрэгтэй байдаг биз. Гэтэл онгод нь өдөр болгон ордоггүй гэнэ бил ээ гэж Генрих өгүүлсэнд — Өө тэгвэл та манай ажлын учир утга, амтыг мэддэггүй юм байна. Чухам ажлын дунд онгод ордог юм. Ажил маань намайг энэ шарзтай адил хөлчүүрүүлдэг. Үгүй, худлаа хэлж байна. Ерийн нэг хөлчүүрлийг хүнийг бүрэн эрхэндээ оруулаад байна гэж мэдрэх нарийн бах цэнгэлтэй яаж зүйрлүүлж болох вэ? Гэнэхэн өршөөнгүй байдал гаргаж байгаад байцаагдаж байгаа хүнийг хавханаас мултарлаа гэж бодохтой нь зэрэг ганцхан цохиод хоншоорын нь өмнө тас хааж орхино! Тактикаа эрс өөрчилж, баривчлагдсан хүнийг сэхээ авах чөлөө олгохгүй байцааж, өөрийн өмнө өвдөг сөгдөж, гуйж, хашгирч гараа үнсэхэд хүргэнэ шүү дээ! Ай тийм цагт өөрийгөө үнэнхүү хүнээс онцгой хүн гэдгээ мэдэрдэг юм! гэж Заугелийг рихад, — Цайвар үстэй шулам! гэж Миллер хөлчүүгээр тас тас хөхөрсөнд: — Аяа, Ницше бол миний тахьдаг шүтээн, Ницше германчууд бидний нусгай

идеализмын өвчнийг эдгээж өгсөн юм. Хүнээс онцгой хүний төлөө бусад хүн зуу, мянга, саяараа үхэж үрэгдэж л байг! Барон та намайг юунд ингэж хараад байна вэ? Ха-ха-ха! Хүнийг ер бишийн хүнээс заагласан заагийг давахаас айж байна уу, та ... Нэг, хоёр хүн байцаагаад үз, тэгвэл өчүүхэн муу боол биш, санаа сэтгэлийн ёстой язгууртан мөн юм бол заагийг тэгж давахад төвөггүй гэдгийг биеэр үзэх болно! гэж Заугель ярив. Заугель улам их согтож, алтлаг өнгийн үс нь сэгсийж, нүд нь улайж, мулцгар урт хуруутай гараа нэг зангидаж, нэг тавьж байв. Генрих, энэ «санаа сэтгэлийн язгууртны» толгой руу архины лонхоор буулгаад авмаар санагдавч биеэ барьж байлаа. Туслагчийнхаа согтуу үгнээс залхсан Миллер: — Тэгээд та миний саналыг хүлээж авах уу, Генрих ээ? гэж асуухад нь — Би эцэгтэйгээ зөвлөх хэрэгтэй байна. Тэгээд зөвшөөрвөл нь бид гурвуул элбэж хамжаад генерал Эверсийг ятгаж, намайг СС-т шилжүүлэхийг зөвшөөрүүлж болно гэж бодож байна гэсэнд — Эрхэм Бертольд зөвшөөрөхөөр барахгүй, ерөөж адислана гэдэгт бат итгэж байна! За тэгэхээр түүнийг зөвшөөрөх болтугай гэж хундага өргөө. Бас бид энд, Сен-Реми бароны хатан Лорхен Бертольдын ирэхийг аль болох хурдан үзэх болтугай гэж хундага өргөө! гэж Миллер хэлсэнд: — Тийм хурдан бүтэхгүй болов уу гэж айж байна! Бид дайн дууссаны дараа гэрлэхээр шийдсэн юм. Сүй тавих ёслолыг хоёрдугаар сарын эхээр, миний болзоот хүүхний төрсөн өдөр хийнэ гэсэнд — Та тэгээд энэ бүх хугацаанд сахилтай гэлэн шиг байна гэж надад батлан итгүүлэх санаа байна уу? гэж Миллерийг инээмсэглэн асуухад — Тэнгэр минь, та миний хэлснийг буруу ойлгожээ! Нээрээ гэлэн хүн л сайхан хүүхэн хараад тэсэх юм биз дээ. Гэвч би нэгэнт болзоотой болохоор болгоомжтой байж, аминчлан хэлэхэд төрхгүй зангаа нууж байх хэрэгтэй байна! Чухмыг хэлбэл нуугаад баймаар юм ч хийсэнгүй. Би энэ Сен-Реми хатуу журам сахиж байна ... гэж Генрих өгүүлэв. Заугель дарга руугаа тонгойж, чихэнд нь нэг юм шивэгнэсэнд Миллер тас тас хөхрөөд: — Сахилт гэлэн та жаахан зугаалж цэнгэхгүй юү! гэж асуухад нь — Байдлыг харж байж болно доо ... — Эрхэм Заугель та Бонвиллоос ирсэн франц хүүхний байцаасан уу? — Хоёр дахь шатандаа яваа гэж хариулаад хөх инээд алдахад нь Генрих гайхаж: — Юун тухай ярьж байгааг нь ойлгохгүй байна гэсэнд: — Эрхэм Заугель байцаалт хийх тусгай арга боловсруулсан юм. Тэр арга нь гурван шагтай. Нэгдүгээрт таны саяын сонссоноор дотоод боловсруулалт хийнэ. Хоёрдугаарт гадаад боловсруулалт хийнэ. Гуравдугаар шатан дээр нэг, хоёрдугаар аргыг хослуулан хэрэглэнэ гэж Миллер инээмсэглэн тайлбарлав. — За тэгээд эрхэм Заугель таны боловсруулалт ямар үр дүн өгөв? Тэр хүүхэн үнэнээ хүлээв үү? гэж Генрих асуухдаа хоолой нь чичирч ханиалгах байдал үзүүлсэнд Заугель дүргүйцсэн янзтай ярвайгаад: — Одоохондоо үгүй. Гэсэн ч би санаа зовохгүй байна. Бид хоёр дахь шатандаа дөнгөж эхэлж ороод байгаа. Өнөөдөр юу гэж хэлдэгсэн билээ дээ? Аа тийм. Өнөөдөр тэр хүүхэн цэцгийг нь үзсэн. Маргааш жимсийг нь амталж үзнэ дээ. Амтыг нь үзэхтэйгээ зэрэг хэн дээр яах гэж ирснээ даруй хэлнэ гэхэд нь, — Тэр хүүхэн буруугүй ч байж болох биш үү? гэсэнд Миллер ярианд хажуунаас оролцож: — Эрхэм Генрих ээ! Та манай ажилд шилжиж ирэх гэж байгаа хүний хувьд нэг зүйлийг мэдэж авах хэрэгтэй. Гестапод баригдсан хүнийг нэг бол хойт ертөнцөд явуулдаг, үгүй бол хорих лагерт явуулдаг юм шүү дээ. Ойр хавьд хорих лагерь байхгүй болохоор хойт ертөнцөд явуулах ганц зам үлдээд байна. Би Заугель сэн бол тэр хүүхэнтэй тэгж удаан зууралдахгүйсэн. Би францчууд цөөн болох тусам дайсан цөөн болно гэсэн зарчим баримталдаг хүн.

Харин энэ хүүхний амтыг нь үзэхгүй алдахад их харамсалтай байна. Тун хөөрхөн хүүхэн гэхэд нь, — Хөөрхөн хүүхэн байхад надад үзүүлдэггүй байна шүү! гэсэнд, — Эрхэм Заугель ээ! Бароны хэлдэг зөв. Тушаал өгнө шүү! гэжээ. Заугель гуйвж дайвсаар тасалгаанаас гарч: — Людвина Декокийг авчир! гэж тушаав. Генрихийн сэтгэл догдлол дээд цэгтээ хүрлээ. Тархи нь түргэн ажиллав. Хүүхний гоо сайхныг гайхсан дүр үзүүлж, өөртэйгээ хоёулхныг үлдээхийг гуйгаад дараа нь тухайн байдлыг харж байж больё ...

Харин яах вэ? Эндээс зугтсан байдал үзүүлэх аргагүй. Баривчлагдсан хүүхнийг аваад машинаар хамт зугаалъя гэж энэ хоёрт хэлэх үү? Үүнээс өөр арга байхгүй шиг. Урьдаар энэ хоёрыг архи сайн уулгаж, чухам аль ертөнц дээр байгаагаа мэдэхгүй болгох хэрэгтэй. Заугель тийм болох ойртоод байна. Миллер нь ... Генрих гуйвсан дүрэм үзүүлэн хундагатай архиа ширээн дээрээс түлхэж унагаад муухай хараал тавьж, шилэн аяга авчрахыг тушаав. Шар жавьжтай жаалууд л шарзыг хундагаар уудаг байх, ёстой эр хүн бол аягаар уух хэрэгтэй гэж Генрих хэлжээ. Хөл дээрээ сайн тогтохоо байсан Миллер, гурван аяга авчирч бялхтал нь архи хийв. Заугель аягатай архиа нэг мөсөн хөнтрөв. Миллер бас ёроолыг нь гаргал сорох гээд чадсангүй, цацан ханиалгаж арайхийн амьсгаа аваад, — Ай чөтгөр! Нүд эрээлжлээд байна! гээд толгойгоо барьж ёолоход нь — Миний ч гэсэн нүдний өмнүүр дугуй юм эрээлжлээд байна гэж Генрих согтуу хүн болж инээд алдаад хэн ч ажиж мэдэхгүй гэж мэдээд аягатай архиндаа ам ч хүрсэнгүй. Хүний хөлийн чимээ гарч, автомат буутай цэрэг тасалгаанд нэг залуу эмэгтэйг оруулж ирэв. Тэр эмэгтэй дан дотуур цамцтай тул даарсандаа дагжин чичирнэ. Зүүн мөрнөөс нь цээжин дагуу цусан зурвас зурайжээ. Баривчлагдсан эмэгтэй Заугелийг хараад хаалга руу ухарч, хамаг биеэ хураасан боловч чулуу мэт хөшсөн нүүрний нь нэг ч булчин хөдөлсөнгүй. Тэр эмэгтэй үхлийн босгыг нэгэнт давсан юм шиг тийнхүү хөшиж хөдөлгөөнгүй болсон нь этгээд хачин харагдана. Залуу эмэгтэй дүрлэгэр хүрэн нүдэнд үхээрийн амгалан байдал тогтжээ. Заугель өндийх гэж оролдоод чадсангүй, сандалдаа лаг хийтэл унаж, хөлчүү нүдээр Людвина Декокийг хэсэгхэн зуур гөлөрснөө гэнэт нүд нь гялалзаж, — Авхай та сууж болно. Би таныг байцаах гэж дуудаагүй ... Бодийг чинь хөтлөх гэж дуудсан юм. Хатагтайг өөрийг нь бодийг нь хөтлөхөд урьж байлцуулна гэдэг маш эелдэг найртай, тун сонин хэрэг бус уу гэж хэлэв. Залуу эмэгтэй, Заугелийн хэлснийг дуулаагүй юм шиг, тасалгаанд байгаа хүмүүсийг хараагүй юм шиг, нэг ч хөдөлсөнгүй. — Аа, та тоохгүй байна уу! гээд дэслэгч дахин өндийх гэж оролдоод урагшаа нэг алхаснаа баруун тийшээ хазайж, эрэгнэгийн шовх буланд тохойгоо өвдтөл цохиод — Ёо ёо! гэж муухай дуугаран архинд халж улайсан царай нь юу юугүй ухаан алдах нь уу гэмээр зөвхий даагаад ирлээ. Миллер туслах тийшээ ухасхийж, мөрнөөс нь түшээд — Үүнтэй зууралдахын хэрэггүй гэж би танд хэлээгүй бил юу! Ганга өөд өвөөч! гэж Миллер сурсан зангаар будах маяг үзүүлэн хуруугаа тас няс хийлгэн инчдэж дохисонд — Тийм тийм, ганга өөд аваач, ганга өөд аваач! гэж Заугель хашгиран нударгаараа ширээ дэлдэв. Миллер гуйвж найгасаар албан тасалгаанд орж, нэгэн дэвтэр барьсаар эргэж ирээд — Энэ бүртгэлд гарын үсэг зурчих! гэсэнд Заугель шалавхан үзэг авч дэвтэрлүү тонгойлоо. Людвина Декокийн нэрний ард «Цаазаар авсан Заугель» гэж бичихийг Генрих харлаа. Генрих Миллерийн мөрнөөс барьж — Ганс аа! Жаахан юм ярья гэсэнд Миллер Генрихтэй хамт ширээнээс баахан холдов. — Танаас хүсэн өчүүхэн зүйл байна. Ганс аа! Надад цаазыг биелүүлэх

зөвшөөрөл өгнө үү. Танай Заугель тэртэй тэргүй үүнийг гүйцэтгэж чадахгүй болсон байна. Энэ хүүхэн надад аятайхан санагдаад байна ... та миний хэлж байгааг ойлгож байгаа биз дээ? гэж Генрихийг хэлэхэд — Аа, сахилт гэлэн гуай нисваанисыг тэвчиж чадсангүй юу! Бологүй яах вэ! Дураараа наргиарай! Энд үлдэх үү! Гэртээ аваачих уу? Нэг ч хүнд мэдэгдэж болохгүй шүү! гэж Миилер өгүүлэхэд — Санаа зовох явдалгүй, надад арын хаалганы түлхүүр бий гэсэнд — Өглөө бололоос нааш бүгдий нь амжуулахыг хичээгээрэй. Заугель аа! Үүнийг яаж хийдгийг баронд хэлээд өг. Түй, унтаад өгсөн байх чинь. За яах гэх вэ, би өөрөө ярья. Манай энэ гудамжнаас шууд голын эрэг дээрх байц хад хүрсэн зам бий. Чи энэ хүүхнийг ганганы ирмэг дээр зогсоож байгаад буудах юм уу, ьүлхэж орхиорой. Тэнд чухам хэнийг хороосныг нэг ч хүн мэдэхгүй. Хүүр нь голын түргэн урсгалд хол урсч очихдоо нүүр ам нь танигдахгүй болтлоо гэмтдэг юм ... гэхэд нь — Ойлголоо, одоо энэ хүүхнийг нэг юмаар ороогоод миний машинд аваачиж хийхийг тушаана уу. Чи бид хоёрыг дахиад нэг нэг хундага уух хооронд автомат буутай цэрэг манаж байг. За хундагалаарай. Миний гар салгалаад байна ... Дасаагүй болохоор тэр бололтой гэсэнд: — Өө эхлээд заавал тэгдэг юм. Сүүлдээ дасна! гэж Миллер хэлээд Генрихийн мөрөн дээр гараа тавьжээ. Шөнийн гурван цаг болж, зочид буудлынхан бүгд унтацгаасан тул Генрих Людвина Декокийг тасалгаандаа хүнд мэдэгдэхгүй оруулав. Залуу эмэгтэй замын турш үг дуугарсангүй, шаг өөд өгсөхдөө солиотой юм шиг хөл дорхио ч харсангүй, хайсыг ч түшсэнгүй. Гагцхүү тасалгаанд орж ирсэн хойноо сая сэрсэн юм шиг болж, энэ орой анх дуугарахыг нь сонслоо. — Булай амьтан! Тэр гэмгүй царайлсан яргачнаас дор бузар новш! гэж Людвина Декок хашгираад үзэн ядах хилэн нь бадрахдаа багтарч тамирдан гуйвахад нь Генрих туслаж суулгахаар ойртож очтол санаанд оромгүй хүчтэй түлхээд: — Битгий наашаа ойрт. Ямар ч гэсэн амьддаа ойртуулахгүй! гэв. — За сайн, би ойртохоо байя. Гэсэн ч Людвина Декок та суучих. Би одоо мадемуазель моникаг дуудъя. Тэр ирээд ... — Би тэр Моника гэдгийг чинь танихгүй. — Моника ирээд танд учрыг хэлнэ. — Тэр мадемуазель Моника гэдгийг чинь танихгүй гэж танд хэлээд байна шүү! — Тэгвэл би танд сануулаад өгье. Тэр бол Бонвильд очиж танд галт тэрэгний тухай мэдээ өгсөн, өнөөдөр үеэл эгчээ галт тэрэгний буудал дээр угтсан бүсгүй юм. — Энд надад нэг ч таних хүн байхгүй, намайг хэн ч угтаж аваагүй. — За тийм байж, одоо бид шалгая ... гэж Генрих хэлээд утасны дэргэд очиж, зохих дугаарт залгалаа. Утасдахыг хүлээж байсан бололтой харилцуурыг даруй авахад нь — Моника! ... манай өрөөнд одоохон хүрээд ирнэ үү гэж Генрихийн тайван дуугарахыг Людвина сонсоод нүдний нь өмнүүр манан бүрхэж, ёроолгүй нүхрүү ойчих шиг санагджээ.

СҮЙ ТАВЬСАН НЬ ГАШУУДАЛ ШИГ БОЛОВ «Нэгдүгээр сарын 25-наас арав хоногийн амралт авлаа. Хоёрдугаар сарын дөрвөнд Мюнхэнд ирсэн байгаарай. Үнсье. Эцэг чинь» гэсэн цахилгаан ирсэн байв.

Энэ нь урьсан биш тушаасантай адил болжээ. Генрих, Бертгольдийн цахилгааныг штабын хаяг дээр аваад тэр даруй генерал дээр оров. Генерал цахилгааныг нь уншиж

үзсэн ч үгүй. — Мэднээ, мэднэ! Уржигдар Бертольддыг утасдахад би таныг явуулна гэж амласан. Танд тав хоногоос илүү чөлөө өгч чадахгүй. Бидний сууж байгаа нөхцөл байдлыг миний найзад мэдээлээрэй. Тэгэхгүй бол намайг офицерууддаа дэндүү хатуу байдаг юм байна гэж бодох магадгүй. Ер нь Бертольд өөрөө энд юу болж байгааг биднээс дутуугүй мэдэж байгаа биз. Бусад цагт бол танд дуртайяа нэг сарын чөлөө олгохсон, гэтэл одоо ... гэхэд нь, — Маш их баярлалаа, эрхэм генерал аа! гэв. Ингээд дахин Мюнхен орох хэрэг болжээ. Ямар хэргээр явах гэж байгааг ганц Миллер мэдэж байв. Генрих Бертольдийн охинтой ямар харилцаатай байдгаа одоогоор Лютцэд ч хэлсний хэрэггүй гэж үзсэн байна. Ахмад аливаа нэгэн юмыг үзэх өөрийн үзэлтэй, тэр нь ихэнх офицерийн нийтээр зөвшөөрсөн үзэлтэй тэр болгон таардаггүй билээ. Лютц санаа алдаад: — За Генрих ээ чи явах болж дээ. Чи эцгээсээ манай сонин хэвлэл, радиогийн огт дурсдаггүй юм дуулж ирэх биз гэж найдаж байна. Чухам юу болж байгааг бүгдийг мэдэхсэн гэж их хүсэх юм. Сохор номин шиг байж бүүр залхлаа. Энэ нүхэнд булагдаж орхиод юу ч мэдэхгүй, юу ч харахгүй юм гэжээ. Үлдсэн хэдэн хоног нисэх мэт хурдан өнгөрөв. Энэ завсар шинээр барьсан удаан цагийн галын цэгийг хүлээн авахаар Понтейд дахин очиж Шамберид дугтуйтай бичиг хүргэж, өөр бусад жижиг боловч төвөгтэй хэдэн даалгавар биелүүллээ. Генрих ийм ажилтай байсан учир Моникатай ганцхан удаа уулзжээ. Бүсгүй Людвина Декокийг аюулгүй газар хүргэсэн гэж мэдэгдэхээр ирсэн байна. Моника Людвина, Генрих хоёрын төлөө сэтгэл нь зовсон байснаа одоо царайд нь баярын туяа гэрэлтэн байх тул Генрих Мюнхен явах гэж байгаагаа хэлж зүрхэлсэнгүй. Цаашдаа нуугаад байх аргагүй болсон тул Генрих явахынхаа урьд өдөр орой нь салах ёс гүйцэтгэхээр ирнэ гэж хэлэхээр зоогийн танхимд орсонд Тарваль авгай туньж, — Ноён Гольдринг та манай зоогийн танхимын босгыг алхсангүй гурав хоночихлоо. Бид танд аргагүй их төвөг удсан улс даа гэвэл. — Хаанаас даа, авгай! Би ерөөсөө танд илүү дараа болохгүйсэн гэж хичээсэн юм. Одоо чинь хүнсний зүйл урьд урьдийнхаасаа ховор байгаа шүү дээ. биднийг хооллодог газрын эзэн хүртэл хэрэгтэй зүйлээ түрүүн ээлжинд хэмжээ тогтоолгүй авдаг хир нь гомдол тавьж байна лээ. — Гэсэн ч би одоохондоо зоогийн танхимаа хаагаагүй л байна. Хүнсний зүйл хичнээн ховор байлаа ч гэсэн ноён танд юухан хээхэн олоод өгнө гэхэд нь — Авгай таны ингэж анхаарсанд баярлалаа. Би таны анхаарал халамжийг алхах гишгэх болгондоо мэдэрч байна, одоо ч гэсэн би мадемуазель Моника та хоёроос хол болсондоо их гунихарч байна гэсэнд хажуунаас нь Моника: — Юу гэнэ ээ? Та дахиад юманд явах нь уу? Хэзээ, хаашаа явах нь вэ? гэж асуухдаа сэтгэл хөдлөлөө нуухыг оролдсон боловч царайд нь даруй уйтгарын шинж илэрчээ. — Маргааш өглөө Мюнхен орно — Өө, дахиад Мюнхен орох нь ээ! — Энэ удаа ердөө тавхан хоноод ирнэ. Миний аз болоход генерал надад илүү удаан хугацааны чөлөө өгч чадахгүй гэнэ гэсэнд — Та тэгээд иймэрхүү янзаар салах ёс хийх гэж гүйж ирсэн хэрэг үү? гэж Моникаг тунихад нь: — Өнөө орой тан дээр түр ороод гарах зөвшөөрөл гуйх гэж ирсэн юм. Бид уулзаагүй их удлаа шүү гэв. Генрих орой нь Моникатай дахин уулзаж чадсангүй, гэнэт Лютц хүрээд иржээ. — Чи чинь тогтсон уламжлалыг зөрчих нь үү? Генрих? Явахын өмнөх оройг найз нөхдийнхөө дунд өнгөрүүлдэг учиртай гэж Лютцийг өгүүлэхэд, — Уг нь үдэлтийн үдэшлэг хийвэл сайхансан гэтэл одоо цагаа олоогүй хэрэг болно. тэр ч байтугай эвгүй юм болно шүү, Карл аа! Фронт дээрх байдал төдий л өөдтэй биш байна ... гэв. — Муу

байна гэж шууд хэлээч. — Илэн далангүй яривал маш муу байна. — Би бүүр бүтэн сарын турш солиотой юм шиг явж байна. Би усан тэнэг юм шиг цаг үргэлж мэхлүүлж маллуулж байгаад одоо л нэг юм болгон ил болж байгаа юм шиг санагдаад байна. Миний итгэж байсан, чухамдаа гэвэл надад итгүүлэх гэж байсан юм бүхэн ердөө инээдэмтэй хачин зүүд зэрэглээ шиг байж дээ. — Сталинградын хэрэг явдал ёамд ингэж их нөлөөлөө юу даа? — Тэр ч миний ухаан цоорохыг хурдатгахаас өөр зүйлгүй. Герман улс ертөнц дахиныг эрхэндээ оруулах ёстой гэлцдэг. Европыг өмнөө сөхрүүлсэн байтал одоо гурван зуун мянган шилдэг цэргээ аварч чадахгүй байна. Энэ чинь юу гэсэн үг вэ, чи ойлгож байна уу? Дампуурал гэсэн үг! Манай командлал бүслэгдсэн цэрэгт туслуулахаар галд түлээ хийж дараа дараагаар армиуд явуулж, явуулсан тэр армиуд үнэндээ ч галд хийсэн түлээ шиг шатаж байна. Сайндаа л тэндээс эрэмдэг зэрэмдэг болж шархтаж, ухаан солирсон хүмүүс ачсан урт цуваа буцаж ирж байна! Аяа, миний сэтгэл яасан их зовж шанална вэ! Гольдринг, Лютц хоёр фронтын байдлын тухай олон удаа ярьдаг байсан боловч дотно нөхөр нь ийм гутруу байдалтай байхыг Генрих хэзээ ч үзээгүй юм. — Ингэхэд байна шүү, Карл аа, өнөөдөр манайд хоноод яв. Хамт хоол идэж, дэмий ярья ... Би мадемуазель Моникатай салах ёс гүйцэтгээгүй байгаа, түүнийг ч урья. — Би үлдвэл чамд саад болох юм биш биз? Би ганцаар элдвийн юм бодож суухаасаа бүүр айгаад байна шүү! — Чамайг зөвшөөрвөл би мадемуазельд утасдаж нааш ирэхийг уриад, хэрэгтэй бүх зүйлийг захиалая гэж Генрих хэлээд утасны харилцуур автал яг энэ үеэр гэнэт ирсэн зочид хаалга тогшсон нь Миллер, Заугель хоёр байжээ. Миллер дөнгөж босго алхангуутаа: — Тийм бий! Та найз нартайгаа салах ёс гүйцэтгэлгүй Мюнхен яваад өгөх санаатай байна уу? гэхэд нь — Харж байгаа биз дээ, би утасны дэргэд зогсоод танайх руу утасдаж байсан юм гэж Генрих худал хэлсэнд — Бид ингээд урилгагүйгээр яваад ирэхэд эвгүйрхэх юм юу ч байхгүй гэж Заугель таньд хэлээгүй юу! Аа, эрхэм Лютц та энд байгаа юм бий. Сайхан хэрэг байна. Дөрвүүлээ бол улам хөгжилтэй. Бас мадемуазельд утасдах юм биш үү? Эмэгтэй хүнтэй хамт байвал ... гэхэд нь Генрих Лютц өөд түргэн зуур харсанд цаадахь нь учрыг ойлгоод, би сая ахлах дэслэгчийг хувцсаа өмсөж байх хооронд түүний даалгавраар мадемуазелийг урьсан юм. Гэтэл бие нь муу байгаа гэнэ. Тэгэхлээр манай энэ үдэшлэгийг эхнэр хүүхэнгүй хийхээс биш дээ гэж хэллээ. Генрих урилгагүй ирсэн зочдоо дагуулаад зоогийн танхимд орохоос өөр замгүй болов. Генрих Миллер, Заугель хоёроос аль болох хурдан салах гэж хичнээн хичээсэн боловч оройн зоог шөнө орой болтол унжирлаа. Тэгээд Моникатай уулзана гэж бодохын ч хэрэггүй боллоо. Генрих өглөө нь хэдэн минут чөлөөчилж бүсгүй дээр очсон боловч Генрихийн зочид санамсаргүй цугларсан гэдгийг Моника үнэмшсэнгүй. Тэгээд албархаг байдалтай салах ёс гүйцэтгэлээ. Генрих болзоот хүүхэн дээрээ очихоор цээж давчуухан мордлоо. Явахынхаа өмнө ч тэр, галт тэргэнд анх суусан үедээ ч тэр, тэр хүүхний тухай бодохгүйг хичээж, яах гэж Мюнхен орж яваагаа мартахыг оролдов. Анхандаа тийм бодлыг зайлуулж чадаж байлаа. Моникагийн гомдсон царай нүдний өмнө барин тавин тодорч, орчин тойрны юм бүхнийг халхална. Моникагийн гомдох нь аргагүй билээ. Генрих хэлсэндээ хүрч салах ёс гүйцэтгэхээр ороогүй болоод ч тэр биш. Генрих Лоратай ямар янзын тоглоом хийх ёстой болж байгаагаа Моникад учирлаж хэлэлгүй, нуугдсан мэт явсандаа сэтгэл шанална. Бертольддын охинтой ийм харилцаатай байгаагаа юу гэж тайлбарлах вэ? моника үнэн учир шалтгааныг нь

мэдээгүй цагт Генрихийн зан авирыг зөвтгөж чадахгүй шүү дээ. Гэтэл чухам тэр учир шалтгааныг хэлж болохгүй байна. Хамаг явдал хичнээн нарийн төвөгтэй болов доо ... замд нь Моника дайралдаж, бүсгүйд ч, өөртөө ч учирч байгаа аюулыг цаг тухайд нь ажиглаж мэдээгүйгээс ийм хэрэг болов ... «Одоо өнгөрчээ ... Одоо өнгөрчээ ...» гэх шиг галт тэрэгний дугуй цохилно. Генрих өөрөө ч гэсэн, Лютцийн нэгэн адил элдвийг бодон ганцаар үлдэж болохгүй юм байна. Генрих сэтгэлийн их хүч гарган байж, өөр юм бодов. Үүнд орвол Лорагийн тухай, түүний зодож занчдаг заяагүй бүсгүйчүүдийн тухай бодсон нь дээр. Үүнийг бодоход ядахдаа уур хилэн бадарна, хилэн бадрах нь хүний ямагт дайчилдаг билээ. Генрих болзоот бүсгүй, барон цолоо хаячихаж болдог бол яасан их дуртай хаях бол?! Гэтэл сэтгэлтэй болсон хүний дүрэм үзүүлж, Лораг эргүүлж байгаа байдал гаргаж, Бертольдийн унжуу яриаг сонсож, фрау Эльзагийн гарыг үнсэх хэрэгтэй болж байна. Эцэст нь бас Лорагийн хуруунд сүйн бөгж зүүлгэх хэрэг болж байна. Олзлогдсон бүсгүйчүүдийг ташуурддаг гарт нь шүү дээ. Үгүй, ер нь бодсоноос унтсан нь дээр. Үйлчлэгч хүнд өрөөндөө хүн бүү оруулаара гэж хэдэн цаас атгуулж орхиод өглөө болтол унтах хэрэгтэй байлаа.

Генрих үүрээр Германы хилийн Мюльгаузен гэдэг жижиг хотод сэрлээ. Тэнд орой болтол хүлээж байгаад Мюнхений галт тэргэнд шилжиж суух ёстой байжээ. Генрих чемоданаа хадгаламжийн газар хадгалуулаад хотоор зугаалахаар явлаа. Бөгчимхөн вагонд суусаар толгой нь дүйрч хүндэрсэн тул хүйтэн цэвэр агаар амьсгалж хотын гудамжаар ямар ч зорилгогүй, урьдаас тогтоосон чиггүй дэмий тэнэж явахад сайхан байлаа. Генрих удалгүй ийм зугаалгаас залхав. Бие нь алжааж ядраагүй боловч энэ хот даанч царай муутай, уруу дорой харагдана. Хүн амьтангүй хоосон гудамж, хамгийн гол нь орчин тойрны ер биүийн нам гүм байдал хачин жигтэй сэтгэгдэл төрүүлнэ. Эмэгтэйчүүд, хүүхэд голдуу хаяа нэг хүн явж үзэгдэх бөгөөд бие биетэйгээ ганц хоёр үг солиод нэг тийшээ яаран одно. Сургуулийн хүүхэд хүртэл бяцхан өвгөчүүл шиг, инээж наадах, хашгирч шуугих нь үл сонсогдоно. Генрих арван нэгэн цагийн үед гэдэс нь өлсөөд гуанзны хаяг харагдахад нь цай уухаар орлоо. Танхимд бас л хоосон байв. Байгаа ганц хүн нь аяга пивоны дээрээс тонгойн үүрэглэж, хоол зөөгч эмэгтэй эрэгнэгийн дэргэд юм хум аялуулж байгаа харагдана. Шинэ хүн орж ирснийг хоол зөөгч ажиглаад дэргэд нь бушуухан ирж хамгийн түрүүнд хүнсний карт бий юугэж асуулаа. Дараа нь талоныг тасалж авсны эцэст сая ноён офицер өглөөний цайнд юу зооглох вэ гэж сонирхжээ. Хоол зөөгч эмэгтэй ёсыг бодож асуусан аж. Юу вэ гэвэл цааш нь яриад үзэхэд гуанзанд нь үилж сонгоод байхаар хоолны юм ер байсангүй. Бүх захиалга нь хоёр ширхэг өндөг, лаазтай мах, аяга пиво, аяга кофе цайгаар дуусдаг байжээ. Генрих хоолыг амсаж үзээд Тарваль авгайг замд идэх юм авч яв гээд байхад нь авч яваагүйдээ үнэхээр харамсав. Лаазтай мах нь тун сэжиглэмээр байдалтай тул Генрих ам хүрсэн ч үгүй, пивоноос нь торхн ыгүнэр ханхалж, кофе цай нь жинхэнэ кофе биш, орломол цай гэж хоол зөөгч хүүхэн хэлжээ. Генрих өндөгийг идээд гэдэс нь улам өлсөх шиг болов. Кофе уух гэтэл гуанзанд суугаа ганц хүн дээр харц нь тогтлоо. Жаран тав орчим настай тэр өвгөн согтуу ажээ. Урьд нь урьд нь залуудаа цэнхэр байсан болов уу гэмээр, одоо хөгширч өнгө алдсан нүдээр Генрихийг илт хорсолтой харж, жигшин зэвүүцэх

байдалтай мушийн инээмсэглээд Генрихийн хажуу тийш түлхсэн пиво, лаазтай мах тийш толгой дохиж дооглосон байдалтайгаар: — Яав, ноён офицерийн санаанд таарахгүй байна уу? Үүнээс илүү сайн хоол зооглох гавьяатай гэж бодож байна уу? Тэгвэл би үгүй гэж хэлэх байна! Та нар үүнийг ч идэх гавьяагүй ... гэж хэлээ. Өвгөн ууж дуусаагүй аягатай пивээ барьсаар Генрихт ойртож суув. Тэр хоёр одоо зэргэлдээ ширээний ард бараг зэрэгцэн суугаад, өвгөний цээжээ хүржигнүүлэн амьсгаадах нь Генрихт дуулдана. — Та нар Германыг энэ дэлхий дээрх шамбалын орон болгоно гэсэн чинь хаана байна вэ? Та нарын үгэнд үнэмшээд та нартай хамт «Герман, Герман орон бүхнээс илүү!» гэж хашгирч байсан тэр цагаас хойш тэр шамбалын орныг чинь би арав гаруй жил хүлээж байна. Ай, би хичнээн усан тэнэг байснаа санахаас ичих юм. Та нарын үгийг үнэмших ч гэж дээ! Ингэж маллуулах ч гэж дээ! Энэ хоёр улаан гарнаасаа өөр юу ч үгүй жирийн герман хүн надад та нарын амласан тэр бүх юм чинь хаана байна вэ? гэж өвгөнийг агсамнахыг Генрих сандлын түшлэг налж суугаад анхааралтай сонсов. Өвгөн үргэлжлүүлэн: — Та энэ хотыг үнэрлэж үзээд цааш нь түлхэж байна. Гэтэл би өвчтэй хэвтэж байгаа хөгшин Эммадаа хоёр өндөг аваачаад өгөх чадалгүй байгааг та мэдэх үү? Үүнийг та мэдэх үү? Та нар надад энэ дэлхийг бүхлээр нь амлаж байсан. Гэтэл би өлбөрч үхэх гэж байна, гэр бүлээ тэжээж чадахгүй байна. Та нар цагдаагийн хэдхэн отряд явуулаад Австрийг эзлээд авсан., та нар хээл хахуульд автсан Чехословакийг эзлээд авсан. Та нар түүндээ толгой чинь эргэсэн байна! Та нар Оросруу хоншоороо шургуулсан! Та нар оросын газар нутаг, тариа будаанд санаархсан байна! Төрсөн ганц хүү минь хаана байна вэ, хэлээд аль! Тар Сталинградаар чинь би үхсэнээ хийх юм бэ? Миний хүүг хэн надад эргүүлж өгөх вэ? Хэн бэ? аан? Та дунд намайг яагаад муухай хараад байгаа юм бэ? Айна гэж бодоо юу! Үхсэн хойноо айна байх аа! Та нар намайг төрсөн ганц хүүгээс минь салгасан. Одоо хөгшин минь үхлүүт өвчтэй хэвтэж байна. Ижил мөрний эрэг дээр миний хүүтэй ижилхэн олон аавын хүү баатарлагаар амь үрэгдэж байгаа гэж би сэтгэлээ хуурч суух уу даа! Юунд зүгээр хараад байгаа юм бэ? Намайг бариад ав! Барьж аваад хүлж орхи! Тэгсний чинь шанд Германы дотоодын дайсныг барьсан гэж цээжин дээр чинь бас нэг төмөр хэрээс зүүнэ биз. Би дайсан биш ээ! Та нар л дайсан! Би германдаа хайртай болохоос та нарт хайргүй гэхэд нь, — Та хэлэх гэсэнээ хэлж дуусав уу? гэж Генрих тайван асуугаад эрэгнэгийн лангуу тийш эргэж харав. Хоол зөөгч хүүхэн, цаад өрөөнөөс цухуйж байсан гуанзны эзэн, аль аль нь өвгөний болох бүтэхгүй үгийг дуулмагцаа салхинд хйиссэн хамхуул шиг арилаад өгчээ. Өвгөн үргэлжлүүлэн: — Үгүй, би хэлж дуусаагүй байна. Би ингэж хэлэх гэсэн юм: Би хэзээ ч коммунист байгаагүй. Одоо Тельманы анд нөхөдтэй тэдний өмнө гурван алхмын цаанаас малгай аван ёсолж тэдний үгэнд оролгүй, та нарын үгийг үнэмшсэнийг минь уучлахыг гуйна. Муусайн молигочингууда аа! гэлээ. Гольдринг халбагаараа таваг цохин хангинуулж, хоол зөөгчид мөнгөө төлөөд гадагш гарав. «Эхэлжээ! Ухаан орж эхэлж! Сталинградын төлөө тулалдааны анхны үр дагавар энэ. Ижил мөрний орчмын хээр талд хүү нь амь үрэгдсэн энэ жирийн герман өвгөн согтуудаа гашуун зовлонд автаад ярьж байгаа ч гэсэн одоо ажиг сэжиг авч дайны эхэн үед бол сэтгэлдээ ч бодож зүрхлэхгүй байсан тийм юмыг офицер хүний улаан нүүрэн дээр ярьж байна» гэж Генрих бодов. Генрихийн сэтгэл овоо онгойж, Мюнхэн орох галт тэргэнд суулаа. Энэ удаа тусгай өрөөнд сууж чадсангүй. Галт тэргэнд офицерууд пиг

дүүрэн байлаа. Тэний ихэнх нь Дорнод фронтруу яваа ажээ. Шөнөжин вагонуудад архидаж, «Лили Марлен» гэх олны дуртай дууг орилолдох нь баясан цэнгэсэн юм байхгүй, үхлээ эрэн очиж яваа Дорнод фронтоос айснаа дарах гэсэн цөхрөнгүй хүсэлдээ тэгсэн байжээ ... Өглөөний дөрвөн цагт галт тэрэг Мюнхэнд хүрч ирэв. Генрийх үүний түрүүнд галт тэрэгний буудлын дэргэдэх зочид буудалд буухад нь фрау Эльзагийн их дургүй байсныг санаад үсээ засуулсны дараа шууд Бертгольдынд очихоор шийдлээ. Бертгольдийнхон, ялангуяа Лора өөрөө чухам одоо л Генрих фон Гольдрингийг битгий ирээсэй гэж юу юунаас илүү хүсэж байсан юмсанж. Ойрын хэдэн өдөр Генрих ирвэл тун зохисгүй цагаар тааралдах байлаа. Үүнийг бүгд ойлгож, ялангуяа болзоот хүүхэн өөрөө сайн мэдэж байв. Лора тэр гайтай золигийн ферм дээр очсондоо өөрийгөө хичнээн их зэмлэсэн гэх вэ? Тийм балай хэрэг болно гэж Лорагийн санаанд яаж орох билээ? Генрихийг анх ирснээс хойш эцэг эх хоёр нь ганц охиныхоо элдвийн занг өршөөн уучлах байдалтай болжээ. Ямар ч гэсэн Лора охин нь бароны хатан болох хариугүй дөхөөд байна шүү дээ! Албан ёсоор сүй тавиагүй ч гэсэн Бертгольд Генрихтэй юу гэж ярьснаа эхнэр, охин хоёртоо нэгд нэгэнгүй хэлсэн байжээ. Бертгольдынхон охиноо мундаг хүнтэй нийлүүлэхээр болсон гэдэг сураг улам их тарсан байна. Тэгээд фрау Эльза, Лора хоёрыг тун дармжхан хүлээж авдаг байсан ихэс язгууртны хүрээнд дахин урих болжээ. Дээгүүр зантай Лорад олны тэр анхаарал, ялангуяа үе тэнгийн бүсгүйчүүлийн атаархал сайхан санагдах болов. Лора одоо сүрхий буурь суурьтай тогтуухан ааштай болж, хуучин танилуудаа шилж голж, саяхан болтол өөрөө үлгэр жишээ болгон дууриадаг байсан Бертинагай бүрмөсөн харилцахаа больжээ. Эхийнхаа шахалт шаардлагаар ингэсэн байна. Лора удахгүй бароны хатан болох гэж байгаадаа хөөрөхн баярлаж, тэр тэмдэглэлт үйл явдлыг тэсч ядан хүлээж, их л хичээнгүйлэн бэлтгэж байлаа. Хамаг зав, чөлөө цагаа инж бэлтгэхэд зориулдаг болов. Фрау Эльзагийн авдар сав, шүүгээнд дарсан хуучин цагийн эд агуурс Лорагийн санаанд огт таардаггүй байжээ. Энэ энгийн зотон даавууг Лора яаж гэр бүлийн орон дээр дэвсэх юм бэ? Бас ийм бүдүүлэг хатгамалтай шөнийн цамц яаж өмсөх юм бэ? Авдарын ёроолд хагас зуун жил шахам дараастай байсан энэ торгоор яаж бошинз оёулах юм бэ? Тэгвэл Голландын нимгэн нэхмэл, Брюсселийн сүлжмэл угалз, Францын хамба хилэн ямар хэрэгтэй байж таарах вэ? Тэгээд Лора арын хаалгаар энэ бүх эд юмсыг олж авч болох дэлгүүр хоршоогоор гүйж, эцэг нь өдөр болгон оросоос өдөн шүүрээр арчиж цэвэрлэх гэж төвөг болдог элдэв баримал авчрахын оронд үнэтэй арьс нэхий авчирсангүй гэж эхийгээ зэмлэдэг байв. Лора алдар цуутай фон Гольдрингтоны удам угсаа залгамжилсан хайрт барон Генрихийнхээ өмнө нэрээ хугалахгүй гэж эхээсээ мөнгө, мөнгө, мөнгө гэж шалгаадаг болжээ. Нөгөөх гайтай фермийг ч залуу хосод инж болгож өгөхөөр шийдсэн юмсанж. Ирээдүйд тэр фермийн эзэгтэй болох Лора одоо тийш зугаацахын тулд очдоггүй, тэр бяцхан эзэмшлээ хөгжүүлж, аар саар юм болгоныг өөд татахад хэрэгтэй гэсэн тушаал заавар бүхнийхээ биелэлтийг эзэн хүний нүдээр харж шалгах гэж очдог болсон байна. Тэгээд нилээд түрүүн Бертинагийн бэлэглэсэн уян мөртлөө хүнд ташуур ямар ч хэрэгцээгүй хананд өлгөөстэй байсныг дахин барих болжээ. Лора өөрийн ажлын хувцсанд энэ ташуур сайхан зохиж байна гэж ээждээ учирласан байжээ. Энэ бүслэхүйгээр татсан богино цамц, бароны ирээдүйн хатны дэндүү тарган биеийн хэлбэрийг аятайхан нууж далдалсан Галифе маягийн өмд, богинохон түрийтэй

маажиндсан савхин гутал, жижигхэн нэхий малгай байжээ. Энэ биеийн тамирын маягтай хувцасны өвөрмөц байдалд ташуур үнэхээр зохиж байгааг фрау Эльза аргагүй зөвшөөрсөн байна. Лора одоо их л тогтуухан зантай болсон тул охиныхоо урьдын «зугаа цэнгэлийг» санасан ч сэтгэл зовсонгүй. Ер нь Лора одоо дан ганц аж ахуйн ажил явдал хөөцөлдөх болсон байжээ. Орон гэрээ тохилог байлгахаар барахгүй, тэр тохилог байдлыг тэжээн тэтгэх уг сурвалжийг ч ширгээхгүйн төлөө санаа тавих ёстой герман хүүхэн болж байна гэж эх нь бодно. Лора үнэхээр ч нэг үе хачин зангаа татж байлаа. Гэтэл болзоот хархүүгээсээ хол байх цаг унжрах тусам эзэн хатагтайнхаа ашиг тусыг огт тоодоггүй нөгөөх «Залхуу хүүхнийүүдийн талаар» тэвчээр нь барагдаж эхэлжээ. Тэгээд ташуур тас тяс хийх нь улам олон болж, заяагүй олзлогдсон эмэгтэйчүүд үзэн яддаг эзэгтэйн ирэхийг санахаас яс үс нь хавталзах болсон байна. Берьтголын охин ялангуяа үгэндээ ороогүй зөрчсөн буюу өөрийг нь дооглох байдалтай инээмсэглэсэн, харсан эмэгтэйчүүдийг туйлын хортойгоор залхаан цээрлүүлдэг байлаа. Лораг анх ферм дээр биеийн тамирын хувцастайгаа хүрч ирэхэд Марина Брыль гэж арван долоон настай нэгэн бүсгүй инээдээ барьж чадсангүй доош тонгойн пир хийтэл хөхөрсөн юмсанж. Лора огт ажиглаагүй дүр гарган өнгөрөөсөн боловч өглөөний турш өөрийг нь гомдоосны өсийг авах аятай аян шалтаг эрсээр байлаа. Нэг удалгүй тийм шалтаг гарч, Марина тэжээл дэвтээх хувинтай халуун ус зөөж яваад торж ойчихдоо гай болж гараа түлчихсэн байна. Түүнийг өндийж завдаагүй байтал ташуураар ороолгон дахин унагаав. Түүнээс хойш Лора нарийхан биетэй жаал охиноос нүд салгахаа больсон байна. Марина хоёр том хувинг дааж ядан өдөржингөө ус тэжээл зөөнө. Түлэгдсэн гар нь эдгэж өгөхгүй өдөр бүрийн ажилд улам үгдэрч, бүсгүй ажил хийх нь бүү хэл, хөлөө зөөж тавих нь улам бэрхтэй болжээ.

Тэгээд залуу бүсгүйн дээгүүр өдөр бүр ташуур тас няс хийж, мөр, нуруу, өвчтэй гар дээр нь ташуур буух болжээ. Дааж давшгүй ажил, өвчин, үргэлжийн зодуур нүдүүрт шаналж туйлдсан бүсгүй бараг солиорох шахав. Тэр бүсгүй машины сигнал удаан дуугарахыг дуулмагцаа хамаг бие нь халуун хумхаатай юм шиг дагжин чичирч, бусад эмэгтэйчүүдийн араар нуугдаж, эзэгтэйн нүдэнд өртөхгүйг хичээх болов. Гэтэл цаадах нь заавал олж хардаг байлаа. Зовлонт бүсгүйг анаж отох нь Лорад нэг ёсондоо өөрийн санасанд яавч хүрэх гэсэн хорон сэтгэл, нөгөө талаас хөөрхий зовлонт найз бүсгүйнхээ амийг яаж ийгээд аврах гэсэн бусад бүх бүсгүйчүүдийн үг дуугүй эсэргүүцэл хоёр мөрийтэй тоглоом шиг болжээ. Нэг өглөө Марина бүр өндийж чадахаа больсон учир найз бүсгүйчүүд нь залуу эзэгтэйг ирэх үед Марианаг нуухаар шийджээ. Тэжээл бэлтгэдэг байранд ус буцалгадаг асар том зуухны араар бөөн гишүү овоолж өвчтэй бүсгүйн атиран таталдан байгаа биеийг бүтээж нуужээ. Лора хорсож зандаг хүнээ харагдахгүй болохоор эрэхээр яваад овоолгоотой гишүүн дор нэг хүн байгааг даруй мэдсэн байна. Энэ нь тушаалыг үл даган үймээн гаргаж, үзэгдээгүй дуулдаагүй зөрүүд загнасан шиг санагдав. Лора тэгээд энэ удаа бүгдээр өөрийн нь бүрэн эрхэнд байгааг үзүүлээд өгөхөөр шийдлээ. Ажил бага хийх гэж гараа санаатайгаар түлж гэмтээсэн залхуу амьтныг үхтэл нанчисан ч яадаг юм гэж боджээ. Лора овоолгоотой гишүүг хөлөөрөө ярж тараагаад ташуураа хар тэнхээгээрээ далайтал ташуур нь энэ удаа ганц

бүсгүйн нуруун дээр буусангүй өнгөрөв. Юу гэвэл зууханд бусдаас ойр зогсож байсан хижээл насны олзлогдсон авгай хөөрхий Маринаг өрөвдсөндөө өөрийн ухаангүй болж, залуу эзэгтэйг түлхэн унагааж, зуухан дээрээс хувинтай ус шүүрч аваад Лорагийн дээрээс буцламгай халуун ус цацаж орхижээ. Нэг цагийн дараа Берггольдийг ферм дээр ирэхэд охины нь амь биед халдсан буруутай этгээдүүдийг хуягууд дангинатал хүлээд овоолгоотой гишүүн дээр хаясан байлаа. Бас дэргэд нь шахам энэ дэлхий дээо санаж сарвайх хайртай ганц охин Лора нь шороон шалан дээр тэсэхүйеэ бэрх өвчинд шаналан тийчилж байлаа. Буруутай этгээдүүдийг цээрлүүлэхэд хоёр сум оров. Берггольдод тэдэнтэй төвөг удаж байх зав ч байсангүй. Юуны өмнө Лораг гэртээ яаж аваачихыг бодох хэрэгтэй байлаа. Тэд нар Мюнхенд хувийнхаа машинаар эргэж ирсэнгүй эмнэлгийн тэргээр ирсэн учир замын овон товон болгонд Лорагийн бие хөндөгдөн тэсвэрлэшгүй өвдөнө. Берггольд охиныхоо ёолон дуу тавихыг сонсоод зам зуур золтой л үс нь бууралтсангүй. Савхин цамц, савхин гутал нь бүсгүйн биеийг халуун усанд шалз түлэгдэхээс хамгаалаагүй бол үүнээс эмгэнэлтэй хэрэг болох байсан гэж докторууд сэтгэл засах үг хэлэвч нэмэр болсонгүй. Бүслэхүйгээс өвдөг хүртэлх биеийн зөвхөн доод хэсэг түлэгджээ. Тэгээд Лора зогсож ч болохгүй, сууж ч болохгүй, гагцхүү түрүүлгээ хараад хэвтэж байх хэрэгтэй болжээ. Удтал хүлээсэн сүй тавих явдал болохоос хоёрхон хоногийн өмнө ийм хэрэг болсон байна. Берггольдийнхон энэ санамсаргүй гай тохиолдсонд ихэд гутарцгаав. Дор бүрдээ янз янзаар шаналан зовж, Лора өглөөнөөс орой болтол өвдсөн, ичсэндээ уйлна. Болзоот хархүүдээ яаж иймэрхүү байдалтай үзэгдэнэ гэж гасална. Берггольд бол гэр бүлийн нь энэ намтар зарим хүнд инээдэмтэй хөгийн юмшигсанагдаж магадгүй гэхээс дотор нв арзалзана. Фрау Эльза бол өөрийг нь охиноо харж хандаж байсангүй гэж зэмлэн буруушаах болов уу гэж айн ширвэгдэнэ. Одоо сүй тавих ёслолыг урьд санаж байсан шигээ сүртэй хөлтэй хийх аргагүй болжээ. Ингээд гэр бүлийн их баяр ёслолын өмнөхөн Берггольдийнхон баяр баясгалантай байсан гэж хэрхэвч хэлэх аргагүй байлаа. Генрих өглөөний дөрвөн цаг хагаст ирэв. Түүний ирэхийг хүлээж байсан болохоор гол хаалганы дэргэдэх манаач цэрэг утасдаж завдахын хооронд үүдний өрөөнд Берггольд өөрөө, хойноос нь фрау Эльза гарч ирлээ. Лораг харагдахгүй болохоор нь Генрих баахан гайхсанд Берггольд илүү дутуу олон үг хэлэлгүй, Лорагийн бие барагтайхан, одоо унтаж байгаа гэж аргацаан өнгөрүүлээд, — За бүгдийг дараа ягримз. Одоо замынхаа тоосыг арилгаж, хувцсаа солиод жаахан амар. Би цэрэг хүний ёсоор өглөөнийхөө цайг эрт уудаг юм. Татгалзахгүй бол хоёр цагийн дараа хоолны өрөөнд уулзъя гэж хэлжээ. Генрих энэ саналыг дуртайяа хүлээн авав. Офицерүүд пиг дүүрэн вагонд шөнө нойргүй хоносны дараа хамаг бие нь нозоороод байжээ. Халуун усанд орсны дараа бие нь тавигдаж, нойр нь сэргэв. Цаг хиртэй хэвтсэнээ босож хувцаслаад яг долоон цагт хоолны өрөөнд орлоо. Өглөөний хоолыг ширээн дээр нэгэнт бэлтгэн тавьжээ. Берггольд фрау Эльза хоёр суудаг байрандаа сууж, Лорагийн сандал эзэнгүй байлаа. — Лора унтаж л байна уу? гэж Генрих гайхан асуусанд — Би чамд гэнэт муу юм дуулгаж цочроохыг түвдсэнгүй, Лора өвчтэй, бие нь тун муу байгаа гэсэнд — Та юунд намайг айлгаад байна вэ, их хүнд өвчин тусаа юу? гэж асуухдаа Генрих сүй тавих ёслолыг хойшлуулж магадгүй гэж баярлан хоолой нь чичирчээ. Фрау Эльза, Берггольд хоёр үүнийг өөр янзаар ойлгожээ. Берггольд өгүүлрүүн: — Бүү их санаа зов. Амь насанд аюултай юм байхгүй. Харин Лора азаар амьд мэнд гарсан байна. Лора хоёр

хоногийн өмнө Эльза, бид хоёрын та нарт бэлэглэх гэж байгаа ферм дээр очсон байна. Нэг ажилчин хүүхэн салан задгай байхлаар нь Лора нарийн дэг журамд дуртай охин болохоор гартаа дайралдсан ташуураар далайсан юм байж л дээ. Тэгтэл хичнээн аймар юм болсон гэж санана? Нэг зэрлэг хүүхэн лораг түлхэж унагаагаад дээрээс нь бараг бүтэн тогоо шахам буцламгай халуун ус цацсан байна. Намайг очиход хөөрхий охин минь ямаршуу байдалтай байсныг чи үзсэн ч болоосой! гэжээ. Лорагийн гарт ташуур тас няс хийж байсныг санаснаас тэр гэжүү, эсвэл нойргүй хоносон нь нөлөөлсөн юм уу, ямар ч гэсэн Генрих биеэ барьж тэссэнгүй, суудлаасаа босон харайж, Бертгольд түүний эхнэр хоёрыг хачин муухай харж, Лорагийн сандлыг өшиглөж орхиод, гэв гэнэт хэний ч санаанд ороогүй байтал, өөрөө ч яаснаа мэдэхгүй шахам өөр тасалгаанд гүйн орж, зөөлөн сандал дээр ойчлоо.

~ ТӨГСӨӨГҮЙ ~